

J. K. ROWLING



Харри Поттер ба
ГАЛТ ЦОМ

Харри Поттер ба Галт цом

Зохиолч:	J. K. Rowling http://www.jkrowling.com/
Орчуулагч:	Asuult Forum-ийн гишүүн CROFT http://forum.asuultserver.com
Эмхэтгэл, хөрвүүлэлт:	Б.Болдхүү Имэйл: bxbenny@gmail.com Блог: http://www.boldkhuu.com Facebook: http://facebook.com/bxbenny Twitter: http://twitter.com/bxbenny

Эхийг Asuult Forum-аас авав.

ГАРЧИГ

БҮЛЭГ 1: РЕДДЛИЙН БАЙШИН	4
БҮЛЭГ 2: СОРВИ	13
БҮЛЭГ 3: УРИЛГА	19
БҮЛЭГ 4: ҮҮРЭНД БУЦАЖ ИРСЭН НЬ	26
БҮЛЭГ 5: УИЗЛИЧУУДЫН ШИДЭТ БҮТЭЭЛҮҮД.....	33
БҮЛЭГ 6: ЗӨӨВӨРЛӨГЧ	42
БҮЛЭГ 7: БЭГМЕН БА КРАУЧ	48
БҮЛЭГ 8: КВИДДИЧИЙН ДЭЛХИЙН ЦОМЫН ТЭМЦЭЭН	60
БҮЛЭГ 9: ХАР ТАМГА	72
БҮЛЭГ 10: ИД ШИДИЙН ЯАМАНД БОЛСОН ХЭРҮҮЛ ШУУГИАН	89
БҮЛЭГ 11: ХОГВАРТС ЭКСПРЕСС	97
БҮЛЭГ 12: ГУРВАН ШИДТЭНИЙ ТЭМЦЭЭН.....	105
Бүлэг 13: ХУРЦ НҮДЭТ ГРЮМ	116
Бүлэг 14: УУЧЛАШГҮЙ ШИВШЛЭГ	126
БҮЛЭГ 15: ШАРМБАТОН БА ДУРМСТРАНГ.....	137
БҮЛЭГ 16: ГАЛТ ЦОМ	148
БҮЛЭГ 17: ДӨРВӨН АВАРГА	161
БҮЛЭГ 18: ШИДЭТ САВАА ДЭНСЭЛСЭН НЬ	170
БҮЛЭГ 19: УНГАРЫН ЭВЭР СҮҮЛТ	184
БҮЛЭГ 20: АНХНЫ ДААЛГАВАР.....	197
БҮЛЭГ 21: БООЛЫН ХӨДӨЛМӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ФРОНТ	211
БҮЛЭГ 22: ГЭНЭТИЙН ДААЛГАВАР	223
БҮЛЭГ 23: БҮЖИГТ ҮДЭШЛЭГ	234
БҮЛЭГ 24: РИТА СКИТЕРИЙН ШУУГИАН.....	251
БҮЛЭГ 25: АЛТАН ӨНДӨГ БА ШИДЭТ НҮД	265
БҮЛЭГ 26: ХОЁР ДАХЬ ДААЛГАВАР.....	276
БҮЛЭГ 27: ТЭНҮҮЛЧ БУЦАЖ ИРСЭН НЬ	291
БҮЛЭГ 28: НОЁН КРАУЧ УХААН СОЛИОРСОН НЬ.....	306
БҮЛЭГ 29: ЗӨНТЭЙ ЗҮҮД	324
БҮЛЭГ 30: ОЮУН УХААНЫ ЦҮНХЭЭЛ.....	334
БҮЛЭГ 31: ГУРАВ ДАХЬ ДААЛГАВАР	347
БҮЛЭГ 32: ЯС, БИЕ, ЦУС.....	365
БҮЛЭГ 33: ҮХЭЛ ЗАЛГИГЧИД.....	369
БҮЛЭГ 34: ЭРТНИЙ ШИВШЛЭГ	377
БҮЛЭГ 35: ҮНЭНИЙГ ХЭЛҮҮЛЭГЧ	383
БҮЛЭГ 36: ЗАМ САЛАВ.....	396
БҮЛЭГ 37: ЭХЛЭЛ	409

БҮЛЭГ 1: РЕДДЛИЙН БАЙШИН

Бага-Хэнглтоны оршин суугчид хэдийгээр түүнийг <<Реддлийн байшин>> гэж нэрлэдэг авч Реддлийн гэр бүлийнхэн тэнд амьдрахаа болиод уджээ. Байшин тосгоны ойролцоох толгод дээр байрлах бөгөөд цонхны самбарууд нь хаалттай, дээврийнх нь тоосгууд нь унасны дээр нүүрэн тал нь ороонго өвсөнд битүү хучигджээ. Урьд нь ойр хавийн хамгийн том сүр жавхлантай эдлэн байсан Реддлийн байшин одоо хаягдсан хоосон болжээ.

Бага-Хэнглтоны оршин суугчид хуучин байшин аймшгийн гэдгийг нэгэн дуугаар зөвшөөрдөг байв. Тавин жилийн тэртээ байшинд ямар нэгэн аймшигтай нууцлаг зүйл болсон талаар тосгоны хөгшчүүд одоог хүртэл ярьдаг байлаа. Энэ түүх ярих болгонд хувирч өөрчлөгдсөөр байгаад үнэн худал эсэхийг нь хэн ч мэдэхээ больжээ. Гэвч үргэлж нэгэн янзаар эхэлдэг байсан юм. Тавин жилийн өмнө Реддлийн байшин сүр хүчээ алдаагүй байхад зуны сайхан өглөө үйлчлэгч эмэгтэй зочны өрөөнд ороод бүх гурван Реддлийг үхсэн байхыг олжээ.

Үйлчлэгч чанга хашгирсаар толгод уруудан тосгоны зүг бүх хүчээрээ гүйж тааралдсан хүмүүст харснаа хэлэв.

- Бүгдийнх нь нүд нээлттэй! Мөс шиг хүйтэн болчихсон! Оройн хоолны хувцастайгаа хэвтэж байна!

Цагдаа дуудагдаж Бага-Хэнглтон гүн сонирхолд автав. Тэд олонд нэр хүндгүй хүмүүс байсан тул хэн ч Реддлийнхний төлөө гунигласангүй. Ноён ба хатагтай Реддл баян, дээрэнгүй, бүдүүлэг хүмүүс байсан бөгөөд тэдний хүү Том бүр дор байлаа. Гэвч бүгдэд ер бусын нэг асуулт байсан юм. Алуурчин хэн бэ? Зүв зүгээр байсан эрүүл саруул хүмүүс нэгэн зэрэг үхнэ гэж байхгүй шүү дээ.

Тэр үдэш <<Дүүжлүүлэгч>> хэмээх бааранд бүх тосгоноороо алуурчны тухай ярилцахаар цугларсан тул урьд хожид байгаагүй хөл хөдөлгөөн ихтэй байв. Гэрийнхээ тохилог дулаахан зуухаа орхиж гарсан хүмүүс хов живэнд дурлан сууж байлаа. Яриа хөөрөө өрнөж байх үед Реддлийнхний тогооч авгай орж ирээд олны дунд зогсон жүжигчилсэн байртай Фрэнк Брайс баригдсан гэж мэдэгдэхэд нам гүм болжээ.

- Фрэнк гэнээ! Байж боломгүй юм! гэж хэдэн хүн дуу алдав.

Фрэнк Брайс Реддлийнхний цэцэрлэгч бөгөөд эдлэнгийн жижигхэн байшинд амьдардаг байлаа. Фрэнк дайнаас шархадсан хөлтэй эргэж ирсэн цагаасаа хойш Реддлийнхэнд ажиллаж байсан бөгөөд олон хүн цугларсан газарт маш дургүй байв.

Хүмүүс тогооч авгайд уралдан уух юм авч өгч цааш нь илүү юм ярихыг хүлээв.

- Би үргэлж түүнийг хачирхалтай гэж боддог байсан юм хэмээн тэрбээр тэсч ядан сонсож байсан хүмүүст дөрөв дэх шерригээ уунгаа хэлээд,

- Нэг тиймэрхүү нөхөрсөг биш... Би түүнийг цай уу гэж бараг зуун удаа урьсан байх. Гэвч тэр ирээгүй шүү гэв.

- Фрэнк аймшигтай дайнаас эргэж ирсэн. Тэр тайван амьдрахыг хүссэн байх. Энэ чинь хүн алах шалтгаан биш... гэж баарны эзэгтэй эсэргүүцэв.

- Тэгвэл түүнээс өөр хэнд арын хаалганы түлхүүр байгаа гэж? Тэдний илүү түлхүүр цэцэрлэгчийн байшинд өлгөөстэй байсныг би сайн санаж байна! Өнгөрсөн шөнө ямар ч хаалга, цонх эвдлээгүй байсан. Фрэнк бүгдийг унтаж байх хооронд байшинд ороод аймшигтай зүйлээ хийсэн байх...

Сонсогчид баргар харц солилцов.

- Би түүнийг үргэлж олиггүй гэж боддог байсан хэмээн лангууны дэргэд зогсож байсан эрэгтэй хэлэв.

- Дайн түүнийг ийм болгосон юм гэж дэн буудлын эзэн хэллээ.

- Би чамайг Фрэнктэй орооцолдох хэрэггүй гэж хэлдэг байсан биз дээ, Дот? гэж буланд сууж байсан эмэгтэй хэллээ.

- Аймшигтай юм. Түүний хүүхэд байсан үеийг санаж байна гэж Дот толгой дохилоо.

Маргааш өглөө нь Бага-Хэнглтонд Фрэнк Брайс Реддлийнхнийг алсан гэдэгт хэн ч эргэлзэхээ больжээ. Гэвч хөрш зэргэлдээх Том-Хэнглтоны цагдаагийн тоостой харанхуй өрөөнд Фрэнк өөрийгөө гэм буруугүй бөгөөд Реддлийнхнийг үхдэг өдөр үл таних өсвөр насны хар үс, цонхигор царайтай хөвгүүнийг харсан гэж шургуу нотолж байв. Тосгоныхны хэн ч тийм хүүг хараагүй болохоор цагдаагийнхан Фрэнкийг зохиосон гэж боджээ.

Ажил хэрэг муу тал руугаа эргэж байтал Реддлийнхний биед задлан шинжилгээ хийсэн үр дүн ирж үйл явдал өөрчлөгдөв.

Тийм хачирхалтай дүгнэлтийг цагдаагийнхан өмнө харж байгаагүй болно. Эмч нар тэдний биесийг шинжлээд Реддлийнхнийг хэн ч хордуулж, хутгалж, буудаж, боож алах болон хийгээр хордуулаагүй болохыг баталжээ.

Гол учир гэвэл (Дүгнэлт итгэхийн аргагүй гайхширлаар үргэлжилжээ) Реддлийнхэн эрүүл чийрэг хүмүүс байсан хэрнээ бүгд үхсэн гэдэгт байлаа. Эмч нар (тэдний биесээс ямар нэгэн гэмтэл олоогүй гэж дүгнэжээ) Реддлчүүдийн царайд үхтлээ айсан төрх тодорсон байсан гэж бичсэн байлаа. Гэвч гонсойж гутарсан цагдаагийнхан гурвын гурван эрүүл хүн айснаасаа болж нэг дор үхсэн тохиолдол гарч байсныг сонссон уу гэж асуужээ.

Реддлийнхнийг Фрэнк алсан гэдэг ямар ч нотлох баримт байхгүй байсан учир цагдаагийнхан түүнийг суллав. Тэднийг Бага-Хэнглтоны оршуулгын газар оршуулсан бөгөөд булш нь багагүй хугацаанд анхаарал татсан хэвээр байсан юм. Харин тосгоны хүмүүсийн гайхал сэжиглэлийг төрүүлэн Фрэнк Брайс Реддлийн эдлэн дэх байшиндаа буцаж очиж амьдрал.

- Минийхээр бол цагдаагийнхан юу ч хэлж байсан хамаагүй тэр л тэднийг алсан. Хэрвээ Фрэнк ёс журамтай хүн байсан бол бүгд түүнийг алсан гэдгийг мэдэж байхад эндээс явах ёстой байсан гэж Дот <<Дүүжлүүлэгч>> бааранд мэдэгджээ.

Гэвч Фрэнк явалгүй цэцэрлэгийг арчилахаар үлдэв. Байшинд өөр гэр бүл нүүн орсон ч удаан тэсдэггүй байлаа. Байшингийн эзэд энэ газар аймшиг төрүүлдэг гэж хэлдэг ч магадгүй энэ бүхэнд зожиг Фрэнк буруутай байж болох юм. Ингээд байшин эзгүйрэн хоосорч аажмаар өмхрөн нурж байв.

Реддлийн байшингийн одоогийн эзэн болох баян хүн тэнд амьдардаггүй бөгөөд огт ашигладаггүй байв. Тосгоныхон түүнийг татварын төлөө худалдаж авсан гэж ярилцдаг ч байшин авсан шалтгааныг хэн ч тодорхой тайлбарлаж чадсангүй. Баян эзэн цэцэрлэгчийн хөлсийг үргэлжлүүлэн төлсөөр байсан юм. Фрэнк далан долоон нас хүрэх үедээ бараг дүлийрч шархадсан хөл нь нугарахаа больсон ч цаг агаар сайхан үед цэцгийн мандлыг арчилж, хогийн өвс ургамлыг зулгаан хаядаг байв.

Фрэнк зөвхөн зэрлэг ургамлуудтай ч тэмцээгүй юм. Тосгоны хөвгүүд зүггүйтэн Реддлийн байшингийн цонх руу чулуу шиддэг байв. Тэд дугуйгаар Фрэнкийн хичээн арчилсан зүлгэн дээгүүр давхилдан ганц хоёр удаа бүр байшинд орж зүрхэлж байлаа. Тэдэнд хөгшин Фрэнк байшинд хайртай нь илт байсан тул цэцэрлэг дундуур таягаа далайн хазганасаар сөөнгө хоолойгоор гуугчин гүйхийг нь хараад баясан инээлддэг байв. Фрэнк хүүхдүүд түүнийг эцэг эхийнхээ адил алуурчин гэж боддог болохоор даажигнадаг гэж боддог байв. Ийм учраас найман сарын тэр нэг шөнө хуучин байшинд ямар нэгэн хачирхалтай зүйл болсныг хараад хүүхдүүдийн залхаан цээрлүүлэх бас нэг оролдлого гэж боджээ.

Фрэнкийг шархтай хөл нь өвдөн сэрээсэн бөгөөд хөгшрөх тусам улам их өвддөг болоод байлаа. Тэр хазганан босож өвчтэй хөл дээрээ халуун жин тавихаар гал тогоо руу уруудав. Фрэнк угаагуурын дэргэд данх дүүргэн зогсож байхдаа Реддлийн байшингийн дээд талын цонхонд гэрэл сүүмэлзэхийг ажиглажээ. Тэгэхээр хөвгүүд ахин байшинд орж сүүмгэр гэрлээс нь үзэхэд гал асаасан байх нь.

Фрэнк Реддлийнхний үхэлд сэжиглэгдэн байцаалтанд дуудагдсанаас хойш утсанд дургүй болсон учир байсангүй. Тэр данхаа тавиад өвчтэй хөлийнхөө чадлаар унтлагын өрөө рүү яран өгсөв. Хувцаслаад доошоо бууж таяг болон байшингийн хуучин түлхүүрийг хаалганы дэргэдэх дэгээнээс авч шөнө гарчээ.

Байшингийн хаалга болон цонхыг эвдсэн шинж огт байсангүй. Фрэнк байшинг тойрон явж үзээд ороонгон дунд нуугдсан арын хаалганд хүрч түлхүүр шургуулан чимээгүй онгойлгов.

Үүд нээгдэхэд харанхуй гал зууханд орлоо. Тэр хэдийгээр энд олон жил орж ирээгүй ч өрөөний хаалга хаана байдгийг санаж байсан болохоор юм мөргөчихгүйн тулд тэмтчин явахад ялзарч муудсан үнэр хамрыг нь нэвт цоргилоо. Тэр дээр хөлийн чимээ юм уу хоолой сонсох эсэхийг анирдаж байв. Түүнийг үүдний өрөөнд хүрэхэд хаалганы хоёр талд том цонхтой болохоор арай гэгээтэй байлаа. Фрэнк шатаар өгсөж тоостой шалан дээр цуурайтах өөрийнхөө алхаа болон таягны чимээг сонсож байв.

Дээд давхарт гараад Фрэнк баруун тийш эргэхдээ урилгагүй зочид хаана байгааг шууд ойлгожээ. Хонгилын эцэст дутуу хаагдсан хаалганы завсараар харанхуй шалан дээр дөлний алтлаг туяа сүүмэлзэнэ. Фрэнк таягаа тулан хэдэн алхам урагшлаад нарийхан завсраар өрөөн доторхыг харлаа.

Гал ханан зууханд асаж байв. Энэ нь Фрэнкийг гайхуулсан учир зогсож өрөөнөөс дуулдах эрэгтэй хүний хоолойг анхааралтай чагнав. Хоолой аяархан бөгөөд айсан янзтай дуулдаж байлаа.

- Лонхонд бага зэрэг үлджээ, эзэнтээн. Хэрвээ та өлсөж байгаа бол...

- Дараа больё. Намайг галд жаахан ойртуулаадах, Сүүлтээ гэх хоёр дахь эрэгтэй хүний мөс шиг хүйтэн хоолой гарав. Энэ хоолойнд ямар нэгэн аймшигтай зүйл байсан учир Фрэнкийн үлдсэн хэдэн буурал үс дээшээ бослоо.

Тэрбээр сайн сонсохын тулд баруун чихээ хаалга руу эргүүллээ. Хатуу газар тавьсан лонхны жингэнэх дуу гарснаа хүнд сандал шалан дээгүүр чирэгдэх бөглүү чимээ гарав. Фрэнк хаалганы өмнүүр сандал түлхсээр өнгөрөх хүний нурууг харж амжив. Тэр урт хар жанч өмссөн орой дээрээсээ халзарч яваа жижигхэн хүн байсан бөгөөд төдхөн үзэгдэхээ болив.

- Нагайна хаана байна? гэж хүйтэн хоолой асуув.

- Би... би мэдэхгүй байна, эзэнтээн. Бодвол байшин дотуур явж байгаа байх гэж эхний хоолой зүрхшээнгүй хэлэв.

- Түүнийг унтахаас өмнө саагаарай, Сүүлтээ. Би шөнө бага зэрэг хооллох хэрэгтэй байна. Аялал намайг их ядраалаа гэж хоёр дахь хоолой хэлэв.

Фрэнк хөмсөг зангидан эрүүл чихээ хаалганд ойртуулаад үг алдахгүй сонсохыг хичээв. Хэсэг чимээгүй болсны эцэст Сүүлт нэртэй хүн ахин ярьж эхлэв.

- Эзэнтээн, бид энд хэр удахыг асууж болох уу?

- Долоо хоног. Түүнээс илүү ч байж магад. Энэ газар бидний төлөвлөгөөнд саад болохооргүй их боломжийн юм. Квиддичийн Дэлхийн цомын тэмцээн дуусахаас өмнө ямар нэг зүйл хийх нь тэнэг хэрэг болохсон.

Фрэнк мойног хуруугаа чихэндээ хийгээд эргүүлэв. Түүний чихэнд хуримтлагдсан хулхи нь ямар нэгэн <<квиддич>> гэх жирийн бус үгийг олж сонсоход нөлөөлсөн бололтой.

- Квиддичийн Дэлхийн цом уу, эзэнтээн? гэж Сүүлт асуув. (Фрэнк мойног хуруугаараа чихээ улам сайн ухаж эхлэв). Өршөөгөөрэй... Гэхдээ би ойлгохгүй байна... Дэлхийн цомын тэмцээний төгсгөлийг хүлээх ямар хэрэгтэй юм бэ?

- Учир нь тэнэг минь, тэмцээн дээр Дэлхийн өнцөг булан бүрээс шидтэнгүүд ирэх учир ид шидийн яамныхан хүний хэрэгт хошуу дүрэхээ больж зөвхөн маглуудад юу ч ажиглуулахгүйн тулд аюулгүй байдалд санаа тавих болно. Ийм учраас хүлээх хэрэгтэй байгаа юм.

Фрэнк чихээ тайван орхилоо. Тэр <<Ид шидийн яам>>, <<Шидтэнгүүд>>, <<Магл>> гэсэн үгнүүдийг маш тод сонсчээ. Эдгээр үгнүүд ямар нэгэн нууц агуулж байгаа бөгөөд зөвхөн тагнуулчид болон гэмт хэрэгтнүүд ийм үгээр ярилцдаг юм. Тэр таягаа улам чанга зуураад илүү анхааралтай сонсов.

- Та бүрэн шийдсэн хэрэг үү? гэж Сүүлт аяархан асуув.

- Мэдээж би шийдсэн гэж хүйтэн хоолой заналхийлсэн өнгөөр дуугарав.

Хэсэг чимээгүй болсны дараа Сүүлт айсан хоолойгоор,

- Харри Поттергүйгээр болох уу, эзэнтээн! гэв.

Ахин хэсэг чимээгүй болсны эцэст,

- Харри Поттергүйгээр гэнэ ээ? Тийм байж... гэх нь сонсогдов.

- Эзэнтээн би хүүгийн төлөө санаа зовсондоо ингэж ярьж байгаа юм биш шүү! Хүү надад ямар ч хамаагүй! Зүгээр л бид өөр шидтэнг сонгон авбал илүү түргэн хийж болно гэсэн юм! Хэрвээ та намайг богино хугацаанд яваад ирэхийг зөвшөөрвөл би өөрийгөө үр дүнтэй хувиргаж хоёр өдрийн дараа тохиромжтой хүнийг аваад ирж болох юм... гэж Сүүлт шогширох адил хоолойгоор хэлэв.

- Тиймээ, өөр шидтэнг ашиглаж бололгүй яахав. Энэ үнэн... гэж хоёр дахь хоолой аяархан хэллээ.

- Эзэнтээн, энэ бол ердөө бодол шүү дээ. Харри Поттерт хүрэх маш хэцүү. Түүнийг хэтэрхий сайн хамгаалж байгаа гэж Сүүлт арай итгэлтэйгээр хэлэв.

- Тэгэхээр чи намайг жаахан асарчихаад орхиод явах гэж байгаа юм биш биз дээ? Сонирхолтой юм... Эсвэл намайг асрах нь чамд залхуутай санагдаа юу, Сүүлтээ? Чиний төлөвлөгөө өөрчлөх санаа чинь надаас зугтах оролдлого биш үү?

- Эзэнтээн! Надад таныг орхих өчүүхэн төдий бодол ч байхгүй!

- Бүү худал хэл! гэж хоёр дахь хоолой исгэрлээ.

- Худал хэлэхийг би үргэлж мэдэг юм, Сүүлтээ! Чи над дээр эргэж ирсэндээ харамсаж байгаа. Би чиний жигшил зэвүүцлийг мэдэрч байна. Чи намайг харах болгондоо агзасхийдэг. Бас надад хүрэх болгондоо чичирдгийг чинь мэднэ...

- Үгүй-үгүй! Миний үүрэг бол таньд үйлчлэх явдал...

- Чиний үүрэг бол ердөө л аймхай хулчгар явдал. Хэрвээ чамд явах газар байсан бол энд нэг ч хором үлдэхгүй байсан. Тэгээд ч би тодорхой цаг болгонд хооллох хэрэгтэй байхад чамгүй бол яаж амьд үлдэх юм бэ? Хэн Нагайнагийн сүүт саах юм?

- Гэхдээ та, хүчирхэг харагдаж байна шүү дээ эзэнтээн...

- Худалч. Би хүчирхэг биш. Би хоёр гурван өдөр ганцаар үлдэхэд л чиний олиггүй арчилгаанаас олж авсан бүх хүчээ алдах болно... Чимээгүй!

Сүүлт ямар нэгэн учир холбогдолгүй юм бувтнаснаа чимээгүй боллоо. Хормын турш Фрэнк гал дүрэлзэн асахаас өөр чимээ сонссонгүй. Гэтэл хоёр дахь хоолой ахин ярьж эхлэхдээ исгэрэх адил боллоо.

- Би чамд хүүг юуны учир ашиглах гэж байгаагаа тайлбарласан. Би арван гурван жил хүлээсэн болохоор хэдхэн сар хүлээх нь юуг ч өөрчлөхгүй. Тиймээ, тэр сайн хамгаалагдсан хэдий ч миний төлөвлөгөө ажиллана гэдэгт итгэлтэй байна. Чиний зүгээс бага зэрэг зүрх зориг шаардагдана, Сүүлтээ. Хэрвээ чи лорд Волан-де-Мортын уурыг хүргэхийг хүсээгүй л юм бол зүрх зоригтой байх хэрэгтэй.

- Эзэнтээ, би таньд хэлэх ёстой! Би наашаа ирэх бүх замын турш төлөвлөгөөний талаар бодож байсан юм. Берта Жоркинсын алга бололт удаан мэдэгдэхгүй өнгөрөхгүй болохоор хэрвээ би үргэлжлүүлэн алвал... гэж Сүүлт сандрангуй хэлэв.
- Хэрвээ гэнээ? Хэрвээ чи миний төлөвлөгөөг дагах юм бол, Сүүлтээ ид шидийн яамныханд хэн нэгэн үхсэнийг мэдэх хэрэг гарахгүй. Чи бүгдийг чимээ шуугиангүй хийх хэрэгтэй. Миний одоогийн байдал ийм болохоор би өөрөө хийж чадахгүйдээ харамсаж байна... Гэхдээ Сүүлтээ ганцхан саадыг зайлуулахад Харри Поттерт хүрэх зам чөлөөлөгдөнө. Би чамайг ганцаараа хий гэж хэлээгүй. Бидэнтэй удахгүй үнэнч зарц минь нэгдэнэ.
- Би... таны үнэнч зарц шүү дээ гэж Сүүлт уруу царайлан бувтналаа.
- Сүүлтээ, надад үнэнч шударга эргэлзэж тээнэгэлзэхээргүй хүн хэрэгтэй байна. Харин чи эдгээрийн алиныг нь ч хангахгүй.
- Би таныг олсон шүү дээ. Би таныг олсон цорын ганц хүн. Би таньд Берта Жоркинсыг авчирсан... гэж Сүүлт улам их гомдсон өнгөөр хэллээ.
- Юу гэвэл энэ үнэн гэж хоёр дахь хоолой үл ялиг хөгжилтэй өнгөөр хэлээд,
- Би чамайг ингэх чадвартай гэж бодоогүй шүү, Сүүлтээ. Гэвч үнэнийг хэлэхэд чи түүнийг барихдаа хэрэгтэй гэдгийг нь мэдээгүй байсан биз, тийм үү? гэв.
- Би... би түүнийг хэрэгтэй гэж бодсон юм, эзэнтээн...
- Худалч гээд хоёр дахь хоолой ахин таагүй хөгжилтэй өнгө тодруулан,
- Түүнээс авсан мэдээлэл үнэ цэнэтэй болохыг би үгүйсгэхгүй. Түүнгүйгээр миний төлөвлөгөө хэзээ ч биелэхгүй байсан. Үүний чинь төлөө чамайг шагнах болно, Сүүлтээ. Би чамд гол даалгавар өгөх болно... Үүнийг төлөө миний олонхи дагалдагчид баруун гараа өгөхөөс буцахгүй тийм даалгавар... гэлээ.
- Үнэн үү, эзэнтээн? Ямар?... гэж Сүүлт айн асуулаа.
- Энэ бол гэнэтийн бэлэг байх болно, Сүүлтээ... Чи миний сэтгэл ханамжийг гутаахыг хүсэхгүй байгаа биз дээ? Чиний оролцоо хамгийн сүүлд нь байх болно... Гэхдээ чи Берта Жоркинсоос ашигтай байна гэдгийг амалж байна.
- Та... та... намайг бас алах гэж байгаа юм уу? гээд Сүүлтийн хоолой гэнэт хатсан юм шиг сөөнгөтлөө.
- Сүүлт минь, Сүүлт минь. Би чамайг алах ямар хэрэгтэй гэж? Би Берта Жоркинсийг хэрэгтэй болохоор нь алсан. Тэр миний асуултанд хариулсны дараа ямар ч хэрэггүй болсон гэж хэлж болно. Хэрвээ тэр ид шидийн яаманд буцаж очоод амралтаараа чамтай тааралдсан гэж хэлвэл таагүй явдал болно. Хүмүүсийн үхсэн гэж боддог шидтэн замын хажуугаас гарч ирээд яамны ажилтан руу тэр болгон дайраад байдаггүй юм.
- Сүүлт ямар нэгэн юм аяархан бувтнахад Фрэнк сонсож чадаагүй хэдий ч хоёр дахь хүн инээв. Энэ бол хөгжилтэй бус хүйтэн цэвдэг инээд байлаа.

- Бид түүний ой ухааныг нь өөрчлөх байсан гэнэ ээ? Гэвч ой ухааны шидийг хүчтэй шидтэн эвдэлж чадна. Түүнээс авсан мэдээллүүдээ ашиглахгүй бол ой ухааныг нь доромжилсон хэрэг болно, Сүүлт минь.

Энэ үед хаалганы гадаа хонгилд байсан Фрэнк таягаа чанга атгаж буй алга нь хөлөрснийг мэджээ. Аймшигтай хүйтэн хоолойтой хүн нэг эмэгтэйг алсан тухайгаа өчүүхэн ч харууссан шинжгүй харин ч хөгжилтэйгээр ярьж байна. Тэр аюултай алуурчин бас шинэ аллагын тухай төлөвлөж байна. Харри Поттер нэртэй хүү аюулд оржээ.

Фрэнк юу хийх ёстойгоо мэдэж байв. Одоохон цагдаагийн газар руу гүйх хэрэгтэй. Нэн даруйхан байшингаас гарч тосгоны телефон утасны бүхээг рүү... Тэгтэл хүйтэн хоолой ахин сонсогдож эхлэхэд Фрэнк байрандаа хөшөөд бүх хүчээ гарган сонсож эхэллээ.

- Ахиад нэг л аллага... Хогвартсад үнэнч зарц минь байгаа... Харри Поттер миний гарт орсон гэж бодож болно, Сүүлтээ. Энэ асуудал шийдэгдсэн болохоор маргах хэрэггүй. Гэхдээ чимээгүй... Нагайна ирж байх шиг байна.

Хоёр дахь хүний хоолой өөрчлөгдлөө. Фрэнк хэзээ ч амьдралдаа ийм чимээ сонсож байсангүй.

Тэр амьсгаа авалгүй исгэчив. Фрэнк түүнийг ямар нэг өвчтэй гэж бодоход хүртэл арынх нь харанхуй хонгилд үл мэдэг хөдөлгөөн мэдрэгдэв.

Тэр эргэж хараад айсандаа хөшлөө. Харанхуй шалан дээгүүр ямар нэгэн зүйл гулсан ойртсоор гэрэлд гарч ирэхэд Фрэнк арван хоёр фунт урт биетэй аварга могой байхыг айдаст автан харлаа. Түүний долгиолон мурилзсан бие тоостой шалан дээгүүр өргөн мөр үлдээж байв. Бүр ойртоод ирлээ... Юу хийх ёстой вэ? Цорын ганц аврагдах зам бол хоёр эрэгтэй хүн аллагад бэлтгэн ярилцаж байсан өрөөний үүд байлаа. Хэрвээ тэр зогссон хэвээр үлдвэл могой түүнийг алах болно.

Гэвч түүнийг шийдвэр гаргаж амжихаас урьтаж могой дөхөн ирээд ямар нэгэн гайхамшигаар дэргэдүүр нь гулсан өнгөрч исгэрч буй хүйтэн хоолойтой хүний зүг ухасхийн ороход сүүлний үзүүр нь нээлттэй хаалгаар гялсхийв.

Фрэнкийн духанд хүйтэн хөлс дааварлаж таягтай гар нь чичирч байлаа. Дотор өрөөнд хүйтэн хоолой үргэлжлүүлэн исгэрэх аж. Тэгтэл Фрэнкийн толгойд байж боломгүй хачин бодол орж ирлээ... Энэ хүн могойтой ярьж чаддаг юм байна.

Фрэнк юу болоод байгааг ойлгохоо болив. Тэр энэ дэлхий дээр юунаас ч илүү халуун устай жин бүхий орондоо эргэж очихыг хүсэж байв. Гэвч гай болоход хөл нь захирагдахаа больжээ. Тэр чичирсэн хэвээр зогсоод өөрийгөө захирахыг оролдох үед хүйтэн хоолой ахин хүний хэлээр ярилаа.

- Нагайнад сонирхолтой мэдээ байна, Сүүлтээ.

- Тийм гэж үү, эзэнтээн?

- Тиймээ. Хэрвээ түүний үгэнд итгэх юм бол өрөөний гадаа хөгшин магл зогсоод бидний үг бүрийг сонсож байгаа юм байна.

Фрэнкэд нуугдах газар байсангүй. Хөлийн чимээ сонсогдож өрөөний хаалга саван онгойлоо.

Фрэнкийн өмнө халзарч буй буурал үстэй шовх хамар бүхий жижигхэн усархаг нүдтэй хүн зогсоод айдас түгшүүр бүхий нүдээр ширтэв.

- Түүнийг дотогш уриач, Сүүлтээ. Ёс заншил чинь хаа байна?

Хүйтэн хоолой ханан зуухны өмнө байх хуучин сандлаас дуулдах хэдий ч ярьж буй хүн үзэгдсэнгүй. Фрэнк зуухны өмнөх хивсэн дээр нохой шиг цагариглан буй могойг олж харлаа.

Сүүлт Фрэнкийг өрөө рүү ор гэж зангав. Фрэнк дагжин чичирэхээ тоолгүй таягаа чанга атгаад хүчээр алхан орлоо.

Өрөөнд байсан цорын ганц гэрэл зуухнаас гарч ханан дээгүүр урт сүүдрүүд бүжиглэнэ. Фрэнк түшлэгтэй сандлын ар луу харлаа. Тэнд сууж байсан хүн зарцаасаа ч бага бололтой. Фрэнк түүний шилэн хүзүүг нь ч харахгүй байлаа.

- Магл, чи бүгдийг сонссон уу гэж хүйтэн хоолой асуув.

- Та намайг юу гэж нэрлээд байна? гэж Фрэнк асуулаа. Тэр одоо өрөөнд орж ирээд үйл явдалд оролцож байгаа учраас дайнд байсан шигээ зоригтой болов.

- Би чамайг магл гэж хэллээ. Энэ бол чи шидтэн биш гэсэн үг юм хэмээн хүйтэн хоолой хэллээ.

- Та шидтэн гэснээрээ юу гэж хэлэх гэснийг мэдэхгүй юм. Гэхдээ би цагдаагийнхан сонирхохоор хангалттай зүйл сонссон. Та аллага хийсэн бөгөөд ахин нэг аллагад бэлтгэж байна. Бас... гэж тэр шийдэмгий хэлээд амьсгал авч,

- Миний эхнэр намайг энд байгааг мэдэж байгаа. Хэрвээ намайг буцаж очихгүй бол... гэлээ.

- Чамд эхнэр байхгүй. Энд байгаа гэдгийг чинь хэн ч мэдэхгүй. Лорд Волан-де-Мортод бүү худал хэл, магл. Тэр худал хэлэхийг үргэлж мэддэг юм... гэж хүйтэн хоолой тайван хэлэв.

- Тийм гэж үү? хэмээн Фрэнк дуу алдаад,

- Та үнэхээр лорд хэрэг үү? Надад таны байдал таалагдахгүй байна, эзэнтээн. Та лорд юм бол яагаад над руу эргэн харж нүүр нүүрээ харалцан ярилцаж болохгүй гэж? хэмээн бүдүүлгээр хэлэв.

- Гэхдээ би хүн бишээ, магл гэж тэр хэлэхэд галын дөл чичигнэлээ.

- Би хүнээс илүү дээр. Гэвч... яагаад болохгүй гэж? Би чамтай нүүр тулья л даа... Сүүлтээ, миний сандлыг эргүүлээдэх.

Зарц гашуунаар дуу алдав.

- Чи намайг сонсов уу, Сүүлтээ.

Тэрбээр үрчийн эзэн рүүгээ ойртохгүй бол үхэхэд ч бэлэн удаанаар галын дэргэдэх могойн хажуугаар өнгөрч сандлыг эргүүлж эхэллээ. Сандлын хөл хивсэнд тээгэлдэхэд могой гурвалжин толгойгоо өргөн аяархан исгэрлээ.

Сандал Фрэнк руу эргэхэд түүн дээр юу байгааг харлаа. Хөгшин цэцэрлэгчийн таяг шалан дээр тачигнан унахад ам нь нээгдэн чанга хашгирсан учир сандал дээр сууж буй амьтны саваа өргөн хэлж буй үгийг сонссонгүй. Ногоон гэрэл нүдэн дээр нь гялсхийн чанга чимээ гарахад Фрэнк Брайсын бие газар унахаасаа өмнө үхсэн байв.

Харин Реддлийн байшингаас хоёр зуун милийн тэртээ Харри Поттер нэртэй хүү зүүднээсээ цочин сэрлээ.

БҮЛЭГ 2: СОРВИ

Харри дээшээ хараад нүүрээ гараараа таглан удаан гүйлтийн дараах шиг амьсгаадан хэвтэж байв. Духан дээрх цахилгаантай адилхан сорви нь арьсан дээр нь улайдсан төмрөөр хайрсан мэт цоргин өвдөнө. Тэр хурц тод зүүд зүүдлэжээ.

Тэр сорвио дарсан хэвээр өндийн суугаад орны хажуугийн ширээн дээрээс шилээ тэмтрэн авлаа. Шилээ зүүхэд хөшигний завсраар тусах гудамжны дэнлүүний бүдэгхэн гэрэл гийгүүлсэн унтлагын өрөө тод харагдав.

Харри сорвин дээгүүрээ хуруугаа гүйлгэсэн ч өвдөлт намжсангүй. Тэр ширээний гэрлийг асаагаад орноос босч хувцасны шүүгээгээ онгойлгон хаалганы доторх толинд өөрийгөө харлаа. Түүний урдаас арван дөрвөн настай туранхай, хурц ногоон нүдтэй, өрвийсөн хар үстэй хүү бодлогоширонгуй харж байв. Тэр цахилгаантай адилхан сорвиныхоо тусгалыг харлаа. Хэвийн харагдах хэдий ч хатгуулсан хэвээр байв.

Харри сэрэхээсээ өмнө юу зүүдэлснээ санахыг оролдов. Бүх зүйл амьд юм шиг байсан даа. Түүний мэдэх хоёр хүн байснаас гадна бас нэг үл таних хүн байлаа... Харри хөмсгөө зангидан санахыг хичээв...

Харанхуй өрөөний бүдэгхэн дүр зураг орж ирэв... ханан зуухны урдах хивсэн дээр мушгиралдах могой... Сүүлт гэдэг нэртэй жижигхэн Питер... чанга хүйтэн лорд Волан-де-Мортын хоолой. Харрийн дотор хүйт даалаа.

Тэр нүдээ аниад зүүдэнд нь Волан-де-Морт ямар харагдаж байсныг санах гэж оролдов. Сүүлт сандлыг эргүүлэхэд түүн дээр сууж байсан зүйлийг хараад Харри айдаст автан сэрсэн. Гэхдээ түүнийг хорсон өвдөж байгаа сорви нь сэрээсэн байж болох уу?

Харин тэр хөгшин эр хэн байсан юм бол? Тэнд үнэхээр хөгшин хүн байсан даа. Тэр яагаад ч юм унасан шүү дээ. Гэвч цаашаагаа замхран одлоо. Харри унтлагын өрөөгөө харахгүйн тулд алгаараа нүүрээ дараад бүдэг гэрэлтэй өрөөний дүр зургийг санах гэж оролдсон ч хурууны завсраар нь асгарах ус шиг гулган одлоо. Түүнийг санах гэж оролдох тусам улам замхарч байлаа... Волан-де-Морт Сүүлттэй хэн нэгнийг алсан тухайгаа ярьж байсан... нэрийг нь Харри мартжээ. Бас хэн нэгнийг алах тухай ярилцаж байсан. Түүнийг!

Тэр алгаа нүүрнээсээ холдуулаад ямар нэгэн ер бусын зүйл харах гэж байгаа мэтээр нүдээ том нээн унтлагын өрөөгөө тойруулан харлаа. Тэнд маш олон хачирхалтай зүйл байсныг хэлэх хэрэгтэй. Холгүй орших орны хөл дээр байгаа нээлттэй том чемодан дотор тогоо, шүүр, хар жанч болон шившлэгийн хичээлийн сурах бичиг байлаа. Бичгийн ширээн дээр байгаа том хоосон тор бол цагаан өнгөтэй Хэдвиг уулийнх. Үлдсэн зайг хуйлаастай цаас эзэлжээ. Орны хажуугийн шалан дээр түүний унтахаасаа өмнө уншиж байсан нээлттэй ном хэвтэнэ. Номны зургууд бүгд хөдөлдөг ажээ. Хурц шаргал өнгийн жанчтай эр хуудаснаас алга болоод шүүрээр нисэн гарч ирэхдээ улаан бөмбөгийг бусад тоглогчиддоо дамжуулж байв.

Харри номоо аваад нэг ангуучин арван таван футын өндөрт байгаа цагаригт маш гайхалтай бөмбөг оруулахыг хараад хаалаа. Квиддич гайхамшигтай тоглоом хэдий ч энэ хоромд спорт түүний бодлыг эзэмдсэнгүй. Тэр <<Педдлийн их буунуудын нислэг>> гэдэг номоо орны хажуугийн ширээн дээр тавиад цонх руу очиж хөшгөө нээн гудамж руу харлаа.

Хотын захын Улаан модон гудамж өглөө эрт ердийнхөөрөө харагдаж байв. Цонхнуудын хөшиг хаалттай. Алсад ямар нэг амьтан битгий хэл муур ч өнгөрөхгүй ажээ.

Тэгэхдээ л тэгэхдээ л... Харри түгшсэн хэвээр орон дээр суугаад сорвио ахин тэмтэрлээ. Өвдөлт түүнийг зовоосонгүй. Өвдөлт болон гэмтэл Харрид танил байсан юм. Тэр нэг удаа баруун гарын бүх ясаа алдаад шөнийн турш зовиурлан байж ургуулсан. Мөн тэрхүү гарт урт хортой соёо зоогдож байсан нь бий. Харин өнгөрсөн жил арван таван футын өндрөөс шүүрнээсээ унасан юм. Тэр золгүй явдал болон хачирхалтай гэмтэлд эртнээс дассан бөгөөд хэрвээ чи ид шидтэний Хогвартс сургуульд сурдаг таагүй явдлыг өөртөө татах чадвартай бол үүнээс зайлсхийх аргагүй билээ.

Үгүй ээ, Харриг өөр зүйл зовоож байлаа. Өнгөрсөн удаа сорви нь өвдөх үед Волаан-де-Морт ойрхон ирсэн байсан... Гэвч энд Волаан-де-Морт байх боломжгүй юм. Аугаа их хар шидтэн Улаан модон гудамжны хаа нэгтээ байна гэж үү.. энэ бол утгагүй зүйл юм...

Харри эргэн тойрноо анирдан шатны гишгүүр чахрах, хувцас шар шурхийх чимээ гарах эсэхийг сонсов. Хананы цааны үеэл Дадли нь чанга хурхирахад Харри огт санаандгүй байсандаа цочлоо.

Биеэ барих хэрэгтэй. Байшинд Дурслийн гэр бүлийнхнээс өөр хэн ч байхгүй. Нагац ах Вернон, Петунья эгч, Дадли нар ямар ч баргар зүүд зүүдлэлгүй бөх унтаж байв.

Унтаж байгаа Дурслийнхан Харрид юунаас ч илүү таалагддаг байлаа. Нагац ах Вернон, нагац эгч Петунья эгч хоёр түүний цорын ганц хамаатан байсан юм. Тэд маглууд болохоор ид шидтэй холбоотой зүйл болгоныг үзэн ядна. Сүүлчийн гурван жил тэд Харригийн удаан хугацааны алга бололтыг гэгээн Брутсын хүнд хэцүү гэмт хэрэгтэн хүүхдүүдийн сургуульд явдаг хэмээн тайлбарлаж байсан юм. Тэд Харриг насанд хүрээгүй шидтэн болохоор сургуулийн хананаас гадуур ид шид хэрэглэх хориотой гэдгийг мэдэх хэдий ч ямар нэгэн зүйл болоход түүнийг буруутгасан хэвээр байлаа. Харри хэзээ ч тэдэнд шидтэний ертөнцийн нууцаа итгэн хэлж байсангүй. Тэдэнд сорвиныхоо өвдөхийг юм уу Волаан-де-Мортын аюулын талаар хэлэх гэж үү? Энэ бодол түүнийг инээмсэглэхэд хүргэлээ.

Харрийн Дурслийнхантай амьдрах болсон цорын ганц шалтгаан бол Волаан-де-Морт билээ. Хэрвээ Хар лорд байхгүй байсан бол духан дээрх цахилгаантай төстэй сорви нь байхгүй байлаа. Хэрвээ Волаан-де-Морт байхгүй байсан бол эцэг эх нь амьд байх байсан юм...

Арван нэгэн жилийн өмнө сүүлчийн зуун жилийн хамгийн аугаа хар шидтэн Волаан-де-Морт улам бүр хүчирхэгжиж байлаа. Хар лорд тэр нэгэн шөнө Харригийн гэрт

ирээд эцэг эхийг нь алах үед тэр ердөө л нэг ойтой байсан юм. Волан-де-Морт шидэт саваагаа түүн рүү чиглүүлэн замд нь тээглэсэн олон арван шидтэнийг алсан хараал илгээсэн авч болсонгүй. Бяцхан Харриг алахын оронд эсрэгээрээ түүнийг нь цохижээ. Харри духан дээрээ зүсэгдсэн цахилгаан хэлбэртэй сорвитой хоцорч харин Волан-де-Морт бүх шидэт хүч чадлаа алдан өрөвдөлтэй амьтан болон хувирчээ. Тэр зугтаж одоо Албанийн уулийн хаа нэгтээ байгаа билээ. Түүний дагалдагч нар бууж өгөхөд шидтэний ертөнц чөлөөтэй болон санаа амарч Харри Поттер алдартай болсон юм.

Харри арван нэгэн нас хүрсэн өдрөө шидтэн гэдгээ мэджээ. Мэдээж энэ багагүй гайхамшигтай зүйл байлаа. Хамгийн гол нь түүнийг алдар нэртэй болсон явдал нь зовоож байв. Хогвартсад түүнийг анх удаагаа очих үед эргэн тойрны бүх хүн шивнэлдэн сониучирхсан харцаар харж байв. Тэр одоо үүнд дасчээ. Зуны сүүлчээр Харри дөрөвдүгээр дамжаанд орохоор шилтгээн руугаа буцах юм.

Ахиад хоёр долоо хоног хүлээх үлджээ. Харри өрөөгөө ахин тойруулан харахад төрсөн өдрийн баяр хүргэсэн ил захидал дээр тусав. Тэр тэднийг долоон сарын сүүлчээр дотны анд Рон, Гермиона хоёроос авчээ. Харри тэдэнд сорвиныхоо тухай бичвэл юу хэлэх байсан бол?

Тэгтэл толгойд нь Гермиона Грэйнджерийн сандарсан хоолой чангаар орж ирлээ.

<<Сорви өвдсөн гэнэ ээ? Харри энэ бол их ноцтой зүйл шүү... Одоохон профессор Дамблдор бич! Харин би <<Ид шидийн ердийн өвдөлт болон эмгэгүүд>> номонд харъя. Тэнд хараалаар үүссэн сорвины талаар ямар нэгэн зүйл байж магадгүй...>>

Тиймээ Гермионагийн бодол ийм л байх байсан. Хогвартсын захиралд бичих юм уу номноос үзэх. Харри цонхоор хилэн хар тэнгэр лүү харлаа. Тэр ном тус болж чадна гэдэгт эргэлзэж байв. Харри Волан-де-Мортын хараалын дараа амьд үлдсэн цорын ганц хүн гэдэг нь тодорхой болохоор шинж тэмдэг нь <<Ид шидийн ердийн өвтөлт болон эмгэгүүд>> номд байхгүй нь мэдээж. Захиа бичихийн тухайд Харрид Дамблдор зуны амралтаа хаа өнгөрүүлж байгаа талаарх төсөөлөл байсангүй. Тэр хормын турш Дамблдорыг урт мөнгөн сахал, шидтэний жанч, шовгор бүрх малгай бүхий далайн эрэг дээр хэвтээд махигар урт хамартаа тос түрхэж байна гэж төсөөлөн баяслаа. Гэхдээ Дамблдор хаа ч байлаа гэсэн Хэдвиг олох л болно. Түүний ууль хаягийг нь мэдэхгүй ч гэлээ захиа хүргэхгүй байсан удаа байхгүй юм. Дараагийн асуулт юу бичих вэ?

Хүндэт профессор Дамблдор.

Тух алдуулсан явдалд уучлал хүсье гэхдээ өнөө өглөө миний сорви өвдлөө.

Таныг хүндэтгэсэн, Харри Поттер

Тэр ч байтугай толгой дотор хүртэл энэ үгнүүд тэнэг сонсогдож байлаа.

Харри өөрийнхөө бас нэг сайн анд болох Рон Уизлигийн юу хэлэхийг төсөөлөв. Түүний бодолд шаргал үс хамар дээрээ сэвхтэй Роны мэл гайхсан төрх харагдав.

<<Чиний сорви өвдсөн гэнэ ээ? Гэхдээ... Хэцүү нэрт ойрхон байх боломжгүй биз дээ. Би үүнийг чи шууд мэдэх байсан гэж хэлэх гэсэн юм. Тэр гарцаагүй чамайг дайрах

гэж байгаа байх. Хараалаар үүссэн сорвиуд үргэлж өвддөг эсэхийг мэдэхгүй юм... Аваас асуухаас...>>

Ноён Уизли бол насанд хүрсэн бүрэн боловсролтой шидтэн юм. Тэр ид шидтэний яаманд эгэлчүүдийн бүтээлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх хэлтэст ажилладаг билээ. Гэхдээ тэр хараал зүхлийн тал дээр Харригийн адил байсан юм. Харри гэнэт инээмсэглэхээ болж зүрх нь шимширлээ. Хатагтай Уизли Гермionaгаас илүү санаа зовж, харин арван зургаан настай ихэр ах дүүс болох Фред, Жорж хоёр Харриг түгшиж байна гэж бодох болно. Уизлигийнхан Харрийн хамгийн дуртай гэр бүл байлаа. Өнөөдөр биш ч тэд түүнийг зочлохоор урина гэж Харри найдаж байв (Рон ямар нэгэн квиддичийн Дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээний тухай яриад байсан даа). Тэр зочлолтоо ямар нэгэн сорвины өвдөлтөөс болж тасалдуулахыг хүсэхгүй байв.

Харри духаа хуруугаараа үрлээ. Дэргэд нь эцэг эхийнх нь адил (энэ тухай бодохдоо өөрөөсөө ичив) насанд хүрсэн шидтэн байгаасай гэж ямар их хүснэ вэ. Ямар нэгэн зөвөлгөө авахад тэнэг хүн шиг харагдахааргүй түүний төлөө санаа тавьдаг хар шидийн туршлагатай...

Тэгтэл нэг санаа төрлөө. Ямар амархан байсан хэрэг вэ! Тэр яагаад энэ тухай өмнө бодоогүй юм бол! Сириус.

Харри орноосоо үсрэн босоод ширээний ард суун хуудас цаас гаргаж ирээд бүргэдийн өдөн үзгээ бэхэнд дүрэн <<Хүндэт Сириус>> гэж бичсэнээ зогсов. Юу гэж бичвэл түгшээхгүй байх бол? Тэр яагаад шууд Сириусын тухай бодоогүй нь гайхалтай юм? Гэхдээ нөгөө өнцгөөс бол Сириус түүний загалмайлан эцэг гэдгийг ердөө хоёр сарын өмнө мэдсэн болохоор гайхах явдалгүй байлаа.

Сириус Харригийн амьдралд оролцоод удаагүй шалтгаан жирийн байсан юм. Тэр энэ бүх хугацаанд сэтгэл хөдлөл сордог Дементоруудаар хамгаалагдсан шидтэнгүүдийн аймшигтай шорон Азкабанд хоригдож байсан бөгөөд түүнийг шоронгоос зугтахад нь Дементоруудыг Хогвартс руу илгээсэн билээ. Сириус аллагад буруугүй байсан бөгөөд түүнийг Волан-де-Мортын туслагч Сүүлт үйлдсэн байсан юм. Бүгд Сүүлтийг үхсэн гэж боддог хэдий ч Харри, Рон, Гермiona гурав амьд гэдгийг нь өнгөрсөн жил өөрийн нүдээр харжээ. Тэдэнд зөвхөн Дамблдор итгэсэн болно.

Сириус сайн нэрээ сэргэхээр хамт амьдрахыг санал болгосон учир Харрийн амьдралд гайхамшигтай мөч болж Дурслийнхнаас явах нь гэж итгэж байлаа. Гэвч энэ найдлага биелсэнгүй. Тэд Сүүлтийг ид шидийн яаманд барьж өгч чадаагүй бөгөөд тэр ахин булгаж Сириуст зугтаж амиа аврах хэрэг гарчээ. Тэр Хогвартсаас Ключокрыл гэдэг гиппогрифын нуруун дээр суун нисчээ. Үүнд нь Харри, Гермiona хоёр тусалсан байна. Одоо Сириус зугтаж байгаа. Харри гэртээ байх хугацаандаа бүхэл зуны турш Сүүлтийг яаж барих тухай бодсоор өнгөрөөжээ. Тэднийг үүрд орхих боломж ойрхон байхад Дурслийнд буцаж ирэх нь хоёр дахин хүнд байлаа.

Гэхдээ Сириус дэргэд нь байхгүй хэдий ч тусалж байв. Зөвхөн түүний ачаар Харри унтлагын өрөөнд сургуулийн бүх шидэт хэрэгслүүдээ авчирсан билээ. Урьд нь энэ

хатуу хориотой байсан юм. Түүний эд зүйлсийг цоожилж зовоох нь ид шидээс айх олон айдсын нэг юм. Ийм учраас л зун болгон түүний чемоданыг сурах бичиг, шүүр бусад хэрэгслийн хамтаар шатны доод талын хонгилд хийгээд цоожилчихдог байсан юм. Гэхдээ Харригийн загалмайлан эцэг нь аюултай алуурчин гэж мэдсэнээс хойш Дурслийнхан бодлоо өөрчилжээ. Харри мэдээж тэдэнд Сириусыг буруугүй гэдгийг хэлэхээ мартчихсан аж.

Сириусаас энэ зун хоёр захиа ирсэн бөгөөд хоёуланг нь ууль биш хурц солонгорсон өнгөтэй том халуун орны шувуу авчирчээ. Хэдваг гялалзсан урилгагүй зочиддоо таагүй хандаж замд гарахаас нь өмнө савнаасаа ус уулгахыг дургүйхэн зөвшөөрсөн байна. Харин Харрид тэд их таалагдаж дал мод цагаан элс бүхий эрэг төсөөлөгдөж байв. Сириус хаа нэгтээ (гэнэт захиа алдагдаж магадгүй болохоор тэр хэзээ ч энэ тухай бичиж байсангүй) муугүй газар байгаа бололтой. Ямар ч байсан гэсэн Дементорууд хурц наранд удаан тэсэж чадахгүй. Магадгүй тийм учраас л Сириус өмнө зүг руу явсан биз. Түүний захиа орон дорх шалны сул хавтан дор нуугаастай байгаа. Захиа хөгжилтэй Сириусыг санагдуулах агаад хоёуланд нь хэрэг гарвал бичээрэй гэсэн байсан юм. Тэгэхээр боломжыг одоо л ашиглах хэрэгтэй...

Чийгтэй саарал өглөөний нарны бүүдгэр туяанд ширээний гэрэл бүдгэрч эхлэв. Эцэст нь нарны алтан цацраг өрөөний ханыг гийгүүлэх үед Вернон ах, Петунья эгч унтлагын өрөөндөө явах чимээ сонсогдов. Харри жижиглэж урсан захиагаа хогийн саванд хаяад өөр хувилбараар бичиж эхлэв.

Хүндэт Сириус.

Захиа явуулсанд чинь баярлалаа. Чиний шувуу том болохоор миний цонхоор арайхийн багтан орж ирсэн.

Энд бүх зүйл хэвийн байна. Дадлигийн хоолны дэглэм баримтлах оролдлого тийм ч сайн болоогүй. Өчигдөр нагац эгч маань түүнийг өрөө рүүгээ нууцаар боов зөөж байхад нь барьчихсан. Эцэг эх нь ахиад ийм явдал давтагдах юм бол халаасны мөнгийг нь хасна гэж хэлсэн болохоор Дадли уурандаа цонхоор playstation-ээ гаргаад шидчихсэн. Энэ бол компьютерийн тоглоом тоглодог зүйл байгаа юм. Хамгийн тэнэг нь тэр одоо уураа гаргах Супперени-III гүй болчихсон.

Миний бүх зүйл хэвийн. Дурслийнхан чамайг гэнэтхэн миний гуйлтаар ирээд тэднийг сарьсан багваахай болгоод хувиргачих вий гэхээс их айдаг.

Гэхдээ өнөө өглөө ойлгомжгүй зүйл боллоо. Ахиад л миний сорви өвдсөн. Өнгөрсөн удаа Хогвартсад Волан-де-Морт ирэх үед өвдсөн ч одоо түүнийг ойрхон байгаа гэж бодохгүй байна. Чи хараал зүхлээр үүссэн сорви олон жилийн дараа өвддөг эсэх талаар сонссон уу?

Би захиагаа Хэдвагээр явууллаа. Тэр одоо анд гарсан бөгөөд удахгүй эргэж ирнэ. Ключикд мэнд хүргээрэй.

Харри.

Болчихлоо гэж Харри бодов. Ямар ч зүүдний талаар байхгүй болохоор Сириус түүнийг хэтэрхий түгшчээ гэж бодох болно. Харри цаасыг хуйлаад ширээний өнцөгт

тавилаа. Удахгүй Хэдвигээр явуулна. Тэр сандлаасаа босож ахин шүүгээгээ онгойлгоод тусгалаа харалгүйгээр хувцаслан өглөөний цайндаа явлаа.

БҮЛЭГ 3: УРИЛГА

Харриг гал тогоонд орох үед бүх гурван Дурслийнхан ширээ хэдийн тойрон сууж байсан ч түүнийг нүднийхээ булангаар ч тоож харсангүй. Вернон ахын том улаан нүүр өглөөний <<Дейли Мейл>> сонины цаана халхлагдаж, харин Петунья эгч морь шиг том шүдээ нуун уруулаа жимийгээд зүржийг дөрвөн хэсэг болгон маш анхааралтай хувааж байв.

Дадли уурлаж дүнсийсэндээ ердийнхөөс их зай эзлэн сууж байх шиг санагдана. Энэ нь түүний дөрвөлжин ширээний нэг талыг ганцаараа эзэгнэн сууж байгааг хэлээд өгч байлаа. Петунья эгч тавган дээр чихэргүй зүржийн дөрөвний нэг хэсгийг тавьж өгөөд эмээсэн янзтай <<Үүнийг чамд Дадли, хонгор минь>> гэж хэлэхэд тэр хорсолтой харснаас өөр зүйл хийсэнгүй. Тэр амралтаараа жилийн эцсийн дүнгийн дүгнэлттэйгээ ирснээс хойш амьдралд нь таагүй явдлууд тохиолдож эхэлжээ.

Вернон ах, Петунья эгч хоёр түүний муу үнэлгээг цагаатгах арга үргэлж олдог байсан юм. Петунья эгч ердийнхөөрөө Дадли бол их авъяаслаг хүүхэд бөгөөд багш нар түүнийг ойлгохгүй гэсэн бол харин Вернон ах <<Надад хичээл хийдэг эмзэгхэн хүү хэрэггүй>> гэж хэлжээ. Тэд Дадлигийн дээрэнгүй занг ч гэсэн өмөөрөх шалтаг олсон байна. <<Тэр хөдөлгөөнтэй хэдий ч ялаа гомдоохооргүй хүүхэд!>> гэж Петунья эгч нулимс мэлтэгнүүлэн хэлжээ.

Хэдий тийм боловч дүгнэлтийн доод талд сургуулийн сувилагчаас хэдэн оновчтой эелдэг тайлбар явуулсныг Вернон ах, Петунья эгч хоёр цагаатгаж чадсангүй. Петунья эгч хичнээн Дадли эрүүл чийрэг том биетэй хүүхэд бөгөөд өсөж буй бие организмд хоол их хэрэгтэй гэж байсан ч баримт бол баримтаараа үлдэж сургуулийн хамгийн том дүрэмт хувцас ч таарахаа больжээ. Сургуулийн сувилагч Петунья эгчийн ханан дээр гарсан хурууны хээ болон хөршүүдийнхээ орж гарсныг хардаг хурц нүдний ажиглаагүй зүйлийг олж харжээ. Нэмэлт хоол Дадлиг бүдүүлгээр хэлбэл халимны зулзагын хэмжээнд хүргэхээр таргалуулсан байлаа.

Сувилагчийн явуулсан зурвасын дараа болсон олон уур цухал бүхий хэрүүл шуугианд Харригийн өрөөний шал доргиж, Петунья эгч нулимс урсган байж шинэ дэглэм тогтоожээ. Сувилагчийн явуулсан хоолны дэглэмийн дагуу хөргөгчнөөс Дадлигийн дуртай бялуу, хийжүүлсэн ундаа, шоколад, хачиртай талхыг авч хаян оронд нь Вернон ахын <<туулайн хоол>> гэж нэрлэдэг жимс, ногоогоор дүүргэжээ. Дадлиг тайвшируулахын тулд Петунья эгч гэр бүлээрээ хоолны дэглэм барихаар шийдсэн байна. Ийм учраас Харри өглөөний хоолондоо зүржийн дөрөвний нэг хэсэг болох үеэл ахынхаа тавган дээрхээс хоёр дахин жижигхэн зүсмийг авлаа. Петунья эгч Дадлигийн муухай аашийг хөдөлгөхгүйн тулд Харригийнхаас их хоол өгөхөөр бодсон бололтой.

Гэвч Петунья эгч Харригийн өрөөний шалны нууц хавтан дор юу нуугаастай байгааг мэдэхгүй. Тэр Харриг хоолны дэглэм баримтлахгүй байгаа гэж төсөөлөх ч үгүй байв. Харри бүх зуны турш зөвхөн лууван идэж өнгөрөөхөө мэдэнгүүтээ Хэдвигийг андууд руугаа тусламж эрэн илгээжээ. Тэгтэл итгэмээргүй амжилт олсон байна. Гермionaгийн гэрээс Хэдвиг эргэж ирэхдээ том хайрцагтай чихэргүй зууш

(Гермионагийн эцэг эх нь шүдний эмч) авчирчээ. Харин Хогвартсын ойн сахиул Хагрид бүтэн шуудай өөрийн гараар хийсэн чулуу шиг хатуу жигнэмэг явуулжээ (Түүнд Харри гар хүрсэнгүй. Тэр Хагридын хоол хийх авъяасыг хэтэрхий сайн мэдэх аж.) Хатагтай Уизли гэр бүлийн уулиар аварга том жимсний бялуу болон хуушуур явуулжээ. Хөөрхий Сум хэтэрхий хөгшин болохоор хүнд аялалынхаа дараа таван өдөр амарч хүчээ сэргээх хэрэг гарлаа. Харин төрсөн өдрөөрөө Харри (Дурслийнхан юу ч өгөөгүй байна) Рон, Гермиона, Хагрид, Сириус нараас шууд дөрвөн гайхамшигтай сайхан бялуу авчээ. Хоёр нь бүтэн байгаа болохоор дээшээ гараад сайхан өглөөний цай ууна даа бодсоор Харри зүржийг авлаа.

Вернон ах сонингоо хажуудаа тавиад зүржийн дөрөвний нэг хэсэг руу муухай харлаа.

- Ингээд болоо юу? гэж тэр бувтналаа.

Петунья эгч түүн рүү ширүүн хараад өөрийн хэсгээ дуусгаад Харригийн дөрөвний нэг хэсэг рүү жижигхэн тооройн нүдээр ширтэж буй Дадли руу толгой дохив.

Вернон ах санаа алдан өтгөн сахлаа сөргүүлэн илбэнгээ сэрээ авлаа.

Хаалганы хонх дуугарлаа. Вернон ах сандлаасаа босоод үүд рүү явав. Ээжийгээ цахилгаан зуухан дээр данх тавих зуур Дадли гялсхийн эцгийнхээ үлдээсэн зүржийг хулгайлав.

Үүдэнд хэн нэгний яриа сонсогдож инээх чимээ гарснаа Вернон ахын бухимдсан дуу гарав. Үүдний хаалга хаагдах үед цаас ураг чимээ гарав.

Петунья эгч ширээн дээр данхаа тавиад Вернон ахыг хаачсаныг гайхан ийш тийшээ харав. Түүнийг удаан хайх хэрэг гарсангүй. Хормын дараа тэр уурласандаа улайн орж ирлээ.

- Чи! Зочны өрөө рүү! гэж тэр Харриг зандарлаа.

Гайхширсан Харри босоод Вернон ахыг дагалдан зэргэлдээх өрөө рүү орлоо.

- Тэгэхээр... гээд Вернон ах хаалга хаагаад ширүүн алхаагаар зуухны өмнө холхих зуураа Харриг баривчлах гэж буй мэдэгдэл хийж байгаа аятай эргэн хараад,

- Тэгэхээр гэлээ.

<<Тэгэхээр яасан юм бол?>> гэж Харри бодсон ч нагац ахыгаа өлсгөлөн ууртай байхад нь асууж зүрхэлсэнгүй. Харин эелдэг тааварлангуй царай гаргахыг хичээв.

- Сая энэ захиа ирлээ. Чиний тухай гээд Вернон ах ягаан өнгийн хуудас цаасыг Харригийн урдуур сүрдүүлэн зангав.

Харри мэгдэн сандрахаа мэдэрчээ. Вернон ахад хэн түүний тухай бичдэг билээ? Бас ердийн шуудангаар шүү.

Вернон ах Харри руу уурсан харснаа чанга уншлаа.

Хүндэт ноён болон хатагтай Дурсль!

Бид бие биенээ танихгүй ч Харригаас миний хүү Роны талаар багагүй сонссон гэдэгт би итгэлтэй байна.

Харри дараагийн долоо хоногийн даваа гаригийн үдэш болох квиддичийн Дэлхийн цомын тэмцээний талаар ярьсан байх л даа. Миний нөхөр Артур ид шидийн спорт тоглоомын хэлтэс дэх хэлхээ холбоогоо ашиглан маш сайхан тасалбар авсан.

Харриг бидэнтэй хамт явахыг зөвшөөрнө гэдэгт итгэж байна. Ийм боломж амьдралд ганц л удаа тохиолдоно. Англид Дэлхийн цомын тэмцээн гучин жил зохиогдоогүй болохоор тасалбар олж авах нь маш хэцүү хэрэг юм. Мэдээж Харри бидэнтэй зуны амралтын үлдсэн хэсгээ өнгөрүүлвэл бид баярлах болно. Бид түүнийг галт тэргэнд суулгаж өгөх болохоор санаа зовох хэрэггүй.

Хариуг аль болохоор түргэн илгээнэ үү. Ердийн аргаар илгээвэл зүгээр байна. Учир нь маглуудын шуудан манай гэрт захиаг хүргэж чадахгүйн дээр хаана байдгийг нь ч мэдэхгүй байх.

Харриг удахгүй харна гэдэгт найдаж байна

Таныг хүндэтгэсэн Молли Уизли.

Жич: Бид хангалттай марк наасан гэж найдна.

Вернон ах уншиж дуусаад дуусгаад гараа энгэрийн халаасандаа шургуулан ямар нэг зүйл гаргаж ирэв.

- Үүнийг хар гэж тэр архираад хатагтай Уизлигийн илгээсэн дугтуйг сунгалаа.

Харри инээдээ арайхийн барьж тэслээ. Дугтуйны нүүрэн талд хатагтай Уизлигийн жижигхэн бичгээр Дурслийн хаягийг бичсэн зайг эс тооцвол дүүрэн марк наасан байлаа.

- Хангалттай марк наасан юм байна шүү дээ гэж Харри ийм алдааг хэн ч хийж болох мэтээр хэлэв. Вернон ахын нүд гялалзлаа.

- Шууданч үүнийг ажиглаад захиа хаанаас ирснийг ихэд сонирхсон. Ийм учраас хонходсон юм. Тэр түүнийг хөгжилтэй гэж бодсон юм билээ гэж шүд зуун хэллээ.

Харри юу ч хэлсэнгүй. Магадгүй хэн ч Вернон ахын олон маркны төлөө дэгдээж байгаа шуугианыг ойлгохгүй байсан хэдий ч Харри Дурслийнхантай хэтэрхий удаан амьдарсан болохоор хэвийн бус зүйл тэднийг галзууртал нь уурлуулдагыг мэднэ. Тэд энэ дэлхий дээр юунаас ч илүү хэн нэгэн хатагтай Уизли шиг хүмүүстэй холбоотой эсэхийг мэдчих вий гэхээс айдаг юм.

Вернон ах Харри руу уурсан харахад тэр бүх хүчээ гарган гэмгүй царайлахыг хичээв. Түүний амьдралд заналхийлж болох учир ямар нэгэн тэнэг юм хэлж болохгүй байлаа. Харри нагац ахыгаа юу хэлэхийг хүлээхэд чимээгүй байсан хэвээр зээгээ ууртай харцаар ажиглана.

- Тэгэхээр би явж болох уу гэж эцэст нь Харри нам гүмийг эвдэн асуув.

Вернон ахын хүрэн улаан царай таталдахад сахал нь өрвийлөө. Энэ сахалны цаана түүний явах эсэх талаар бодож байгааг Харри мэдэж байв. Нагац ахынх нь хамгийн

гол бодлууд зөрчилдөж байлаа. Харриг явахыг зөвшөөрөх нь түүнийг жаргалтай болгох учраас Вернон ахын арван гурван жил тэмцэж байгаа зүйл ашиггүй болно. Гэтэл нөгөө талаас хоёр долоо хоногийн өмнө явах нь түүний гэр бүлийг жаргалтай болгоно. Дурслийнхан Харриг гэртээ байхыг тэвчдэггүй байсан юм. Тэрбээр эсрэг тэсрэг зөрчилд автан хатагтай Уизлигийн захиаг ахин харлаа.

- Энэ юун эмэгтэй вэ? гэж тэр гарын үсгийг зэвүүцэнгүй харж асуув.

- Та түүнийг харсан шүү дээ. Миний найз Роны ээж нь байгаа юм. Биднийг Хог... сургуулийн галт тэрэгнээс буухад угтан авч байсан.

Тэр золтой л <<Хогвартс Экспресс>> гээд хэлчихсэнгүй. Энэ нь нагац ахыг нь уурлуулах байлаа. Дурслийнхан хэзээ ч сургуулийнхаа нэрийг чанга хэлэхийг тэвчдэггүй юм.

Вернон ах ямар нэгэн таагүй зүйл санасан мэт ярвайлаа.

- Бүдүүн авгай юу үү? Шаргал үстэй хүүхдүүд дагуулсан? гэж тэр эцэст нь хэлэв.

Харри хөмсөг зангидав. Хэн нэгнийг бүдүүн гэж нэрлэх ёстой бол түүний хүү Дадлид гурван настайгаас нь хойш байх ёстой хэмжээнээсээ илүү өргөн болох аюул үргэлжид заналхийлж байсан!

Вернон ах захиаг ахин анхааралтай уншлаа.

- Квиддич. Квиддич... Энэ юу гээчийн дэмий зүйл вэ? гэж тэр бувтналаа.

Харри уур ахиад л хүрлээ.

- Спорт байгаа юм. Шүүрэн дээр тоглодог...

- Болно, болно! гэж Вернон ах яаран түүний яриаг таслав.

Харри нагац ахыгаа бухимдаж эхлэхийг баясан ажиглалаа. Түүний мэдрэл зочны өрөөнд <<Шүүр>> мэтийн үг гарахыг тэсэхгүй нь ойлгомжтой байв. Харри уруулынх нь хөдөлгөөнөөр юу уншиж буйг нь ажиглав. <<Ердийн аргаар илгээсэн нь дээр байх>>. Вернон ах хөмсгөө өргөлөө.

- Ердийн аргаар гэдэг нь юу гэж байгаа юм? гэж тэр тургилав.

- Бидний хувьд ердийн гэж Харри тайлбарлалаа. Тэгээд нагац ахыгаа зогсоохоос өмнө амжиж,

- Та уулийн шууданг мэднэ шүү дээ. Шидтэнгүүдийн хувьд ердийн зүйл байгаа юм гэж хэлэв.

Вернон ах Харриг аймшигтай хараал хэлсэн аятай дүрсхийлээ. Уурсаж чичирсэн тэрбээр хөршийн хэн нэгэн шилэнд чихээ наагаад сонсож байгаа аятай цонх руу харлаа.

- Чамд хичнээн удаа миний гэрт ёсноос гажууд үг хэлж болохгүй гэж сануулах юм бэ? Чи одоо энд Петунья бид хоёрын ач санадаггүй мөрөнд чинь углаж өгсөн хувцастай зогсож байна! гэж тэр зандрахад нүүр нь чавга шиг улаан болсон байв.

- Дадлигийн өмсөж дуусгасны дараа шүү дээ! гэж Харри хүйтнээр хэллээ. Үнэндээ түүний цамц хэмжээнээсээ тав дахин том байлаа. Өвдөг шүргэх шахам урт ханцуй нь хоёр дахин урт, харин жинсэн өмд нь шуудай өмсчихсөн юм шиг харагдана.

- Надтай ийм өнгөөр битгий ярь! гэж тэр дэлбэрлээ.

Гэвч Харри дуугүй байж тэвчсэнгүй. Өдөр хоногуудыг тэр Дурслийн тэнэг дүрэм журмыг баримтлан өнгөрүүлсээр ирсэн билээ. Тэр хоолны дэглэмийн тухайд Вернон ахтай маргалдаагүй ч Дэлхийн цомын тэмцээн рүү явахыг нь хорихыг хүссэнгүй. Тэгээд гүнзгий амьсгал аваад,

- За яахав, тэгвэл би Дэлхийн цомын тэмцээнийг харахгүй юм байж. Гэвч одоо явж болох уу? Загалмайлсан эцэг Сириустээ бичиж байгаа захиагаа дуусгах хэрэгтэй байна л даа... гэлээ.

Тэр шидэт үг хэлжээ. Вернон ахын нүүрэн дээр улаан толбонууд гарч ирэхэд муухан хутгасан жимсний зайрмагтай төстэй боллоо.

- Чи... түүнд... захиа бичиж байгаа юм уу? гэж тэр аль болох тайван хоолойгоор хэлсэн ч жижигхэн нүдэнд нь айдас хурсан харагдав.

- Тэгэлгүй яахав. Түүнд удтал бичсэнгүй. Тэр надаас юм сонсохгүй удах юм бол гэнэт ямар нэгэн юм тохиолдсон гэж бодож болох юм...

Тэгээд энэ үгийнхээ үзүүлсэн нөлөөнд баясан зогслоо. Тэр Вернон ахын нямбайлан хагалж самнасан өтгөн үсний дор эргэлдэж байгаа жижигхэн араануудыг бараг л харлаа. Хэрвээ Харриг захиа бичихийг хоривол аюултай гэмт хэрэгтэн түүнийг муу байгаа гэж бодно. Хэрвээ түүнийг Дэлхийн цомын тэмцээн рүү явуулахгүй бол Харри энэ тухай бичих болохоор түүнд муу байгааг бас мэдэх болно. Ердөө ганц гарц үлджээ. Харри нагац ахынхаа тархинд шийдвэр гарч харлаа. Түүнд хайхрамжгүй байдлаа хадгалахын тулд хүчээр инээмсэглэх хэрэг гарчээ. Эцэст нь...

- За яахав. Тэгвэл... наад тэнэг... Дэлхийн цомын тэмцээндээ явж болно. Явж энэ Уизлид чамайг эндээс авч болно гэж бич. Надад чамайг бүх орон даяар зөөж байх зав алга. Тэндээ зуныхаа үлдсэн амралтыг өнгөрүүлээрэй. Өөрийнхөө... загалмайлсан эцэгт... явах болсноо... хэлнэ биз.

- Баярлалаа гэж Харри баясан хэлэв.

Тэр эргээд зочны өрөөний хаалгаар гарахдаа дэвхцэх хүслээ арай ядан барилаа. Тэр явах нь байна... Уизлигийнх руу явах нь байна! Квиддичийн Дэлхийн цомын тэмцээн рүү явах нь байна!

Үүдний өрөөнд тэр аав нь хэрхэн Харриг хараахыг сонсоно гэж найдан зогсож байсан Дадлитай тааралдав. Харригийн нүүр дүүрэн инээмсэглэсэн царайг хараад тэр цочирдох шиг болов.

- Өглөөний хоол гайхалтай байсан шүү. Би бараг цадсан. Харин чи? гэж Харри асуулаа.

Гайхсан үеэл ахаа хараад Харри инээсээр өрөөндөө орохоор гурван гишгүүр алгасан харайлаа.

Түүнийг тэнд Хэдваг хүлээж байв. Тэр торон дотроо суугаад том хуван нүдээрээ ширтэн таагүйхэн хошуугаа тас няс хийлгэв. Түүнийг уурлуулж байсан зүйл даруйхан ил болов.

- ЁО! гэж Харри одон бөмбөг шиг жижигхэн саарал өдтэй зүйл нисэн ирээд толгойг нь мөргөхөд дуу алдав.

Харри толгойгоо үрээд дээшээ харвал алганд багтмаар жижигхэн ууль галын наадам хийж байгаа аятай хөөрөн нисэж байлаа. Шалан дээр захидал уналаа. Харри бөхийхдөө Роны бичгийг танилаа. Дотор нь сараачин бичсэн зурвас байв.

Харри! ААВ БИЛЕТ АВСАН! Даваа гаригийн орой Ирланд Болгарын эсрэг тоглоно. Ээж чамайг амралтын төгсгөл хүртэл манайд үлдээх зөвшөөрөл авахын тулд маглуудад захиа бичсэн. Тэд хэдийн захиаг авсан байх. Маглуудын шуудан хэр түргэн ажилладагыг мэдэхгүй юм. Захиаг Гахайгаар явууллаа.

<<Гахай гэнээ?>> Харри адрын доогуур чийдэнгийн бүрхүүл тойрон нисэж байгаа жижигхэн уулийг харлаа. Гахайтай огт төсгүй юм. Тэр Роны бичгийн хэвийг гаргаагүй юм болов уу? Харри захиаг эргэн уншлаа.

Маглуудад таалагдах ч бай үгүй ч бай бид чамайг авахаар очих болно. Чи Дэлхийн цомын тэмцээнийг алгасаж болохгүй шүү дээ. Гэхдээ ээж, аав хоёр ямар ч л гэсэн тэднээс зөвшөөрөл асуусан нь дээр гэж бодсон юм. Хэрвээ тэд зөвшөөрвөл Гахайгаар хариу явуулаарай. Ням гаригийн таван цагаас чамайг авахаар очье. Хэрвээ тэд үгүй гэж хэлэх юм бол бас захиа явуулаарай. Бид ням гаригийн таван цагаас чамайг авахаар очих болно.

Гермиона өнөөдөр үдээс хойш ирнэ. Перси олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтэст ажилд орсон. Энд байхдаа үхтлээ уйдахыг хүсээгүй бол гадаадын талаар бүү яриарай.

Удахгүй уулзая

Рон

Жижигхэн ууль ахин толгой дээгүүр нь галзуурсан аятай эргэлдэв. Магадгүй захиа хүргэж өгсөндөө их бахархаж байгаа байх.

- Алив зогс л доо! Нааш ир. Ронд хариуг нь аваачиж өг! гэж Харри хашгирлаа.

Ууль Хэдвагийн торон дээр буулаа. Тэр зочноо ойртож зүрхлэхээргүй хүйтнээр харлаа!

Харри бүргэдийн өдөн үзгээ авч шинэ хуудас цаасан дээр бичлээ.

Рон бүх зүйл хэвийн. Маглууд намайг явж болно гэж хэлсэн. Маргааш таван цагаас уулзая. Хүлээж чадахгүй нь.

Харри

Тэр захиаг жижиг болгон эвхээд баярлан дэвхцэж буй уулийн зүүн сарвуунд арайхийн уялаа. Захидал аюулгүй болмогц ууль цонхоор дэрхийн гарч тэнгэрт хөөрөн үзэгдэхээ болив.

Харри Хэдви́г руу эргэн харлаа.

- Чи удаан хугацааны аялалд бэлэн үү?

Хэдви́г сүр жавхлантайгаар гууглав.

- Үүнийг Сириуст хүргэж өгч чадах уу? Хүлээгээрэй, би хэдэн үг бичээдхэе.

Тэр цаасыг эргүүлээд яаран бичсэн нь,

Би зуны үлдсэн хугацааг найз Рон Уизлигийн гэрт өнгөрүүлэх боллоо. Түүний аав нь бидэнд Дэлхийн цомын тэмцээний тасалбар авсан. Над руу тийш нь бичээрэй.

Тэр захиагаа дуусгаад Хэдви́гийн саварт уялаа. Тэр ховорхон тохиолдох тайван өнгөөр биеэ жинхэнэ шуудангийн уулийн ёсоор авч явлаа.

- Би Роньд байх болно. Шууд тийшээ нисээрэй, ойлгомжтой юу? гэж Харри хэллээ.

Тэр хурууг нь зөөлөн тоншоод далавчаа сүр сархийлган дэлгэж онгорхой цонхоор нисэн одлоо.

Харри түүнийг дагуулан хараад орны дорх шалны хавтанг холдуулан нууц газраасаа бялуу гаргаж ирлээ. Тэр шалан дээр суугаад идэхдээ аз жаргалтай байлаа. Түүнд бялуу байхад харин Дадлид зүржээс өөр юу ч байхгүй. Гудамжинд зуны сайхан өдөр болж тэр маргааш Улаан модон гудамжыг орхин сорви нь өвдөхөө больсон болохоор удахгүй квиддичийн Дэлхийн цомын тэмцээнийг харах нь байна. Санаа зовох юмгүй болохоор лорд Волан-де-Мортын тухай мартах болно.

БҮЛЭГ 4: ҮҮРЭНД БУЦАЖ ИРСЭН НЬ

Маргааш нь арван хоёр цагаас Харри том модон чемодандаа сургуулийнхаа бүх хэрэгсэл болон хамгийн үнэт зүйл болох эцгээс нь өвлөгдөн ирсэн үл үзэгдэх жанч, Сириусын бэлэг болох <<Аянга>>, өнгөрсөн жил Фред, Жорж хоёрын бэлэглэсэн шидэт газрын зургийн хамтаар хийжээ. Харри орны дорх нууц газраасаа нөөц хүнсээ хоосолж, хоёр ч удаа унтлагын өрөөний хаа нэгтгээ ном, үзэг үлдсэн эсэхийг шалгаад, хананаасаа Хогвартс явах есөн сарын нэгэн хүртэл өдрийг тэмдэглэж байсан хуанлиг хуулан авлаа.

Улаан модон гудамжны дөрвөн тоот байшинд уур амьсгал хурцадмал болов. Айсуй ирэх гэж буй бүлэг шидтэнгүүд Дурслийнхны уурыг нь хүргэж байв. Харри Уизлигийнхан түүнийг авахаар маргааш үдээс хойш таван цагаас ирэхийг хэлсэн цагаас хойш Вернон ах илт түгшиж байлаа.

- Чи тэднийг жирийн хувцас өмсөөрэй гэж хэлсэн биз дээ. Би та нарын ямар новш өмсдөгийг харсан шүү. Тэднийг ёс журамтай хүмүүс шиг хувцасласан нь дээр гэх гэсэн юм.

Харрийн сэтгэл санаа таагүй боллоо. Ноён ба хатагтай Уизлид Дурслийнхны жирийн гэж дуудах хувцас ховорхон байлаа. Тэдний хөвгүүд амралтаараа маглуудынх шиг хувцас өмсдөг ч ноён ба хатагтай Уизли ихэнхдээ элэгдэж хуучирсан урт жанч өмсдөг юм. Харри хөршүүд юу гэж хэлэх бол гэдгээс санаа зовсонгүй. Харин Дурслийнхан шидтэний тухай бүх муу төсөөллийг шингээсэн Уизлигийнханд хэр бүдүүлэг хандах бол гэхээс санаа зовж байлаа.

Вернон ах хамгийн шилдэг костюмаа өмсчээ. Энэ нь зарим хүмүүст зочныг угтаж буйн дохио мэт харагдаж болох ч гэсэн айлган сүрдүүлсэн төрхтэй харагдахыг хүссэн болохыг Харри мэдэж байв. Дадли эсрэгээрээ жижгэрсэн юм шиг харагдаж байлаа. Хоолны дэглэм ингэж нөлөөлсөн хэрэг биш л дээ. Сүүлчийн удаа насанд хүрсэн шидтэнтэй уулзсан явдал түүнд тооройн сүүл бэлэглэсэн бөгөөд өмдийг нь цоолон ургасан билээ. Вернон ах, Петунья эгч хоёр түүний сүүлийг Лондонгын хувийн эмнэлэгт очиж авхуулсан юм. Түүний түгшсэн шинжтэй дайсандаа бай үзүүлэхгүй мэт ар талаа барьж өрөөн дотуур явж байгаад нь гайхах юмгүй байлаа.

Өдрийн хоол чимээгүйхэн өнгөрөв. Дадли хүртэл хоолыг эсэргүүцсэнгүй (гэрийн бяслагтай, үрсэн байцаа). Петунья эгч бараг юу ч идсэнгүй. Тэрбээр цээжиндээ гараа зөрүүлэн хөмхийгөө зуугаад Харриг хашгичин загнахгүйн тулд хэлээ хазсан мэт байлаа.

- Тэд машинаар ирнэ биз дээ? гэж Вернон ах ширээний цаанаас зандчив.

- Э-э-э гэж Харри түгдэрлээ.

Үнэнийг хэлэхэд энэ тухай огт бодсонгүй. Уизлигийнхан ийшээ яаж ирэх юм бол? Хуучин <<Англи>> гэдэг загварын форд нь Хориотой ой дотуур тэнэж байгаа болохоор тэдэнд машин байхгүй байлаа. Өнгөрсөн жил ноён Уизли ид шидтэний яамнаас машин түр авсан. Магадгүй өнөөдөр бас тэгэх юм болов уу?

- Тийм гэж бодож байна хэмээн Харри хэллээ.

Вернон ах тургилав. Ердийн тохиолдолд тэр бусад эрчүүдийг ямар машин унадгаар нь зэрэглэл тогтоодог болохоор ноён Уизлиг ямар машинаар ирэх эсэхийг асуух байсан байх л даа. Гэвч Харрид Вернон ах ноён Уизлиг <<феррари>>-гаар ирсэн ч авч хэлцэхгүй гэсэн сэжиглэл төржээ.

Харри үдээс хойшийг унтлагын өрөөндөө өнгөрүүлээ. Тэр Петунья эгчийн хором бүр зурагтаар сүрэг галзуу хирс зугтсан гэж зарласан аятай гудамж руу хөшигний цаанаас шагайхыг харж тэвчээгүй юм. Эцэст нь таван цагт арван таван минут дутуу байхад Харри зочны өрөөнд орлоо.

Петунья эгч буйдангийн дэр тэгшилж байв. Хари Вернон ах сонин уншиж байгаа дүр эсгэж байсан ч жижигхэн нүд нь нэг цэг рүү төвлөрөн машин ойртон ирэх чимээ гарах эсэхийг анхааралтай чагнаж харагдана. Дадли буйдан дээр суугаад булцгар гараараа өгзөгөө даржээ. Харри өрөөнөөс гарч үүдний өрөөний шатны гишгүүр дээр суугаад цагийн зүү рүү нүд салгалгүй ширтэв. Догдолсондоо болоод зүрхний цохилт нь хурдасчээ.

Таван цаг өнгөрлөө. Өмссөн костюмдаа үл ялиг хөлөрсөн Вернон ах хаалга онгойлгон гудамж руу шагайгаад яаран эргэж харав.

- Хоцорч байна! гэж тэр Харрид бувтналаа.

- Тиймээ. Магадгүй... м-м-м автомашины бөглөрөл юм уу эсвэл өөр ямар нэгэн...

Арван хором өнгөрлөө... арван тав... Харри хүртэл түгшиж эхлэв. Хагас цагийн дараа зочны өрөөнд Вернон ах, Петунья эгч хоёрын уурссан дуу хадлаа.

- Ямар ч хүндэтгэл алга.

- Бид зочин шиг урилаа шүү дээ.

- Хэрвээ тэд хоцорвол оройн хоолонд урина гэж бодсон юм болов уу?

- Тэднийг мэдээж урихгүй гэж Вернон ах хэлэв. (Харри түүний зочны өрөөн дундуур холхих чимээг сонслоо). Тэд хүүг аваад шууд явна. Гэхдээ ирэх юм бол шүү дээ. Магадгүй өдрөө андуурсан байх. Иймэрхүү төрлийн хүмүүс цаг баримталж мэддэггүй байж таарна. Эсвэл тэдний ямбий машин замдаа эвдэрч А-А-А-А-А-А-А-А-А-А!

Харри үсрэн бослоо. Зочны өрөөний хананаас дуулдаж буй чимээ Дурслийнхнийг байрандаа хөшин зогсоход хүргэжээ. Дараагийн агшинд өрөөнөөс айсан Дадли нисэн гарав.

- Юу болоод байна? Яасан бэ? гэж Харри дуу алдав.

Гэвч Дадли хэлээ залгисан мэт байлаа. Тэр өгзөгөө базсаар гал зуух руу ухасхийн оров. Харри яаран зочны өрөө лүү орлоо.

Дурслийнхний битүүлсэн ханан зуухнаас чанга нүдэх болон маажлах чимээ гарна. Тэд саяхнаас зочны өрөөндөө хуурамч гал асдаг цахилгаан зуух тавьдаг болсон юм.

- Энэ юу вэ? Энэ юу вэ, Вернон? гэж Петунья эгч амьсгаадан асуугаад зуухны хана руу айдаст автан ширтлээ.

Хормын дараа хаалттай зуухны дотор хоолой сонсогдов,

- Ёо! Фред ухар! Ямар нэгэн алдаа болсон бололтой! Жоржод түүнийг... Жорж, энд ямар ч гарц алга гэж Ронд түргэн хэл...

- Ааваа, Харри биднийг сонсоод гаргаж магадгүй...

Хавтангын цаанаас нударгаар балбах чимээ сонсогдов.

- Харри! Харри чи биднийг сонсож байна уу?

Дурслийнхан Харри руу уурссан нохой зээх аятай эргэн харав.

- Энэ юу вэ? Юу болоод байна? гэж Вернон ах дэлбэрлээ.

- Тэд... тэд ийшээ нисдэг даринь тусламжтай ирэх гэж оролджээ хэмээн Харри галзуутай инээх хүслээ арайхийн дарж хэлэв.

- Тэд зуухны яндангаар дамжин аялж чаддаг юм. Гэхдээ та зуухаа битүүлсэн болохоор... Одоохон, хүлээгээрэй...

Тэр зуух руу очоод ханын модон самбар луу,

- Ноён Уизли! Та намайг сонсож байна уу? гэж хашгирлаа.

Балбах чимээ зогсож яндангын хэсэгт байгаа хэн нэг нь,

- Чшш! гэлээ.

- Ноён Уизли, би Харри байна... Та нар ийшээ орж чадахгүй. Зуух хаалттай!

- Хараал идээсэй! Хэний толгойд зуухыг хаах бодол орж ирдэг байна? гэх ноён Уизлигийн дуу сонсогдов.

- Тэд цахилгаан зуух хэрэглэдэг юм гэж Харри тайлбарлав.

- Тийм гэж үү? хэмээн ноён Уизли хөөрөн хэлээд,

- Цахилгаан гэж чи хэлэв үү? Залгууртай юу? Бурхан минь би үүнийг харах ёстой.. алив бодъё... Ёо, Рон! гэв.

Одоо Роны хоолой бусадтайгаа нэгдлээ.

- Та нар энд юу хийж байгаа юм бэ? Ямар нэгэн буруу зүйл болоо юу?

- Юу гэж дээ, Рон. Энэ биднийг ирэхийг хүссэн газар мөн гэх Фредийн даажигнасан хоолой гарлаа.

- Тийм шүү, бид энд амьдралынхаа хамгийн сайхан мөчийг өнгөрүүлж байна гэж түүнтэй Жорж нэгдлээ. Түүний хоолой барьж аваад хананд шахсан мэт хүчилсэн сонсогдох ажээ.

- Хөвгүүдээ, тайвшир. Би ямар нэг юм бодож олохыг хичээе... Тиймээ... энэ цорын ганц арга бололтой... Харри, хойшоо ухраарай... гэж ноён Уизли хэллээ.

Харри буйдан руу ухарлаа. Вернон ах анхааруулгыг үл тоон урагш алхав.

- Түр хүлээгээрэй! Та нар юу... гэж тэр зуух руу орилов.

ТҮН!

Ханын модон самбар хэсэг болон бутарч шидэгдэхийн хамтаар тоосгоны хэлтэрхий санжигнасан банз дундаас ноён Уизли, Фред, Жорж болон Рон нар гарч ирэв. Петунья эгч муухай орилоод кофены ширээн дээгүүр өнхөрч унахад Вернон ах амжин шүүрч аваад Уизлигийнхан руу мэлрэн харлаа. Бүгд гал шаргал үстэй агаад Фред, Жорж хоёрыг оролцуулаад ч сэвхтэй харагдана.

- Бурханы авралаар гэж ноён Уизли амьсгаадан хэлээд тоос болсон урт ногоон жанчаа гүвэх зуураа нүдний шилээ засаад,

- Аан, та нар Харригийн нагац ах, эгч байх нь! гэв.

Өндөр туранхай халзарч байгаа тэрбээр Вернон ахтай гар барихын тулд урагшаа алхсан хэдий ч цаадах нь Петунья эгчийг чирсээр хойшоо ухарлаа. Дээд зэргийн костюм цагаан тоосонд хучигдан сахал үс нь цагаарсан болохоор тэр хоромхон зуур гучин насаар хөгширсөн харагдав.

- М-м-м... энэ бүхэнд уучлал гуйя гээд ноён Уизли гараа хөдөлгөн эвдэрсэн ханан зуух руу харлаа.

- Энэ бол миний буруу. Миний толгойд ханан зуухны гарцыг хаасан гэсэн бодол огт орж ирсэнгүй... Би Харриг авахын тулд танай сараалжыг ганц өдрийн хугацаатай нээлгэсэн юм. Шуудхан хэлэхэд маглуудын ханан зуухыг нээж өгдөггүй ч нэг танил маань нисдэг даринь сараалжыг зохицуулагч сүлжээнд ажилладаг болохоор надад тусалсан. Би энэ бүхнийг дор нь янзалчих болохоор санаа зовох хэрэггүй дээ. Хөвгүүдийг буцаахын тулд жаахан гал асаахад болно. Би шилжихээсээ өмнө засаад өгнө

Харри Дурслийнхан түүний хэлсэн үгнээс нэгийг нь ч ойлгоогүй гэж тангараглахад бэлэн байлаа. Тэд өмнөхийн адил ноён Уизли руу мэлрэн харцгаана. Петунья эгч Вернон ахын нурууны ард нуугдсан хэвээр.

- Сайн уу, Харри! Чи чөмоданаа зэхсэн үү? гэж ноён Уизли баяртайгаар дуу алдав.

- Дээр байгаа гэж Харри хэлээд инээмсэглэв.

- Бид аваад ирье гэж Фред хэллээ.

Тэрбээр Харри руу нүд ирмээд Жоржын хамтаар өрөөнөөс гарлаа. Ихрүүд Харригийн унтлагын өрөө хаана байрладгийг нэг удаа шөнө тэндээс авах хэрэг гарсан болохоор санаж байлаа. Гэвч Харри Фред, Жорж хоёрыг Дадлиг харахыг хүссэн байх гэж сэжиглэжээ. Тэд түүний тухай Харригаас хэтэрхий олон удаа сонссон юм.

- За тэгэхээр... гэж ноён Уизли хэлээд ичингүйрсэн байртай гараа үрж таагүйхэн нам гүм байдлыг эвдэх үг олохыг хичээн,

- Та нар маш... сайхан газарт амьдардаг юм байна гэв.

Ердийн үед нэг ч толбогүй цэвэр цэмцгэр байдаг зочны өрөө тоос шороо болон хэмхэрсэн тоосгоор дүүрсэн болохоор Дурслийнхан үүнийг муу тоглоомоор хүлээн авчээ. Вернон ахын царай хүрээнтэхэд, Петунья эгч ахин хэлээ зажилж эхлэв. Хэдийгээр тэд ямар нэг зүйл хэлэхийг хүссэн ч их айсан байлаа.

Ноён Уизли эргэн тойрноо харав. Тэр маглуудын хийсэн бүхэнд их дуртай билээ. Харри түүнийг видео тоглуулагч болон зурагтыг ойроос харахыг хүсч байгааг олж харлаа.

- Тэд цахилгаанаар ажилладаг биз дээ? гэж тэр мэддэг дүр эсгэн бахдан хэлээд,

- А-а би залгуур харлаа. Би залгуур цуглуулдаг юм л даа. Бас батарейнууд. Надад батарейны баялаг цуглуулаг бий. Миний эхнэр намайг галзуурсан юм гэж боддогыг та ойлгож байгаа биз дээ гэв.

Вернон ах эргэлзээгүй ноён Уизлиг тэгж бодох шиг боллоо. Тэр ноён Уизлигийн гэнэт харайн довтлохоос айсан мэт Петунья эгчийн хамтаар аяархан хаалга руу дөхөв.

Энэ агшинд өрөөнд гэнэтхэн Дадли эргэн орж ирлээ. Харри гишгүүр алгасан чемодан харайх чимээг сонслоо. Энэ чимээ Дадлиг гал тогооноос хөөн гаргасан нь эргэлзээгүй. Тэр нуруугаараа хана налан ноён Уизлиг айдас дүүрэн харцаар нүд салгалгүй ширтсээр эцэг эхийнхээ ард нуугдахыг хичээв. Азгүй явдал болоход Вернон ах овор хэмжээ ихтэй хэдий ч Петунья эгчийн хамтаар Дадлиг нуухад хүрэхгүй ажээ.

- Энэ чиний үеэл үү, Харри? гэж ноён Уизли таатай яриа өрнүүлэх ахин нэг оролдлого хийв.

- Тийм. Энэ бол Дадли гэж Харри хэллээ.

Харри, Рон хоёр бие биерүүгээ хараад инээх хүслээ арай ядан барилаа. Дадли унахаас айсан мэт өгзөгөө барьсан хэвээр ажээ. Ноён Уизли түүний энэ хачин авирыг жинхэнэ утгаар нь авч үзсэн бололтой. Түүний байдлаас үзэхэд ноён Уизли Дадлиг галзуу гэж бодох шиг боллоо. Гэвч Дурслийнхнаас ялгаатай нь айдсаас илүү өрөвдөх сэтгэл илрэх аж.

- Амралтаа сайхан өнгөрүүлж байна уу, Дадли? гэж тэр эелдэгээр сонирхов.

Дадли гонгиносон дуу гаргаад махлаг өгзөгөө улам чанга барилаа.

Фред, Жорж хоёр зочны өрөөнд Харрийн сургуулийн чемодантай эргэж ирэхдээ Дадлиг олж хараад нүүрэнд нь хорон инээмсэглэл тодров.

- Та хоёр хүрээд ирэв үү. Ажилдаа орсон дээр юм шиг байна! гэж ноён Уизли хэллээ.

Тэрбээр жанчныхаа ханцуйг шуугаад шидэт саваагаа авлаа. Дурслийнхан хананы хажууд овооролдов.

- Инсендио! гэж ноён Уизли ханын нүх рүү саваагаа чиглүүлэн хэллээ.

Ханан зууханд гал хэдийн дүрэлзэж байсан мэт хөгжилтэй аслаа. Ноён Уизли халааснаасаа амыг нь чангалан боосон хүүдий гаргаж ирээд уяаг нь тайлан чимх дарь гал руу хийхэд маргад ногоон дөл дээш цоролзов.

- Фред яваарай гэж ноён Уизли хэллээ.

- Очиж байна. Өө, үгүй ээ... Хүлээгээрэй...

Түүний халааснаас хайрцагтай амттан асгарч шалаар дүүрэн хурц өнгийн боодолтой чихэр тарав.

Фред яаран чихрийг цуглуулж халаасандаа хийгээд хөгжилтэйгээр Дурслийнхан руу даллан ханан зуух руу ороод <<Үүр!>> гэж хашгирлаа. Петунья эгч дуу алдав. Исгэрэх чимээ гарснаа Фред алга болов.

- Одоо чиний ээлж, Жорж. Чемоданаа аваарай гэж ноён Уизли хэллээ.

Харри Жоржод чемоданыг дөлөн дээр барин зогсоход туслав. Жорж <<Үүр!>> гэж хашгирахад исгэрэх чимээ гарснаа мөн адил алга боллоо.

- Рон, чи дараагийнх нь.

- Удахгүй уулзая! гэж Рон Дурслийнханд хөгжилтэй толгой дохив. Тэр Харри руу харж нүүр дүүрэн инээмсэглээд гал руу орж <<Үүр!>> гэж хэлэнгээ ах нарынхаа араас алга боллоо.

Одоо зөвхөн Харри, ноён Уизли хоёр үлдэв.

- Тэгэхээр... Баяртай гэж Харри Дурслийнханд хэллээ.

Тэд юу ч хэлсэнгүй. Харриг зуух руу орж арай амжаагүй байтал ноён Уизли мөрнөөс нь татан эргүүлэв. Тэрбээр Дурслийнхан руу гайхан харлаа.

- Харри та нарт баяртай гэж хэллээ шүү дээ. Та нар сонссонгүй юу?

- Энэ чухал биш дээ. Үнэндээ надад хамаагүй гэж Харри бувтналаа.

Гэвч ноён Уизли мөрөн дээр нь тавьсан гараа авсангүй.

- Та нар зээгээ бараг жилийн турш харахгүй шүү дээ. Салах ёс гүйцэтгэсэн нь зүйтэй байх гэж тэр эгдүүцсэн байртай аяархан хэлэв.

Вернон ахын царайд уурсаж хилэгнэсэн өнгө тодорлоо. Түүний зочны өрөөний ханыг дэлбэлсэн хүн сайн ёс заншилд сургах юм гэнэ! Энэ арай дэнднээ!

Гэвч Вернон ахын жижигхэн нүд ноён Уизлигийн гартаа барьж байсан шидэт саваан дээр тусахад ихэд унтууцсан өнгөөр <<Баяртай>> гэж хэллээ.

- Дараа уулзацгаая гээд Харри дулаахан амьсгал мэт таатай ногоон дөл рүү дөхөхөд гэнэтхэн ард нь хахаж буй аятай чимээ гарч Петунья эгчийн орь дуу тавих сонсогдов.

Харри эргэж харлаа. Дадли кофены ширээний хажууд дөрвөн хөллөн шүлсээ үсчүүлэн байх агаад амнаас нь ямар нэгэн ягаан өнгийн урт зүйл цухуйж байлаа. Түүний дэргэд тод өнгөтэй чихрийн цаас харагдав. Харри ягаан зүйл бол Дадлигийн хэл гэдгийг даруй ухаарсангүй. Петунья эгч ухасхийн Дадлигийн урт хэлийг нь мулт

татах гэж оролдсон ч цаадах нь чарлан эхийгээ цааш нь түлхлээ. Вернон ах гараа савчин орилов.

- Санаа зовох хэрэггүй дээ, би түүнд туслая! гэж ноён Уизли бүхнээс чанга хашгирахыг хичээгээд Дадли руу шидэт саваагаа чиглүүлэв. Петунья эгч муухай орилоод Дадлигийн өмнүүр халхалж шидтэнгээс хамгаалахыг оролдов.

- Тайширцгаа. Энэ чинь ердөө л чихэр шүү дээ. Миний хүү Фред тоглоом хийх дуртай юм. Үүнийг Ховдог шид гэдэг. Би одоохон бүгдийг нь засаадхая... гэж ноён Уизли цөхрөн хэллээ.

Гэвч Дурслийнхан илүү их айж сандарлаа. Петунья эгч чанга цурхиран уйлж хүндээр амьсгаадах Дадлигийн хэлийг тасдан хаяхаар оролдох бөгөөд, өөрийн ухаангүй болсон Вернон ах шүүгээнээс хятад баримал авч ноён Уизли руу хүчтэй нүүлгэв. Түүнийг бөхийн бултахад зуух онож хагарав.

- Алив та нар больцгоо! Би туслахыг хичээж байна шүү дээ! гэж ноён Уизли уурсаад шидэт саваагаа сүрдүүлэн зангав.

Шархадсан усны үхэр мөөрөх адил чимээ гарч Вернон ах дараагийн чимэглэлийг шүүрэн авлаа.

- Эндээс одоохон яв, Харри! Би эндхийн учрыг олно гэж ноён Уизли хашгираад Вернон ах руу шидэт саваагаа чиглүүлэв.

Харри хөгжилтэй явдлаас хагацахыг хүссэнгүй. Гэвч Вернон ахын хоёр дахь баримал зүүн чихний хажуугаар нь шунгинан өнгөрөхөд үйл явдлыг ноён Уизлид орхисон нь дээр гэж бодлоо. Харри гал руу алхаж ороод <<Үүр!>> гэж хэллээ. Түүний зочны өрөөг орхихын өмнө зурвас харсан зүйл гэвэл Вернон ахын гарт байсан гурав дахь баримлыг ноён Уизли саваагаа өргөн дэлбэлж, Петунья эгч Дадли дээр сунаж хэвтэн орилох агаад түүний хэл аварга том могой адил мурилзаж байв. Дараагийн агшинд Харриг дулаахан хуй эргэлдүүлэн Дурслийн зочны өрөө ногоон дөл дунд алга боллоо.

БҮЛЭГ 5: УИЗЛИЧУУДЫН ШИДЭТ БҮТЭЭЛҮҮД

Харри тохойгоо биендээ шахаад маш түргэн эргэлдэх зуур ханан зуухны бүдэг дүрсүүд дэргэдүүр нь гялсхийн өнгөрч байв. Түүний дотор нь муухайрахад нүдээ аньжээ. Хөдөлгөөн эцэст нь удааширч эхлэхэд Харри зуухнаас гарахдаа унахаас сэргийлэн гараа урдаа барилаа.

- Тэр түүнийг идсэн үү? гэж Фред хөөрөн асуугаад шинэ бүтээлийнхээ үр нөлөөг мэдэхээр тэвчээргүйхэн Харри руу гараа сунгав.

- Идсэн. Энэ юу байсан бэ? гэж Харри асуулаа.

- Хүнд-хэлэн чихэр гэж Фред баясан тайлбарлаад,

- Жорж бид хоёр зохион бүтээгээд турших хүнээ зуны турш хайсан юм... гэв.

Жижигхэн гал тогоогоор дүүрэн инээд хадлаа. Харри эргэн тойрноо харахад модон ширээний ард Рон, Жорж хоёрын хажууд ахин хоёр шар толгой сууж байв. Харри урьд нь тэднийг харж байгаагүй ч Роны том ах нар болох Билл, Чарли хоёр гэдгийг таньжээ.

- Сонин юу байна, Харри? гэж ойр сууж байсан нь инээмсэглэн асуугаад том алгаа сунгав.

Харри эвэршиж цэврүүтсэн гарыг бариад Румынд луутай ажилладаг Чарли байна гэж мэдлээ. Чарли ихрүүдтэй адилхан бөгөөд Перси, Рон хоёроос арай намхан туранхай ажээ. Өргөн эелдэг царай нь дүүрэн сэвхтэй агаад наранд борложээ. Булчинлаг гар дээр нь түлэгдсэн сорви байлаа.

Билл ч мөн адил инээмсэглэн босож Харригийн гарыг барилаа. Билл төсөөлж байснаас өөр байсан явдал нь Харриг гайхшируулав. Харри түүнийг шидтэнгүүдийн Гринготтс банкинд ажилладаг бөгөөд сургуулийн ахлагч байсан гэдгийг мэднэ. Харри түүнийг Персигийн адил дүрэм зөрчихөд дургүй эргэн тойрноо захирах дуртай мэтээр төсөөлж байсан юм. Харин Билл гайхамшигтай байлаа. Өндөр биетэй урт үсээ хойноо боосон агаад чихэндээ санжигнасан соёо бүхий ээмэг зүүсэн нь хаа нэгтээ рок концертэн дээр байгаа юм шиг санагдуулна. Хөлдөө жирийн биш лууны ширэн гутал өшиглөжээ.

Тэднийг ярилцаж амжихаас урьтаж бүдэгхэн тасхийх чимээ гарч Жоржын мөрний ард ноён Уизли гарч ирлээ. Түүнийг тийм ууртай байсныг Харри амьдралдаа харж байсангүй.

- Фред, энэ чинь инээдтэй биш байна. Чи тэр хөөрхий магл хүүд юу өгсөн бэ?

- Би түүнд юу ч өгөөгүй. Зүгээр л уначихсан юм... Харин тэр түүнийг аваад идчихсэн... Өөрөө буруутай гээд Фред зальжин инээмсэглэв.

- Чи түүнийг зориуд унагасан! Чи түүнийг хоолны дэглэм барьж байгаа болохоороо иднэ гэдгийг мэдэж байсан шүү дээ... гэж ноён Уизли уурслаа.

- Хэл нь хэр урт сунасан бэ? гэж Фред тэсч ядан асуулаа.

- Эцэг эх нь эцэстээ миний тусламжыг авахыг зөвшөөрөх үед бараг дөрвөн фут урт болсон байсан!

Харри ах дүү нарын хамтаар хөхрөлдөв.

- Ямар ч инээдтэй зүйл алга! Та нарын гаргаж буй авир шидтэн магл хоёрын хоорондын харилцааг гутааж байна! Би амьдралынхаа хагасыг маглуудын эсрэг зүйлд зориулсан байхад миний хүүхдүүд... гэж ноён Уизли хашгирлаа.

- Бид түүнийг магл учраас нь өгөөгүй! гэж Фред эсэргүүцэв.

- Зөвхөн сул доройг дээрэлхэх дуртай болохоор нь өгсөн юм. Тийм биз дээ, Харри? гэж Жорж нэмэрлэв.

- Тиймээ, ноён Уизли гэж Харри батлав.

- Энэ чинь шалтгаан биш! Би бүгдийг ээжид чинь хэлнэ... гэж ноён Уизли хилэгнэлээ.

- Надад юу хэлнэ гэж? хэмээх дуу түүний ард сонсогдов.

Гал зууханд хатагтай Уизли орж ирлээ. Энэ бол намхан булцгар эелдэг царайтай эмэгтэй байсан ч харц нь сэжигтэй нарийсчээ.

- Өө сайн уу, Харри хонгор минь гэж тэр зочиндоо хандан хэлээд ахиад нөхөр лүүгээ эргэж,

- Надад юу хэлнэ гэж, Артур? гэв.

- М-м гэж ноён Уизли түгдчив.

Тэр хэдийгээр Фред, Жорж хоёрт их уурласан ч гэлээ хатагтай Уизлид хэлэхгүй байсан гэдгийг Харри мэдэж байв. Нам гүм болоход ноён Уизли эхнэр лүүгээ нүд бүлтийлгэн харав. Хатагтай Уизлигийн араас гал тогоонд хоёр охин орж ирэв. Нэг нь өтгөн хүрэн үстэй, үүдний шүд нь яльгүй том Харри, Рон хоёрын сайн анд болох Гермiona Грэйнджер. Харин нөгөөдөх нь жижигхэн шаргал үстэй Роны дүү Жинни байлаа. Тэд хоёулаа Харриг хараад баяртай инээмсэглэж Жиннигийн царай улайлаа. Харри <<Үүр>>-энд гурван жилийн өмнө ирсэн анхны цагаас л түүний зүрхийг эзэмдсэн юм.

- Надад юу хэлнэ гэж, Артур? хэмээн хатагтай Уизли тун аюултай хоолойгоор давтан хэллээ.

- Онц зүйл болоогүй дээ, Молли минь. Зөвхөн Фред, Жорж хоёр... Би тэдэнд хэдэн үг хэлсэн юм.

- Тэд энэ удаад юу хийсэн бэ? гэж хатагтай Уизли сонирхов.

- Ахиад л Уизлигийн шидэт бүтээлүүд үү?

- Рон чи Харрид хаана унтахыг нь үзүүлсэн нь дээр байх? гэж үүдэн дээр зогсож байсан Гермiona хэлэв.

- Тэр хаана гэдгийг нь мэднэ. Өнгөрсөн жил ирэхдээ миний өрөөнд унтаж байсан... гэж Рон хэллээ.

- Бид хамт явж харж болох уу гэж Гермiona хэлэв.
- А-а. Тэгвэл, явцгаая гэж Рон эцэст нь ойлгоод хэллээ.
- Бид ч гэсэн явъя даа гэж Жорж дуугарав.
- Та хоёр эндээ үлд! гэж хатагтай Уизли зандарлаа.

Харри, Рон хоёр гал зуухнаас Жинни, Гермiona хоёрын араас даган гараад яйжгий шатаар дээшээ тахиралдан өгслөө.

- Уизличуудын шидэт бүтээл гэж юу вэ? гэж Харри асуулаа.

Рон, Жинни хоёр хөхрөлдөв. Гермiona харин инээхийг яарсангүй.

- Ээж тэдний өрөөг цэвэрлэж байхдаа овоолоостой захиалгын хуудас олсон юм. Урт жагсаалтаар дүүрэн тэдний зохион бүтээсэн зүйлсийн үнийн жагсаалт байсан. Тоглоомон инээдмийн зүйлс гэдгийг чи мэднэ дээ. Ид шидийн хуурамч саваа, чихэр болон өөр бас бус зүйл байсан. Гайхамшигтай байгаа биз! Би тэднийг тийм зүйл зохион бүтээж байгаа гэж бодоогүй шүү.

- Тэдний өрөөнд үргэлж юм дэлбэрч байдаг ч хэний ч толгойд жинхэнээсээ юм туршиж байгаа гэж ороогүй. Бид зөвхөн тэднийг чимээнд дуртай юм байх гэж бодсон хэмээн Жинни нэмэрлэв.

- Гэхдээ тэдний зохион бүтээсэн зүйлүүд үнэндээ бага зэрэг аюултай байсан. Тэд түүнийгээ Хогвартсад худалдаж мөнгө олохоор төлөвлөж байсан гэж бодоод үз дээ. Ээж галзууртлаа уурласан! Тэдэнд ийм зүйл хийхийг нь хориглоод бүх захиалгын хуудсыг нь шатаачихсан... Тэдэнд өмнө нь уурлачихсан байсан юм л даа. Тэд түүний бодож байсан шиг олон С.И.Ш аваагүй ...

С.И.Ш (Сүпер ид шид) бол Хогвартсын тавдугаар дамжаандаа өгдөг шалгалт юм.

- Бөөн хэрүүл шуугиан болсон. Ээж тэднийг аавыг залгамжлан ид шидийн яаманд ажиллаасай гэж хүсэж байхад харин тэр хоёр зөвхөн шидэт тоглоомон зүйлсийн дэлгүүр нээхийг хүсдэг гэж андгайлсан.

Шатны хоёр дахь талбайн үүд нээгдэж эвэр хүрээтэй нүдний шил бүхий ууртай царай цухуйв.

- Сайн уу, Перси гэж Харри хэллээ.
- Сайн уу, Харри. Би юун чимээ шуугиан гаргаад байгаа юм бол гэж бодлоо. Би ажиллах хэрэгтэйг ойлгож байна уу? Илтгэлээ дуусгах хэрэгтэй байна. Өглөөний хойш дээш доошоо хөлхөлдөн шат хяхтнуулаад байхад төвлөрч болохгүй байна.
- Бид хяхтнуулаагүй. Бид дээшээ гарч байна. Хэрвээ ид шидийн яамны маш нууц ажилд саад болсон бол уучлаарай гэж Рон хэллээ.
- Чи юун дээр ажиллаж байгаа юм? гэж Харри сониучирхав.
- Олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтэст тавих илтгэл. Бид тогоонуудын зузаанд жишиг тогтоох хэрэгтэй байгаа юм. Гаднаас оруулж ирсэн

тогоонуудын зарим нь нимгэн байдаг болохоор жилийн дотор цооролт нь гурав шахам хувиар ихсэж байна гэж Перси албархуу хэлэв.

- Чиний илтгэл ертөнцийг өөрчилнө дөө. <<Өдөр тутмын Зөнч>> сонины эхний нүүрэн дээр зузаан тогоо! Дэлхий даяар шуугиан болно! Цооролттой амжилттай тэмцлээ! гэж Рон хэллээ.

Персигийн царай ягаарлаа.

- Инээж болно шүү, Рон. Хэрвээ бид олон улсын стандартыг баримтлахгүй бол зах зээл нимгэн ёроолтой тогоонуудаар дүүрч ноцтой аюул авчирч болзошгүй...

- Тиймээ, зөвшөөрч байна гэж Рон түүнийг зогсоохын тулд яаран хэлээд бүгд дээшээ өгсөв.

Перси унтлагын өрөөний хаалгаа чанга хаалаа. Тэднийг дөрөвдүгээр давхар лүү өгсөж байтал гал зуухнаас чанга дуу хадав. Энэ нь ноён Уизли эхнэртээ гайтай чихэрний тухай хэлсэн байж магадгүй сонсогдож байлаа.

Дээврийн дор байдаг Роны унтлагын өрөө Харрийн сүүлийн удаа ирснээс хойш бараг өөрчлөгдсөнгүй. Роны дуртай <<Педдлийн их буунууд>> багийн зурагт хуудаснууд хана адар дээрээс гараа даллаж, цонхны тавцан дээр байсан мэлхийн түрстэй цөөрмөгт одоо ганц том мэлхий сууж байлаа. Хөгшин харх Скабберс байсангүй орыг нь Улаан модон гудамж руу захиа авчирсан саарал ууль эзэлжээ. Тэр жижигхэн торон дотор дээш доошоо үсчин цөхрөн шулганаж байв.

- Чимээгүй, Гахай гэж Рон өрөөнд тавьсан дөрвөн орны дундуур хажуулдан гарахдаа хэллээ.

- Фред, Жорж хоёр энд унтах болно. Тэдний унтлагын өрөөнд Билл, Чарли хоёр байгаа юм. Перси ажллах ёстой болохоор амгалан тайван байдлаа хэнд ч эвдэхийг зөвшөөрөөгүй.

- Э-э-э... Чи яагаад уулиа Гахай гэж нэрлэсэн юм бэ? Тэр чинь бор шувуутай төстэй шүү дээ гэж Харри асуулаа.

- Учир нь тэнэг болохоор тэр. Үнэн хэрэгтээ Гахайхан гэж нэрлэвэл зохих байсан юм гэж Жинни хэллээ.

- Харин би түүнийг зүгээр л Гахай гэж дуудмаар байна гэж Рон даажигнасан маягтай хэлээд,

- Жинни түүнийг ингэж нэрлэсэн юм. Харин би өөрчлөх гэсэн ч хоцорсон байсан. Тэр өөр нэр тоохгүй байсан. Өөрийгөө том шувууг гэж бодог л дээ. Түүнийг өрөөндөө байлгахгүй бол Сум, Гермес хоёр түүнд дургүй юм. Тэр надад ч гэсэн яршиг удаж байдаг юм гэв.

Гахай сэтгэл хангалуунаар торонд гууглав. Харри түүний үгийг үнэмших хэрэггүй гэдгийг мэднэ. Тэр Рон хөгшин харх Скабберсийг бүгд Гермionaгийн муур идсэн гэж бодох үед ихэд гомдоллож байсан билээ.

Муурын тухай санангуутаа Харри Гермiona руу эргэж харлаа.

- Живоглот хаа байгаа юм бэ?
- Цэцэрлэгт байгаа байх. Анахайнуудын араас хөөцөлдөж байгаа биз. Тэр тэднийг урьд нь харж байгаагүй юм.
- Перси ажилдаа сэтгэл хангалуун байгаа бололтой гээд Харри орон дээр суун <<Педдлийн их буунууд>> адар дээрх зурган дээр нисэхийг ажиглав.
- Сэтгэл хангалуун гэнэ ээ? Тэр аав түүнийг дагуулж ирдэггүй байсан бол ажил дээрээ хонох байсан байхаа. Түүний даргын тухай яриаг битгий сөхөөрэй. <<Ноён Краучын үгээр бол...>>, <<Би ноён Краучад юу гэж хэлсэн гээч...>>, <<Ноён Краучын бодлоор>>, <<Ноён Крауч хэлэхдээ...>> Харж байгаарай өнөөдөр биш ч маргааш тэд гэрлэхээ зарлах байх гээд Рон тургилав.
- Зуныг сайхан өнгөрүүлсэн үү, Харри? Бидний явуулсан илгээмжийг авсан уу? гэж Гермиона асуулаа.
- Тиймээ, их баярлалаа. Та нарын бялуу миний амьдралыг аварсан гэж Харри толгой дохив.
- Харин түүнээс сураг... гэж Рон эхэлсэн ч Гермионагийн болгоомжлуулсан харцыг хараад зогсов.

Рон Сириусын тухай асуухыг хүссэн болохыг Харри тааварлав. Рон, Гермиона хоёр түүний амьдралыг ид шидийн яамныхнаас аврахын тулд Харригаас дутуугүй тусламж үзүүлсэн болохоор санаа зовж байлаа. Гэвч Жинниг байхад загалмайлан эцгийнхээ тухай ярьж болохгүй байлаа. Түүнийг гэм буруугүй гэсэн тэдний үгэнд профессор Дамблдорос өөр хэн ч итгээгүй юм.

- Тэд маргалдахаа дууссан байх гэж Гермиона амаргүй байдлыг хөнгөвчлөх санаатай хэллээ. Жинни сониучирхсан харцаар Харри, Рон хоёр руу харна.
- Доошоо бууж ээжид чинь ширээ засахад туслах уу?
- Явцгаая гэж Рон зөвшөөрөв.

Тэд дөрвүүлээ өрөөнөөс гарч шатаар уруудан гал зуух руу ороход хатагтай Уизли ууртай байлаа.

- Бид цэцэрлэгт хооллох болно. Бидэнд арван нэгэн хүнийг багтаах өрөө байхгүй. Охидууд таваг зөөгөөрэй. Билл, Чарли хоёр ширээ аваад явсан. Харин сэрээг та хоёр ав гэж Харри, Рон тушаагаад саваагаа авч хүчтэй даллахад угаагуурт овоолоостой байсан төмснүүд үсчин гарч хана, адар цохин уналаа.
- Ай бурхан минь! гэж тэр уулга алдаад саваагаа буланд байсан хогийн гаргуул руу чиглүүлэн шалнаас төмсийг цуглуулав.
- Энэ хоёр дахиа тохиолдож байна! Тэдэнд юу тохиолдсоныг мэдэх юм алга! Үнэхээр мэдэх юм алга! Ямар ч зорилгогүй! Зөвхөн хүмүүст таагүй зүйл учруулах юм! гэж тэр ууртайгаар бувтнаад шүүгээнээс сав суулга гаргахад Харри Фред, Жорж хоёрын тухай ярьж буйг нь ойлголоо.

Тэр хоолны том зэс савыг ширээн дээр тасхийтэл тавиад шидэт саваагаараа тойруулан хутгахад үзүүрээс нь цөцгийний сүмс гоожиж эхлэв.

- Тэдэнд тархи байхгүй биш л дээ гэж тэр уурсан үргэлжлүүлээд савыг зуухан дээр тавин гал асаахын тулд ахин саваагаа даллав.

- Гэхдээ тархиа буруугаар ашиглаж байгаад л гол учир байгаа юм. Тэд засрахгүй бол жинхэнэ асуудал тулгарах байх даа. Хогвартсаас тэдний тухай гомдоллосон захиа бусдынхыг нь нийлүүлснээс олон ирсэн. Хэрвээ тэд одооных шигээ байх юм бол ид шидийг хэтрүүлэн хэрэглэх Комиссийн үүдэнд л дуусна шүү.

Хатагтай Уизли саваагаараа хутга сэрээний шургуулгыг чичихэд тасхийн онгойв. Харри, Рон хоёр үсрэн холдоход дэргэдүүр нь хэд хэдэн хутга нисэн өнгөрч хогийн гаргуулын тусламжтай угаагуурт орсон төмсийг хальсалж эхлэв.

- Бид хаана алдаа гаргасныг ойлгох юм алга гэж хатагтай Уизли мөрөө хавчаад саваагаа доош нь тавьж өөр савнууд гаргаж ирэв.

- Жил болгон л ингэх юм, бүр жил болгон шүү. Юу ч сонсохыг хүсэхгүй шүү... ӨӨ ҮГҮЙ ЭЭ, АХИАД Л!

Түүний ширээн дээрээс авсан шидэт саваа часхийгээд том резинэн хулгана болж хувирлаа.

- Ахиад л бас нэг хуурамч саваа! Би хичнээн удаа тэднийг энд тэнд тавьж болохгүй гэж хэлэх юм бэ! гэж хатагтай Уизли хашгичав.

Түүнийг жинхэнэ шидэт саваагаа аван эргэж хартал зуухан дээрх сүмснээс өтгөн утаа уугиж байв.

- Явж Билл, Чарли хоёрт туслая гэж Рон яаран хэлээд шургуулга онгойлгон багц хутга, сэрээ авлаа.

Тэд хатагтай Уизлигийн хажуугаар өнгөрөөд арын хаалгаар хашаа руу гарав. Хоёр ч алхаж амжаагүй байтал Гермionaгийн майга хөлтэй шаргал муур цэцэрлэг дотуур өтгөн сүүлээ даллаж шавар шавхай болсон хөлтэй төмсийг хөөж байв. Харри агшин зуур анахайг танилаа. Бараг арван инчийн өндөртэй анахай эвэршиж хатуурсан хөлөөрөө маш хурдан гүйж хаалганы хажууд овоолсон усны гутал руу үсрэн оров. Живоглот сарвуугаараа гутлыг ухан олзондоо хүрэхийг хичээхэд анахай гижигдүүлж байгаа аятай хөхөрнө. Тэгтэл байшингийн нөгөө захаас чих дүлийрэм мөргөлдөх чимээ гарав. Тэнд бүтэн үзвэр болж байлаа. Билл, Чарли хоёр шидэт саваагаа агаарт эргэлдүүлэн хоёр хуучин ширээг зүлгэн дээр нисгэн тулалдуулна. Ширээнүүд нэг нь нөгөө рүүгээ нисэлдэн өрсөлдөгчөө унагахыг хичээнэ. Фред, Жорж хоёр улайран дэмжиж, Жинни инээд алдан харин Гермiona таримал бургасан хашааны хажууд баясахаасаа илүүтэй санаа зовон зогсож байлаа.

Биллийн ширээ Чарлигийн ширээг чанга мөргөн нэг хөлийг хугаллаа. Гурван давхрын цонх тачигнан нээгдэж Персигийн толгой цухуйв.

- Та нар холдож болдоггүй юм уу? гэж тэр орилов.

- Уучлаарай, Перси. Тогоонуудын зузаан юу болж байна даа? гэж Билл инээмсэглэв.

- Муу байна! гээд Перси цухалдан цонхоо тасхийтэл хаалаа.

Билл, Чарли хоёрыг инээд алдан ширээнүүдийг ногоон дээр аюулгүй газардуулав. Билл саваагаа даллан ширээний хөлийг нь засаад бүтээлгийг нь бүтээв.

Долоон цагаас хоёр ширээ хатагтай Уизлигийн гараа гаргаж хийсэн зоог бүхий таваг дийзийг дааж ядан хотойж есөн Уизли, Харри, Гермiona нар үүлгүй цэлмэг тэнгэрийн дор хооллохоор суулаа. Бүх зуны турш хатсан бялуу идэж өнгөрүүлсэн хүний хувьд жинхэнэ найр байлаа. Харри эхэндээ ярихаас илүү сонсож тахианы махтай хуушуур, чанасан төмс зууштай хийж авлаа.

Ширээний төгсгөлд Перси эцэгтэйгээ тогооны ёроолын тухай илтгэлийнхээ талаар ярилцаж байв.

- Би ноён Краучид мягмар гаригт бэлэн болгоно гээд амалчихсан юм. Ноён Крауч тийм хурдан болно гэж бодоогүй шүү. Гэхдээ би их хичээж байгаа. Намайг түргэн дуусгавал түүнийг баярлах байх гэж бодож байна. Одоо манай хэлтэс Дэлхийн цомын тэмцээнийг зохион байгуулах гээд ямар ч завгүй байгаа. Бидэнд ид шидийн спорт тоглоомын хэлтэсээс ямар ч тусламж үзүүлээгүй шүү. Людо Бэгмен...

- Надад Людо таалагддаг. Тэр л бидэнд Дэлхийн цомын тэмцээний сайхан тасалбар авахад тусалсан шүү дээ. Би түүнд багахан тусламж үзүүлсэн юм. Түүний ах Отто нь таагүй зүйлд орооцолдсон. Тэр зүлэг т шидэт хүчтэй болгон өөрчилсөн байсан юм л даа. Би үүнийг нь аргалж өгсөн гэж ноён Уизли аяархан өгүүлэв.

- Людо мэдээж аятайхан хүн гэж Перси үл тоомсорлон хэлээд,

- Гэхдээ тэр яаж хэлтсийн дарга болсон юм бол... Түүнийг ноён Краучтай харьцуулаад үз л дээ! Ноён Краучыг хэлтсийнхээ ажилтанд юу тохиолдсоныг мэдэхээр хайхгүй байна гэж бодох ч юм биш. Берта Жоркинс бүтэн сараар байхгүй байна гэж төсөөлөөд үз дээ! Албани руу амралтаараа яваад эргэж ирээгүй!

- Тиймээ, би энэ тухай Людогоос асуусан. Тэр Бертатай урьд нь тийм явдал тохиолдож байсан гэж хэлсэн. Хэдийгээр тэр манай хэлтсийн ажилтан биш ч гэсэн миний санаа зовж байна... гэж ноён Уизли хөмсөг зангидан хэллээ.

- Берта бүтэлгүй л дээ. Би түүнийг үргэлж хэлтсээс хэлтэс дамжин явдаг асуудал ихтэй хүн гэж сонссон... Гэхдээ Бэгмен түүнийг хайж эхлэх ёстой. Ноён Крауч энэ асуудлыг хувийн шугамаар сонирхож байгаа юм. Тэр манай хэлтэст ажиллаж байсан болохыг та мэднэ. Ноён Крауч тэр хоёр их дотно харилцаатай юм. Гэтэл Бэгмен зөвхөн хөгжилтэйгээр инээж түүний газрын зургаа андуураад Албани руу явахын оронд Австрали руу явсан байх гэсэн шүү гээд тэр сэтгэл хөдөлсөндөө дарснаас том балгаад,

- Манай олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтэст түүнгүйгээр ажил хангалттай их бий. Өөр хэлтсийн ажилчдын учрыг олж байх зав алга. Дэлхийн цомын тэмцээний дараа ахин нэг чухал арга хэмжээ болох гэж байгааг та мэднэ шүү дээ.

Перси ширээний төгсгөлд байсан Харри, Рон, Гермiona гурвыг хараад хоолой засан учиртай ханиалгав.

- Та намайг юун тухай ярьж байгааг ойлгож байгаа биз дээ, аав аа. Энэ бол маш нууц зүйл юм.

Рон нүдээ эргэлдүүлээд Харри, Гермiona хоёрт,

- Тэр биднийг арга хэмжээний асуунгуут ажлаа ярьж эхлэх гэж байгаа юм. Магадгүй олон улсын зузаан ёроолтой тогооны үзэсгэлэн худалдааны тухай байх гэв.

Ширээний гол хэсэгт хатагтай Уизли Биллээс ээмгийнх нь тухай асууж байгаагаас үзэхэд саяхан олж авсан эд бололтой.

- Аймшигтай соёо байна даа, Билл! Энэ тухай банкин дээр чинь юу хэлж байх юм?

- Ээжээ, би тэдэнд мөнгө л олж өгч байвал яаж ч хувцасласан байсан юу ч хэлэхгүй гэж Билл тэвчээртэй тайлбарлав.

- Харин үс чинь, хонгор минь! Энэ чинь инээдтэй байна шүү. Хэрвээ бага зэрэг тайрчихвал... гэж хатагтай Уизли хэлээд шидэт саваагаа тэмтэрлээ.

- Харин надад таалагдаж байна. Ээжээ, та ямар хоцрогдсон загварынх юм бэ. Ямар ч л гэсэн түүний үс профессор Дамблдорынх шиг лав урт биш гэж Биллийн дэргэд сууж байсан Жинни хэллээ.

Цаана нь сууж байсан Чарли Фред, Жорж хоёртой Дэлхийн цомын тэмцээний тухай улайран хөөрөлдөж байв.

- Цомыг Ирландчууд авна. Шигшээ тэмцээнд тэд Перуг арчаад өгсөн гэж амаараа дүүрэн төмс чихсэн Чарли хэлэв.

- Гэхдээ Болгарчуудад Виктор Крам байгаа шүү дээ гэж Жорж хэлэв.

- Крам тэдний цорын ганц сайн тоглогч байхад харин Ирландчуудад долоо бий. Би Англичуудыг хагас шигшээд ороосой гэж хүсэж байсан юм. Ямар гутамшигтай юм болсон гээч...

- Юу болсон юм бэ? гэж Харри тэвчээргүйхэн сонирхоод Улаан модон гудамжинд шидэт ертөнцөөс тусгаарлагдсан байсандаа харамсав.

- Трансильванчуудад гурван зуун ер арваар хожигдсон. Аймшигтай юм болсон доо. Уэльс Угандад хожигдож, Люксембург Шотландад хүйс тэмтрүүлсэн.

Харри Хогвартсад сурдаг эхний жилдээ Гриффиндорын шигшээ багийн баригч болсон бөгөөд дэлхий дээр хамгийн хурдан <<Аянга>> хэмээх шүүртэй билээ.

Хоолны төгсгөлд гэрийн нөхцөлд хийсэн гүзээлзгэнэтэй зайрмагаа идэхийн өмнөхөн цэцэрлэгт бүрэнхий болоход ноён Уизли лаануудыг илбэдэн асаав. Ширээн дээгүүр дэнгийн эрвээхэй нисэлдэн далан хальс мод болон ногооны үнэр дулаахан агаарт ханхална. Харри цадаад залхуутайгаар хэзээ ч мэдэрч байгаагүй эргэн тойрны ертөнцийн найрал хөгийг мэдрэн хэдэн анахай сарнайн бут руу инээд алдан зугтаж араас нь Живоглот элдэхийг харж суулаа.

Рон ширээн дээгүүр завгүй ярилцаж буй гэр бүлийнхнээ болгоомжтой хараад Харригаас аяархан,

- Чи Сириусаас захиа авсан уу? гэж асуулаа.

Гермиона ийш тийшээ харснаа сонсохоор ойртов.

- Тиймээ. Хоёр ч удаа. Бүх зүйл хэвийн гэж байна лээ. Би түүнд өчигдөр захиа бичсэн. Хариу нь шууд ийшээ ирэх ёстой гэж Харри нам дуугаар хэлэв.

Тэгтэл гэнэтхэн яагаад Сириуст захиа бичихээр шийдсэн нь санаанд оров. Тэр Рон, Гермиона хоёрт сорвиныхоо өвдөлт болон цочин сэрсэн зүүднийхээ талаар яриагүй байв. Андуудаа түгшээх ямар хэрэгтэй гэж. Тэр ямар ч аймшигтай зүйл болохгүй гэдэгт бүрэн итгэлтэй байлаа.

- Цаг орой болчихож! гэж хатагтай Уизли бугуйн цагаа хараад дуу алдав.

- Бүгд ор луугаа. Маргааш үүр гэгээрээгүй байхад босно шүү. Харри хичээлийн хэрэгслийн жагсаалтаа үлдээгээрэй. Би маргааш Тахир гудамж руу явж юм худалдаж авах юм. Дэлхийн цомын тэмцээний дараа авах цаг үлдэхгүй байж магадгүй. Сүүлчийн тэмцээн таван өдрийн турш үргэлжилсэн гэсэн.

- Хөөх! Тэгнэ гэж найдъя! хэмээн Харри урам зоригтойгоор дуу алдав.

- Үгүй гэж найдаж байна. Хэрвээ би таван өдөр ажилдаа явахгүй бол ширээн дээр минь овоорох ажлыг бодохоос ч цочиж байна гэж Перси маяглав.

- Тийм шүү, хэн нэг нь ахиад лууны шивх явуулбал яана, тийм үү Перси? гэж Фред баяслаа.

- Тэр чинь Норвегээс ирсэн бордоо байсан юм! Ямар ч хувийн зүйл байгаагүй! гэж Перси улайн хэллээ.

- Байсан юмаа. Бид түүнд явуулсан юм гэж Фред ширээнээс босохдоо Харрид шивнэлээ.

БҮЛЭГ 6: ЗӨӨВӨРЛӨГЧ

Харри толгойгоо дэрэн дээр тавьж амжаагүй байтал хатагтай Уизли түүнийг сэрээх шиг санагджээ.

- Босох цаг болж, Харри хонгор минь гэж тэр хэлээд Роны ор луу очив.

Харри шилээ хайж зүүгээд босож суулаа. Өрөөнд харанхуй байв. Рон ээжийнхээ сэрээх гэсэн оролдлогын хариуд ямар нэгэн зүйл бувтнав. Хөнжил дороос хоёр сэгсгэр толгой цухуйв.

- Юу, өглөө болчихсон уу? гэж Фред нойрмог хэллээ.

Тэд эвшээн нойрмоглож сунисаар чимээгүйхэн хувцаслаад доошоо гал зуух руу уруудлаа.

Хатагтай Уизли зуухан дээрх том савтай зүйлийг эргүүлэн хутгаж харин ноён Уизли ширээний ард суугаад багц тасалбаруудыг шалгаж байв. Ноён Уизли хөвгүүдээ хараад гараа дэлгэн босч өмссөн хувцсаа харуулав. Тэрбээр хуучин гольфын цамц, томдсон жинсэн өмд өмсөөд өргөн арьсан бүс бүсэлжээ.

- За, ямар харагдаж байна? Хэн ч биднийг шидтэн гэдгийг мэдэхгүй биз дээ. Би маглтай адилхан байна уу, Харри? гэж ноён Уизли сэтгэл зовонгуй асуулаа.

- Тиймээ. Их адилхан байна гэж Харри инээмсэглэн хэлэв.

- Билл, Чарли, Пе-Пе-Перси хаана байна? гэж Жорж томоор эвшээх хүслээ арай ядан дарж хэлэв.

- Тэд шилжиж очих юм. Ийм учраас ахиад жаахан унтаж болно гэж хатагтай Уизли хэлээд хоолны савыг ширээн дээр тавьж шанагаар будаа аягалж эхлэв.

Харри шилжих нь нэг газраас алга болоод агшин зуур нөгөө газарт гарч ирдэг болохыг мэднэ. Энэ нь маш хэцүү зүйл бөгөөд тэр Хогвартсын нэг ч сурагч шилжиж байхыг хараагүй билээ.

- Тэд орноосоо босоогүй байгаа юм уу? Харин бид яагаад шилжиж болдоггүй юм бэ? хэмээн Фред үглээд тавагтай будаа ойртуулав.

- Учир нь чи шалгалт өгөх насанд хүрээгүй. Ингэхэд охидууд хаа байна? гэж хатагтай Уизли хэлэв.

Тэр гал зуухнаас түргэн алхаагаар гараад гишгүүр шажигнуулан дээшээ өгслөө.

- Та шилжих шалгалт өгсөн үү? гэж Харри асуулаа.

- Мэдээж гэж ноён Уизли толгой дохиод тасалбарыг өмдний арын халаасандаа нямбайлан шургуулаад,

- Дашрамд ид шидийн тээврийн хэлтэс саяхан нэг хосыг торгожээ. Энэ бол тийм ч амархан зүйл биш. Шилжилт хөнгөмсөг харьцсан тохиолдолд гунигтай үр дүн авчирдаг юм. Тэр хосууд хуваагдсан байсан гэв.

Харригаас бусад хүмүүс ярвайлаа.

- Хуваагдсан гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? гэж Харри асуулаа.
 - Биений хагас нь байрандаа үлдэж хагас нь цаашаа ниснэ гэж ноён Уизли тайлбарлаад будаандаа том халбага чихэр хийж,
 - Тэд гацаад наашаа ч үгүй цаашаа ч үгүй болсон байсан. Санаандгүй шидийг хүчингүй болгох хэлтсийнхнийг хүлээх хэрэг гарсан. Хичнээн их бичиг цаасны ажил болсон гээч. Бас энэ нь маглуудын нүдэн дээр болсон байдаг... гэв.
- Харри гэнэтхэн Улаан модон гудамжны зам дээр хоёр хөл, нэг нүдний алим хэвтэж байна гэж төсөөлөв.
- Гэхдээ тэд одоо зүгээр биз дээ? гэж тэр айн асуулаа.
 - Тиймээ, тэдэнд ихээхэн торгуул оногдуулсан даа. Тэд шилжихээсээ өмнө яарах хэрэггүй гэдгийг ойлгосон байх. Шилжилт бол тоглоом биш. Би олонхи насанд хүрсэн шидтэнгүүд түүнтэй холбогдохын оронд шүүр унасан нь дээр гэж үздэгийг мэднэ. Удаан хэдий ч аюулгүй гээд ноён Уизли толгой дохилоо.
 - Харин Билл, Чарли, Перси нарт зөвшөөрөл байгаа юм уу?
 - Чарли шалгалтыг нь хоёр удаа өгсөн. Эхний удаад нь байх ёстой газраасаа таван милийн зайд дэлгүүрт байсан хөөрхий хөгшины дээр газардсаныг санаж байна уу? гээд Фред мушийн инээмсэглэв.
 - Харин хоёр дахь удаадаа сайн болсон гэж хатагтай Уизли гал зууханд хөгжилтэй орж ирлээ.
 - Перси ердөө хоёр долоо хоногийн өмнө шалгалт өгсөн. Тэгээд өглөө болгон гурван давхараас шилжиж ирдэг юм гэж Жорж хэлэв.
- Хонгилд хөлийн чимээ сонсогдож гал зууханд Гермiona, Жинни хоёр нойрмог орж ирлээ.
- Биднийг ийм эрт сэрээх ямар хэрэгтэй юм бэ? гэж Жинни ширээний ард суугаад нүдээ нухлан хэлэв.
 - Та нар багахан зугаалга хийнэ гэдгээ мартсан байна гэж ноён Уизли хэлэв.
 - Зугаалга гэнээ? Бид цомын тэмцээнд явган явах юм уу? гэж Харри гайхлаа.
 - Үгүй-үгүй. Цэнгэлдэх хүрээлэн эндээс олон милийн зайд байгаа. Бид багахан замыг нь явган алхах хэрэгтэй. Олон тооны шидтэнгүүдийг маглуудын анхаарлыг таталгүй тийш нь хүргэх нь маш хэцүү ажил. Бид Дэлхийн цомын тэмцээн шиг чухал үйл явдлын хувьд аялалаа маш болгоомжтой зохицуулахгүй бол...
 - Жорж! гэж хатагтай Уизли бүгдийг цочтол чанга хашгирав.
 - Яасан? гэж Жорж гэмгүй царайлан асуулаа.
 - Халаасанд чинь юу байгаа юм бэ?
 - Юу ч биш!
 - Надад бүү худал хэл!

Хатагтай Уизли шидэт саваагаа Жоржын халаас руу чиглүүлээд,

- Акцио! гэж тушаав.

Тэгтэл халааснаас жижигхэн тод өнгөтэй юмнууд нисэн гарлаа. Жорж тэднийг барьж авахыг оролдсон ч хатагтай Уизлигийн сунгасан гарт буулаа.

- Би та нарыг устга гэж хэлээ биз дээ! Бүгдийг нь устга! Алив хоёулаа халаасаа шалгуул! гэж тэр хүнд-хэлэн чихэрийг бариад уурсан хэллээ.

Таагүй үйл явдал болов. Ихрүүд олон тооны чихрийг байшингаас нууцаар гаргах гэж байсан бололтой. Гэвч хатагтай Уизли татах шидийн тусламжтай бүгдийг нь хаман авлаа.

- Акцио! Акцио! Акцио! гэж тэр хашгирахад чихрүүд ар араасаа хамгийн санаанд оромгүй газар болох Жоржын хүрэмний нууц халаас болон Фредийн жинсэн өмдний нугалаас зэрэг газраас нисэн гарсаар байлаа.

- Бид бараг хагас жилийн турш хийсэн шүү дээ! гэж Фред ээж нь бүх чихрийг устгахад цөхрөн орилов.

- Хагас жил өнгөрүүлэх сайхан арга байна даа! Та нарыг хэдхэн С.И.Ш. авсан гэдэгт гайхах юм алга!

Эцэстээ эвгүйхэн уур амьсгалд салж явах боллоо. Хатагтай Уизли уурсан хэвээр ноён Уизлигийн хацар дээр үнслээ. Гэвч ихрүүд зуу дахин илүү уурласан байлаа. Тэд үүргэвчээ нуруундаа үүрээд ээжтэйгээ салах ёс гүйцэтгэлгүй байшингаас гарч одов.

- Цагаа сайхан өнгөрүүлээрэй. Томоотой байцгаагаарай гэж тэр ихрүүдийн араас хашгирсан ч тэд хариу хэлсэнгүй.

- Билл, Чарли, Перси гурвыг үдээс хойш явуулья гэж тэр ноён Уизлид хэлэхэд бүгдээрээ харанхуй хашаанд Фред, Жорж хоёрын араас гарлаа.

Гадаа жихүүн бөгөөд сартай тэнгэрийн хаяанд үүр гэгээрэхийн тэмдэг болон бүдэг ногоон судал татна. Квиддичийн Дэлхийн цомын тэмцээн рүү яарч байгаа олон мянган шидтэнгүүдийн талаар бодсоор Харри алхаагаа хурдасган ноён Уизлиг гүйцлээ.

- Тэд яаж бүгдээрээ цэнгэлдэх хүрээлэнд цуглах юм бэ? Маглууд үнэхээр юу ч ажиглахгүй гэж үү? гэж тэр асуулаа.

- Үүний тулд асар том зохион байгуулалтын ажил хийгдэнэ. Дэлхийн цомын тэмцээнд ойролцоогоор зуун мянган шидтэн цуглардаг болохоор нилээдгүй хүнд ажил юм. Бидэнд мэдээж бүгдийг нь сууцаар хангах илбэдсэн газар байхгүй. Тиймээ маглууд хүрэхээргүй газар. Тахир гудамж юм уу есөн бүхэл дөрөвний гурав дугаар тавцангаар зуун мянган шидтэнг цувуулан гаргаж болно гэж үү. Үүний тулд маглуудын эсрэг боломжтой бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан хоосон газар хэрэгтэй. Ид шидийн яамнаас үүнд дөрвөн сар зарцуулсан. Мэдээж эхлээд шидтэнгүүдийг хэрхэн хүлээн авахыг зохицуулах хэрэгтэй болно. Хямдхан тасалбар авсан хүмүүс хоёр долоо хоногийн өмнө ирнэ. Шидтэнгүүдийн зарим хэсэг нь маглуудын тээврийн хэрэгслээр ирэх ч бас автобус, галт тэргийг дүүргээд байж

болохгүй. Шидтэнгүүд дэлхийн өнцөг булан бүрээс ирнэ гэдгийг мартаж болохгүй. Зарим нь шилжих хэдий ч маглуудаас хол аюулгүй газар хэрэгтэй. Үүний тулд ойг сонгосон юм. Шилжихийг хүсээгүй хүмүүс зориулан хоёр зуун зөөвөрлөгч бэлтгэсэн байгаа. Энэ бол тодорхой хугацаанд шидтэнг нэг газраас нөгөө рүү тээвэрлэдэг хэрэгсэл юм. Түүний тусламжтайгаар нэг дор томоохон бүлэг хүмүүсийг зөөж болно. Эдгээр зөөвөрлөгчид Английн янз бүрийн газарт байгаа. Бидэнтэй хамгийн ойрхон нь Үентолгой толгодын орой дээр байгаа юм. Бид тийшээ хүрэх замд явж байна.

Ноён Уизли Оттери-Сент-Кэчпоул тосгон дээгүүр харлан байгаа толгод руу заалаа.

- Зөөвөрлөгч юутай адилхан юм бэ? гэж Харри сониучирхав.

- Энэ бол ямар ч зүйл байж болно. Нүдэнд тусахааргүй маглууд сонирхохооргүй жирийн зүйлс... Тэдний нүдэнд бол хог хаягдал болж харагдана.

Тэд харанхуй чийгтэй замаар тосгон дундуур явахад нам гүмийг алхааны чимээ эвдэж байлаа. Тосгоныг ардаа орхих үед тэнгэрийн бараан өнгө цэнхрээр өөрчлөгдөж эхлэв. Харрийн хөл гар даарч, ноён Уизли цагаа харлаа.

Удалгүй Үентолгой толгод руу амьсгаадан өгсөх үед ярих хүч байсангүй. Алхах зуураа туулайн нүхэнд тээгэлдэн бүдэрч, өтгөн ургасан өвс ногоонд хальтарч байлаа. Харрийн амьсгалах тоолонд цээжээр нь хатгуулж хөл нь гуйвлана. Эцэст нь тэгшхэн талбай дээр гарч ирэв.

- Хөөх. Бид хурдан ирсэн байна шүү. Бидэнд ахиад нөөц арван минут байна гэж ноён Уизли амьсгаадан хэлээд нүдний шилээ цамцаараа арчлаа.

Гермиона толгод руу хамгийн сүүлд өвдгөө тулсаар гарч ирэв.

- Одоо зөөвөрлөгчийг олох хэрэгтэй. Нэг тийм жижигхэн зүйл байгаа. Анхааралтай хараарай гэж ноён Уизли хэлээд шилээ зүүн эргэн тойрны газрыг хяламхийн харлаа.

Бүгд хайгуул хийн янз бүрийн хэсэгт тарав. Хэдэн хормын дараа зүүрмэглэн буй агаарыг хашгиралт эвдэж,

- Наашаа ир, Артур! Бид түүнийг оллоо! гэх дуу гарав.

Одод түгсэн тэнгэр дор толгодын нөгөө өнцгөөс хоёр урт дүрс гарч ирэв.

- Амос! гээд ноён Уизли инээмсэглэн хашгирсан хүн рүү алхав. Бүгд түүний араас дагалаа.

Ноён Уизли улаа бутарсан царайтай, өрвийсөн хүрэн сахалтай шидтэнтэй гар барилаа. Тэр гартаа хуучин шаахай барьжээ.

- Танилц энэ бол Амос Диггори. Ид шидийн яамны шидэт амьтдад хяналт тавин зохицуулах хэлтсийн ажилтан гэж ноён Уизли танилцуулаад,

- Харин энэ чиний хүү Седрик үү? гэв.

Седрик Диггори арван долоон настай царайлаг сайхан залуу байлаа. Тэр Пуффендуйн квиддичийн багийн ахлагч бөгөөд баригч хийдэг билээ.

- Сайн уу гэж бүгдтэй Седрик мэндлэв.

Фред, Жорж хоёроос бусад нь Седриктэй мэндлэв. Тэд Седрик өнгөрсөн жил Гриффиндорыг эхний тэмцээнд хожсоныг мартаагүй байгаа болохоор зөвхөн хүйтнээр толгой дохижээ.

- Наашаа ирэх гэж удав уу, Артур? гэж Седрикийн эцэг асуулаа.

- Үгүй дээ. Бид тосгоны цаана амьдардаг юм. Харин чи? гэж ноён Уизли хэллээ.

- Бид хоёр цагт боссон. Седрикийг шилжих шалгалтаа амжилттай өгөөсэй гэж бодож байна. Би бараг унтсангүй! Квиддичийн Дэлхийн цомын тэмцээн шүү дээ! Үүнийг уут дүүрэн галлеоноор ч солихгүй гэхдээ тасалбар нь угаасаа тийм үнэтэй. Гэхдээ надад аз таарсан л даа гээд тэр ах дүү гурван Уизли болон Харри, Гермiona, Жинни нар луу харснаа,

- Бүгд чинийх үү, Артур? гэв.

- Зөвхөн шаргал үстэй нь гэж ноён Уизли инээмсэглэн хүүхдүүдээ заагаад,

- Энэ бол Гермiona. Роны найз байгаа юм. Бас түүний анд Харри...

- Мерлины сахал минь! Харри? Харри Поттер уу? гээд Амос Диггорийн нүд бүлгийлээ.

- М-м-м... тийм гэж Харри хэллээ.

Тэр түүнтэй уулзсан хүмүүс духан дээрх сорви руу нь нүдээ бүлгийлгэн хардаг явдалд дассан ч эвгүйцэхээ мэдэрчээ.

- Мэдээж, Седрик чиний тухай ярьсан. Чамайг өнгөрсөн жил хэрхэн хожсон тухайгаа ярьсан.. Би түүнд <<Седрик чи үүнийг ачдаа ярих ёстой... Чи Харри Поттерийг ялсан!>> гэж хэлсэн.

Харри юу хэлэхээ мэдсэнгүй. Фред, Жорж хоёр ахин баргар царайлж, Седрик ичингүйрлээ.

- Харри шүүрнээсээ унасан шүү дээ, аав аа. Би таньд хэлсэн биз дээ... Золгүй тохиолдол болсон гэж.

- Тиймээ, гэхдээ чи унаагүй биз дээ? Чи минь даруухан жинхэнэ эр хүн шүү... Гэхдээ шилдэг хүн л ялдаг. Харри намайг зөвшөөрч байгаа биз дээ! Нэг нь шүүрнээсээ унасан байхад нөгөө нь үгүй. Хэн нь илүү нисдэг байна? Ийм энгийн асуултанд хариулахын тулд гоц ухаантай байх шаардлагагүй! гээд тэр хүүгийнхээ нуруун дээр элэгсэгээр алгадлаа.

- Явах цаг болчихож. Одоо хэн нэгэн ирэх эсэхийг мэдэхгүй биз, Амос? гэж ноён Уизли цагаа хараад асуулаа.

- Үгүй байх... Лавгуд тэнд долоо хоногийн өмнө очсон харин Фосеттэд тасалбар олдоогүй. Энд бүсэд биднээс өөр хүн байхгүй биз дээ гээд ноён Диггори толгой сэгсэрлээ.

- Хэн ч байхгүй гэж ноён Уизли зөвшөөрөөд,

- Нэг хором үлдлээ... Бэлтгээрэй. Зөөвөрлөгчид нэг хуруугаараа хүрэхэд болно гэж Харри, Гермиона хоёрт хандан хэллээ.

Нүсэр том үүргэвчнүүдтэйгээ шахалдан байж бүгд арайхийн Амосын барьж байгаа хуучин шаахайнд хуруугаа хүргэн тойрон зогслоо.

Толгодын орой дээр хүйтэн салхитай байсан болохоор цагариглан зогсоод нэг ч үг хэлсэнгүй. Харри гэнэт энэ үйл явдал санамсаргүй өнгөрч байгаа маглд ямар харагдах талаар бодлоо. Насанд хүрсэн хоёр эрэгтэй бүхий есөн хүн хуучин шаахайнд гараа хүргээд харанхуйд дугуйран зогсож ямар нэгэн хүлээж байдаг...

- Гурав... хоёр... нэг... гэж ноён Уизли шивнээд цагаа хяламхийн харлаа.

Харри дийлдэшгүй хүчээр хүйснээсээ дэгээдүүлсэн мэт урагшаа татагдан хөл нь газраас хөндийрөхөд баруун зүүн талд нь Рон, Гермиона хоёрын мөр цохилж байлаа. Тэд салхины улин исгэрэх дуунд хуйлран эргэлдэж долоовор хуруу нь гутланд соронзон аятай татагдан хийслээ.

Хөл нь гэнэт газардахад Рон дээр нь дарж уналаа. Шаахай бөглүү чимээ гаргаад Харрийн чихний хажууд газардав.

Харри толгойгоо өргөөд ноён Уизли, ноён Диггори болон Седрик нар хөл дээрээ газардсаныг харав.

- Таван цаг долоон минут Үентолгой толгод гэж тэдний ард хэн нэгний хэлэх хоолой сонсогдлоо.

БҮЛЭГ 7: БЭГМЕН БА КРАУЧ

Харри Роны дороос мөлхөж гараад босов. Тэд манантай зэлүүд намагт газарджээ. Тэднийг хоёр эцэж ядарсан ууртай шидтэн угтан ирлээ. Нэг нь том алтан цагаа харахад, нөгөөх нь хуйлаастай цаас үзэг гаргалаа. Хоёулаа маглуудын хувцас өмссөн нь авцалдаагүй харагдана. Цагтай шидтэн ноосон даавуун костюм өмсөж урт түрийтэй гутал угласан байх агаад мэргэжил нэгт нөхөр нь шотланд банзал өмсөж нөмрөг хөдөрчээ.

- Өглөөний мэнд, Бэзил гэж ноён Уизли хэлээд шаахайг банзалтай шидтэнд сунгав.

Тэр түүнийг аваад ашиглагдсан зөөвөрлөгчийн хайрцагт хийлээ. Харри тэнд хуучин сонин, пивоны лааз, хагарсан бөмбөг байхыг харлаа.

- Өглөөний мэнд гэж Бэзил ядрангуй бувтнаад,

- Жижүүрт гараагүй юу, Артур? Зарим нэгэн ч... бид энд шөнөжингөө зогслоо... Та нар замдаа гарсан нь дээр байх. Удахгүй таван цаг арван таван минутад Хар ойд томоохон хэсэг ирнэ... Хүлээгээрэй, чиний буудаллах газар бол... Уизли... Уизли... гээд урт жагсаалт гүйлгэн,

- Эндээс дөрвөн милийн зайд байгаа нэгдүгээр талбай. Талбай зохицуулагчыг ноён Робертс гэж дуудаарай. Диггори... Хоёрдугаар талбай... ноён Пейнээс асуугаарай гэв.

- Баярлалаа, Бэзил гэж ноён Уизли хэлээд бүгдийг араасаа дага гэж дохив.

Тэд хүнгүй зэлүүд талбайгаар явахад мананд бараг юу ч олж харах боломжгүй байлаа. Хорин хормын дараа хаалганы дэргэд байрлах чулуун байшин тодрон харагдав. Байшингийн цаана манан дунд олон зуун майхан харагдаж харанхуй ой тэнгэрийн хаяа хүртэл үргэлжилжээ. Тэд Диггорийнхонтой салах ёс гүйцэтгээд байшингийн үүд рүү очлоо.

Үүдэн дээр нэг хүн зогсоод майхнууд руу харж байв. Харри түүнийг харсан даруйдаа тэдний өмнө жинхэнэ магл зогсож буйг ойлголоо. Тэр хөлийн чимээ сонсоод ирэгсэд рүү эргэн харав.

- Өглөөний мэнд! гэж ноён Уизли хөгжилтэйгээр хэлэв.

- Өглөөний мэнд гэж магл хэллээ.

- Таныг ноён Робертс гэдэггүй биз?

- Би байна. Харин та нар хэн бэ? гэж ноён Робертс хэллээ.

- Уизли... Хэдэн өдрийн өмнө хоёр майхан захиалсан.

- Уизли байна. Таны газар ойн хажууд байгаа... Нэг шөнө үү? гэж ноён Робертсон хаалганд хадсан жагсаалтыг харан хэллээ.

- Тийм.

- Одоо төлбөрөө хийх үү?

- Тиймээ, тэгэлгүй яахав гэж ноён Уизли хэлээд байшингаас холдон Харриг ойрт гэж зангалаа.

- Надад туслаач гэж тэр нам дуугаар шивнээд халааснаасаа хуйлсан маглуудын мөнгө гаргаж нэг талаас нь эргүүлэн,

- Энэ чинь юу билээ... –э-э-э... арав уу? Аан тийм л дээ жижигхэн тоо байна... Харин энэ тав уу? гэв.

- Энэ бол хорь гэж Харри аяархан хоолойгоор хэллээ. Робертс тэдний яриаг сонсох гэж чих тавьж харагдана.

- Аан тийм л дээ... Би энэ жижигхэн цааснуудыг ялгахгүй юм...

- Та гадаадаас ирсэн үү? гэж ноён Уизлиг зөв дэвсгэртээ барьсаар ирэхэд ноён Робертсон асуулаа.

- Гадаадаас гэнэ ээ? гэж ноён Уизли бодлогоширон асуулаа.

- Та мөнгө ялгаж чадахгүй байгаа анхны хүн биш. Арван хормын өмнө хоёр удаа автомашины дугуйн тагны хэмжээтэй алтан зоосоор надад төлбөр хийхийг оролдсон шүү.

- Тийм гэж үү? гэж ноён Уизли бухимдан асуулаа.

Ноён Робертс лаазан дотор бутархай мөнгө жингэнүүлэн онгичсоноо,

- Хэзээ ч ийм олон хүнийг харж байсангүй. Зуу зуун захиалга. Ердийн хүмүүс бол зүгээр л хүрээд ирдэг... гээд ахин манантай талбай руу харлаа.

- Тэгэх нь зүйтэй юу? гэж түүний яриаг ноён Уизли таслаад хариулт авахаар гараа сунгасан ч ноён Робертс буцааж өгөхөөр яарсангүй.

- Тиймээ. Хичнээн их хүн гээч! Дүүрэн гадаадынхан. Зүгээр ч нэг гадаадынхан биш хачирхалтай хүмүүс. Тэдний нэг нь шотланд банзал нөмрөгтэй явж байсан гэж тэр бодлогоширон хэллээ.

- Тэгэх ёсгүй байсан юм уу? гэж ноён Уизли сэтгэл зовон асуулаа.

- Энэ ямар нэгэн төрлийн... сайн мэдэхгүй юм... цуглаантай адил гээд толгойгоо сэгсэрснээ,

- Бүгд бие биенээ таньдагаас үзэхэд томоохон бүлэг бололтой... гэв.

Яг тэр агшинд ноён Робертсын хажууд хаа агаараас гольфын өмдтэй шидтэн гарч ирлээ.

- Обливиэйт! гэж тэр ноён Робертс руу саваагаа чиглүүлэн чанга хашгирав.

Маглын нүд зүг бүр тийш эргэлдсэнээ духны үрчлээс нь толийж царай нь нойрмог хайхрамжгүй төрхтэй боллоо. Харри ой ухаан өөрчлөлтийн шинж тэмдэгүүдийг танилаа.

- Энэ таны буудаллах газрын зураг. Бас хариулт чинь гэж ноён Робертс дөлгөөхөн бувтналаа.

- Их баярлалаа гэж ноён Уизли хэлэв.

Гольфийн өмдтэй шидтэн тэднийг талбайн хаалганд хүргэж өгөв. Түүний зүдэрсэн царайн сахал нь өрвийж, нүдний дор нь хар өнгө сүүдэртэнэ. Ноён Робертсэд сонсогдохооргүй холдсон хойно шидтэн ноён Уизлид аяархан гомдоллов.

- Энэ хүн бишгүй төвөг удаж байна. Өдөрт арван удаа ой ухааны шидийг хэрэглэж байна. Людо Бэгмен огт туслахгүй юм. Буудлаар нэг гүйж блажер, квоффлийн талаар хашгираад явахаас бус маглуудаас сэргийлэх тухайд санаа тавьж байгаа юм алга. Энэ бүгдийг дуусахыг хүлээж чадахгүй нь. Баяртай, Артур удахгүй уулзая.

Жижүүр шилжин алга болов.

- Гэхдээ ноён Бэгмен ид шидийн спорт тоглоомын хэлтсийн дарга шүү дээ! Тэр маглуудын хажууд блажерын тухай ярилцаж болохгүйг мэднэ биз дээ? гэж Жинни гайхлаа.

- Тэр мэднэ л дээ. Гэвч Людо үргэлж... аюулгүй байдалд хайнга ханддаг юм. Спортод дуртай л даа. Спортын хэлтсийг өөр урам зоригтой хүн толгойлоосой гэж хүсэх юм биш. Түүнийг Английн шигшээд квиддич тоглодог байсныг мэднэ биз дээ. Уимбурнскийн хэдгэнүүдэд хэзээ ч тийм довтлогч байгаагүй юм шүү гээд гээд ноён Уизли инээмсэглэн талбайн хаалгаар орлоо.

Тэд манантай талбай дээрх майхны урт эгнээ дундуур явлаа. Олонхи майхны эзэд ердийн байдалтай харагдахыг оролдож байсан ч зуухны яндан ёрдойж, хонх өлгөн, салхины чиг заагч тавьсан харагдана. Тэд нээлттэй майхнуудын хажуугаар өнгөрөх үед шидтэнгүүдийг хараад Харри ноён Робертсийн сэжиглэлийг ойлголоо. Замын хагаст тэд чамин тансаг торго шиг эдээр хийсэн жижигхэн ордон харлаа. Гадаа нь уяатай хэдэн тогос зугаалж байв. Тэр ч байтугай хэд хэдэн цамхаг бүхий гурван давхар майхан байлаа. Түүнээс цаахан талтайд шувуутай цөөрөм, нарны цаг болон усан оргилуур бүхий цэцэрлэгтэй ч байв.

- Үргэлжид ийм байх юм даа. Хамтдаа байхдаа гайхуулах боломжыг алдахгүй шүү. За ирцгээлээ. Энэ манай газар гэж ноён Уизли инээмсэглэн өгүүлэв.

Тэд талбайн өндөрлөгт байрлах модны зах дахь хоосон газар хүрч ирсэн бөгөөд <<УИЗЛИ>> гэж бичсэн жижиг самбар газар зоожээ.

- Үүнээс сайхан газрыг олохгүй шүү! Тэмцээн болох газар ойн цаана байгаа. Бидэнтэй маш ойрхон гэж ноён Уизли баяртайгаар гараа үрчин хэлээд газар үүргэвчээ тавьж үл ялиг сэтгэл зовнисон өнгөөр,

- Тэгэхээр бүх төрлийн ид шид хориотой гэдгийг санаж авцгаа. Хатуухан хэлэхэд ямар ч ид шид байхгүй. Бид маглуудын газар нутагт байна. Майхнаа өөрийн гараар босгоно! Энэ тийм ч хэцүү биш байх... Маглууд үүнийг үргэлж хийж байдаг юм... Харри, чинийхээр бол хаанаас эхлэх ёстой вэ? гэв.

Харри амьдралдаа хэзээ ч майхан босгож байсангүй. Дурслийнхан түүнийг амралтаараа авч явдаггүй бөгөөд зэргэлдээх хөрш болох хатагтай Фиггтэй үлдээдэг байв. Гермiona тэр хоёр олон тулгуур, гадаснуудын учрыг олж ажиллаж эхлэхэд

ноён Уизли сэтгэл хөөрсөндөө модон алх барин туслахаасаа илүү саад болж эцэст нь хоёр хүний майхан бослоо.

Бүгд ухран өөрсдийн гараар байгуулсан зүйлээ бахдан харав. Энэ майханг хараад шидтэн босгосон гэж хэний ч толгойд орохгүй аж. Харри Билл, Чарли, Перси гурав ирэхээр арвуулаа болох нь гэж бодов. Гермiona ч мөн санаа зовсон бололтой Харри руу асуунгуй харахад ноён Уизли дөрвөн хөллөн майхан руу мөлхөн орлоо.

- Жаахан давчуу л юм. Гэхдээ бүгдээрээ шахаад багтана. Ороод харцгаа гэж дотроос нь хэлэв.

Харри үүдийг сөхөн шурган ороод амаа ангайлаа. Энэ бол унтлагын өрөө, жорлон, гал зуух бүхий хуучин загварын маглын байшин байв. Хамгийн хачирхалтай нь тавилга хэрэгсэл нь хатагтай Фиггийн байшинг санагдуулж сүлжээсэн бүтээлэгтэй янз бүрийн сандлууд байх бөгөөд муурын үнэр хүчтэй ханхалж байлаа.

- Бид энд нэг л хонох болно. Би үүнийг хэлтэст хамт ажилладаг Перкинсээс түр авсан юм. Тэр ч одоо аялалаар явахаа больсон доо, хөөрхий амьтан нурууны өвчтэй юм гэж ноён Уизли хэлээд халзан толгойгоо алчуураар арчин унтлагын өрөөний дөрвөн ширхэг давхар орыг харав.

Тэр данх авснаа доторхыг нь харав.

- Бидэнд цай чанах ус хэрэгтэй...

- Газрын зураг дээр маглуудын ус түгээгүүр байсан. Талбайн нөгөө талд гэж Харригийн араас орж ирсэн Рон хэллээ. Тэр майхны ер бусын хэмжээнд гайхсангүй.

- Харри, Гермiona та гурав усанд яваад ир. Үлдсэн нь гишүү цуглуулж гал асаана шүү гэж ноён Уизли хэлээд хэдэн данх болон хоолны сав өглөө.

- Гэхдээ бидэнд зуух байгаа биз дээ. Яагаад зүгээр л... гэж Рон эсэргүүцэв.

- Маглуудын эсрэг аюулгүй байдал! Маглууд зугаалганд явах үедээ задгай агаарт хоолоо бэлтгэдэг юм байна лээ. Би үүнийг яаж хийхийг харсан гэж ноён Уизли сэтгэл хангалуун инээмсэглэн хэллээ.

Арай жижиг муурын үнэр ханхлаагүй охидын майхантай танилцах аялал хийснийхээ дараа Харри, Рон, Гермiona гурав буудал дундуур данх савтай усанд явлаа.

Манан нэвтлэн нарны туяа тусахад андууд аварга том майхны хотод орлоо. Тэд эгнээ хооронд алгуурхан явж майхны эздийг сонирхон харж байв. Одоо л Харри дэлхий дээр ямар олон шидтэн байдгийг ойлгов. Тэр өөр улсад байдаг шидтэнгүүдийн тухай хэзээ ч бодлогоширч байсангүй.

Буудал сэрж эхэлж байсан учир хөл хөдөлгөөн багатай байлаа. Хүүхэдтэй эцэг эхчүүд түрүүлэн сэржээ. Харри хэзээ ч бяцхан шидтэнгүүдийг харж байсангүй. Хоёр наснаас хэтрээгүй жаахан хүү пирамидтай төстэй майхны үүдэнд суугаад шидэт саваагаар ногоон дээр байсан өтийг зайдасны хэмжээтэй болгон томруулав. Тэднийг ойртож очих үед майхнаас ээж нь яаран гарч ирэв.

- Чи юу хийж байна, Кевин? Аавынхаа саваанд хүрч болохгүй гэж чамд хичнээн хэлэх гэсэн юм бэ!

Тэрбээр томорсон өтийг няц гишгэв. Түүний зэмлэхтэй дуутай зэрэгцэн хүүгийн <<Та өтийг алчихлаа! Түүнийг алчихлаа!>> гэж хашгирах сонсогдоно.

Түүнээс цаахан Кевинээс хэд эгч хоёр охин тоглоомон шүүрэн дээр суугаад нам газар нисэхэд хөл нь өвсөн дээр шүргэх аж. Ид шидтэний яамны ажилтан дүрэм зөрчихийг даруй ажиглан тэр гурвын хажуугаар гүйн өнгөрөөд түгшсэн дуугаар <<Гэгээн цагаан өдрөөр шүү! Эцэг эхчүүд нь унтаж байгаа биз...>> гэж дуу алдав.

Энд тэнд насанд хүрсэн шидтэнгүүд майхны үүдэнд суугаад өглөөний цайгаа бэлтгэж байв. Зарим нэг нь сэмхэн хяламхийн хараад саваагаараа гал асаахад, өөр нэг нь энэ ажиллахгүй дээ гэсэн байртай шүдэнз зурж байлаа. Урт цагаан жанч бүхий Африкаас ирсэн гурван шидтэн халуун яриа өрнүүлэн сууж туулайн бололтой махыг хурц ягаан гал дээр шарна. Холгүйхэн орших америкаас ирсэн шидтэнгүүд хөгжилтэйгээр шуугилдан гялтганасан далбаа дээр <<САЛЕМИЙН ШУЛМУУДЫН ХҮРЭЭЛЭН>> гэж бичээд майхан дээрээ хатгалаа. Тэдний олонхи нь догдолсон байртай үл мэдэх хэлээр ярьцгаана.

- Миний нүдэнд учир байна уу эсвэл эргэн тойрны бүх зүйл ногоорчихов уу? гэж Рон дуу алдав.

Роны нүд буруу харсангүй. Тэднийг явах тусам гурван навч бүхий майхнууд өсөн нэмэгдсээр хачирхалтай ногоон толгод шиг үзэгдэнэ. Зарим майхнаас үүдээр хөгжилтэй инээмсэглэх царай харагдана. Тэгтэл тэдний нэрийг дуудах нь сонсогдлоо.

- Харри! Рон! Гермиона!

Энэ бол Гриффиндорын дөрөвдүгээр дамжааны Симус Финниган байв. Тэр гурван навч бүхий майхны дэргэд сууж байв. Хажууд нь эх нь бололтой шаргал үстэй эмэгтэй болон түүний дотны анд Дин Томас байлаа.

- Манай чимэглэл ямар байна? Ид шидийн яамныханд таалагдаагүй гэж Симус инээмсэглэн асуув.

- Бид яагаад майхнаа дуртай өнгөөрөө яагаад будаж болохгүй гэж? Болгарынхан майхнаа яасныг та нар хараарай! Та нар Ирландыг дэмжиж байгаа биз дээ? гэж эмэгтэй нүдээ гялалзуулан асуулаа.

Тэд үнэхээр ирландыг дэмжиж байгаа гэж итгүүлээд цаашаа явахад Рон <<Ийм нөхцөлд өөр юу хэлэх ёстой байсан гэж?>> хэмээн хэлжээ.

- Болгарынхан майхнаа юугаар чимсэн нь сонирхолтой юм? гэж Гермиона хэлэв.

- Явж харцгаая! гээд Харри салхинд улаан ногоон цагаан өнгөөр дэрвэлзэх далбаа бүхий майхны зүг заав.

Эдгээр майхнууд амьд ургамлын өнгөөр хучигдаагүй ч бүгд ширүүн царай, өтгөн хар хөмсөг бүхий зурагт хуудсаар дүүрсэн байлаа. Хөрөг зураг амьд хэдий ч хөмсөг зангидан нүд цавчихаас өөр зүйл хийхгүй аж.

- Крам гэж Рон аяархан хэлэв.
- Юу гэнээ? гэж Гермiona асуулаа.
- Крам! Виктор Крам. Болгарын баригч! гэж Рон давтлаа.
- Их ууртай төрхтэй юм гэж Гермiona эргэн тойрон нүд цавчин хөмсөг зангидаж буй олон Крамыг харж хэлэв.
- Ууртай гэнээ? Гэхдээ хэний санаа үүнд зовно гэж? Тэр бол гайхалтай! Их залуухан ердөө арван найман настай. Тэр бол гоц авъяастан орой өөрөө хараарай.

Талбайн өнцгийн ус түгээгүүрт багахан дараалал үүсчээ. Харри, Рон, Гермiona гурав маргалдаж буй хоёр шидтэний ард зогслоо. Тэдний нэг болох хөгшин шидтэн том цэцэгтэй унтлагын урт цамц өмсчээ. Хоёр дахь нь ид шидийн яамны ажилтан бололтой судалтай өмд барин уйлах нь холгүй зогсож байв.

- Арчи үүнийг өмсчих. Чи ингээд яваад байж болохгүй шүү дээ. Хаалган дээрх магл хэдийн сэжиг авчихсан гэж тэр цөхрөн хашгирлаа.
- Би үүнийг маглуудын дэлгүүрээс авсан юм. Маглууд ийм хувцас өмсдөг гэж хөгшин шидтэн зөрүүдлэн хэллээ.
- Маглуудын эмэгтэйчүүд өмсдөг болохоос эрэгтэйчүүд нь биш. Эрэгтэйчүүд нь үүнийг өмсдөг юм гээд ид шидийн яамны ажилтан өмдөө сэгсрэв.
- Өмсөхгүй ээ. Би биеэ цэвэр цэвэр агаарт байлгах дуртай, баярлалаа гэж Арчи зэвүүцэнгүй хэлэв.

Гермiona тачигнатал инээд алдан дарааллаас гарсан бөгөөд Арчиг усаа аваад явсан хойно эргэж ирлээ. Буцах замдаа тэд усаа өргөсөөр буудал дундуур алгуурхан явах зуураа Хогвартсын олон таньдаг царай харав. Гриффиндор багийн ахмад байсан Оливер Вуд (өнгөрсөн жил сургуулиа төгссөн) Харриг майхныхаа дэргэдүүр өнгөрөхөд эцэг эхтэйгээ баяртайгаар танилцуулж <<Пэдлмор Юнайтед>> багийн нөөц тоглогчоор орохоор гэрээнд гарын үсэг зурснаа баяртайгаар ярилаа. Дараа нь тэднийг Пуффендуй тэнхимийн дөрөвдүгээр дамжааны Эрни МакМиллан зогсоож, ердөө хэдэн алхамын цаана байсан Когтевраны баригч Чжоу Чанг Харриг хараад гар даллан инээмсэглэхэд тэр хариу даллахдаа ихэнхи усаа асгачихлаа. Рон ойлгосон шинжтэй харахад Харри ичсэндээ түүнийг нудраад хэсэг үл таних өсвөр насны үеийнхэн рүү заав.

- Чинийхээр бол тэд хэн бэ? Хогвартсад явдаггүй биз дээ? гэж тэр асуулаа.
- Ямар нэгэн гадаадын сургуулийнх байх. Өөр сургуулиуд байдаг гэдгийг мэднэ. Гэхдээ сурч байгаа хүнтэй тааралдаж байгаагүй юм байна. Билл Бразилд сурдаг нэг сурагчтай захиагаар харилцдаг байсан юм... бараг зуун жилийн өмнө... Тэр солилцоогоор аялалд явахыг хүссэн ч эцэг эхэд маань тийм боломж байгаагүй учир Билл очихгүй гэдгээ бичсэн л дээ. Бразилийн найз нь гомдсондоо түүнд шившлэг хийсэн малгай илгээгээд Биллийн чих агшчихсан.

Харри инээд алдсан ч бусад сургуулиудын тухай сонсоод гайхсангүй. Буудалд маш олон үндэстний төлөөлөл байгаагаас үзэхэд Хогвартс цорын ганц сургууль гэж

бодох нь тэнэг хэрэг байлаа. Харри Гермиона руу хальт харахад тэр бусад сургуулийн тухай мэддэг бололтой огт гайхсан шинжгүй харагдана. Тэр бусад сургуулийн тухай ямар нэг номноос уншсан нь эргэлзээгүй.

- Та нарыг үхсэн л юм байх гэж бодлоо хэмээн Жорж тэднийг майхандаа эргэж ирэхэд нь бувтнажээ.

- Хичнээн их танил хүмүүстэйгээ тааралдсан гээч! Харин та нар галаа ч асаагаагүй байгаа юм уу! гэж Рон усаа доош нь тавиад хэлэв.

- Аав шүдэнзээр тоглож байгаа гэж Фред хэллээ.

Ноён Уизлигийн түүдэг асаах оролдлого амжилтгүй болжээ. Эргэн тойрны газар хугарсан шүдэнзээр дүүрсэн ч түүнийг тийм аз жаргалтай байхыг хэзээ ч харж байсангүй.

- Өө! гэж тэр гал манасхийхэд дуу алдаад шүдэнзээ газар хаялаа.

- Надад өгөөч ноён Уизли гэж Гермиона аяархан хэлээд хайрцагыг авч шүдэнз асаахыг үзүүлэв.

Эцсийн эцэст түүдэг ассан ч илч муутай гал дээр хоол чанаж болохооргүй байсан учир ахин цаг хүлээв. Харах зүйл их байсан болохоор уйдах юм байсангүй. Тэдний майхан яг цэнгэлдэх хүрээлэн рүү явах замд байв. Дэргэдүүр нь ид шидийн яамны ажилчид яаран өнгөрөх үедээ ноён Уизлитай нөхөрсөг мэндлэх агаад тэрбээр ихэвчлэн Харри, Гермиона хоёрын талаар товч тайлбар тавьж байв (Түүний хүүхдүүдийг ид шидийн яамныхан бүгд мэддэг юм шиг санагдана).

- Энэ бол Катберт Мокридж албингуудын холбооны удирдах дарга... Харин энэ бол Гилберт Уимпил ид шидийн шившлэгийн туршилтын хорооны мэргэжилтэн. Эврийг нь харж байна уу... ургаад удаагүй байгаа юм. Сайн уу Арни... Энэ бол Арнольд Миргуд ой ухаан цэвэрлэгч байгаа юм. Санаандгүй шидийг цуцлах хэлтсийн гишүүн. Харин энэ бол Бойд, Крокер хоёр... хэлж болохооргүйчүүд.

- Хэн гэнээ?

- Нууцын хэлтсийнх. Бүх юм нууц байдаг болохоор юу хийдгийг нь мэдэх юм алга.

Эцэст нь гал асаж өндөг чанаж, зайдас шарлаа. Тэгтэл Билл, Чарли, Перси нар ирцгээв.

- Саяхан шилжиж ирлээ.. Ямар сайхан юм бэ! Яг хоолон дээр! гэж Перси хэлэв.

Хоол идэх зуур ноён Уизли гэнэт үсрэн босоод тэдэн рүү ирж буй хүн рүү гар даллав.

- Үйл явдлын гол царай! Сайн уу, Людо! гэж тэр баяртайгаар дуу алдав.

Өнөөдөр хөгшин Арчийн эмэгтэй хүний цэцэгтэй унтлагын хувцасыг оролцуулаад ч Харри ийм анхаарал татам хүн харж байсангүй. Людо Бэгмен квиддичийн тоглогчийн хөндлөн шаргал хар судал бүхий цээжин дээрээ том хэдгэнэтэй урт жанч өмсчээ. Түүний хүч тэнхээ нь харьсан бололтой жанч нь нэгэн цагт Английн шигшээд тоглож байх үедээ ийм байгаагүй том гэдсийг нь чанга барьж байв. Хамар

нь хугархай агаад (Блажерт цохиулсан байх гэж Харри бодов) дугуй цэнхэр нүд, богинохон цайвар үс, ягаан хацар нь түүнийг сургуулийн өсгөлүүн сурагч шиг харагдуулна. Тэрбээр хөөрсөндөө хөлдөө пүрштэй юм шиг дэвхэрч явлаа.

- Сайн уу. Артур, хөгшин минь гэж Бэгмен хөгжилтэй хашгиран мэндлээд,

- Сайхан өдөр байна тийм үү! Үүнээс илүү цаг агаарыг хүсэх юм биш. Өнөө шөнө үүлгүй байна гэсэн... Аюулгүй байдлын арга хэмжээнд саад болох юм алга... Надад энд хийх зүйл юу ч алга! гэв.

Түүний нурууны ардуур ид шидийн яамны хэдэн эцэж ядарсан ажилтангууд гүйн өнгөрч шидэт гэдгийг нь нотлох хөх ягаан өнгийн оч бүхий арван метрийн өндөрт дүрэлзэж байгаа гал руу яарлаа. Перси яаран очиж гар барив. Мэдээж тэр Людо Бэгмен хэлтсээ яаж удирддагт зэмлэнгүй ханддаг ч яаж таагүй сэтгэгдэл төрүүлж болох билээ!

- Энэ миний хүү Перси. Саяхан яаманд ажилд орсон юм. Харин энэ бол Фред... үгүй ээ, Жорж байна уучлаарай. Фред энэ байна. Энэ Билл, Чарли, Рон миний охин Жинни болон Роны найз Гермiona Грэйнджер бас Харри Поттер гэж ноён Уизли инээн хэллээ.

Алдартай нэрийг сонсоод Бэгмен Харригийн духан дээр байгаа сорви руу харлаа.

- Бүгдээрээ сонсож бай. Та нарын өмнө Людо Бэгмен өөрийн биеэр зогсож байна. Түүнд сайхан тасалбар олж өгсөний төлөө талархлаа илэрхийлээрэй!

Бэгмен инээмсэглээд юу ч биш гэсэн байртай гараа дохив.

- Тоглолтонд азаа үзэхгүй юм уу, Артур? гэж тэр сонирхон асуугаад багагүй алт бүхий судалтай жанчныхаа халаасыг шажигнуулан,

- Ирландын гурав сүүлийн жилүүдэд их хүчтэй байгаа ч гэсэн би Болгарын ангууч Родди Понтнерийг түрүүлж оноо авна гэж тавьчихсан.. Харин жижиг Агата Тиммс могой загасныхаа фирмийн хувьцааг тэмцээн долоо хоног үргэлжлэнэ гэж тавьсан гэв.

- Бодох хэрэгтэй. Ирландыг ялна гэж нэг галлеон тавьдаг юм бил үү? гэж ноён Уизли хэлэв.

- Нэг галлеон гэнэ ээ? гэж Бэгмен урам хугарсан байртай асуусан ч дорхноо биеэ бариад,

- Сайхан хэрэг галлеон бол галлеон шүү дээ... Харин бусад нь мөрийцөхгүй юм уу? гэв.

- Тэд мөрийтэй тоглоом тоглоход хэт залуу байна. Молли үүнийг зөвшөөрөхгүй гэж ноён Уизли хэлэв.

- Бид гучин долоон галлеон, арван таван сикль, гурван кнатыг Ирланд хожсон ч снитчийг Виктор Крам барина гэж тавилаа. Бас нэг хуурамч шидэт саваа нэмэрлэе гэж Фред, Жорж хоёр халаасаа хоослон хэлэв.

- Ноён Бэгменд тэнэг зүйлээ үзүүлэх хэрэггүй шүү гэж Перси уурсан бувтналаа.

Гэвч саваа Людо Бэгменд таалагджээ. Тэр түүнд хүрэхэд саваа чанга гооглох дуу гаргаад резинэн тахиа болон хувирлаа. Бэгмений хүүхдийн царай баясан гийж инээд алдав.

- Гайхамшигтай! Ийм үнэмшилтэй зүйл удтал харсангүй! Таван галлеоноор тооцож авлаа!

Перси унтууцан хөшлөө.

- Хөвгүүдээ би та нарыг мөрийцөөсэй гэж хүсэхгүй байна. Энэ чинь та нарын бүх хадгаламж шүү дээ... Ээж чинь... гэж ноён Уизли хэлэв.

- Хорих хэрэггүй дээ, Артур! гээд Людо Бэгмен халаасаа хөгжилтэй шажигнуулан сэгсэрснээ,

- Тэд нар юу хүсч байгаагаа мэдэх насанд хүрсэн! Тэгэхээр та нар Ирланд ялсан ч снитчийг Крам барина гэдэгт итгэлтэй байгаа юм биз дээ? Бага боломж байна хүүхдүүдээ, бага шүү... Бооцоонд чинь амжилт хүсье... Хуурамч савааны таван галлеоныг нэмлээ...

Людо Бэгмен дэвтэр, үзэг гаргаж ирээд ноён Уизлигийн золгүй царайн дор ихрүүдийн нэрсийг бичив.

- Баярлалаа гээд Жорж Бэгменээс хуудас цаасыг аваад жанчны дотор халаасандаа хийлээ.

Людо баяртайгаар ноён Уизли руу эргэн харав.

- Цайгаар зочлохгүй юм уу? Би Барти Краучыг хайж байгаа юм. Надад Болгарын талтай ойлголцоход хүндрэл үүсээд байна. Тэдний юу яриад байгааг ойлгохгүй байна л даа. Барти бараг зуун тавиад хэл мэддэг болохоор тусалж чадах байх.

- Ноён Крауч уу? Бараг зуун тавиад гэнэ ээ? гээд Персигийн царайнаас дургүйцсэн өнгө нисэн алга болж,

- Тэр бараг хоёр зуугаад хэлээр ярьдаг юм! Лусны дагина, албин, савдагийн хэлээр хүртэл гээд тэсч ядан чичигнэлээ.

- Хэн ч савдагын хэлээр ярьж чадна. Зөвхөн хуруугаараа чичиж хуухитнахад хангалттай гэж Фред үл ойшоосон байртай хэллээ.

Перси Фред руу таагүйхэн харсан ч түүдэг гал дээрх цайг буцалгахын тулд галаа заслаа. Бэгмен өвсөн дээр тэдэнтэй зэрэгцэн суув.

- Берта Жоркинсоос сураг байна уу? гэж ноён Уизли асуув.

- Ямар ч сураг алга. Гэхдээ тэр эргээд ирнэ. Хөөрхий Берта ой ухаан нь шүүрэн шанага шиг болохын дээр бас газрын зураг мэдэхгүй. Хаа нэгтээ төөрч л яваа. Хэлтэстээ арван сард эргэж ирэхдээ долоон сар гэж итгэх л хүн дээ гэж Бэгмен тайван хэлээд Персигийн сунгасан цайг авлаа.

- Түүнийг эрэхээр хэн нэгнийг явуулсан нь дээр гэж бодохгүй байна уу? гэж ноён Уизли шийдэмгий бус асуув.

- Барти надтай энэ тухай ярилцсан. Гэхдээ бидэнд одоо сул хүн алга. Өө, чөтгөр гэж! Барти байна! гэж Бэгмен дуу алдаад цэнхэр нүдээ гэмгүйхэн бүлтийлгэв.

Түүдэг галын дэргэд хэдгэнэтэй хуучин жанч бүхий тэрийн сууж байгаа Людо Бэгменээс эсрэг төрхтэй шидтэн шилжин гарч ирлээ. Барти Каруч үнэнч шударга байрын ахимаг насны хүн бөгөөд өөлөх юмгүй цэвэрхэн костюм өмсөж зангиа зүүжээ. Богинохон буурал үсээ жигдхэн самнаж, уруулын дээд сахлаа тэгшлээд, шаахай нь лакадсан мэт гялалзаж байв. Тэр Персигийн шүтээн гэдэг нь ойлгомжтой байлаа. Перси дүрэм журмыг тууштай дагадаг бөгөөд харваас ноён Крауч тийм хүн байлаа. Тэр аюулгүй байдлыг даган мөрдөж маглуудын хувцсыг өмссөн нь банкинд ажилладаг мэт харагдана. Вернон ах хүртэл түүнийг шидтэн гэдгийг мэдэхгүй байсан буй за.

- Бидэнтэй ногоон дээр суугаач гэж хөгжилтэй Людо Бэгмен хэлээд дэргэдэх газраа алгадав.

- Үгүй дээ баярлалаа, Людо. Би чамайг хайж байлаа. Болгарчууд нэгдүгээр зэргийн суудалд арван хоёр сандал өгөхийг хүссэн гэж тэр ялимгүй тэвчээр алдсан өнгөөр хэлэв.

- Өө, тэд үүнийг л гуйгаад байсан хэрэг үү? Харин би чимхүүр асууж байгаа юм байх гэж бодлоо. Жаахан чанга аялгатай ярьдаг юм билээ.

- Ноён Крауч! Аяга цай уухгүйсэн болов уу? гэж Перси хагас бөхийн хэллээ.

- М-м-м? гээд ноён Крауч түүнийг гайхан харснаа,

- Тиймээ, баярлалаа Уизерби гэв.

Фред, Жорж хоёр аяга руугаа тургилав. Перси хавч шиг улайлаа.

- Би чамд хэдэн үг хэлэх гэсэн юм, Артур. Али Башир ууртай байна лээ. Тэр чамтай нисдэг хивсний хоригийн талаар ярилцахыг хүсэж байгаа юм байх гээд ноён Крауч хурц харцаар өрөмдлөө.

Ноён Уизли гүнзгий санаа алдав.

- Би түүнд өнгөрсөн долоо хоногт ууль илгээсэн. Бараг зуун дахиа хэлж байгаа юм. Нисдэг хивс бол маглуудын бүтээлийг шидтэн илбэдсэн хэрэг болохоор хориотой юм. Гэхдээ тэр сонсохыг хүсээгүй л дээ!

- Энэ ч илэрхий байна. Али Башир үүнийгээ зах зээлд оруулахыг маш их хүсч байсан гээд ноён Крауч толгой сэгсрэн Персигийн гараас цай авлаа.

- Гэхдээ тэд хэзээ ч Английн шүүрнүүдийг орлохгүй биз дээ? гэж Бэгмен асуулаа.

- Али нисдэг хивс гэр бүлийн тээвэрт чухал байр суурь эзлэнэ гэж үзэж байгаа юм. Өвөөд маань арван хоёр хүн багтдаг нисдэг хивс байсныг санаж байна. Гэхдээ хориглохоос өмнө л дөө.

Ноён Крауч өвөг дээдэс нь хүртэл хууль зөрчиж байгаагүй гэж батлахыг хүсч байгаа аятай харагдав.

- Ажил их байна уу, Барти? гэж Бэгмен хайхрамжгүй асуулаа.

- Хангалттай их. Зөөвөрлөгчдийг таван тив газар дагуу байрлуулах нь багагүй хүнд ажил шүү, Людо гэж Крауч хүйтнээр хэлэв.

- Гэхдээ маргааш бид чөлөөтэй амьсгал авч болно гэж тэднийг ноён Уизли урамшуулав.

Людо Бэгмен гайхсанаа нуусангүй.

- Чөлөөтэй амьсгална гэнэ ээ? Би хэзээ ч ийм хөгжилтэй байсангүй! Гэхдээ дахиад хийх зүйлс байхгүй гэсэн үг биш л дээ, Барти. Ахиад зохион байгуулах ажил зөндөө байгаа.

Ноён Крауч хөмсгөө учиртай өргөөд,

- Бид нарийн ширийн зүйлс тодорхой болтол олонд зарлахгүй тохиролцсон биз дээ... гэв.

- Нарийн ширийн зүйлс гэнээ! хэмээн Бэгмен шумуул хөөж буй аятай гараа даллаад,

- Бүгд гарын үсэг зурсан биз дээ? Бүгд зөвшөөрсөн. Тэгээд ч энэ тухай удахгүй хүүхдүүд мэднэ гэдэгт мөрийцсөн ч бэлхэн байна. Хогвартсад болох үед нь... гэв.

- Людо биднийг Болгарууд хүлээж байгааг битгий мартаарай гэж ноён Крауч түүний яриаг огцом таслаад,

- Цай өгсөнд баярлалаа, Уизерби хэмээн Персид хүрээгүй аягаа буцаан өглөө.

Бэгмен үлдсэн цайгаа ганцхан балгаад арайхийн хөл дээрээ босоход халаасан дахь зооснууд нь хөгжилтэй шаржигнав.

- Дараа уулзъя! Дээд талын давхарт хамт сууна шүү дээ. Би тайлбарлах юм! гээд тэрбээр гараа даллахад, Крауч хөндийдүү толгой дохиж хамтдаа агшин зуур шилжин алга болов.

- Хогвартсад юу болох юм бэ, аав аа? Тэд юуны тухай ярилцсан бол? гэж Фред даруйхан асуулаа.

- Удахгүй мэднэ гээд ноён Уизли инээмсэглэв.

- Энэ бол хаалттай мэдээлэл. Ид шидийн яам мэдэгдэх цаг нь хүртэл. Ноён Краучын зөв түүнийг задруулж болохгүй гэж Перси албархуу хэлэв.

- Амаа тат, Уизерби гэж ахдаа Фред зөвлөв.

Нар баруунаа хэлбийхэд хүмүүсийн сэтгэлийн хөөрөл шуурганы өмнөх үүл шиг нэмэгдсээр байв. Агаар хүртэл аугаа их цугларалтанд чичирч байх шиг санагдана. Үдшийн бүрэнхий буудлыг хучихад тэвчээрийн сүүлчийн хязгаар болов. Ид шидийн яам сэтгэл хөөрөлтэй эвлэрэхээр шийдсэн бололтой эргэн тойрон хаа сайгүй ид шид үзэгдэж байв.

Худалдаачид эргэн тойрны хоосон газарт шилжин ирж шидэт бараа бүхий тэрэг түрж явцгаана. Тэнд Ирландын хөгжөөн дэмжигчдийн ногоон, Болгарын дэмжигчдийн гэрэлтдэг улаан чимэглэл зарж байсан нь тоглогчдынхоо нэрсийг чангаар дуудах аж. Шовгор оройтой ногоон бүрх малгай дээр гурван навч бүжиглэж,

Болгарчуудын ороолтны арслан жинхэнээсээ архирч, улс бүрийн далбаа дээр үндэсний сүлд дуулал эгшиглэн, жижигхэн <<Аянга>>-ын загвар нисэж, алган дээрээ тавиад үс зүсээ янзлахыг нь харж болохоор тоглогчдын дүрс бүхий бүхэл бүтэн цуглуулга байлаа.

- Би үүний тулд зунжингаа халаасны мөнгөө цуглуулсан гэж Рон андуудтайгаа бэлэг дурсгал дундуур хэсэж байхдаа хэллээ.

Рон бүжиглэдэг навч бүхий том ногоон бүрх малгай болон Болгарын баригч Виктор Крамын жижиг дүрсийг авлаа. Жижигхэн Крам түүний алган дээгүүр зугаалж ногоон чимэглэл руу нь ширүүн харах аж.

- Энд юу байгааг хараач! гэж Харри хөөрөн хэлээд дурантай адил зүйл бүхий тэрэг рүү ухасхийв. Энэ бол хүрэл өнгийн олон янзын ойлгомжгүй товчлуур бүхий эд байв.

- Омнинокли. Дурын хөдөлгөөнийг давтаж чадна... Удаашруулж... эсвэл хөдөлгөөн бүрээр нь зураглан харж болно. Тийм ч үнэтэй биш ердөө арван галлеон гэж худалдагч хэллээ.

- Ээ, би яах гэж энэ дэмий зүйлийг худалдаж авав аа! хэмээн Рон бүжиглэдэг навч бүхий малгай руугаа дохиод омниноклийг ширтлээ.

- Гурван ширхэг гээд Харри худалдагчид гучин галлеон сунгав.

- Хэрэггүй! гээд Рон цөхөрсөндөө улайлаа. Тэр үргэлж эцэг эхийнхээ бага мөнгөтэй гэдгээс ичдэг байсан юм.

- Зул сараар ямар ч бэлэг өгөхгүй шүү. Ойрын арван жилдээ гэж бодоорой хэмээн Харри түүнийг тайвшируулаад андууддаа омниноклыг сунгалаа.

- Тэгвэл ч яахав гээд Рон инээмсэглэв.

- Баярлалаа, Харри. Харин би бүгдэд хөтөлбөр авчихъя Гермiona хэлэв.

Тэд мөнгөний хэтэвчээ хоослоод майхандаа эргэн ирлээ. Билл, Чарли, Жинни гурав бас бэлэг тэмдэг бүхий ногоон бүрх малгай авсан бөгөөд ноён Уизли Ирландын далбаа авчээ. Фред, Жорж хоёр бүх мөнгөө Бэгменд өгсөн болохоор юу ч авсангүй.

Хаа нэгтээ ойн гүнээс харанга чанга нүргэлэн дуугарахад мододын дунд ногоон улаан дэнлүү асаж цэнгэлдэх хүрээлэн рүү явах замыг гийгүүлэв.

- Явах цаг боллоо! гэж хүүхдүүдээсээ дутуугүй догдолсон ноён Уизли хэллээ.

БҮЛЭГ 8: КВИДДИЧИЙН ДЭЛХИЙН ЦОМЫН ТЭМЦЭЭН

Худалдаж авсан зүйлсээ барьсаар ноён Уизли тэргүүлэн бүгд ойн дундах дэнлүүгээр гийгүүлэгдсэн өргөн замаар яаран явлаа. Ой олон мянган хүмүүсээр дүүрэн байсан бөгөөд хашгирах, инээх, дуулах чимээ хадна. Бүгд ер бусын сэтгэл хөөрөлд автсан байлаа. Харри ч бас инээмсэглэж байв. Тэд модон дундуур тоглоом хийж хөгжилтэй ярилцан алхсаар хорин хормын дараа аварга том цэнгэлдэх хүрээлэнгийн ханын сүүдэрт орж ирлээ. Энд талбайг тойрон хүрээлсэн алтан ханын зөвхөн хэсэг нь л харагдаж байв. Харрид цэнгэлдэх хүрээлэн дотор арваад сүм багтах шиг санагдав.

- Зуун мянган суудал. Ид шидийн яамны таван зуун ажилтан бүтэн жил ажилласан юм. Маглуудыг түлхэгч шид эндхийн зай бүрт бий. Маглууд ойртон ирсэн ч гэнэт хойшлуулашгүй ажилтайгаа санаад холдох хэрэг гарна гэж ноён Уизли Харригийн биширсэн харцыг ажиглаж хэлээд цэнгэлдэх хүрээлэнгийн гарцаар оволзон шуугилдах шидтэнгүүдтэй оров.

- Нэгдүгээр зэргийн суудал! Хамгийн дээд давхар! Шатаар өгсөөд хамгийн дээр нь байгаа, Артур гэж яамны ажилтан тэдний билетийг шалгаад хэллээ.

Цэнгэлдэх хүрээлэнгийн шатан дээгүүр улаан хивс дэвсчээ. Тэд үзэгчдийн суудлын баруун зүүн талаар өгсөх цугласан олон дундуур түлхэлцэн явлаа. Ноён Уизли шатаар тэргүүлэн дээшээ өгсөж хамгийн дээд эгнээний хоёр талын алтан цагаригийн голд байрлуулсан багахан тавцанд хүрлээ. Тэнд ойролцоогоор хориод алтлаг зөөлөн сандал бүхий хоёр эгнээ суудал байв. Уизлигийн гэр бүл нүүрэн талын эгнээг эзлэн суулаа. Харри доошоо хараад гайхамшигтай сайхан дүр зураг олж харлаа.

Зуун мянган шидтэнгүүд зууван талбайг тойрон хүрээлсэн үзэгчдийн суудалд суужээ. Цэнгэлдэх хүрээлэнгийн хананаас нууцлаг алтлаг гэрэл туяаран бүгдийг гийгүүлнэ. Ногоон талбай хамба хилэн шиг зөөлөн агаад талбайн төгсгөлд арван таван футын өндөрт гурван цагариг байрлуулжээ. Тэдний эсрэг талын аварга том хар самбар дээр үл үзэгдэх гараар бичигдэх мэт алтлаг үсгүүд урсана. Харри зар сурталчилгааг уншлаа.

Хонхон цэцэг гэр бүлийн шүүр. Аюулгүй, найдвартай, хулгайчийн эсрэг дохиололтой. Хатагтай Скоурын ид шидийн таагүй явдал арилгагч. Өвдөхгүй, Толбо үлдээхгүй! Сүүлийн үеийн загварын шидэт хувцас... Лондон, Париж, Хогсмид...

Харри тэдний давхарт хэн сууж байгааг гүйлгэн харлаа. Хоёр дугаар эгнээний сүүлчийн суудалд суусан жижигхэн амьтныг эс тооцвол бараг хоосон байлаа. Түүний богинохон хөл нь сандлаасаа цухуйхгүй агаад нүүр гарын алчуур хөдөрч алгаараа нүүрээ даржээ. Сарьсан багваахайны шиг чих нь Харрид танил амьтныг санагдуулав...

- Добби? гэж Харри итгэлгүйхэн дуудлаа.

Жижигхэн амьтан гараа холдуулаад том хүрэн нүдээрээ харахад хамар нь боловсорч гүйцсэн улаан лоолийн адил ажээ. Энэ бол Добби биш хэдий ч гэрийн үйлчлэгч гэдэг нь илэрхий байлаа. Ингэхэд Харри заль гарган Доббиг боолын хөдөлмөрөөс сулласны дараа юу хийж байгаа бол? Түүний эзэд Малфойнх байсан шүү дээ.

- Ноёнтоон, та намайг Добби гэж дуудав уу? гэж гэрийн үйлчлэгч хурууны завсраараа харж часхийн дуугарав.

Хоолойных нь өнгөнөөс үзэхэд эмэгтэй үйлчлэгч байх гэж Харри бодлоо. Рон, Гермiona хоёр бас эргэж харлаа. Тэд Доббийн тухай сонсож байсан хэдий ч уулзаж байгаагүй билээ. Тэр ч байтугай ноён Уизли хүртэл хачирхалтай амьтныг сониучирхан ширтэв.

- Өршөөгөөрэй. Би таныг нэг танилтайгаа андуурлаа гэж Харри гэрийн үйлчлэгчид хандан хэлэв.

- Би Доббиг бас мэднэ, ноёнтоон. Намайг Винки гэдэг. Харин та Харри Поттер уу? гэж үйлчлэгч хурц гэрэлд анивчиж байгаа аятай нүүрээ халхлан асуугаад таваг шиг нүдээ бүлтийлгэн Харрийн сорви руу харлаа.

- Тиймээ гэж Харри толгой дохив.

- Добби таны тухай үргэлж ярьдаг юм, ноёнтоон минь гээд тэр гараа үл ялиг буулган хүндэтгэсэн байртай харлаа.

- Тэр ямархуу байна даа? Эрх чөлөө хэр зохиж байна?

- Ай даа, ноёнтоон минь. Бүдүүлэг авирласанд уучлаарай. Гэхдээ та яагаад түүнийг чөлөөлсөн юм бэ, Харри Поттер? Та Доббид муу тус хүргэлээ гэж Винки толгойгоо сэгсрэн хэлэв.

- Яагаад? Түүнд ямар нэг юм тохиолдоо юу? гэж Харри хирдхийн асуулаа.

- Эрх чөлөө Доббигийн толгойг эргүүлсэн, ноёнтоон минь. Энэ түүний үүрэг шүү дээ, ноёнтоон. Тэр хаа нэгтээ ажил олох найдлагагүй болсон гэж Винки гунигтай хэлэв.

- Яагаад? хэмээн Харри гайхжээ.

- Тэр ажил хийснийхээ төлөө цалин авахыг хүсэж байгаа, ноёнтоон гэж Винки шивнэлээ.

- Цалин гэнэ ээ? Юу нь муу байгаа юм бэ? гээд Харри ойлгосонгүй.

Винки часхийн дуугараад ахиад л нүүрээ алгаараа дарав.

- Гэрийн үйлчлэгч цалин авч болохгүй, ноёнтоон! Би Доббид явж өөртөө сайн гэр бүл ол гэсэн. Бусад үйлчлэгч шиг амьдар гэж. Харин тэр галзуурсан аятай хөгжилдөж байгаа. Энэ бол гэрийн үйлчлэгчид болохгүй, ноёнтоон. Зугаалах бол тийм сайн зүйл биш. Би Доббид энэ бүхэн чинь шидэт амьтдыг хянан зохицуулах хэлтсийн үүдэнд дуусах вий гэсэн. Яг л зарим нэг албин шиг.

- Тэр яагаад жаахан хөгжилдөж болохгүй билээ? гэж Харри хэлэв.

- Гэрийн үйлчлэгч хөгжилдөж болохгүй, Харри Поттер. Гэрийн үйлчлэгч юу зарлигдсаныг хийх ёстой. Би өндрөөс айдаг юм, Харри Поттер. Гэхдээ эзэн тушаасан учир би ийшээ ирсэн гэж Винки нүүрээ даран хэлээд давхрын ирмэг рүү харан амьсгаа нь давхацлаа.

- Тэр өндөрт дургүйг чинь мэдсээр байж яах гэж ийш нь илгээсэн юм бэ? гэж Харри хөмсөг зангидан асуулаа.

- Эзэн суудлыг нь хадгалж байхыг хүссэн юм, Харри Поттер. Тэр их завгүй байгаа л даа. Винки майхандаа очмоор байвч юу тушаасныг хийх ёстой. Винки бол сайн гэрийн үйлчлэгч гээд Винки хоосон суудал руу бөхийлөө.

Тэр ахиад давхрын ирмэг рүү айсан янзтай харснаа алгаараа нүдээ дарав. Харри бусад руугаа эргэв.

- Энэ гэрийн үйлчлэгч үү? Ямар гайхамшигтай юм бэ! гэж Рон шивнэлээ.

- Добби илүү гайхамшигтай гэж Харри хэллээ.

Рон омниноклоо авч эсрэг талын үзэгчдийн суудлыг ажиглав.

- Гайхалтай! Одоо тэр хөгшин хамраа ахин ухна гэж тэр дуу алдаад давтдаг товчлуурыг эргүүлэв.

Гермиона хилэн цацагтай хөтөлбөрийг харж байв.

- Тэмцээний өмнө багуудын шүтээний үзүүлбэр болох юм байна гэж тэр чанга уншив.

- Энэ ч үргэлж үзүүштэй зүйл болдог шүү! Үндэстний шигшээ ер бусын зүйл авчирч багахан тоглолт үзүүлдэг юм гэж ноён Уизли тайлбарлав.

Хагас цагийн дараа давхар алгуурхан хүнээр дүүрлээ. Ноён Уизли чухал царайны шидтэнгүүдтэй гар барьж байв. Перси зараан дээр сууж байгаа аятай үсрэн босно. Эцэст нь ид шидийн яамны сайд Корнелиус Фаж өөрийн биеэр ирэхэд Перси хэт гүнзгий бөхийн ёсолсноос болж хамар дээрх шил нь унаж хагарав. Тэр ичингүйрэн босч ирээд саваагаараа шилээ янзлан суудалдаа суугаад Харри Фажтай хуучин танилын ёсоор мэндэлж байгааг атаархангуй харлаа. Тэд өмнө уулзаж байсан ч гэлээ тэр Харригийн гарыг бусад шидтэнгүүдийн ёсоор барилаа.

- Харри Поттер шүү дээ. Та ойлгож байна уу? Мэдээж та хүүг мэдэлгүй яахав. Тэр Хэцүү нэртийг ялсан... Та түүнийг хэн гэдгийг мэднэ биз дээ... гэж Фаж алтан эмжээр бүхий тансар хилэн жанчтай Болгарын ид шидийн яамны сайд болох хүнд хэлэв.

Болгарын шидтэн гэнэт Харрийн сорвийг хараад сэтгэл хөдөлсөн янзтай ямар нэг зүйл дуржигнуулан хуруугаараа заалаа.

- Би үүнийг мэдэж байсан юм. Миний хоолойны хүч хүрэхгүй нь... Ийм үйл явдал Барти Краучгүйгээр болох юм биш. Аан, би гэрийн үйлчлэгч нь суудал хадгалж байхыг харлаа... Зүйтэй! Эдгээр Болгарын өөдгүй амьтад хамаг сайн суудлыг эзэлж авахыг оролдож байгаа юм... Энэ чинь, Люциус үү дээ!

Харри, Рон, Гермиона гурав түргэн эргэн харлаа. Ноён Уизлигийн ард байрлах хоёрдугаар эгнээний гурван сул суудал руу өөр хэн ч биш Добби үйлчлэгчийн эзэн Люциус Малфой хүү Драко болон нэг эмэгтэйн хамтаар ирж байлаа. <<Дракогийн ээж нь байх >> гэж Харри бодлоо.

Харри, Драко Малфой хоёр Хогвартс явах эхний аялалаараа дайсан болсон билээ. Драко цонхигор цагаан нүүр, өнгөгүй үсээрээ аавтайгаа адилхан юм. Ээж нь өндөр гоолиг биетэй муухай юм үнэрлэсэн аятай ярвайсан төрхгүй бол үзэсгэлэнтэй гэж болохоор ажээ.

- Сайн уу, Фаж! Ажил хэрэг ямар шуу байна даа? Та миний эхнэр Нарцисса болон хүү Драког минь мэдэх бил үү? гэж ноён Малфой сайд руу гар сунгангаа асуулаа.

Фаж инээмсэглэн хатагтай Малфойд бөхийн ёслолгоо,

- Оройн мэнд. Таныг ноён Обланскад танилцуулахыг зөвшөөрнө үү... Обалонск... ноён... товчхондоо Болгарын ид шидийн яамны сайд байгаа юм. Тэр манай яриаг ойлгохгүй болохоор санаа зовох хэрэггүй дээ. Өнөөдөр бидэнтэй Артур Уизли байгаа юм... Та Артур Уизлиг мэдэх бил үү? гэв.

Таагүйхэн нам гүм болов. Ноён Уизли болон ноён Малфой нар бие биенээ харахад Харри тэдний сүүлчийн уулзалтыг саналаа. Энэ бол Флориш ба Блоттс номын дэлгүүрт болсон явдал бөгөөд зодооноор дууссан билээ. Малфойгын хүйтэн саарал нүд ноён Уизли дээр хальтарснаа бүх эгнээг гүйлгэн харав.

- Бурхан минь, Артур. Хамгийн дээд талын эгнээнд хичнээн суудал аваа вэ! Ямар нэг зүйл зарсан байх даа? Танай гэр ийм үнэ хүрэхгүй гэдэгт итгэлтэй байна шүү гэж тэр аяархан хэлэв.

Фаж түүний үгийг сонсолгүй үргэлжүүлэн,

- Люциус гэгээн Мунгогийн ид шидийн өвчин эмгэгийн эмнэлэгт өгөөмөр хандив өгсөн юм, Артур. Тэр одоо миний зочноор ирээд байна гэлээ.

- Ямар... ямар таатай юм бэ гэж ноён Уизли хэлээд хүчлэн инээмсэглэв.

Ноён Малфойн харц Гермiona дээр тусаад нүд салгалгүй ширтэхэд үл мэдэгхэн улайлаа. Харри ноён Малфойн уруул яагаад ярвайсныг мэдэж байв. Малфойн гэр бүлийнхэн цэвэр цусаараа бахархах дуртай бөгөөд маглуудыг доогуур амьтад гэж үздэг билээ. Гэвч тэрбээр ид шидийн яамны сайдын хажууд дуугүй байх хэрэг гарчээ. Ноён Уизли шоолонгуй толгой дохиод суудалдаа суулаа. Драко тэдэн рүү жигшсэн харц чулуудсанаа эцэг эх хоёрынхоо дунд суулаа.

- Бузар өт гэж Рон Харри, Гермiona хоёрт шивнээд талбай руу эргэж харав. Тэгтэл Людо Бэгмен хүрч ирлээ.

- Бүгд бэлэн үү? Эхэлж болох уу, сайдаа? гэж тэр хэлэхэд дугуй нүүр нь бяслагтай төстэй харагдав.

- Хэрвээ та бэлэн бол эхлэнэ үү, Людо гээд Фаж тохилог суудалдаа суулаа.

Бэгмен түргэн хөдөлгөөнөөр шидэт саваагаа хоолойдоо тулгаад,

- Сонорус! гэж тушаахад түүний хоолой том нижигнэлт болон хувирч үзэгчдийн суудлын өнцөг булан бүрт цуурайтглаа.

- Ноёд хатагтай нараа! Дөрвөн зуун хорин хоёр дахь квиддичийн Дэлхийн цомын тэмцээнд тавтай морилно уу!

Үзэгчид орилон шуугиж алга ташицгаан олон мянган далбаагаар даллахад янз бүрийн хоолойгоор үндэстний сүлд дуулал дуулах замбараагүй чимээ хадав. Эсрэг талын аварга том самбар дээр сүүлчийн зар сурталчилгаа (Янз бүрийн амттай Берти Боттс үрэл) гарсны дараа <<БОЛГАР – ТЭГ, ИРЛАНД - ТЭГ>> гэж гарч ирлээ.

- Харин одоо чимээгээ аядаж надад хэдэн үг хэлэхийг зөвшөөрнө үү... Болгарын үндэсний багийн сахиус!

Баруун талын үзэгчдийн улаан суудал орилон шуугив.

- Тэд юу авчирсан юм бол? гээд ноён Уизли доошоо бөхийн харснаа,

- А-а-а! Вейланууд! гэж яаран нүдний шилээ заслаа.

- Энэ чинь тэгээд юу...

Гэвч талбай дээгүүр зуугаад вейла гулсан гарч ирэхэд Харри асуултынхаа хариултыг харлаа. Вейла гэдэг нь эмэгтэй хүн байлаа... тийм үзэсгэлэнтэй эмэгтэй Харри урьд өмнө харж байсангүй... тэд хүн байж боломгүй юм... Эд нар хэн юм бол? Тэдний арьс сарны гэрэл шиг туяарч, алтан үс нь давалгаа шиг намирна. Хөгжим дуугарч эхлэхэд Харри бүхнийг мартаад тэдний хүн мөн биш эсэхэд санаа зовохоо болив.

Вейланууд эргэлдэн бүжиглэхэд Харрийн толгой хоосорч жаргалтай болов. Энэ дэлхий дээр вейлагийн бүжиглэхийг харахаас өөр юу ч түүнийг зовоохгүй байлаа. Тэднийг бүжиглэхээ болиход амьдрал зогсоно!

Вейланууд түргэн бүжиглэхэд Харрийн тархинд бодлууд орж эхлэв. Тэр одоо ямар нэгэн сэтгэл хөдөлгөсөн зүйл хийх ёстой... Талбай рүү харайх уу? Муугүй л бодол байна! Гэвч хангалттай байж чадах болов уу?

- Харри чи яаж байна? гэх Гермionaгийн дуу хаа нэгтээгээс гарав.

Хөгжим зогслоо. Харри нүдээ анивчив. Тэр хөлөө хашлага давуулаад зогсож байв. Түүний хажууд Рон үсэрдэг тавцангаас шумбан харайхад бэлэн мэт зогсоно.

Уурсан хашгиралт цэнгэлдэх хүрээлэн даяар нүргэлэв. Үзэгчид вейлаг явуулахыг хүсэхгүй байлаа. Харри Болгарыг дэмжиж байсан болохоор тэдний талд байлаа! Ийм учраас л түүний цээжин дээр гурван навч байгаа билээ. Рон өөрийн ухаангүй мэт гурван навчтай малгайгаа зулгааж байв.

- Энэ чамд шаардагдах байх гээд Ноён Уизли инээмсэглэн түүний малгайг авлаа.

- А-а? гэж Рон талбайн нэг талд эгнээ болон суусан үзэсгэлэнтэй вейланууд руу гөлрөн харсан чигээр хэлэв.

Гермиона дургүйхэн тургилаад Харриг суудалд нь буцаан суулгаж,

- Энэ чинь одоо юу вэ! гэж уурсав.

- Харин одоо саваагаа өргөн... Ирландын шигшээгийн үзүүлбэрийг угтан авна уу гэх Людо Бэгмений хоолой нүргэлэв.

Тэгтэл ямар нэгэн том ногоон-алтлаг сүүлт од цэнгэлдэх хүрээлэнгээр нисэв. Эргэлт хийгээд сүүлт од хоёр болон хуваагдаж онооны цагариг руу нислээ. Холбоотой хоёр бөмбөлөг талбай дээгүүр нуман солонго болон татлаа.

- А-ах! гэж цэнгэлдэх хүрээлэн нэгэн зэрэг уулга алдав.

Солонго бөхөхөд гэрэлтэй бөмбөгүүд ойртон нэгдэж аварга том гурван навч болон агаарт хөөрөн тогтсоноо үзэгчдийн суудал руу алтан бороо оруулав.

- Ямар сайхан юм бэ! гэж Рон зулай дээр нь хүнд зоос цохиход уулга алдав.

Харри хөөрөн буй гурван навчнаас улаан хантааз бүхий мянгаад жижигхэн сахалтай хүн бүр гартаа алтан юм уу ногоон дэнлүү барьсныг харлаа.

- Лепреконууд! гэж ноён Уизли үзэгчдийн чимээ шуугианыг давахыг хичээн хашгиран хэллээ. Олонхи үзэгчид сандал доогуур унасан алтан зоос хайн тэмтчин хайж байв.

- Үүнийг чамд! Омниноклийн төлөө! Одоо чи надад зул сарын бэлэг өгөх боллоо шүү! гэж Рон баясан хэлээд Харрийн алган дээр алтан зоос овоолов.

Аварга том гурван навч уусан алга болоход лепреконууд талбай дээр буун вейлагийн эсрэг хөлөө зөрүүлэн суулаа.

- Ноёд хатагтай нараа. Болгарын үндэсний шигшээг хүлээн авна уу! Димитров!

Доод талын гарцнаас Болгарын хөгжөөн дэмжигчдийн нижигнэтэл алга таших чимээ гарч гал улаан хувцастай тоглогч агаарт хөөрлөө. Түүний нислэгийг дагуулж харахын аргагүй хурдтай нисэж байв.

- Иванова!

Хоёр дахь улаан жанчтай тоглогч нисэн гарлаа.

- Зогров! Левски! Волчанов! Волков! Т-т-т-т-тэгээд Крам!

- Тэр байна, тэр байна гэж Рон омниноклыг нүүрэндээ наан орилов.

Харри яаран өөрийнхөөрөө харлаа.

Виктор Крам бол туранхай хар үс, боровтор царайтай, том бүргэд хамартай, өтгөн хар хөмсөгтэй залуу байлаа. Тэр махчин шувуутай төстэй санагдана. Түүнийг арван найман настай гэхэд итгэмээргүй байлаа.

- Харин одоо Ирландын үндэсний шигшээг угтацгаая! Конолли! Райан! Трой! Маллет! Моран! Куигли! Б-б-бас Линч! гэж Бэгмен хашгирлаа.

Долоон ногоон хувцастай тоглогч хөөрөн гарч ирэв. Харри омниноклийн тохируулагчыг эргүүлж тоглогчдын хөдөлгөөнийг удаашруулан харлаа. Хүн болгон <<Аянга>> шүүртэй бөгөөд нуруун дээр нь мөнгөн үсгээр нэрээ хатгамласан ажээ.

- Тэмцээний шүүгчээр Египетээс ирсэн олон улсын квиддичийн холбооны тэргүүлэгч Хасан Мустафа!

Талбай дээр жижигхэн туранхай биетэй халзан толгойтой Вернон ах ч атаархахаар сахалтай шижир алтан хувцастай шидтэн гарч ирлээ. Сахал дороо мөнгөн шүгэл зүүсэн бөгөөд нэг гартаа том модон хайрцаг барьж нөгөө гартаа шүүр барьжээ.

Харри тохируулагчаа жирийн дээр нь тавиад Харри Мустафагийн хөдөлгөөн бүрийг анхааралтай харлаа. Тэр шүүрэндээ суугаад хөлөөрөө хайрцагыг өшиглөн онгойлгоход дөрвөн бөмбөг агаарт хөөрлөө. Тод улаан өнгийн квоффл, хоёр хар блажер, жижигхэн алтан снитч гарч ирснээ агшин зуур алга болов. Мустафа чих дөжрөм шүгэлдээд бөмбөгүүдийн араас хөөрлөө.

- Эхэлцгээе! Урагшаа, Маллет! Трой! Моран! Димитри! Ахиад л Маллет! Трой! Левски! Моран.

Ийм квиддичийг Харри амьдралдаа үзэж байсангүй. Харри омниноклийг нүүрэндээ чанга наалаа. Тоглогчид итгэмээргүй хурдтай нисэлдэх бөгөөд ангуучид агшин зуур квоффлыг бие биедээ дамжуулж Бэгмен тэднийг нэрлэж амжихгүй байлаа.

Харри удаашруулагчыг ахин эргүүлэн <<тайлбарлагч>> гэсэн товчлуурыг дарахад агшин зуур тоглогчид удаашран харагдав. Дурангийн линзэн дээгүүр тайлбарлагчын улаан үг гүйж чихний хэнгэрэгийг нь үзэгчдийн шуугиан балбана.

<<ХАРЦАГЫН ТОЛГОЙ ЦУВААГ ДАЙРЛАА. Ирландын гурван ангуучин нисэж байна. Голд нь Трой баруун зүүн талд нь Маллет, Моран нар нисэж Болгарын хамгаалалтыг нэвтрэх гэж оролдож байна... Трой хууран дээшээ хөөрч Болгарын ангууч Ивановаас бултаад квоффлийг ангууч Моранд дамжууллаа. Болгарын довтлогч Волков блажерыг түүн рүү чиглүүлэн цохилоо. Тэр блажераас бултан доошоо эргэхдээ квоффлыг алдчихлаа. Доор нь нисч байсан Левски түүнийг барьж авлаа.>>

- ТРОЙ ОНОО АВЛАА! Арав – тэг Ирланд тэргүүлж байна! гэж Бэгмен орилоход цэнгэлдэх хүрээлэн нижигнэсэн алга ташилт хашгиралтанд чичигнэлээ.

- Юу? Левски квоффлыг барьж авсан биз дээ! гэж Харри гайхан омнинокль руу харлаа.

- Харри, чи жирийн дээр нь тавьж харахгүй юм бол олон зүйлийг алдана даа! гээд Гермiona Трой талбай дээгүүр нисэн өнгөрөхөд хөлөө нүдэн хашгирч гар даллав.

Харри омниноклоор тоглогчдыг хажуугаас нь ширтэж буй лепреконууд руу харахад ахин агаарт хөөрч аварга том гялалзсан гурван навч болов. Талбайн нөгөө өнцгөөс вейланууд тэднийг баргар царайлан харав.

Харри өөртөө уурсан тохируулагчыг жирийн дээр тавихад тоглолтыг үргэлжлүүлэн харлаа.

Харри квиддичийн талаар олон зүйл мэддэг ч Ирландын ангуучид шиг сүрлэг сайхан зүйлийг хараагүй ажээ. Тэд багаар хамтран ажиллаж бие биенийхээ бодлыг уншиж буй аятай солбилцон хөөрч байв. Харрийн энгэр дээр байсан чимэглэл <<Трой! Маллет! Моран!>> гэж хашгирав. Арван хормын дараа Ирланд ахин хоёр удаа бөмбөг оруулснаар оноо гуч – тэг болов. Ногоон хувцастай хөгжөөн дэмжигчидээс орилолт алга ташилтын чимээ нүргэлэв.

Тоглоом илүү хурдтай хэрцгий боллоо. Болгарын довтлогч болох Волков, Волчав хоёр блажерыг Ирландын ангуучдын зүг чиглүүлэн цохиж тэдний хөдөлгөөнийг хаахыг оролдож байв. Болгарын оролдлого хоёр удаа бүтэлгүй болсны эцэст гурав дахь дайралт амжилттай болов. Иванова тэдний эгнээг нэвтлэн хаалгач Райныг хууран анхны бөмбөгийг оруулав.

- Чихээ дар! гэж ноён Уизли вейланууд баярын бүжиг хийж эхлэхэд хашгирлаа.

Харри ухаан санаагаа тоглолтонд хадгалж үлдэхийг хүсэн нүдээ анилаа. Хэдэн хормын дараа тэр талбай руу хяламхийн харлаа. Вейланууд бүжиглэхээ зогсож, квоффл ахиад л Болгарынхны гарт байлаа.

- Димтров! Левски! Димитров! Иванова! Гайхамшигтай! гэж Бэгмен хашгирлаа.

Зуун мянган шидтэнгүүд амьсгаа даран баригчид болох Крам, Линч хоёрыг онгоцноос шүхэргүй унах мэт доошоо шумбахыг ажиглана. Харри тэднийг омниноклоороо дагуулан харж снитчийг харахыг хичээв...

- Тэд мөргөх нь байна шүү дээ! гэж Гермiona дуу алдав.

Тэр бараг л таачихлаа. Сүүлчийн хоромд Крам огцом эргэлдэн холдоход Линч амжсангүй газар мөргөхөд падхийн унах бөглүү чимээ цэнгэлдэх хүрээлэн даяар гарав. Ирландын хөгжөөн дэмжигчид дуу алдан ёолов.

- Тэнэг амьтан! Крам хуурсан шүү дээ! гээд ноён Уизли толгойгоо сэгсэрлээ.

- Цаг авлаа! Талбай дээр эмч яаралтай гарч ирж Эйдан Линчийг үзнэ үү! гэж Бэгмен зарлав.

- Тэр зүгээр дээ, зөвхөн газар мөргөлөө! Крам үүнийг тооцсон доо... гэж Чарли айдаст автсан Жинниг тайвшируулахыг оролдов.

Харри яаран давтах товчлуурыг дарлаа. Крам, Линч хоёр удаашран ахин доошоо шунгалаа. Линзэн дээр гялалзсан улаан үсгээр <<Финт Воронски баригчийн аюултай тактик>> гэж бичигджээ. Тэр Крамын царай сүүлчийн агшинд муруйн дээшээ нисэхийг харав. Харин Линч үлдээд газар мөргөв. Харри Крам снитчийг хараагүй харин Линчийг занганд оруулсан болохыг ойлголоо.

Харри амьдралдаа хэн нэгэн тэгж нисэхийг харж байсангүй. Крамд шүүр хэрэггүй бөгөөд тэр огт жингүй юм шиг санагдана. Омниноклыг жирийн горимд нь тохируулаад Харри Крамын зүг чиглүүлэв. Тэр эмч нар ханд уулгаж буй Линчийн дээгүүр гучин метрийн өндөрт тойрог эргэлдэнэ. Харри дуранг Крамын нүүрэн дээр тааруулахад түүний хар нүд газар дээгүүр снитчийг хараачилж байв. Тэр золгүй тохиолдлыг ашиглан снитчийг хөндлөнгийн оролцоогүй барих санаатай байлаа.

Линч эцэст нь хөл дээрээ босоход ногоон хувцастай үзэгчид хөөрөн хашгиралдав. Тэрбээр <<Аянга>>-даа суугаад хөлөөрөө түлхэн дээшээ хөөрлөө. Түүний эргэн ирэлт Ирландчуудыг урамшуулжээ. Мустафа шүгэл үлээхэд Ирландын ангуучид тэмцэлд орж хосгүй ур чадвар бүхий үзүүлбэрээ үргэлжлүүлэв.

Арван таван хором өнгөрсний дараа Ирландчууд ахин арван оноо авахад оноо зуун гуч – арав боллоо. Тоглоом бохир бүдүүлэг болов.

Маллет ахин хаалга руу квоффлыг тэврэн нисэхэд Болгарын хаалгач Зогров түүнийг чиглэн нисэв. Бүх зүйл маш хурдан болсон болохоор Харри ойлгосонгүй хэдий ч Ирландын хөгжөөн дэмжигчдийн ууртай хашгиралт удтал үргэлжилж Мустафагын шүгэл жингэнэн дүрэм зөрчсөнийг зарлав.

- Мустафа Болгарын хаалгач Ирландын довтлогчыг тохойгоороо хүчтэй цохисон гэж байна. Ирланд торгуулийн цохилт хийнэ! гэж Бэгмен мэдэгдэв.

Лепреконууд уурсан сүрэг зөгий адил агаарт хөөрөн Болгарын хаалгачыг шоолсон <<ХА-ХА-ХА!>> гэсэн үг болж хувирав. Талбайн нөгөө өнцгөөс вейланууд үсрэн босож үсээ ууртайгаар сэгсчээд мансууруулам бүжгээ эхлэв.

Уизлигийн хөвгүүд болон Харри нүдээ анин хуруугаараа чихээ бөглөв. Гермионад бүжиг нөлөөлөөгүй болохоор Харригийн гараас татлаа.

- Шүүгчийг хараач! гэж тэр инээд алдан хэлэв.

Харри доошоо харлаа. Хасан Мустафа бүжиглэж байгаа вейлануудын дэргэд газардаад хачирхалтай үйлдэл гарган залуу хүн шиг мушгирсан сахлаа толийлгохыг оролдож байв.

- Энэ ч үзэгдээгүй юм болж байна шүү! Хэн нэг нь шүүгчийг алгадаад аваач! гэж Бэгмен хөгжилтэй өнгөөр хашгирав.

Шидэт эмч талбай дээгүүр чихээ таглан ухасхийж Мустафагийн шилбэ рүү хүчтэй өшиглөлөө. Шүүгч ухаан орсоноо аймшигтай ичингүйрч (Харри түүнийг омниноклоороо харжээ), вейлануудад бүжгээ болихыг тушаав.

- Хэрвээ би эндүүрээгүй бол Мустафа талбайгаас Болгарын багийн шүтээнийг хөөхийг хүсэж байна! Ийм зүйлийг урьд нь харж байсангүй... Үйл явдал муу тал руугаа эргэж болох юм! гэж Бэгмен тайлбарлав.

Болгарын довтлогчид болох Волков, Волчанов хоёр шүүгчийн дэргэд газардан түүнтэй уурсан маргалдаж <<ХИ-ХИ-ХИ!>> гэсэн үг болж хувирсан лепреконууд руу заав. Мустафа тэднийг хэрэгссэнгүй тэнгэр лүү хуруугаараа заан үргэлжлүүлж тоглохыг тушаав. Тэднийг татгалзахад шүглээ хоёр удаа богинохон үлээлээ.

- Ирландчуудад хоёр торгуулийн цохилт өглөө! гэж Бэгмен хашгирахад Болгарын хөгжөөн дэмжигчид эсэргүүцэн орилолдов.

- Волков, Волчанов хоёр шүүрэндээ буцаж суусан нь дээр байх... тиймээ... тэд нислээ... Одоо квоффл Тройд байна.

Тоглоом илүү хэрцгий боллоо. Хоёр багийн довтлогчид өршөөлгүй тоглож байлаа. Волков Волчанов хоёр гарт өртсөн бүхнээ цохиураар цохиж байв. Димитров бөмбөг эзэмшиж байсан Мораны араас нисэхдээ цохин арай л шүүрнээс нь унагасангүй.

- Дүрэм зөрчлөө! гэж Ирландын хөгжөөн дэмжигчид уурсан орилоод босон зогсоход үзэгчдийн суудал ногоон өнгөөр давалгаалав.

- Дүрэм зөрчлөө! Димитров Мораныг санаатайгаар мөргөсөн учир ахин нэг торгуулийн цохилт өглөө... гэх Бэгмений шидэт хоолой цуурайтав.

Лепреконууд ахин тэнгэрт хөөрч аварга том гар болон талбайн цаад захад буй вейлануудад бүдүүлэг зүйл үзүүлэв. Вейланууд үүнд галзууртлаа уурлажээ. Тэд бүжиглэхийнхээ оронд лепрекончууд руу гал чулуудаж эхэллээ. Дурангаас нүд салгаагүй Харри тэдэнд гоо үзэсгэлэнгийн өчүүхэн тэмдэг үлдсэнгүй болохыг олж харлаа. Тэдний нүүр урагшаа сунан хурц хошуутай шувууны толгой болон хувирч хайрстай урт далавч мөрөн дээр нь ургалаа.

- Харав уу, хөвгүүд ээ? Хэзээ ч гадаад байдалд битгий хууртаж бай! гэж ноён Уизли үзэгчдийн чимээ шуугианыг давахыг хичээн орилов.

Ид шидийн яамны шидтэнгүүд вейла лепреконуудыг салгахыг оролдсон ч амжилт багатай боллоо. Гэхдээ тэмцэл газар дээр явагдахаас илүү тэнгэрт явагдаж байлаа. Квоффл бууны сум шиг гараас гар дамжин нисч байв.

- Левски! Димитров! Моран! Трой! Маллет! Иванова! Ахиад л Моран! Моран! Моран! МОРАН ОНОО АВЛАА!

Ирландын хөгжөөн дэмжигчдийн хөөрөл вейлануудын орилоон, ид шидийн яамны ажилчдын саваанаас гарч буй дэлбэрэлт, Болгарчуудын хилэгнэсэн хашгиралт дундаас арай ядан сонсогдлоо. Тоглолт дахин цааш үргэлжлэхэд квоффлыг Левски эзэмшиж түүний араас Димитров явж байлаа.

Ирландын довтлогч Куигли дэргэдээ яваа блажерыг харангуутаа маш хүчтэйгээр их бууны сум шиг Крам руу чиглүүлэн цохив. Түүнд бултах зав болсонгүй шууд нүүр лүү нь цохижээ.

Цэнгэлдэх хүрээлэн даяар чих дөжрөм дуу алдалт нүргэлэв. Крамын хамар хугарсан бололтой нүүр нь цусанд будагджээ. Хасан Мустафа шүгэл үлээсэнгүй. Түүний анхаарал сарнисан байсан явдалд Харри зэмлэсэнгүй. Нэг Вейла түүн рүү гал чиглүүлэн шидсэн учир шүүгчийн шүүрний сүрэл шатжээ.

Харри Крамыг гэмтсэн явдалд түгшлээ. Хэдийгээр тэр Ирландыг дэмжиж байсан ч гэлээ Крам агуу баригч байлаа! Ронд ч мөн тийм сэтгэгдэл төрсөн бололтой.

- Цаг авлаа! Хөөе доошоо, тэр ийм байдалтай тоглож болохгүй...

- Линчийг хараач! гэж Харри орилов.

Ирландын баригч гэнэтхэн доошоо шунгахад Харри снитчийг жинхэнээсээ олж харсан гэдэгт эргэлзсэнгүй.

- Тэр снитчийг харжээ! Түүний араас явж байна! гэж Харри хашгирав.

Цэнгэлдэх хүрээлэний хагас нь юу болоод байгааг ойлгожээ. Ирландын хөгжөөн дэмжигчдийн эгнээ баригчаа дэмжин ногооноор давалгаалан бослоо... Гэвч Крам хэдийн түүний ард явж байв. Тэр хаашаа нисэхээ яаж мэдсэн талаар Харрид ямар нэг санаа байсангүй. Түүний ард цусан мөр үлдэж байв. Крам Линчтэй зэрэгцэн ирж хоёулаа газар луу ахин шунгалаа.

- Тэд мөргөх нь байна! гэж Гермiona уулга алдав.

- Үгүй ээ, тэгэхгүй! гэж Рон хашгирлаа.

- Линчийн төлөө айж байна! гэж Харри орилов.

Түүний зөв байлаа. Линч хоёр дахь удаагаа хүчтэй хөлөөрөө газардахад уурссан вейланууд түүний зүг ухасхийв.

- Снитч, хаа байна? гэж Чарли бүх чадлаараа орилов.

- Тэр түүнийг барьжээ! Крам барьж! Тэмцээн дууссан! гээд Харри хөл дээрээ үсрэн бослоо.

Крам цусны толбо бүхий улаан жанчтайгаа яаралгүйхэн агаарт хөөрөн гартаа барьсан алтан снитчийг өргөлөө.

Самбар дээр <<БОЛГАР – ЗУУН ЖАР, ИРЛАНД – ЗУУН ДАЛ>> гэсэн оноо гарч ирэв. Үзэгчид болсон явдлыг даруй ойлгосонгүй. Хормын турш цэнгэлдэх хүрээлэн чимээгүй болов. Тэгснээ аварга том тийрэлтэт онгоц нисэх лугаа адил болов. Ирландын хөгжөөн дэмжигчид баярлаж хөөрсөндөө гал уул дэлбэрч байгаа юм шиг орилолдов.

- ИРЛАНД ЯЛЛАА! КРАМ СНИТЧИЙГ БАРЬСАН Ч ИРЛАНД ЯЛЛАА! Хэн ингэж бодох билээ! гэж Бэгмен тэмцээний санаандгүй төгсгөлд балмагдсан ирландчуудад чанга хоолойгоор зарлав.

- Хэн түүнийг снитчийг бариадах гээ вэ? Тэмцээн дуусахын өмнө Ирландчууд зуун жаран оноо аваад байсан шүү дээ. Тэнэг амьтан! гэж Рон хашгираад үсрэн босч толгой дээрээ алга ташлаа.

- Крам Ирландыг гүйцэж чадахгүй гэдгээ ойлгосон! Ирландын ангуучид хэтэрхий сайн юм! Тэр тэмцээнийг өөрийн гавъяагаар дуусгахаар шийдэж гэж Харри чанга алга ташихдаа хэллээ.

- Тэр их зоригтой байлаа, тийм биз дээ? гэж Гермiona хэлээд хаалтан дээгүүр бөхийн Крамыг газардахад хэсэг эмч нар вейла лепреконуудын зодоон дундуур түүн рүү гүйн очихыг харснаа,

- Тэр аймшигтай харагдаж байна! гэлээ.

Харри омниноклийг ахин нүдэндээ ойртуулав. Лепреконууд талбай дээгүүр баярласандаа галзуурсан юм шиг үсчиж байхад бараг юу ч харах боломжгүй байлаа. Гэвч тэр эмч нараар хүрээлэгдэн зогсч буй Крамыг ялган танив. Эмч нар цусыг нь арчих гэхэд тэр баргар царайлан дургүйцэж байв. Түүний багийнхан дэргэд нь зогсоод толгойгоо гутрангуй сэгсэрлээ. Харин холгүйхэн Ирландын тоглогчид баярласандаа хөөрөн бүжиглэхэд сахалтай шүтээнүүд нь алтан зоос буулгаж байв. Эргэн тойрон ирландын далбаа мандаж цэнгэлдэх хүрээлэнд үндэсний сүлд дуулал нь эгшиглэв. Вейланууд ахиад үзэсгэлэнтэй эмэгтэй хүний дүрд хувирсан ч ихэд сэтгэлээр унасан харагдана.

- Тиймээ, тэд зоригтой тэмцэлдлээ гэх баргар хоолой Харрийн ард гарлаа. Харри эргэж харахад Болгарын ид шидийн яамны сайд байв.

- Та англиар ярьж чаддаг юм уу! Тэгээд яагаад өдөржингөө намайг дохиж зангахад хүргэв ээ! гэж Фаж бухимдан дуу алдав.

- Хөгжилтэй байсан юм гээд тэр мөрөө хавчлаа.

- Ирландын шигшээ шүтээнүүдийхээ хамтаар хүндтэй гавъяа байгууллаа. Дээд талын суудалд Квиддичийн цомыг гардуулна! гэж Бэгмен мэдэгдлээ.

Харри гэнэтхэн нүд сохлом цагаан гэрэлд анивчлаа. Дээд эгнээний бүх суудал шидэт гэрэлд гийгүүлэгдэв. Түүнийг үүд рүү харахад хоёр шидтэн хүнд алтан цомыг зөөн оруулж ирээд өдөржин дохио зангаагаар ярьсандаа унтууцсан Корнелиус Фажын өмнө тавив.

- Алив эрэлхэг ялагдагчдын төлөө чанга алга ташицгаая! Болгарчууд! гэж Бэгмен хашгирлаа.

Дээд талын суудалд Болгарын ялагдсан долоон тоглогч өгсөн гарч ирэв. Үзэгчид талархлын алга ташлаа. Харри олон мянган омниноклын аничвсан гэрэл багийнхан руу чиглэхийг олж харлаа.

Тэд нэг нэгнийхээ араас Бэгмен нэрийг нь дуудахад гарч ирцгээв. Эхнийх нь Болгарын сайдтай гар бариад дараа нь Корнелиус Фажтай гар барив. Крам хамгийн сүүлд гарч ирлээ. Нүдэн дор нь хөхөрч царай нь цус болсон ч снитчийг чанга атгаж байв. <<Газар дээр тэр өөртөө итгэлгүй юм>> гэж Харри бодов. Тэр илт анзаарагдам гуйван алхах аж. Крамын нэрийг хэлэхэд бүх цэнгэлдэх хүрээлэн даяар чих дежрөм хашгиралт нүргэлэв.

Дараа нь ялагчид гарч ирэв. Эйдан Линч Моран, Конолли болон хоёр дахиа мөргөчихөөгүй залуугийн нүд зүг бүр тийш гүйн аз жаргалтайгаар инээмсэглэж байв. Трой Куигли хоёр цомыг өндөрт өргөхөд үзэгчдийн суудал сэтгэл хөөрөлд дэлбэрэв. Харрийн гар алга ташсаар байгаад мэдээ алджээ.

Эцэст нь Ирландын шигшээ доошоо бууж шүүрэн дээрээ суугаад хүндэтгэлийн тойрог хийв (Эйдан Линч Коноллийн ард суугаад бүсэлхийгээр нь чанга тэврэн инээмсэглэнэ). Тэгтэл Бэгмен саваагаа хоолойдоо хүргээд,

- Квиетус гэж хэлэв. Тэгээд сөөнгө хоолойгоор,

- Энэ тэмцээний тухай олон жилийн турш ярих болно. Ийм үр дүнг хүлээсэнгүй шүү... Түргэн дууссан нь харамсалтай. Аан тийм л дээ би та нарт өртэй... хэд билээ? гэв.

Түүний өмнө Фред, Жорж хоёр аз жаргалтай инээмсэглэн зогсоод Людо Бэгмен рүү гараа сунгаж байв.

БҮЛЭГ 9: ХАР ТАМГА

- Ээждээ мөрийцсөн гэж битгий хэлээрэй хэмээн улаан хивстэй шатаар бууж байхдаа ноён Уизли Фред, Жорж хоёрт хэлэв.

- Санаа зовох хэрэггүй дээ, ааваа. Бидэнд гайхамшигтай төлөвлөгөө байгаа болохоор мөнгөө хураалгахыг хүсэхгүй байна гэж Фред зальжин инээмсэглэн хэллээ.

Хормын турш ноён Уизли гайхамшигтай төлөвлөгөө нь юу болох талаар асуух эсэхээ эргэлзлээ. Гэхдээ мэдэхгүй байсан нь дээр гэж бодов бололтой.

Тэд үймсэн олон дундуур цэнгэлдэх хүрээлэнгээс гарч майхан руугаа буцлаа. Замын хажуугаар дэнлүүнүүд асан гэрэлтүүлж шөнийн агаарт дуулах чимээ хадаж толгой дээгүүр лепреконууд ялалтын дуу гуугчин дэнлүүгээр даллана. Майхандаа очих үед хэн ч унтахыг хүсээгүй болохоор ноён Уизли унтахын өмнө аяга какао увал дээр гэж үзжээ. Тэд тэмцээний тухай хөгжилтэйгээр маргалдахад ноён Уизли Чарлитай цохилтын тухай санал зөрөлдөж байтал Жинни ширээн дээр нойрмоглон унтахдаа аягатай халуун шоколадаа асгачихав. Ноён Уизли даруй бүгд унтахыг зарлигдав. Гермiona, Жинни хоёр майхан руугаа явж Харри үлдсэн Уизличуудын хамтаар унтлагын хувцсаа өмсөн орондоо орлоо. Буудлын зүгээс дуулалдах болно ойлгомжгүй тас хийх чимээ гарна.

- Ай даа, би жижүүр бишдээ ямар их баяртай байна гээч. Ирландчуудыг баяраа хэзээ тэмдэглэж дуусахыг мэдэх юм алга гэж ноён Уизли нойрмог бувтналаа.

Роны дээд талын орон дээр хэвтэж байсан Харри майхны брежентэн адар дээгүүр лепрекондуудын дэнлүүний гэрэл сүүмэлзэхийг хараад ой ухаанд нь ахин Крамын үзүүлбэрийн гайхамшигтай дүр зураг орж ирэв. Харри <<Аянга>>-аа Воронски Фент шиг эзэмшиж үзэхсэн гэхээс тэсч ядлаа... Яагаад Оливер Вудын бодож олсон нэг ч төлөвлөгөө үүнтэй адилхан тодорхой байдаггүй юм бол. Тэр өөрийгөө хэдийн нэрээ хатгамласан дүрэмт хувцастайгаар төсөөлж Людо Бэгмений <<Талбай дээр По-оттер!>> гэж зарлахад зуун мянган шидтэн орилон шуугих нь сонсогдох шиг боллоо.

Харри сэрүүн байгаа болон зүүдэлж байсан эсэхээ ойлгосонгүй. Түүний Крамын адил уран зөгнөл бүхий нислэг зүүд болон хувирах үед майханд ноён Уизлигийн хашгиралт сонсогдов.

- Рон, Харри босоорой! Түргэл! Маш яаралтай!

Харри өндийн суухдаа толгойгоо адарт цохичихлоо.

- Юу болсон бэ?

Тэр байдал нэг л биш болсныг мэдэрлээ. Буудлын чимээ өөрчлөгджээ. Дуулах чимээ зогсож оронд нь түгшсэн хашгиралт болон гүйлдэх чимээ гарна.

Харри давхар орноос гулган буугаад хувцас руугаа сарвайсан ч ноён Уизли,

- Цаг алга, Харри! Хүрмээ аваад гадагшаа гар, түргэл! гэлээ.

Харри майхнаас яаран үсрэн гарахад Рон дагалдав.

Түүдэг галын гэрэлд тэр ой руу гүйлдэж буй хүмүүсийг харав. Талбай дээгүүр харанхуй дүрс хөдлөн гэрэл гялсхийхэд буу буудах лугаа адил чимээ гарав.

Чанга тохуурхсан инээд согтуу хашгиралт тэдний зүг ойртож байлаа. Тэгтэл хүчирхэг ногоон гэрэл харваж үйл явдлыг гэрэлтүүлэв. Бүлэг юүдэнтэй шидтэнгүүд саваагаа өргөн талбай дээгүүр яаралгүй явж байв. Харрид эхлээд тэдэнд нүүр байхгүй юм шиг санагджээ. Гэвч юүдэн өмсөж баг угласан болохоос биш нүүр байлаа. Агаарт тэдний дээгүүр тахийн мушгиралдан эсэргүүцэх дөрвөн хар дүрс хөвж байлаа. Энэ нь багтай шидтэнгүүд үл үзэгдэх олсоор оньсон хүүхэлдэй мэт залж байгаа юм шиг санагдана. Хоёр дүрс нь жижигхэн байхыг бодоход хүүхдүүд байв.

Юүдэнтэй шидтэнгүүдтэй хэдэн хүмүүс нэгдэн инээлдэн хөвж байгаа дүрсүүдийг заах аж. Тэдний явж өнгөрсөн газрын майхан нуран унаж байв. Харри тэдний нэг нь саваагаа өргөн замд байсан майхан руу чиглүүлэхэд дэлбэрэлт үүсэн шатахыг харлаа.

Хөвж байгаа хүмүүсийг шатаж буй майхны гэрэл гийгүүлэхэд Харри газрын зохицуулагч ноён Роберстын дүрсийг танив. Үлдсэн гурав нь харваас эхнэр хүүхдүүд нь байв. Багтай шидтэн саваагаараа хатагтай Робертсийг уруу харуулан эргүүлэхэд унтлагын хувцас нь сөхөгдөж дотуур өмд нь ил гарахад тэр чадлаараа дээш татахыг оролдов. Цугларагсад баясан инээлдлээ.

- Энэ ч гунигтай хэрэг байна даа. Ямар жигшүүртэй юм гэж Рон магл хүүхэд хорин метрийн өндөрт эрүүл адил эргэлдэхийг хараад хэлэв. Түүний толгой нарийхан хүзүүн дээрээ амьгүй санжигнана.

Гермиона, Жинни хоёр унтлагын хувцсан дээгүүрээ хүрмээ өмсөөд майхнаас гүйн гарч ирэхэд ноён Уизли араас нь гарч ирэв. Түүнтэй зэрэгцэн бүрэн хувцаслаж ханцуйгаа шамлан гартаа саваагаа бэлхэн барьсан Билл, Чарли, Перси нар ирлээ.

- Бид яамны жижүүрүүдэд туслахаар явлаа. Харин та нар ой руу гүйгээрэй. Бие биенээсээ салж болохгүй шүү хамтдаа байгаарай. Бүх зүйл тайван болохоор би та нарыг олох болно! гэж ноён Уизли хашгираад ханцуйгаа шамлав.

Билл, Чарли, Перси гурав багтай хүмүүсийг угтан явахад ноён Уизли араас нь дагав. Зүг бүрээс тэдэн рүү ид шидийн яамны ажилчид гүйлдэн очив.

- Түргэл! гээд Фред Жиннигийн гараас шүүрэн авч ой руу гүйлээ. Харри, Рон, Гермиона, Жорж нар түүний араас дагалдав. Модонд хүрээд эргэн харахад багтай шидтэнгүүд цагариг шиг дугуйрч яамны ажилчид төв рүү нэвтрэхийг хичээж байв. Энэ нь тэд шид хэрэглэхгүй байгаа нь Робертсийн гэр бүлийг унахаас айсан мэт харагдана.

Цэнгэлдэх хүрээлэн хүртэлх замыг гийгүүлж байсан дэнлүүнүүд асахаа больжээ. Мододын хооронд хар дүрснүүд хөлхөлдөн хүүхдүүд уйлж, айж сандарсан хоолой шөнийн хүйтэн агаарт цуурайтна. Харри хэн нэгэнтэй мөргөлдчихлөө. Харанхуйд нүүрийг нь ялгах боломжгүй байв. Хажууханд нь Рон өвдсөндөө дуу алдав.

- Яасан бэ? Рон чи хаа байна? Өө, ямар тэнэг юм бэ! Люмос! гэж Гермиона хэлээд зогсоход Харри түүн рүү очив.

Түүний шидэт савааны нарийхан гэрэл замыг гийгүүлэхэд Рон газар тэрийн хэвтэж байв.

- Үндсэнд бүдэрчихлээ гэж тэр ууртай бувтнаад хөл дээрээ босов.

- Ийм шөнө өөр юу хүлээнэ гэж хэмээн ард нь үгээ сунган хэлэх хоолой сонсогдов.

Харри, Рон, Гермиона гурав эргэж харлаа. Тэднээс хоёр алхамын зайд Драко Малфой мод налан цээжиндээ гараа зөрүүлэн зогсоод хайхрамжгүйхэн буудалд болж буй үйл явдлыг харж байв. Рон Малфойд хатагтай Уизлийн хажууд хэзээ ч хэлж зүрхлэхээргүй үг хэллээ.

- Үгээ зөв сонго, Уизли. Эндээс хурдхан холдохыг зөвлөе. Чи түүнд таагүй зүйл тохиолдохыг хүсээгүй биз дээ? гэж Малфой өнгөгүй саарал нүдээ гялалзуулан ууртай хэлэв.

Түүнийг Гермиона руу дохих агшинд буудалд дэлбэрэх лугаа адил чимээ гарч ногоон гэрэл гялсхийн орчин тойрны мододыг гийгүүлэв.

- Чи үүгээрээ юу хэлэх гэсэн юм? гэж Гермиона өдсөн байртай асуулаа.

- Юу гэнээ Грэйнджер? Тэд маглыг хайж байгаа юм. Чи дотуур хувцсаа үзүүлэхийг хүсээд байгаа юм уу? Учир нь чамайг дэргэд нь дүүжлэх болно... Тэднийг энд ирэхээр хөгжилтэй юм болно доо гэж Малфой хэлэв.

- Гермиона бол шидтэн гэж Харри уурслаа.

- Чи тэгж бодож байна уу, Поттер? Хэрвээ тэднийг бохир цустангуудыг ялгаж чадахгүй гэж бодож байвал зогсож бай л даа гэж Малфой хорсолтой инээмсэглэн хэллээ.

- Амаа тат! гэж Рон орилов. Хүн бүр бохир цус гэдэг нь магл гаралтай шидтэнгүүдийг доромжилсон үг болохыг мэддэг байв.

- Тоох хэрэггүй дээ, Рон гээд Гермиона түүнийг Малфой руу ухасхийхэд гараас нь чангаалаа.

Ойн захад маш хүчтэй дэлбэрэх чимээ гарахад хүмүүс айсандаа орилолдов.

Малфой аяархан инээлээ.

- Тэднийг айлгах амархан байгаа биз? Аав чинь чамайг ой руу зугт гээ юу? Харин өөрөө маглуудыг аврах гэж байгаа юм биз дээ?

- Харин чиний эцэг эх хаа байна? Тэнд багтай байгаа юу? гэж Харри уурласандаа чичигнэн хэллээ.

Малфой инээмсэглэсэн хэвээр Харригийн зүг харав.

- Тийм ч байж болно. Гэхдээ мэдээж би үүнийг чамд хэлэхгүй, Поттер.

- За алив ээ, явцгаая. Явж бусдыгаа ольё гээд Гермиона Малфой руу жигшсэн байртай харлаа.

- Сэгсгэр толгойгоо аварсан чинь дээр байх шүү, Грэйнджер гээд Малфой инээд алдав.

- Явъя гэж Гермиона давтаад Рон, Харри хоёрыг зам руу түлхэв.

- Түүний эцэг нь багтай дээрэмчдийн дунд байгаа гэж мөрийцөхөд ч бэлэн байна! гэж Рон уурсан хэллээ.

- Яамны хүмүүс түүнийг барьчихна! гэж Гермиона итгэлтэй хэлээд,

- Өө, итгэж ч чадахгүй нь. Бусад маань хаашаа явчихав? гэлээ.

Фред, Жорж, Жинни нар хаа ч байсангүй. Хэдийгээр замаар дүүрэн хүмүүс хөлхөлдөж байсан ч гэлээ буудалд болж байгаа чимээ шуугианы зүг түгшсэн байртай эргэн харцгаана.

Урд нь хэсэг өсвөр насныхан ямар нэг юмны талаар чанга маргалдаж байв. Харри, Рон, Гермиона гурвыг хараад өтгөн бужгар үстэй охин дуржигнуулан,

- Oü est Madame Maxime? Nous l'avons perdue гэв.

- Э-э-э.. юу гэнээ? гэж Рон гайхширан асуулаа.

- Өөх... гээд охин бусад руугаа буцаж очоод <<Огвартс>> гэх нь андуудад сонсогдов.

- Шармбатон гэж Гермиона шивнэлээ.

- Юу гэнээ? хэмээн Харри асуув.

- Тэд Шармбатаноос ирсэн байх. Шармбатон бол ид шидийн сургууль юм. Би энэ тухай <<Европын ид шидийн сургуулиудын тойм>> гэдэг номноос уншсан гэж Гермиона тайлбарлав.

- Аа... ойлгомжтой.

- Фред, Жорж хоёр ийм хол яваагүй байх гэж Рон хэлээд Гермионагийн жишгээр савааныхаа гэрлийг асаав.

Харри халаасандаа гараа хийсэн ч саваа нь байсангүй. Зөвхөн омнинокль баригдав.

- Би саваагаа гээсэн бололтой!

- Чи тоглож байгаа байлгүй дээ!

Рон, Гермиона хоёр савааныхаа гэрлийг өндөрт тусган хайсан ч Харрийн саваа хаа ч байсангүй.

- Майханд үлдсэн байх гэж Рон хэллээ.

- Эсвэл биднийг зугтаж байх үед халааснаас уначихсан юм болов уу? гэж Гермиона сэтгэл зовнин хэлэв.

- Тиймээ. Магадгүй л юм...

Тэр шидтэний ертөнцөд байхдаа үргэлж саваатайгаа байдаг болохоор ийм нөхцөлд түүнгүй үлдэх нь ямар ч хамгаалалтгүй байгаагийн адил байлаа.

Бутны цаана юм шаржигнахад бүгд цочлоо. Гэвч энэ бол ердөө Винки байсан хэрэг байж. Тэр ямар нэгэн үл үзэгдэх юмтай тэмцэлдэж байгаа мэт маш хачирхалтайгаар зогсож байв.

- Тэнд муу шидтэн байна! Хүмүүс тэнгэрт байна! Винки замаас нь зугтах ёстой! гэж тэр айн хэлээд урагшаа ухасхийсэн ч гүйсэнгүй.

Тэгснээ мододын цаагуур үл үзэгдэх хүчтэй тэмцэлдэх мэт алга болов.

- Тэр яагаа вэ? Яагаад тийм хачин зугтаж байгаа юм бол? гээд Рон Винкиг сониучирхан дагуулан харав.

- Винкид нуугдах зөвшөөрөл өгөөгүй гэж мөрийцсөн ч болох юм гэж Харри хэллээ. Тэр Доббигийн эздийнхээ эсрэг юм хэлэхдээ өөрийгөө хамгийн хэрцгий аргаар шийтгэдэг байсан нь санаанд оров.

- Шидтэний ертөнцөд гэрийн үйлчлэгчидтэй ямар аймшигтай харьцдаг юм бэ! Энэ чинь жинхэнэ боолын хөдөлмөр байна! Ноён Крауч түүнийг өндрөөс үхтлээ айдаг байхад цэнгэлдэх хүрээлэнгийн хамгийн өндөрлөгт суулгасан. Одоо майхнаа орхисны төлөө шийтгэх гэж байна. Майхан шатааж байхад тэр амиа аврах нь зөв шүү дээ. Яагаад хэн ч энэ талаар юу ч хийдэггүй юм бол? гэж Гермiona уурсан дуу алдав.

- Гэрийн үйлчлэгчид хувь заяандаа хангалуун байдаг юм. Чи хөгшин Винки тэмцээн дээр хэлсэн үгийг санахгүй байна уу <<гэрийн үйлчлэгч хөгжилдөж болохгүй>> гэсэн. Тэр эзэндээ захирагдах дуртай байдаг байх гэж Рон хэллээ.

- Рон, чам шиг хүмүүс л шударга бус ялзарсан тогтолцооны өмөг түшиг болж байдаг юм. Учир нь тэд зөвхөн залхуу болохоороо...

Ойн захад ахин нэг дэлбэрэлт боллоо.

- Эндээс холдоё... гэж түгшсэн Рон түүний яриаг тасаллаа. Магадгүй Малфой том аюул заналхийлж байгаа гэж үнэн хэлсэн байж болох шүү дээ.

Андууд цаашаа явлаа. Харри бүх халаасаа уудлан онгичсон ч саваа нь байсангүй.

Харанхуй зам тэднийг ойн гүн рүү хөтлөн оруулахад савааныхаа гэрлийг тусган Фред, Жорж, Жинни нарыг хайсан хэвээрээ байлаа. Тэдний замд уут дүүрэн алттай инээлдэн явах албингууд тааралдав. Эргэлзээгүй тэмцээнээс хожсон байх! Цаашаа модны чөлөөнд мөнгөлөг гэрэл бүхий гурван вейла сууж тэднийг тойроод нэг нь нөгөөгөөсөө чанга ярихыг оролдох залуучууд зогсож байв.

- Би бүтэн жилийн турш ажиллаад зуун хүүдий галлеон олсон. Аюултай амьтдыг хянах хэлтэст луу алсан юм.

- Үгүй шүү! Чи Цоорхой тогоонд сав суулга угаасан байх! Харин намайг хэн гэдгийг мэдэх үү... цус сорогчийн ангууч. Зуугаас ч ихийг алсан! гэж найз нь орилов.

Гурав дахь залуугийн батгатай эрүү вейлагийн мөнгөлөг гэрэлд ялгаран харагдлаа.

- Харин би удахгүй ид шидийн яамны сайд болно. Хамгийн залуу нь...

Харри батгатай залууг таниад тургилан инээд алдав. Тэр <<Шөнийн хөлөг баатар>> автобусаны тасалбар түгээгч Стэн Шанпайк байв.

Харри энэ тухай Ронд хэлэхийг хүссэн ч түүний царай инээдтэй болон хувираад,

- Би та нарт Бархасбадь гариг хүртэл нисэх шүүр зохион бүтээсэн гэж хэлээд байна шүү дээ гэж хашгирлаа.

- Энэ чинь одоо юу вэ? гэж Гермiona эгдүүцэв.

Тэр хоёр Роны гараас зуураад цааш явлаа. Андууд ойн хамгийн гүнд оржээ. Вейла болон түүнийг шүтэн бишрэгчдийн чимээ намдахад эргэн чив чимээгүй боллоо. Харри эргэн тойрноо харав.

- Энд хүлээцгээе. Ойртон ирэх хөлийн чимээ бээрийн цаанаас ч сонсогдоно.

Түүнийг үгээ дуусгаж амжаагүй байтал ойролцоох модны араас Людо Бэгмен гарч ирлээ.

Хоёр савааны сулхан гэрэлд Харри түүний байдал өөрчлөгдсөнийг харав. Түүнээс амьдралын баяр баясалтай өнгө нь алга болж пүрштэй юм шиг дэвхэрч явсангүй. Царай нь цонхийн цайж зүдэрсэн харагдана.

- Хэн бэ? гэж тэр нүдээ анивчин царайг нь танихыг оролдон хэлээд,

- Та нар энд юу хийж байгаа юм бэ? гэв.

Андууд бие биенээ гайхан харлаа.

- Тэнд үймээн болоод байна... гэж Рон хэлэв.

- Үймээн гэнээ? хэмээн Бэгмен түүн рүү харлаа.

- Тэнд буудалд... багтай хүмүүс маглын гэр бүлийг барьцаалсан байсан...

- Хараал идээсэй! гэж Бэгмен чанга дуугаар хараагаад сэтгэлээр унасан шинжтэй бөглүүхэн тасхийгээд шилжин алга боллоо.

- Бэгмен юу ч мэдээгүй байна! гэж Гермiona хөмсөг зангидан хэллээ.

- Гэхдээ тэр бол агуу довтлогч шүү дээ. Уимбурнскийн хэдгэнүүдийн багт тоглодог байсан юм. Тэд гурван удаа дараалан аврага болж байсан гэж Рон хэлээд модны дор байсан хуурай өвсөн дээр суулаа.

Тэрбээр халааснаасаа Крамын жижиг дүрсийг гарган ирээд газар тавьж алдартай баригчийн явахыг ажиглав. Амьд Крамын адил дуураймал нь хөл дээрээ үл мэдэгхэн найган явж байв. Харри буудлаас ямар нэгэн чимээ сонсогдох эсэхийг анирдав. Эргэн тойрон нам гүм байхыг үзэхэд үймээн дууссан бололтой.

- Бусдад маань ямар нэг юм болоогүй байх гэж найдахаас гэж Гермiona хэсэг хугацааны хэлэв.

- Тэднийг зүгээр байгаа гэдэгт итгэлтэй байна гэж Рон татгалзав.

- Аав чинь гэнэт Люциус Малфойг барьчихвал яах бол. Юу болно гэж бодож байна? Тэр үргэлж түүний эсрэг ямар ч баримт байхгүй гэдэг биз дээ гээд Харри Ронтой зэрэгцэн суугаад навчин дээгүүр явж байгаа жижигхэн Крамыг харлаа.

- Хөгшин Малфогийн нүүрнээс инээмсэглэл алга болох биз.

- Тэр золгүй маглуудыг газар буулгасан болов уу? гэж Гермиона асуулаа.

- Ид шидийн яамны баг ажиллаж байгаа. Тэд арга олох л болно гэж Рон түүнийг тайвшируулав.

- Ид шидийн яамныхны нүдэн дээр ийм зүйл хийдэг тэд лав галзуурсан байхаа! Тэд юу гэж бодсон бол? Эсвэл хэт уусан...

Тэр гэнэтхэн чимээгүй болоод ийш тийшээ харав. Харри, Рон хоёр бас харанхуй руу харлаа. Хэн нэгэн хүн тэдэн рүү ирж байх шиг байв. Андууд хөлийн чимээг сонсож байтал нам гүм болов.

- Хөөе! гэж Харри дуудав.

Нам гүм байсан хэвээр. Харри хөл дээрээ босоод мөчрийн завсраар харав. Тэнд юу ч үзэгдэхгүй байсан ч хэн нэгэн байгаа нь мэдрэгдээд байлаа.

- Тэнд хэн байна? гэж тэр асуулаа.

Тэгтэл гэнэтхэн нам гүмийг нүргэлсэн хоолой эвдэн,

- Мортмордре! гэж хашгирав.

Бутны цаана Харрийн харж байсан зүгт аварга том гялалзсан ногоон бөмбөлөг үүсэн мододын дээгүүр тэнгэр лүү хөөрлөө.

- Энэ чинь одоо юу вэ? гэж Рон дуу алдаад хөл дээрээ үсрэн босож дээшээ харлаа.

Хормын нэг хувьд Харри лепреконуудын бас нэг хувиралт гэж бодлоо. Гэвч маргад ногоон одод асар том гавал болон хувирахад амнаас нь могойн толгой цухалзав. Тэд түүнийг ногоон утаа савсуулан улам өндөрт хөөрсөөр харанхуй тэнгэрт байраа эзлэхийг харлаа.

Ой даяар чимээ шуугиан болов. Тэд яасан юм бол? Гавлаас айлаа гэж үү? хэмээн Харри гайхлаа. Гэнэт үүссэн гавал тэнгэрт байсан хэвээр ойг бүхэлд нь аймшигт тэмдэг мэт гийгүүлэв. Харри гавал гаргасан хүнийг эрлээ. Ойр хавьд хэн ч байсангүй.

- Тэнд хэн байна? гэж тэр ахин дуудав.

- Харри, эндээс түргэн явцгаая! гээд Гермиона хүрэмнээс нь арагш чангаалаа.

- Юу болоо вэ? гээд Харри түүний айсандаа цонхийсон царайг хараад түгшлээ.

- Энэ бол Хар тамга байна, Харри! Хэцүү нэртийн бэлэг тэмдэг! гэж Гермиона дуу алдаад түүнийг бүх чадлаараа түлхэв.

- Волан-де-Морт уу?

- Түргэл, Харри!

Рон жижигхэн Крамыг шүүрэн авахад гурвуулаа ойн цоорхой дээгүүр ухасхийв. Гэвч тэднийг гурав алхаж амжаагүй шахам байхад эргэн тойрон тасхийх чимээ гарч агаараас шидтэнгүүд гарч ирлээ.

Харри шидтэн болгоны гарт байгаа шидэт саваа тэдэн рүү чиглэснийг олж харлаа.

- Хэвт! гэж тэр хашгираад тэднийг газар луу дарлаа.

- Окаменей! гэж хорин хоолой хашгирав.

Нүд сохлом гэрэл цацрахад Харрийн үс хүчтэй салхинд бослоо. Тэр толгойгоо ялимгүй өргөтөл дээгүүр нь улаан оч нисэн өнгөрөөд модны их биеийг цохин үсчин алга боллоо.

- Зогс! Больцгоо! Энэ чинь миний хүү байна! гэж танил хоолой хашгирав.

Харригаас хэдэн алхамын зайд зогсож байсан ноён Уизли саваагаа буулгаад айсан байртай хүрч ирэв.

- Рон... Харри... Гермiona... та нар амьд уу? гээд түүний хоолой чичирлээ.

- Замаас холд, Артур гэх ширүүн хүйтэн хоолой гарав.

Энэ бол ноён Крауч байлаа. Тэр тэдэн рүү яамны шидтэнгүүдийн хамтаар ойртон ирэв. Харри түүнийг угтан алхав. Түүний царай уурандаа татвалзана.

- Та нарын хэн чинь ингэсэн бэ? Хэн Хар тамгыг гаргасан? гэж тэр зандраад хурц нүдээрээ өрөмдөн харлаа.

- Бид үүнийг хийгээгүй! гэж Харри хэлээд гавал руу заав.

- Бид юу ч хийгээгүй! Та нар яагаад бидэн рүү дайрч байгаа юм! гэж Рон хэлээд тохойгоо үрэн эцэг рүүгээ зэвүүцэнгүй харав.

- Битгий худал хэл! Та нар гэмт хэргийн газар байсан! гэж ноён Крауч уурсан хэлээд саваагаа буулгалгүй Рон руу харлаа.

- Барти. Энэ чинь хүүхдүүд байна шүү дээ. Тэд үүнийг чадахгүй... гэж унтлагын урт цамцтай шидтэн шивнэлээ.

- Та нар Хар тамга хаанаас гарсныг харсан уу? гэж ноён Уизли түргэхэн асуув.

- Тэндээс. Тэнд модны цаана хэн нэгэн байсан... тэр ямар нэгэн шившлэг... хашгирсан... гээд Гермiona чичирсэн гараар хоолой сонсогдсон зүгийг заав.

- Тэнд гэнэ ээ? Би зөв ойлгосон уу? Тэндээс шившлэг хашгирсан гэнэ ээ? Хатагтай, та Хар Тамга хэрхэн дуудах тухай маш сайн мэдэж байх шиг байна! гэж Краучын нүд Гермiona дээр төвлөрөн итгэлгүйхэн хэлэв.

Гэхдээ ид шидийн яамны ажилтангуудын хэн ч ноён Краучын адил тэр гурвыг тэнгэрт гавал илгээсэн буруутай гэж итгэсэнгүй. Тэд саваагаа буулгаж Гермionaгийн заасан харанхуй мод руу харлаа.

- Бид хоцорчихож. Тэд шилжээд явчихсан даа! гээд халаттай шидтэн толгойгоо сэгсэрлээ.

- Би тэгж бодохгүй байна. Бидний шившлэг модны цаана нуугдаж байсан хэн нэгнийг оносон байж болох юм хэмээн Седрикийн эцэг болох бавгар сахалтай Амос Диггори эсэргүүцээд мөрөө тэгшилж саваагаа өргөн модны цаагуур орлоо.

Гермиона түүнийг дагуулан хараад амаа гараараа дарлаа.

- Амос болгоомжтой! гэх түгшсэн хоолой сонсогдов.

- Энэ байна! Нэг нь баригдлаа! Ухаангүй! Чөтгөр ав... гэх дуу хормын дараа сонсогдов.

- Чи хэн нэгнийг бариа юу? Хэнийг тэр вэ? Хэн байна? гэж ноён Крауч итгэлгүйхэн асуулаа.

Модны мөчир хяхтнах, навч шаржигнах чимээ гараад ноён Диггори модны цаанаас гарч ирэхдээ гартаа жижигхэн үлбэгэр бие барьжээ. Харри нүүр гарын алчуурыг танилаа. Энэ бол Винки байв.

Ноён Диггори үйлчлэгчийг нь түүний хөлд тавихад Ноён Крауч хөдөлсөнгүй нэг ч үг хэлсэнгүй. Ид шидийн яамны ажилтангууд ноён Крауч руу харлаа. Түүний царайд үхлийн цонхигор өнгө тодорч чулуу шиг хөшөөд Винки рүү гөлөрч байв. Дараа нь тэр амьдралд ахин ирэх шиг боллоо.

- Байж боломгүй юм. Үгүй ээ... гэж тэр дуу алдаад түргэн алхаагаар Винкигийн байсан газар луу алга болов.

- Буцаад ир, ноён Крауч. Тэнд өөр хүн байхгүй байсан гэж түүний араас ноён Диггори хашгирав.

Гэвч ноён Крауч түүний үгийг хэрэгссэнгүй. Навч шар шурхийлгэн холдоод бутан дунд юм хайлаа.

- Жаахан эвгүй л юм. Барти Краучын гэрийн үйлчлэгч... гэж ноён Диггори хэлээд Винкигийн хөдөлгөөнгүй бие рүү ширтлээ.

- Больж үз, Амос. Чи үнэхээр гэрийн үйлчлэгч хийсэн гэж бодоогүй биз дээ? Хар тамга бол шидтэний тэмдэг. Үүнд шидэт саваа шаардагдана гэж ноён Уизли аяархан хэлэв.

- Тийм л дээ. Гэхдээ түүнд саваа байсан гэж ноён Диггори хэллээ.

- Юу гэнээ?

- Энэ байна гээд ноён Диггори халааснаасаа саваа гаргаж ирэн ноён Уизлид сунгалаа.

- Түүний гарт байсан. Шидэт савааг хэрэглэх хуулийн гуравдугаар зүйлд хүн биш амьтан савааг ашиглах юмуу зөөвөрлөх нь хориотой гэж заасан байдаг юм.

Тэгтэл ахин нэг тасхийх чимээ гараад ноён Уизлигийн дэргэд Людо Бэгмен гарч ирлээ. Тэрбээр толгойгоо сэгсрэн ногоон гавал руу нүд бүлтийн харав.

- Хар тамга! Хэн үүнийг хийсэн бэ? Та нар түүнийг барьсан уу? Барти! Юу болсон бэ? гээд тэр талбай дээр байгаа шидтэнгүүдийг тойруулан харахдаа Винкиг анзаарсангүй.

Ноён Крауч хоосон гартай эргэж ирлээ. Түүний царай хий үзэгдэл шиг цонхийсон хэвээр байх агаад сахал нь татвалзаж байв.

- Чи хаана байсан бэ, Барти? Яагаад тэмцээн дээр ирээгүй юм? Чиний үйлчлэгч суудлыг чинь тэмцээний турш хадгалаагүй бол намайг луу идэг! гэж Бэгмен хэлээд эцэст нь Винкиг ажиглаж,

- Тэр яагаа вэ? гэлээ.

- Би их завгүй байсан, Людо. Харин миний үйлчлэгч шившлэгт өртчихөөд байна гэж ноён Крауч уруулаа арай ядан хөдөлгөж хэлэв.

- Шившлэг гэнээ? Хэн түүнийг тэгдэг байна? Та нар уу? Яах гэж?

Тэгтэл Бэгмений гялалзсан дугуй царайд гэнэт ойлгосны тэмдэг тодорлоо. Тэр тэнгэр дээрх гавал руу харснаа дараа нь доошоо Винки руу харж эцэст нь Крауч руу харав.

- Байж боломгүй юм! Винки юу даа? Хар тамгыг илбэдсэн гэж үү! Тэр үүнийг яаж хийхийг мэдэхгүй шүү дээ! Хамгийн багадаа шидэт саваа хэрэгтэй!

- Түүнд саваа байсан. Би үүнийг гарт нь байхыг олсон юм, Людо. Хэрвээ та ноён Крауч дургүйцэхгүй бол юу болсныг бид түүнээс юу болсныг асууж болох юм.

Крауч түүний үгийг сонссон эсэх нь мэдэгдсэнгүй. Түүний чимээгүй байгааг зөвшөөрсний тэмдэг гэж бодоод Диггори саваагаа аван Винкид хүргээд,

- Оживи! гэв.

Винки сулхан хөдлөв. Тэр том хүрэн нүдээ нээж мэгдэн анивчнаа чимээгүй байгаа шидтэнгүүдийг хараад чичирч газар суучихлаа. Тэр ноён Диггорийн хөл рүү харснаа дараа нь алгуур айсан харц өргөн тэнгэр лүү харлаа. Гавал бүгдийн нүдэн дээр хөөрч байв. Винки хүндхэн санаа алдаад эхэр татан уйлав.

- Үйлчлэгч! Чи намайг хэн гэдгийг мэдэх үү? Би шидэт амьтдад хяналт тавин зохицуулах комиссийн гишүүн! гэж ноён Диггори ширүүн хэлэв.

Винки амьсгаадан бослоо. Харри шууд Доббийн өөрийгөө тэгж буруутай гэж мэдэрч байсныг саналаа.

- Хэн нэг нь тэнгэр лүү Хар тамга илгээсэн байна. Тэр газраас чамайг оллоо. Энд юу болсныг тайлбарлаач.

- Би үүнийг хийгээгүй, ноёнтоон! Би яаж хийхийг мэдэхгүй, ноёнтоон гэж Винки уйлагнав.

- Гэхдээ чамайг гартаа саваатай байхад чинь олсон шүү дээ! гэж ноён Диггори зандраад савааг даллав. Саваан дээр гавлын ногоон гэрэл тусахад Харри гэнэтхэн түүнийг танилаа.

- Энэ чинь миний саваа байна шүү дээ! гэж тэр баярлав.
- Ойн цоорхойд байсан бүх хүн түүн рүү эргэн харлаа.
- Өршөөгөөрэй? гэж ноён Диггори эргэлзэнгүй хэлэв.
- Энэ миний саваа байна! Би түүнийг гээчихсэн юм! гэж Харри тайлбарлав.
- Гээчихсэн гэнэ ээ? Энэ чинь тэгээд юу гэж байгаа юм? Чи түүнийг Хар тамга илгээснийхээ дараа хаясан уу? гэж ноён Диггори үл итгэн асуулаа.
- Амос, хэнд юу ярьж байгаагаа бодоод үз дээ! Чинийхээр бол Харри Поттер Хар тамгыг илгээсэн байх нь уу? гэж ноён Уизли уурсан хэлэв.
- Э-э-э... үгүй л дээ. Уучлаарай... цааш нь үргэлжлүүл гэж ноён Диггори хэлэв.
- Мэдээж, би үүнийг энд гээгээгүй. Би түүнийг ой руу орсныхоо дараа байхгүй болохыг нь мэдсэн гээд Харри гавал хөөрөн гарсан модны зүг заалаа.
- Тэгэхээр чи савааг олсон хэрэг үү, үйлчлэгч ээ? Тэгээд хэрэглэхээр шийдсэн юм биз дээ? гэж ноён Диггори Винкиг дальдичтал харж хэллээ.
- Би түүнийг хэрэглээгүй, ноёнтоон! Би... би... зүгээр л түүнийг авсан юм, ноёнтоон! Би Хар тамгыг илгээгүй, ноёнтоон... би яаж гэдгийг нь мэдэхгүй! гээд Винкигийн төмс шиг хамрыг нь даган хоёр дусал нулимс бөмбөрлөө.
- Энэ тэр биш! гэж Гермiona яамны шидтэнгүүдэд хандан хэлээд сэтгэл зовсондоо илүү шийдэмгий болж,
- Винкигийн хоолой нарийхан харин шившлэгийг чанга эрэгтэй хүний хоолой хэлсэн! Тийм биз дээ? гээд Харри, Рон хоёр луу дэмжлэг эрэн харлаа.
- Үнэн. Энэ бол үйлчлэгчийн хоолой биш байсан гэж Харри толгой дохив.
- Шившлэгийг хүн илгээсэн гэж Рон батлав.
- За яахав, одоохон үүнийг мэдэх болно. Энэ саваанаас ямар шившлэг сүүлд гарсныг мэдэх жирийн арга хэрэглэе. Үйлчлэгч ээ, чи үүнийг мэдэх үү? гэж Диггори урам хугарсан бололтой асуулаа.
- Винки чичирснээ толгойгоо сэгсрээд ноён Диггори саваагаа өргөхөд уулийн далавч шиг чихээ алгаараа дарав.
- Приор Инкантато! гэж тэр хэллээ.
- Энэ үгийн дараа ахин нэг амнаас нь могой цухуйсан аймшигтай гавал нисэн гарлаа. Гермiona ногоон гавал тэдний дээгүүр сүүдэртэн үнсэн саарал өнгийн утаа адил уугихад дуу алдав.
- Делетриус! гэж ноён Диггори хэлэхэд утаан гавал алга болж хөнгөхөн үүл боллоо.
- За боллоо гэж ноён Диггори ялалт байгуулсандаа хөөрсөн янзтай хэлээд чичирч байгаа Винки рүү ширүүн харав.

- Би... би... үүнийг хийгээгүй! Би бишээ, би... яаж гэдгийг нь мэдэхгүй! Би саваа ашиглахааргүй сайн, үйлчлэгч! Яаж гэдгийг нь мэдэх юм алга! гэж тэр айдаст автан нүдээ бүлтийлгэн хэллээ.

- Чи гэмт хэргийн үйлдэл дээрээ баригдсан, үйлчлэгч ээ! Гартаа гэмт хэргийн зэвсэгтэй баригдсан! гэж ноён Диггори орилов.

- Амос. Энэ шившлэгийг яаж хийхийг хэдхэн шидтэн л мэднэ. Тэр хаана сурах юм бэ? гэж ноён Уизли чанга хэлэв.

- Магадгүй, Амос намайг гэрийн үйлчлэгчдээ Хар тамга илгээхийг зааж өгсөн гэж итгүүлэхийг хүсч байгаа байх л даа хэмээн ноён Крауч уурсан хэллээ.

Таагүйхэн гүм чимээгүй байдал болов. Амос Диггори айсан бололтой.

- Ноён Крауч.. тийм биш... ерөөсөө тийм биш...

- Чи энэ талбай дээр Хар тамга илгээсэн гэж хоёр хүнийг буруутгаж болно. Харри Поттер болон намайг. Энэ хүүгийн түүхийн тухай мэднэ биз дээ, Амос?

- Тэгэлгүй яахав... бүгд л мэддэг шүү дээ... гэж ноён Диггори хэлэхдээ газар цөмрөн ороход бэлэн байгаа мэт харагдав.

- Миний урт удаан ажлын туршлага намайг хар шидтэнгүүдийг үзэн яддаг гэдгийг баталж байгаа гэдгийг чамайг санаж байгаа байх гэж найдна! гээд ноён Краучын нүд бүлтийлээ.

- Ноён Крауч, би... хэзээ ч таныг үүнд хамаатай гэж батлаагүй билээ! гээд Амос Диггори час улайлаа.

- Миний үйлчлэгчийг буруутгаж байна гэдэг чинь намайг буруутгаж байна гэсэн үг, Диггори! Өөр хэн түүнд ийм шид зааж өгөх юм бэ?

- Тэр... Тэр магадгүй... өөр газар сурсан байх...

- Яг тийм, Амос гээд ноён Уизли үйлчлэгч рүү эелдэгээр хандан,

- Винки, чи Харригийн савааг хаанаас олсон бэ? гэв.

Винкигийн царай нүүр гарын алчуур шигээ цайрч тэр хуруугаараа оролдов.

- Би... тэндээс олсон... тэнд... модны ард, ноёнтоон.

- Харж байна уу, Амос? Хэн нэгэн Хар тамгыг гаргаад шилжихдээ савааг газар унагажээ. Ул мөр үлдээхгүйн тулд бусдын савааг хэрэглэх ухаалаг алхам шүү. Харин Винки золгүй тохиолдлоор савааг авчээ.

- Гэхдээ тэр жинхэнэ гэмт хэрэгтнээс хоёр алхамын зайд байсан юм байна шүү дээ! Үйлчлэгч! Чи хэн нэгнийг харсан уу? гэж ноён Диггори тэвчээргүйхэн хэлэв.

Винки урьд урьдынхаас илүү чичирлээ. Түүний том нүд ноён Диггори, Людо Бэгмен дараа нь ноён Крауч дээр тусав. Тэр арайхийн шүлсээ залгиад,

- Би... хэнийг ч хараагүй, нёнтоон... хэнийг ч... гэв.

- Амос, чи Винкиг байцаахыг хүсч байгааг би маш сайн ойлголоо. Надад түүнтэй ярилцахыг зөвшөөрөөч гэж ноён Крауч занган хэлэв.

Ноён Диггори энэ гуйлтанд хөөрөх юм байсангүй. Гэвч ноён Крауч ид шидийн яамны чухал ажилтан болохоор эсэргүүцэх зүрх хүрсэнгүй.

- Тэр эргэлзэх юмгүй шийтгэгдэнэ гэж ноён Крауч хүйтэнээр нэмлээ.

- Э-э-ээнтээн. Э-э-ээнтээн, гуйя... гэж Винки ээрэн хэлээд ноён Краучыг нулимс дүүрэн нүдээр харав.

Ноён Краучын ширүүн царайд өрөвдөн хайрлах шинж байсангүй.

- Өнөө шөнө Винки итгэмээргүй үйлдэл гаргажээ. Би түүнд майханд үлдэхийг даалгасан. Харин тэр миний тушаалыг зөрчжээ. Энэ бол Винки чи хувцас авна гэсэн үг.

- Үгүй! Үгүй, эзэн минь! Хувцас хэрэггүй, би хувцас хүсэхгүй байна! гэж Винки хашираад хөлд нь сөгдөв.

Харри эзэн хувцас өгнө гэж юу гэсэн үг болохыг мэдэж байв. Энэ бол гэрийн үйлчлэгчийн чөлөөтэй болох цорын ганц арга билээ. Гэвч Винки алчуурнаасаа зуураад ноён Краучын хөлд цурхиран уйлахыг харахаас өрөвдөлтэй байлаа.

- Гэхдээ түүнд аймшигтай байсан шүү дээ! Винки өндрөөс айдаг. Харин тэнд багтай шидтэнгүүд агаарт маглуудыг өлгөсөн байсан! Түүнийг ой руу зугтаасанд нь буруутгах хэрэггүй. Тэр зүгээр л нуугдахыг хүссэн хэмээн Гермiona ноён Крауч руу уурсан муухай харж хэллээ.

Ноён Крауч Винкиг гялалзсан шаахайг нь муухай болгохоос айсан мэт хойшоо ухарлаа.

- Надад тушаал зөрчдөг гэрийн үйлчлэгч хэрэггүй. Эзнийхээ нэр хүндийг уландаа гишгэн өөрийн үүргээ мартдаг зарц хэрэггүй гэж тэр Гермiona руу харж мөс шиг хүйтэн хоолойгоор хэллээ.

Винки эхэр татан уйлахад ойгоор нэг цуурайтав. Бүгд барайн чимээгүй болов. Эцэст нь Ноён Уизли нам гүм байдлыг эвдлээ.

- Хэрвээ хэн нэгэн эсэргүүцэхгүй бол би өөрийнхнөө буудалд буцааж аваачмаар байна. Амос, энэ саваа бидэнд чадах бүхнээ үзүүллээ. Түүнийг Харрид буцааж өгч болно биз дээ?

Ноён Диггори савааг сунгахад Харри баяртайгаар авч халаасандаа хийлээ.

- За, бид явлаа гэж ноён Уизли тэдэнд толгой дохин хэлэв.

Гэвч Гермiona эхэр татан уйлж буй Винкиг хараад байрнаасаа хөдөлсөнгүй.

- Гермiona! гэж ноён Уизли шаардангуй дуудахад тэр хүндээр санаа алдан найзуудынхаа араас явлаа.

- Винки яах бол? гэж тэр замд орсон хойноо асуув.

- Мэдэхгүй гэж ноён Уизли хэллээ.

- Тэд түүнтэй яаж харьцаж байна аа! Ноён Диггори үргэлж үйлчлэгч гээд л... ноён Крауч өөрөө болохоор! Тэр түүний буруугүйг мэдэж байгаа ч гэрээсээ хөөхийг хүсч байна! Түүнд ганцаараа байх нь аймшигтай байдаг санааг нь ер зовоохгүй байна. Түүнийг хүн биш болохоор тэгж байгаа юм! гэж Гермiona уурсан хэлэв.

- Тиймээ тэр хүн биш гэж Рон хэллээ.

Гермиона уурсан түүн рүү харлаа.

- Энэ чинь түүнд мэдрэмж байхгүй гэсэн үг биш, Рон. Энэ чинь жигшмээр зүйл...

- Гермiona би үүнийг чинь зөвшөөрч байна. Гэхдээ одоо үйлчлэгчийн буруу зөвийг хэлэлцэж байх цаг биш. Аль болохоор түргэн майхан руугаа буцах хэрэгтэй. Бусад чинь хаана байгаа бол? гэж ноён Уизли түргэхэн хэлэв.

- Бид тэднийг харанхуйд алдсан. Ааваа, яагаад бүгд энэ гавалд санаа зовоод байгаа юм бэ? гэж Рон хэлэв.

- Майхандаа эргэж очсон хойно бүгдийг тайлбарлая гэж ноён Уизли тэднийг яаруулав.

Гэвч тэднийг модны захад гарч ирэхэд буудал дээр айж сандарсан шидтэнгүүд бөөгнөрсөн байлаа. Тэд ноён Уизлиг хараад ханаран ирцгээв.

- Тэнд юу болоо вэ?

- Хэн Хар тамгыг илгээсэн юм?

- Артур, тэр биш биз дээ?

- Мэдээж тэр биш. Гэхдээ хэн гэдгийг нь мэдсэнгүй. Тэр шилжсэн байсан. Харин одоо намайг бүү саатуулаач. Майхандаа орох гэж яарч байна. Их ядарсан болохоор унтмаар байна.

Хүмүүс зай тавьж өгөхөд бүгд буудал руу орлоо. Энд нам гүм болж зөвхөн шатсан майхны үлдэгдэл уугина.

Эрэгтэйчүүдийн майхнаас Чарлигийн толгой цухуйгаад,

- Аав аа, юу болсон юм бэ? Фред, Жорж, Жинни гурав аль түрүүн эргэж ирсэн. Харин бусад нь хаа байна? гэж харанхуйд асуух нь сонсогдов.

- Тэд надтай хамт байна гээд ноён Уизли майхан руу бөхийн ороход найзууд түүний араас дагалдав.

Билл гал зуухны жижигхэн ширээний ард суугаад нэг гараа цус болсон орны даавуугаар ороожээ. Персигийн хамар хугарч, Чарли бүрэн бүтэн байсан ч цамц нь урагдсан байлаа. Фред, Жорж, Жинни гурав чичирсэн хэвээр гэхдээ тэмцлийн нэг ул мөр байсангүй.

- Та нар түүнийг барьсан уу, аав аа? Хэн Хар тамгыг илгээсэн юм бол? гэж Билл огцом асуув.

- Үгүй. Бид Барти Краучын гэрийн үйлчлэгч Харрийн шидэт савааг бариад зогсож байхад нь олсон. Харин тамга илгээсэн хүн усанд шумбасан мэт сураггүй болсон.

- Юу гэнээ? гэж Билл, Чарли, Перси гурав зэрэг дуу алдав.
 - Харрийн саваа гэнээ? гэж Фред гайхлаа.
 - Ноён Краучын үйлчлэгч гэнээ хэмээн Перси аянганд ниргүүлсэн аятай дуугарав.
- Бүгд ойд юу болсныг ярилаа. Яриа дуусах үед Перси зэвүүцсэн байртай,
- Ноён Краучын туйлын зөв! Тийм үйлчлэгчийг даруйхан зайлуулах хэрэгтэй! Түүнд байрандаа үлд гэж тодорхой хэлсэн байхад зугтжээ. Ид шидийн яамныхны өмнө түүнийг ичгүүртэй байдалд оруулаад шүү! Энэ ч бас хангалттай биш түүнийг хяналтын хэлтсийнхэнд тушаах хэрэгтэй! гэв.
 - Тэр муу зүйл юу ч хийгээгүй. Зүгээр л хэрэггүй газартаа тохиромжгүй цагт байж байсан! гэж Гермиона маргалдав.
 - Ноён Крауч шиг шидтэнгүүд гэрийн үйлчлэгч галзуурсан аятай шидэт саваа даллаж байхыг тэвчдэггүй юм!
 - Тэр галзуу юм шиг даллаагүй! Тэр зүгээр л газраас олсон юм! гэж Гермиона дүрсхийлээ.
 - Сонсооч, хэн нэгэн надад энэ гавлыг тайлбарлаад өгөөч? Тэр хэнийг ч гэмтээгээгүй биз дээ. Яагаад түүнээс болж ийм их чимээ шуугиан болоод байгаа юм? гэж Рон тэсч ядан хэлэв.
 - Би чамд Хэцүү нэртийн бэлгэ тэмдэг гэж хэлсэн биз дээ. Би энэ тухай <<Хар урлагын хөгжилт уналт>> номоос уншсан гэж хэн ч ам нээж амжаагүй байхад Гермиона хэлэв.
 - Тэр арван гурван жилийн турш үзэгдээгүй юм. Хүмүүс сандралд орж байгаад гайхах юм алга. Энэ нь бараг Хэцүү нэртийг эргэн ирсэн юм шиг санагдуулж байна! гэж ноён Уизли аяархан хэлэв.
 - Ойлгох юм алга. Энэ чинь ердөө л тэнгэрт байгаа үүл байсан шүү дээ гээд Рон хөмсөг зангидлаа.
 - Рон Хэцүү нэрт болон түүний дагалдагчид хэн нэгнийг алах үедээ түүнийг тэнгэр лүү илгээдэг байсан юм. Чи түүний хичнээн аймшигтай болохыг мэдэхгүй байна. Чи хэтэрхий бага байна. Чи гэр лүүгээ явж байхдаа түүн дээр Хар тамга байна гээд төсөөлөөд үз дээ... Хүмүүс үргэлж муу... аймшигтай зүйлээс болгоомжилдог юм гэж ноён Уизли хэлэв.
- Бүгд чимээгүй болов. Билл гарныхаа боолтыг тайлж шархаа хараад,
- Өнөө шөнө тамга бидэнд Үхэл идэгч нарыг барихад саад болсон. Тэд түүнийг хараад маш түргэн шилжихсэн. Бид нэгнийх нь ч багийг хуулж чадаагүй. Харин бид Робертсыг газар унахаас нь өмнө барьж авсан. Одоо түүний ой ухааныг хэн нэгэн өөрчилж байгаа гэв.
 - Үхэл идэгч гэнээ? Тэд хэн юм бэ? гэж Харри асуулаа.
 - Хэцүү нэртийн талынхныг тэгж нэрлэдэг юм. Бид нар өнөөдөр тэдний нэг хэсэгтэй тэмцлээ. Тэд цөөхүүл үлдсэн дээ. Харин тэд яаж Азкабанаас зугтсан юм бол.

- Тэднийг байсан гэх баталгаа байхгүй. Хэдийгээр тэд байсан гэж үзэж байгаа ч гэж ноён Уизли толгой сэгсэрээд найдлагагүйгээр гараа савчив.

- Тэднийг байсан гэж мөрийцөхөд ч болох юм! Биднийг ойд Драко Малфойтой уулзах үед тэр бараг л эцэг нь багтай хүмүүсийн дунд байгаа гэж хэлсэн шүү! Бүгд л Малфойнх Хэцүү нэртийн хамгийн ойрын туслах гэж мэддэг биз дээ! гэж Рон гэнэтхэн хэлэв.

- Гэхдээ Волан-де-Мортын туслагчид яагаад... гэж Харри хэлэхэд бүгд давхийлээ. Уизлигийнхан олонхи шидтэний адил Хар лордын нэрийг хэлэхээс зайлсхийдэг билээ.

- Өршөөгөөрэй. Гэхдээ Хэцүү нэртийн туслагчид яагаад маглыг агаарт хөөргөсөн юм бол? Ямар нэгэн онцгой бай байсан юм болов уу?

- Бай гэнэ ээ? хэмээн ноён Уизли хөгжилтэй бус инээмсэглэн,

- Харри, тэд хөгжилдөж байсан юм. Энэхүү хүчирхэг Хэцүү нэрт маглуудын хагасыг алахдаа хөгжилтэй байдаг байсан. Би өнөөдөр тэднийг бидэнд олуулаа гэдгээ сануулахын тулд уусан гэж бодож байна. Хуучин найзуудын багахан үдэшлэг гээд ярвайлаа.

- Гэхдээ Үхэл идэгч нар яагаад Хар тамгыг хараад шилжсэн юм бол? Баярлах ёстой юм биш үү! гэж Рон хэлэв.

- Толгойгоо ажиллуул, Рон. Хэрвээ тэд нар жинхэнэ Үхэл идэгч байсан бол ямар аргаар Азкабанд оролгүй зайлсхийсэн байж болох вэ. Хэцүү нэртийг хүчээ алдсаны дараа зөвхөн түүнийг л хүмүүсийг тамлан зовоож алж байсан гэж худал ярьсан. Хэрвээ тэр үнэхээр эргэж ирвэл дагалдагчид нь айсандаа чичрэх болно. Тэд түүнийг хүчээ алдсаны дараа холбоотой байхаас татгалзаж ердийн амьдралдаа эргэн орсон. Түүнийг тэднийг уучилна гэж бодохгүй байна!

- Тэгэхээр... Хар тамгыг Үхэл идэгч нарыг дэмжих юмуу айлгахын тулд илгээсэн байх нь гэж Гермиона бодлогоширон хэлэв.

- Бид өөрсдөө үүнд толгойгоо гашилгах болно, Гермиона. Нэг зүйлийг хэлэхэд Үхэл идэгч нар л хэрхэн илгээхийг мэддэг юм. Хэн ч түүнийг илгээсэн ч бай тэр хэзээ нэгэн цагт Үхэл идэгч байсан гэсэн үг... За болно, явж жаахан хажуулъя. Их оройтсон болохоор унтах цаг бараг үлдсэнгүй. Эртхэн гарч эхний зөөвөрлөгчид хүрэх хэрэгтэй. Ээж чинь өглөөний сонинг уншиж юу болсныг мэдээд санаа нь зовох болно гэж ноён Уизли хэллээ.

Харри орон дээр хэвтэхэд толгой нь дүнгэнэж байв. Шөнийн гурван цаг болж байхад тэр унталгүй сэрүүн түгшин хэвтэж байлаа.

Гурван өдрийн өмнө түүний сорви нь өвдөж сэрээсэн. Харин энэ шөнө арван гурван жилд анх удаа тэнгэрт Волан-де-Мортын тамга гарлаа. Энэ бүхэн ямар учиртай юм бол?

Тэр Улаан модон гудамжинд байхдаа Сириуст захидал илгээсэн. Хариу нь хэзээ ирэх юм бол? Харри адар өөд харж хэвтэж байхдаа зөгнөлт нислэгээ бодож чадаагүй

болохоор унтахад амар байсангүй. Эцэст нь Чарлигийн хурхиралт майханд түгэх үеэр Харри унтлаа.

БҮЛЭГ 10: ИД ШИДИЙН ЯАМАНД БОЛСОН ХЭРҮҮЛ ШУУГИАН

Ноён Уизли амласан ёсоороо бүгдийг эрт сэрээв. Шидэт майхнаа хураагаад бүгд буудлыг яаран орхин гарлаа. Тэд байшингийнхаа үүдэн дээр зогсож буй ноён Робертсийн хажуугаар гарав. Зохицуулагч тэдэн рүү хачирхалтай мэлрэн харж салах ёс гүйцэтгэн даллаад <<Зул сарын баярын мэнд...>> гэв.

- Тэр зүгээр дээ. Заримдаа ой ухааныг өөрчлөх үед цаг хугацааны баримжаа алдах тохиолдол гардаг юм. Түүнд олон зүйлийг мартаж хэрэг гарна гэж ноён Уизли хонин арц ургасан газраар явахдаа хэлэв.

Тэд зөөвөрлөгч байгаа газар хүрч очоод тэвчээргүйхэн хоолойнууд сонсов. Бэзилийн эргэн тойрон буудлаас аль болох түргэн гарахыг яарсан шидтэнгүүд цуглаад шуугилдаж байлаа. Ноён Уизли Бэзилтэй товчхон яриад бүгд нар мандахын өмнөхөн Үентолгой толгод руу хүргэж өгөх хуучин хаймран дугуйны дэргэд дугаарлан зогсов. Тэд Оттери-Сент-Кэтпоул тосгоны чийгтэй замаар өнгөрөөд <<Үүр>> лүү явахдаа өглөөний цай уух хүсэлдээ автан хэнд ч ярих хүч байсангүй. Тэднийг булан тойроод Үүр харагдах үед,

- Бурханд баярлалаа гэх дуу хадав.

Хатагтай Уизли тэднийг хашааны урд хүлээн зогсож байснаа гэрийн шаахайтай гүйж ирэхдээ царай нь цонхийж түгшсэн бөгөөд гартаа <<Өдөр тутмын Зөнч>> сонин барьсан харагдана.

- Артур! Би ямар их санаа зовов оо...

Тэр ноён Уизлиг тэврэхэд <<Өдөр тутмын Зөнч>> сонин гараас нь мултран уналаа. Харри доошоо хараад <<Дэлхийн цомын тэмцээн дээр болсон аймшигт явдал>> гэсэн гарчгийг олж харав. Хар цагаан зурган дээр Хар тамга модны орой дээгүүр хөвж байлаа.

- Бүгд бүрэн бүтэн биз гэж хатагтай Уизли уулга алдаад тэднийг улайсан нүдээр ширтлээ.

- Та нар амьд байна... Хөвгүүд минь...

Бүгдийн гайхлыг төрүүлэн тэр Фред, Жорж хоёрыг өвдтөл чанга тэвэрлээ.

- Ёо! Ээж ээ, та биднийг боож алах нь байна...

- Би та нарыг явахаас өмнө хэлсэн үгийнхээ тухай бодож байлаа! Би зөвхөн энэ тухай л бодож байлаа! Хэрвээ Хэцүү нэрт та нарыг алсан бол ээжээсээ сонссон сүүлийн үг чинь С.И.Ш хангалттай аваагүй тухай байлаа! Өө Фред... Жорж хоёр минь дээ... гэж хатагтай Уизли уйлан хэлэв.

- Болно, Молли минь, болно! Бид бүгд маш сайн байна гээд ноён Уизли эхнэрээ тайвшируулан ихрүүдийг тавиулаад араас нь явахдаа,

- Билл сонинг аваадхаач, би юу байгааг нь хараадхъя гэж аяархан хэлэв.

Жижигхэн гал тогоонд бүгдээрээ оров. Гермiona хатагтай Уизлид аагтай цай аягалж, ноён Уизли огденийн хуучин виски гарган дусаалаа. Билл эцэгтээ сонинг сунгав. Ноён Уизли эхний нүүрийг гүйлгэн харав. Перси догдолсон байртай мөрөн дээгүүр нь шагайлаа.

- Би үүнээс л айж байсан юм. <<Ид шидийн яамны алдаа... гэмт хэрэгтэн баригдсангүй... сул дорой аюулгүй байдал... Хар шидтэнгүүд хараа хяналтгүй сэлгүүцэж байна... үндэстний шившиг...>> Хэн үүнийг бичсэн юм бэ? Аан... Мэдээж Рита Скитер л байж таарна гэж ноён Уизли гунигтайгаар хэллээ.

- Энэ эмэгтэй Ид шидийн яамыг дайрч байна гэж үү! Долоо хоногийн өмнө бичсэн бол бид тогооны зузааны илтгэлд цагаа үрэхийн оронд цус сорогчыг устгах байлаа! Яг л шидтэн биш хүмүүст аюул заналхийлэх тохиолдолд авах удирдамжын арван хоёр дугаар зүйлд заасны дагуу...

- Перси минь, эелдэгээр амаа хамхиж үз гэж Билл эвшээлээ.

- Намайг дурссан байна... гээд ноён Уизли нүдээ бүлтийлгэн мөрний төгсгөлийг нь харав.

- Хаана? Хэвээ би чиний нэрийг харсан бол амьд гэдгийг чинь мэдэх байсан! гэж хатагтай Уизли вискитэй цай оочлонгоо хэлэв.

- Тэр нэр дурьдаагүй байна. Сонсож бай: <<Хэдийгээр айсан шидтэнгүүд ойн цоорхойд цуглан амьсгаа даран шинэ мэдээ хүлээж ид шидийн яамны зүгээс ямар нэгэн тайлбар тавина гэж найдаж байсан ч гэсэн гүнзгий урам хугарсан юм. Ид шидийн яамны албан төлөөлөгч хэсэг хугацааны дараа Хар ойгоос гарч ирээд хязгаарлагдмал мэдээгээр хэн ч гэмтээгүй гээд цааш нь тайлбар хийхээс татгалзлаа. Ийм мэдэгдэл нь ойгоос хэд хэдэн хүүр олсон гэх цуу яриаг хүчингүй болгож байна >>. За, би та нарт хэлсэн биз дээ... гээд ноён Уизли унтууцан сонинг Персид өгөөд,

- Хэн ч гэмтээгүй гэнээ. Би тэдэнд өөр юу хэлэх ёстой байсан гэж? <<Цуу яриагаар бол ойгоос хэдэн хүүр олдсон гэнээ>>. Одоо үүний дараа хангалттай цуу тарна. Би ажилдаа явлаа, Молли минь. Энэ түүхийн учрыг олох хэрэгтэй байна гээд хүндээр алдав.

- Би таньтай хамт явъя, аав аа. Ноён Краучид одоо хүн бүр хэрэгтэй. Юуны түрүүнд би түүнд тогооныхоо илтгэлийг гардуулна гэж Перси чухалчлан хэлэв.

Тэрбээр гал тогооноос яаран гарч одлоо.

Хатагтай Уизли аймшигтай сэтгэлээр унажээ.

- Артур чи чинь амралттай байгаа биз дээ! Тэнд чамгүй бол ямар ч зүйл бүтэхгүй байна уу!

- Би явах ёстой Молли минь. Хувцсаа солиод явахаас... гээд ноён Уизли ахин санаа алдав.

- Хатагтай Уизли, Хэдвиг захиа авчраагүй юу? гэж Харри тэсэлгүй асуулаа.

- Хэдвиг гэнэ ээ? Үгүй дээ... ямар ч шуудан ирээгүй гэж сэтгэлээр унасан хатагтай Уизли хэлэв.

Рон, Гермоиона хоёр Харри руу сониучирхан харна.

- За, би дээшээ юмаа аваачиж тавилаа шүү, Рон гээд Харри андуудаа учиртай харлаа.

- Тэгэлгүй яахав би чамтай хамт явна. Харин чи, Гермона? гэж Рон даруйхан хэлэв.

- Хамт явъя гэж тэр толгой дохиод гурвуулаа гал зуухнаас гаран гүйх шахам дээшээ өгслөө.

- Харри, юу болоо вэ? гэж Рон тэдний ард дээврийн хөндийн хаалга хаагдахад асуув.

- Би та нарт зарим зүйл хэлээгүй юм. Бямба гаригийн өглөө миний сорви хүчтэй өвдөөд сэрсэн...

Рон, Гермона хоёр мэдээг Харригийн Улаан модон гудамжны унтлагын өрөөндөө бодсон ёсоор хүлээн авчээ. Гермона дуу алдаад олон номын талаар дурьдан зөвлөгөө өгч, Альбус Дамблдор болон Хогвартсын сувилагч хатагтай Помпри нарын талаар дуржигнуулав.

Рон нүдээ бүлтийлгэв.

- Гэхдээ... тэр тэнд байгаагүй биз дээ! Хэцүү нэрт? Өнгөрсөн удаа чиний сорви өвдөх үед тэр Хогвартсад байсан. Санаж байна уу?

- Мэдээж тэр Улаан модон гудамжинд байгаагүй. Би түүнийг зүүдэндээ Питер хэмээгч Сүүлттэй хамт харсан. Миний санаж байгаа зүйл гэвэл тэд... хэн нэгнийг алах талаар төлөвлөж байсан.

Түүний уруулаас золтой л <<намайг>> гэсэн үг нисэн гарсангүй. Учир нь Гермона түүнийг айдас дүүрэн харцаар харжээ.

- Энэ чинь ердөө зүүд шүү дээ. Ердөө хар дарсан зүүд гэж Рон түүнийг тайвшируулав.

- Тиймээ, гэхдээ тэр байсан! Хачирхалтай нь сорви Үхэл идэгчид болон тэнгэрт Волан-де-Мортын бэлэг тэмдэг гарч ирэхээс гурван өдрийн өмнө өвдсөн гэж Харри цонхоор ширтэнгээ хэлэв.

- Энэ нэрийг бүү дурьд! гэж Рон шүдний завсраар сийгүүлэв.

Гэвч Харри сонсоогүй юм шиг үргэлжлүүлээ.

- Профессор Трелони өнгөрсөн жилийн төгсгөлд юу хэлснийг санаж байна уу?

Профессор Трелони бол Хогвартсын мэргэ төлгийн хичээлийн багш билээ. Гермонагийн айдас агшин зуур алга болоод сэжигтэй тургилав.

- Өө, Харри минь дээ чи үнэхээр хөгшин луйварчны үгэнд итгэж байгаа юм уу?

- Чи тэнд байгаагүй шүү дээ. Чи түүнийг сонсоогүй. Тэр чинь онцгой тохиолдол байсан юм. Би түүнийг жинхэнэ ховсдуулсан юм шиг байдалд ороод байсан гэж хэлсэн биз дээ. Тэр хэлэхдээ Хар лорд ахин эргэж ирнэ... өмнөхөөсөө илүү

хүчирхэгжинэ... Харин түүнд эргэж очсон зарц нь туслана гэсэн. Тэр шөнө Сүүлт зугтаа биз дээ гэж Харри эсэргүүцэв.

Андууд чимээгүй боллоо. Рон суудал дээрээ хавчганан бүтээлгэн дээр байсан <<Педдлийн их буунууд>> зураг руу харна.

- Харин чи яагаад Хэдвигийн талаар асуугаад байсан бэ? Захиа хүлээж байсан юм уу? гэж Гермиона нам гүмийг эвдэн хэлэв.

- Би Сириуст сорвиныхоо тухай захиа бичээд хариу хүлээж байсан юм.

- Зүйтэй хийжээ. Сириус үүнийг учрыг олох байх гэж Рон хэлэв.

- Би түүнийг шууд л хариу илгээнэ гэж найдаж байлаа гэж Харри хэлэв.

- Гэхдээ бид түүний одоо хаана байгааг мэдэхгүй шүү дээ... Африкт юм уу илүү хол байгаа байх. Тийм аялал хийхэд Хэдвигт хэдэн өдөр шаардагдана гэж Гермиона ухаалгаар хэлэв.

- Тиймээ, би ойлгож байна гэж Харри хэлэв. Гэвч цонхны цаадах хоосон тэнгэрийг хараад сэтгэл нь эвгүйрхжээ.

- Явж квиддич тоглоё. Гурвын эсрэг гурав. Ах нар татгалзахгүй ээ. Чи Финт Воронскийн нислэгийг туршиж...

- Рон хэмээн Гермиона <<тэнэг толгойгоо ажиллуул>> гэж байгаа аятай хэлээд,

- Харри одоо квиддич тоглохыг хүсэхгүй байгаа. Тэр түгшиж ядарсан байна... Бид бүгдээрээ унтаж амрах хэрэгтэй... гэв.

- Явж тоглоё. Хүлээгээрэй би <<Аянга>>-аа аваадхая гэж Харри зөвшөөрлөө.

Гермиона өрөөнөөс гарахдаа <<хөвгүүд>> гэсэнтэй туйлын адилхан үг бувтналаа.

Дараагийн долоо хоногийн турш ноён Уизли, Перси хоёр гэртээ бараг үзэгдсэнгүй. Өглөө эрт яваад бүгд унтсан хойно оройн хоолноос хожимдон ирцгээж байв.

- Энэ ч ид шидийн яам биш гай зовлон байна даа. Долоо хоногийн турш би гал асахыг л харлаа. Хүмүүс эцэс төгсгөлгүй Аянгын мэдээ ирүүлж даруйхан онгойлгохгүй бол дэлбэрч байлаа. Миний ширээ түлэгдээд дуртай үзэг минь хүртэл шатчихсан шүү гэж Перси Хогвартс явахын өмнөх орой хэлэв.

- Тэд яагаад Аянгын мэдээ ирүүлж байгаа юм бол? гэж Жинни зуухны өмнөх хивсэн дээр хэвтээд шидэт наалдамхай хальсаар <<Ид шидэт мянган ургамал мөөг>> ном нааж байхдаа асуулаа.

- Дэлхийн цомын тэмцээний аюулгүй байдалд сэтгэл хангалуун бус байгаа юм. Сүйрсэн эд хөрөнгөндөө нөхөн төлбөр шаардаж байгаа юм. Наземникус Флетчер майхнаа арван хоёр унтлагын өрөөтэй гэж зүтгэлээд байгаа. Би түүнийг буудал дээр дээлээ нөмрөөд унтаж байсныг мэднэ л дээ.

Хатагтай Уизли буланд байсан өвөөгийнхөө цаг руу харав. Харрид энэ цаг их таалагддаг юм. Энэ цаг заахгүйгээрээ ашиггүй хэдий ч өөр ашигтай зүйлийг заана. Цаг есөн алтан зүүтэй бөгөөд тус бүр дээр нь Уизлийн гэр бүлийн гишүүний нэрийг

бичсэн байдаг юм. Тоо байхгүй оронд нь гэр бүлийн гишүүн бүрийг тодорхойлсон <<байшин>>, <<сургууль>>, <<ажил>>, <<замд>>, <<хаа байгаа нь мэдэгдэхгүй>>, <<эмнэлэг>>, <<шорон>> бас арван хоёрын тоон дээр <<үхлийн аюул >> гэж бичсэн байлаа.

Одоо наймдугаар зүү <<гэрт>> гэсэн бичгийг зааж байх бөгөөд хамгийн урт зүү ноён Уизли <<ажил>> гэсэн үгэн дээр байгааг зааж байв. Хатагтай Уизли санаа алдлаа.

- Эцэг чинь Хэцүү нэртийг байх үед ч амралтын өдрөөр ажилладаггүй байсан. Харин одоо ажилдаа дарагджээ. Ахиад л хоцорч байна. Оройн хоол хөрчихлөө гэж хатагтай Уизли хэлэв.

- Аав тэмцээний дараа алдаа гаргасан. Үнэнийг хэлэхэд түүний зүгээс хэлтэстэйгээ хамааралгүй ийм мэдэгдэл хийх нь ухаалаг биш хэрэг байлаа гэж Перси хэлэв.

- Эцгээ битгий буруутга. Энэ жигшүүртэй Скитер бичсэн нь багадаад байна уу! гэж хатагтай Уизли дүрсхийлээ.

- Аав юу ч хэлээгүй гэсэн хөгшин Рита ид шидийн яамны хэн ч мэдэгдэл хийгээгүй гэж буруутгасан! Рита Скитер хэний тухайд ч сайн үг хэлдэггүй юм. Тэр Гринготтс банкны шившлэг цуцлагчдаас ярилцлага авахдаа намайг урт үстэй гэж дуудсаныг санаж байна уу? гэх Ронтой шатар тоглож байсан Биллийн хоолой гарав.

- Чиний үс үнэхээр урт байна, хонгор минь. Хэрвээ чи надад зөвшөөрвөл... гэж хатагтай Уизли аяархан хэллээ.

- Үгүй дээ, ээжээ.

Зочны өрөөний цонхыг бороо нүднэ. Гермiona <<Ид шидийн сурах бичиг. Дөрөвдүгээр дамжаа>> гэсэн хатагтай Уизлигийн Тахир гудамжнаас авч өгсөн номыг шимтэн уншиж, Чарли галд тэсвэртэй дуулга нөхөж, Харри <<Аянга>>-аа Гермionaгийн төрсөн өдрөөр нь бэлэглэсэн шүүр арчлах цуглуулгын сойзоор өнгөлж байлаа. Фред, Жорж хоёр буланд суугаад гартаа үзэг барьж ямар нэг юмны тухай аяархан шивнэлдэн цаас руугаа тонгойно.

- Та нар тэнд юу хийгээд байна? гээд хатагтай Уизли ихрүүдийг сэжигтэй харав.

- Гэрийн даалгавар гэж Фред бүдэгхэн хэлэв.

- Битгий инээдтэй юм яриад бай. Та нар чинь амарч байгаа биз дээ.

- Бид хоцорч байгаа юм гэж Жорж хэлэв.

- Та нар захиалгын шинэ хуудас бичээгүй биз дээ? Эсвэл ахиад л шидэт бүтээлүүд чинь үү гэж хатагтай Уизли хөмсөг зангидан хэлэв.

- Ээжээ хэрвээ маргааш <<Хогвартс Экспресс>> галт тэргэнд осол гараад Жорж бид хоёр үхчихвэл таны талаарх сүүлчийн дурсамж минь ямар үг байх бол? гэж Фред хэллээ.

Бүгд тэр ч байтугай хатагтай Уизли хүртэл инээлээ.

- Ашгүй аав чинь ирж байна! гэж тэр дуу алдаад ахин цаг руу харав.

Ноён Уизлигийн зүү <<замд>> гэсэн үгэн дээр тогтсоноо хормын дараа тэдний удтал хүлээсэн <<гэрт>> гэсэн үгийг заалаа. Гал тогоонд танил дуу гарах сонсогдов.

- Артур, очиж байна! гээд хатагтай Уизли өрөөнөөс яаран гарлаа.

Хэдэн хормын дараа дулаахан зочны өрөөнд тавиуртай хоол барьсан ноён Уизли орж ирэв. Тэр үнэхээр ядарсан төрхтэй харагдана.

- Бидэнд ахиад л таагүй явдал тохиолдлоо гэж хатагтай Уизлид хэлээд сандал дээр суухдаа зуухны өмнөх хивсэн дээр сэрээгээ байцааны хэсэгтэй унагачихлаа.

- Рита Скитер долоо хонгийн турш өмхий хүрэн шиг хаа сайгүй шиншилж ид шидийн яамыг буруутгах шалтаг хайж байгаад хөөрхий хөгшин Брертагийн алга болсон тухай мэдчихлээ. Одоо маргаашийн <<Зөнч>> сонины тэргүүн нүүрэнд дараагийн шившигтэй явдал бичигдэхийг хүлээх хэрэгтэй болох нь. Уул нь би Бэгменд аль эрт түүнийг хайхаар хүн илгээх хэрэгтэй гэж хэлж байсан даа.

- Ноён Крауч энэ тухай маш олон өдрийн өмнө хэлсэн! гэж Перси яаран хэлэв.

- Чиний Краучын аз болоход Рита Винкигийн түүхийн тухайд мэдээгүй. Гэрийн үйлчлэгч Хар тамга илгээсэн савааг барьж зогсоод баригдсан нь бүтэн долоо хоногийн шуугиан болох байлаа гэж ноён Уизли бувтналаа.

- Бид Винкиг тушаал зөрчсөнийг хүлээн зөвшөөрсөн биз дээ. Хар Тамганд ямар ч хамаагүй гэж Перси хэллээ.

- Харин минийхээр бол ноён Краучын аз болоход <<Өдөр тутмын Зөнч>> сонины хэн ч түүний үйлчлэгчтэйгээ хүн бус харьцдаг тухай мэдээгүй! гэж Гермiona уурсан хэлэв.

- Сонсооч Гермiona! гээд Перси давшилтанд оров.

- Ид шидийн яамны өндөр тушаалтангууд ноён Краучын адил түүний зарцыг дуулгавартай байх ёстой гэдэгт гуйвалтгүй байгаа!

- Боолынхоо талаар гэж чи хэлэх гээ юу! Тэр түүнд хөлс төлдөггүй биз дээ? гэж Гермiona уур нь дүрэлзэн хэлэв.

- Дээшээ гарч ачаа бараагаа зэхсэн чинь дээр байх. Алив, одоо бүгд явцгаа... хэмээн хатагтай Уизли маргаанд оролцов.

Харри сойзоо далд хийн <<Аянга>>-аа мөрөн дээрээ тавиад Ронтой хамт дээш өгслөө. Дээврийн өрөөнд бороо шаагих чимээ бүр хүчтэй сонсогдоно. Бороо шаагих салхи улих чимээ даган дээвэр дээр амьдардаг ороолонгын дуулах сонсогдож байв. Тэднийг орж очиход Гахай торон дотроо хөөрсөн байртай жиргэв. Хагас багласан чемоданууд түүний сэтгэлийг хөөрөхөд хүргэсэн бололтой.

- Түүнд уулийн жигнэмэг өгье. Тэгвэл амаа хамхих байх гээд Рон Харрийн хайрцагыг түлхэв.

Харри сүрэл дундаас хэдэн жигнэмэг аваад чемодандаа эргэж ирлээ. Дэргэд нь Хэдвигийн хоосон тор байсан хэвээр байв.

- Тэр долоо хоногийн турш ирсэнгүй. Рон чи юу гэж бодож байна? Сириус баригдсан юм болов уу? гэх Харригийн хоолойд түгшсэн өнгө илрэв.

- Үгүй дээ. Ид шидийн яамныхан хэн нэгнийг барьсан бол <<Зөнч>> сонин нүд ирмэх зуур л гаргачихна.

- Тийм байх...

- Ээж чамд Тахир гудамжнаас юу худалдаж авсныг хараач... Чиний шүүгээнээс жаахан мөнгө авсан гэсэн. Бас бүх оймсыг чинь угаачихаж.

Рон Харригийн орон дээр овоолсон оймсын хажуудах боодолтой зүйлсийг заав. Харри дэлгүүрээс авсан зүйлсийг задалж Миранда Гуссоклын <<Ид шидийн сурах бичиг>>, шинэ өднүүд, хуйлаастай цаасны хамт байхыг харав. Хатагтай Уизли түүний уусмалын хичээлд ч санаа тавин арслан загасны сээр нуруу авсан байлаа. Харри цагаан хэрэгслэлийн тогоо руу шагайтал ард нь Роны цөхөрсөндөө орилох дуу хадав.

- Энэ чинь одоо юу вэ?

Тэр гартаа ямар нэгэн бор өнгийн зах ханцуй нь шаргал торон эмжээртэй урт хилэн даашинз барьсан байлаа.

Тэгтэл өрөөний хаалга цохин Хатагтай Уизли сургуулийн цэвэрлэсэн дүрэмт хувцаснуудыг барин орж ирлээ.

- Энэ та нарынх. Чемодандаа хийхдээ үрчийлгэхгүйг хичээгээрэй гэж хэлээд хоёулангийнхийг нь өглөө.

- Ээжээ та надад Жиннигийн шинэ даашинзыг өгчихсөн байна гээд Рон түлхэв.

- Энэ Жиннигийн даашинз биш. Чамд авсан юм. Баяр ёслолын жанч гэж хатагтай Уизли тэвчээртэйгээр тайлбарлав.

- Юу гэнээ? гэж Рон дуу алдлаа.

- Ёслолын хувцас! гэж хатагтай Уизли давтаад,

- Сургуулийн жагсаалтанд бичихдээ энэ жил та нарт ёслолын хувцас хэрэг болно гэсэн байсан... албан ёсны үйл явдалд зориулан гэв.

- Та тоглож байна уу? Би хэзээ ч ийм муухай зүйл өмсөхгүй! гэж Рон чихэндээ итгэхгүй шахам хэлэв.

- Түүнийг бүгд өмсдөг юм, Рон. Тэгээд ч бүгдэд таалагддаг! Эцэгт чинь байдаг биз дээ! гэж хатагтай Уизли уурсаж эхлэв.

- Би үүнийг өмссөнөөс нүцгэн явсан нь дээр гэж Рон зөрүүдлэв.

- Тэнэг юм бүү ярь. Чи жагсаалтанд бичсэн ёслолын хувцасыг өмсөх ёстой! Би Харрид ч бас худалдаж авсан... Харри түүнд үзүүл дээ.

Харри сүүлчийн боодлыг болгоомжлон урлаа. Түүнд дотор ямар ч эмжээр байхгүй бүрэн ёслолын хувцас байлаа. Сургуулийн жанчтай адилхан ч хар өнгөтэй биш ногоон өнгөтэй ажээ.

- Би чиний нүдний өнгөнд тааруулан сонгосон юм гэж хатагтай Уизли энхрийлсэн байдалтай хэлэв.

- Гэхдээ энэ чинь хэвийн байна шүү дээ! Яагаад худалдаж авахын өмнө надаас асууж болоогүй юм бэ? гэж Рон Харригийн жанчыг хараад уурсан хэллээ.

- Яагаад гэвэл... би түүнийг хуучин эдлэлийн мухлагаас худалдаж авсан юм. Тэдний сонголт их биш гэдгийг мэднэ биз дээ гэж хатагтай Уизли улайн хэллээ.

Харри эргэж харлаа. Тэр Уизлийн гэр бүлийн Гринготтс банкинд хадгалагддаг мөнгийг сайн мэдэх аж. Тэдэнд хэзээ ч их мөнгө байгаагүй юм.

- Би яагаад ч үүнийг өмсөхгүй. Яагаад ч шүү! гэж Рон өөрийн талдаа хатуу зогслоо.

- Сайн байна! Тэгвэл нүцгэн яв. Харри түүнийг тийм байдалтай байхад зургийг нь дараарай. Инээх юмтай болвол сайн хэрэг гэж хатагтай Уизлигийн тэвчээр алдагдав.

Ингэж хэлээд тэрбээр хаалга чанга хаалаа. Тэдний ард хачин чимээ сонсогдов. Гахай уулийн том жигнэмэгт хахаж байлаа.

- Яагаад надад дандаа хоёрдугаар зэрэглэлийнх ногддог юм бол? гэж Рон Гахай руу алхангаа хорсолтой хэлэв.

БҮЛЭГ 11: ХОГВАРТС ЭКСПРЕСС

Маргааш өглөө нь сэрэхдээ Харри зуны амралт дууссаны гунигтай уур амьсгалыг мэдэрчээ. Аадар бороо цонх балбасан хэвээр. Дөрвүүлээ босож хувцаслан жинсэн өмд, ноосон цамц өмсөв. Сургуулийн дүрэмт хувцсаа Хогвартс Экспресс галт тэргэнд өмсөх юм. Ингээд ундаа уухаар буулаа.

Хоёр дугаар давхарын талбай дээр хатагтай Уизлигийн түгшсэн хоолой хадсанаа даруй нэг дүгээр давхар руу шилжив.

- Артур! Артур! Ид шидийн яамнаас яаралтай мэдэгдэл иржээ! гэж тэр шат руу толгойгоо цухуйлган хашгирав.

Ноён Уизли жанчаа углах зуур модон шат тачигнуулан доошоо уруудахад Харри хананд яаран наалдлаа. Андууд араас нь буув. Гал зууханд гэрийн эзэгтэй сэтгэл зовсон янзтай шүүгээ онгичих зуур <<Надад хаа нэгтээ үзэг байсан даа>> гэж хэллээ. Харин ноён Уизли гал руу бөхийн хэн нэгэнтэй ярилцах аж... Харри буруу харчихаагүй байгаа даа гэж нүдээ аниад ахин нээн харлаа.

Амос Диггорийн толгой зуухны голд сахалтай том өндөг адил лугаа байж байв. Толгой ямар нэгэн юм түргэн хэлэхэд дөл чихийг нь долоож оч үсчиж байлаа.

- Хөрш маглууд цохилт болон чанга хашгирахыг сонсоод цагдаа дуудсан байна... Артур чи тэнд түргэн очих ёстой... гэх нь сонсогдов.

- Май! гээд хатагтай Уизли нөхөр рүүгээ гүйж очоод хуудас цаас, бэх, галууны өдөн үзэг гарт нь бариулав.

- Аз болоход би энэ тухай сонссон нь яамай даа. Өрөөндөө түрүүлж очоод ид шидийг хортойгоор ашиглах хэлтсийнхэнд хэдэн ууль илгээх хэрэгтэй юм байна. Хэрвээ энэ тухай Рита Скитер үнэрлэвэл, Артур минь... гэж ноён Диггорийн толгой хэлэв.

- Хурц нүдэт энэ тухай юу гэж хэлж байна даа? хэмээн ноён Уизли асуугаад бөхийн саваа онгойлгон үзгээ дүрээд бичиж эхлэв.

Ноён Диггорийн толгойн нүд эргэлдэв.

- Хэн нэгэн түүний хашаа руу орохыг сонссон гэсэн. Түүнийг гэрээсээ гарах үед хогийн савны хажууд отоож байсан гэсэн.

- Хогийн савыг нь яасан гэнээ? хэмээн ноён Уизли яаран бэх үсчүүлэн бичлээ.

- Миний ойлгосноор бол хогийн савнаас чөтгөр шулмын чимээ гарсан юм байна. Цагдаагийнхыг ирэх үед нэг хогийн сав үүд рүү нисчээ.

Ноён Уизли дуу алдан ёолов.

- Хорон санаатан яасан бол?

Ноён Диггорийн нүд ахин эргэлдлээ.

- Артур, чи Хурц нүдэт Грюмыг мэднэ биз дээ. Хэн түүний хаалга руу шөнө очих билээ дээ? Тэнэмэл муур л төмсний хальс эрж хогийн савыг онгичсон байх. Хэрвээ

Хурц нүдэт ид шидийг хортойгоор ашиглах хэлтсийнхний гарт орвол таагүй явдал болно. Үүнд буруутгах зүйл байгаа нь яамай даа. Энэ бол чиний хэрэг. Хогийн сав дэлбэлсний төлөө ямар шийтгэл онооно гэж бодож байна?

- Анхааруулга байхад болно байх. Хурц нүдэт шидэт саваа хэрэглээгүй биз дээ? Хэнийг ч дайраагүй биз дээ? гэж ноён Уизли бичих зуураа хөмсгөө өргөн хэллээ.

- Мэдэхгүй хэдий ч төсөөлж болох юм. Орноосоо үсрэн босоод цонх руугаа шившлэг илгээсэн. Гэхдээ үүнийг санамсаргүй зүйл биш байсан гэж батлах хэрэгтэй.

- Бүгд ойлгомжтой гэж ноён Уизли хэлээд цаасыг халаасандаа хийн гал зуухнаас үсрэх шахам гүйн гарав.

Ноён Диггорийн толгой хатагтай Уизли руу эргэн харав.

- Намайг уучлаарай, Молли минь. Гэхдээ Артур Хурц нүдэтэд тусалж чадах цорын ганц хүн. Тэр өнөөдөр л шинэ ажилдаа орж байгаа. Түүнийг өнгөрсөн шөнө юу хатгасан юм бол... гэж Диггори тийм эрт түгшээсэн хэр нь тайван өнгөөр хэлэв.

- Юуных нь тийм байх вэ дээ, Амос! Чамайг явахаасаа өмнө шарсан талх идэхээс татгалзахгүй байх гэж бодож байна.

Хатагтай Уизли ширээн дээрээс цөцгийн тос түрхсэн талх аваад галын хавчуураар ноён Диггорийн аманд хийв.

- Баярлалаа гэж тэр бувтнаад тасхийн алга боллоо.

Ноён Уизли удалгүй хонгилд Билл, Чарли, Перси болон охидтой салах ёс гүйцэтгэх нь сонсогдов. Таван хормын дараа тэр гал зууханд орж ирэхдээ гарахад бэлэн хувцсаа өмсөөд үсээ самнаж байлаа.

- Би их яарч байна. Сайн суралцаарай, хөвгүүдээ гэж ноён Уизли Харри, Рон болон ихрүүдэд хэлээд жанчаа мөрөндөө углан шилжихэд бэлтгэв.

- Молли чамд хүүхдүүдийг Кингс Кросс буудал руу аваачих хэцүү биш биз дээ?

- Үгүй дээ. Чи Хурц нүдтийн ажлаараа хөөцөлд. Бид чамгүй учраа олно.

Ноён Уизли шилжих агшинд гал зууханд Билл, Чарли хоёр орж ирлээ.

- Хэн нэгэн Хурц нүдтийн талаар юм хэлэв үү? Түүнд ахиад л юм тохиолдоо юу? гэж Билл асуув.

- Шөнө хэн нэгэн түүний байшинд нэвтрэхээр оролджээ гэж хатагтай Уизли хэлэв.

- Хурц нүдэт Грюм уу? Шал дэмий юм... гээд Жорж жимсний чанамал талханд түрхлээ.

- Чиний аав чинь Грюмийн тухайд их өндөр сэтгэгдэлтэй байдаг шүү гэж хатагтай Уизли ширүүхэн хэлэв.

- Тиймээ, аав бас залгуур цуглуулдаг юм чинь. Шувууны өднүүд... гэж Фред хатагтай Уизлиг өрөөнөөс гарахад аяархан хэлэв.

- Грюм цаг үеийнхээ хамгийн агуу шидтэн гэж Билл эсэргүүцэв.

- Хэрвээ андуураагүй бол Дамблдортой эртний андууд байх аа гэж Чарли хэллээ.
- Дамблдорыг бас хэвийн гэж хэлж болохгүй. Тэр агуу хэдий ч нэг л тийм... гэж Фред хэлэв.

- Хурц нүдэт гэдэг чинь хэн юм бэ? гэж Харри асуулаа.

- Тэр одоо тэтгэвэртээ байгаа. Ид шидийн яаманд олон жил ажилласан юм. Аав намайг ажил дээрээ аваачихад би нэг удаа түүнийг харж билээ. Тэр бол мракоборец дундаа... хамгийн шилдэг нь байсан даа... хар шидтэнгүүдийг барьдаг юм. Азкабаны ерөөнүүдийн хагас нь дүүрснийхээ төлөө түүнд талархах ёстой. Тэр тоо тоомшгүй олон дайсантай болохоор... хамгийн гол нь энэ гэр бүлийг тэр барьсан юм... Миний сонссоноор тэр хөгшрөөд паранойтой болсон гэсэн... тэр хэнд ч хэзээ ч итгэдэггүй гэсэн. Эргэн тойронд нь хар шидтэнгүүд үзэгдээд байдаг юм байх гэж Чарли нэмэрлэв.

Билл Чарли хоёр тэднийг Кингс Кросс хүргэж өгөхөөр шийдэв. Перси ажил руугаа явах ёстой болсон учраас гүнзгий өршөөл эрэв.

- Би ийм шалтгааны улмаас цаг зарцуулж чадахгүй нь. Ноён Крауч намайг жинхэнэ ёсоор үнэлж эхлээд байтал...

- Тийм шүү яагаад гэдгийг нь мэдэх үү, Перси. Тэр тун удахгүй чиний нэрийг зөв хэлж сурах болно гэж Жорж буурьтайгаар хэлэв.

Хатагтай Уизли зориглон тосгоны шуудангаас гурван маглын такси дууджээ. Лондонд ямар нэгэн аргаар хүрэх хэрэгтэй байлаа.

Машиныуд төдхөн хүрээд ирэв. Жолооч нар бороон дунд тээшний саваа онгойлгон зургаан хүнд чемодан, хоёр тортой шувуу, нэг уулийг хийлээ.

- Артур яамнаас машин гуйсан. Гэхдээ сул машин байгаагүй л дээ. Минийхээр бол эдгээр жолооч нар их золгүй төрхтэй юм гэж хатагтай Уизли таксинуудыг харан хэллээ.

Харри хатагтай Уизлид маглуудын таксинд уулийн чангаар гуугчих дуу ховорхон сонсогддог гэж хэлсэнгүй. Гахай чих дөжрөм жингэнүүлж байв. Таагүй явдал Фредийн чемоданы таг онгойсны дараа боллоо. Түүнээс доктор Фоейрверкусын цаасан буу нисэн гараад дэлбэрэв. Живоглот айсандаа үсрэн жолоочийн хөлд хумсаа шигтгэхэд цөхрөн орилох дуу хадав. Гэвч эрт орой хэдийд ч таагүй явдал дууслаа. Бүгд машиндаа суугаад Лондон руу хөдлөв.

Аялал тухгүй болов ялангуяа арын суудал дээр шүү дээ. Чемодануудтайгаа хөл тавих зайгүй чихэлдэн сууцгаалаа. Живоглот цаасан бууны дараа шууд тайвширсангүй Харри, Рон, Гермiona гурав Лондон хүрэх замдаа цөөнгүй маажуулав. Усархаг бороог тоолгүйгээр машиныуд Кингс Кросс буудалд хүрэхэд бүгд тайвширав. Тэд голдоо ортол норон байж тэргэнцэртэй чемодануудаа буудлын замаар түрэн явав.

Харри есөн бүхэл дөрөвний гурав дугаар тавцан дээр ирж хэдийн дассан билээ. Зүгээр л хаалтыг нэвтрээд болох нь тэр. Нэг хүндрэлтэй зүйл байдаг нь маглуудын анхаарлыг татахгүй байх явдал юм. Өнөөдөр тэд бүлгээрээ явж байлаа. Харри, Рон,

Гермиона гурав түрүүлж явахдаа Живоглот, Гахай хоёроос болоод илт анзаарагдам байлаа. Тэд ердийнхөөрөө бөхийн хаалтыг даван гарахад... есөн бүхэл дөрөвний гурав дугаар тавцан өмнө нь үзэгдэв.

Хогвартс Экспресс хэмээх гялалзсан улаан буухиа галт тэрэгнээс өтгөн утаа уугихад Ховгварстын сурагчид болон эцэг эхчүүд буудал дээрх хий үзэгдэл адил харлана. Гахай чимээтэй гууглахад хариуд нь олон уульнууд дуугарав. Андууд маань галт тэрэгний төв хэсэгт сул суудал олж аваад чемодан болон торнуудаа оруулж тавин хатагтай Уизли, Билл, Чарли нартай салах ёс гүйцэтгэхээр тавцан руу үсрэн буулаа.

- Магадгүй бид бодсоноос ч эрт уулзах байх гэж Чарли инээмсэглэн хэлээд Жинниг тэвэрлээ.

- Юу гэнээ? хэмээн Фред чих тавив.

- Цаг нь болохоор мэднэ ээ. Намайг ярьсан гэж Персид битгий хэлж үзээрэй дээ. Бүгд <<Ид шидийн яамнаас зарлах хүртэл хаалттай мэдээлэл>> шүү.

- Би энэ жил Хогвартсад байхыг ямар их хүснэ вэ гээд Билл халаасандаа гараа хийж галт тэрэг рүү атаархангуй байртай харав.

- Яагаад? гэж Жорж сонирхлоо нуулгүй асуулаа.

- Та нарын хувьд сонирхолтой жил болно. Тийм зүйлийг нэг нүдээрээ ч болтугай хараад авахыг хүсч байна гэж Билл нүдээ гялалзуулан хэлэв.

- Юу харах гэж? хэмээн Рон асуулаа.

Тэгтэл шүгэл тасхийж хатагтай Уизли тэднийг галт тэрэгний хаалга руу түлхэв.

Бүгд галт тэргэнд орсон хойноо цонх руу очлоо.

- Зочилсонд баярлалаа, хатагтай Уизли гэж Гермиона цонхоор толгойгоо цухуйлган хэлэв.

- Бүх зүйлд чинь баярлалаа, хатагтай Уизли гээд Харри гараа даллав.

- Та нарыг бидэн дээр ирсэнд би ямар их баяртай байна гээч. Бас зул сарын баяраар хүлээнэ шүү. Гэхдээ та нар Хогвартсад үлдэхийг хүсэх байх даа... янз бүрийн шалтгаанаас болоод.

- Ээж ээ! Та нар ямар нэгэн зүйл мэдэж байхад харин бид үгүй! Энэ чинь шударга бус шүү дээ гэж Рон бухимдан дуу алдав.

- Өнөө орой та нар ч бас мэднэ гэж бодож байна. Гайхамшигтай мэдээ! Би тэднийг дүрмээ өөрчилсөн явдалд баяртай байна... гэж хатагтай Уизли инээмсэглэн хэлэв.

- Ямар дүрэм? гэж бүгд нэгэн зэрэг орилолдов.

- Профессор Дамблдор та нарт удахгүй бүгдийг тайлбарлана... Тэгээд томоотой байгаарай даа. Ялангуяа Фред, Жорж хоёрт хэлж байна шүү!

Галт тэрэгний бүлүүр исгэрснээ дугуй нь хөдөлж эхлэн удалгүй хурдаа авлаа.

- Хогвартет юу болохыг бидэнд хэлээч! Ямар дүрэм өөрчилсөн юм бэ? гэж Фред цонхоор хатагтай Уизли, Билл, Чарли нар луу орилов.

Гэвч хатагтай Уизли зөвхөн инээмсэглэн гар даллаж галт тэрэг далд орохоос өмнө гурвуул шилжин алга боллоо.

Харри, Рон, Гермиона гурав тасалгаандаа эргэж ирэв. Борооны дусал цонх даган урсаж юу ч харагдах боломжгүй байлаа. Рон чемоданаа онгойлгон ёслолын хувцсаа аваад Гахайн торон дээгүүр бүтээж чимээг нь намсгав.

- Энэ чинь одоо юу гэсэн үг вэ. Бэгмен Хогвартсад юу болох тухай хэлэхийг хүссэн шүү дээ. Дэлхийн цомын тэмцээний үеэр санаж байна уу? Гэтэл төрсөн ээж минь чимээгүй байдаг! Сонирхолтой юм... гэж Рон Харрийн дэргэд суунгаа хэллээ.

- Чш-ш! гэж Гермиона хуруугаа уруулдаа хүргээд зэргэлдээх тасалгаа рүү заав. Харри, Рон хоёр онгорхой хаалгаар танил сунжирсан хоолойгоо олж сонслоо.

- Аав минь намайг Хогвартсад биш Дурмстрангад сургахыг хүссэн юм. Тэр захиралтай нь эртний танил юм. Та нар Дамблдорыг эрлийзүүдэд яаж ханддагыг мэднэ шүү дээ. Дурмстрангад тийм нийгмийн шааруудыг хүлээн зөвшөөрдөггүй юм. Гэхдээ ээж намайг хол явуулахыг хүсээгүй л дээ. Аав хэлэхдээ Дурмстрангад хар урлагын талаар илүү ухаалаг ханддаг гэж хэлсэн. Тэндхийн сурагчидын заавал судлах ёстой хичээлд орохоос биш түүнээс хамгаалах ч мэтийн дэмий зүйлээр оролддоггүй...

Гермиона босоод өлмий дээрээ гэтэн хаалга хаалаа.

- Тэгэхээр тэр Дурмстранг руу явсан нь дээр гэж боддог юм байна! Эцэг нь явуулаагүй нь харамсалтай! гэж тэр уурсан хэлэв.

- Дурмстранг гэж бас ахиад нэг ид шидийн сургууль уу? хэмээн Харри сонирхлоо.

- Тиймээ. Гэхдээ муу нэртэй. Хэрвээ <<Европын ид шидийн сургуулиудын тойм>>-д итгэх юм бол тэндхийн гол хичээл нь хар урлаг судлах гэсэн.

- Би ч гэсэн түүний тухай сонсож байсан юм байна. Тэр хаана байдаг билээ? Ямар оронд байдаг юм бол? гэж Рон итгэлгүйхэн хэлэв.

- Үүнийг хэн ч мэдэхгүй гээд Гермиона хөмсгөө өргөлөө.

- Яагаад? гэж Харри асуув.

- Уламжлал ёсоор ид шидийн сургуулиудын хооронд өрсөлдөөн байдаг юм. Дурмстранг болон Шармбатон тэдний нууцыг мэдэхээргүй газарт байдаг гэж Гермиона багшийн өнгөөр хэлэв.

- Больж үз дээ! Энэ Дурмстранг Хогвартсын адил хэмжээтэй байх. Тийм том шилтгээнийг яаж нуух юм бэ? гээд Рон инээд алдав.

- Гэхдээ Хогвартс нууц байдаг биз дээ. Үүнийг <<Хогвартсын түүх>>-ийг уншсан бүх хүн мэднэ хэмээн Гермиона гайхжээ.

- Товчхондоо гэвэл чи л мэднэ. Гэхдээ Хогвартс шиг том шилтгээнийг яаж нуудаг юм бол?

- Илбээдэг юм. Маглууд шилтгээнийг биш нурж унасан эртний балгасыг л олж харна. Үүдэн дээр нь <<ОРЖ БОЛОХГҮЙ. АЮУЛТАЙ БҮС>> гэсэн тэмдэг хатгасан байдаг юм.

- Дурмстранг бас балгас шиг харагддаг байх даа?

- Магадгүй л юм гээд Гермiona мөрөө хавчив.

- Эсвэл Дэлхийн цомын цэнгэлдэх хүрээлэн шиг магл түлхэгч шидээр хамгаалагдсан байх. Хэрвээ шилтгээнийг гадаадын шидтэнгүүд олж чадахгүй байвал тусгай шид хэрэглэнэ.

- Энэ юу болохыг тайлбарлаач гэж Харри гуйлаа.

- Илбээдүүлсэн газрыг нэг ч газрын зурагнаас олж чадахгүй.

- Ойлгомжтой гээд Харри толгой дохилоо.

- Гэхдээ Дурмстранг алс холын хойд зүгт байдаг байх. Тэнд их хүйтэн болохоор дүрэмт хувцас нь үстэй дээл байдаг юм гээд Гермiona хөмсгөө өргөлөө.

- Алдаж болохооргүй боломж байна! Малфойг мөсөн гол руу түлхээд золгүй тохиолдол байсан гэж хэлж болно шүү дээ. Тэр ээжийн хүү болохоор харамсалтай л байна гэж Рон мөрөөдөнгүй хэлэв.

Галт тэрэг хойд зүг рүү алслан холдох тусам бороо улам хүчтэй шаагиж байлаа. Тэнгэр хар үүлэнд бүрхэгдэн цонх бүүдийж галт тэргэнд өдөр дунд чийдэн асчээ. Хонгилоор хоолны тэрэг түжигнэн явах чимээ гарахад Харри бүгдэд тогоон бялуу авлаа. Дараа нь Симус Финниган, Дин Томас болон эмээ дээрээ өссөн дугуй царайтай будлиу хүү болох Невилл Долгопупс нар орж ирэв. Симусын жанчандаа ирландын бэлэг тэмдгээ зүүсэн хэвээр хэдий ч шид нь мэдэгдэм суларчээ. <<Трой! Маллет! Моран>> гэж тэмдэг сулхан хашгирав. Гермiona хагас цагийн дараа квиддичийн тухай сонсохоо болиод буланд суун дөрөвдүгээр дамжааны <<Ид шидийн сурах бичиг>>-ээ дэлгэв.

Хөөрхий Невилл найзууд нь шигшээ тэмцээний тухай хөөрөн ярилцахыг атаархангуй сонслоо.

- Эмээ явахыг хүсээгүй. Тасалбар ч аваагүй. Харин тэнд ямар гайхамшигтай байсан хэрэг вэ! гэж гомдонгуй хэллээ.

- Үнэхээр гайхамшигтай! Үүнийг хар даа, Невилл...

Рон тээшийн саван дээр хэвтэж байгаа чемодан дотроосоо Виктор Крамын жижигхэн дүрсийг гаргаж ирлээ.

- Хөөх! гэж Невилл Рон түүний булцгар алган дээр Крамыг тавихад бахдав.

- Би түүнийг чам шиг л ийм ойроос харсан. Бид нар хамгийн дээд талын суудалд сууж байсан юм...

- Амьдралдаа анх удаа болон сүүлчийн удаа, Уизли минь.

Өрөөний үүдэнд Драко Малфой зогсож байлаа. Түүний ард Крэбб, Гойл хоёрын өсгөлүүн том бие үзэгдэнэ. Хоёулаа энэ зун их өсчээ. Тэд Дин, Симус хоёр гарахдаа хаалга хаагаагүй болохоор бүгдийг сонссон байлаа.

- Бид чамайг уриагүй байх аа, Малфой гэж Харри хүйтнээр хэлэв.

- Уизли... энэ чинь одоо юу вэ? гэж Малфой асуугаад тор бүтээсэн ёслолын хувцсыг заав. Роны жанчны ханцуй галт тэрэгний хөдөлгөөнд унжсан учир хуучин шаргал эмжээр нь тод харагдана.

Рон шүүрч аваад далд хийхийг хичээсэн ч Малфой түүнээс хурдан байлаа. Тэр ханцуйнаас нь шүүрэн авав.

- Үүнийг хар даа! Уизли чи үүнийг өмсөх гэж байгаа юм уу? Энэ чинь мянга найман зуун оноос хойш загвараас хасагдсан эд байна шүү дээ гээд тэр Крэбб, Гойл хоёрын өмнө жанчыг сэгсэчлээ.

- Чамд хамаагүй, Малфой! гээд Рон жанчтайгаа адил улайн Малфойн гараас суга татаж авлаа. Малфой шоолонгуй инээхэд Крэбб, Гойл хоёр тэнэг юм шиг хөхрөлдөв.

- Чи... оролцохыг хүсэж байгаа байх даа, Уизли? Гэр бүлдээ жаахан ч гэсэн алдар гавъяа авчирахыг хүсэхгүй байна уу? Ялсан хүн багагүй мөнгө авна шүү дээ... Чи түүгээр олигтой ёслолын хувцас авч болох юм...

- Чи юуны тухай яриад байна? гэж Рон уурслаа.

- Чи оролцохыг хүсэж байгаа биз дээ! Магадгүй, Поттер ч гэсэн хүсэж байгаа байх, тийм үү? Чи хэзээ ч ийм боломжыг алдахгүй биз дээ?

- Малфой, нэг бол тайлбарла эсвэл эндээс зайл гэж Гермiona <<Ид шидийн сурах бичгээс>> харц холдуулалгүй хэлэв.

Малфойгийн цонхигор нүүрэн дэх инээмсэглэл алга боллоо.

- Тэгэхээр та нар юу ч мэдэхгүй юм байна! Чиний эцэг болон ах чинь ид шидийн яаманд ажилладаг байхад юу ч сонсоогүй байна гэнэ ээ? Бурхан минь, миний эцэг энэ тухай зуун жилийн өмнө мэдсэн!... Корнелиус Фажаас сонссон юм. Тэр ид шидийн яамны чухал түшмэлүүдтэй нөхөрлөдөг юм. Магадгүй аав чинь энэ тухай мэдэхэд бага тушаалынх байх, Уизли. Тэд түүнд ийм чухал мэдээллийг хэлээгүй байж таарна гэж Малфой хөөрөн хэлэв.

Малфой үхтлээ инээсээр Крэбб, Гойл хоёрт толгой дохин гурвуул гарч одов. Рон үсрэн босоод хөлөөрөө хаалга ууртай саван хаахад шил нь хагарав.

- Рон! гэж Гермiona зэмлэнгүй хэлээд саваагаа өргөн <<Репаро!>> гэж хэлэн шилний өөдөснүүдийг буцаан эвлүүлэв.

- За яахав. Тэр бүгдийг мэддэг байхад бид үгүй юм гэнэ... Аав нь яамны том түшмэлүүдтэй нөхөрлөдөг юм гэнэ... Миний эцэг ч гэсэн тушаал дэвшиж болох байсан. Гэхдээ тэр энэ ажилдаа их дуртай...

- Мэдээж тэгэх байсан. Рон Малфойгийн ярьж байгаа зүйлийг хэзээ ч зүрхэндээ ойрхон хүлээн бүү ав гэж Гермiona тайван хэлэв.

- Түүнийг үү! Би авсан гэж үү! хэмээн Рон тогоон хэлбэртэй бялуу авч няц шахав.

Замын төгсгөлд Роны сэтгэл санаа хамгийн тааруу үедээ хүрлээ. <<Хогвартс Экспресс>> удааширсаар Хогсмидын харанхуй буудал дээр зогсоход тэр нэг ч үг хэлэлгүй сургуулийн дүрэмт хувцсаа өмсөөд инээмсэглэсэн ч үгүй.

Галт тэрэгний үүд нээгдэх агшинд аянгын дуу нүргэлэв. Гермиона Живоглотыг жанчиндаа хучихад, Рон ёслолын хувцсаараа Гахайгын торыг бүтээв. Тэд бороон дунд галт тэрэгнээс гаран анивчин бөхийн гүйлдлээ. Хүйтэн бороо толгой дээрээс нь хувингаар цутгаж байгаа аятай орж байлаа.

- Хөөе, Хагрид! гэж Харри тавцангын нөгөө өнцөгт байгаа аварга биетийн дүрс рүү хашгирав.

- Сайн уу, Харри? Цайллага дээр... уулзацгаая... хэрвээ бид живчихгүй бол! гэж Хагрид хариу хэлээд гар даллав.

Хагрид уламжлал ёсоороо нэгдүгээр дамжааныхныг шилтгээн руу нууран дээгүүр авч явах гэж байлаа.

- Ийм цаг агаартай үед нууран дээр хөвнө гэж бодохоос ч аймшигтай юм хэмээн Гермиона хэлээд андууд хамтдаа чичирсээр харанхуй тавцангаас гарлаа. Тавцангын гадаа зуугаад өөрөө явдаг сүйх тэрэг хүлээж байв. Харри, Рон, Гермиона, Невилл нар тэдний нэгэнд суулаа. Хаалга чахран хаагдахад хэдэн хормын дараа сүйх тэрэг хазайн гуйвалсаар шавар шавхай үсчүүлэн Хогвартс орох замаар хатируулав.

БҮЛЭГ 12: ГУРВАН ШИДТЭНИЙ ТЭМЦЭЭН

Хүчтэй салхинд сүйх тэрэг хазайсаар хоёр жигүүртээ далавчтай гахайн хөшөө бүхий хаалгаар орж толгодын дээгүүрх урт замаар давхиуллаа. Харри цонхоор ойртон ирэх Хогвартсын цамхагыг харж байлаа. Ихэнхи цонхонд нь гэрэл асаж хөшиглөсөн бороон дунд бүүдгэртэн гялалзана. Сүйх тэрэг чулуун шат бүхий аварга том царсан хаалгатай үүдний өмнө зогсов. Тэднийг сүйх тэрэгнээс үсрэн гарах агшинд тэнгэрт аянгын дуу нүргэлэхэд андууд шилтгээний бамбараар гийгүүлэгдсэн гантиг шаттай танхим руу аврагдах найдлагатай ухасхийлээ.

- Ёстой аадар байна даа! Хэрвээ зогсохгүй бол нуур эргээсээ халина даа. Би нэвт норчихлоо. Чөтгөр гэж! хэмээн Рон нойтон толгойгоо сэгсрэхэд усны дуслууд зүг бүр тийш үсчив.

Дүүрэн хүйтэн устай бөмбөлөг түүний толгой дээр уналаа. Шалба норсон Рон ямар нэгэн юм хашгираад Харригийн хажуу руу нударлаа. Тэгтэл хоёр дахь устай бөмбөг Гермionaг арай онолгүй Харригийн хөлд унаж оймс нэвт норгочихлоо. Танхимд байгсад хашгиран түлхэлдэж галын бүсээс гарахыг хичээв. Харри толгойгоо өргөөд долоон метрийн өндөрт хий үзэгдэл Пивз хонхтой бүрх малгай өмсөөд, шаргал өнгийн эрвээхэй зангиа зүүж, гартаа бөмбөлөг бариад хорон санаатай нүүрээ мурийлган дараагийн золиос руугаа чиглүүлж байхыг харлаа.

- ПИВЗ! Пивз, эндээс одоохон яв! гэх ууртай хоолой сонсогдов.

Гриффиндор факультетын эрхлэгч сургуулийн орлогч захирал профессор МакГонагалл Их танхимаас гарч ирэхдээ усанд хальтираад унах шахан Гермionaгийн мөрнөөс шүүрч авлаа.

- Өршөөгөөрэй, хатагтай Грэйнджер.

- Зүгээр дээ, профессор гэж Гермiona мөрөө үрэн хэлэв.

- Пивз, эндээс одоохон яв! гэж профессор МакГонагалл зандраад шовгор оройтой бүрхээ засан дөрвөлжин шилнийхээ цаанаас ууртай харлаа.

- Би юу ч хийгээгүй! Тэд нар бүгд норчихсон байсан шүү дээ. Жаахан л шүршлээ! гээд Пивз ногоон бөмбөлөг танхим руу хашгиралдан ухасхийсэн тавдугаар дамжааны охидын дунд унагаад ахиад нэг бөмбөлөгийг хоёр дугаар дамжааныхны толгой руу чиглүүлэв.

- Би захирлыг дуудлаа! Чамд анхаарууллаа шүү, Пивз! гэж профессор МакГонагалл хилэгнэлээ.

Пивз хэлээ гаргаад сүүлчийн бөмбөгөө гантиг шатан дээр унагаад галзуурсан юм шиг хөхрөв.

- Их танхим руу түргэл! гэж норж бохирдсон сурагчдад профессор МакГонагалл тушаав.

Харри, Рон, Гермона гурав хальтиран түлхэлцсээр танхимын хаалгаар орлоо. Рон явах зуураа ууртай чимээгүй харааж нүүрнээсээ нойтон үсээ холдуулав.

Их танхим баяр ёслолын үеэр үргэлжид байдаг шигээ сүр жавхлантай байлаа. Агаарт хөөрөн буй олон зуун лааны гэрэлд алтан таваг цомууд гялалзана. Дөрвөн урт ширээний ард суугаа сурагчид шуугилдан ярилцана. Сурагчдын урдаас харсан тав дах ширээний ард багш нар сууж байв. Их танхимд хамаагүй дулаахан байлаа. Найзууд Слизерин, Когтевран, Пуффендуй тэнхимийнхэнтэй зөрөлдсөөр ширээндээ хүрч бараг толгойгүй Никийн хажууд суулаа. Сувд лугаа тунгалаг өнгөтэй Ник эргэдэг том зах бүхий баяр ёслолын хувцастайгаа байх агаад толгой нь яльгүй арьснаас торгоостой байлаа.

- Оройн мэнд гэж тэр андуудад инээмсэглэн хэлэв.

- Та хэнд хэлсэн бэ? Тэднийг хуваарилж дуустал өлсөж үхэхгүй гэж найдаж байна хэмээн Харри шаахайныхаа усыг агаарт сэгсрэв.

Нэгдүгээр дамжааныхныг хичээлийн анхны жилд тэнхимүүдэд хуваарилдаг юм. Хачирхалтай тохиолдлоор Харри өөрийнхөөсөө бусад хуваарилалтанд байж үзээгүй учир ёслолыг харахыг хүсч байлаа.

- Хөөе, Харри! гэх догдолсондоо болоод чичирсэн гуравдугаар дамжааны Колин Кривигийн дуу гарав. Тэр Харриг баатар гэж үздэг бөгөөд шүтэн бишрэгч нь билээ.

- Сайн уу Колин гэж Харри болгоомжлон хэллээ. Энэ бахадсан хүндэтгэл түүнд багагүй таагүй зүйл авчирсан юм.

- Харри чи төсөөлөх ч үгүй дээ! Үгүй, Харри таагаад үз дээ! Миний дүү сургуульд элсэж байгаа! Миний дүү Деннис!

- Энэ ч сайн хэрэг байна даа гэж Харри юу хэлэхээ мэдэхгүй бувтнав.

- Тэр их санаа зовж байгаа юм. Би түүнийг Гриффиндорт орох болов уу гэж найдаж байна! Харри аз хүсээд хуруугаараа загалмайлах уу? гээд Колин арай л байрнаасаа үсрэн боссонгүй.

- М-м-м... за тэгнэ гэж Харри толгой дохиод Рон, Гермiona, бараг толгойгүй Ник нар руу эргэн харав.

- Ах дүүс ер нь бол нэг тэнхимд ордог уу? гэж Харри асуув.

Тэр Уизлийн гэр бүлийн тухай хэлсэн юм. Тэдний долоон хүүхэд нь нэг тэнхимд сурдаг билээ.

- Заавал тэгэх албагүй. Парвати Патилын эгч Когтевранд сурдаг шүү дээ. Тэд ихрүүд юм гэж Гермiona эсэргүүцэв.

Харри багш нарын ширээ рүү харахад өнөөдөр олонхи нь хоосон байлаа. Хагрид мэдээж нэгдүгээр дамжааныхныг нууран дээгүүр авч явж байгаа, профессор МакГонагалл үүдний танхимын усыг цэвэрлүүлэхээр явсан биз. Бас нэг хоосон суудал байлаа.

- Хар урлагаас хамгаалах хичээлийн шинэ багш хаа байгаа юм бол? гээд Гермiona мөн адил багш нарын ширээ рүү харав.

Гурван жилийн дараа ахин нэг хамгаалах хичээлийн багш сургуульд хэрэгтэй болжээ. Харри профессор Люпиныг өнгөрсөн жил үлдээгүйд харамсаж суув.

- Магадгүй тэд хэнийг ч олоогүй юм болов уу? гэж Гермiona санаа зовон хэлэв.

Харри ахин нэг удаа профессоруудыг гүйлгэн харахад шинэ царай байсангүй. Шившлэгийн хичээлийн багш жижигхэн биетэй Флитвик сандал дээр өндөр жинтүү тавин суугаад, дэргэд нь малгай дороос нь буурал үс цухуйсан ургамал судлалын багш профессор Стебль одон орон судлалын хичээлийн Синистра багштай хөөрөлдөж байв. Синистрагын нөгөө талд шарангуй царай, унжуу хамар, тослог үстэй Снегг сууж байв. Шидэт уусмалын мэргэжилтэн Снегг Харрийн хамгийн дургүй багш байлаа. Харрийн Снеггийг үзэн ядах нь Снегг Харриг үзэн ядахтай тэнцэнэ. Өнгөрсөн жил Харри Сириусыг уусмалын хичээлийн багшийн урт хамар дороос зугтахад тусалсан юм. Снегг Сириус хоёр сургуулийн үеэс эвлэршгүй дайснууд байсан билээ.

Снеггийн цаана профессор МакГонагаллын суудал байв. Харин дэргэд нь ширээний голд Хогвартс сургуулийн захирал профессор Дамблдор сууж байлаа. Түүний урт мөнгөлөг сахал үс нь лааны гэрэлд гялалзан, од сар хамтгамласан сайхан ногоон жанч өмсчээ. Тэрбээр урт хуруугаараа эрүүгээ тулан адар луу бараан шилнийхээ цаанаас ширтэх аж. Түүний бодол хаа нэгтээ алсад байгаа юм шиг санагдлаа. Харри бас дээшээ харлаа. Шидэт адар тэнгэрийн байдлыг давтдаг билээ. Ийм шуургатай хэзээ ч байсангүй. Түүн дээр бараан үүл хөшиглөн, аянга нижигнэж, цахилгаан цахилж байв.

- Удахгүй хооллох болов уу? Би бүтэн гиппогрифыг идсэн ч чадахаар байна гэж Рон дуу алдав.

Түүний энэ үгийн дараа хоёр далавчтай хаалга нээгдэхэд танхимд нам гүм болов. Профессор МакГонагалл нэг дүгээр дамжааныхны урт жагсаалыг дагуулан орж ирээд багш нарын ширээний урд танхим руу харуулан зогсоов. Хэдийгээр найзуудад хуурай газар үлдээгүй ч гэлээ нэг дүгээр дамжааныхан завин дээр биш усан дотуур хөвсөн юм шиг нэвт норсон байв. Хамгийн жижигхэн хүүгээс бусад нь даарах догдлох хосолсондоо чичирч байлаа. Хүү ер бусын арьсан дээл өмсчээ. Харри Хагридын сохор номингийн арьсан хүрмийг танив. Хүрэм том болохоор тэр үстэй дугуй майханд өлгөгдсөн юм шиг харагдана. Түүний жижигхэн царай захнаас нь цухуйх агаад хөөрсөн янзтай байв. Тэр айсан хүүхдүүдийн дунд байраа эзлээд Колин Кривиг хармагц хоёр эрхий хуруугаа гозойлгон <<Би нууранд унасан!>> гэж хашгирлаа. Хоолойны өнгөнөөс нь үзвэл үүгээр бахархаж байгаа бололтой.

Профессор МакГонагалл нэгдүгээр дамжааныхны өмнө гурван хөлтэй сандал авчирч тавиад түүн дээр үнгэгдсэн бохир шидэт бүрхийг тавив. Нэгдүгээр дамжааныхан түүнээс нүд салгалгүй ширтэв. Тэгтэл малгайн дээр ам гарч ирээд дуулсан нь,

Мянган жилийн өмнө өөр үе байлаа

Би шинэхэн оёод удаагүй байлаа

Тэнд дөрвөн шидтэн байсан юм

Тэдний нэр бүгдэд алдартай
Хойд зүгийн тэгш талын эзэн
Аймшиггүй зоригт Годрик Гриффиндор
Нарны хөндийн шидтэн
Хурц ухаант Кандида Когтевран
Нойрмог хөндийд өссөн
Жижигхэн эелдэг Пенни Пуффендуй
Сэрвээ байцнаас ирсэн
Хэрсүү зальт Салли Слизерин
Тэдний бодол, төлөвлөгөө, мөрөөдөл эцэстээ
Зоригтой төлөвлөгөө хийхэд хүргэсэн юм
Бүх английн авьяаслаг хүүхдүүдийг цуглуулж
Шидтэн болгох зорилготой байсан юм
Хогвартс мянган жилийн өмнө ингэж үүссэн юм
Ингэж Хогвартс сургуулийн түүх эхэлсэн юм
Дөрвөн тэнхимийг үндэслэн байгуулагч бүр
Янз бүрийн давуу чанарыг үнэлдэг байлаа
Гай зовлонгоос айдаггүй хүн Гриффиндорт чухал
Когтевранд ухаалаг хүн чухал
Ажил хөдөлмөрөөс бэрхшээдэггүй хүн Пуффендуйд чухал
Аугаа эрх мэдэлд дуртай нь Слизеринд чухал
Бүгд сайхан болсон ч нэг асуудал зовоож байв
Биднийг үхэхээр сурагчдыг хэн хуваарилах болж байна?
Тэгтэл намайг Гриффиндор санал болгосноор
Миний цаг эхлэн тоглоомд оролцсон юм
Түүнд итгэ бидний сонголт гэж тэр хэлээд
Түүнд цаг хугацаа заналхийлэн үхэхгүй гэсэн юм
Дөрвөн үндэслэн байгуулагч шившлэг хийхэд
Би бараг юу ч мэдрээгүй
Ердөө хоёр удаа саваагаа даллаад
Тэдний ухаан шидэт хүч надад шингэсэн юм
Тэгэхээр чи намайг өмсвөл

Би бүгдийг харна алдах юмгүй

Хөдөлмөрт дуртай, зальтай, ухаалаг, зоригтойг хараад

Би чамайг хаана сурахыг хэлэх болно

Шидэт малгай дуулж дуусахад Их танхим даяар нижигнэтэл алга ташив.

- Биднийг хуваарилагдаж байх үед тэр өөр дуу дуулж байсан шүү дээ гэж Харри алга таших зуураа хэлэв.

- Тэр жил болгон шинэ дуу дуулдаг юм. Хөөрхий малгайд ингэж амьдрах уйтгартай байх даа. Жилдээ ердөө ганц удаа дуу зохиож дуулах ажилтай гэж Рон хэллээ.

Профессор МакГонагалл урт хуйлаастай цаас дэлгэлээ.

- Нэрээ сонсоод урагшаа гарч ирэн малгайг өмсөөд сандал дээр суугаарай. Малгай тэнхимийг нэрлэмэгц явж өөрийнхөө ширээ рүү суугаарай гэж тэр шинэ сурагчдад хандан хэллээ.

- Акерли Стюарт!

Хөлөөсөө толгой хүртлээ чичирсэн жижигхэн хүү шидэт бүрхийг аван заасан ёсоор хийлээ.

- КОГТЕВРАН! гэж малгай зарлав.

Стюарт Акерли малгайг тайлаад Когтевранчуудын ширээ рүү очиход түүнийг алга ташилт угтав. Түүнийг суудалдаа суумагц Когтевраны баригч Чжоу ямар нэг юм хэлэв. Тэгтэл Харри гэнэтхэн тэдний ширээнд суухыг маш их хүслээ.

- Бэддок Малкольм!

- СЛИЗЕРИН!

Заалны нөгөө өнцгийн ширээнд орилон шуугилдав. Харри Малфой алгаа ташиж байхыг хараад Бэддокыг Слизерины тэнхим хар шидтэн болгож хувиргах болов уу гэж бодлоо. Фред, Жорж хоёр тэсэлгүй шүгэлдэв.

- Брэнстоун Элеонора!

- ПУФФЕНДУЙ!

- Колдуэл Оуэн!

- ПУФФЕНДУЙ!

- Криви Деннис!

Жижигхэн Деннис Криви Хагридын хүрэмд тээгэлдсээр урагшлав. Тэгтэл Хагрид Их танхимд орж ирээд багш нарын ширээнд ажиглагдамгүй суулаа. Ердийн хүнээс гурав дахин бүдүүн Хагридын урт хар ширэлдсэн сахал анх удаагаа уулзсан хүнд аймшигтай сэтгэгдэл төрүүлэх хэдий ч андуудад хичнээн сайхан сэтгэлтэй нь илхэн байлаа. Ойн сахиул андууд руу нүд ирмээд Деннис Криви шидэт бүрхийг өмсөхийг харав. Малгайн ам нээгдэн,

- ГРИФФИНДОР! гэж зарлав.

Хагрид Гриффиндорынхны хамт алга ташихад Деннис баяртай инээмсэглэн малгайг сандал дээр буцаан тавиад ах руугаа яарлаа.

- Колин би усанд унасан. Ямар гайхамшигтай байсан гээч! Намайг хэн нэгэн завин дээр буцааж гаргасан! гэж тэр ахынхаа хажуугийн суудалд суугаад нарийхан хоолойгоор хашгирав.

- Янзтай! Магадгүй аварга том арваалж аварсан байх! гэж Колин бахдав.

- Хөөх! гэж Деннис дуу алдав.

Ах дүүсийн хамгийн зоригтой мөрөөдөл нь шуургатай үед нууранд унахад нуурын мангас аварсанд талархах бололтой.

- Деннис! Деннис! Тэр хүүг харж байна уу? Хар үстэй нүдний шилтэй! Чи түүнийг харав уу? Хэн гэдгийг нь мэдэх үү, Деннис?

Харри яаран Эмма Доббсын толгойд байгаа малгай руу харав. Хуваарилалт үргэлжилэн айсан шинжтэй хөвгүүд охид нэг нэгнийхээ араас гурван хөлтэй сандал дээр суун өмсөж үзсээр байлаа. Дараалал алгуур урагшлан профессор МакГонагалл дөнгөж <<М>> үсгэнд хүрээд байв.

- Түргэлээсэй. Би яг өлсөж үхэх нь гэж Рон хэлээд гэдсээ илэв.

- Хуваарилалт бол хоолноос чухал шүү дээ, Рон гэж бараг толгойгүй Ник хэллээ.

Малгай энэ үед Пуффендуй тэнхимд Лора Мэдлиг хуваарилж байв.

- Үхсэн хүмүүст мэдээж шүү дээ гэж Рон унтууцав.

- Энэ жил биднийг баярлуулна гэж найдаж байна шүү. Уламжлал ёсоор манай ялалтаар дуусах байх гэж бараг толгойгүй Ник Роны үгийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлээд Натали Макдональд Гриффиндорын ширээнд суухад хэлэв.

Гриффиндорынхон гурван жил дараалан тэнхим хоорондын тэмцээнд түрүүлсэн билээ.

- Причард Грэхэм!

- СЛИЗЕРИН!

- Квирк Орла!

- КОГТЕВРАН!

Эцэст нь <<Уитби Кевин!>> Пуффендуйд орлоо. Түүгээр хуваарилалт дууслаа. Профессор МакГонагалл малгайг сандлын хамтаар гаргав.

- Ашгүй боллоо гэж Рон хэлээд хутга сэрээгээ авч тэвчээргүйхэн алтан таваг руу ширтлээ.

Профессор Дамблдор сурагчид руу баясаж инээмсэглэн нөхөрсгөөр гар даллаад суудлаасаа босов.

- Та нарт зөвхөн ганц үг хэлье. Идэцгээ! гэх түүний хоолой танхим даяар цуурайтав.

- Ура! гэж Рон, Харри хоёр хашгирлаа. Тэдний урдах ширээ нүд ирмэх зуур хоол ундаар дүүрэв.

Бараг толгойгүй Ник Харри, Рон, Гермiona гурав тавган дээрээ хоол овоолж байхыг гунигтай харцаар ширтэнэ.

- Ямар амштай юм бэ! гэж Рон ам дүүрэн төмсний нухаш чихэн дуугарлаа.

- Та нарын аз болоход цайллага хоцорсон ч гэсэн эхэллээ. Өнөөдөр гал зууханд юу болсныг мэдэх үү гэж бараг толгойгүй Ник яриагаа үргэлжлүүлэв.

- Шу болсон юм бэ? гэж Харри аман дахь махаа арайхийн залгиад сониучирхав.

- Дүрсгүй Пивз! гээд Ник толгойгоо сэгсэрэхэд маш аюултайгаар дайвалзав. Тэрбээр өргөн захаа түлхэн толгойгоо тэгшилээд,

- Пивз цайллаганд оролцохыг хүсчээ. Энэ мэдээж боломжгүй л дээ. Та нар түүнийг тавган дээрх хоол тайван харахааргүй бүдүүлэг амьтан гэдгийг мэднэ дээ. Заавал хөмрөнө. Хий үзэгдлүүдийн зөвлөлөөс бүдүүн Номлогч Пивзэд боломж олгохыг гуйсан. Миний бодлоор Цуст барон шийдэмгий эсрэг байсан нь зөв хэрэг болсон.

Цуст барон бол Слизерин тэнхимийн хий үзэгдэл бөгөөд эцэнхий царайтай хөлөөсөө толгой хүртлээ мөнгөлөг цусан толбонд хучигдсан чимээгүй хий үзэгдэл юм. Тэр Пивзийн жинхэнээсээ айдаг ганц зүйл билээ.

- Бид Пивз хэн нэгнийг их гомдоосон гэж ойлголоо. Тэгээд тэр гал тогоонд юу бусниулаа вэ? гэж Рон үүдний танхимд болсон хүйтэн сэтгэгдлээ санаад баргар хэлэв.

- Ердийнхөөрөө бужигнуулсан. Сав суулгуудыг хөмөрсөн. Гал зуухаар нэг шөл асгарч хөөрхий үйлчлэгч нар үхтлээ айсан гээд Ник мөрөө хавчлаа.

Жин! Гермiona алтан цомтой хулууны шүүсээ чанга тавилаа. Нүд гялбам цагаан бүтээлэг том шар толбоор бүрхэгдэв. Гермionад түүнийг ажиглах сөхөө ч байсангүй.

- Энд гэрийн үйлчлэгч нар байдаг хэрэг үү? Хогвартсад уу? гээд Ник рүү мэгдэн харлаа.

- Байлгүй яахав. Английн хамгийн том цугларалт нь байх. Бараг зуугаад гэж бараг толгойгүй Ник түүний байдалд гайхширан хэллээ.

- Би хэзээ ч тэднийг харж байгаагүй шүү дээ!

- Учир нь тэд өдрийн цагаар гал зууханд байдаг юм. Зөвхөн шөнө гарч шилтгээнээр бамбарын гэрэлд тэнүүчилнэ. Та нарт тэднийг харах боломж байхгүй л дээ... Үйлчлэгч нар хүний нүдэнд өртөхгүй. Үл үзэгдэх байх ёстой. Энэ бол сайн зүйлийн шинж тэмдэг. Хүмүүжилтэй үйлчлэгч хэзээ ч энэ дүрмийг зөрчихгүй.

Гермiona түүнийг уурссан харцаар ажиглаад,

- Гэхдээ тэдэнд хөлс төлдөг биз дээ? Тэдэнд амралтын өдөр гэж байдаг болов уу? Өвдвөл эмчлүүлж тэтгэвэрт гардаг болов уу?

Бараг толгойгүй Ник хүчтэй тургилахад том зах руу нь толгой нь унасан ч арьсандаа торгоогдон тогтов.

- Амралт болон тэтгэвэр гэнэ ээ? гэж тэр ахин асуугаад толгойгоо байранд нь тавьж,

- Гэрийн үйлчлэгч нарт ямар ч амралт тэтгэвэр хэрэггүй! гэлээ.

Гермиона тавган дээрх хоол руугаа харснаа холдуулан түлхээд хутга сэрээгээ тавилаа.

- Боль доо, Эмиона гэж Рон хэлэхдээ Харрийн чунз руу шүлсээ үсэргэв.

- Өө... уушлаарай Арри гээд хоолоо залгингаа.

- Гермиона ид л дээ, чи гэрийн үйлчлэгч нар амардаггүйгээс болж өлсөж болохгүй! гэв.

- Боолын хөдөлмөр. Энэ оройн хоол боолын хөдөлмөрөөр бүтсэн байна! гэж Гермиона уурсан хилэгнэлээ.

Тэгээд нэг ч зүсмийг амандаа ойртуулсангүй.

Бороо урьдын адил харанхуй цонх балбана. Ахин нэг удаа аянга нижигнэхэд шуургатай адарт цахилгаан цахин алтлаг тавган дээрээс алга болж буй чунзны үлдэгдлийг гийгүүлэв.

- Бурамтай бялуу, Гермиона! Энд бас үзэмтэй бялуу байна! Шоколадтай бялуу! гээд Рон хоолнуудыг Гермионад үнэртүүлэхээр урдуур нь даллав.

Гермиона түүн рүү профессор МакГонагалл шиг харсанд Рон дуугүй боллоо.

Удалгүй алтан тавагнууд хоосрон гялалзахад Альбус Дамблдор ахиад л суудлаасаа бослоо. Дүнгэнэлдэж буй хоолойнууд нам гүм болж салхи исгэрэн бороо шаагих чимээ чангарав.

- Ингээд найзууд минь, бүгд цадсаныг харж байна гэж Дамблдор инээмсэглэн хэлэв.

Гермиона энэ үгийг таагүйхэн үл тоомсорлов.

- Одоо надад хийх хэдэн мэдэгдэл байна. Сургуулийн харуул ноён Филч надаас та нарт шилтгээний хананд өлгөөтэй байгаа зүйлсийн жагсаалт хориотой гэж мэдэгдэхийг хүссэн юм. Тэнд одоо исгэрдэг йо-ой, соёотой нисдэг таваг, догшин бумеранг нэмэгдсэн. Бүтэн жагсаалт дүүрэн дөрвөн зуун гучин долоон төрлийн тийм зүйлүүд байгаа. Сонирхож байгаа хүн байвал түүнтэй ноён Филчийн өрөөнд очоод танилцах боломжтой гээд инээвхийллээ.

- Хориотой ой сурагчдын хувьд хаалттай гэдгийг сануулахыг хүсч байна. Хогсмид тосгон нэг болон хоёрдугаар дамжааныханд хаалттай. Заавал мэдэгдэх ёстой таагүй мэдээ бол тэнхим хоорондын квиддичийн аварга шалгаруулах тэмцээн энэ жил болохгүй.

- Юу? гээд Харри ихрүүд болон багийнхаа нөхөд рүү харлаа. Тэгтэл унтууцах дуу хадав.

- Учир нь арван сард тэмцээн эхлээд жилийн турш үргэлжлэх болно. Багш нараас ихээхэн хүч хөдөлмөр цаг хугацаа шаардагдана. Гэхдээ бүгдийг тааламжтай байна гэдэгт итгэлтэй байна. Баяр хөөртэйгээр мэдэгдэхэд энэ жил Хогвартсад...

Энэ агшинд цонхны цаана аянга нижигнэхэд Их танхимын хаалга саван нээгдэв.

Үүдэн дээр аян замын урт хар жанчаар хучсан хүн зогсож байв. Бүгдийн толгой үл таних хүн рүү эргэн харахад адарт цахилгааны гэрэл гялсхийв. Үл таних хүн юүдэнгээ буулгаад урт буурал нойтон үсээ сэгсэрч багш нарын ширээ рүү очив.

Түүний хоёр дахь алхам болгоныг модон хөлний бөглүү чимээ дагалдаж байлаа. Тэр багш нарын ширээнд ойртоод баруун талаар нь тойрон Дамблдор руу очлоо. Ахин нэг удаа адарт цахилгаан цахив. Гермiona дуу алдлаа.

Цахилгааны ярсхийсэн гэрэл ирэгчийн царайг тод гийгүүлэв. Тийм нүүр Харри харж байсангүй. Салхи модонд сийлэн үлдээсэн аятай энэ хүний нүүрийг бүдэг цүүцэдсэн юм шиг санагдана. Арьс нь битүү сорвитой байсан бөгөөд ам нь гүнзгий зүсэгдэн, хамарны хэсэг нь үлджээ. Гэхдээ хамгийн аймшигтай нь нүд нь байлаа.

Нэг нь жижигхэн гялалзсан хар өнгөтэй. Нөгөөдөх нь том дугуй хурц цэнхэр өнгөтэй. Энэ цэнхэр нүд тасралтгүй хөдөлж цавчих ч үгүй дээш доош зүг бүр эргэлдэж байв. Дараа нь тэр баруун тийшээ эргэлдэн алга болоход цагаан бүрхэвч үлдэхийг нь харлаа.

Үл таних хүн Дамблдорт нүүрнийхээ адил гэмтсэн сорви бүхий гараа сунгав. Захирал түүнийг бариад аяархан хэдэн үг хэлэхэд Харри сонссонгүй. Тэр ирсэн хүнээс нэг юм асуусан бололтой инээмсэглэлгүй толгой сэгсрээд ямар нэгэн юм аяархан хэллээ. Дамблдор толгой дохиод баруун талын сул суудал дээрээ суухыг урив.

Үл таних хүн суугаад нүүр лүүгээ унасан үсээ сэгсэрч өөртөө тавагтай зайдас ойртуулаад хамарныхаа үлдсэн хэсгээр үнэрлэн халааснаасаа жижиг хутга гаргаж зүсэн идэж эхлэв. Жирийн нүд нь хоолон дээр тусаж байхад цэнхэр нүд нь тасралтгүй эргэлдэн танхим дахь сурагчдыг ажиглаж байлаа.

- Та нарт хар урлагаас хамгаалах хичээлийн шинэ багшийг танилцуулахыг зөвшөөрнө үү. Профессор Грюм гэж Дамблдор сэтгэл хангалуун инээмсэглэн нам гүмийг эвдэн хэлэв.

Ердийнхөөрөө шинэ багш нарыг алга ташилтаар угтдаг байтал энэ удаад Дамблдор, Хагрид хоёроос өөр хэн ч алга ташсангүй. Тэдний алга ташилт чимээгүй танхимд гунигтай дуулдаад удалгүй замхрав. Сурагчид Грюмын ер бусын төрх байдалд гайхсандаа нүд бүлтийлгэн ширтэцгээнэ.

- Грюм гэнээ? Хурц нүдэт Грюм уу? Өглөө танай эцэг чинь туслахаар явсан биз дээ? гэж Харри Ронд шивнэлээ.

- Тийм байх гээд Рон Грюм руу харав.

- Түүнд юу тохиолдоо вэ? Нүүр нь яасан юм бол? гэж Гермiona шивнэлээ.

- Мэ... мэдэхгүй гэж Рон айсан байртай хэлэв.

Хурц нүдэт Грюм хүйтэн хандлагыг хайхрамжгүй хүлээн авлаа. Тэр урдаа байгаа шилэн аягатай хулууны шүүсийг үл тоомсорлон халаасаа ухаж дашмаг гарган балгалаа. Түүний тохой өргөгдөхөд жанч нь дээшилж ширээн дороос модон хөл цухуйхыг Харри харлаа.

Дамблдор Хурц нүдэт Грюм руу чиглэсэн сурагчдын харцыг харж инээмсэглэн хоолой засаад,

- Би энэ жил бидэнд онцгой хүндтэй зүйл болж байгаа хэлсэн билээ. Хогвартсад зуун жил болоогүй сэтгэл хөдлөм үйл явдал болох гэж байна. Та бүхэнд баяртайгаар мэдэгдэхэд Хогвартст энэ жил Гурван шидтэний тэмцээн болно гэв.

- Тоглож байна уу! гэх Фред Уизлигийн чанга дуу гарахад Хурц нүдтийг ирснээс хойш бий болоод байсан хүчилсэн уур амьсгал эвдэгдэв.

Бүгд инээлдэж тэр ч байтугай Дамблдор хүртэл ойлгосон янзтай инээвхийлэв.

- Юуных нь тоглоом байх вэ дээ, ноён Уизли. Хэрвээ тоглож хэлэх юм бол би энэ зун нэг онигоо сонссон юм байна. Савдаг, эмгэн шулмас, лепреккон гурав бааранд ороод...

Профессор МакГонагалл учиртай ханиалгав.

- Э-э-э... дараагийн удаа больё. Би юуны тухай ярьж байлаа даа? Аан тийм, Гурван шидтэний тэмцээн... Бүгд энэ тэмцээний тухай мэдэхгүй гэж бодож байна. Мэдэх нэг нь ахин сонсондоо уучлахыг хүсье.

- Гурван шидтэний тэмцээн бол долоон зуун жилийн өмнөөс үүсэлтэй бөгөөд европын гурван шидэт сургууль болох Хогвартс, Шармбатон, Дурмстрангын хооронд нөхөрсгөөр зохиогдсоор ирсэн юм. Сургууль болгон аваргаа сонгох бөгөөд эдгээр аваргууд гурван ид шидийн сорилтыг туулна. Тэмцээнд тавдугаар дамжаанаас хойшхи сурагчид оролцоно. Энэ бол янз бүрийн үндэстний залуу шидтэнгүүдийг холбон нөхөрлүүлэх хамгийн сайн арга гэдэг нь илэрхий юм. Сүүлчийн тэмцээн олон жилийн өмнө болсон билээ. Тэр үед оролцогчдын дунд амь үрэгдэгсдийн тоо ихэссэн болохоор тэмцээнийг хаах шийдвэр гарсан юм.

- Үхэгсдийн тоо гэнэ ээ? хэмээн Гермiona түгшин хэлэв. Бүгд шивнэлдэн Харри хүртэл тэмцээнд оролцож байсан хүмүүсийн зуун жилийн өмнө болсон азгүй явдлын тухай сонирхлоо.

- Зуун жилийн өмнө хэд хэдэн удаа тэмцээнийг сэргээх оролдлого хийсэн. Гэвч нэг нь ч амжилттай болоогүй. Ингээд олон улсын ид шидийн спорт тоглоомын хамтын ажиллагааны хэлтсээс ахин нэг оролдлого хийх цаг болжээ гэж үзсэн юм. Бид зуны турш энэ удаад оролцогчидод үхлийн аюултай байдал учруулахгүйн тулд шургуу судалсан.

- Арван сард бидэн дээр Шармбатон, Дурмстрангийн захирлууд өрсөлдөгчдийнхөө хамтаар ирэх юм. Гурван аваргыг Хэллоуины баярын өдөр сонгох болно. Шударга шүүгч Гурван шидтэний тэмцээний оролцогчыг сонгох бөгөөд ялагч сургуулийнхаа алдар хүндийн хамтаар мянган галлеон авах юм.

- Би тэмцээнд оролцохыг хүсч байна! гэж Фред Уизли ширээний цаанаас мэдэгдлээ. Түүний хацар алдар гавъяа болон эд баялаг хүлээж байгаа явдалд эргэлзээгүй улайжээ. Тэр Хогвартсын аварга болохыг хүссэн цорын ганц хүн байсангүй. Ширээ болгон дээрх сурагчид Дамблдор руу анхаарал хандуулан ширтэж зэргэлдээх хүмүүстэйгээ шивнэлдэж байлаа.

Бүлэг 13: ХУРЦ НҮДЭТ ГРЮМ

Маргааш өглөө нь шуурга намдаж Их танхимын адарт бүрхэг саарал үүл толгой дээгүүр хөшилдөж байлаа. Харри, Рон, Гермиона гурав өглөөний цайгаа уух зуур шинэ хичээлийн хуваариа судалж байв. Ширээний төгсгөлд Фред, Жорж, Ли Жордан нар Дамблдорыг хэрхэн залилан оролцогчын тоонд багтах талаар толгойгоо гашилгаж байв.

- Өнөөдөр муугүй өдөр бололтой... өглөөний бүх хичээл цэвэр агаарт орох юм байна. Ургамал судлал Пуффендуйнхантай... шидэт амьтны хичээл... чөтгөр гэж ахиад л Слизеринийхэнтэй хэмээн Рон Даваа гаригийн хичээлийн хуваарь дээгүүр хуруугаа гүйлгэн хэлэв.

- Харин хоолны дараа хоёр цаг мэргэ төлгийн хичээл орох юм байна гэж Харри жагсаалтын төгсгөлийг хараад санаа алдан хэлжээ.

Мэргэ төлгийн хичээлийг Харри уусмалын хичээлийн адил тэвчиж чаддаггүй байв. Профессор Трелони түүний үхнэ гэж ямагт зөгнөн хэлдэг билээ.

- Чи над шиг явахаа больчих л доо. Арай илүү ухаалаг юм сонгож ав. Жишээлбэл шидэт тооны ухаан ч юм уу гэж Гермона шийдэмгий зөвлөөд талхан дээрээ тос түрхэж байв.

- Өлсгөлөнгөө зогсоосныг чинь харж байна гэж Рон хэлээд Гермионаг хэрхэн талхан дээр өтгөн тос түрхэж байхыг ажиглав.

- Хөл дээрээ зогсох бол гэрийн үйлчлэгчийг хамгаалах хамгийн сайн зам гэдийг ойлгосон юм гэж Гермиона хэллээ.

- Тийм дээ... чи их өлссөн байна гээд Рон инээд алдав.

Толгой дээгүүр нь далавчны шарчигнах чимээ гарч онгорхой цонхоор өглөөний шуудан болох зуугаас доошгүй ууль нисэн орж ирлээ. Харри зөнгөөрөө дээшээ харсан ч хүрэн бор шувууд дотор ганц ч цагаан толботой байсангүй. Уулиуд ширээн дээгүүр эргэлдэн хаяглагдсан хүндээ захиа илгээмжийг унагаж байв. Том шар ууль Невилл руу нисэн очиж өвдөг дээр нь хайрцаг унагалаа. Невилл амралтын дараа ирэхдээ юм хумаа дандаа мартана. Танхимын нөгөө өнцөгт Драко Малфойгийн эвэрт ууль эзнийхээ мөрөн дээр буун гэрээс нь долоо хоног болгон илгээдэг амтантай хайрцаг авчирав. Харри сэтгэлээр унахгүйн тулд будаагаа идлээ. Хэдвигт ямар нэгэн юм тохиолдсон болоод Сириус захиа аваагүй байх.

Тэр энэ хөгжилтэй бус бодолтойгоо бороон дундуур гарч гурав дахь хүлэмж рүү очив. Тэнд профессор Стебль өөр ямар ч ургамлыг тэгж нэрлэхээргүй аймшигтай муухай ургамал үзүүллээ. Тэд аварга том нялцгай биет шиг зузаан бөгөөд газраас эгц дээш ургажээ. Ургамал болгон ямар нэгэн шингэнээр дүүрсэн мушгиралдсан хавдартай байлаа.

- Бубонотюберууд! Өнөөдөр бид тэдний идээг шахан цуглуулах болно.

- Юу цуглуулах гэнээ? хэмээн Симус Финниган жигшсэн байртай асуулаа.

- Идээ, Финниган идээ. Их үнэ цэнэтэй зүйл болохоор дуслыг ч асгахгүйг хичээгээрэй дээ. Эдгээр лонхнуудад хийгээрэй. Лууны ширээр хийсэн бээлийгээ өмсвөл идээ нь арсанд аюул учруулж чадахгүй.

Бубонотюберов их таагүй зүйл байсан ч хачирхалтай нь ажил хэрэг амжилттай явагдлаа. Хавдар болгоны идээг шахан өтгөн ногоон шингэн гаргаж авахад шатахуун шиг үнэртэж байв. Сурагчид идээгээ лонхонд нямбайлан хийж эцэст нь хичээл дууслаа.

- Хатагтай Помфри баярлах байх даа. Бубонотюберовын идээ бол нүүр хүзүүнд юм гарахад гайхалтай сайн эмчилгээ болдог юм. Сурагчдын батганаасаа ангижрах гэсэн цөхөрсөн оролдлогыг зогсоох байх хэмээн профессор Стебль сүүлчийн лонхыг аваад инээмсэглэн хэлэв.

- Хөөрхий Элоиза Мжен. Тэр нүүрэн дээрх батгаа шившлэгээр арилгахыг оролдсон юм гэж Пуффендуйн Ханна Эббот аяархан хэлэв.

- Тэнэг охин! Гэхдээ хатагтай Помфри түүний хамрыг байранд нь эргүүлж тавих байх гээд профессор Стебль толгой сэгсрэв.

Шилтгээнд дараагийн хичээл орох хонх дуугарахад ангиуд саллаа. Пуффендуйнхан хувиргалын хичээлд орохоор шилтгээн рүүгээ буцаж харин Гриффиндорынхон чийгтэй нуга дээгүүр Хориотой ойн цоорхойд байрлах Хагридын овоохой руу явлаа.

Хагрид овоохойнхоо гадаа зогсоод том биетэй чоноч нохой Соёотынхоо хүзүүвчнээс барьж байв. Түүний өмнө хэд хэдэн онгорхой хайрцаг байх агаад Соёот гаслан хүзүүвчнээсээ мултрахыг хичээх нь доторх зүйлтэй танилцахыг хүссэн мэт. Ойртож очих үед хачирхалтай таржигнасан чимээ шуугиан гараад сулхан дэлбэрэлт сонсогдов.

- Сайн уу! Слизеринийхнийг хүлээж байна. Тэд үүнд баярлах байх. Надад соплохвост байна гэж Хагрид тэр гурвыг хараад инээмсэглэн хэлэв.

- Ахиад л уу? гэж Рон асуулаа.

Хагрид хариуд нь хайрцаг руу заав.

- Пүү! гээд Лаванда Браун үсрэн ухрав.

Энэ дуу Харриг хайрцагт байгаа амьтныг харахад хүргэлээ. Тэд хавчуургүй болохоос хавчтай адилхан гаж төрхтэй агаад салсархаг арван таван см урт биетэй, хөл нь хаа нэгтээ цухуйж толгой нь хаа байгаа нь мэдэгдэх юмгүй ажээ. Хайрцаг болгонд ойролцоогоор зуугаад байх агаад бие биеэ түлхэн мөлхөж хана мөргөж байв. Тэднээс хамар сэтлэм муудсан загасны үнэр ханхална. Үе үе сүүлнээс нь оч гаран аяархан <<пафф!>> гээд хэдэн инчийн урд бууж байлаа.

- Дөнгөж өндөгнөөс гараад байгаа юм гэж Хагрид бардам хэлээд,

- Та нар чинь яагаа вэ. Тэднийг тэжээх хэрэгтэй гэлээ.

- Үүнийг яагаад тэжээх ёстой юм? гэх Драко Малфойгийн хоолой овоохой руу дөхөн ирж буй Слизеринийхний зүгээс хадав. Крэбб, Гойл хоёр хөхрөлдөв.

Асуулт Хагридыг бодолд оруулав.

- Би тэд ямар хэрэгтэй юм бэ? Ямар ашигтай болж байна? гэж асууж байна хэмээн Малфой тодотгов.

Хагрид бодлогоширон амаа ангайснаа дараа нь,

- Энэ тухай... дараагийн хичээл дээр үзнэ, Малфой. Өнөөдөр та нар зөвхөн... тэжээх хэрэгтэй. Хоол бэлэн байна! Ийм жижигхэн зүйлийг... би өөрөө ч харж байсангүй. Бидэнд шоргоолжны өндөг... мэлхийний элэг... жаахан могой байгаа. Бүгд оролдоод үз дээ гэв.

- Эхлээд идээ одоо энэ заваан юм гэж Симус үглэв.

Зөвхөн Хагридыг хайрласан хайр Харри, Гермиона, Рон гурвыг мэлхийний нойтон элэг авч хайрцаг руу тонгойход хүргэлээ. Харри тэднийг хооллохдоо ам байгаа эсэхэд эргэлзлээ.

- Ёо! Нэг нь намайг түлчихлээ! гэж Дин Томас арваад хормын дараа орилов.

Хагрид туслахаар яаран очив.

- Түүний сүүлнээс гал гарсан гээд Дин Хагридад түлэгдсэн хуруугаа үзүүлэв.

- Тиймээ тэгдэг юм. Энэ тэдний үндсэн хөдөлгөөн байгаа юм гэж Хагрид толгой дохив.

- Ёо! Ёо, Хагрид энэ хурц зүйл чинь юу вэ? гэж Лаванда Браун орь дуу тавив.

- Тэдний зарим нь... хатгууртай. (Лаванда гараа хурдхан буулгав). Тэр нь эр нь байх... Эмэгчингүүд нь гэдсэндээ соруултай. Тэд түүгээрээ цус сордог юм гэж Хагрид санаа алдан тайлбарлав.

- Ойлгомжтой тэгвэл бид тэжээх ямар хэрэгтэй юм бэ. Гэртээ ийм амьтантай болох гэж үү. Шатаах, хатгах эсвэл цус сорно! гэж Малфой егөөдөнгүй хэлэв.

- Тиймээ, тэдэнд таалагдах зүйл бага. Гэхдээ энэ чинь ашиггүй гэсэн үг биш шүү дээ. Лууг аваад үзэхэд түүний цус ховорхон шидийн хүч агуулдаг гэхдээ хэн гэртээ луу тэжээдэг билээ? гэж Гермиона эсэргүүцэв.

Харри, Рон хоёр Хагрид руу инээмсэглэхэд тэр сахал дороо нууцхан инээмсэглэв. Гурван найзууд ойн сахиулын гэртээ луу тэжээх хүслийг сайн мэддэг юм. Урьд нь түүнд Норвегийн бөгтөр Норберт нэртэй луу байлаа. Хагрид мангасын төрлийн амьтангуудын аюултай байх тусам улам дуртай билээ.

- Соплохвостууд үнэн хэрэгтээ жижигхэн амьтан юм гэж Рон нуга дундуур шилтгээн рүү буцахдаа хэлэв.

- Одоохондоо тийм байгаа юм. Гэхдээ Хагрид тэднийг тэжээх юм бол хоёр метрээс багагүй болно гэдгийг мэдэж байна хэмээн Гермиона бухимдангуй дуугарав.

- Шал дэмий юм. Магадгүй тэдний хор тэнгисийн өвчнийг ангаадаг байх гээд Рон нүд ирмэлээ.

- Чи намайг Малфойн амыг хамхиулахын тулд хэлснийг мэдэж байгаа биз дээ, Рон. Гэхдээ ер нь бол түүний зөв л дөө. Тэд биднийг дайраагүй үед бүгдийг нь няц гишгэвэл таарна.

Хоолны дээр андууд чанасан хурганы мах, жигнэсэн төмстэй идлээ. Гермiona түргэн идэж эхэллээ.

- Энэ чинь үйлчлэгчийг хамгаалах шинэ арга уу? гэж Рон гайхсанаа нуулгүй асуув.

- Үгүй. Зүгээр л номын сан руу явах гэж яарч байна хэмээн Гермiona ам дүүрэн хоол чихэнгээ хэлэв.

- Юу гэнээ? Гермoина! Энэ чинь хичээлийн эхний өдөр шүү дээ! Бидэнд юу ч заагаагүй байна! гээд Рон чихэндээ итгэсэнгүй.

Гермiona хариуд нь мөрөө хавчаад гурван өдөр юу ч идээгүй аятай тавагтай хоол руугаа тонгойлоо. Тэгснээ үсрэн босоод <<Оройн хоолон дээр уулзацгаая!>> гээд алга болов.

Хонх дуугарахад Харри, Рон хоёр хойд цамхаг руу зүглэв. Нарийхан эргүүлгэн шатаар хамгийн дээш өгсөн гараад мөнгөн олсон шатны тусламжтай тагтай үүдээр нэвтэрч профессор Трелонигийн өрөө лүү орлоо.

Ханан зууханд гал асаж үргэлж байдаг шигээ бүгчим агаартай байлаа. Цонхны хөшиг хаалттай бөгөөд дугуй өрөөг цацагтай бүтээлэг бүхий ширээн дээр тавьсан олон тооны чийдэнгүүд бүүдгэр улаан өнгөөр гийгүүлнэ. Харри, Рон хоёр сандал дундуур явсаар цонхны хажуугийн жижигхэн дугуй ширээний ард суулаа.

- Өдрийн мэнд гэх профессор Трелонигийн бүүдгэр хоолой Харрийн чихний ард гарахад аймшигтай цочжээ.

Маш туранхай зузаан нүдний шилтэй эмэгтэй түүнийг том нүдээрээ эмгэнэлтэй харлаа. Тэрбээр тоо тоомшгүй олон зүүлт, гинж, бугуйвч зүүсэн байх агаад ханан зуухны гэрэлд нууцлагаар гялтагнана.

- Чамайг ямар нэгэн зүйл зовоож байна, хүү минь. Сүүлчийн удаа намайг билгийн мэлмийгээрээ харах үед чиний эрэлхэг царайд түгшсэн өнгө илэрсэн байсан. Чамайг үндэслэлгүй зүйлд санаа зовж байгааг би хэлэх ёстой. Хүнд цаг ирж байна, маш хүнд шүү... Чамайг айлгахыг хүсэхгүй байгаа ч их ойрхон иржээ. Магадгүй чиний бодсоноос ч ойрхон байж мэдэх юм... гэж тэр гашуудалтай хэллээ.

Түүний хоолой намсан шивнэх адил болов. Рон, Харри хоёр чулуун царай гарган хөшлөө. Профессор Трелони тэдний дэргэдүүр өнгөрөөд зуухны өмнөх байх түшлэгтэй сандалд суулаа. Лаванда Браун, Парвати Патил хоёр түүнд сандлаа ойртуулан бишрэн хүндэтгэсэн харцаар харав.

- Хүүхдүүд минь бидэнд ододыг авч үзэх цаг иржээ. Од гаригсын хөдөлгөөн нууцлаг шинж тэмдэг агуулдаг бөгөөд тэнгэрийн бүжгийг тайлсан хүн л нээж чадна. Од гаригсын цацрагаас хүний хувь заяаг уншиж болно.

Харрийн бодол алсан холдлоо. Анхилуун үнэр түүнийг ямагт нойрмог тэнэг юм шиг болгох бөгөөд манан дундаас профессор Трелонигийн хэлэх зөгнөл хэзээ ч далдын

мэдрэмж төрүүлж байсангүй. Гэхдээ түүний <<Чамайг айлгахыг хүсэхгүй байгаа ч их ойрхон иржээ...>> гэсэн үгийг бодохгүй байж чадсангүй.

Үгүй ээ, Гермионагийн зөв гэж Харри уурсан бодлоо. Профессор Трелони бол үнэндээ хөгшин луйварчин юм. Тэр одоохондоо юунаас ч айхгүй байгаа боловч хэрэв Сириусын талаар бодоод үзвэл... Трелони юу мэдсэн байж болох вэ? Юу ч биш! Тэр эртнээс түүний зөгнөлүүд ердөө тохиолдлын таавар байдаг гэдийг ойлгосон билээ. Зөвхөн нэг нь л хичээлийн жилийн төгсгөлд таарсан хэрэг. Тэгэхэд Трелони ховсдлын байдалд орсон байсан бөгөөд Волан-де-Мортыг эргэж ирнэ гэж хэлсэн юм. Харрид Дамблдор хэлэхдээ жинхэнэ төлөгч хүн л тэгж чадна гэсэн...

- Харри! гээд Рон түүнийг түлхэв.

- Яасан?

Тэр эргэн тойрноо харахад бүгд түүнийг харж байв. Харри мансуурам үнэрт бодолдоо автан бараг зүүрмэглэж байснаа цэхлэн суулаа.

- Би сая хэлэхдээ хүү минь чамайг Санчир гаригийн муу нөлөөлөл дор төрсөн байх гэлээ хэмээн профессор Трелони түүнийг үгийг сонсоогүйд гомдолтой хоолойгоор хэлэв.

- Юуны дор төрсөн гэнэ ээ, уучлаарай? гэж Харри асуулаа.

- Санчир, хүү минь Санчир гариг! гэж профессор Трелони уурсангүй давтсан ч энэ нь Харриг зовоосонгүй.

- Би чиний төрсөн агшин дахь гариг эргэлзээгүй Санчир гэж хэллээ... Хар үс... сулхан бие бялдар... амьдралын замын эхлэлдээ эмгэнэлтэй явдал тохиолдсон... Хэрвээ алдаагүй бол чи өвлийн дунд сард төрсөн байх.

- Үгүй ээ. Би долоон сард төрсөн гэж Харри хэлэв.

Рон инээдээ далдлан ханиалгав.

Хагас цагийн турш одот тэнгэрийн ярвигтай бүдүүвч зураг судлан төрсөн өдрийнхөө гаригуудын байрлалуудыг тогтоов. Цагийн хуваарийн дагуу өнцгийн тооцоо хийх нь уйтгартай ажил байлаа.

- Надад хоёр Далай ван гариг байна. Байж боломгүй юм! гэж Харри баргар царайлан хуудсаа харж хэлэв.

- А-а-ах! Хоёр Далай ван гэдэг чинь, энэ бол чи бяцхан шилтэй төрсний жинхэнэ шинж тэмдэг... гэж Рон профессор Трелонигийн нууцлаг хоолойг дуурайн даажигнан хэллээ.

Симус, Дин хоёр газрын зураг руугаа харан инээд алдахад Лаванда Брауны дуу гарч,

- Профессор хараач! Надад тодорхойгүй гариг байх шиг санагдаж байна! Энэ юу байж болох вэ, профессор? гэлээ.

- Энэ бол Тэнгэрийн ван, хонгор минь гэж профессор Трелони газрын зургийг авч үзээд хэллээ.

- Би Лавандагийн Тэнгэрийн ванг харж болох уу? гэж Рон егөөдөнгүй асуув.

Профессор Треллони азгүйтэхэд түүнийг сонсоод магадгүй энэ шалтгааны улмаас маш их гэрийн даалгавар өглөө.

- Өөрсдийн төрсөн сарын гаригийн хөдөлгөөнийг судалж дүн шинжилгээ хийгээрэй. Даваа гариг гэхэд бэлэн байх ёстой шүү. Ямар ч үг яриа хүлээж авахгүй! гэж тэр ширүүн хэлэхэд дууны өнгөнд нь профессор МакГонагаллын аялга сонсогдов.

- Чөтгөр авсан золгүй хөгшин сарьсан багваахай! Энэ шинжилгээ нь бүх амралтын өдрийг авах нь байна гэж Рон хоолонд орохоор явж байхдаа уурсан хэлэв.

- Их даалгавар өгөө юу? Харин профессор Вектор бидэнд бараг даалгавар өгөөгүй! гэж Гермiona зэрэгцэн ирээд хэлэв.

- Түүний зүгээс их эелдэг хэрэг байна хэмээн Рон бувтналаа.

Их танхимын үүдэнд өлсгөлөн Хогвартсынхан дараалал үүсгэжээ.

Андууд дараалалд нэгдтэл хэн нэгний чанга хоолой,

- Уизли! Хөөе, Уизли! гэх нь сонсогдов.

Малфой хашгирчээ. Тэр ердийнхөөрөө дагалдагч нарынхаа хамтаар ямар нэг зүйлд их баярласан шинжтэй зогсож байлаа.

- Юу хэрэгтэй вэ? гэж Рон огцом асуув.

- Чиний эцэг сонинд гарчээ, Уизли! Сонс гэж Малфой танхимд байгаа хүмүүст сонсуулахын тулд чанга хэлээд <Зөнч>> сонины дугаарыг даллав.

ИД ШИДИЙН ЯАМНЫ ШИНЭ АЛДАА

Ид шидийн яамныхны таагүй сэтгэгдэл дуусахгүй нь бололтой гэж тусгай сурвалжлагч Рита Скитер бичиж байна. Саяхан квиддичийн дэлхийн цомын тэмцээний үеэр хяналтаа алдсан таагүй явдлын тухайд спортын хэлтэсээс тайлбар тавихыг хүсээгүй юм. Тэгтэл үдэш шинэ шуугиан гарлаа. Эгэлчүүдийн бүтээлийг хууль бусаар ашиглахтай тэмцэх хэлтсийн Арнольд Уизли хачирхалтай үйлдэл хийсэн байна.

Малфой дээшээ харлаа.

- Түүний нэр яагаад зөв бичигдээгүй явдлыг төсөөлж байна. Энэ чинь түүнийг шалихгүй амьтан гэсэн үг биз дээ?

Танхимд байсан хүн бүр чих тавьж байв. Малфой сонинг эргүүлээд цааш нь уншив.

Арнольд Уизли хоёр жилийн өмнө машинаа хууль бусаар нисдэг болгосон хэмээн торгуулж байсан юм байна. Өчигдөр журам сахиулдаг маглуудтай (цагдаагийнхан) түрэмгий ааштай хогийн савны төлөө зодоон хийжээ. Ноён Уизли тусламжын гар болон алуурчны гарыг ялгахаа болиод ид шидийн яамнаас тэтгэвэртээ гараад удаагүй байгаа экс маркоберц болох “Хурц нүдэт” Грюмд тусламж үзүүлэхээр яаран ирсэн юм байна! Ноён Грюмын найдвартай хамгаалалттай гэрт ноён Уизли хуурамч түгшүүр өгсөн болохыг илрүүлсэнд гайхах зүйлгүй юм.. Энэ бүхэн ноён Уизли ой

дурсамж өөрчлөх шившлэг хэрэглэсэнээр дууссан байна. Аз болоход тэр маглуудын цагдаагаас нуугдаж чаджээ. Түүний яагаад ид шидийн яамны шинэ шуугианд оролцсон талаарх сурвалжлагчын асуултанд ноён Уизли хариулахаас татгалзсан байна.

- Энд тэдний зураг нь байна, Уизли! Эцэг эх чинь байшингийнхаа өмнө авхуулжээ. Хэрвээ үүнийг байшин гэж дууддаг бол! Чиний ээж чинь жингээ хасах талаар бодож үзсэн үү? гэж Малфой баясан хэлээд сонинг өргөлөө.

Рон галзууртлаа уурлалаа. Түүнийг танхимд байсан бүх хүн харж байв.

- Амаа тат, Малфой! Явъя Рон гэж Харри найзыгаа гараас нь татлаа.

- Өө, би мартсан байна! Поттер чи тэднийд зун зочилсон гэлүү. Түүний ээж нь үнэхээр тийм тарган юм уу эсвэл зурган дээр тэгж гарсан юмуу? гэж Малфой инээсэн хэвээр хэлэв.

- Чи өөрийнхөө ээжийг санасан нь дээр шүү! Тэр үргэлж муухай юм үнэрлэсэн юм шиг ярвайж байдаг. Тийм хамартай хүнээс ийм хүүхэд гарсан гэхэд гайхах юм алга гэж Харри Гермionaгийн хамтаар нударга зангидан зүтгэлэх Роны жанчнаас зуурангаа хэлэв.

Малфойн цонхигор царай үл мэдэг ягаарлаа.

- Миний ээжийг бүү доромжил, Поттер!

- Чи өөрөө эхэлснээрээ амаа хамхи! гээд Харри эргэн явлаа.

ТҮН!

Танхимд байсан охидууд дуу алдав. Цагаан оч чамархайг нь шүргэн өнгөрөхөд Харри халаасан дахь саваа руугаа гараа сунгасан ч амжсангүй. Тэр агшинд ахин нэг удаа ТҮН хийгээд танхим даяар сөөнгө хоолой,

- ЭНЭ ЧИНИЙ ХЭРЭГ БИШ, ЗАЛУУ МИНЬ! гэлээ.

Харри эргэж харав. Гантиг шатан дээрээс профессор Грюм хазганан бууж ирэв. Тэрбээр гартаа шидэт саваа бариад Малфойн зогсож байсан газар дахь өмхий хүрэн рүү чиглүүлж байлаа. Танхимд айдас хүрэм нам гүм болов. Хэн ч хөдөлж зүрхэлсэнгүй. Грюм Харри руу хэвийн нүдээрээ харахад нөгөө шидэт нүд нь арагшаа эргэн харлаа.

- Тэр чамайг дайраа юу?

- Үгүй ээ, оноогүй.

- ТҮҮНИЙГ ОРХИ! гэж Грюм зандрав.

- Хэнийг? гэж Харри гайхан асуулаа.

- Чи бишээ, тэр! гээд Грюм том хуруугаараа шалан дээр байсан өмхий хүрэнг тэвэрч авах гэж байсан Крэббийг заахад айсандаа хөшлөө. Грюмын эргэлддэг нүд шилэн хүзүүгээ нэвт хардаг мэт ажээ.

Грюм хазганасаар Крэбб, Гойл хоёр руу очиход өмхий хүрэн айсандаа часхийгээд газар дорхи хонгил руу ухасхийв.

- Үгүй ээ, чи тийшээ явахгүй... гэж Грюм сөөнгөтөн орилоод ахин шидэт саваагаа чиглүүлэхэд өмхий хүрэн агаарт гурван метрийн өндөрт хөөрөн шал алгадан унаснаа ахин хөөрлөө.

- Би араас дайрдаг хүмүүсийг тэвчиж чаддаггүй юм. Өөдгүй хулчгар новшийн алхам байлаа... гэж Грюм хэлэхэд өмхий хүрэн улам өндөрт цовхчин өвдсөндөө часхийв.

Өмхий хүрэн агаарт шидэгдэхэд сарвуу болон сүүл нь сарвалзана.

- Хэзээ ч-битгий-тэгж-бай гэж Грюм хэлэхэд үг бүрийх нь тоогоор өмхий хүрэн шал цохилон агаарт хөөрлөө.

- Профессор Грюм! гэх уурссан дуу хадав.

Гантиг шалан дээрээс гартаа дүүрэн ном барьсан профессор МакГонагалл бууж ирэв.

- Сайн уу, профессор МакГонагалл гэж Грюм өмхий хүрэнг хөөргөсөн хэвээр тайван хэлэв.

- Юу... Та юу хийж байна? гэж тэр асуугаад агаарт хөөрч буй өмхий хүрэнг дагуулан харав.

- Сургаж байна гэж Грюм хариулав.

- Сургах гэнэ ээ? Грюм энэ чинь сурагч юм уу? гээд МакГонагаллын гараас номнууд нь уналаа.

- Тийм.

- Байж боломгүй юм! гэж профессор дуу алдаад шатны гишгүүр уруудан ухасхийв. Тэрбээр шидэт саваагаа авч хормын дараа чанга тасхийхэд Драко Малфойн толийтол самнагдсан үс нь сэгсийн цайвар царай нь улайн газардав. Тэр хөл дээрээ босоод дальдчив.

- Грюм бид хэзээ ч хувиргалыг шийтгэлд хэрэглэдэггүй! Профессор Дамблдор таньд хэлсэн байх! гэж профессор МакГонагалл ууртай хэлэв.

- Хэлсэн шиг санагдаж байна. Гэхдээ би хурц мэдрэмж саад болохгүй гэж бодож байна... хэмээн Грюм хайхрамжгүй хэлэв.

- Бид хичээлийн дараа үлдээдэг! Эсвэл тэнхимийн эрхлэгчид нь мэдэгддэг.

- Би тэгж хийе гэж Грюм зөвшөөрөв.

Дракогын өнгөгүй нүдэнд өвдсөн болон гутаан доромжлогдсоны нулимс дүүрч Грюм руу харан ууртайгаар эцгийнхээ тухай юм бувтналаа.

- Аавдаа хэлнэ гэнээ? хэмээгээд Грюм хазганан хоёр алхам урагшилахад модон хөл нь танхимын шалан дээр цуурайтав.

- Би чиний эцгийг эртээс сайн мэднэ, залуу минь... Түүнд Грюм хүүг нь харж байгаа гэж хэлэх болно. Дашрамд тэнхимийн эрхлэгч чинь хэн бэ? Снегт үү?

- Тиймээ гэж Малфой дургүйхэн хэлэв.

- Бас нэг хуучин танил маань. Эртнээс хуучин найз Снеггтэйгээ ярилцахыг мөрөөддөг байлаа. Алив явъя... гэж Грюм сөөнгөтөн хэлээд Малфойгийн мөрөн дээр гараараа дарж газар дорхи хонгил руу дагуулан явав.

Профессор МакГонагалл хэдэн хормын турш түүний араас сэтгэл зовонгуй дагуулж харснаа саваагаа даллахад газар унасан номууд гар луу нь нисэн ирлээ.

- Надад юу ч битгий хэл гэж Рон Гриффиндорын ширээнд суухдаа дуугарав. Танхим даяар саяны гэнэтийн үйл явдлыг хөөрөлдөнө.

- Яагаад тэр вэ? гэж Гермиона гайхлаа.

- Яагаад гэвэл энэ үйл явдал ой ухаанд минь үүрд хадгалагдан үлдэх болно. Хөөрхий өмхий хүрэн Драко Малфой үсрэлтийн аврага! гэж Рон хэлээд урамшсан байртай нүдээ анилаа.

Андууд инээлдэхэд Гермиона тавгандаа вандуйтай үхрийн мах хийж авлаа.

- Тэр Малфойг үнэхээр өвтгөсөн дөө. Профессор МакГонагалл цагаа олж түүнийг зогсоолоо.

- Гермиона! Чи миний амьдралын хамгийн сайхан мөчийг гутааж байна! гэж Рон ууртай дуу алдав.

Гермиона тургилаад ахиад хоолоо хурдтай идлээ.

- Хоолны дараа номын санд очно гэж бүү хэлээрэй дээ хэмээн Харри хэлэв.

- Очно. Надад ямар их ажил байгааг гээч!

- Гэхдээ чи профессор Вектор...

- Энэ бол гэрийн даалгавар биш гэж тэр хариулаад таван хормын дотор тавгаа хоослов.

Түүний байранд Фред Уизли суулаа.

- Грюм! Ямар мундаг гээч! гээд Фредийн нүд бахдан дүрэлзэн асав.

- Биширмээр янзтай гэж Жорж мэдэгдээд Фредийн эсрэг талын сандал дээр суулаа.

- Дээд зэргийн гайхамшиг гэж ихрүүдийн найз болох Ли Жордан Жоржын хажууд суунгаа толгой дохиод,

- Өнөөдөр тэр бидэнд хичээл орсон юм гэж Харри, Рон хоёрт тайлбарлав.

- Ямар байна даа? гэж Харри асуулаа.

Фред, Жорж, Ли нар учиртай харц солилцов.

- Тийм хичээл хэзээ ч орж байсангүй гэж Фред хэллээ.

- Энэ хөгшин ч юм мэддэг юм байна шүү гэж Ли нэмэрлэв.

- Юу мэддэг гэж? хэмээн Рон урагшаа бөхийв.

- Өөрийн хийх ёстой ажлаа гэж Жорж сэтгэл хөдөлсөн байртай хэлэв.

- Ямар ажил? гэж Харри ойлгосонгүй асуулаа.
 - Хар урлагтай тэмцэх гэж Фред хэлэв.
 - Тэр хичнээн ихийг барьсан гээч! гэж Жорж толгой дохино.
 - Товчхондоо гайхмшигтай хөгшин байна гэж Ли төгсгөв.
- Рон даруйхан цүнхнээсээ хичээлийн хуваариа гаргаад,
- Бидэнд зөвхөн пүрэв гаригт орох юм байна! гэж урам хугаран хэлжээ.

Бүлэг 14: УУЧЛАШГҮЙ ШИВШЛЭГ

Хэрвээ Невилл зургаа дахь уусмалын тогоогоо хайлуулсныг эс тооцвол онцын зүйл бололгүй хоёр хоног өнгөрөв. Профессор Снегг зуны амралтын дараа ч хонзогносон байх хэвээр агаад Невиллд шийтгэл оноож хичээлийн дараа үлдээсэн бөгөөд тэр торх шиг гэдэстэй эвэртэй бахтай эргэж иржээ.

- Яагаад Снегг ийм муухай ааштай байгаа юм бол? гэж Рон Харригаас асуугаад Гермiona Невиллийн баханд Цэвэрлэх шившлэг хийж гэдэс дотрыг нь цэвэрлэхийг харав.

- Грюмээс болж байгаа юм гэж Харри хэлэв.

Бүгд Снегг эртнээс хар урлагаас хамгаалах хичээлийн багшийн суудлыг эзлэхийг хүсдэг болохыг мэднэ. Ингээд дөрөв дэх жилдээ түүнд энэ байр суурь оногдсонгүй. Снегг өмнөх багш нарыг нь тэвчиж чаддаггүй байсан бөгөөд үүнийгээ ч нуудаггүй байлаа. Гэхдээ Грюмтэй ер бусын болгоомжтой харилцан дайсагнахаас аль болох зугтаж байв. Харри тэдний хамтдаа хоолны ширээнд суух юм уу хонгилд явж байхыг нь харсан бөгөөд Снегг Грюмын ерийн ч тэр шидэт ч тэр нүднээс нь зугтаж байлаа.

- Минийхээр бол тэр Снеггийг айлгадаг байх гэж Харри хэллээ.

Рон мөрөөдөнгүй нүдээ эргэлдүүлээд,

- Грюм түүнийг эвэртэй бах болгон хувиргахад газар дорхи хонгилд бүгдийн нүдэн дээр үсчиж байгаа нь төсөөлөгдөж байна гэв.

Гриффиндорын дөрөвдүгээр дамжааныхан Грюмын эхний хичээлийг тэсэн ядан хүлээж байв. Пүрэв гаригт хоолны дараа тэд хонх дуугараагүй байхад анги руу нь явлаа. Зөвхөн Гермiona л байсангүй. Тэр хичээл эхлэхэд иржээ.

- Би саатчихлаа...

- ...номын санд гэж Харри түүний яриаг дуусгаад,

- Түргэн явж байраа эзэлье гэв.

Тэд яаран багшийн ширээний өмнөх гурван сандлыг эзлэн <<Хар урлагаас өөрийгөө хамгаалах гарын авлага>> номоо дэлгээд хүлээж байхад анги дасал болоогүй нам гүм байлаа. Төдхөн хонгилд модон хөлийн чимээ гарч ангид орж ирэхэд түүний байдал үргэлжид байдаг шигээ хачирхалтай айдас хүрэм байв. Тэд түүний жанчны дороос хумстай модон хөл цухуйхыг харлаа.

- Номнуудаа хурааж болно. Та нарт шаардагдахгүй гэж тэр сөөнгөтөн хэлээд ширээ лүүгээ явлаа.

Хүүхдүүд сурах бичгээ буцааж цүнхлэв. Рон зүүн дээр суусан аятай өндөлзөнө.

Грюм ангийн бүртгэл гаргаад урт буурал үсээ сорвитой нүүрнээсээ сэгсрэн холдуулав. Түүнийг нэр дуудаж байх зуур ердийн нүд нь жагсаалт ширтэн огт хөдлөхгүй байхад шидэт нүд нь хариулж байгаа сурагчдын зүг гүйж байлаа.

- Сайн байна гэж тэр сүүлчийн сурагчтай танилцсаныхаа дараа хэлээд,

- Профессор Люпин надад танай ангийн тухай бичсэн. Та нар боггарт, улаан толгойт, дэнлүүт, гриндилоу, усны чөтгөр болон хүн чонын тухай үзсэн. Би зөв ойлгосон уу? гэв.

Сурагчид зөвшөөрөн дүнгэнэлдлээ.

- Шившлэгийн хувьд та нар хоцорчээ. Маш их хоцорч. Би та нарт шидтэнгүүд хэрхэн бие биеэ хэрхэн хорлодгийг үзүүлэхийг хүсч байна. Миний зорилго бол та нарыг хар хүчний эсрэг тэмцэхэд сургах явдал юм. Надад үүнд жилийн хугацаа байна.

- Зөвхөн жил үү? гэж Рон асуув.

Грюмын шидэт нүд түүний зүг хандахад Рон давхийлээ. Тэр агшинд Грюм энэ бүх хугацаанд анх удаагаа инээмсэглэв. Сорвитой царай нь аймшигтай үрчийлээ. Тэр үргэлж инээж байсан ч элэгсэг мэдрэмж төрүүлэхээргүй ажээ. Гэхдээ юутай ч гэсэн Рон сэтгэл амарлаа.

- Чи Артур Уизлигийн хүү юу? Чиний эцэг хэдэн өдрийн өмнө намайг эвүй байдлаас аварсан... Тиймээ, би энд жил орчим байх болно. Дамблдорын хүсэлтээр. Ердөө жил болоод чимээгүй буцах юм.

Тэр таагүйхэн инээмсэглээд мойног хуруугаа хавсарлаа.

- Ажилдаа орцгооё. Шившлэгүүд. Тэд янз бүрийн утга агуулгатай байдаг. Ид шидийн яамнаас намайг та нарт хараалын эсрэг хэдэн шившлэг сургахыг зөвшөөрсөн. Хууль бус шившлэгүүдтэй та нар танилцах болоогүй. Тэднийг зургадугаар дамжаандаа сурах болно. Та нар бас л эрт байна. Гэхдээ профессор Дамблдор та нарын тэсвэр хатуужилд өндөр сэтгэгдэлтэй байгаа бөгөөд мэдэх хэрэгтэй гэж үзэж байгаа юм. Би ч гэсэн эрт танилцсан нь дээр гэж бодож байна. Яаж өөрийгөө гэнэтийн аюулаас хамгаалах вэ? Хорон санаатан хууль бус шившлэг хийн дайрах болно. Тэр чамтай эелдэг байхгүй. Та нар үүнд бэлтгэх хэрэгтэй. Сэрэмжтэй байх бас ахин сэрэмжтэй байх! Соргог байх хэрэгтэй... Хатагтай Браун намайг ярьж байх үед сонсох хэрэгтэй шүү. Ширээн дорх зүйлээ далд хий.

Лаванда цочоод час улайв. Тэрбээр ширээн доогуур Парватид зурхайгаа үзүүлж байжээ. Тэгэхээр... Грюмын шидэт нүд шилэн хүзүүгээ нэвт хардагын адил мод нэвт хардаг юм байна.

- Та нарын хэн нэг чинь шидтэний хуулиар хориглосон шившлэг мэдэх үү?

Хэдэн хүүхдүүд итгэлгүйхэн гар өргөсний дотор Рон, Гермiona хоёр орлоо. Грюм Ронд толгой дохиж байсан ч шидэт нүд нь Лавандаг ширтэж байлаа.

- Аав хэлэхдээ тэдний нэгийг... Имперуус гэдэг гэсэн.

- Тэгэлгүй яахав. Чи эцэг түүнийг мэдэх ёстой. Тэр ид шидийн яаманд багагүй балаг авчирсан юм шүү гэж Грюм үнэлсэн байртай хэлэв.

Грюм хөл дээрээ хүчлэн босоод ширээний шургуулга онгойлгон шилэн сав гаргаж ирлээ. Дотор нь гурван том хар аалз гүйлдэж байв. Рон сандалтайгаа огло үсрэн цаашлав. Тэр аалзыг үзэн яддаг билээ.

Грюм нэгийг нь барьж алган дээрээ бүгдэд харагдахаар тавиад шидэт саваагаа чиглүүлэн <<Империио!>> гэж хэллээ.

Аалз алган дээрээс үсрэн нарийхан утаснаас зүүгдээд урагш хойш савлав. Хөлөө сунган тэрэгний дугуй шиг хойшоо эргэлээ. Гэнэтхэн аалзны шүлс тасарч ширээн дээр тонгорцоглон уналаа. Грюм саваагаа зангахад хойд хоёр хөлөн дээрээ босоод гарцаагүй бүжиглэв.

Грюмээс бусад бүх хүн инээлдэв.

- Инээдтэй байна уу? Хэрвээ та нарт таалагдаж байгаа бол би та нар дээр үзүүлэх үү? Инээд агшин зуур бөхөв.

- Бүрэн хяналт гэж Грюм аалзыг ширээн дээгүүр бөмбөг болон өнхрөхөд хэллээ.

- Би түүнийг цонхоор үсэргэж чадах ч хэн нэгний ам руу харайлгасан нь дээр гэж бодож байна.

Рон өөрийн эрхгүй чичрэв.

- Дээр үед олон шидтэнгүүдийг энэ шившлэг удирддаг байсан юм. Ид шидийн яамнаас хэн удирдаж байгааг шалган олох хэрэгтэй болсон юм.

Түүний ярьж байгаа өдрүүдийг Харри Волан-де-Мортын хүчтэй байсан үе байх гэж бодов.

- Империиусын эсрэг тэмцэхэд би та нарыг сургах болно. Гэхдээ хатуу араншин шаарддаг болохоор бүгд чадахгүй. Боломжтой бол үүнд өртөхгүй байхыг хичээгээрэй дээ. **ҮРГЭЛЖ СЭРЭМЖТЭЙ БАЙ!** гэж тэр бүх ангийг цочтол хашгирлаа.

Грюм тахиралдсан аалзыг авч шилэн саванд хийв.

- Хэн өөр хууль бус шившлэгийн талаар мэдэх вэ?

Гермиона гараа өргөхөд Харригийн гайхлыг төрүүлэн Невилл хулчгардуухан гараа өргөв. Тэр зөвхөн өөрийн дуртай хичээл болох ургамал судлалын хичээл дээр л хариулдаг байсан юм. Невилл зориглосондоо өөрөө хүртэл гайхаж байх шиг санагдана.

- За? гээд Грюмын шидэт нүд Невиллийн зүг эргэлдэн харав.

- Круциатус гэж Невилл аяархан хэдий ч тод хэллээ.

Грюм түүнийг энэ удаад хоёр нүдээрээ ширтэж харлаа.

- Чамайг Невилл гэдэг байх аа? гэж асуухад шидэт нүд нь бүртгэлийн дэвтрийн зүг тусав.

Невилл догдолсондоо толгой дохисон ч Грюм өөр асуулт тавьсангүй. Тэрбээр шилэн савнаас дараагийн аалзыг гаргаж ирээд ширээн дээрээ тавихад айсандаа хөшлөө.

- Тийм үнэн, Круциатус гэдэг юм. Жаахан томруулсан нь дээр байх гээд тэр саваагаа аалз руу чиглүүлэн,

- Энгоргио! гэв.

Аалз томорч тэмээн аалз адил болов. Рон бүх санаархлаа мартаад сандал налан Грюмын ширээнээс аль болох холдохыг хичээв.

Грюм саваагаа өргөөд,

- Круцио! гэж шивнэлээ.

Тэр агшинд аалз нуруугаараа дээшээ харж унаад хөлөө аймшигтай сарвалзуулав. Ямар ч чимээ гарсангүй. Гэхдээ Харри түүнийг хашгирч байгаа гэдэгт итгэлтэй байлаа. Грюм түүнээс саваагаа холдуулсангүйд аалз чичирч эхэллээ.

- Болиоч! гэж Гермиона дуу алдав.

Харри түүн рүү эргэн харлаа. Тэр нударгаа цайртал нь зангидаад айдас дүүрэн нүдээр ширтэх Невиллийг харж байв.

Грюм саваагаа буулгав. Аалзын хөл суларсан хэдий ч татвалзсан хэвээр байлаа.

- Редуцио гэж Грюм тушаахад аалз багассаар ердийн хэмжээндээ орлоо. Грюм түүнийг шилэн саваанд буцаан хийв.

- Өвдөж байна. Ямар ч эрүү шүүлт тулгах багаж хэрэггүй. Зөвхөн Круциатус байхад л хангалттай. Энэ ч бас өргөн тархсан байдаг юм. Хэн нэгэн өөр юм мэдэх үү?

Харри эргэн тойрноо харав. Бүгдийн царайг харахад сүүлчийн аалзыг юу хүлээж байгаа нь ойлгомжтой байлаа. Гермиона гурав дахь удаагаа чичирсэн гараа өргөв.

- За? гээд Грюм түүн рүү харав.

- Авадра Кедавра гэж Гермиона шивнэлээ.

Хэдэн сурагчид түүний дотор Рон айдаст автан харав.

- Тиймээ. Сүүлчийн хамгийн аймшигтай шившлэгийг Авадра Кедавра гэдэг юм. Аллагын шившлэг гэж Грюм үл мэдэг инээвхийлэн хэллээ.

Тэр шилэн сав руу ахин гараа шургуулахад гурав дахь аалз түүнд юу тохиолдохыг тааварласан бололтой Грюмын хуруунаас мултрахыг хичээв. Тэр түүнийг барьж аваад ширээн дээр тавилаа. Аалз нуугдах газар хайн ширээн дээгүүр гүйлээ.

Грюм саваагаа өргөхөд Харри муу ёрын совинд автав.

- Авадра Кедавра! гэж Грюм хашгирав.

Гялалзсан ногоон оч харван ташуур исгэрэх адил чимээ гарахад аалз агшин зуур нуруугаараа сарвайн унаад амьдралын ямар ч шинж тэмдэг илтгэсэнгүй. Хоёр гурван охин айсандаа хашгиралдав. Аалз түүний ширээ рүү унасан учир Рон хойшилохдоо арай л сандлаас ойчсонгүй.

Грюм үхсэн аалзыг шалан дээрээс хаман аваад,

- Таагүй л юм. Жигшүүртэй. Ямар ч аврагдах шид байхгүй. Зайлуулах боломжгүй. Түүхэнд ердөө ганц хүн энэ шившлэгийн өмнө зогссон. Тэр одоо энд миний урд сууж байна гэлээ.

Грюм түүн рүү харахад Харрийн нүүр улайлаа. Бүх ангиараа түүн рүү ширтэв. Харри хоосон самбар руу ширтэн бодлогоширов.

Тэгэхээр эцэг эхээ ямар үхлээр үхсэнийг мэдлээ. Яг л энэ аалз шиг. Магадгүй тэд өвдөлтөө мэдэрч амжаагүй байх даа? Тэд ногоон гэрлийг харсан даруйдаа исгэрэх чимээ сонсогдсон нь амьдралынх нь сүүлчийн агшин байсан гэж үү?

Гурван жилийн турш Харри ахин дахин эцэг эхийнхээ Волан-де-Мортын гарт яаж үрэгдсэнийг төсөөлжээ. Түүний бодол Сүүлт эцэг эхээс нь урван хаана нуугдсаныг хэлсэн шөнө рүү буцан очлоо. Волан-де-Морт гэрт нь ороод эцгийг нь довтолсон. Жеймс Поттер түүнийг тогтоохыг хичээн эхнэртээ <<Харрийг аваад зугт!>> гэж хашгирсан юм. Тэгээд л үхсэн. Волан-де-Морт Харриг алахын тулд Лили Поттерыг замаасаа зайлуулахыг хүссэн. Тэр түүнээс хүүг нь алахгүй байхыг гуйн өөрийн биеэрээ халхалсан билээ. Волан-де-Морт түүн рүү шидэт саваагаа чиглүүлэх үед тэр ердөө л ойтой байсан юм.

Харри өнгөрсөн жил Дементорын эсрэг тэмцэх хүнд хэцүү шившлэг сурахдаа эцэг эхийнхээ хоолойг сонссон билээ. Тэдний золиос хамгийн аймшигтай дурсамжаа санадаг болохоор ой ухаанд нь цөхрөлийг авчирдаг байсан юм.

Грюм ахин ярьж эхлэхэд түүний үг алсад сонсогдоно. Харри багагүй зүтгэл гаргаж байж профессорын үгийг сонслоо.

- Авардра Кедавра бол онцгой шидэт хүчийг шаардана. Хэрвээ та нар бүгд над руу саваагаа чиглүүлэн энэ аймшигт үгийг хэлэх аваас миний хамраас цус ч гарахгүй гэж бодож байна. Гэхдээ энэ чухал биш. Би та нарт үүнийг заах гээгүй билээ.

- Хэрвээ үхлийн шившлэгийг эсэргүүцэх зүйлгүй бол би та нарт яагаад зааж байгаа билээ? гэсэн асуулт урган гарч байна. Яагаад гэвэл та нар хамгийн муу зүйл юу болохыг мэдэх байх ёстой. Үйл явдалд оролцохгүйн тулд. СЭРЭМЖТЭЙ БАЙ! гэж тэр ахин бүх ангийг цочтол хашгирлаа.

- Ингээд та нар уучлашгүй гурван шившлэг болох Авадра Кедавра, Имперуус, Круциатус нарыг мэдэж авлаа. Энэ бол хориотой шившлэгүүд юм. Тэдний нэгийг хэрэглэсэн хүн бүх амьдралаа Азкабанд өнгөрүүлэх шийтгэл авна. Та нар үүний эсрэг байх ёстой. Би та нарыг тэмцэхэд сургах болно. Бэлтгэл хийх хэрэгтэй. Үргэлж зэвсэгтэй байх хэрэгтэй. Гэхдээ хамгийн гол нь сэрэмжтэй байдал. Хэзээ ч сонор сэрэмж алдаж болохгүй. Харин одоо үзгээ аваад энэ тухай бичицгээ.

Хичээлийн үлдсэн хугацааг уучлашгүй шившлэгүүдийн тухай бичиж өнгөрүүлэв. Хонх дуугаргал хэн ч үг хэлсэнгүй. Ангиас гарах үед хүүхдүүд шившлэгийн тухай бишрэн ярилцаж байлаа. <<Тэр аалзыг яаж чичирснийг харсан уу? Харин тэр түүнийг ганц цохиод л дуусгачихсан!>>

Хичээлийн тухай яриа Харрид нэгэн төрлийн үзүүлбэр байсан юм шиг санагдана. Түүний хувьд энэ шившлэг сонирхолтой байсангүй. Гермionaд ч мөн адил бололтой.

- Түргэл! гэж тэр Харри, Рон хоёрыг түгшсэн шинжтэй дуудав.

- Ахиад л номын сан руу юу? гэж Рон асуув.

- Үгүй ээ. Невилл! гэж Гермоина хэлээд хонгил руу гараараа заав.

Невилл хана руу айдас дүүрэн нүдээр ширтэн амаа ангайн зогсож байв. Тэр Грюмын Криуциатус хийсэн үеийнх шиг л байлаа.

- Невилл гэж Гермиона аяархан дуудав.

Невилл эргэж харлаа.

- Өө, сайн уу гэж тэр дасал болоогүй нарийхан хоолойгоор хэлээд,

- Сонирхолтой хичээл байна, тийм үү? Би өнөөдөр хоолонд юу байгааг мэдмээр байна... өлсөж үхэх нь байна, харин та нар? гэв.

- Невилл чи зүгээр үү? гэж Гермиона асуув.

- Өө, тэгэлгүй яахав зүгээр дээ. Их сонирхолтой хоол байна... хичээл гэх гэсэн юм... Бидний оройн хоолонд юу байгаа бол?

Рон түгшин Харри руу харав.

- Невилл, юу...

Тэдний ард модон хөлийн чимээ гараад профессор Грюм доголсоор яаран ирэв. Бүгд түүн рүү болгоомжлон харлаа. Гэвч Грюм гайхалтай нам бүр зөөлөн юм шиг хоолойгоор ярилаа. Тэдний хичээл дээр сонссон сөөнгөтсөн дуутай огтхон ч төс байсангүй.

- Зүгээр дээ, хүү минь. Чи яагаад миний анги руу орж болохгүй гэж? Явж аяга цай ууя... гэж тэр Невиллд хандан хэлэв.

Грюмын урилга Невиллийг илүү их айлгажээ. Тэр юу ч хэлэлгүй хөшлөө.

Грюмын шидэт нүд Харри руу харав.

- Харин чи, Харри зүгээр үү?

- Тиймээ гэж Харри хэлэв.

Грюмын цэнхэр нүдний сормуус үл мэдэг чичрлээ. Тэрбээр чимээгүй болсноо,

- Та нар энэ бүхнийг мэдэх болсон. Хэрцгий байна уу? Тэгэлгүй яахав. Гэхдээ мэдэх ёстой юм. Амьдралд элдэв зүйл тохиолдоно. Невилл надад чамд сонирхуулах номнууд байгаа шүү... гэлээ.

Грюмын сорвитой гар түүний мөрөн дээр дарахад Невилл найзууд руугаа царайчлан харснаа юу ч хэлсэнгүй.

- Үүнийг юу гэж ойлгох вэ? гээд Рон Грюм, Невилл хоёрыг дагуулан харав.

- Мэдэхгүй гэж Гермиона гүн бодолд автан хэллээ.

- Энэ хичээл үү! Фред, Жорж хоёрын зөв байж. Грюм өөрийн ажлаа сайн мэддэг юм байна. <<Авада Кедавра>>-г гаргахад аалз тогонд цохиулсан юм шиг унасан... гэж Рон дуу алдав.

Гэвч Харригийн царайг хараад Их танхим руу ортлоо юм ярьсангүй. Хоолны үеэр мэргэ төлгийн даалгаварын тухай ярилцлаа.

Гермиона яриа хөөрөнд оролцсонгүй. Тэр ахиад л түргэхэн залгилаад номын сан руу гүйж одов. Тэр хоёр Гриффиндорын цамхаг руу явахад Харри замын турш уучлашгүй шившлэгээс өөр зүйл бодсонгүй.

- Чинийхээр бол бол ид шидийн яамнаас Грюм, Дамблдор хоёрыг энэ шившлэгийг зааж байгааг мэдэх юм бол таагүй зүйл болох болов уу? гэж Харри тарган хатагтай руу явах замдаа асуулаа.

- Тиймээ магадгүй л юм. Гэхдээ Дамблдор үргэлж өөрийнхөөрөө хийдэг. Грюмд энэ жил таагүй явдал их учирсан. Хогийн савны тухай санаад үз дээ... Дэмий яриа!

Тарган хатагтайн хөрөг нээгдэхэд андууд нүхэн гарцаар амралтын өрөөнд ороход хөл хөгжөөн ихтэй байлаа.

- Өнөөдөр мэргэ төлгийн даалгавар хийх ёстой билүү? гэж Харри хэлэв.

- Тиймээ гэж Рон санаа алджээ.

Тэд унтлагын өрөө рүү ном газрын зургаа авахаар өгсөв. Тэнд зөвхөн Невилл байлаа. Тэр орон дээр суугаад ном уншиж байв. Түүний байдал хичээл дээр байснаасаа тайван байсан ч бас ч гэж хэвийн болоогүй байв. Нүд нь улаан харагдана.

- Чи зүгээр биз? гэж Харри асуулаа.

- Зүгээр дээ. Баярлалаа. Хараач профессор Грюм надад үүнийг уншуулахаар өгсөн...

Тэр тэдэнд <<Газар дундад тэнгисийн шидэт усны ургамал>> гэсэн ном үзүүлэв.

- Магадгүй профессор Стебль намайг профессор Грюмд ургамал судлалын хичээлдээ сайн гэж хэлсэн байх. Тэгээд л тэр надад энэ ном таалагдана гэж бодож хэмээн Невилл бардам хэлэв.

<<Невиллийг профессор Стелбль авъяаслаг сурагч гэж хэлсэн бол сайн байна. Түүнийг хүмүүс ховорхон магтдаг шүү дээ. Бардам байдал бол түүний хувьд харь мэрэмж юм. Профессор Люпин л ийм алхам хийх байсан даа>> гэж Харри бодлоо.

Харри, Рон хоёр <<Хэрхэн мананг нэвглэн ирээдүйг харах вэ>> гэдэг сурах бичгээ аваад амралтын өрөө рүү уруудан сул ширээ олоод ажилдаа орлоо. Цаг өнгөрлөө. Тэдний ширээ нийлбэр тэмдэг бүхий цаасаар дүүрч Харрийн толгой профессор Трелонигийн зуухнаас гардаг анхилам үнэрт манантан дүйрнэ.

- Энэ юу болохыг ойлгох юм алга гэж тэр тооны урт жагсаалтыг харж хэллээ.

- Минийхээр бол хуучин мэргэ төлгийн хичээл рүүгээ буцсан нь дээр байхаа гэж Рон гонсойсон байртай хэлээд хуруугаараа үсээ сөргүүлэн иллээ.

- Зохиох хэрэгтэй гэж бодож байна уу?

- Тэгье гээд Рон замбараагүй сараачсан тэмдэглэлүүдээ харж үзгээ бэхэндээ дүрэв.

- Ирэх даваа гаригт золгүй тохиолдлын Ангараг гариг, Бархасвадь гариг хоёр нэгдэх учир би ханиад хүрэх болно. Чи түүний өвчин зовлонд баярладгийг мэднэ дээ.

- Оролдоод үзье гэж Харри зөвшөөрөөд тооцоогоо базан нэгдүгээр дамжааныханы толгой дээгүүр ханан зуух руу чулуудав.
- Даваа гаригт надад аюул заналхийлж байгаа юм байна... м-м-м шатах.
- Болж байна шүү. Даваа гаригт бидэнд соплохвостууд орно шүү дээ. Мягмар гаригт би э-э-э...
- Үнэт зүйлээ алдана хэмээн Харри <<Хэрхэн мананг нэвтлэн ирээдүйг харах вэ>> гэдэг сурах бичгээ гүйлгэн хараад хэллээ.
- Сайн байна гэж Рон бувтнаад,
- Буд гариг эрхшээх юм байна. Харин чи яагаад сайн найзынхаа нуруу руу хутга дүрж болохгүй гэж! хэмээн сараачингаа хэлэв.
- Хөөх гайхалтай! Сугар гариг хоёр дахь гэртээ байхад тохиох юм байна.
- Харин би Лхагва гаригт муу тэмцэлд татагдан орно.
- Чөтгөр гэж, би наадахыг чинь бичих гэж байсан юм! За яахав, мөрий тавихаас.
- Тийм шүү чи намайг тэмцэлд хожно гэж мөрийцөөрэй.

Тэд ахин нэг цаг мэргэ төлгийн хичээл хийж суухад (эмгэнэлт яриа улам бүр өсөн нэмэгдэж байв) амралтын өрөө хоосорлоо. Сурагчид унтлагын өрөө лүүгээ явжээ. Живоглот тэдний хажуугаар өнгөрөөд сандал дээр үсрэн гарч Харриг даалгавар хийхгүй байна гэсэн аятай Гермionaгийн адил сэжигтэй харцаар харлаа.

Харри зочны өрөөг гүйлгэн хараад Фред, Жорж хоёрыг буланд суугаад үзгээ гартаа барьж хуудас цаасан дээр төвлөрөн байхыг харлаа. Эргэн тойронд нь хүн байсангүй. Тэд буланд нуугдан суугаад чимээгүй юм бичих нь ер бусын зүйл байлаа. Тэд үргэлж шуугих дуртай байсан юм. Тэдний нууцлаг байдлыг хараад Үүрэнд бас ингэж суугаад юм бичиж байсан нь санаанд оров. Тэгэхэд тэднийг шинэ бүтээлийнхээ захиалгын хуудас бичиж байгаа юм байх гэж бодсон. Гэвч одоо энэ адилгүй байлаа. Тэд үүндээ Ли Жорданыг ч байлцуулсангүй. Гурван шидтэний тэмцээнд оролцох ямар нэгэн арга хайж байгаа юм болов уу?

Жорж Фредийн үзгээр сараачснаа толгой сэгсрэн ямар нэгэн юм аяархан хэлэхэд хоосон амралтын өрөөнд цуурайтан <<Үгүй ээ, энэ бид түүнийг буруутгаж байгаа юм шиг сонсогдож байна. Болгоомжтой байх хэрэгтэй>> гэх нь сонсогдов.

Жорж толгойгоо өргөөд Харритай харц тулгармагц тэр инээмсэглээд мэргэ төлгийн зохион бичлэгээ үргэлжлүүлэв.

Тэр түүнийг сонсож байна гэж бодоогүй нь лавтай.

Удалгүй ихрүүд цаасаа хуйлаад тавтай нойрсохыг ерөөн унтлагын өрөө лүүгээ явлаа. Арван хормын дараа хөргөн үүд нээгдэн амралтын өрөөнд нэг гартаа боодолтой цаас, нөгөө гартаа шаржигнасан хайрцаг барьсан Гермiona орж ирэв. Живоглот нуруу гүдийлгээд хүржигнэлээ.

- Сайн уу. Би сая л дууслаа гэж тэр дуу алдав.

- Би ч гэсэн! гэж Рон баясгалантайгаар мэдэгдээд үзгээ тавив.

Гермиона цаас хайрцгаа тавин сандал дээр суугаад Роны мэргэ төлгийн хичээлийг дөхүүлж үзэв.

- Чамайг амархан сар хүлээж байгаа гэж хэлж болохгүй гэж инээмсэглэн хэлээд Живоглотыг илэн өвдөг дээрээ авлаа.

- Намайг юу хүлээж байгааг би одоо мэдэх болсон гээд Рон эвшээлээ.

- Чи хоёр удаа живсэн байна!

- Хаана? Үнэн үү! За яахав энэ бүхнийг уурсан гиппогрифд дэвслүүлсэн болгож өөрчилье хэмээн Рон яаран харж хэлэв.

- Та нарын зохиосон чинь ажиглагдахгүй гэж бодож байна уу?

- Чи биднийг доромжилж яаж зүрхэлнэ вэ! гэж Рон тоглон уурсаад,

- Бид гэрийн үйлчлэгч шиг хичээн хөдөлмөрлөснийг хараач! гэв.

Гермиона хөмсгөө өргөлөө.

- Зүгээр л тэгээд хэлчихлээ гэж Рон яаран тайлбарлав.

Харри мэргэ төлгийн хичээлээ толгойгоо цаазлуулахаар дуусгаад үзгээ тавилаа.

- Хайрцганд чинь юу байгаа юм бэ? гэж тэр сониучирхав.

- Асуухын оронд таа л даа гээд Гермиона Рон руу таагүй харангаа хайрцагны тагыг онгойлгон үзүүлэв.

Дотор хагас зуун ширхэг янз бүрийн өнгөтэй <<Г.Ү.Х.Н>> гэсэн үсэгтэй тэмдэг байлаа.

- Гүхн гэсэн чинь юу гэсэн үг юм бэ? гээд Харри тэмдгийг аван харлаа.

- Ямар ч Гүхн биш. Энэ бол Гэрийн үйлчлэгчийг хамгаалах нийгэмлэг гэсэн үг.

- Хэзээ ч тийм зүйл сонсож байсангүй гээд Рон мөрөө хавчлаа.

- Мэдээж сонсож байгаагүй. Би түүнийг зохиосон юм гээд Гермиона мөрөө бардам тэгшлэв.

- Тийм үү? Хэдэн гишүүнтэй юм бэ? гэж Рон гайхсан янзгүй хэллээ.

- Та хоёртой нийлээд гурав.

- Биднийг энгэртээ энэ ГҮХН-ийг зүүгээд явна гэж бодож байна уу?

Гермиона санаа алдлаа.

- Би эхлээд эхлээд зөвхөн <<Ү>> үсэг бичсэн юм. Гэвч гоё болоогүй л дээ. Би бүр тунхаг бичиг бэлдсэн шүү.

Тэр хуйлаастай цаас гаргаж ирэн үзүүлэв.

- Би номын санд судалгаа хийсэн юм. Үйлчлэгчийн боолын хөдөлмөр зуунаас ч гүнд байжээ. Ягаад одоо болол хэн ч үүний талаар юм хийгээгүйг мэдэх юм алга.

- Гермиона, чихээ онгойлго л доо! Тэдэнд! Энэ чинь! Таалагддаг юм! Тэдэнд боолын амьдрал таалагддаг юм! гэж Рон чанга хэлэв.

- Бидний ойрын зорилго бол гэж Гермиона огт сонсоогүй аятай хэлээд,

- Гэрийн үйлчлэгч нарыг аюулгүй орчинд хөдөлмөрлүүлэх юм. Алсын зорилго бол тэдний шидэт саваа хэрэглэхгүй байх шийдвэрийг халж шидэт амьтдыг хянан зохицуулах хэлтсийн хяналтнаас холдуулах явдал юм. Тэд цаашдаа үүнийг тэвчээд байх боломжгүй гэв.

- Бид үүнийг яаж хийх юм бэ? гэж Харри асуулаа.

- Холбоондоо гишүүн цуглуулахаас эхлэнэ. Гишүүн болж тэмдэг зүүхэд хоёр сикль авах болно. Цугларсан мөнгөөрөө кампанит ажлынхаа ухуулах хуудсыг санхүүжүүлэх юм. Чи бол нярав шүү шүү, Рон. Би мөнгөний савыг бэлдчихсэн. Харин Харри чи бол нарийн бичиг болохоор миний юу ярьж байгааг бичиж авах ёстой. Анхны цугларалтын протокол хөтөл .

Чимээгүй болцгоолоо. Гермиона андууд руугаа гийн харахад Харри уурлах инээх эсэхээ мэдсэнгүй. Нам гүмийг цонх тогших чимээ эвдэв. Харри сарны гэрэлд цасан цагаан ууль чулуун тавцан дээр сууж байхыг харлаа.

- Хэдви́г! гэж тэр хашгираад сандлаасаа үсрэн босч цонх онгойлгохоор ухасхийв.

Хэдви́г хормын дараа өрөөнд нисэн орж ирээд Харрийн мэргэ төлгийн хичээл дээр газардав.

- Арайхийж ирэв үү! гээд Харри түүн рүү гүйж очлоо.

- Хараач, тэр хариулт авчирсан байна! гэж Рон Хэдви́гийн сарвуунд уясан бохир цаасыг харж хэлэв.

Харри цаасыг яаран тайлан авч суугаад уншиж эхлэхэд Хэдви́г өвдөг дээр нь суугаад далавчаа дэвэн сэтгэл хангалуун гууглав.

- За юу гэж байна? хэмээн Харригаас дутуугүй догдолсон Гермиона хэллээ.

Захиа товчхон агаад ихэд яарсан бололтой таталган бичсэн байв. Харри чанга уншлаа.

Харри!

Би хойд зүг рүү даруйхан нисэх боллоо. Чиний сорвинд тохиолдсон явдал намайг зовоож байна. Хэрвээ сорви ахиад өвдөх юм бол огт алгуурлалгүй Дамблдор мэдэгдээрэй. Тэр тэтгэвэртээ гарсан Хурц нүдэтийг дуудсан гэж ярьцгааж байна. Энэ бол тэр шинж тэмдэгийг харсны тэмдэг байх. Удахгүй уулзая. Рон, Гермона хоёрт сайн сайхныг хүсье. Нүдээ нээлттэй байлга Харри.

Сириус.

Харри Рон, Гермиона хоёр луу харахад өөдөөс нь ширтлээ.

- Хойд зүг рүү нисэх гэнэ ээ? Тэр буцаж ирэх гэж байгаа юм уу? гэж Гермиона шивнэлээ.

- Дамблдор ямар шинж тэмдэг харсан гэж? Ямар юм бол, Харри? гэж Рон гайхширан хэлээд мөрөө хавчив.

Харри уурандаа духаа цохилоо. Хөөрхий Хэдвиг өвдөг дээрээс нь нисэн буув.

- Би түүнд үнэнийг бичээгүй юм! гэж Харри уурсан хэлэв.

- Чи юуны тухай яриад байна? гэж Рон гайхлаа.

- Хэрвээ миний захиа байгаагүй бол тэр ийм шийдвэр гаргахгүй байсан! гээд Харри нударгаараа ширээ цохиход шалан дээр сууж байсан Хэдвиг нисээд Роны ард сууж уурсан гууглав.

- Тэр намайг зовлонд орсон гэж бодоод ийшээ ирэхээр шийджээ! Харин миний бүх зүйл хэвийн байна! Би чамд юу ч хадгалаагүй гэж тэр Хэдвиг горьдонгуй хошуугаа тас няс хийлгэхэд зандрав.

- Идэхийг хүсч байгаа бол уулийн байшин руу нис!

Хэдвиг түүнийг доромжлогдсон харцаар хараад далавчаа дэлгэн онгорхой цонхоор нисэн одлоо.

- Харри... гэж Гермiona тайтгаруулах өнгөөр хэлэв.

- Би явж унтлаа. Өглөө уулзацгаая гэж Харри хэлэв.

Тэр шатаар өгсөн унтлагын өрөөндөө ороод хувцсаа тайлан орондоо шургасан ч даруй унтаж чадсангүй.

Хэрвээ Сириус эргэж ирээд баригдах юм бол энэ Харригийн буруу байх болно. Тэр яах гэж захиа бичсэн юм бэ? Хэдхэн хормын өвдөлтийн төлөө... Яагаад Сириусыг?

Харри унтлагын өрөөнд Рон орж ирэхийг сонссон ч нэг ч үг хэлсэнгүй. Тэр харанхуй адар руу ширтэн удаан хэвтлээ. Өрөөнд нам гүм оргино. Харри их сэтгэлээр унасан болохоор Невиллийн зөөлөн хурхирах чимээг тоосонгүй. Ингээд нэг шөнө унтаж чадахгүйгээ ойлгожээ.

БҮЛЭГ 15: ШАРМБАТОН БА ДУРМСТРАНГ

Харри үүр гэгээрэхэд сэрэв. Толгойд нь шөнийн турш бодсон төлөвлөгөө бэлэн болжээ. Тэр босож Роныг сэрээхгүйг хичээн хувцаслаад хоосон амралтын өрөө рүү уруудан оров. Ширээн дээр өчигдөр түүний хийж байсан мэргэ төлгийн хичээлийн гэрийн даалгавар хэвтэнэ. Харри суугаад цаас авч бичиж эхэллээ.

Хүндэт Сириус!

Миний сорвинд санаа зовох хэрэггүй. Тэр өвдөөгүй надад тэгж санагдсан хэрэг. Сүүлчийн захиагаа би бичихдээ нойрмог байсан юм. Тэгэхээр ийшээ ирэх хэрэггүй. Би зүв зүгээр байгаа бөгөөд толгой ч гэсэн хэвийн байна.

Харри

Тэр хөргөн нүхээр үсрэн гараад баруун цамхагын хамгийн дээр байдаг уулийн байшин руу яарлаа. Шилтгээнд нам гүм агаад зөвхөн дөрөвдүгээр давхарт Пивз түүнд саад болж дээрээс нь хүнд ваар унагах гэснээс өөр хэнтэй ч тааралдсангүй.

Эцэст нь уулийн байшин болох цонхоор нь хүйтэн салхи нэвт үлээсэн дугуй чулуун өрөөнд ирлээ. Шалаар дүүрэн сүрэл, уулийн баас болон хоолны үлдэгдэл болох хулгана оготнын яс хөглөрөлдөнө. Зуугаас доошгүй уульнууд дээврийн дорх хонууртаа эгнэн сууж байлаа. Бараг бүгд унтаж байсан ч түүн рүү дугуй хуван шар нүд ууртай ширтэж байв. Харри Хэдвиг руу яаран очихдоо золтой л хальтраад уначихсангүй.

Хэдвиг хоёр уулийн дунд сууж байснаа зүүрмэглэн түүн рүү сүүлээ харуулав. Харри уулийг эргүүлэн зовхийг нь нээхийн тулд нилээн хичээх хэрэг гарчээ. Хэдвиг залилж байлаа. Өчигдөр орой түүнийг гомдоосон явдалд уурласан хэвээр байв.

- Чи өчигдөр их ядарсан. Роны Гахайг гуйхаас даа гээд Харри санаа алдан нурууны өдийг нь иллээ.

Энэ үгийг сонсмогц Хэдвиг агшин зуур сэрэн сарвуугаа сунгав.

- Сириусыг аль болох түргэн олоорой. Түүнийг Дементоруудын гарт орчих вий гэхээс айж байна гээд Харри уулийг авч нэг цонх руу очлоо.

Хэдвиг түүний хурууг өвдтөл базаад гууглан далавчаа дэлгэн нар угтан нисэж одлоо. Харри түүнийг дагуулан харахад сэтгэл санаа нь хүндхэн байв. Тэр Сириусын хариулт ингэж түгшээнэ гэж бодоогүй билээ.

Өглөөний цайны үеэр Харри найзууддаа Сириуст илгээсэн захианы талаар хэлэв.

- Гэхдээ Харри энэ чинь худал биз дээ. Чи сорвины тухайд санаанаасаа зохиогоогүй гэж Гермiona түгшлээ.

- Тэгээд юу гэж? Чи түүнийг Азкабанд оруулахыг хүсээд байгаа юм уу?

Гермиона эсэргүүцэхийг завдсан ч Рон хажуу руу нь нудраад,

- Боль гэж шивнэлээ.

Хоёр долоо хоногийн турш Харри загалмайлан эцэгтээ сэтгэл зовнилоо. Тэр өглөө бүр зүрх түшин байж уулийн шуудан ирэхийг хүлээх агаад зүүд нь бүр аймшигтай болжээ. Сириусыг Дементорууд Лондондын харанхуй гудамжинд барьж авч байна. Квиддичийн бэлтгэл байхгүй нь харамсалтай. Тэр хүндхэн бодлоос салах сайн эм болдог юм. Ялангуяа хар урлагаас хамгаалах хичээлийн дадлага илүү хэцүү болж багш илүү ихийг шаардаж байлаа.

Бүгдийн гайхлыг төрүүлэн профессор Грюм хүн бүр Имперуус шившлэгийн хүчийг эсэргүүцэн тэмцэх хүчтэй болох ёстой гэж мэдэгджээ.

- Гэхдээ профессор та хуулиар хориглосон... гэж Гермiona итгэлгүйхэн эхлэв.

Профессор чимээгүйхэн саваагаа даллахад ширээнүүд зүг бүр тийш холдон ангийн голд хоосон зай гарлаа.

- ... хүмүүст энэ шившлэгийг хэрэглэж болохгүй гэж хэмээн сайн сурагч маань бодлоо дуусгав.

- Дамблдор та нарыг аюул тохиолдоход энэ шившлэгийг мэддэг байхыг хүсч байгаа юм гэж Грюм маргахын аргагүй өнгөөр хэлэхэд шидэт нүд нь Гермionaг аймшигтайгаар цоо ширтэв.

- Хэрвээ чи боол байх илүү жигшүүртэй замыг сонгож байгаа бол татгалзаж болно энэ чиний сонголт. Хичээлийг орхиж болно гээд тэр мойног хуруугаараа хаалга руу заав.

Гермiona час улайгаад ямар нэг юмны талаар бувтналаа. Харри, Рон хоёр бие бие рүүгээ инээмсэглэн харав. Гермiona тийм чухал хичээлийг орхиж байснаас бубонтюберийн идээ уусан нь дээр биз.

Грюм сурагчдыг ээлжээр дуудаж шидийг хийв. Тэд түүний нөлөөн дор хачин жигтэй үйлдэл хийлээ. Дин Томас өрөө гурван удаа тойрон үндэсний дуулал дуулан гүйлээ. Лаванда Браун өөрийгөө хэрэм гэж бодов. Невил жирийн үедээ чадахааргүй гайхал төрүүлэм гимнастикийн дасгал хийлээ. Тэдний хэн нь ч Грюм шившлэгийг цуцлах хүртэл эсэргүүцэж чадсангүй.

- Поттер чиний ээлж гэж Грюм эцэст нь сөөнгөтөв.

Харри ангийн голд гарлаа. Профессор түүн рүү саваагаа чиглүүлээд,

- Имперуо! гэв.

Гайхалтай мэдрэмж! Харри тэнгэрт хөөрөх шиг болов. Ямар ч сэтгэл түгшил зовнил байхгүй зөвхөн тайлбарлаж боломгүй аз жаргал мэдрэгдэх аж. Баяр хөөрийн давалгаан дунд түүнийг хэн нэгэн түүнийг хараад байгаа юм шиг мэдрэмж төрөв. Тэгтэл хоосон тархинд нь Хурц Нүдэтийн тушаал алсаас сонсогдож,

<<Ширээн дээрээс үсэр... Ширээн дээрээс үсэр...>> гэв.

Харри дуулгавартайгаар өвдгөө нугалаад үсрэхэд бэлтгэлээ.

<<Ширээн дээрээс үсэр...>>

Тэгтэл сэтгэл зүрхнийх нь гүнд өөр нэгэн хоолой,

<<Ингэх ямар хэрэгтэй гэж? Энэ чинь тэнэг хэрэг шүү дээ!>> гэлээ.

<<Ширээн дээрээс үсэр...>>

<<Үсрэхгүй, баярлалаа. Би хүсэхгүй байна... гэж хоёр дахь хоолой чанга хэллээ...>>

<<Үсэр! ОДООХОН!>>

Дараагийн агшинд Харри хүчтэй өвдөхийг мэдрээд үүнтэй тэмцэхийн тулд цөхрөн үсэрлээ. Үр дүнд нь толгойгоороо ширээ мөргөн уналаа. Хоёр өвдөг нь хугарчих шиг санагдав.

- Энэ л дөхөж очлоо! гэх Грюмын чанга хоолой сонсогдоход толгойд нь байсан хоосон гэнэтхэн алга болов. Харри түүнд юу тохиолдсоныг санатал хоёр өвдөг нь янгиналаа.

- Бүгд Харриг харлаа! Поттер тэмцлээ! Тэр тэмцээд, чөтгөр гэж бараг л зогслоо. Ялалт түүнд ойрхон байлаа! Ахин нэг оролдоод үзье, Поттер! Харин та нар түүний нүдийг нь ажиглаарай. Түүнд бүх зүйл тусдаг юм. Сайн байна, Харри! Чамайг боол шиг тийм ч амархан хөдөлгөж чадахгүй юм байна...

- Үгүй, тэр яаж ингэж ярьж байна аа! (Грюм түүнийг дасгалжуулах үед Харри дөрөв дэх оролдлого дээрээ эсэргүүцэж чаджээ). Бид дурын агшинд халдлаганд ойрхон байлаа гэж Харри андууддаа хичээл дуусан шат уруудаж байхдаа хэллээ.

- Тэр зүгээр л галзуу юм байна гээд Рон түгшсэн байртай эргэж харан Грюм байгаа эсэхийг шалгав.

Түүний шившлэгтэй тэмцэх оролдлого Харригийнхийг бодвол илүү хэцүү байсан бөгөөд явах биш гишгүүр алгасан харайж байлаа. Гэхдээ Грюм оройн хоолны үеэр шид өөрөө арилна гэж хэлсэн аж.

- Ид шидийн яамныхан түүний алга болсонд баярлаж байгаад гайхах юм алга. Чи Симусыг дөрвөн сарын тэнэгүүдийн өдөр шиг <<бу-у>> гэж хашгируулахыг сонсоо биз дээ? Хэзээ түүний Имперуусын эсрэг тэмцэж сурахын тулд юм бол доо?

Дөрөв дүгээр дамжааныхан энэ жил гэрийн даалгавар урьдынхаас их болсныг анзаарчээ. Профессор МакГонагалл хувиргалын хичээлийн гэрийн даалгаварыг яагаад сайтар хийх ёстойг тайлбарлав.

- Та нар ид шидийн урлагийн чухал шатанд дэвшин орлоо. С.И. Ш-ийн шалгалт холгүй байна... гэж профессор МакГонагалл сүрдүүлсэн янзтай хэлэхэд дөрвөлжин хүрээтэй шил нь гялсхийв.

- Тийм шалгалтыг тав дугаар дамжаандаа өгдөг шүү дээ! гэж Дин Томас эсэргүүцэв.

- Тиймээ, Томас. Гэхдээ урьдчилж бэлтгэх хэрэгтэй. Бүх ангиас ердөө хатагтай Грэйнджер л ганцаараа зарааг зүүний хатгуур болгон хувиргаж байна. Харин таны хатгуур, Томас зүү хатгахаас ч айдас төрөм юм.

Гермиона улайсан ч бардмаар инээмсэглэхгүй байж чадсангүй.

Мэргэ төлгийн хичээл дээр Рон, Харри хоёрт аз таарчээ. Профессор Трелони тэр хоёрын зохион бичлэгт хамгийн өндөр оноо өгсөн гэж мэдэгджээ. Тэр тэдний

төлгийг уншиж үзээд аймшигтай түүхийг нь ихэд сайшаасан байна. Гэхдээ баяр хөөр түргэн бөхөв. Трелони тэднээс дараагийн сард юу тохиолдох талаар шинэ даалгавар өгөхөд тэдний толгойд байсан гай зовлон, золгүй явдлын нөөц барагдсан байлаа.

Өөр багш нар ч бас дутсангүй. Ид шидийн түүхийн багш профессор Бинс долоо хоногийн турш XVIII зууны үеийн албингуудын бослогын тухай зохион бичлэг хийх даалгавар өгчээ. Профессор Снегт тэдэнд хорны эсрэг үйлчилгээтэй уусмалын тухай бичихийг даалгаж зул сарын өмнө хэн нэгэн дээр туршиж үзэхээ амалсан байна. Харин профессор Флитвик Татдаг шидийн тухай гурван зузаан номыг номын сангаас нэмэлтээр уншихыг үүргэж болгожээ.

Тэр ч байтугай Хагрид хүртэл өршөөсөнгүй. Түүний галт соплохвостууд юугаар тэжээснийг бүү мэд аймшигтай хурдан томров. Тэрбээр овоохойны хажууд үдэш ирж соплохвостуудын сайн талыг судалж бич гэлээ.

- Би явж чадахгүй. Баярлалаа энэ заваан юмгүй хичээл хангалттай байгаа гэж Драко Малфой татгалзав.

Хагридын царайнаас инээмсэглэл алга боллоо.

- Намайг тушаавал хийх л болно доо. Би профессор Грюмын жишээг дагалдах болно шүү.. Чамайг ямар сайхан өмхий хүрэн болсныг чинь сонссон, Малфой!

Гриффиндорынхон инээлдэв. Малфй уурсан хилэгнэсэн ч эсэргүүцэж чадсангүй. Түүнд Грюмын шийтгэлийг мартагдаагүй байгаа нь илт.

Харри, Рон, Гермиона гурав шилтээндээ маш хөгжилтэй эргэж ирлээ. Хагрид сайн байна Малфойг байранд нь тавиад өглөө. Өнгөрсөн жил тэр ойн сахиулыг Хогвартсаас хөөлгөхийг хүсч байсан юм.

Тэднийг танхимд ороод холдож амжаагүй байтал гантиг шатны дэргэд том зарлал гарч түүнийг тойроод сурагчид шавжээ. Рон өлмийгөө өргөөд хүмүүсийн толгой дээгүүр чангаар уншив.

ГУРВАН ШИДТЭНГҮҮДИЙН ТЭМЦЭЭН

Шармбатон болон Дурмстрангын төлөөлөгчид Хогвартсад арван сарын гучны баасан гаригт оройн арван найман цагаас ирнэ. Хичээл энэ өдөр хагас цагийн өмнө дуусна.

ХИЧЭЭЛИЙН ДАРАА СУРАГЧИД ЦҮНХ БОЛОН СУРАХ БИЧГЭЭ УНТЛАГЫН ӨРӨӨНДӨӨ ХУРААГААД ШИЛТГЭЭНИЙ УРД ЗОЧДЫГ УГТАХААР ЦУГЛАХ ЁСТОЙ.

- Гайхалтай! Баасан гаригийн сүүлчийн хичээл уусмалынх шүү дээ! Снегт хэнийг ч хордуулж амжихгүй! гэж Харри баярлав.

- Долоо хоногийн дараа ирэх юм байна! Седрик энэ тухай мэдсэн болов уу? Явж түүнд хэлье! гээд Пуффендуйн Эрни МакМиллан шатаар ухасхийлээ.

- Седрик энд ямар хамаатай юм бэ? гэж Рон гайхлаа.

- Седрик Диггори тэмцээнд оролцох гэж байгаа байх гэж Харри хэлэв.

- Энэ тэнэг Хогвартсыг төлөөлөх юм уу? гэж Рон хүүхдүүдээс холдохдоо хэлэв.

- Диггори тэнэг биш. Тэр квиддичийн тэмцээн дээр Гриффиндорыг хожсон учраас л чамд таалагдахгүй байгаа юм. Харин би түүнийг маш сайн сурагч гэж сонссон шүү. Бас тэнхимийнхээ ахлагч гэж Гермиона хэлэв.

- Чамд таалагдаад байгаа хэрэг үү! Царайлаг гээ биз дээ гэж Рон түүнийг цаашлуулав.

- Уучлаарай би хүмүүсийг гадаад төрхөөр нь дүгнэдэггүй гэж Гермиона эгдүүцлээ.

- Кха-кха! Туг-кха-кха-үс! гэж Рон чанга ханиалгав. Харри түүний ханиалгах чимээнээс <<Туг үс>> гэсэн үг олж сонслоо.

Зарлалын тухай шилтгээний хаа сайгүй ярьж байлаа. Харри долоо хоногийн турш хаа ч явсан гэсэн зөвхөн <<Гурван шидтэний тэмцээн>>, <<Гурван шидтэний тэмцээн>> гэсэн үг сонсож байв... Сурагчдын хооронд хэн Хогвартсыг төлөөлөн тэмцээнд оролцохоор бэлдэж байгаа болон Шармбатон, Дурмстрангын сурагчид хэр ялгаатай байх талаар цуу яриаг дэгдэж байв.

Мэдээжийн хэрэг шилтгээнд их цэвэрлэгээ хийв. Хэд хэдэн бохирдсон хөргийг сойздон цэвэрлэхэд тэд таагүй байлаа. Хөргүүд жаазан дотроо баргар царайлан холхилдож чийгтэй ягаан нүүрээ ярвайлгана. Рыцарын хуяг дуулгууд нүд гялбам гялалзав. Аж ахуйн эрхлэгч Аргус Филч хөлөө арчихыг мартсан хүүхдүүдэд хэрцгий хандаж тэр ч байтугай нэг дүгээр дамжааны хоёр охиныг уйлтал нь загнажээ.

Багш нар хүртэл санаа зовж байв.

- Долгопупс гуйя, Дурмстрангын зочдод хамгийн энгийн шившлэг чадахгүй гэдгээ үзүүлж болохгүй шүү! гэж профессор МакГонагалл дадлагын хичээлийнхээ төгсгөлд гуйхад Невилл сандарсандаа өөрийнхөө чихийг кактус болгон хувиргачихлаа.

Ингээд удаан хүлээсэн өдөр ирлээ. Өглөө нь тэднийг Их танхимд ороход ёслолын гоёл чимэглэлээ зүүжээ. Тэнхим бүрийн асар том далбаа ханан дээр намирч байлаа. Гриффиндорынх улаан дэвсгэр дээр алтан арслантай байсан бол, Когтевраных цэнхэр дэвсгэр дээр хүрэл бүргэд, Пуффендуйнх шаргал дэвсгэр дээр хар дорго, Слизеринийх ногоон дэвсгэр дээр мөнгөн могой байлаа. Багш нарын ширээний ард итгэмээргүй том хэмжээтэй Хогвартсын сүлд тэмдэг болох болох том <<X>> үсгийг арслан, бүргэд, дорго, могой хүрээлсэн далбаа өлгөжээ.

Фред, Жорж хоёр хэдийн хооллож дуусчээ. Гэвч ахиад юуны ч тухай юм шивнэлдэж байлаа. Рон найзуудынхаа хамтаар тэдний зүг очив.

- Тиймээ ажил хэрэг ч муугаар эргэж байна шүү. Хэрвээ тэр бидэнтэй ярихаас татгалзвал уулийн шуудангаар ар араас нь захиа илгээх болно. Бид түүнийг барих л болно. Тэр биднээс үүрд зугтаж чадахгүй гэж Жорж Фредэд баргар царайлан хэлэв.

- Хэн та нараас зугтаж байгаа юм? гээд Рон дэргэд нь суув.

- Далд ор гэж Фред уурсан бувтнав.

- Яагаад ажил муу байна гэж? хэмээн Рон Жоржоос асуув.

- Бяцхан дүү хэтэрхий сониуч байна гэж Жорж хэлэв.

- Та нарт тэмцээний тухай юу гэж бодож байна? Түүнд оролцохыг хүсч байна уу?
- Би профессор МакГонагаллаас аваргыг яаж сонгох вэ гэж асуухад юу ч хэлээгүй. Намайг амаа хамхиад илбэнхээ хувирга гэсэн.
- Тэмцээнд юу байх нь сонирхолтой юм? Ямар ч л гэсэн бид ялах болно тийм биз дээ, Харри? Бид өмнө нь аюултай учирч байсан гэж Рон бодлогоширон хэллээ.
- Аюултай учирч байсан гэнэ шүү. МакГонагалл даалгавар болгоныг оноогоор дүгнэнэ гэж хэлсэн хэмээн Фред хэлэв.
- Шүүгчээр хэн байх юм бол? гэж Харри асуулаа.
- Үргэлж сургуулийн захирлууд байдаг. Мянга долоон зуун ерөн хоёр оны тэмцээн дээр бүх аваргууд гэмтэж байсан. Тэр үед оролцогч нь василискт баригдсан гэж Гермiona хэлэхэд бүгд түүн рүү гайхан харлаа.
- Олон хүн гайхан харахыг хараад Гермiona үргэлж уурладаг байв. Тэд яагаад ийм бага уншдаг юм бол!
- Энэ тухай <<Хогвартсын түүх>>-нд бичсэн байсан. Үнэндээ бүгд үнэн зөв биш л дээ. <<Засан сайжруулсан Хогвартсын түүх>>-нд алдаа мадаггүй бичсэн байдаг юм. Эсвэл <<Сонгон шалгаруулсан Хогвартсын түүх. Сайжруулсан толь бичиг>>-ийг уншвал дээр.
- Чи юуны тухай яриад байна? гээд Рон ойлгосонгүй. Харин Харри юу болохыг нь тааварлажээ.
- Гэрийн үйлчлэгч нар! <<Хогвартсын түүх>>-ийн мянган хуудасны нэгэнд ч боолуудад дарамт үзүүлж байсан талаар байгаагүй гэж Гермiona нүдээ гялалзуулан хэлэв.
- Харри толгойгоо сэгсрээд жаврайгаа хутгалаа. Тэд Гермionaгийн гэрийн үйлчлэгчийг хамгаалах хөдөлгөөнд идэвхгүйхэн хандаж байв.
- Үнэнийг хэлэхэд тэд Гермionaг тайвшируулахын тулд хоёр сиклээр Г.Ү.Х.Н гэдэг тэмдэг худалдан авсан юм. Гэхдээ энэ нь мөнгөө салхинд хийсгэсэнтэй адил хэрэг байв. Тэднийг тэмдгээ зүүхийг шаардахын зэрэгцээ бусдыг ч мөн адил ухуулав. Орой болгон Гермiona амралтын өрөөнд ирээд ээлжит золиосоо барьж аван буланд шахаж хамар дор нь шилэн савтай тэмдэг тулгана.
- Та нар ойлго л доо. Чиний орны даавууг сольж, галыг чинь асааж, ангийг чинь цэвэрлэж, хоолыг чинь бэлтгэж байдаг бүтэн армийн дайтай жижигхэн шидтэнгүүд байна. Тэд үүнийхээ төлөө нэг ч сикль авдаггүй. Энэ бол жинхэнэ боолын хөдөлмөр! хэмээн тэр ухуулан хэллээ.
- Невилл тэргүүтэй хүмүүс шилэн сав руу Гермionaгийн муухай харахыг болиулахын тулд хэдэн сикль хийлээ. Зарим нэг нь үүнийг сулхан сонирхож кампанит ажилд дурамжхан нэмэгдлээ. Олонхи нь үүнийг тоглоом наадмаар хүлээн авч байв.
- Рон намрын нарны сүүлчийн цацраг гийгүүлж буй адар руу харав. Фред үхрийн утсан маханд анхаарал тавин (ихрүүд тэмдэг худалдаж авсангүй).

- Гермiona чи хэзээ нэгэн цагт гал зууханд байж үзсэн үү? гэж Жорж асуулаа.
- Мэдээж үгүй. Сурагчдыг орохыг зөвшөөрдөггүй биз дээ... гэж Гермiona эсэргүүцэв.
- Харин бид байсан. Нэг бус удаа хоол хулгайлж байсан юм. Тэгээд гэрийн үйлчлэгч нарыг ч харсан. Тэд тэнд жаргалтай байдаг. Үүнээс сайхан ажил хоёвоод байхгүй гэж боддог юм! гэж Жорж Фредийг нудран хэлэв.
- Яагаад гэвэл тэд боловсролгүй бүдүүлэг! гэж Гермiona хурцаар хэлтэл толгой дээгүүр нь уулийн шуудангын далавч шаржигнан гууглах чимээ гарахад дуугүй болов.

Харри түүн дээр Хэдваг нисэн ирэхийг харлаа. Рон, Гермiona хоёр түүнээс түгшсэн харцаа салгасангүй. Ууль Харрийн мөрөн дээр суугаад далавчаа буулган ядарсан байртай сарвуугаа сунгалаа.

Харри Сириусын захиаг аваад махны хальс өгөхөд Хэдвагийг баяртайгаар идэв. Тэрбээр ихрүүдийг Гурван шидтэний тэмцээний тухай ярьж байгаа эсэхийг магадлаад андууддаа захиаг уншиж өглөө.

Сайхан оролдлого байлаа, Харри!

Би байсан газартаа эргэж ирсэн. Одоо найдвартай нуугдсан байгаа. Надад Хогвартсад юу болж байгаа талаар мэдээлэл өгч байгаарай. Хэдвагийг бүү ашигла өөр уулиар соль. Надад санаа зовохоос илүү өөртөө санаа тавь. Миний сорвины тухай хэлсэн үгийг бүү мартаарай.

Сириус

- Уулиа солих ямар хэрэгтэй гэж? хэмээн Рон аяархан асуув.
- Хэдваг бусад шувуун дундаасаа хэтэрхий ялгаатай. Цасан цагаан өнгөтэй үргэлж нэг газраас нөгөө рүү нисээд байвал анхаарал татаж магадгүй. Цагаан том ууль ховорхон шүү дээ гэж Гермiona хэлэв.

Харри захиаг хуулиад жанчиндаа шургуулахдаа түгших нь багассан байлаа. Сириус аюулгүй газар очсон нь сайн хэрэг. Гэхдээ нөгөө талаас бол Сириус холгүй байгаа болохоор тайван болж илгээсэн захидлынхаа хариуг удаан хүлээх хэрэггүй боллоо.

- Баярлалаа, Хэдваг гээд Харри уулиа илэв. Ууль нойрмог гууглаад хошуугаа зүржийн шүүстэй цомонд дүрээд уулийн байшин руу нисэн одов.

Агаарт баярын уур амьсгал тархав. Хэн ч хичээлд анхаарал хандуулсангүй бүгдийн бодол Шармбатон, Дурмстрангийн зочдод төвлөрчээ. Тэр ч байтугай уусмалын хичээл хүртэл үүнийг эсэргүүцэж чадсангүй. Бүх хичээл хагас цагийн өмнө дуусав. Хонх жингэнэлээ. Харри, Рон, Гермiona гурав цамхаг руугаа яаран очив. Унтлагын өрөөндөө цүнхээ үлдээгээд жанчаа өмсөж үүдний танхим руу шатаар уруудлаа.

Тэнхимийн эрхлэгч нар сурагчдыг эгнээ болгон жагсаав.

- Уизли малгайгаа зас гэж профессор МакГонагалл тушаагаад,
- Хатагтай Патил үс чинь инээдтэй харагдаж байна шүү! гэв.

Парвати муухай хараад гэзгэндээ сүлжсэн том шар эрвээхэйгээ авлаа.

- Миний араас яваарай. Нэгдүгээр дамжааныхан урдаа... битгий түлхэлцээд бай гэж профессор МакГонгалл хэллээ.

Эгнээгээрээ гол шатаар бууж шилтгээнээс гарав. Хүйтэн хэдий ч цэлмэг орой байлаа. Үдшийн зөвхий туяанд хагас тунгалаг сар Хориотой ойн дээгүүр мандаж үзэгдэв. Харри дөрөв дэх эгнээнд Рон, Гермиона хоёрын дунд зогсч байхдаа нэгдүгээр дамжааны Дэннис Криви сэтгэл хөөрсөндөө чичирч байхыг харлаа.

- Удахгүй зургаа болох нь байна. Тэднийг юугаар ирнэ гэж бодож байна? Галт тэргээр юм болов уу? гэж Рон гол хаалгаар орж ирсэн зам руу харж хэллээ.

- Эргэлзэж байна гэж Гермиона хэлэв.

- Тэгвэл яаж? Шүүрээр үү? гэж Харри хэлээд одод түгсэн тэнгэр лүү харлаа.

- Тэгж бодохгүй байна. Тийм ч ойрхон биш шүү дээ.

- Зөөвөрлөгч юм болов уу? Эсвэл тэдэнд арван долоо хүрээгүй байхад нь шилжихийг зөвшөөрсөн байж болох юм? хэмээн Рон таавар дэвшүүлэв.

- Хогвартсын нутаг дэвсгэрт шилжих боломжгүй гэж хичнээн хэлэх юм бэ гэж Гермиона хэлэв.

Андууд бараан тэнгэр лүү анхааралтай харав. Нисэж байгаа зүйлийн өчүүхэн төдий ч шинж тэмдэг мэдэгдэхгүй байлаа. Үргэлж байдаг шигээ тайван нам гүм байв. Харри даарч эхлэв. Зочид ирэх болсон баймаар юм! Тэд ямар нэгэн ер бусын байдалтай байж болох уу! Түүнд ноён Уизлигийн Дэлхийн цомын тэмцээн дээр хэлсэн <<Үргэлж ийм байх юм. Бие биендээ гайхуулах боломжыг алдахгүй шүү>> гэж хэлсэн нь санаанд оров.

Аз болоход Дамблдор сурагчдын сүүлчийн эгнээнд ирээд багш нарын дунд зогсон,

- Аанхан! Хэрвээ би эндүүрээгүй бол Шармбатоны төлөөлөгчид холгүй байна гэж хашгирлаа.

- Хаана? Хаана? гэж хүүхдүүд баярлан толгойгоо эргүүлэв.

- Тэнд! гээд зургадугаар дамжааныхан Хориотой ойн зүг заалаа.

Ямар нэгэн шүүрнээс томхон зүйл тэнгэрт нисэн гарч ирээд хэмжээ нь түргэн томров. Магадгүй зуугаад шүүр юм болов уу.

- Луу! гэж үхтлээ айсан нэгдүгээр дамжааны хүү часхийн орлов.

- Чи чинь тэнэг юм уу? Энэ чинь нисдэг байшин байна! гэж Колин Кривигийн дүү хэллээ.

Түүний таавар үнэнд ойртжээ. Аварга том хар сүүдэр мододын оройг шүргэх алдан нисэхэд шилтгээний цонхонд ойртон ирж буй гайхамшигтай том цэнхэр сүйх тэрэг тусав. Тэр заан шиг том алтан жигүүртэй цагаан дэл бүхий арван хоёр гүү хөллөсөн байлаа.

Сүйх тэрэг доошилоход сурагчдын эхний гурван эгнээ хойшоо ухрав. Сүйх тэрэг галзуурсан хурдтай газардаж чих дүлийрэм дуу гарахад Невилл огло үсрэхдээ тавдугаар дамжааны Слизериний сурагчийн хөл дээр гишгэчихлээ. Морьдын таваг шиг том туурай Хориотой ойн цоорхойд буулаа. Араас нь сүйх тэрэг газардаж аврага том дугуйн дээрээ харайхад алтан морьд толгойгоо сэжлэн том улаан нүдээ бүлтийлгэв.

Сүлдээр чимэглэгдсэн үүд нээгдэн (гуван оч цацруулан зөрөлдсөн хоёр алтан саваа бүхий) цэнхэр жанчтай хүү үсрэн бууж шалны хавьцаа юм тэмтчээд алтан шат буулгалаа. Тэр хойшоо хүндэтгэлтэй үсрэн ухрав. Тэгтэл сүйх тэрэгнээс гялалзсан өндөр өсгийтэй хүүхдийн чарганы хэмжээтэй том хар шаахай гарч ирээд түүний араас гайхамшиг төрөм үзэгдэл болох эзэн нь гарч ирэв. Тийм аварга биетийг Харри амьдралдаа харж байсангүй. Сүйх тэрэг болон морьдын хэмжээг энэ тайлбарлаад өглөө. Хэдэн хүүхдүүд дуу алдав.

Зөвхөн ганц Хагрид л түүнтэй дүйцэж очих агаад бас ч гэж хэдэн инч дутуу байв. Тэр Хагридад дассан хэдий ч шатны эхний гишгүүр дээр зогсоод мэгдсэн үзэгчдээ тойруулан харах эмэгтэй ер бусын хэмжээтэй санагджээ. Тэр шилтгээний цонхноос тусч байсан гэрэлд гарахад чидун жимсний өнгө бүхий үзэсгэлэнтэй царай, тунгалаг том хар нүд, бүргэд хамар, гялалзсан пөмбөгөр үстэй нь илт болов. Хатагтай хөлөөсөө толгой хүртэл хар атлаасан дашинз өмсөж хүзүү болон бүдүүн хуруунд нь гайхамшигтай сайхан опал гялсхийв.

Дамблдор алга ташив. Сурагчид даган алга таших зуураа олонхи нь аварга биетийг сайн харахын тулд өлмийгөө өргөж байлаа.

Тэр царайдаа ялдам инээмсэглэл тодруулан Дамблдор руу алхаж очоод үнэт чулуу гялалзсан гараа сунгав. Сургуулийн захирал бөхийн гарыг нь үнслээ.

- Хүндэт хатагтай Максим! Хогвартсад тавтай морилоорой!

- Дамблэ-дорр. Таны бие-е-е сайн гэдэгт найдна? хэмээн хатагтай Максим гүн хоолойгоор хэлэв.

- Баярлалаа. Би маш сайн байна гэж Дамблдор хэлэв.

- Миний сурагчид гээд тэр том гараа хайхрамжгүйхэн даллав.

Харри хатагтай Максимд анхаарал татагдаад сүйх тэрэгний сүүдэрт зогсож буй арван тав зургаан настай хүүхдүүдийг сая л олж харлаа. Тэд арвуулаа торгоор хийсэн жанч өмссөн байх агаад бүгд даарсандаа чичирч байсанд гайхах явдалгүй байлаа. Зарим нь толгойгоо дулаан ороолтоор ороосон харагдана. Харри тэдний (сурагчид хатагтай Максимийн аварга том сүүдэрт нуугджээ) айсан янзтай шилтгээн рүү харж байхыг олж харлаа.

- Кар-ркарров ирсэн үү? гэж хатагтай Максим асуув.

- Хормын дараа ирнэ. Та түүнтэй энд мэндчилэх юм уу эсвэл шууд шилтгээн рүү явах уу?

- Шилтгээн рүү явсан нь дээр байх. Энд хүйтэн юм. Зөвхөн энэ моринууд...

- Манай шидэт амьтаны хичээлийн багш тэдэнд санаа тавихдаа баяртай байх болно. Тэр багахан явдлын учрыг олоод удахгүй ирнэ. Түүний... асрамжинд байсан амьтдад анхаарал шаардагдаад.

- Соплохвостууд гэж Рон Харрид шивнээд инээлээ.

- Миний морьдод сайн хашаа хэрэгтэй. Тэд их хүчтэй гэж хатагтай Максим шидэт амьтны хичээлийн багш морьдыг нь дийлэх эсэхэд харамссан янзтай хэллээ.

- Хагрид энэ ажилд хэнээс ч илүү гэдэгт итгэ хэмээн Дамблдор инээмсэглэв.

- Ихх сайн-байна! Ноён 'Агридад миний морьд зөвхөн арвайн шарз уудаг гэж хэлээрэй гээд хатагтай Максим үл ялиг бөхийлөө.

- Заавал дамжуулна гээд Дамблдор бас хариу бөхийв.

- Миний араас гээд хатагтай Максим сурагчдаа даллав.

Хогвартсын сурагчид хуваагдан тэднийг дундуураа өнгөрүүлэв.

- Дурмстрангынхан хэр том мориор ирэх бол? гэж Симус Финниган Харри, Рон хоёрт Парвати Патилийн толгой дээгүүр өндөлзөн хэлэв.

- Үүнээс ч том байвал Хагрид тэднийг дийлж чадахгүй. Хэрвээ түүнийг соплохвостууд дуусгачихгүй бол шүү дээ. Тэдэнд юу тохиолдсон юм бол? гээд Харри толгойгоо сэгсэрлээ.

- Тэд зугтчихсан юм болов уу? гэж Рон найдангуй хэлэв.

- Бурхан минь! Тийм амьтдыг шилтгээний нутаг дэвсгэрээс зугтаж байна гээд төсөөлөөд үз дээ хэмээн Гермiona давхийлээ.

Дурмстрангынхныг ирэхийг хүлээх зуур хүйтэн ясанд хүртэл жиндэж байв. Хэн нэг нь тэнгэр рүү найдангуй харав. Нам гүмийг зөвхөн хатагтай Максимийн морины туурайн чимээ болон тургилах дуу эвдэж байв.

- Сонсож байна уу? гэж Рон гэнэтхэн дуу алдав.

Хаа нэгтээ харанхуйгаас аймаар чимээ чангарсаар тэдний зүг ойртон ирлээ. Энэ хүржигнэх дуутай төстэй сонсогдох бөгөөд аварга том тоос сорогч усан дээгүүр хөвж байгаа юм шиг санагдуулна.

- Нуур! Нуур луу хараач! гэж Ли Жордан хашгирав.

Тэдний зогсож байсан газар нугын өндөрлөг хэсэг байсан болохоор харанхуй усны гөлгөр гадарга сайтар харагдаж байв. Гадарга гэнэтхэн оволзон булгилав. Нуурын голд дараа нь аварга том хөөс гарч ирснээ эргүүлэг үүсч том далбаа гарч ирлээ. Эргүүлгийн яг голоос ут хар багана гарч ирэн улам өсөн нэмэгдсээр тоноглол нь үзэгдэв.

- Энэ бол шураг! гэж Харри Рон, Гермiona хоёрт тайлбарлав.

Аварга том хөлөг онгоц ус зүсэн удаанаар гарч ирээд сарны гэрэлд гялалзав. Энэ нь сүйрлээс сэргээгдсэн юм шиг хачирхалтай ядуулаг төрхтэй агаад бүүдгэр гэрэлтэй хөлөг онгоцны цонх хий үзэгдлийн нүд адил гэрэлтэн байлаа. Эцэст нь чанга ус

цалгих чимээ дуулдаж хөлөг онгоц бүхлээрээ гарч ирээд хөөсрөн бургिलाх усан дээр эрэг лүү хөвлөө. Төдхөн гүехэн усанд зангуу хаях чимээ гарч эргийн нам усанд банз падхийв.

Хөлөг онгоцны цонхоор эрэгт буух гэж буй хүмүүсийн сүүдэр үзэгдэв. Тэд Крэбб, Гойл хоёр ч хавьтахааргүй том биетэй байлаа. Гэхдээ тэднийг шилтгээний цонхны гэрэлд гарахад Харри тийм ч том биш бөгөөд зөвхөн үстэй дээл өмссөнийг олж харлаа. Түрүүлж ирсэн хүн үс шигээ гялалзсан мөнгөлөг дээл өмсчээ.

- Дамблдор! Хуучин найз минь юу байна даа? гэж тэр налуу газар өгсөн гарч ирэхдээ баяртай дуу алдав.

- Баярлалаа, маш сайн байна профессор Каркаров.

Каркаров зөөлөн нялуун хоолойтой аж. Дамблдорын адил өндөр туранхай агаад буурал үс нь богинохон, үзүүр нь мушгирсан ямаан сахалтай байлаа. Тэр Дамблдор руу очоод гарыг нь чанга атгалаа.

- Хуучин Хогвартс минь гээд тэр шилтгээн рүү харж инээмсэглэв. Түүний шүд шар бөгөөд инээмсэглэл нь хүйтэн харцтайгаа зохицохгүй ажээ.

- Энд ирсэн маань ямар сайхан хэрэг вэ... ямар сайн... Виктор нааш ир. Дулаац. Та эсэргүүцэхгүй биз дээ, Дамблдор? Виктор толгойгоо хүйтэн усанд хальт...

Каркаров нэг сурагчаа занган дуудав. Биерхүү бүргэд хамартай, өтгөн хар хөмсөгтэй залуу байлаа... Түүнд андыгаа нудрах хэрэг байсангүй. Рон хэдийн таньчихаад чихэнд нь шивнэж байлаа.

- Харри, энэ Крам байна.

БҮЛЭГ 16: ГАЛТ ЦОМ

- Нүдэндээ ч итгэхгүй нь! гэж Рон мэгдсэн хоолойгоор дуу алдав.

Хогвартсынхан зочдоо дагалдан чулуун шатаар өгслөө. Рон ухаангүй хөөрчээ.

- Крам! Төсөөлж байна уу, Харри? Виктор Крам шүү дээ!!!

- Бурхан минь, Рон. Тэр чинь ердөө квиддичийн тоглогч шүү дээ гээд Гермиона мөрөө хавчлаа.

- Ердөө квиддичийн тоглогч гэнэ шүү! Гермиона чи мэддэггүй юм уу? Энэ чинь дэлхийн хамгийн хүчтэй баригч! Би түүнийг сурагч гэдгийг мэдсэнгүй! гэж Рон чихэндээ итгэхгүй шахам хэлэв.

Тэднийг үүдний танхимд ороход Хогвартсын сурагчид Их танхим руу чиглэж байх агаад Харри Ли Жордан, Виктор Крамын шилэн хүзүүг харахын тулд өлмий дээрээ үсэрч байхыг харав. Хэдэн зургадугаар дамжааныхан жанчныхаа халаасыг уудалцгаана.

- Байж боломгүй юм. Надад нэг ч үзэг алга! Яах вэ!

- Тэр малгайн дээр уруулын будгаар гарын үсэг зурах болов уу?

- Үнэн үү! гэж Гермиона аяархан хэлээд уруулын будагны тухай маргалдаж байгаа охидын хажуугаар өнгөрлөө.

- Би ч гэсэн түүний гарын үсгийг авахаас буцахгүйсэн. Харри чамд үзэг байна уу? гэж Рон асуув.

- Алга. Дээр цүнхэндээ үлдээчихэж.

Андууд ширээ лүүгээ очлоо. Рон Крамыг харахын тулд үүдний хаалга руу харан суулаа. Дурмстрангынхан хаана суухдаа итгэлгүй бөөгнөрчээ. Шармбатоны зочид хэдийн Когтевраны ширээнд суужээ. Тэд Их танхимыг дүнсгэр царайлан харцгаана. Тэдний гурвын толгой дулаан ороолтоор ороолтой хэвээр байлаа.

- Тийм ч хүйтэн биш байна. Дээлээ авчирхад хэцүү байлаа гэж үү? хэмээн Гермиона уурсав.

- Нааш ир. Бидэнтэй суугаач! Гермиона цаашаа суугаад зай гарга... гэж Рон зочдоо даллав.

- Юу?

- Хоцорчихлоо гэж Рон гашуунаар хэлэв.

Виктор Крам болон нэг ангийнхан нь Слизериний ширээ лүү хөдлөв. Крэбб, Гойл хоёр хөөрсөндөө тэнгэрт гарах нь холгүй байлаа. Малфой Крамтай яриа хөөрөө үүсгэв.

- Бялдуучлаад бай, Малфой гэж Рон зэвүүцэн хэлээд,

- Крам чамайг нэвт харна гэдэгт мөрийцөхөд ч бэлэн байна. Ингэхэд тэд хаана унтах нь юм бол? Харри... тэдэнд унтлагын өрөөгөө өгөх үү! Би түүнд ороо өгөхөд бэлэн байна! Харин өөрөө газар унтчихъя гэв.

Гермиона тургилав.

- Тэд Шармбатоныхнаас хөгжилтэй юм гэж Харри хэлэв.

Дурмстрангынхан үстэй дээлээ тайлж одод түгсэн харанхуй адар руу сониучирхан ширтэв. Зарим нь бахадсанаа нуулгүй алтан таваг цомыг эргүүлэн сонирхоно.

Сургуулийн харуул Филч хуучин загварын элэгдсэн хормой бүхий ёслолын хувцас өмсөөд багш нарын ширээнд Дамблдорын баруун зүүн талд дөрвөн суудал нэмэв.

- Гэхдээ ердөө хоёр профессор ирсэн биз дээ. Филч яагаад дөрвөн сандал тавьж байгаа юм бол. Хэн нэг нь бас ирэх юм болов уу? гэж Харри гайхлаа.

- Аа? гэж сэтгэлээр унасан Рон асуугаад Крамыг хомхойрон харав.

Эцэст нь бүх сурагчид суудлаа эзлэхэд багш нар ширээндээ сууж профессор Дамблдор, профессор Каркаров, хатагтай Максим нар орж ирцгээлээ. Өөрийн захирлаа хараад Шармбатоныхан босон харайлаа. Хэдэн сурагч инээлдэв. Хатагтай Максим Дамблдорын зүүн гарт суув. Дамблдор босоход Их танхимд нам гүм боллоо.

- Оройн мэнд ноёд, хатагтай, хий үзэгдэл болон манай зочидоо. Хогвартсад ирсэн явдалд чинь их баяртай байна! Та нарыг энд ая тухтай байна гэдэгт итгэлтэй байна гэж гадны зочдод хандан инээмсэглэн хэлэв.

Энэ үгийн дараа толгойгоо ороолтоор боосон Шармбатоны нэг охин чанга инээв.

- Хэн ч чамайг энд бариагүй гэж Гермиона таагүйхэн бувтналаа.

- Гурван шидтэний тэмцээний албан ёсны нээлт цайллагын төгсгөлд болно. Хүндэт найзууд минь тавтай морилоорой. Идэж ууж гэртээ байгаа юм бай!

Дамблдор суухад Каркаров түүн рүү бөхийн ямар нэг юмны талаар ярилцаж эхэллээ.

Тавагнууд ердийнхөөрөө нүд ирмэх зуур хоол дүүрэв. Энэ удаад гэрийн үйлчлэгч нар хичээн ажилласан бололтой. Зөвхөн олон төрлийн амтат зоог байгаад зогсохгүй гадаадын хоол хүртэл байлаа.

- Энэ юу вэ? гэж Рон асуугаад йоркширийн чунзны дэргэд байгаа том тавагтай хоолыг заав.

- Буйябес гэж Гермиона тайлбарлав.

- Юу гэнээ? хэмээн Рон гайхлаа.

- Франц хоол байгаа юм. Би түүнийг өнгөрсөн зуны амралтаар идэж үзсэн. Их амттай шүү.

- Чиний үгэнд итгэж байна гэж Рон хэлээд чунзнаас хийж авлаа.

Их танхимд ойролцоогоор хорин сурагч нэмэгдсэн болохоор ердийнхөөс арай давчуу байлаа. Магадгүй зочдын дүрэмт хувцаснаас болсон байх. Хогвартсынхны

хар хувцсан дунд Дурмстрангынхны дээлэн доторх час улаан жанч ялгаран харагдана.

Хорин хормын дараа хаалгаар Хагрид орж ирээд багш нарын ширээ рүү явлаа. Ердийн суудалдаа суугаад зузаан боолттой гараар Харри, Рон, Гермиона гурав руу даллав.

- Соплохвостууд хэр байна даа, Хагрид? гэж Харри асуув.

- Өсч өндийж байгаа гэж ойн сахиул нүүр дүүрэн инээмсэглэв.

- Тодорхой байна. Тэд идэх хоолоо олсон бололтой. Хагрид хуруунууд гэж Рон аяархан хэлэв.

- Өршөөгөөрэй, буйя-а-бес! авч болох уу гэх хэн нэгний хоолой гарлаа.

Энэ бол Дамблдорыг үг хэлэх үед инээдээ барьж тэсээгүй Шармбатоны охин байлаа. Тэр ороолтоо тайлж бүсэлхийгээ хүрсэн мөнгөлөг цагаан үсээ унжуулжээ. Том цэнхэр нүд, жигд цагаан шүд нь профессор Локонсийн инээмсэглэлийг санагдуулна.

Рон чихээ хүртэл улайв. Тэр охин руу харж амаа ангайсан хэдий ч сулхан хоржигнох чимээнээс ондоо дуу гарсангүй.

- Тэгэлгүй яахав гээд Харри түүн рүү дийзийг түлхэв.

- Та нар идчихсэн юм уу?

- Т-иймээ и-их амттай байсан гэж Рон ээрэн хэлэв.

Охин хоолыг аваад Когтевраны ширээ рүү болгоомжтой аваачлаа. Рон түүний араас бүлтийн ширтэнэ. Түүний байдал Харрийн инээдийг хүргэлээ.

- Вейлатай төстэй юм! гэж Рон сөөнгөтөн хэлэв.

- Тэнэг гэдэг нь. Чи ганцаараа түүн рүү гөлийгөөд байна гэж Гермиона уурсан хэлэв.

Гэвч тэр эндүүрчээ. Олонхи сурагчид Роны адил ухаанаа алдсан янзтай охин руу харж байлаа.

- Чамд хэлэхэд тэр дэлхий дээрх хамгийн ер бусын охин байна! Хогвартсад лав байхгүй гэж Рон түүнийг хараанаасаа алдахгүйн тулд суудал дээрээ эргэлдэн хэллээ.

- Хогвартст илүү дээр байгаа шүү дээ! гэж Харри хэлээд цайвар үстэй охиноос холгүйхэн сууж байгаа Чжоу Чанг руу хяламхийв.

- Та хоёр гөлийхөө больж үз! Танхимд хэн орж ирснийг хараач гэж Гермиона уурлав.

Тэр багш нарын ширээ рүү дохилоо. Хоёр хоосон сандал эзэнтэй болжээ. Профессор Каркаровын хажууд Людо Бэгмен харин хатагтай Максимын зүүн талд Персигийн дарга ноён Крауч байлаа.

- Тэд энд юу хийж байгаа юм бэ? гэж Харри гайхлаа.

- Тэд Гурван шидтэний тэмцээний зохион байгуулагч. Тэмцээний нээлтэнд оролцохоор ирээд байна гэж Гермиона үргэлж ихийг мэддэгээрээ хэлэв.

Төдхөн хоёрдугаар хоол ирэхэд дунд нь бас мэдэхгүй амттангууд байлаа. Рон Когтевраны ширээнд сууж байгаа цайвар үстэй охиныг харуулахын тулд амттангуудыг баруун тийш шилжүүлэн тавив. Гэхдээ вейлатай адилхан охин цадсан бололтой тэдэн дээр ирсэнгүй.

Эцэст нь алтан тавагнууд хоосроход Дамблдор ахиад л суудлаасаа босов. Танхим нам гүм боллоо. Харри сэтгэл хөөрөн догдлохоо мэдэрчээ. Ихрүүд захирал руу маш анхааралтай ширтэнэ.

- Ёслолын мөч ойртлоо. Гурван шидтэний тэмцээн удахгүй нээлтээ хийнэ. Түүний өмнө авчирсан хайрцагныхаа талаар хэдэн үг хэлэх гэсэн юм хэмээн Дамблдор сурагчид руу инээмсэглэн хэлэв.

- Юу авчирсан гэнэ ээ? хэмээн Харри ойлгосонгүй.

Рон мөрөө хавчив.

- ...би энэ жил болох тэмцээний тухай товч тайлбар хийхийг хүсч байна. Гэхдээ түүний өмнө мэдэхгүй хүмүүст зориулан олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга ноён Бартемиус Краучыг танилцуулахыг зөвшөөрнө үү. Харин энэ бол Людо Бэгмен ид шидийн спорт тоглоомын хэлтсийн дарга гэж хэлэхэд сонсогчид хүндэтгэлтэйгээр алга ташив.

Бэгменд илүү чанга алга ташилт оногдов. Магадгүй түүний довтлогчийн алдар хүндээс л болсон байх учир нь илүү нөхөрсгөөр хандаж байлаа. Бэгмен алга ташилтын хариуд нүд гялбам инээмсэглэж гараа даллав. Харин баргар царайтай Бартемиус Каруч Дамблдор нэрийг нь дурьдахад хөмсгөө ч хөдөлгөсөнгүй. Дэлхийн цомын тэмцээн дээр түүний сайхан хослолтой байхыг харсан Харрид одоо шидтэний жанч өмссөн нь эвгүй санагдана. Түүний нямбайлан тэгшилсэн сахал нь Дамблдорын урт мөнгөлөг үс сахалтай хачирхалтай хосолж байлаа.

- Ноён Бэгмен болон ноён Крауч нар тэмцээнийг зохион байгуулахын тулд хэдэн сарын турш амралтгүй ажилласан юм. Ингээд аваргуудыг шүүх шүүгчдийн баг маань бүрдлээ гэж Дамблдор үргэлжлүүлэв.

Түүнийг “аварга” гэж хэлэнгүүт танхим даяараа үг алдахгүйг хичээн чагналаа. Дамблдор гэнэтийн чимээгүй болсон явдалд инээмсэглэн,

- Ноён Филч хайрцаг аваад ирээч гэлээ.

Филч энэ мөчийг хүртэл хаа нэгтээ алсын буланд нуугдаж байснаа багш нарын ширээнд үнэт чулуу шигтгэн сийлбэрлэсэн эртний модон хайрцаг барьсаар хүрч ирэв. Танхим шуугин өндөлзлөө. Жижигхэн биетэй Дэннис Криви хөршүүдийнхээ толгой дээгүүр харахаар сандал дээрээ босч зогсов.

Филч хайрцагыг Дамблдорын өмнө болгоомжтой тавихад тэрбээр,

- Тэмцээний заавар ёсоор даалгаваруудад ноён Крауч, ноён Бэгмен хоёр шалгалт хийсэн. Тэмцээн болгоны бүх зүйл бэлэн болсон. Гурван сорилт хичээлийн жилийн дундуур явагдах бөгөөд аваргууд хүнд сорилтыг... шидэт чадвар эр зоригоороо даван туулах болно.

Түүний сүүлчийн үгийг танхим амьсгаа даран сонсов. Дамблдор үргэлжүүлэн,

- Тэмцээнд сургууль бүрээс сонгогдсон гурван аварга оролцох болно. Тэднийг тэмцээн бүрийн дараа оноогоор дүгнэнэ. Бүх даалгаварт хамгийн өндөр оноо цуглуулсан аварга ялах болно. Аваргыг шударга шүүгч буюу Галт цом сонгоно гэв.

Дамблдор шидэт саваагаараа хайрцагны тагыг гурван удаа тогшив. Таг алгуур чахран онгойв. Дамблдор гараа дотогш шургуулан том бүдүүлэг хийцийн эртний модон цом гаргаж ирэв. Энэ нь ирмэгээрээ цухалзах цэнхэр дөлийг эс тооцвол онцлох зүйлгүй ердийн цом байлаа. Дамблдор хайрцагны тагыг хаагаад цомыг болгоомжтойгоор бүгдэд харуулахаар хайрцаг дээр тавив.

- Шалгаруулалтанд оролцохыг хүсэгч нэрээ цаасан дээр сургуулийн хамт тодорхой бичээд цомд хийх ёстой. Аварга болохыг хүсэгчдэд нэрээ дэвшүүлэх хорин дөрвөн цагийн хугацаа өгч байна. Цомыг танхимд маргаашийн үдэш хүртэл байрлуулах болно. Маргааш орой Хэллоуйны баярын үеэр цом Гурван шидтэний тэмцээнд сургуулиа төлөөлөн оролцогчын нэрийг сонгоно. Цомыг танхимын хонгилд өнөө шөнө байруулах тэмцээнд оролцохыг хүссэн хүн бүрийг хүлээн авна. Тэмцээнд оролцогч нь арван долоон нас хүрсэн байх ёстой. Харин арван долоон нас хүрээгүй хүнийг оролцуулахгүйн тулд би цомыг тойруулан хориотой шугам татах болно. Арван долоон нас хүрээгүй хэн ч энэ шугамыг давж чадахгүй.

- Эцэст нь би тэмцээнд оролцогсдыг шударга өрсөлдөөсэй гэж хүсч байна. Аваргыг Галт цом нэг л удаа сонгох бөгөөд тэмцээний төгсгөл хүртэл оролцох ёстой. Нэрээ цомд хийснээрээ та бүхэн шидэт гэрээ байгуулж байгаа бөгөөд үүнийг зөрчих боломжгүй юм. Иймээс нэрээ цомд хийхээс өмнө үнэн зүрхнээсээ тэмцээнд оролцохыг хүсч байгаа эсэхээ сайн бодоорой. Одоо найзууд минь унтах цаг болж. Бүгдэд тавтай нойрсохыг хүсье.

- Насны хориотой шугам! Түүнийг хөгшрүүлдэг уусмал хуурч чадах байх. Бидний нэр цомд орох үед <<ура>> хашгирах болно доо! Цомд чиний хэдэн настай чинь хамаагүй! гэж Фред танхимаас гарахдаа нүдээ гялалзуулан дуу алдав.

- Насан хүрсэн гэдэгтээ байгаа юм биш. Бид тэмцээнд оролцох хангалттай мэдлэгтэй биш гэдэгт байгаа юм гэж Гермiona эсэргүүцэв.

- Наад үгээ зөвхөн өөртөө хэл гэж Жорж уурсаад,

- Харри оролдоод үзэхийг хүсч байгаа биз дээ? гэлээ.

Харри Дамблдорын үгийг санаж байлаа. Арван долоон наснаас доош бүх хүнд тэмцээнд оролцох хориотой гэсэн. Гэтэл тэмцээний ялагч болсон гайхамшигтай дүр зураг ахин зурсхийв... Сайхан л хэрэг! Гэхдээ Дамблдор яах бол? Тэр арван долоон нас хүрээгүй хүн хориотой шугамыг давсныг мэдээд яаж уурлах бол...

- Тэр хаашаа явчихав аа? Дамблдор Дурмстрангын зочид хаана байхыг хэлээгүй биз дээ? гэж Рон яриаг хайхралгүй олон хүний дунд Крамыг хайж хэлэв.

Хариултыг хүлээх хэрэг гарсангүй. Андууд Слизериний ширээ рүү харахад Каркаров сурагчидтайгаа бужигнаж байлаа.

- Бүгд хөлөг онгоц руугаа буц. Виктор чи ямаршуу байна даа? Сайн идэв үү? Би чамд гал зуухнаас дарс авчируулах уу?

Крам толгойгоо сэгсрээд дээлээ өмсөв.

- Профессор, би дарс уумаар байна гэж өөр сурагч хэлэв.

- Би чамд хэлээгүй шүү, Поляков. Салан амьтан минь чи ахиад л хоолоо жанч руугаа асгачихаа юу гэж Кракаров зандрахад эцэг ёсны халамжлангуй өнгө агшин зуур алга болов.

Тэр эргээд сурагчдын хамтаар хаалга руу явлаа. Андууд танхимаас гарахад Харри Каркаровд зай тавьж өглөө.

- Баярлалаа гээд Каркаров Харри руу хяламхийн харлаа.

Тэгээд гайхан хөшсөнөө нүдэндээ итгэхгүй байгаа мэт харав. Түүний дагалдагчид бас зогсоод Харри руу сониучирхан харахад олонхийн нь царайд айдас тодров. Хоол болсон жанчтай залуу дэргэдээ зогсож байгаа охиныг ёвроод Харригийн дух руу хуруугаараа заав.

- Тиймээ, энэ Харри Поттер гэж хэн нэгэн сөөнгөтөв.

Профессор Каркаров огцом эргэн харлаа. Хурц нүдэт Грюм таягаа тулан зогсоод шидэт нүд нь Дурмстрангын захирал руу цавчилгүй ширтэж байв.

Каркаров уурласан айсандаа цонхийн цайгаад,

- Чи! гэсэн ганцхан үг л хэллээ.

- Тиймээ, би. Хэрвээ чамд Харри Поттерт хэлэх үг байхгүй бол эелдэгээр саатуулалгүй явж үз. Чи зам хаагаад байна гэж Грюм баргар царайлан хэлэв.

Юу гэвэл энэ үнэн байлаа. Грюмын ард танхим даяараа цуглараад хаалга чөлөөлөхийг хүлээж байв. Хүүхдүүд бие биенийхээ мөрөн дээгүүр харан юу болсныг ойлгохыг хичээнэ.

Каркаров нэг ч үг хэлэлгүй сурагчдынхаа хамтаар явав. Грюм түүний араас шидэт нүдээрээ удтал харахад зэрэмдэг царайд нь дургүйцсэн өнгө тодров.

Бямба гаригт сурагчид өглөөний цайндаа оройхон босов. Энэ удаад Харри, Рон, Гермiona гурав ч эрт боссонгүй. Танхимд хэдийн хориод хүн ирсэн байлаа. Зарим нэг нь шарсан талх идэх зуураа Галт цомоос нүд салгалгүй ширтэнэ. Цомыг танхимын голд шидэт бүрх малгай тавьдаг сандал дээр байрлуулжээ. Түүний тойруулаад гурван метрийн зайд шалан дээр дугуй алтан шугам татсан байлаа.

- Хэн нэгэн цомд нэрээ хийсэн үү? гэж гурав дугаар дамжааны охиноос Рон тэсч ядан асуув.

- Дурмстрангынхан бүгд нэрээ хийсэн. Харин Хогвартсаас би хэнийг ч харсангүй.

- Шөнө хэн нэгэн хийсэн гэдэгт итгэлтэй байна. Би тэгж л хийх байсан. Тийм үед бүгд хараад байх нь таагүй шүү дээ. Гэнэт цом чиний нэрийг нүүр лүү чинь нулимвал яана гэж Харри хэллээ.

Харрийн ард хэн нэгэн хөхрөв. Тэр эргэж хараад ихрүүд болон Ли Жорданыг олж харлаа. Тэд шатны дороос гүйж гарч ирэхдээ ихэд баяссан төрхтэй байлаа.

- Болчихлоо. Бид түүнийг уучихсан! гэж Фред Харри, Рон, Гермиона гуравт ялгуусан хоолойгоор шивнэв.

- Юу гэнээ? гээд Рон ойлгосонгүй.

- Хөгшрүүлдэг уусмал уучихсан гэж Фред тайлбарлав.

- Ердөө л нэг дусал. Бидэнд арван долоо хүрэхэд хэдхэн сар дутуу байсан юм гэж Жорж гэрэлтсэн царайгаар хэлэв.

- Бидний хэн ялсан нь мянган галлеоноо хуваах юм! гээд Лигийн царайд нүүр дүүрэн инээмсэглэл тодров.

- Би үүнийг бүтнэ гэж бодохгүй л байна шүү. Дамблдор энэ талаар бодсон гэдэгт итгэлтэй байна хэмээн Гермиона анхааруулав.

Тэд Гермионагийн үгийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлэв.

- Бэлэн үү? Би түрүүлж орно! Миний араас! гэж Фред сэтгэл хөөрсөндөө чичрэх нөгөөдүүлээсээ асуув.

Харри гайхал төрүүлэм зүйл харлаа. Фред халааснаасаа <<Фред Уизли, Хогвартс>> гэж бичсэн цаасны тасархай гаргаж ирээд шугамын өмнө арван таван метрийн зайд харайх гэж буй аятай зогслоо. Тэгээд гүнзгий амьсгаа аваад бүгдийн нүдэн дээр алтан шугамыг давлаа.

<<Үнэхээр хуурчихлаа гэж үү?>> хэмээн Харри хормын нэг хувьд бодов. Жорж ч мөн адил итгэжээ. Тэр ялсан дуу хашгираад огтхон ч алгуурлалгүй ахынхаа араас үсрэв. Дараагийн агшинд чанга тасхийх чимээ гарч ихрүүд үл үзэгдэх гольфын цохиураар цохиулсан аятай алтан шугам дээгүүр чулуудагдав. Агаарт гурван метр нисээд хүйтэн чулуун шалан дээр янгинатал газарджээ. Хоёр дахь удаа тасхийгээд ихрүүдэд урт цагаан сахал ургав.

Танхимд байсан бүх хүн түүний дотор Фред, Жорж хоёр ч инээлдэв. Тэд шалан дээрээс босож бие биенийхээ сахалтай царай луу харлаа.

- Би анхааруулсан биз дээ гэх Дамблдорын намуухан дуу гарахад түүний нүдэнд хөгжилтэй оч дүрсхийн үзэгдэв.

- Би та хоёрыг хатагтай Помфри руу очихыг зөвлөх байна. Тэр хэдийн Когтевраны хатагтай Фосетт болон Пуффендуйн ноён Саммерсыг эмчилж байгаа. Тэд ч бас хөгшрүүлдэг уусмал уусан юм. Гэхдээ тэдний сахал та нарыхтай харьцуулалтгүй л дээ.

Фред, Жорж хоёр эмнэлэг рүү гарахад нулимсаа гартал инээсэн Ли дагалдав. Харри, Рон, Гермиона гурав мөн инээлдээд өглөөний цайгаа уухаар яарав. Их танхимын чимэглэлийг Хэллоуиныхаар сольжээ. Шидэт адарт сарьсан багваахай нисэлдэн нүд

ам гаргасан зуугаад хулуу хөөрөлдөнө. Харри Дин, Симус хоёртой суугаад Хогвартсынхаас хэн нэрээ цомд хийсэн талаар хөөрөлдөв.

- Уоррингтон хийсэн гэх цуу үг явж байна лээ. Слизериний лазан том залуу.

Уоррингтон Слизериний багт тоглодог бөгөөд Харри түүнийг сайн мэдэх юм. Цом Слизеринийхнээс хэн нэгийг бүү сонгоосой билээ! Харри жигшсэндээ давхийлээ.

- Харин Пуффендуйнхан Диггориин талаар ярилцаж байна. Энэ сайхан залуу гадаад төрхөө эрсдэлд оруулахаар шийджээ хэмээн Симус зэвүүцэнгүй хэлэв.

- Чимээгүй! гэж Гермиона гэнэт хэллээ.

Танхимын гадаа хөөрсөн хоолой сонсогдов. Гриффиндорынхон толгойгоо эргүүлэн харахад квиддичийн багийн ангууч Анжелина Жонсон ичингүйрэн инээмсэглэсээр орж ирэв.

- За. Би нэрээ хийчихлээ гэж тэр найзуудын дэргэд суунгаа хэлэв.

- Чи тоглож байна уу? гэж Рон гайхлаа.

- Чи арван долоо хүрчихсэн юм уу? гэж Харри асуув.

- Мэдээж хүрсэн. Чи сахлыг нь харахгүй байна уу? гэж Рон цаашлуулав.

- Өнгөрсөн долоо хоногт хүрсэн гэж Анжелина хэллээ.

- Гриффиндорынхноос хэн нэг нь нэрээ хийсэнд би ямар их баяртай байна гээч! Цом чиний нэрийг сонгох байх гэж найдаж байна, Анжелина! хэмээн Гермиона хэлэв.

- Баярлалаа Гермиона гээд тэр инээмсэглэв.

- Чи тэр сайхан залуу Диггороос хамаагүй дээр гэж Симус Пуффендуйнхан руу харж хэлэв.

- Бид өнөөдөр юу хийх билээ? гэж Рон андуудаасаа танхимаас гарахдаа асуулаа.

- Бид Хагридын удтал очсонгүй гэж Харри сануулав.

- Гүйгээрэй тэр бидэнд хуруугаараа соплохвостыг хэрхэн тэжээсэн тухай ярих байх гэж Рон зөвшөөрөв..

Гермионагийн царай гэнэт туяарлаа.

- Би яагаад урьд нь энэ тухай бодсонгүй вэ! Хагридыг нийгэмлэгтээ элсэхийг урих хэрэгтэй юм байна! Намайг энд хүлээж байгаарай, би одоохон тэмдгэндээ гүйгээд ирье.

- Юу түүнийг хатгаа вэ? гэж Рон унтууцан хэлээд гантиг шатаар гүйн одож байгаа Гермионагийн араас харлаа.

- Хараач, Рон. Чиний найз... явж байна гээд Харри найзыгаа нудрав.

Танхимын үүдний хаалгаар Шармбатоньхон орж ирэхэд дунд нь вейлатай төстэй охин явж байлаа. Тэд цомыг тойрон цуглаад сониучирхан харав. Хатагтай Максим хамгийн сүүлд орж ирээд Галт цом руу чиглэв. Зочдын нэг нь алтан шугамыг алхаж хуудас цаас цэнхэр цагаан дөл рүү хийхэд улаан оч дүрсхийв.

- Цом тэднийг хэнийг ч сонгохгүй бол яах бол? гэж Рон Харрид шивнээд охиныг гал руу цаас хийхийг харав.

- Чинийхээр бол тэд гэртээ харих болов уу эсвэл тэмцээнийг харахаар үлдэх болов уу?

- Мэдэхгүй. Үлдэх байх. Хатагтай Максим шүүгч шүү дээ.

Шармбатоньхан нэрээ цомд хийж дуусахад хатагтай Максим тэднийг дагуулан гадагш гарав.

- Тэд хаана унтсан юм бол? гээд Рон хаалга руу дөхөн араас нь харав.

Ард нь тачигнан гүйх чимээ гараад Гермiona хайрцаг дүүрэн тэмдэгтэй буцаж иржээ.

- Ашгүй ирэв үү! гээд Рон чулуун шатаар вейлагаас нүд салгалгүй яаран уруудан Хагридын овоохой руу явж байгаа хатагтай Максимын араас явлаа.

Андууд мөн тэр зүг явав. Түүн рүү дөхөж очоод Рон түүнийг зовоож байсан асуултынхаа хариуг харлаа. Овоохойноос хорин метрийн зайд Шармбатоньхан ирсэн аварга том сүйх тэрэг зогсох агаад сурагчид алтан гишгүүрээр өгсөн орцгоолоо. Холгүй орших хашаанд нүсэр том биетэй далавчтай моринууд бэлчиж байв.

Харри овоохойны үүдийг тогшиход Соёт чанга хуцав.

- Удаан хүлээлээ! Та нарыг намайг хаана амьдардагийг мартчихсан юм байх гэж бодлоо хэмээн Хагрид хаалга нээхдээ хэлэв.

- Бид их завгүй байсан, Хаг... гээд Гермiona Хагрид руу гайхан харав.

Тэр ёслолын (аймшигтай!) хүрэн костюм өмсөж шаргал өнгийн эрвээхэй зангиа зүүжээ. Гэхдээ энэ ч хамгийн аймшигтай нь биш байв. Тэр давирхайны тусламжтай толгойны үсээ толийлгохыг оролдсон бөгөөд нэг том хоёр жижиг болгон хуваажээ. Энэ нь доошоо Биллийн үс адил унжих хэдий ч хэт өтгөн байлаа. Хагридад энэ нь огт зохицолдоогүй харагдана. Гермiona түүн рүү нүд бүлтийлгэн хараад ухаан орж,

- Э-э... соплохвостууд хаана байна? гэж асуув.

- Гадаа хулууны талбайд байгаа. Их томорсон. Бараг метр болсон. Гай болоход тэд бие биеэ алж эхэлсэн шүү.

- Байж боломгүй юм! гэж Гермiona дуу алдаад Хагридын хачирхалтай үсний засалтыг амаа ангайн ширтэх Рон руу анхааруулсан харц шидлээ.

- Тиймээ. Одоо зүгээр дээ. Би тэднийг хайрцагт салган хийсэн. Ойролцоогоор хориод үлдсэн дээ.

- Ямар азтай юм бэ! гэж Рон даажигнан дуу алдав.

Хагрид үүнийг ойлгосонгүй бололтой толгой дохив.

Хагридын овоохой ердөө ганц өрөөтэй билээ. Буланд нөхөөстэй бүтээлгээр хучсан аварга том ор байна. Зуухны өмнөх аварга том ширээг тойруулаад сандал тавьж,

адраас шувууны утсан гуя өлгөсөн байлаа. Тэднийг ширээнд суух үед Хагрид цай аягалж удалгүй тэмцээний тухай ярианд шилжлээ. Хагрид тэднээс дутуугүй санаа зовж байлаа.

- Жаахан хүлээгээрэй. Та нар хэзээ ч тийм юм хараагүй шүү. Нэгдүгээр даалгавар бол... гэхдээ би ярьж болохгүй л дээ.

- Хагрид алив л дээ... гэж хүүхдүүд ятгахад ойн сахиул маань зөвхөн толгой сэгсрэн инээмсэглэв.

- Энэ тухай ярихыг хүсэхгүй байна. Нэг л үг хэлье сонирхолтой юм бодож олсон шүү! Аваргад хүч хэрэгтэй! Ийм зүйлийг нэг ч Гурван шидтэний тэмцээнээс хүлээж байсангүй.

Зочломтгой Хагрид найзуудыг махтай хучмалаар дайлав. Гэвч найзууд нэг их идсэнгүй. Гермiona тавган дээрээ том хумс байхыг илрүүлсний дараа Харри, Рон хоёр хоолны дуршилаа алджээ. Хоолны дараа яриа хөөрөө үргэлжилсэн ч Хагридаар даалгаварыг хэлүүлэх оролдлого амжилтгүй болов.

Үдээс хойш шиврээ бороо оров. Ханан зуухны өмнө суугаад цонхны цаана бороо дуслах чимээг сонсож суухад юутай таатай билээ. Хагрид оймсоо нөхөх зуур Гермionатай гэрийн үйлчлэгч нарын талаар маргалдав. Тэр түүнд тэмдгээ үзүүлсэн ч элсэхээс татгалзав.

- Энэ чиний бодсон шиг биш, Гермiona. Тэд хүмүүст үйлчлэх тавилантай юм. Тэдний ажлын төлөө мөнгө төлөх юм бол доромжилсон хэрэг болно гэж Хагрид шаргал өнгийн утас том ясан зүүнд сүвлэнгээ хэлэв.

- Гэхдээ Харри Доббиг чөлөөлөлөхөд баярласандаа тэнгэрт арай хөөрөөгүй шүү дээ. Бид түүний цалин авахыг хүсч байгаа тухай сонссон гэж Гермiona эсэргүүцэв.

- Гэр бүл болгонд л нэг гаж амьтан байдаг. Би үйлчлэгчдийг чөлөөлөхийн эсрэг байна гэж хэлээгүй. Гэхдээ олонхи нь Гермiona... э-э... хэлж чадахгүй нь.

Уурссан Гермiona хайрцагтай тэмдгээ буцаан халааслав.

Тав хагаст бүрий болж эхлэв. Шилтгээн рүү явж Хэллоуины цайллаганд оролцонгоо хамгийн гол нь сургуулийн аварга хэн болсныг мэдэх цаг болж.

- Би та нартай хамт явна. Хүлээгээрэй гэж Хагрид хэлээд оёж байсан юмаа цааш тавилаа.

Тэрбээр босож орны хажуугийн шүүгээн дотроос ямар нэгэн юм эрж эхлэв. Тэгтэл гэнэт аймшигтай муухай үнэр ханхлав.

- Хагрид энэ юу вэ? гэж Рон ханиалгав.

- Аа? Чамд таалагдсангүй юу? гээд Хагрид эргэн харахдаа гартаа том лонх барьжээ.

- Сахлын ус уу? гэж Гермiona асуув.

- Сүрчиг. Би хэтэрхий түрхчихэв үү? Хүлээгээрэй би удахгүй гээд тэр ичингүйрэн овоохойноос гарав.

Тэд цонхоор Хагридыг борооны устай торхонд толгойгоо шургуулахыг харлаа.

- Сүрчиг гэнэ ээ? Хагрид уу? гэж Гермiona гайхлаа.

- Түүний үс ячихаа вэ? Бас энэ ёслолын костюм?

- Хараач! гэж Рон гэнэт цонх руу заав.

Хагрид зогсоод эргэж харлаа. Өмнө нь түүний хацар ягаан байсан бол одоо бүр час улайсан харагдана. Бүгд Хагридад харагдахгүйн тулд ширээний цаанаас болгоомжтой цонх руу харав. Сүйх тэрэгнээс Шармбатонхны захирал хатагтай Максим цайллаганд оролцохоор явах гэж байгаа бололтой гарч ирлээ. Хагридын үг сонсогдсонгүй. Гэхдээ тэд аварга биетийг хөөрсөн байхыг олж харжээ. Харри түүнийг өмнө нь нэг удаа хайртай луу Норберттайгаа тийм байхыг харсан юм байна.

- Тэр түүнтэй шилтгээн рүү явж байна! Харин би биднийг хүлээж байгаа юм байх гэж бодлоо хэмээн Гермiona хэлэв.

Хагрид овоохой нэг ч харсангүй хатагтай Максимын хамтаар шилтгээн рүү явахад Шармбатонхон тэдний нүсэр алхааг яаран дагалдав.

- Тэр дурлачихаж! Хэрвээ тэд гэрлэж хүүхэд төрүүлвэл маргахыг ч хүсэхгүй байна дэлхийн дээд амжилт болох бие! Хүүхэд нь тоннын жинтэй болох байх даа! гэж Рон огт итгэсэнгүй байртай дуу алдав.

Андууд овоохойноос гарахдаа хаалгаа хаалаа. Гадаа бүрий болсон үзэгдэнэ. Жанчаараа хучаад шилтгээн рүү явлаа.

- Тэнд хэн байгааг хараач! гэж Гермiona шивнэлээ.

Нуурын зүгээс Дурмстрангынхан шилтгээн рүү явж байв. Виктор Крам профессор Каркаровын дэргэд явж байв. Үлдсэн сурагчид араас нь явах аж. Рон Крамаас биширсэн харцаа салгасангүй. Гэхдээ тэр эргэж харалгүй явсаар шилтгээний хаалгаар орлоо.

Лааны гэрэл дэх Их танхим хэдийн дүүрчээ. Галт цом багш нарын ширээн дээр Дамблдорын хоосон суудлын өмнө байлаа. Фред, Жорж хоёр цэвэрхэн царайтай болсон хэдий ч гүнзгий урам хугарсан харагдана. Харри, Рон, Гермiona гурав дэргэд нь суулаа.

- Анжелинаг сонгоно гэж найдаж байна хэмээн Фред хэлэв.

- Би ч гэсэн! Одоохон мэдэх болно! гэж Гермiona дэмжлээ.

Хэллоуйны цайллага хэзээ ч дуусахгүй юм шиг санагдана. Учир нь баяр хоёр дахь өдрөө үргэлжилснээс ч болсон уу Харри олон янзын чамин хоолд анхаарал хандуулсангүй. Зөвхөн тэр ч биш эргэн тойрон дахь сурагчид ийш тийшээ харж суудал дээрээ хавчигнах зэргээр тэсч ядан цайллага дуусахыг хүлээж байлаа. Хэн гурван аварга болох бол?

Эцэст нь алтан тавагнууд хоосров. Танхим шуугиснаа Дамблдорыг суудлаасаа босмогц чимээгүй болов. Түүний хоёр талд суусан профессор Каркаров болон хатагтай Максим нар чимээгүй хүлээв. Людо Бэгмен цаг ямагт байдаг шигээ

инээмсэглэн сурагчид руу ирмэж байлаа. Крауч харин эсрэгээрээ бараг уйдсан янзтай үзэгдэнэ.

- Галт цом удахгүй шийдвэр гаргана. Түүнд ахин нэг хором хэрэгтэй байх гэж бодож байна. Аваргын нэр тодорхой болмогц ширээнээс босоод танхимын нөгөө өнцөг дэх ерөө рүү ороорой. Тэнд эхний тэмцээний заавар өгөгдөх болно гээд багш нарын ширээний ард байгаа хаалга руу заав.

Тэр шидэт саваагаа аваад даллахад лаанаас авхуулаад хулууны нүдэнд доторхи гээд бүх гэрэл унтрав. Танхим бүүдгэр боллоо. Галт цом гэрэлтэн хурц оч цацруулж цэнхэр дөл нүд гялбам дүрсхийв. Бүгдийн нүд цом руу харж зарим нэг нь цагаа харна...

- Нэг секунд үлдлээ гэж Ли Жордан хэлэв.

Дөл гэнэт улаан болж оч үсэргэснээ дараагийн агшинд нарийхан дөл агаарт цухалзахад шатсан цаас дэрвэлзэн нисэв. Танхим чимээгүй боллоо.

Дамблдор гар сунган цаасыг аваад дөлний гэрэлд ойртуулан чанга хоолойгоор,

- Дурмстрангын аварга бол Виктор Крам! гэж уншив.

Танхим чанга хашгиралт нижигнэсэн алга ташилтаар дүүрэв.

- Тийм байх ёстой! гэж Рон бүгдээс илүү хашгирав.

Виктор Крам Слизериний ширээнээс босоод Дамблдор руу очин баруун талаар нь эргэн багш нарын ширээг өнгөрөөд зэргэлдээх өрөөнд орж алга болоо.

- Сайн байна, Виктор! Сайн байна! Би чамайг сонгогдоно гэж мэдэж байсан юм! хэмээн Каркаров бүгдэд сонсогдохоор хашгиран алга ташин хэлэв.

Танхимын чимээг шуугиан намдахад бүгдийн анхаарал ахин цом руу шилжив. Дөл ахин улайснаа дараагийн цаас үсрэн гарлаа.

- Шармбатоны аварга бол Флер Делакур! гэж Дамблдор хэлэв.

- Рон, хараач! Тэр энэ байна! гэж Харри хашгирав.

Вейлатай төстэй охин босоод цайвар үсээ хойш шидэн Когтевран болон Пуффендуйн ширээний дундуур нисэн өнгөрөв.

- Та нар тэдний сэтгэлээр унасныг хараач! гэж Гермiona дуу алдаад Шармбатоньхны зүг заав.

Сэтгэлээр унасан гэж зөөлөн хэллээ гэж Харри бодов. Хоёр ч охин нүүрээ алгаараа даран уйлж байлаа.

Флер Делакур зэргэлдээх өрөөнд ормогц танхим ахин чимээгүй боллоо. Гэхдээ сэтгэл хөөрөл намдаагүй байв. Одоо зөвхөн Хогвартсын аварга үлджээ!

Бүгд ахин давтагдав. Галын дөл улайснаа оч үсрэн нарийн дөл цухалзахад цомоос гурав дахь цаас нисэн гарлаа. Дамблдор түүнийг барьж аваад уншсан нь,

- Хогвартсын аварга Седрик Диггори! гэв.

- Үгүй ээ! Яагаад тэр гэж? хэмээн Рон орилсон ч Харригаас өөр хэн ч түүний үгийг сонссонгүй.

Пуффендуйнхан хөл дээрээ үсрэн босож хашгиралдан багш нарын ширээ рүү нүүр дүүрэн инээмсэглэн явж байгаа Седрикт баяр хүргэв. Алга ташилт удтал намжсангүй. Дамблдор зогсоод хүлээхэд чимээгүй болж тэр сэтгэл хангалуунаар,

- Маш сайн байна! Бид одоо аваргуудын нэрийг мэддэг боллоо. Би Шармбатон, Дурмстрангын сурагчдыг оролцуулаад та нарыг бүгдийг өөрсдийн аваргаа дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Өөрийн аваргаа дэмжин зоригжуулж...

Дамблдор гэнэтхэн яриагаа зогсооход яагаад гэдэг нь шууд ойлгомжтой болов.

Цом ахиад улайжээ. Оч зүг бүр тийш үсрэхэд урт дөл цухалзан агаарт ахин нэг цаас нисэн гарлаа.

Дамблдор зөнгөөрөө гар сунган аваад дэлгэв. Галын гэрэлд нэр тодров. Удтал нам гүм болов. Дамболдор цаас руу харахад бүгд түүнийг ширтлээ. Тэр эцэст нь ханиалгаад уншсан нь

- Харри Поттер гэлээ.

БҮЛЭГ 17: ДӨРВӨН АВАРГА

Харри аянганд ниргүүлсэн юм шиг болов. Тэр үнэн сонссон байгаа даа... Магадгүй энэ зүүд юм болов уу... Гэхдээ үгүй юм шиг байна. Багш нар болон сурагчид түүнийг гайхан ширтэнэ.

Ямар ч алга ташилт байсангүй зөвхөн уурссан зөгий шиг дүнгэнэлт сонсогдоно. Зарим нэг нь Харриг сайн харахын тулд босон зогслоо.

Профессор МакГонагалл түргэн босоод Людо Бэгмен болон профессор Каркаровыг өнгөрч Дамблдортой ямар нэгэн зүйлийн талаар шивнэлдлээ. Сургуулийн захирал хөмсгөө зангидав.

Харри Рон, Гермиона хоёр руу эргэн харав. Гриффиндорынхон түүнийг амаа ангайлган ширтэнэ.

- Би нэрээ цомд хийгээгүй. Намайг биш гэдгийг та нар мэдэж байгаа шүү дээ гэж Харри хэлэв.

Рон, Гермиона хоёр хариуд нь түүнийг алмайран ширтлээ.

Багш нарын ширээнээс профессор Дамблдор босож профессор МакГонагалл руу толгой дохив.

- Харри Поттер! Харри! Ийшээ хүрээд ир гэж тэр хэлэв.

- Яваач гэж Гермиона шивнээд түлхэв.

Харри хөл дээрээ босоод жанчиндаа бүдчин багш нарын ширээ лүү явлаа. Баруун зүүн талаар нь Гриффиндор болон Пуффендуйн ширээ өнгөрөв. Алхаад л байдаг алхаад л байдаг ямар дуусдаггүй зам вэ! Дүнгэнэлдсэн чимээ улам чангарч бүгд түүнийг прожекторын гэрэл мэт дагуулан харцгаана. Эцэст нь тэр багш нарын ширээнд сууж байсан Дамблдорын нүд рүү харав.

- Тэр хаалга руу яв, Харри гэж захирал инээмсэглэлгүй хэлэв.

Харри хаалга рүү хөдөллөө. Хагридын хажуугаар өнгөрөхөд урамшуулсан ч үгүй нүд ирмэсэн ч үгүй. Тэр түүнээс дутуугүй гайхсан байлаа. Харри хаалга онгойлгоод багахан өрөөнд оров. Хананд шидтэнгүүдийн хөрөг өлгөж эсрэг талд байрлах ханан зууханд гал дүрэлзэн асна.

Хөргүүдийн царай Харри руу эргэн харлаа. Хатсан алим шиг үрчгэр шулам жааз дамжин үсчиж зэргэлдээх сахалтай шидтэний чихэнд ямар нэг юм шивнэлээ.

Виктор Крам, Седрик Диггори, Флер Делакур нар зуухны өмнө зогсож байв. Дүрэлзэн асах галын гэрэлд тэдний сүүдэр хачирхалтай өсөн харагдаж байлаа. Крам ямар нэг зүйлийн талаар бодлогоширон зуухны тавцан руу тонгойно. Седрик гараа тулан суугаад гал руу ширтэнэ. Флер Делакур Харри руу эргэн хараад,

- Юу болоо вэ? Танхим руу буцаж очих юм уу? гэлээ.

Тэр харваас Харриг шүүгч илгээсэн гэж бодсон бололтой. Тэдэнд юу болсныг яаж тайлбарлах вэ? Тэр чимээгүйхэн гурван аварга руу харлаа. Тэд түүнээс ямар том өндөр юм бэ?

Ард нь хөлийн чимээ сонсогдон өрөөнд Людо Бэгмен гүйж орж ирлээ.

- Итгэмээргүй юм! гэж тэр дуу алдаад Харригийн гарыг атгаж,

- Ер бусын үйл явдал! Ноёд... хатагтай нараа... Та бүхэнд итгэмээргүй хэдий ч тэмцээний дөрөв дэх аваргыг танилцуулахыг зөвшөөрнө үү! гэж тэдэнд хандан хэлэв.

Виктор Крам босож Харриг хөлөөс толгой хүртэл хараад царай нь улам барайв. Седрик буруу сонсоогүй биз дээ гэсэн байртай Бэгмен рүү мэгдэн харлаа. Флер цайвар үсээ хойш чулуудаад инээмсэглэв.

- Өө! Их хөгжилтэй тоглоом байна, ноён Бэгмен!

- Тоглоом гэнээ! Үгүй дээ, тийм биш! Юун тоглоом! Харригийн нэрийг цом саяхан сонголоо.

Крам өтгөн хөмсгөө хөдөлгөв. Седрик эелдэгээр гайхсан янзтай харсаар байлаа. Харин Флер хөмсгөө зангидаад,

- Энэ алдаа байх. Тэр оролцож чадахгүй. Тэр жижигхэн шүү дээ гэж зэвүүцэнгүй хэлэв.

- Тиймээ... гайхамшигтай зүйл боллоо. Та нар насанд хүрсэн хүн л шугамыг аюулгүй нэвтэрч чадна гэдгийг мэднэ. Түүний нэр цомоос үсрэн гарсан болохоор... одоо юу ч хийх боломжгүй болсон... Дүрмийн дагуу оролцох үүрэгтэй гээд Бэгмен эрүүгээ үрэн Харри руу инээмсэглэв.

Тэдний ар дахь хаалга ахин нээгдэхэд профессор Дамблдор, ноён Крауч, профессор Каркаров, хатагтай Максим, профессор МакГонагалл, профессор Снегг нар орж ирлээ. Харри танхим дахь сурагчдын дүнгэнэлдэх чимээг сонстол профессор МакГонагалл хаалга хаав.

- Хатагтай Максим! Тэд энэ жижигхэн хүү бас тэмцээнд оролцох болсон гэж хэллээ! гэж Флер унтууцан дуу алдав.

Харри гайхсан чимээгүй байдал уур хилэнгээр солигдов. Жижигхэн хүү гэнээ!

Хатагтай Максим аварга том биеэрээ цэх зогсоход толгойны орой нь лааны суурийг шүргэлээ. Тэрбээр хар атлаасан дашинз өмсчээ.

- Дамблэ-дорр! Энэ юу-у болоод байна? гэж тэр захирангуй асуув.

- Би ч гэсэн мэдэхийг хүсч байна, Дамблдор! Хогвартсаас хоёр аварга гэнэ ээ? Тэмцээний түүхэнд хоёр аварга сонгогдож байсныг санахгүй юм байна. Эсвэл би дүрмийг муу мэддэг юм болов уу? гэж профессор Каркаров хүйтнээр инээмсэглэн хэлэхэд цэнхэр нүд нь мөсний хэлтэрхий адил болов.

Тэрбээр ёжтой инээмсэглэлээ.

- ‘Огвартс хоёр аваргатай байж болохгүй энэ чинь шударга бус шүү дээ гээд хатагтай Максим гоёмсог опал чулуутай том гараа Флерийн мөрөн дээр тавилаа.

- Бид Дамблдор зөвхөн ахлах ангийн сурагчдыг оролцуулахын тулд хориотой шугам тавьсан гэдэгт итгэлтэй байсан. Иймээс л цөөхөн тооны өрсөлдөгч авчирсан шүү дээ гэж Каркаров хүйтнээр инээмсэглэсэн чигээр хэлэхэд харц нь улам хүйтэн боллоо.

- Каркаров үүнд Поттероос өөр хэн ч буруугүй. Поттер тэмцээний дүрмийг зөрчсөнд Дамблдор буруугүй. Энэ хүү анх удаагаа сургуулийн дүрмийг эвдэж байгаа хэрэг биш гэж Снегг хар нүдээ хорсолтойгоор гялалзуулан хэлэв.

- Баярлалаа, Северус гэж Дамблдор чанга хэлэхэд Снегг чимээгүй болсон ч тослог үсэн дундаа нүд нь хортойгоор гялалзсан хэвээр байлаа.

Дамблдор Харригийн нүүрний хувирлыг уншихыг хичээн бараан шилнийхээ цаанаас анхааралтай харлаа.

- Харри чи цомд өөрийн нэрээ хийсэн үү? гэж тэр тайван асуув.

- Үгүй гэж Харри хэлэхэд хүн бүр түүн рүү харлаа.

Снегг егөөдөнгүй байртай үл итгэсэн чимээ гаргав.

- Чи ахлах ангийн хэн нэгнээс цомд нэрээ хийхийг гуйсан уу? гэж Дамблдор Снеггийг үл тоомсорлон хэлэв.

- Үгүй гэж Харри шийдэмгий хэлэв.

- Тэр худал ярьж байна! гэж хатагтай Максим уулга алдав.

Снегг толгойгоо сэгсэрэхэд уруул нь мурийлаа.

- Харри хүссэн ч хориотой шугамыг давж чадахгүй. Үүнд эргэлзэх юмгүй гэж МакГонагалл унтууцан хэлэв.

- Тэгвэл Даблэ-дорр шугаманд алдсан байх гээд хатагтай Максим мөрөө хавчив.

- Магадгүй алдсан байх гэж Дамблдор зөвшөөрлөө.

- Дамблдор та энэ алдаа биш гэдгийг сайн мэдэж байгаа шүү дээ! Энэ бүхэн чинь тэнэг хэрэг! Харри шугамыг даваагүй. Тэр ахлах ангийн хэнд ч хандаагүй. Дамблдор үүнд итгэлтэй байгаа. Энэ энэ бүгдэд хангалттай тайлбар болно гэж бодож байна! гэж профессор МакГонагалл хэлээд Снегг рүү ихэд уурсан харав.

- Ноён Крауч... ноён Бэгмен. Та нар бол шүүгчид. Тэгээд тэмцээний дүрэмд ийм явдал болохыг зөвшөөрч байна уу? гэж Каркаров нялуун хоолойгоор хэлэв.

Бэгмен нусны алчуураар дугуй нүүрээ арчаад Крауч руу харав. Тэр хэдхэн алхамын зайд сүүдэрт зогсож байлаа. Бүрэнхийд тэр хий үзэгдэлтэй адилхан аймшигтай харагдаж байлаа. Тэгтэл Крауч ердийн хүйтэн хоолойгоороо,

- Бид дүрэм журмыг хатуу дагах ёстой. Дүрэмд цагаан дээр хараар хэний нэрийг Галт цом сонгоно тэр тэмцээнд оролцоно гэж бичээстэй байгаа гэв.

- Мэдээж шүү дээ! Барти дүрмийг таван хуруу шигээ мэддэг юм! гэж Бэгмен баясан хэлээд эсэргүүцэн буй зочид руу маргах хэрэггүй гэсэн байртай харав.

- Миний оролцогчын тоог нэмэхийг би шаардаж байна. Ахин нэг удаа оролдоод үзье. Бүх сургууль ижилхэн тооны аваргатай байх ёстой. Дамблдор, энэ шударга биз дээ! гэж Каркаров царайнаас нь инээмсэглэл алга болоод хэллээ.

- Каркаров энэ боломжгүй гэж бодож байна. Галт цом унтарсан дараагийн тэмцээн хүртэл асааж болохгүй гэж Бэгмен эсэргүүцэв.

- Тэгвэл Дурмстранг өрсөлдөөнд оролцохгүй! Бидний бүх уулзалт хэлэцээрийн дараа би ямар ч ийм зүйл хүлээгээгүй билээ! Одоо бүгдийг хаяж явахад бэлэн байна гэж Каркаров дүрсхийлээ.

- Хоосон сүрдүүлэг, Каркаров. Чи аваргынхаа нэрийг татаж чадахгүй. Дамблдор аварга шидэт гэрээ байгуулсан гэж хэлэхийг сонсоо биз дээ. Тэд хүсэх ч бай үгүй ч бай тэмцээнд оролцох л болно. Үүнтэй эвлэрэхгүй юм уу? гэх сөөнгө хоолой үүдний тэндээс сонсогдов.

Өрөөнд Грюм орж ирээд хазганан зуух руу очлоо. Түүний баруун хөлийн алхаа болгоныг чимээ дагалдаж байлаа.

- Эвлэрэх гэнээ? Би чамайг ойлгосонгүй гэж айж байна, Грюм.

Каркаров бүгдэд Грюмын үг түүнийг басамжилсан гэж харагдахгүйг хичээж байсан ч нударга зангиджээ.

- Тийм гэж үү? Тэгвэл сонсож бай. Бүгд их амархан, Каркаров. Хэн нэгэн Галт цомд Поттерын нэрийг тэмцээнд оролцуулахын тулд хийжээ гэж Грюм тайван хэлэв.

- Тэгэхээр 'Огвагтсд нэг алимыг хоёр удаа хаздаг хэрэг үү гэж хатагтай Максим хэлэв.

- Таны хэлснийг бүрэн зөвшөөрч байна. Би олон улсын ид шидийн шид шидийн холбоонд гомдол гаргах болно... хэмээн Каркаров толгой дохилов.

- Хэнд эсэргүүцэл чинь хэрэгтэй юм бэ. Энэ чинь Харри Поттер шүү дээ. Инээдтэй нь... би түүнээс өөр үг сонссонгүй.

- Яагаад гомдол гаргаж болохгүй гэж? Хуруугаа хөдөлгөөгүй хүн аварга болохгүй! Бид олон сарын турш аварга болохын тулд хөдөлмөрлөсөн. Бүх сургуулийн хүндэтгэл шүү дээ. Мянган галлеон тэдний амьдралд олон зүйлийг өгөх болно гэж Флер Делакур хөлөө дэвслэн хэлэв.

- Магадгүй хэн нэгэн Поттерыг үхэл рүү илгээхийг хүссэн байх л даа гэж Грюм аяархан хэлэв.

Түүний үгийн дараа өрөөнд хүчилсэн уур амьсгал бий болов.

Бүгд тоглоомгүй түгшсэн байлаа. Людо Бэгмен сэтгэл зовнин урагш алхаж нам гүмийг эвдлээ.

- Грюм, хөгшин минь.. чи юуны тухай яриад байна?

- Бүгдэд илхэн шүү дээ. Грюм өглөөнөөс үдийн хоолны хооронд хаа сайгүй аюул болгоныг илрүүлж байдаг юм. Түүнд үргэлж аюул осол үзэгдэж байдаг. Бас сурагчдыг аллагаар айлгадаг. Зөөлөн хэлэхэд хачирхалтай тохиолдлоор хар урлагаас

хамгаалах хичээлийн багш болжээ. Гэхдээ мэдээж Дамблдорт ингэх шалтгаан байсан байлгүй гэж Каркаров доромжилсон өнгөөр хэлэв.

- Үзэгдсэн гэнээ? Уран зөгнөл үү? Тэгвэл ойлгож ав, Галт Цомд Поттерын нэрийг хийсэн хүн шидэт их хүчийг эзэмшдэг!

- Баталгаа байгаа юм уу? гээд хатагтай Максим гараа савчив.

- Онцгой шидийн хүч эзэмшсэн хүн л үүнийг эвдэж чадна. Зөвхөн хүчирхэг шившлэг болох Конфоундус л Галт цомыг тэмцээн гурван оролцогчтой гэдгийг мартаход хүргэнэ. Гэхдээ цом сургуулиас ганц оролцогч сонгохыг л эргэлзэнэ. Тэгэхээр Поттерын нэрийг дөрөв дэх сургууль гэж хийсэн байх гэж бодож байна...

- Надад та энэ талаар их бодсон юм шиг санагдаж байх юм. Харин би саяхан ийм нэг түүх сонссон юм байна. Та толгойгоо цохьсон. Ха-ха! Төрсөн өдрөөрөө авсан бэлгийн нэг чинь зальжин далдалсан василискийн өндөг байсан. Чи түүнийг аваад хагалтал машины цаг байжээ. Иймээс л бид чамд ноцтой хандаагүй гэдгийг ойлго... хэмээн Каркаров хүйтнээр хэлэв.

- Тиймээ, хүмүүс ялааг заан болгож өсгөн ярьдаг юм. Ажил маань хар хүчний эсрэг тэмцэх юм, Каркаров. Чамайг энэ тухай санаж байгаа байх гэж бодож байна... хэмээн Грюм заналхийлсэн өнгөөр хэлэв.

- Аластор! гэж Дамблдор анхааруулав.

Тэр хэнд хандсан болохыг Харри ойлгосонгүй. Гэвч хормын дараа Хурц нүдэт Грюмын жинхэнэ нэр болохыг ойлгов. Грюм чимээгүй болоод час улайсан Каркаровыг сэтгэл ханамжтай харна.

- Энэ бүхэн яаж болсныг бид мэдэхгүй. Гэхдээ зөвшөөрөхөөс өөр гарц байхгүй. Цом Седрик, Харри хоёрыг тэмцээнд оролцуулахаар сонгосон. Тэд үүнийг хийхээс аргагүй... гэж Дамблдор өрөөнд байгаа хүмүүст хандан хэлэв.

- Гэхдээ Дамблэ-дорр...

- Хүндэт хатагтай Максим, таньд өөр арга байна гэж үү? Баяртайяа сонсох байна.

Гэхдээ хатагтай Максим нэг ч үг хэлсэнгүй уурласан янзтай болов. Зөвхөн тэр ч биш. Снегг Каркаровоос дутуугүй уурласан байлаа. Зөвхөн Бэгмен л баяр хөөр дүүрэн байв.

- За тэгэхээр учраа ололцов уу? Одоо аваргуудад зааварчилгааг танилцуулъя. Энэ Бартид оногдох хүндлэл. Чи татгалзахгүй биз дээ?

- Тиймээ, тийм... Заавар. Анхны тэмц... гэж Крауч гүн бодолд автан хэллээ.

Тэр ханан зуух руу очлоо. Харри түүний ойртон ирэхийг нь хараад хүнд өвджээ гэж бодов. Нүдийг нь тойрон хар сүүдэр татаж янжуурын цаас шиг нимгэн арьс нь үрчийжээ. Цомын тэмцээн дээр тэр хамаагүй дээр харагдаж байсан даа.

- Анхны тэмцээн та нарын авхаалж самбааг шалгах болно. Бид цаг нь болох хүртэл та нарт ямар сорилт хүлээж байгааг хэлэхгүй. Шидтэн бүр гэнэтийн явалдалтай нүүр тулахад бэлэн байх хэрэгтэй. Энэ маш чухал шүү.

- Анхны тэмцээн арван нэгэн сарын хорин дөрвөнд үзэгчид болон шүүгчдийн хяналтан дор явагдана. Тэмцээний оролцогч даалгаварыг гүйцэтгэхэд багшаасаа ямар нэг тусламж авахгүй. Аваргын цорын ганц зэвсэг бол шидэт саваа. Нэгдүгээр тэмцээний төгсгөлд хоёр дахь тэмцээний зааврыг өгөх болно. Тэмцээнд хүч зарцуулан бэлтгэх учир аварга жилийн эцсийн шалгалтаас чөлөөлөгдөх юм. Ингээд болно биз дээ, Альбус? гээд ноён Крауч Дамблдор руу эргэн харлаа.

- Тиймээ, болно. Барти та шилтгээнд хонохгүй юм уу? гээд Хогвартсын захирал Крауч руу түгшсэн байртай харав.

- Үгүй дээ, Дамблдор. Би яам руу буцах ёстой. Бидэнд маш амаргүй үе ирсэн учир их завгүй байгаа. Оронд маань залуу Уизерби үлдэх болно... маш их урам зоригтой... үнэнийг хэлэхэд бүр дэндүү их шүү...

- Замд гарахын өмнө юм уух уу? гэж Дамблдор хэлэв.

- Алив л дээ, Барти! Би үлдэж байна. Хогвартсад тохиолдох зүйл танай албан тасалгаанаас хамаагүй сонирхолтой гэж Бэгмен баяртай дуу алдав.

- Үгүй дээ, Людо чадахгүй гэж Крауч ердийнхөө хатуу араншингаар татгалзав.

- Профессор Каркаров, хатагтай Максим хундага юмнаас татгалзахгүй байгаа юм биз дээ?

Гэвч хатагтай Максим Флерийн мөрөн дээр тавьсан гараа буулгаад франц хэлээр ямар нэг юм дуржигнуулан үүд рүү явлаа. Каркаров Крамыг дохиод нэг ч үг хэлэлгүй гарахаар яарав.

- Харри, Седрик та хоёрыг одоохон өөрсдийнхөн рүүгээ явахыг зөвлөх байна. Гриффиндор, Пуффендуй тэнхимийнхэн та нарын амжилтыг тэмдэглэх хүсэлтэй байгаа гэдэгт эргэлзэхгүй байна. Андуудаа хөгжилтэй баяр хөөрөөс нь салгаж болохгүй шүү дээ.

Харри Седри руу харж толгой дохиод хоёул хаалгаар гарлаа.

Их танхим хоосорчээ. Хулууны доторх лааны гэрэл асаж аймшигтайгаар инээмсэглэж үзэгдэнэ.

- Тэгэхээр, Харри бид ахиад л өрсөлдөгч болох шив гэж Седрик инээвхийлэн хэлэв.

- Ахиад л гэж Харри хэлэв. Өөр зүйл түүний толгойд орсонгүй. Тархийг нь бусниулчихсан аятай бодол нь үймчиж байлаа.

Танхимаас гарцгаалаа. Галт цомын байранд ердийн бамбар гийгүүлж байв.

- Харри... чи яаж нэрээ цомд хэлснээ хэлээч? гэж Седрик асуулаа.

- Би хийгээгүй. Үнэн шүү гээд Харри Седрик руу харав.

- Тэгвэл, яахав... Баяртай гээд тэр гар даллав.

<<Мэдээж, тэр надад итгэсэнгүй>> гэж Харри бодоод түүний араас дагуулан харлаа.

Седрик гантиг шатаар өгсөхийн оронд баруун тийш эргэн алга болов. Харри зогсоод түүний хэрхэн чулуун шатаар доош гүйхийг сонсож байснаа гантиг шатаар өгслөө.

Үнэхээр Рон, Гермиона хоёроос өөр хэн ч түүнд итгэхгүй гэж үү? Бүгд түүнийг өөрийн биеэр Галт цомд нэрээ хийсэн гэж бодож байгаа хэрэг үү? Яаж болох юм бэ! Өрсөлдөгчид нь гурван насаар ах бараг л шидтэн гэсэн үг. Тэмцээний даалгавар маш аюултай бөгөөд бараг зуугаад үзэгчийн өмнө болдог. Тиймээ тэр энэ тухай ургуулан бодсон хэдий ч... зүгээр л хоосон мөрөөдөл байсан шүү дээ! Хэзээ ч жинхэнээсээ аварга болно гэж бодоогүй юм...

Тэгэхээр хэн нэгэн түүнийг тэмцээнд оролцуулахыг хүсчээ. Яах гэж? Түүнд юу өгөх юм бол? Ямар сэтгэл ханамж вэ... Түүнийг тэнэг байдалд оруулах гэсэн юм болов уу... Магадгүй л юм... Эсвэл алах гэсэн юм болов уу? Гэхдээ Грюмын ахин нэг ургуулан бодолт байвал яана? Эсвэл хортой тоглоом юм уу? Гэнэтхэн хэн нэгэн түүнийг үнэнээсээ алахыг хүссэн байвал яана? Хэн юм бол?

Удаан бодох хэрэг байсангүй. Үүнийг хүсч байгаа хүн байгаа. Түүнийг ойтой байх үеэс л хүсч байсан хүн бий. Лорд Волан-де-Морт... Гэхдээ тэр яаж түүний нэрийг Галт цомд хийсэн юм бол? Тэр сул дорой хүчгүй болоод эндээс хол нуугдаж байгаа биз дээ...

Харрийн зүүд үнэн байх нь. Тэр өглөө сорви нь хүчтэй өвдөн сэрэхэд Волан-де-Морт ганцаараа байгаагүй... Тэр Сүүлттэй Харриг алахаар ярьж байсан.

Харри Тарган хатагтайн хөрөг рүү яаж хүрснээ мэдсэнгүй. Хөл нь түүнийг хөтлөөд иржээ. Хатагтай ганцаар байсангүй. Аваргуудын өрөөнд зэргэлдээх зурагны жаазанд үсэрч ордог үрчлтээтэй хөгшин шулам тарган хатагтайтай тухтай хөөрөлдөж байв. Долоон давхарын бүх зурганууд энд цугларсан бололтой. Хоёр хатагтай Харри руу сонирхон ширтлээ.

- Тэгэхээр Виолета сая надад бүгдийг хэллээ. Хэн сургуулийн аваргаар сонгогдсоныг? гэж тарган хатагтай хэлэв.

- Дэмий үг гэж Харри бувтнав.

- Юуны чинь дэмий үг вэ? Тийм биш! гэж зочин эсэргүүцэв.

- Үгүй дээ, энэ нууц үг байгаа юм гэж Тарган хатагтай тайвшируулав. Хөрөг эргэхэд Харриг амралтын өрөөнд орлоо.

Чих дөжрөм чимээ гарахад Харри хөл дээрээ арай ядан тэслээ. Олон арван гар түүнийг дотогш чирэн оруулав. Амралтын өрөөнд бүх Гриффиндорынхон цугларсан бололтой. Хашгирах, шүгэлдэх, алга таших чимээнд Харрийн толгой эргэлээ.

- Чи үүнийг яаж хийв? Яагаад бидэнд хэлсэнгүй вэ? гэж Фред орилов. Тэр гайхсаны зэрэгцээ уурссан байлаа.

- Сахал чинь хаана байна? Гайхамшигтай! гэж Жорж дэлбэрлээ.

- Энэ би бишээ. Хэн хийснийг мэдэх юм алга гэж Харри хэлэв.

- Би биш хэдий ч хамгийн гол нь Гриффиндорын хүн! гээд Анжелина түүнийг хүзүүдэв.

- Харри Диггороос өнгөрсөн жил ялагдсаныхаа өшөөг аваарай! гэж Гриффиндорын багийн ахин нэг ангууч Кэти Бэлл хашгирлаа.

- Бидэнд хичнээн их идэх юм байгаа гээч, Харри! Идээрэй!

- Би өлсөөгүй байна. Цайллага дээр хооллочихсон...

Гэхдээ хэн ч түүнийг цатгалан бөгөөд цомонд өөрийн нэрээ хийгээгүй гэдэгт итгэсэнгүй. Бас хэн ч түүнийг баатрын ёсоор баярлаж хөөрөхгүй байгааг анзаарсангүй. Ли Жордан хаа нэгтгээгээс Гриффиндорын далбааг гаргаж ирээд Харрийн жанчин дээр зүүлээ. Харри унтлагын өрөө лүүгээ өгсдөг шат луу хүрэхийг хичээсэн авч замд нь түүнийг хүчээр цөцгийний шар айраг уулган, алган дээр нь бутарсан газрын самар тавьж байлаа. Хүн бүр л түүнийг Дамблдорын хориотой шугамыг яаж нэвтрэн нэрээ цомд хийснийг мэдэхийг хүсэж байв.

- Би бишээ. Яаж гэдгийг нь мэдэхгүй байна гэж Харри ахин дахин хэлж байлаа.

Гэвч тэдний царайнаас харахад ямар нэг зүйл хэлээд ашиггүй бололтой.

- Би их ядарлаа! Үнэн шүү, Жорж явж унтахыг хүсч байна гэж хагас цагийн дараа хэллээ.

Түүнд одоо амралтын өрөөнд байгаа хүмүүсээс илүү эрүүл саруул ухаантай Рон, Гермiona хоёр хэрэгтэй байв. Амралтын өрөөнд тэд байсангүй. Эцэст нь Харри дээшээ өгсөхдөө жижигхэн Кривиг золтой л мөргөөд унагачихсангүй. Тэр арайхийн хүмүүсээс салан унтлагын өрөө лүүгээ орлоо.

Бурханы авралаар Рон хоосон унтлагын өрөөндөө ганцаар байв. Орон дээр хувцастайгаа дээшээ харан хэвтэж байлаа.

- Чи хаана байсан бэ? гэж Харри хаалга хаагаад асуулаа.

- Аан чи юу? Сайн уу гэж Рон хэлэв.

Тэр маш хачирхалтай хүчилсэн юм шиг инээмсэглэх аж. Харри түүнд Лигийн бэлэг болох Гриффиндорын далбаа зүүлттэй байгааг мартсан байв. Харри яаран авах гэсэн ч болсонгүй. Рон орон дээр хөдөлгөөнгүй хэвтээд андыгаа харна. Харри тэмдгийг мулт татан аваад булан руу чулуудав.

- Чамд баяр хүргэе гэж Рон хэлэв.

- Баяр хүргэх гэнэ ээ? Юунд тэр вэ? гээд Харри түүн рүү муухай харав.

Инээмсэглэл нь ярвайхтай төстэй үзэгдэх аж. Рон нэг л биш байлаа!

- За боль доо чи! Хэн ч хориотой шугамыг давж чадаагүй. Фред, Жорж хоёр хүртэл шүү. Үл үзэгдэх цув өмссөн үү?

- Үл үзэгдэх цув шугамыг хуурч чадахгүй шүү дээ гэж Харри удаанаар хэлэв.

- Ойлголоо. Энэ жанчин дотор бид хоёулаа багтах байсан. Тэгэхээр өөр ямар нэгэн арга олсон юм биз дээ?

- Сонсооч, Рон. Би цомонд нэрээ хийгээгүй. Өөр хэн нэгэн миний нэрийг хийсэн.

Рон хөмсгөө өргөлөө.

- Яах гэж тэгдэг байна?

- Мэдэхгүй.

<<Намайг алахын тулд!>> гэж эмгэнэлтэйгээр хариулах байсан хэрэг үү. Тэнэг юм!

Роны хөмсөг дээшээ өргөгдсөөр үсэнд нь аюултай ойртов.

- Мэдэхгүй гэнэ ээ? Би ямар их итгэж байв аа! Чи надад үнэнээ хэлж болох л байсан! Чамд таагүй байгааг бүгд мэдэж байгаа. Гэхдээ яагаад худал хэлэх ёстой гэж! Чамайг үүний чинь төлөө хэн ч шүүхгүй! Тарган хатагтайн найз хөгшин Виолетта бидэнд бүгдийг хэлсэн. Дамблдор чамайг оролцогчоор авсан. Мянган галлеон, муугүй биз, тийм үү? Бас жилийн эцсийн шалгалт өгөхгүй гээд байгаа.

- Гэхдээ би цомонд нэрээ хийгээгүй! гэж Харри уурсаж эхлэв.

- За яахав. Чи өглөө <<Би нэрээ шөнө хэн ч хараагүй байхад хийсэн>> гэж хэлж болох л байсан. Би тэнэг юм шиг харагдаад байна уу? гэж Рон Седрикийн адил үл итгэсэн өнгөөр хэлэв.

- Наадах чинь яг онож байна.

- Юу гэнэ ээ? Чи унтах хэрэгтэй, Харри. Маргааш эрт босно. Янз бүрийн зураг авхуулна... гээд Роны нүүрнээс инээмсэглэл алга болов.

Тэр хөнжлөө дээгүүрээ нөмрөв. Харри шалнаас ургасан аятай зогсоод хамба хилэн хөшгийг ширтлээ. Түүний өмнө Харрийг хэзээ ч худал хэлсэн гэж сэжиглэж байгаагүй найз нь хэвтэж байна.

БҮЛЭГ 18: ШИДЭТ САВАА ДЭНСЭЛСЭН НЬ

Ням гаригийн өглөө Харри сэрээд баяр дээр юу болсныг шууд ойлгосонгүй. Толгойд нь таагүй санаа зовнил дүүрэн байлаа. Тэр одоо Ронтой ярилцах болно. Мэдээж Рон түүнд итгэж байгаа. Харри хөшгөө сөхөөд Роны ор луу хартал хоосон байв. Бодвол өглөөний ундаа уухаар явсан байх.

Харри хувцаслаад эргүүлгэн шатаар амралтын өрөө рүү уруудлаа. Түүнийг чанга алга ташилт угтав. Хаашаа явах вэ? Их танхим руу явах уу? Тэнд Гриффиндорынхон түүнийг баатар шиг хүлээж авна. Энд үлдэх үү? Ахиад л ах дүү Криви тэсч ядсан байртай ирж явна. Үгүй ээ, одоо бүгдийг Гермионатай ярилцах хэрэгтэй. Харри шийдэмгий үүд рүү яван хөрөг түлхэн гарахдаа гартаа олон давхарласан хачиртай талх барьсан Гермионатай золтой мөргөлдсөнгүй.

- Сайн уу. Би чамд үүнийг авчирсан юм. Явж зугаалах уу? гэж Гермиона хэлээд амны алчууранд боосон хоолоо Харрид өглөө.

- Сайхан санаа байна гэж Харри талархав.

Тэд шатаар уруудан Их танхим руу харалгүй гадагшаа түргэн гарч нуурын эрэг рүү явлаа. Дурмстрангын хөлөг онгоцны зангуу харанхуй усанд гэрэл ойлгон харагдана. Өглөө жихүүн байсан болохоор тэд талх идэн зугаалах зуураа Харри бүгдийг Гермионад хэлэв. Гермиона түүний санааг амраан нэг ч үгийг нь сэжиглэсэнгүй.

- Чи тэнд хамаагүй гэдэг нь ойлгомжтой. Дамблдор <<Харри Поттер!>> нэрийг уншихдаа царай нь ямар болсныг харсан уу! Хэн үүнийг хийсэн бол? Грюмын зөв, Харри. Ямар ч сурагчид Дамблдорын шугамыг давах хүч байхгүй... Тэд хэзээ ч цомыг мэхэлж чадахгүй гэж Гермиона түүний танхимд болсон явдлын ярианы төгсгөлд хэлэв.

- Чи Роныг харав уу? гэж Харри түүний яриаг таслав.

- Тиймээ... өглөөний цайны үеэр гэж Гермиона тээнэгэлзэн хэлэв.

- Тэр намайг хийсэн гэж бодож байна уу?

- Үгүй... Би тэгж бодохгүй байна... Жинхэнээсээ биш байх гэж Гермиона эв хавгүйхэн хэлэв.

- Жинхэнээсээ биш гэдэг чинь юу гэж байгаа юм?

- Харри чамд үнэхээр ойлгомжтой биш байна уу? Тэр зүгээр л атаархаж байгаа юм! гэж Гермиона цөхрөн хэлээд гараа савчлаа.

- Атаархах гэнэ ээ? Юунд тэр вэ? Бүх сургуулийнхний өмнө тэнэг гэдгээ харуулах гэж үү? хэмээн Харри эргэлзэнгүй хэлэв.

- Ойлго, Харри. Чи үргэлж анхаарлын төвд байдаг... гэж тэр тэвчээртэй тайлбарлав.

Харри эсэргүүцэхийг хүсэн ам нээсэн авч Гермиона түүнд боломж өгөлгүй үргэлжүүлэн,

- Чамайг буруутай биш гэдгийг мэдэж байна. Алдар нэр чамд хэрэггүй. Гэхдээ Роныг ойлго л доо. Түүнд том ах нартайгаа үргэлж өрсөлдөх хэрэг гардаг. Чи түүний сайн найз хэдий ч алдартай. Тэр үргэлж сүүдэрт байдаг. Рон үүнийг хэзээ ч цухуйлгаж байгаагүй. Гэхдээ цомын түүхийн хувьд арай дэнднээ.

- Ямар гайхамшигтай юм бэ! Үнэхээр гайхамшигтай. Намайг түүнтай баяртайгаар солигдох болно гэж хэл. Хаашаа ч явсан бүгд чиний дух руу ширтэж байх ямар тэнэг болохыг мэдэж аваг...

- Ямар ч нэмэр болохгүй. Түүнтэй өөрөө ярилц. Энэ бол цорын ганц арга.

- Би түүний атаархлыг болиулах гэж араас нь гүйхгүй! Намайг хүзүүгээ хугалсан цагт л тэр итгэх байх... Ямар юмных нь баярлах... гэж Харри чанга хэлэхэд ойролцоох модон дээр сууж байсан хэдэн ууль цочин нислээ.

- Тиймээ хөгжилтэй зүйл бага л даа. Юу хийх ёстойг мэдэх үү? Даруйхан шилтгээн рүү буц гэж Гермiona санаа тавьсан өнгөөр хэлэв.

- Тийм шүү, Роныг нэг сайн өшиглөх юмсан...

- Сириуст захиа бич. Юу болсон тухай бүгдийг нь хэл. Тэр түүнд Хогвартсад болсон үйл явдлын тухай хэлж бай гэсэн биз дээ. Би чамд үзэг цаас аваад ирье.

- Юу ч бичихгүй гээд Харри эргэн тойрондоо хүн байгаа эсэхийг шалган хараад,

- Сириус эх орондоо зөвхөн миний сорви өвдсөний төлөө ирсэн. Би түүнд тэмцээний тухай бичих юм бол ийшээ шууд хүрээд ирэх байх гэв.

- Гэхдээ энэ чинь түүний шийдвэр шүү дээ. Тэр энэ тухай мэдэх л болно.

- Яаж?

- Харри үүнийг чимээгүй байлгах боломжгүй. Гурван шидтэний тэмцээн бол нэртэй үйл явдал. Чи ч гэсэн алдартай юм чинь. Хэрвээ <<Зөнч>> сонинд <<Харри Поттер Хогвартсын аварга>> гэсэн гарчигтай нийтлэл гараагүй бол би үнэхээр гайхах байна. Чи Хэцүү нэртийн тухай хэдийн ном бичигдсэнийг мэднэ. Сириус чамаас өөрөөс чинь мэдсэн дээр гэдэгт итгэ.

- За, бичнэ ээ. Чиний зөв юм байна.

Харри сүүлчийн зүсэм талхаа нуур луу хаяхад уснаас том тэмтрүүл цухуйснаа хоол алга болов. Андууд шилтгээн рүүгээ буцлаа.

- Ямар ууль илгээх вэ? Сириус Хэдвигийг илгээхгүй байхыг гуйсан байдаг гэж Харри шатаар өгсөхдөө хэлэв.

- Роны Гахайг гуй.

- Би Роноос юу ч гуйхгүй гэж Харри эсэргүүцэв.

- Сургуулийн уулийг авч болно байх.

Уулийн байшин руу явцгаалаа. Гермiona Харрид хуудас цаас, үзэг, бэх өгөөд хонуур дээрээ байгаа өөр уулиудыг харахаар явав. Харри хана налан суугаад бичиж эхэллээ.

Хүндэт Сириус.

Чи надаас Хогвартет болсон сүүлийн үеийн зүйлийн талаар хэлэхийг гуйсан билээ. Чамайг Гурван шидтэний тэмцээн болно гэдгийг мэдэж байсан эсэхийг мэдэхгүй юм. Гэвч бямба гаригт намайг Хогвартсын дөрөв дахь аваргаар сонголоо. Миний нэрийг цомд хэн хийснийг ойлгох юм алга. Мэдээж би өөрөө хийгээгүй. Хогвартсын өөр аварга бол Пуффендуйн Седрик Диггори юм.

Харри цэг тавиад юу гэж хэлвэл загалмайлсан эцгээ түгшээхгүй байх вэ гэж бодтол өчигдөр үдшийг санаад зүрх нь түгшлээ. Тэгээд үзгээ бэхэндээ дүрээд товчхон төгсгөв.

Клювокрыл та хоёр зүгээр гэдэгт найдаж болох уу?

Харри

- Гермiona дуусчихлаа гээд Харри шалан дээрээс өндийн сүрэл болсон жанчаа сэгсэрлээ. Мөрөн дээр нь Хэдваг суугаад сарвуугаа сунгав.

- Намайг уучлаарай, өнөөдөр чамайг илгээж чадахгүй нь. Эдний нэгийг авахаас гэж тэр хэлээд сургуулийн уулиуд руу харав.

Хэдваг чанга гууглаад хумсаараа мөрийг нь базан сүр сархийн нислээ. Тэр захиагаа том уулийн хөлд уяв. Ууль нисээд явчихлаа. Харри Хэдвагийг илэхийг хүссэн ч ууртайгаар хошуугаа тас няс хийлгэн адар руу хөөрсөн учир ойртож чадсангүй.

- Эхлээд Рон, одоо чи. Энэ миний буруу биш шүү дээ гэж Харри уурсан хэлэв.

Харри бүгд түүнийг аварга болсон учир харьцаагаа сайжруулахыг хүсэх болно гэж буруу боджээ. Тэр өөр тэнхимийн сурагчдаас удтал зугтаж чадсангүй. Тэд Гриффиндорынхны адил Харриг цомд нэрээ хийсэн гэж бодож байгаа ч ялгаатай нь гэвэл баатар гэж авч үзэхгүй аж.

Пуффендуйнхан Гриффиндортой нөхөрсөг харилцаатай байдаг бол одоо хүйтэн харилцаатай болжээ. Энэ ч Харри тэдний аварга болох Седрик Диггорын алдрыг булаах гэж байгаа болохоор ойлгомжтой байлаа. Седрик тэднийг нэг удаа ялахад хүргэж байснаас ондоо Пуффендуйнхан нэг ч ялалт байгуулж байсангүй. Тэр Гриффиндорынхныг квиддичийн тэмцээн дээр хожсон билээ.

Харри эхний цаг ургамал судлалын хичээл гэдэгт итгэлтэй байлаа. Түүнтэй нөхөрсөг харьцаатай байдаг Эрни МакМиллан болон Жастин Финч-Флетчли нар үсэрдэг болцуу шилжүүлэн суулгах хичээлийн турш нэг тавиур дээр хамт ажилласан хэр нь чимээгүй байлаа. Нэг болцуу гараас нь суга үсрээд Харрийн нүүр лүү өвдтөл цохиход Пуффендуйнхан доогтой инээлдэв. Профессор Стебль хүртэл ширүүн хандаж байлаа. Тэр Пуффендуй тэнхимийн эрхлэгч шүү дээ.

Рон түүнтэй найрамдаагүй хэвээр. Гермiona Их танхимд тэдний дунд суухдаа чадахаараа яриа дэлгэнэ. Түүнтэй найзууд нь байвч бие бие рүүгээ харахгүй аж.

Тэр Хагридын хичээлийг үргэлж баяртайгаар хүлээдэг байлаа. Одоо тийм биш болжээ. Тэр аварга болсноосоо хойш Слизеринийхэнтэй нүүр тулгарахыг хүсэхгүй байв.

Түүний тааварласан ёсоор Малфой овоохойн дэргэд доогтой инээмсэглэн хүлээж байлаа.

- Залуусаа хэн энд байгааг хараач. Гриффиндорын аварга! Тэмдэглэлийн дэвтрээ гаргаарай! Гарын үсэг авахаар яарцгаагтун. Түүнд бидний дунд байх цаг удаан үлдсэнгүй! Тэмцээнийг давна гэдэг бол хар дарсан зүүд! Оролцогчдын хагас үхсэн юм. Хэр удаан тэсэх вэ гэж үү, Поттер? Эхний тэмцээн дээр арван хором болно гэж мөрийцье! гэж тэр үнэнч бие хамгаалагч Крэбб, Гойл хоёрт хандан хэллээ.

Крэб, Гойл хоёр бялдуучилан хөхрөлдөхөд Малфой чимээгүй болгов. Овоохойны арын хаалгаар маш том соплохвост бүхий тор барьсан Хагрид гарч ирэв. Тэгээд бүгдийн айдсыг төрүүлэн соплохвостууд бие биенээ алдаг тухай тайлбарлав. Ингээд бүгдэд аймшигтай даалгавар өглөө. Сурагч бүр соплохвостын хүзүүвчнээс барин зугаалуулах ёстой юм гэнэ. Даалгаварын ганц сайн зүйл гэвэл Малфой ухаанаа алдтал уурлав.

- Тэднийг зугаалуулах гэнэ ээ? Бид хүзүүвчээрээ хаанаас барих нь сонирхолтой юм? Эсвэл сүүл, хатгуур эсвэл соруулаас нь барих уу? гэж дургүйцэн хэлээд нэг хайрцаг руу шагайв.

- Их амархан дундаас нь. Зөвхөн... лууны ширээр хийсэн... бээлийгээ өмсөх хэрэгтэй. Харри нааш ир надад энэ амьтныг гаргахад тусал...

Үнэн хэрэгтээ тэр Харритай ганцаар ярихыг хүсчээ.

Хүүхдүүд амьтныг зугаалуулан одоход Хагрид Харри руу эргэлээ.

- Тэгэхээр чи оролцохоор болсон юм биз дээ. Гурван шидтэний тэмцээнд... сургуулийн аваргаар гэж өтгөн хөмсгөө өргөн хэлэв.

- Нэг аваргаар нь гэж Харри залруулав.

Өтгөн хөмсөг дорх цох шиг хар нүд түгшүүртэй гялалзав.

- Хэн ингэсэн талаар санаа алга уу, Харри?

- Чи намайг биш гэдэгт итгэж байгаа юм уу? гээд Харри баярласандаа хүзүүнээс нь зүүгдэх шахав.

- Өөр яах гэж. Чи биш л гэж хэлсэн бол би итгэнэ. Дамблдор болон бүгд ч гэсэн...

- Хэн үүнийг хийснийг мэдэхийг хүсч байна! гэж Харри гашуунаар хэлэв.

Тэд нуга дээр байгаа сурагчид руу харав. Хүүхдүүд энд тэндгүй тарж ажил хэрэг нь хүндхэн байгаа бололтой. Соплохвостууд гурван фут өсч хүчирхэг болсон байлаа. Зөөлөн цагаан өнгө нь ул мөргүй болж зузаан саарал гялалзсан хуягтай болсон байх аж. Аварга том хилэнц юм уу сунгасан наймаалж шиг болсон хэдий ч толгой нь мэдэгдэхгүй хэвээр байв. Энэ хүчирхэг амьтныг жолоодох их хэцүү байв.

- Зугаалга тэдэнд хөгжилтэй санагдсан болов уу? гээд Хагрид сэтгэл хангалуун инээмсэглэв.

Харри түүний соплохвостын тухайд хэлснийг ойлгож байв. Сурагчид хөөрсөн янзгүй байлаа. Учир нь хилэнцийх шиг сүүлнээс нь гал гарч дэлбэрэн урагшаа гурван

метрийн зайд буудах аж. Азгүй нь нэг нь гэдсээрээ чирүүлж байсан ч энэ ховор тохиолдлоо.

- Ай даа, мэдэхгүй юм, Харри... Сургуулийн аварга... Үргэлж л чамд ямар нэгэн юм тохиолдож байх юм даа гээд Хагрид хүндээр санаа алдан Харри руу түгшсэн харцаар ширтэв.

Харри чимээгүй болов. Тиймээ, түүнтэй үргэлж л ямар нэг юм тохиолдож байх юм. Гермiona үүнийг нуур тойрон зугаалж байх үедээ хэлсэн шүү дээ. Тэр үүнийг Рон түүнтэй ярилцахаа больсон учир хэлсэн байх.

Дараагийн хэдэн өдрүүдэд байдал улам муу болов. Энэ нь хоёрдугаар дамжаанд байсантай адил санагдаж байлаа. Тэгэхэд түүнийг сургуулийн сурагчыг дайрсан хэмээн сэжиглэж байсан билээ. Гэхдээ Рон түүний талд байсан. Түүнтэй эргэж нөхөрлөсөн бол үүнийг давахад амар байлаа. Гэхдээ тэр Ронд ойртсонгүй бөгөөд тэр ч найрамдахыг хүссэнгүй. Бүх ертөнц түүний эсрэг болсон юм шиг санагдана.

Тэр Пуффендуйнханд хичнээн гомдолтой болохыг ойлгож байв. Тэд өөрийн аваргаа дэмжиж байгаа. Слизеринийхнээс харгис доромжлолоос өөр юу ч хүлээх хэрэггүй. Тэд түүнийг тэвчиж чаддаггүй юм. Чухамдаа Харри л Гриффиндорынхныг квиддич болон тэнхим хоорондын тэмцээнд түрүүлэхэд тусалсан шүү дээ. Гэхдээ Когтевраныхан түүнийг Седрикийн адил дэмжиж болох юм. Үгүй дээ. Харваас ихэнхи нь түүнийг алдар гавъяа олохыг хүссэн гэж бодсон байна.

Седрикт аваргын дүр юунаас ч илүү зохиж байлаа. Тэр хар үс, шулуун хамар, саарал нүдтэй царайлаг сайхан залуу байсан юм. Түүнийг Крамаас дутуугүй бахдаж байлаа. Харри зургадугаар дамжааны охид Крамын гарын үсэгний араас хөөцөлддөг шиг Седрикийг цүнхэн дээрээ бичиж өгөхийг гуйж байгааг харжээ.

Сириусээс хариу ирээгүй л байв. Хэдвигийн уур гараагүй хэвээр. Профессор Трелонигийн хэлсэн ёсоор өдрүүд улам хэцүү болсоор байв. Профессор Флитвикийн хичээл дээр Невиллийг эс тооцвол Татдаг шидийг ангийнхнаасаа ганцаараа муу хийсэн болохоор нэмэлт гэрийн даалгавар авчээ. Гермiona хичээл дээр тоосны алчуур, сарны дуран, хогийн савыг шидэт соронзон аятай нисгэж байв.

- Энэ тийм ч хэцүү биш. Чи зүгээр л муу төвлөрөөд байгаа хэрэг гэж Гермiona түүнийг хичээлийн дараа тайвшируулав.

- Чи яагаад гэдгийг нь тааварлахгүй байна уу? Үдээс хойш уусмалын хоёр хичээл орно шүү дээ! гэж Харри баргар хэлэх үед Седрик дэргэдүүр нь худал инээсэн охидоор хүрээлүүлсээр өнгөрөв. Тэд түүнийг шилтгээнд том соплохвост орж ирсэн аятай харжээ.

Уусмалын хоёр хичээл үргэлж аймшигтай болдог хэдий ч эдгээр өдрүүдэд эрүү шүүлт адил байлаа. Цагийн турш газар дор Снег болон Слизеринийхэнтэй байхад сайн юм хүлээх хэрэггүй. Тэр Хогвартсын аварга болсон байдаг! Өнгөрсөн баасан гаригт Гермiona дэргэд нь суугаад үргэлж <<анхаарал хандуулах хэрэггүй, анхаарал хандуулах хэрэггүй>> гэж шивнэж байлаа. Өнөөдөр түүнээс илүү гэж бодохын ч хэрэггүй.

Хоолны дараа тэр Гермионатай хамт газар дорх хонгил руу орон Снеггийн анги руу очиход Слизеринийхэн энгэртээ том тэмдэг зүүсэн байв. Хормын зуур <<Үнэхээр Г.Ү.Х.Н үү?>> гэсэн бодол гялсхийв. Тэгтэл газар дорх бүрэнхий хонгилд,

СЕДРИКИЙГ ДЭМЖИЦГЭЭЕ

ТЭР ХОГВАРТСЫН ЖИНХЭНЭ АВАРГА гэсэн бичиг үзэгдэв.

- Таалагдаж байна уу, Поттер? Энэ ч бас бүгд биш шүү! гэж Харригийн ирэхийг хараад Малфой хөөрөн дуу алдав.

Тэр тэмдгээ зүлгэхэд улаан бичиг нь алга болоод ногооноор,

ПОТТЕР ӨМХИЙ! гэсэн бичиг гарч ирэв.

Слизеринийхэн хөхрөлдөв. Бүгд нэгэн зэрэг тэмдгээ арчихад Харри эргэн тойрондоо ногоон үсэг гялсхийхийг харав. Түүний нүүр хүзүү нь халуу оргив.

- Их инээдтэй байна! Маш ухаантай байлаа! гэж Гермиона даажигнан хэлээд Слизериний бүгдээс чанга инээж буй Пэнси Паркинсон гэдэг охины зүг харав.

Рон ханын дэргэд Дин, Симус хоёрын хамт зогсож байв. Тэр инээсэнгүй хэдий ч Харри руу ирсэнгүй.

- Грэйнджер чамд өгөх үү? гээд Малфой Гермионад тэмдэг сунгав.

- Ёо, намайг битгий түлх л дээ. Би саяхан гараа угаасан. Ямар цэвэр болохыг нь харж байна уу. Бохир цусаар бохирдуулахыг хүсэхгүй байна.

Харри тэссэнгүй. Эдгээр өдрүүдэд цээжинд нь хуримтлагдаж байсан уур нь дэлбэ үсэрлээ. Тэр халааснаасаа шидэт саваагаа гаргахад Слизеринийхэн айсандаа ухрав.

- Харри! гэж Гермиона анхааруулан хашгирав.

- Алив үзэх үү, Поттер. Грюм энд байхгүй болохоор чамайг хэн ч хамгаалахгүй. Зоригтойгоороо чи эхэл гэж Малфой хэлээд саваагаа гаргалаа.

Хормыг нэг хуваасны төдийд тэд бие биенийхээ нүд рүү хараад зэрэг хашгирлаа.

- Фурункулюс! гэж Харри орилсон бол,

- Дантисимус! гэж Малфой хашгирчээ.

Тэдний саваанаас оч харван зөрөлдөв. Харрийн оч Гойлын нүүрийг оносон бол, Малфойн оч Гермионаг оножээ. Гойл үзэшгүй муухай буцалж байгаа хамраа бариад орилон дэвхэцлээ. Гермиона алгаараа амаа дарахад нулимс нь цийлэгнэв.

- Гермиона чи яагаа вэ? гэж Рон дуу алдаад гарыг нь холдуулав.

Тойруулан хүрээлэгсэд таагүй зүйл харав. Гермионагийн шүд алга болсноо түргэн ургав. Дараагийн агшинд тэр минжтэй төстэй болж шүд нь уруулаа давж эрүүгээ хүрлээ. Гермиона цөхөрсөндөө орь дуу тавив.

- Юун чимээ шуугиан болоод байна? гэх хоолой гарав.

Снегг хүрэлцэн иржээ.

Слизеринийхэн уралдан тайлбар тавьж эхлэв. Снегг урт хуруугаараа Малфойг заалаа.

- Чи хэл, Драко.

- Поттер намайг дайрсан, ноёнтоон.

- Бид бие биеэ рүүгээ зэрэг дайрсан! гэж Харри хашгирав.

- Харин түүний оч Гойлыг оносон. Харж байна уу?

Снегг Гойл руу харлаа. Түүний царай хортой мөөгийг санагдуулам болжээ.

- Эмнэлэг рүү яв, Гойл гэж Снегг тайван хэлэв.

- Малфой Гермионаг ясныг хараач гэж Рон түүнд хандав.

Гермиона гараа шүднээсээ холдуулахгүйг хичээсэн ч хэдийн жанчны захад нь хүрчээ. Слизеринийхэн түүнийг Снеггийн цаанаас заан инээлдэнэ.

Снегг түүнийг хүйтнээр хараад,

- Би ямар ч ялгаа харсангүй гэлээ.

Гермиона чанга дуу алдаад өсгий дээрээ эргэн дээшээ гүйж одлоо.

Харри, Рон хоёр Снегг руу зэрэг орилов. Аз болоход тэднийг хоолой чулуун хонгилд нүргэлэн юу хэлсэн нь мэдэгдсэнгүй. Гэхдээ гол санаа нь ойлгогдсон илэрхий.

- Тайвширав уу? Харин одоо сонсоцгоо. Гриффиндороос тавин оноо хаслаа. Поттер, Уизли хоёр шийтгэгдсэн болохоор хичээлийн дараа үлдээрэй. Харин одоо долоо хоногийн турш шийтгэгдэхийг хүсээгүй бол анги руугаа ор.

Харрийн чих шуугилаа. Ямар шударга бус юм бэ! Снеггийг шившлэгээр мянган хэсэг болгож хаях юмсан. Харри хамгийн сүүлд анги руу ороод цүнхээ ширээн дээр тавилаа. Рон бас уурандаа чичирч байв. Хормын турш Харрид тэдний харьцаа хэвийн болох шиг санагджээ! Гэхдээ зөвхөн хормын турш шүү! Рон Дин, Симус хоёрын дэргэд суухад Харри ахиад л ганцаараа үлдэв. Ангийн нөгөө өнцөгт Малфой эргэж хараад тэмдгээ зүлгэн инээлээ. <<ПОТТЕР ӨМХИЙ>> гэсэн ногоон гэрэл гялсхийв.

Харри хичээл дээр янз бүрийн аймшигтай зүйл төсөөлөв. Тэр Снеггт Криуцатиус илгээлээ. Снегг нуруугаараа унаж аалз шиг хөл гар нь татвалзана...

- Ерөндөг! Та нар жороо бэлтгэсэн байх ёстой. Одоо болгоомжтой чанацгаа. Дараа нь хэн нэгнийг сонгон авч туршиж үзэх болно гэж жинхэнэ Снегг нүдээ ууртайгаар гялалзуулан хэлэв.

Түүний харц Харри дээр тусав. Харри юу болохыг ойлголоо. Снегг одоо түүнийг хордуулах гэж байна. Тэр тогоогоо аваад ангийн урд гүйн гарч Снеггийн тослог үстэй толгойг доош нь дарж байгаа нь төсөөлөгдөв...

Мөрөөдлийг газар дорх хонгилын хаалга цохих чимээ таслав.

Ангид Колин Криви орж ирээд Харри руу инээмсэглэн Снеггийн ширээ рүү рүү очлоо.

- За? хэмээн Слизерин тэнхимийн эрхлэгч хөндий асуув.

- Уучлаарай, ноёнтоон Харриг дээр дуудаж байна.

Снегг Колин руу унжуу хамраа бөхийлгөхөд хөөрсөн царайных нь инээмсэглэл алга боллоо.

- Поттер ахиад нэг цаг уусмалын хичээл хийх ёстой. Дээшээ хичээлийн дараа явах болно гэж тэр хүйтнээр хэлэв.

Колин улайлаа.

- Ноёнтоон гэхдээ түүнийг ноён Бэгмен хүлээж байгаа шүү дээ. Бүх аваргууд очих ёстой. Тэдний зургийг авах гэж байгаа байх гэж тэр айсан хоолойгоор хэлэв.

Зураг авах гэнээ! Тэр яах гэж үүнийг хэлдэг байна! Харри Рон руу хяламхийн харахад адар руу ширтэж байлаа.

- Сайн байна. Поттер энд цүнхээ орхиорой. Чи уусмал шалгахад надад хэрэг болно шүү гэж Снегг хэлэв.

- Ноёнтоон Харри цүнхээ авах ёстой. Бүх аваргууд... гэж Колин дуугарав.

- Их сайн байна! Цүнхээ аваад миний нүднээс далд ор! гэж Снегг зандрав.

Харри цүнхээ мөрөн дээрээ тавиад хаалга руу явлаа. Түүнийг Слизеринийхний ширээний хажуугаар өнгөрөхөд <<ПОТТЕР ӨМХИЙ>> гэсэн ногоон гэрэл дараалан асаж байлаа.

- Ямар гайхалтай юм бэ, Харри? Чи аварга гээд төсөөлөөд үз дээ! гэж Колин хаалганы цаана гараад дуржигнуулав.

- Тиймээ, гайхалтай байна. Тэд зураг авч яах гэж байгаа юм бол? гэж Харри санаа алдан дээшээ өгслөө.

- <<Зөнч>> сонинд тавих байх!

- Гайхалтай! Энэ л надад хэрэгтэй байсан юм. Зар сурталчилгаа гэж Харри дүнсгэр хэлэв.

- Амжилт хүсье! гээд Колин хаалганы өмнө салав.

Харри тогшоод дотогш орлоо.

Энэ бол багахан анги байлаа. Ихэнхи ширээнүүдийг холдуулан голд нь хоосон зай үүсгэжээ. Хар самбарын өмнө хилэн бүтээлгээр бүтээсэн ширээ тавьжээ. Түүний ард таван сандал үзэгдэнэ. Нэгэн дээр нь Людо үл таних ягаан жанчтай эмэгтэйтэй ярилцан сууж байлаа.

Виктор Крам буланд ердийнхөөрөө бодлогоширон харж зогсоно. Седрик Флер хоёр хөөрөлдөнө. Флерийн царай сэтгэл хангалуун байв. Тэрбээр толгойгоо хаялахад урт мөнгөлөг үс нь намирав. Яльгүй утаа уугисан том хар гэрэл зургийн дуран барьсан гүзээтэй хүн Флерийг булангаас сониучирхан харна.

Харриг хараад Бэгмен үсрэн босож баяртайгаар ирэв.

- Аан тэр ирлээ! Манай дөрөв дэх аварга. Харри, орооч. Санаа зовох хэрэггүй зөвхөн шидэт саваа шалгах ёслол болох гэж байгаа юм. Одоохон шүүгчдийн баг ирнэ.

- Шидэт саваа шалгах гэнээ? хэмээн Харри бодлогоширон асуулаа.

- Ямар нэгэн гэмтэл байгаа эсэхийг заавал шалгах хэрэгтэй. Энэ бол тэмцээний гол дүрэмд орсон байгаа. Мэргэжилтэн дээр захиралтай уулзаж байгаа. Ёслолын дараа та нарын зургийг авах юм. Рита Скитертэй танилц. Тэр <<Зөнч>> сонинд тэмцээний тухай багахан мэдээлэл нийтлүүлэх гэж байгаа юм гээд Бэгмен ягаан жанчтай эмэгтэй рүү дохив.

- Багахан бишээ, Людо гэж Рита Скитер засаж хэлээд Харри руу харав.

Түүний гоёмсог хийцийн мушгиа үс нь том эрүүтэй нь хачирхалтайгаар хослоно. Үнэт чулуугаар хийсэн нүдний шил зүүж, хумсаа улаанаар будсан агаад урт хуруугаараа матрын арьсан цүнхээ хэлтгий барьжээ.

- Ёслол эхлэхийн өмнө Харригаас багахан ярилцлага авч болох уу? Хамгийн залуу аварга шүү дээ гэж тэр Бэгменд хандан хэлэхдээ Харригаас харцаа салгасангүй.

- Тэгэлгүй яахав! Харри чи татгалзахгүй биз дээ? гэж Бэгмен хашгирав.

- М-м гэж Харри гүнгэнэв.

- Тааламжтай байна гэж Рита Скитер хэлээд улаан хумстай гараараа Харригийн тохойноос зуурлаа. Сурвалжлагч түүнийг өрөөнөөс гаргаж ойролцоох хаалга руу авчрав.

- Тэнд чимээ шуугиан ихтэй юм. Энд нам гүм болохоор ярилцахад тохьтой.

Харри түүн рүү мэгдэн харлаа. Тэд шүүр, хувин хадгалдаг пинд оржээ.

- Ор ор хонгор минь... зүйтэй... гээд Рита Харриг хатуу цаасны хайрцаг дээр түлхэн суулгаж өөрөө хувин хөмөрч суугаад хаалга хаалаа.

- Эхлэх үү.

Тэрбээр матрын арьсан цүнхээ нээгээд лаа асааж шидэт саваагаараа хөөргөв.

- Харри чи Түргэн бичигч үзгийг эсэргүүцэхгүй биз дээ? Тэгж байж би чамтай чөлөөтэй ярилцаж чадах юм.

- Тэр чинь юу юм бэ?

Рита Скитер нүүр дүүрэн инээмсэглэв. Харри гурван алтан шүд байхыг тоолов. Рита цүнхнээсээ урт ногоон үзэг хуйлсан цаас гаргав. Түүнийгээ хатагтай Сковерийн ид шидийн таагүй явдлыг арилгагчын хайрцган дээр тавилаа. Тэрбээр ногоон үзгээ амандаа суугаад сэтгэл хангалуунаар цаасыг дэлгэв. Тэгтэл үзэгний үзүүр чичирлээ.

- Туршиж үзье.... Намайг Рита Скитер гэдэг. <<Зөнч>> сонины сурвалжлагч.

Харри үзэг руу харав. Рита амаа нээж амжаагүй байхад үзэг цаасан дээгүүр сараачиж эхлэв.

Дур булаам цайвар үстэй Рита Скитер. Дөчин гурван настай. Түүний хурц үзэг алдар хүндийн төлөө үйл явдлыг хөөргөдөн...

- Сайн байна гээд Рита цаасыг авч цүнхэндээ шургуулаад Харригийн зүг тонгойн,
- Тэгэхээр юу чамайг Гурван шидтэний тэмцээний оролцогч болгоход хүргэсэн бэ?
гэв.

- М-м гэж Харри бувтналаа. Түүнийг юу ч хэлээгүй байхад үзэг цаасан дээгүүр чавхдан шинэхэн өгүүлбэр бичив.

Эмгэнэлт явдлаас үлдсэн үзэшгүй муухай сорви Харри Поттерын нүднээс бусдыг зэрэмдэглэжээ...

- Харри үзгэнд анхаарал хандуулах хэрэггүй дээ гэж Рита Скитер хатуу хэлэв. Харри дургүйхэн дээшээ харав.

- Чи яагаад цомд нэрээ хийхээр шийдсэн юм бэ?

- Би түүнийг хийгээгүй. Хэн миний нэрийг цомд хийснийг мэдэхгүй. Би түүнд ойртоогүй.

Рита Скитер зурагтай хөмсгөө зангидав.

- Чамд юу ч болохгүй, Харри айх хэрэггүй. Бид бүгд чи хорио зөрчсөнийг мэдэж байгаа. Санаа зовох хэрэггүй. Манай уншигчид сахилгагүй занд дуртай байдаг юм.

- Гэхдээ би юу ч зөрчөөгүй шүү дээ. Би хэн гэдгийг нь мэдэхгүй...

- Тэмцээний өмнө юу мэдэрч байна даа? Сэтгэл хөдөлж байна уу? Санаа зовж байна уу?

- Би... би мэдэхгүй... магадгүй санаа зовж байх шиг байна гэж Харри хэлэхэд зүрх нь түгшлээ.

- Өмнөх тэмцээний хэд хэдэн аваргууд үхсэн. Чи энэ тухай юу гэж бодож байна? гэж Рита хэрцгий хэлэв.

- Тэгж ярьцгаадаг л юм. Энэ жил аюулгүй болно гэж хэлсэн.

Үзэг цаасан дээр тэшүүрээр гулгаж байгаа аятай чохруулан гүйнэ.

- Чи урьд нь үхэлтэй тулгарч байсан биз дээ. Чи энэ тухай юу гэж хэлмээр байна? гээд Рита түүнийг ойртон харлаа.

- М-м гэж Харри ахин гүнгэнэв.

- Хүүхэд насандаа авсан шархаа эдгээх гээ юу? Эсвэл нэрээ өргөхийг хүсээ юу? Алдар гавьяагаа батлах гэсэн юм уу?

- Би нэрээ хийгээгүй гэж Харри уурсаж эхлэв.

- Чи эцэг эхээ санадаг уу? гэж Рита сэдвийг өөрчлөв.

- Үгүй.

- Тэдний хүү Гурван шидтэний тэмцээнд орох болсноо мэдээд яаж баярлах байсан гэж бодож байна? Бахархах байсан болов уу? Түгших байсан болов уу? Эсвэл уурлах байсан юм уу?

Харри жинхэнээсээ уурслаа. Тэр хаанаас эцэг эхийнхээ тухай мэдэх билээ дээ? Харин энэ эмэгтэй түүнийг анхааралтай харж байна. Харри хөмсөг зангидан түүнээс харц буруулахын тулд үзэг руу харлаа.

Бидний яриа эцэг эх дээр нь хүрэх үед маргад ногоон нүдэнд нулимс дүүрэв. Тэр тэднийг бараг санаж байлаа.

- Миний нүдэнд ямар ч нулимс байхгүй! гэж Харри хашгирлаа.

Рита Скитер хариулж амжихаас урьтаж пингийн хаалга нээгдэв. Харри хурц гэрэлд нүдээ анивчин эргэж харлаа. Үүдэн дээр Альбус Дамблдор зогсоод <<Зөнч>> сонины сурвалжлагч болон давчуу хонгилд шахагдсан олз руу нь харлаа.

- Дамблдор! гэж Рита Скитер баяртай хашгирав. Үзэг цаас хоёр агшин зуур ид шидийн таагүй явдлыг арилгагчын хайрцаган дээрээс алга болоход сэтгүүлч яаран матрын арьсан цүнхээ хаав.

- Ямар шуу байна даа? Та миний олон улсын шидтэнгийн холбооны бага хурлын тухай сурвалжлагыг уншсан гэж найдаж байна? хэмээн Рита том эршүүд гараа Хогвартсын захиралд сунгалаа.

- Жигшүүртэй муухай. Ялангуяа та намайг хөгшин зөнөг гэж бичсэн байсан гээд Дамблдорын нүдний шил гялсхийв.

Рита Скитер өчүүхэн төдий ч ичсэнгүй.

- Би зөвхөн таны хуучин загварыг тодотгохыг хүссэн юм, Дамблдор. Олонхи жирийн шидтэнгүүд гудамжинд...

- Таны гүтгэлгийн шалтгааныг би сонсохдоо баяртай байх болно, Рита. Гэхдээ бидний яриа өөр үед үргэлжлэх байх гэж айж байна. Одоо хормын дараа шидэт саваа шалгах ёслол эхлэх гэж байхад нэг аварга шалны хувин, шүүртэй пинд нуугдаж байна.

Рита Скитерээс зугатаасандаа баярласаар Харри яаран анги руу эргэж оров. Аваргууд хаалганы хажуугийн сандал дээр сууж байв. Тэр түргэхэн шиг Седрикийн хажууд суулаа. Хилэн хар бүтээлэгтэй ширээнд хэдийн дөрвөн шүүгч суужээ. Профессор Каркаров, хатагтай Максим, ноён Крауч бас Людо Бэгмен. Рита буланд суугаад цүнхээ нээн өвдгөн дээрээ цаас дэлгээд Түргэн бичигч үзгээ гаргаж тавилаа.

- Та нарт ноён Оливандерыг танилцуулахыг зөвшөөрнө үү. Тэр та нарын савааг тэмцээний сорилтонд оролцоход бэлэн эсэхийг шалгах болно гэж Дамблдор шүүгчдийн ширээнээс аваргуудад хандан хэллээ.

Харри цонх руу эргэн харлаа. Тэнд хижээл насны том саарал нүдтэй шидтэн зогсож байв. Энэ ч түүний хуучин танил байна даа! Гурван жилийн өмнө Харри түүнээс шидэт саваагаа худалдаж авсан шүү дээ.

- Хатагтай Делакур хэрвээ татгалзахгүй бол таниас эхлэе гээд ноён Оливандер өрөөний голд очлоо.

Флер түүн рүү очин саваагаа сунгав.

- Хм-м... гээд Олливандер савааг урт хуруун дээрээ очир таяг адил эргэлдүүлэв. Саваанаас алтлаг ягаан оч гарлаа. Мэргэжилтэн түүнийг анхааралтай харж байснаа,

- Ойлгомжтой. Есөн дюйм урт зандан модон саваа... маш хатуу. Бурхан минь! Дотор нь...

- Миний эмээ болох вейлагийн толгойны үс байгаа юм.

Тэгэхээр тэр яагаад вейлатай төстэй байсан нь ойлгомжтой болов! Харри Ронд хэлэх тухай бодсон ч маргалдсанаа саналаа.

- Тиймээ... тийм. Би хэзээ ч вейлагийн үсийг саваанд ашиглаж байсангүй. Хэтэрхий хувьсамтгай саваа болдог юм. Гэхдээ таньд зохицож байгаа бол гэж Олливандер хэлэв.

Ноён Олливандерын хуруунууд саваан дээгүүр гүйн зураас овор товон байгаа эсэхийг шалгалаа.

- Орхидеус! гээд тэр савааны үзүүрээс баглаа цэцэг гаргав.

- Маш сайн ажилладаг юм байна. Ноён Диггори таны ээлж гэж тэр дуу алдаад цэцгийг саванд хийж Флерт савааг нь буцаан өгөв.

Флер суудалдаа суух замдаа Седрикт инээмсэглэл бэлэглэв.

- Аан, би өөрийн бүтээлээ танилаа. Маш сайн санаж байна. Хосгүй сайхан ганц эвэртийн азарга байсан даа. Бараг хорин метрийн урт сэрвээтэй. Намайг сүүлнээс нь хялгас зулгаах үед арай л мөргөөгүй юм. Арван хоёр инч... туяхан. Энэ ч нөхцлийг сайн хангана даа. Түүнийг цэвэрлэж байгаа юу? гэж ноён Оливандер урам зоригтой хэллээ.

- Уржигдар орой зүлгэсэн гэж Седрик инээмсэглэн хэлэв.

Харри саваагаа харлаа. Битүү хурууны хээ болжээ! Тэр жанчныхаа үзүүрээр сэмхэн зүлгэлээ. Үзүүрээс нь алтлаг оч цацрав. Флер Делакур түүн рүү хяламхийн харлаа.

Ноён Олливандер Седрикийн савааг даллахад мөнгөлөг утаа гарлаа. Тэрбээр сэтгэл хангалуунаар,

- Ноён, Крам гэж дуудлаа.

Виктор Крам залхуутайхан босч тонгойгоод мэргэжилтэн рүү очив. Саваагаа халааснаасаа гарган өгөхдөө хөмсгөө зангидлаа.

- Хм-м. Хэрвээ би андуураагүй бол энэ Грегоровичийн бүтээл үү? Маш сайн мэргэжилтэн дээ... Хэдий тийм боловч...

Тэр савааг анхааралтай эргүүлэн харав.

- Тиймээ... эвэр мод лууны хатаасан зүрх үү? гээд Крам руу харахад толгой дохив.

- Арван инчийн урт... зузаан... маш хатуу... Авис!

Савааны үзүүрээс буу буудах адил чимээ гарч жижигхэн шувуу цонх руу нислээ.

- Сайн байна гэж ноён Олливандер хэлээд Крамд савааг буцаан өглөө.

- Өөр хэн үлдлээ?... Поттер!

Харри суудлаасаа босож Крамын хажуугаар өнгөрөөд саваагаа сунгав.

- Өө! Тийм, тийм. Би үүнийг маш сайн санаж байна гээд ноён Олливандерийн нүдэнд оч дүрсхийлээ.

Харри ч бас санаж байв. Энэ нь өчигдөрхөн юм шиг санагдана.

Дөрвөн жилийн өмнө тэр Хагридын хамтаар ноён Олливандерын дэлгүүрт орж шидэт саваа худалдан авсан билээ. Эзэн түүний саваа барьдаг гарны хэмжээ авсан юм. Харри хэрэгтэй саваагаа олохын тулд маш олныг даллаж үзсэн юм. Энэ бол арван нэгэн дүймийн урттай галт шувууны өд, ганц эвэртийн сүүлний хялгасаар хийсэн саваа байсан. Ноён Олливандер тэгэхэд Харрид тэр саваа оногдсонд маш их гайхаж <<Сонирхолтой юм... сонирхолтой юм>> гэж бувтнасан. Тэгээд Харриг асуухад учрыг нь хэлсэн билээ. Галт шувууны нөгөө өд Волан-де-Мортын саваанд оногдсон юм.

Харри үүнийг хэнд ч хэлээгүй юм. Тэр Хар лордтой холбоотой хэдий ч саваандаа хайртай байлаа. Зөвхөн ноён Олливандер энэ тухай одоо битгий яриасай гэж хүслээ. Рита Скитерын Түргэн бичигч үзэг дэлбэрэх шахам баярлах биз.

Ноён Олливандер савааг бусдаас удаан судаллаа. Эцэст нь саваанаас усан оргилуур шиг дарс оргилуулаад Харрид савааг өгөхдөө маш сайн болзол хангаж байна гэж хэлжээ.

- Бүгдэд баярлааа. Одоо хичээл рүү буцацгаа. Хичээл дуусах гэж байгаа болохоор хоолондоо орсон ч болно гэж Дамблдор шүүгчдийн ширээнээс босон хэлэв.

Эцсийн эцэст сэтгэл санаа нь арай дээрдэв. Харри гарахын даваан дээр зургийн дуран барьсан хүн үсрэн босож хоолойгоо засав.

- Зураг, Дамблдор зураг авна! Бүх шүүгчид болон аваргуудын! Та юу хэлмээр байна, Рита? гэж Бэгмен хөөрөн хашгирав.

- Тэгэлгүй яахав. Эхлээд бүгдээрээ дараа нь тусдаа гэж тэр Харри руу харж хэлэв.

Зураг авах явдал удтал үргэлжлэв. Хатагтай Максим бүгдийг халхалж байсан болохоор түүнийг зурагчин хүрээнд багтааж чадсангүй. Эцсийн эцэст тэр сууж бусад нь босон авхуулав. Каркаров хуруугаараа ямаан сахлаа имэрч нэмэлт мушгиа үүсэв. Крам ард нь байр эзлэв. Зурагчин Флерийг голлуулахыг хүссэн ч Рита яаран хориглож голд нь Харриг тавив. Зураг бэлэн болох үед тэр тэмцээний оролцогчдыг салангид авхуулахыг шаардав.

Эцэст нь бүгд тарав. Харри хооллохоор явлаа. Гермiona эмнэлэг рүү шүдээ багасгуулахаар явсан болохоор байсангүй. Ганцаар хооллоод цамхаг руугаа Татдаг шидийн тухай бодсоор явлаа. Унтлагын өрөөнд Рон ганцаар байв.

- Чамд ууль ирсэн гэж тэр бувтнаад Харрийн ор луу заав. Түүний дэрэн дээр сургуулийн ууль байв.

- Баярлалаа.

- Снегг шийтгэлээ маргааш орой болгож хойшлуулсан гээд Харри руу харалгүй өрөөнөөс гарч одлоо.

Харри түүний араас гүйх үү яахав гэж бодов. Ярилцах уу? Эсвэл буулт хийх үү? Өөр зүйл муугүй л юм. Гэтэл Сириусаас хариу ирсэн байдаг. Харри уульнаас авч захиаг аван нээж уншлаа.

Харри.

Би чамд хүсч байгаа болгоноо захианд хэлж чадахгүй нь. Хэрвээ ууль баригдвал хэтэрхий аюултай. Бид нүүр нүүрээ харалцан ярилцах хэрэгтэй байна. Танай амралтын өрөөний ханан зууханд арван нэгэн сарын хорин нэгнээс хорин хоёронд шилжих шөнө уулзая.

Энэ хэн ч байлаа гэсэн Дамблдор, Грюм хоёрыг байхад чамд хор учруулахгүй гэдэгт итгэлтэй байна. Хэдийгээр сайн оролдлого хийсэн ч гэсэн. Чиний нэрийг цомд Дамблдорын хамар дор хийнэ гэдэг чинь эрсдэлтэй зүйл шүү дээ.

Сонор соргог байгаарай Харри. Би өмнөхийн адил шилтгээнд болсон ер бусын бүх зүйлийг мэдэх хэрэгтэй байна. Хорин хоёронд аль болох түргэн уулзья.

Сириус

БҮЛЭГ 19: УНГАРЫН ЭВЭР СҮҮЛТ

Хоёр долоо хоногийн турш Харри Сириустэй уулзах найдлагаар амьдрал. Энэ бол харанхуй тэнгэрийн хаяанд сулхан гэрэл тусахтай адил зүйл байлаа. Эхний тэмцээн хаяанд иржээ. Түүний өмнө аймшигт мангас юм уу саадтай зам байгаа эсэхийг хэлж мэдэхгүй байв. Харри нэг ч тэмцээний өмнө ингэж сэтгэл түгшиж байсангүй. Тэр ч байтугай Слизериний эсрэг тоглосон сургуулийн квиддичийн цомын тэмцээн дээр ч гэсэн шүү дээ.

Одоо тэр ямар нэг ирээдүйн талаар бодож чадахааргүй болжээ. Түүний бүх амьдрал эхний тэмцээн яаж дуусахаас хамаарах юм шиг санагдана.

Үнэнийг хэлэхэд Сириус энэ айдсыг давахад туслах эсэхийг тэр төсөөлөхгүй байв. Ямар нэгэн үл мэдэгдэх аймшигтай аюултай шидийн өмнө олон зуун үзэгчийн нүдэн дээр зогсох болно. Гэхдээ уулзалт түүнийг жаахан ч гэсэн сэргээж байлаа. Харри загалмайлсан эцэгтэй тухайн цагт түүнийг амралтын өрөөндөө хүлээж байх болно гэж хариу бичжээ. Тэр Гермионатай санамсаргүй гэрчгүй яаж уулзах талаар удаан ярилцав. Хамгийн муу тохиолдолд шивхэн бөмбөг дэлбэлж болох юм. Гэхдээ Филчтэй орооцолдох болохоор үүнийг хүсэхгүй байв.

Тэр үед шилтгээнд юу ч болсонгүй. Рита Скитер <<Зөнч>> сонинд Гурван шидтэний тэмцээний тухай мэдээлэл өгчээ. Гэхдээ тэнд тэмцээний тухай ярьсан нь бага. Ихэнхи хэсгийг нь Харригийн амьдралын түүх эзэлжээ. Сонины тэргүүн нүүрэнд гэрэл зураг нь байлаа (хоёр, зургаа, долдугаар нүүрэнд ч гэсэн адил). Тэрбээр Шармбатон, Дурмстрангын аваргуудын тухай хальт дурьдаад харин Седрикийн нэр огт гарсангүй.

Арван өдрийн өмнө гарсан сурвалжлагыг Харри санах болгондоо газар цөмрөөд орчихмоор санагддаг юм. Рита Скитер түүний пинд ч тэр амьдралдаа ч тэр хэзээ ч хэлээгүй үгийг бичжээ.

Миний хүч бол эцэг эхээс минь уламжлагдан ирсэн авъяас юм. Хэрвээ ээж аав хоёр минь намайг одоо харсан бол их бахархах байлаа. Би заримдаа шөнө тэднийг санахаараа уйлдаг. Би үүнээсээ ичихгүй байна. Тэмцээнд надад юу ч тохиолдохгүй гэдгийг мэдэж байна учир нь эцэг эх минь намайг тэнгэрээс харж байгаа...

Рита Скитер түүний зөвхөн <<м-м>> гэж хэлсэн үгийг уртасган хэрэгтэй өгүүлбэр болгон хувиргажээ. Бас тэр өөр сурагчдаас түүний тухай бодлыг асуусан байлаа.

Хогвартсад Харри хайртайгаа учирчээ. Түүний дотны анд Колин Криви хэлэхдээ Харри маглуудаас гаралтай түүний адил сургуулийн гялалзсан сурагч болох хөөрхөн охин Гермиона Грэйнджертэй хаа сайгүй явж байдаг гэж мэдэгдсэн байна.

Сурвалжлага гарсны дараахан Харри хүмүүсийг тэвчин өнгөрүүлэх хэрэгтэй болжээ. Слизеринийхэн түүнийг хажуугаар нь өнгөрөх болгонд инээлдэн хашгиралдаж байлаа.

- Чамд нусны алчуур өгөх үү, Поттер? Гэнэт хувиргалын хичээл дээр уйлаад эхлэвэл яана!

- Тэгэхээр чи сургуулийн гялалзсан сурагч хэрэг үү? Долгопупс та хоёр Хогвартсыг үндэслэсэн юм биш биз?

- Харри сайн уу! гэх хэн нэгний хоолой сонсогдов.

- Тиймээ гээд Харриг хонгилоор эргэн явахад араас нь,

- Бүгдийн нүдэн дээр уйлсан гэнээ! Явж уйл! гэж хашгирах сонсогдож байлаа.

- Чи яагаа вэ? Үзгээ хаячихлаа!

Энэ бол Чжоу Чанг байлаа. Харри үзгээ авахдаа улайжээ.

- Уучлаарай... гэж зөвхөн хэлж амжив.

- Мягмар гаригт амжилт хүсье. Чамайг сайн тэмцэнэ гэдэгт итгэлтэй байна гэж хэлээд Чжоу явчихлаа.

Харри хичнээн тэнэг харагдсанаа мэдэрлээ.

Гермиона таагүй сэтгэгдлийг хуваалцсаар ирэв. Гэхдээ тэр тэднийг тоосонгүй. Харри түүний ирсэн явдалд баярлав.

- Гайхалтай хөөрхөн гэнэ ээ? Тэр үү? Минийхээр бол <<Хатагтай жирх!>> хэмээн Ритагийн сурвалжлагыг дөнгөж уншсан Пэнси Паркинсон орилов.

- Анхаарах хэрэггүй дээ, Харри. Битгий тоо гэж Гермиона хэлээд толгойгоо бардам өргөн инээлдэж буй Слизериний охидуудын хажуугаар явлаа.

Тэр яаж анхаарахгүй байж чадах билээ? Харрид Снеггийн шийтгэлийн талаар мэдэгдсэнийхээ дараа Рон юу ч ярьсангүй. Харри газар дорхи хонгилд Ронтой бүтэн хоёр цаг хархын тархи даршилах үедээ харилцаа сайжирна найдаж байсан юм. Гэвч Рита Скитерийн ярилцлага гарсны дараа тэр алдараараа бахархаж байгаа хүн болон хувирчээ.

Гермиона тэдэнд их уурлажээ. Тэр нэг нэгэн рүү нь гүйн хүчээр эвлэрүүлэхийг хичээж байсан ч Харри тууштай байлаа. Тэр Роныг цомд нэрээ хийгээгүй гэхэд худалч гэж хэлсэндээ уучлал гуйсан цагт л ярих болно.

- Би үүнийг эхлээгүй. Тэр л уучлал гуйг гэж Харри зөрүүдлэв.

- Чи түүнгүй байж хангалттай! Түүнд ч гэсэн чамайг байхгүйд хэцүү байгааг мэдэж байна! гэж Гермионагийн тэвчээр алдагдан хэлэв.

- Түүнгүй гэнэ ээ? Би түүгээр дутаагүй... гэж Харри уурслаа.

Гэхдээ энэ худал гэдэг нь илэрхий байлаа. Гермиона түүний хамгийн сайн найз хэдий ч Роныг орлож чадахгүй юм. Тэр түүнтэй номын сангаас номын санд суун өнгөрүүлж байлаа. Харри Татдаг шидийг эзэмшээгүй болохоор ямар нэг зүйл хааж байна гэж үзээд Гермиона онол сурахыг шаардсан юм. Үр дүнд нь үдийн хоолны дараах бүх цагийг номны дунд өнгөрүүлэх болов.

Виктор Крам бас номнуудын дунд олон цагийг өнгөрүүлдэг байв. Юу түүнийг ийш нь авчраа вэ? Юу судалж байгаа юм бол? Эсвэл эхний тэмцээнд бэлтгэж байгаа юм болов уу? Гермиона Крам номын санд саад болж байна гэж үргэлж гомдоллодог байлаа. Үнэндээ Крам тэдэнд саад болоогүй ч номын тавиурын ар өврөөр инээлдэн дагадаг охид нь төвлөрөхөд саад болж байлаа.

- Тэд түүнээс юугаа олсон юм бол! Тэр царайлаг биш шүү дээ! Зөвхөн алдартай болохоор нь охид араас нь гүйж байгаа юм! Хэрвээ Вонки Финт шиг амьтан байсан бол тоож харгахгүй байсан гэж Гермиона уурсав.

- Вонки биш Вронски гэж Харри бувтналаа. Квиддичийн сэдвийг засахын сацуу Роны Гермионагийн Вонки Файнтын тухай сонссон бол царай нь яахыг төсөөлж байлаа.

Хачирхалтай нь тэр санаа зовох тусам цаг хугацаа эсрэгээрээ галзуурсан юм шиг хурдан өнгөрч байв. Анхны тэмцээний өдрийн хугацаа хэн нэгэн цагийн зүүг хоёр дахин хурдлуулчихсан аятай ойртож байв. Харриг хаашаа ч явсан гэсэн Рита Скитерийн сурвалжлагын доогтой инээд дагалдаж байлаа.

Анхны тэмцээний өмнөх Бямба гаригт гуравдугаар дамжааны зөвшөөрөлтэй сурагчид Хогсмид явж эхлэв. Гермиона түүнийг шилтгээнийг жаахан ч гэсэн орхих хэрэгтэй гэж ятгаж байсан Харрид тийм ятгалаг хэрэггүй байлаа.

- Роны тухайд юу гэж бодож байна? Чи түүнтэй явахыг хүсч байна уу?

- Э-э... Бид түүнтэй Гурван шүүрт уулзаж болох юм гэж бодлоо хэмээн Гермиона үл мэдэг улайн хэлэв.

- Яагаад ч үгүй! гэж Харри эсэргүүцэв.

- Гэхдээ энэ чинь тэнэг хэрэг шүү дээ...

- Би очсон ч Ронтой уулзахгүй. Үл үзэгдэх цув өмсөөд явна.

- За яахав тэг л дээ... Гэхдээ би чамайг жанчтай байхад чинь ярихыг үзэн яддаг. Чамайг байгаа эсэхийг чинь мэдэхгүй шүү дээ.

Харри унтлагын өрөөндөө үл үзэгдэх цуваа өмсөөд шат уруудан Гермионагийн хамтаар Хогсмид явлаа.

Харри жанчин дор ямар гайхамшигтай эрх чөлөөтэй болохыг мэдрэв. Дэргэдүүр нь <<Седрикийг дэмжиж байна>> гэсэн тэмдэг зүүсэн сурагчид өнгөрсөн ч хэн ч түүнийг хараагүй болохоор тоглоом наадам хийсэнгүй!

- Хүмүүс намайг хараад байна. Намайг өөртэйгээ ярьж байна гэж бодно доо гэж Гермиона <<Амтат Ван>>-д орж цөцгийтэй шоколад идсэнийхээ дараа хэлжээ.

- Уруулаа аяархан хөдөлгөн яриад үздээ.

- Алив л дээ жаахан ч гэсэн жанчаа тайл. Энд чамайг хэн ч харгахгүй.

- Тийм гэж үү! Чи харна биз дээ!

Гурван шүүрээс Рита Скитер болон зурагчин хоёр гарч ирлээ. Тэд ярилцсаар Гермионагийн дэргэдүүр түүнийг харалгүй өнгөрөв. Харри дэлгүүрийн хананд наалдахад Ритагийн матрын арьсан цүнх арай шүргэчихсэнгүй өнгөрлөө. Эцэст нь хоёулаа далд оров.

- Тэд тосгонд буудаллажээ. Эхний тэмцээнийг харахаар ирээд байгаа юм байна гэж Харри хэлэхдээ дотор нь хүйт оргилоо. Гэхдээ айдсынхаа тухай Гермионад ярьсангүй. Тэр Гермионаг энэ тухай бодоосой гэж хүсэхгүй байв.

- Тэр явчихлаа. Явж Гурван шүүрт орж цөцгийний шар айраг ууя. Би даарч байна гэж Гермиона Харриг нэвт харж хэлээд,

- Ронтой ярина гэж айх хэрэггүй гэж чимээгүй байхад нь уурсан нэмэрлэв.

Гурван шүүрт үйлчлүүлэгчид дүүрэн байсны ихэнхи нь хагас сайны чөлөөгөөр яваа Хогвартсын сурагчид байлаа. Гэхдээ тэнд өөр газар харж болохооргүй янз бүрийн шидтэнгүүд байлаа. Хогсмид бол Английн зөвхөн шидтэнгүүд амьдардаг цорын ганц тосгон болохоор зүсээ хувиргасан шидтэн шулмууд ирдэг юм.

Олон хүн дунд үл үзэгдэх цувтай явах маш хэцүү байлаа! Хэн нэгэнтэй санамсаргүй мөргөлдчихгүйн тулд замаас нь хазайн явж байлаа. Гермиона түүнд шар айраг авахад Харри удаанаар хана даган булангийн хоосон ширээ рүү явлаа. Замдаа ихрүүд болон Ли Жордангийн хамт сууж байгаа Роныг олж харав. Тэрбээр хуучин найзынхаа шилэн хүзүү рүү буулгаад өгөх хүсэлдээ автсаар ширээнд хүрч суулаа.

Хормын дараа Гермиона хүрч ирээд жанчин дор нь цөцгийний шар айраг шургуулж өгөв.

- Би ганцаар сууж байгаа болохоор тэнэг харагдаж байгаа байх даа. Аз болоход хийх зүйл авчирч.

Тэр Г.Ү.Х.Н-ийн гишүүдийн богинохон жагсаалт бүхий тэмдэглэлийн дэвтэр гаргаж ирэхэд Харри болон Роны нэр тэргүүнд нь байлаа. Гермиона тэднийг нарийн бичиг, няраваараа сонгосноос хойш бараг бүтэн зуун өнгөрсөн шиг санагдана.

- Би нийгэмлэгтээ тосгоноос хэдэн гишүүн элсүүлж болох юм хэмээн Гермиона баарны хүмүүсийг ажиглангаа мөрөөдөнгүй хэлэв.

- Болох л юм. Гермиона чи хэзээ толгойноосоо энэ нийгэмлэгээ авч хаях юм бэ? гээд Харри шар айргаа балгалаа.

- Гэрийн үйлчлэгч нар цалин хөлс авч ажиллах нөхцөл нь сайжрах үед үед гэж Гермиона уруулаа хөдөлгөхгүй шахам хэлээд,

- Минийхээр бол илүү идэвхтэй үйл ажиллагаа хэрэгтэй. Чи шилтгээний гал зууханд яаж орохыг мэдэхгүй биз? гэв.

- Мэдэхгүй. Фред, Жорж хоёроос асуу.

Гермона гүнзгий бодлогошироход Харри шар айргаа уунгаа бааранд байгаа үйлчлүүлэгчдийг харав. Тэдний байдал хөгжилтэй сайхан байлаа. Эрни МакМиллан, Ханна Аббот хоёр зэргэлдээх ширээнээс школадан мэлхийний зураг солилцоно.

Хоёулангынх нь жанчин дээр <<Седрикийг дэмжиж байна!>> гэсэн тэмдэг байх аж. Хаалганы баруун талын суудал дээр Чжоу Когтевраны найзтайгаа байлаа. Түүний энгэр дээр тэмдэг байсангүй явдал нь сэтгэлийг нь арай дээрдүүллээ.

Эдэн шиг аз жаргалтай байх юмсан! Найзуудынхаа дунд суугаад инээлдэн ярилцах юмсан. Гэрийн даалгавараас ондоо зүйл бодохгүй байх юмсан. Түүний нэрийг цомд хийгээгүй ийшээ үл үзэгдэх цувтай ирээгүй байх юм сан. Дэргэд нь Рон сууж байсан бол. Гурвуулаа мягмар гаригт аваргад ямар хэцүү байх талаар төсөөлөн хөөрөлдөх юмсан. Тэр тэмцээнийг үзэгчдийн суудлаас үзэхийг ямар их хүснэ вэ! Бүгдийн хамт Седрикийг үзэгчдийн аюулгүй суудлаас дэмжээд л...

Өөр аваргуудад ямар санагдаж байгаа бол? Седрик үргэлж эргэн тойрондоо хөгжөөн дэмжигчдээр хүрээлүүлсэн байдаг. Мэдээж санаа зовж байгаа ч сэтгэл нь догдолж байгаа. Хонгилд заримдаа Флер Делакуртай тааралдах үед үргэлж ихэмсэг агаад тайван амгалан байдаг. Крам номын санд овоолсон номны ард суудаг.

Харри Сириусын тухай бодлоо. Тэгтэл шимширч байсан сэтгэл нь арай тайвширав. Удахгүй тэд амралтын өрөөний хана зууханд уулзах болно. Сүүлчийн удаагийн цугларалт шиг.

- Хараач, Хагрид байна! гэж Гермiona хэллээ.

Хагридын сэгсгэр толгой олон хүний дундаас цухуйв. Харри түүнийг шууд ажигласангүйдээ гайхлаа. Тэрбээр Грюмтэй суугаад ямар нэг юмны тухай аяархан бөхийн шивнэлдэж байв. Ердийнхөөр түүний дэргэд том сэнжтэй шилэн аяга байхад, Хурц нүдэт дашмагтайгаасаа балгаж байв. Гурван шүүрийн элэгсэг эзэгтэй хатагтай Розмерта ширээн дээрээс шилэн аягануудыг цуглуулан дашмаг болон түүний эзэн рүү муухай харав. Харваас энэ нь түүнийг доромжилсон хэрэг байлаа. Гэхдээ Харри учир юунд байгааг мэдэж байв. Грюм тэдэнд хар урлагаас хамгаалах сүүлчийн хичээл дээр өөрийн бэлтгэсэн хоолыг идэж уухыг эрхэмлэдэг гэсэн юм. Хар шидтэн аяга руу нь хор хийчихэж магадгүй шүү дээ.

Хагрид Грюм хоёр үүд рүү явлаа. Харри үл үзэгдэх цувтай байгаа гэдгээ мартан тэдэн рүү даллав. Грюм зогсоход шидэт нүд нь Харрийн сууж байгаа буланд тусав. Тэр Хагридын мөрөн дээр алгандан ямар нэг юм хэлэхэд хоёулаа Гермionaгийн ширээ рүү харав.

- Юу байна даа, Гермiona? гэж Хагрид чанга хэлэв.

- Сайн уу, Хагрид зүгээр дээ гээд охин инээмсэглэв.

Грюм хазганан ширээ рүү ирээд бөхийв. Түүний анхааралыг ГҮХН-ийн гишүүдийн жагсаалттай тэмдэглэлийн дэвтэр татсан юм болов уу? Гэхдээ Харри алджээ.

- Сайхан цув байна, Поттер гэж Грюм сөөнгөтөв.

Харри гайхсандаа золтой л сандлаасаа уначихсангүй. Грюмын хамраас үлдсэн хэсэг нь хэдхэн инчийн зайд ирлээ. Тэрбээр инээмсэглэв.

- Таны нүд... таньд...

- Тиймээ. Би үл үзэгдэх цувьг нэвт харж чадна. Заримдаа энэ ашигтай байдгийг чамд хэлэх байна.

Хагрид ч бас инээмсэглэн тэмдэглэлийн дэвтэрийг харахыг хүссэн аятай бөхийгөөд Харрид,

- Өнөөдөр шөнө дунд манай овоохойд ирээрэй. Цуваа өмсөөд гэв.

Тэгснээ тэгшрэн зогсож,

- Чамтай уулзахад таатай байлаа, Гермiona гэж нүд ирмээд хаалга руу явлаа. Грюм түүнийг дагалдав.

- Тэр яагаад надтай шөнө дунд уулзахыг хүссэн юм бол? гэж Харри гайхав.

- Шөнө дунд гэнээ. Тэр юу бодсон юм бол? Чи явах ёстой гэж бодож байна уу? хэмээн Гермiona айн асууснаа ийш тийшээ харан,

- Чи Сириустэй уулзахаас хоцорч магадгүй гэж шивнэлээ.

Гермионагийн зөв байлаа. Тэр ойн сахиулд Хэдвигээр энэ шөнө очиж чадахгүй гэдгээ тайлбарлах ёстой. Хэрвээ Хэдвиг түүний уучилж нисэхийг зөвшөөрвөл шүү дээ. Гэхдээ Харри очихоор шийдлээ. Хагрид яагаад дуудсан нь сонирхолтой байв. Тэр хэзээ ч зочдоо тийм орой дууддаггүй билээ.

Арван нэг хагаст Харри амралтын өрөөнд сууж байгаад ядарсан дүр үзүүлэн унтлагын өрөө лүү явлаа. Үл үзэгдэх цуваа өмсөж өлмий дээрээ гэтэн доош буулаа. Амралтын өрөөнд хүүхдүүд сууцгааж байв. Ах дүү Криви <<Седрикийг дэмжиж байна>> гэдэг тэмдэгийг <<Харри Поттерыг дэмжиж байна>> гэсэн үгтэй болгон хувиргахыг хичээж байв. Гэхдээ тэдний зүтгэл талаар өнгөрч тэмдгэн дээр <<ПОТТЕР ӨМХИЙ>> гэсэн бичиг гарч ирлээ. Харри аяархан хөргөн гарц руу очоод хормын турш хүлээв. Гермiona хэлэлцсэн ёсоороо нүхийг нээн нууц үг хэлэн орж ирлээ. Харри талбай руу гарахдаа түүнд <<Баярлалаа!>> гэж шивнээд доош уруудав.

Гадаа харанхуй байлаа. Харри нуга дээгүүр алхан ойн сахиулын овоохойн гэрлээр олж очлоо. Гадаа нь Шармбатоны том сүйх тэргэнд бас гэрэл асаж хаа нэгтээгээс хатагтай Максимын хоолой сонсогдоно. Харри овоохойн хаалга цохилоо.

- Энэ чи юу, Харри? гэж Хагрид шивнээд хаалга онгойлгон ийш тийшээ харав.

- Тиймээ, би. Юу болсон бэ? гээд Харри дотогш орон толгойгоо ил гаргав.

- Нэг юм үзүүлэх гэсэн юм.

Хагрид ер бусын баярлаж догдолсон царайтай байлаа. Энгэртээ аварга том хадаасан цэцэг зүүжээ. Тэрбээр ширэлдсэн үсээ самнах гэж оролдсон бололтой самны хэд хэдэн хугархай шүд зүүлттэй харагдана.

- Юу үзүүлэх гэсэн юм? гэж Харри сэжигтэй асуув. Магадгүй соплохвостын өндөг авчрах юм болов уу? Эсвэл ахиад л бааранд байсан хүнээс аварга том гурван толгойтой нохой аваа юу?

- Надтай цуваа өмсөөд яваарай. Чимээгүй байхыг хичээгээрэй дээ. Соёотыг авч явахгүй. Тэр үүнд дургүй юм.

- Сонсооч Хагрид би удаж болохгүй. Арван хоёр гэхэд шилтгээнд буцсан байх хэрэгтэй байна.

Гэвч Хагрид сонссонгүй хаалга нээж харанхуйд алхан гарлаа. Харри түүний араас яаран дагалдав. Гэхдээ түүний гайхлыг төрүүлэн ойн сахиул Шармбатоны сүйх тэрэг рүү очжээ.

- Хагрид яах гэж?...

- Чш-ш-ш!... гээд ойн сахиул хуруугаа уруулдаа наан гурван удаа алтлаг шидэт саваагаар чимэглэгдсэн сүйхний хаалгыг цохилоо.

Тэдэнд торгон алчуур мөрөндөө зүүсэн хатагтай Максим хаалга онгойлгож өгөв. Зочноо хараад тэр инээмсэглэв.

- 'Агрид цаг болчихсон уу?

- Бом-свар гэж Хагрид мэндлээд аварга эмэгтэйгээс бахадсан харцаа салгалгүй алтан гишгүүрээр уруудахад нь туслав.

Хатагтай Максим хаалгаа хаалаа. Хагрид түүнд гараа өгөхөд тэд хашааны хажуугаар явж аварга том далавчтай морьдыг өнгөрөв. Харри тэдний ард үлдэхээс айн гүйлээ. Хагрид хатагтай Максим болон түүнд юу үзүүлэхийг хүссэн юм бол? Гэхдээ хатагтай Максим түүнээс дутуугүй гайхсан байлаа.

- 'Агрид та намайг хааш нь авч яваад байна? гэж тоглоом хийсэн өнгөөр дагуулагчаасаа сониучихав.

- Танд таалагдана гэдэгт эргэлзэх хэрэггүй. Хараад хэнд ч хэлж болохгүй. Та үүнийг эрт мэдлээ... гэж тэр хэлэв.

- Тэгэлгүй яахав гэж хатагтай Максим урт хар сормуусаа дэвэн итгүүлэв.

Тэгээд хоёулаа замаа үргэлжлүүлэв. Харри тэдний араас дагахыг хичээх зуураа хором бүр цагаа харж уурлах нь улам ихсэж байлаа. Ахиад л хөнгөмсөг Хагридын ямар нэгэн утгагүй төлөвлөгөө байх! Тэгтэл Сириусээс хоцорч болохгүй байдаг. Хэрвээ тэд таван хормын дараа зорьсон газартаа хүрэхгүй бол тэр эргээд шилтгээн рүү явах болно. Харин Хагрид сарны гэрэл дэх зугаалгаа хатагтай Максимтай үргэлжлүүлэн цэнгэх биз.

Тэд ой руу ороход нуур болон шилтгээн үзэгдэхээ болив. Гэнэтхэн хүмүүсийн чанга дуу сонсогдоод чих дөжрөм архиралт сонсогдов.

Хагрид хатагтай Максимыг хэсэг модны ард зогсооход Харри тэдэн рүү хүрч очлоо. Хормын нэг хувьд хурц гэрэлтэй түүдэг харагдсанаа түүний эргэн тойронд хүмүүс үзэгдэв... Тэгтэл Харри ам ангайлаа.

Луунууд.

Төмрөөр хүрээлсэн хашаанд нас бие гүйцсэн аварга том хэрцгий төрхтэй дөрвөн луунууд хөлхөлдөн чанга хүрхрэлт сонсогдож соёотой амнаасаа харанхуй тэнгэр лүү

хорин метрийн өндөрт дөл тургилж байлаа. Газраас тавин футын өндөрт хүзүү нь байв. Саарал цэнхэр өнгийн урт эвэртэй луу газар байгаа шидтэн рүү тас нясхийн архирлаа. Мөлгөр ногоон өнгийн луу хүчирхэг сарвуугаа дэвслэв. Улаан өнгийн нүүрийг нь тойрон алтан хадаасаар хүрээлсэн мэт хачирхалтай цацагтай луу галаар тургилав. Ахиад нэг хар өнгийн гүрвэлтэй адилхан луу дэргэд нь байлаа.

Нэг луун дээр долоо найм гээд гучаас багагүй шидтэн байх бөгөөд тэднийг номхотгохыг хичээн гинжнээс нь зуурч зузаан арьсан оосроор хүзүү сарвууг нь хүлж байлаа. Харри хар лууны нүд рүү харахад муурынх шиг нүдэнд нь айдас ч тэр уур хилэн ч тэр байсангүй. Амьтан цус царцаам орилов.

- Ухар Хагрид! Тэд долоон метрийн зайд галаар тургидаг гэдгийг мэдэж байгаа биз дээ. Харин энэ эвэр сүүлт бол арван таван метрийн зайд тургина! гэж хашаанаас гинж уяж байсан шидтэн хашгирлаа.

- Ямар сайхан юм бэ гэж Хагрид хэлэв.

- Тэгж битгий хэл! Гурав тооллоо шүү... Дөжрөөх шившлэг! гэж нэг шидтэн хашгирлаа.

Харри лууг тойрсон хүмүүс саваагаа гартаа барихыг харлаа.

- Отключис! гэж тэд нэгэн зэрэг хашгирахад саваанаас Дөжрөөх шившлэг галтай пуужин адил нисэн гарч лууны хайрстай арьсан дээр одон бороо оров.

Харригийн ойролцоох луу луу аюултайгаар сарвуугаа дэвсэлж найган ганхсанаа чимээгүйхэн хүрхэрсэн ч хамраас нь дөл биш утаа суунаглав. Хэдэн тонн хүнд жинтэй луу маш удаанаар газар пидхийн унахад мододын орой ганхав.

Луу сургагчид саваагаа буулган жижиг толгод шиг овойсон биесийн дундуур гүйлдлээ. Тэд яаран гинжийг чангалж төмөр гадсанд бэхлэн савааны тусламжтай газарт гүн суулгав.

- Ойроос харж болох уу? гэж хатагтай Максим Хагридад шивнэлээ. Тэд хашаанд ойртож очиход Харри араас нь дагалдав. Хагридыг анхааруулсан шидтэнд дөхөн очиход Харри Чарли Уизли болохыг нь танилаа.

- Юу байна даа, Хагрид? Тэд төдхөн сэргэнэ. Бид замдаа чимээгүй байлгахын тулд Нойрсуулах шившлэг хэрэглэсэн юм. Юу болсныг хараач. Тэд их дургүй байна... гэж Чарли амьсгаадан хэлэв.

- Энэ ямар төрлийнх вэ? гээд Хагрид хар луу руу биширсэн байртай харав. Унтаж буй лууны нүд хагас нээлттэй байв. Харанхуй үрчийсэн зовхин дороос шар судал харагдана.

- Энэ бол Унгарын эвэр сүүлт. Тэнд Уэльсийн ердийн ногоон луу байна. Түүний цаахан тал байгаа цэнхэр саарал өнгөтэй бол Шведийн богино хоншоорт. Харин улаан өнгөтэй бол Хятадын галт бөмбөлөг гэж Чарли хэлэв.

Чарли ийш тийшээ харахад хатагтай Максим хашаа руу очиж муужирсан луунуудыг харав.

- Чи хэнийг авчирсныг мэдэхгүй юм, Хагрид. Гэхдээ аваргууд тэдний юу хүлээж байгааг мэдэх ёсгүй. Харин тэр өөрийнхдөө хэлнэ дээ гэж тэр хөмсөг зангидав.
- Түүнд харсан нь дээр байх гэж бодсон юм гэж Хагрид луунаас бахадсан харцаа салгалгүй хэлэв.
- Сэтгэл хөдлөм болзоо байна даа гээд Чарли толгойгоо сэгсэрлээ.
- Тэгэхээр дөрөв байгаа юм байна. Аварга бүр нэг луутай. Тэд түүгээр юу хийх болж байна? Тулалдах юм уу?
- Тэдний дэргэдүүр өнгөрөх байх. Бид үргэлж дэргэд нь байна. Хэрвээ байдал аюултай болвол Устгах шившлэг хэрэглэх юм. Зохион байгуулагчдад яагаад ч юм эмэгчин луунууд хэрэг болсон. Яагаад гэдгийг нь ойлгохгүй юм. Би эвэр сүүлт оногдох хүнд атаархахгүй гэдийг хэлэх байна. Энэ харгис амьтан ардаасаа урдаа байгаа юм шиг аюултай. Өөрөө хар л даа.

Чарли эвэр сүүлт рүү даллахад урт хүрэл өнгийн цацаг нь хөдлөв.

Чарлигийн багийн таван хүн дэвсгэр дээр боржин чулуу шиг саарал өндөг тавин болгоомжтой зөөж ирээд лууны хажууд тавилаа. Хагрид цээжнээс хөөрсөн дуу гарав.

- Бүгд тоотой байгаа Хагрид гэж Чарли хатуу хэлээд,
- Харри хэрэг байна даа? гэлээ.
- Маш сайн байгаа гээд Хагрид лууны өндөг рүү ширтсэн хэвээр байлаа.
- Эдэнтэй уулзсаны дараа тийм байна гэж найдъя. Би ээждээ Харриг анхны тэмцээнд юу хүлээж байгааг хэлээгүй. Тэр түүнийг муурын зулзага шиг санадаг юм. <<Тэд яаж түүнийг тэмцээнд оруулж чадав аа! Тэр жижигхэн шүү дээ! Би тэднийг аюулгүй байлгахын тулд насны хязгаарлалт тогтоосон гэж бодсон юмсан>> гэж Чарли хашаа руу харангаа хатагтай Уизлигийн хоолойг дуурайн даажигнан хэллээ.
- Тэр энэ тухай <<Зөнч>> сонин дээрээс уншсан цагаасаа эхлэн нулимс асгаруулж эхэлсэн. Тэр эцэг эхийнхээ араас уйлсан хэвээр гэнээ, хөөрхий амьтан. Би үүнийг мэдсэнгүй!

Харрийн хувьд хангалттай боллоо. Хагридын анхаарал дөрвөн луу болон хатагтай Максимд татагдаад түүний байгаа эсэхийг анзаарахаа больжээ. Тэр чимээгүйхэн эргээд шилтгээн рүү явлаа.

Одоо түүнийг юу хүлээж байгаа нь тодорхой боллоо. Тэр лууны тухай мэдсэн нь дээрдэх болов уу үгүй болов уу? Дээрдэнэ л гэж найдахаас. Ямар ч л гэсэн анхны цочирдол өнгөрлөө. Хэрвээ мягмар гаригт тэр энэ луунуудтай анх тааралдсан бол юу тохиолдох байсан бол? Бүх сургуулийнхны өмнө ухаан алдаж унах болов уу. Эсвэл зутах байсан болов уу... Тэр шидэт саваагаар зэвсэглэсэн байх хэдий ч нарийхан мод аварга том дөлөөр тургидаг хурц соёогоор зэвсэглэсэн лууны эсрэг юу болох юм бэ? Яаж үзэгчдийн өмнө түүний хажуугаар өнгөрөх юм бэ? Яаж?

Харри ойн захад хүрээд хурдаа нэмлээ. Сириустэй амралтын өрөөнд ханан зууханд уулзахад ердөө арван таван хором үлджээ. Түүнд хэн нэгэнтэй ярих хэрэгтэй байв.

Харри гүйж байгаад санамсаргүй хэн нэгэнтэй мөргөлдөн унаад шилээ застал гэнэт хэн нэгний хоолой дэргэд нь,

- Энд хэн байна? гэлээ.

Харри яаран цуваа нөмрөөд бараан дүрсийг харав. Тэр ямаан сахлыг танилаа. Энэ бол профессор Каркаров байв.

- Энд хэн байна? гэж Каркаров сэжигтэй давтаад ийш тийшээ харав. Харри хэвтээд хөдөлсөнгүй. Хором өнгөрлөө. Каркаров ямар нэгэн амьтан гүйж өнгөрсөн гэж бодсон бололтой доошоо харж байв. Сэжигтэй зүйл юу ч хараагүй болохоор лууны хашааны зүг харлаа.

Харри маш болгоомжтой дээшээ босоод чимээ гаргахгүйг хичээн ахиад л шилтгээн рүү гүйв.

Каркаров ойд юу хийж байсанд эргэлзэх юм алга. Хөлөг онгоцоо нууцаар орхин аваргыг юу хүлээж байгааг мэдэхийг хүссэн биз. Эсвэл Хагрид, хатагтай Максим хоёрыг ойн захаас дагасан байх боломжтой. Тэднийг ажиглахад амархан шүү дээ. Зөвхөн хүрхрэх чимээг сонсоод лууны нууцыг тайлсан биз. Тэгэхээр мягмар гаригт зөвхөн Седрик л аюултай юу ч мэдэхгүй тулгарах нь байна.

Харри цамхагт орохдоо үүдний хаалган дээр хальтирч унаад гантиг шатаар өгсөв. Тэр амьсгаадаж байсан ч алгуурлаж болохгүй байв. Зууханд хүрэхэд ердөө таван хором үлдээд байлаа... Тарган хатагтай хөрөгтөө зүүрмэглэж байв.

- Дэмий яриа гэж тэр хашгирав.

- Үнэн гэж тэр нүдээ нээлгүй нойрмог бувтнаад нээгдэн Харри дотогш оруулав. Амралтын өрөө хоосон байсан бөгөөд юу ч үнэртсэнгүй. Тэгэхээр Гермиона шивхэн бөмбөг хэрэглэлгүй зохицуулсан байх нь.

Харри үл үзэгдэх цуваа тайлаад зуухны дэргэдэх сандал дээр суулаа. Амралтын өрөөнд харанхуй агаад зөвхөн гал асна. Ойролцоох ширээн дээр Седрикийг дэмсэн тэмдэгнээс ногоон туяа татна. Түүн дээр <<ПОТТЕР ЖИНХЭНЭ ӨМХИЙ>> гэсэн ах дүү Кривигийн удаан хөдөлмөрийн үр дүн хэвтэж байв. Харри зуух руу хялам хийн хараад золтой л сандлаасаа уначихсангүй.

Ханан зуухны гал дундаас Сириусын толгой цухуйж байв. Харри Уизлигийн ханан зуухнаас ноён Диггорийн толгой цухуйсныг хараагүй бол үхтлээ айх байлаа.

Харин тэр нүүрэнд олон өдрийн дараа инээмсэглэл тодорч байв. Харри сандлаасаа үсрэн босоод зуухны урд суулаа.

- Юу байна даа, Сириус?

Сириус их өөрчлөгджээ. Тэднийг салах ёс гүйцэтгэх үед тэр эцэнхий хөнхөр нүдтэй мөрөө хүрсэн хар үстэй байсан юм. Одоо үсээ богинохон засуулсан нь царайг нь

цэвэрхэн залуу харагдуулна. Тэр Харрид байдаг цорын зураг болох хуримын зурагтайгаа адилхан байлаа.

- Надад анхаарал хандуулах хэрэггүй. Харин чи хэр байна даа? гэж Сириус чухалчлан хэлэв.

- Би... гээд Харри сайн байна гэж хэлэхийг хүссэн ч чадсангүй. Түүнийг яаж хуурч болох юм бэ. Тэр хэн ч түүний тэмцээнд оролцохыг хүсээгүй гэдэгт итгэхгүй байгаа, Рита Скитер түүний талаар <<Зөнч>> сонин дээр худал мэдээ гаргаж, хонгилоор явахад нь хүүхдүүд шоолон инээддэг болсон хамгийн гол нь түүнд сайн найз нь итгэхээ больж алдар нэрт нь атаархаж байгаа зэрэг бүгдийг яриад,

- Дөнгөж сая Хагрид надад тэмцээний анхны даалгавар болох луу үзүүлсэн гэж яриагаа цөхрөн төгсгөв.

Сириус Харри руу сэтгэл зовсон байртай харна. Түүнийг загалмайлан эцэгтээ ярих боломж өгөхөд,

- Луутай тэмцэхэд амархан дараа нь тайлбарлая. Надад хугацаа бага байна. Би гэртээ байхгүй үл таних шидтэний зуухыг ашиглаж байна. Эзэд нь хэдийд ч хүрээд ирж болзошгүй. Чамд анхааруулах хэдэн зүйл байна.

- Анхааруулах гэнэ ээ? гээд Харри сэтгэлээр уналаа. Луунаас аймшигтай юу байж болох вэ!

- Каркаров Үхэл залгигч байсан. Чи энэ юу болохыг мэднэ биз дээ?

- Хэн гэнээ? Каркаров уу?

- Тэр надтай Азкабанд сууж байсан ч суллагдсан. Түүнийг хянахын тулд Дамблдор энэ жил Хогвартсад мракоборец Грюмыг урьсан гэж мөрийцөхөд ч бэлэн байна. Грюм Каркаровыг барьсан юм. Тэгээд Азкабанд илгээсэн.

- Дараа нь түүнийг сулласан гэнээ? Яагаад? гэж Харри удаан хэлэхэд тархи нь үүнтэй эвлэрч чадсангүй.

- Тэр ид шидийн яамтай хэлэлцээр хийсэн юм. Тэр өөрийн алдсан гэдгээ хүлээн зөвшөөрөөд нэрс хэлэхэд бэлэн байсан. Олон хүмүүс Азкабанд орсон явдалдаа түүнд баяртай байгаа. Тэнд түүнийг үзэн яддаг болохыг би мэднэ. Тэр одоо Дурмстрангад багшилж сурагчдаа хар урлагт сургаж байна. Түүний аваргатай болгоомжтой байгаарай.

- Тэгье ээ... Гэхдээ Каркаров миний нэрийг цомд хийсэн гэж бодож байна уу? Тэр ч сайн жүжигчин юм даа. Тэр намайг дөрөв дэх оролцогч болсныг мэдээд үхтлээ уурласан шүү. Тэр намайг өрсөлдөхөө болихыг шаардсан.

- Тиймээ, түүний жүжигчний авьяас алдартай. Учир нь яамныхныг итгүүлж чадсан учраас л суллагдсан хэрэг. Энэ бүх хугацаанд би <<Зөнч>> сониныг анхааралтай уншиж байлаа, Харри...

- Зөвхөн чи ч биш бүх шидтэний ертөнц гээд Харри хүндээр санаа алдав.

- Өнгөрсөн сар энэхүү Скитерийн ярилцлагыг уншаад Хогвартст юу болохыг мэдсэн. Грюм Хогвартст ирэхийн өмнөх шөнө дайралтанд өртсөн. Харин тэр түүний ээлжит хуурамч түгшүүр гэж бичсэн хэмээн Сириус түүнийг эсэргүүцэхээс өмнө яаран тайлбарлав.

- Гэхдээ би тэгж бодохгүй байгаа. Хэн нэгэн түүнийг Хогвартсад ирэхийг хүсээгүй болохоор саад хийхийг оролджээ. Гэхдээ Грюмын эргэн тойронд үргэлж дайснууд байдаг болохоор хэн ч үүнд түгшихгүй байгаа хэрэг. Грюм ид шидийн яамны шилдэг мракоборец байсан юм шүү.

- Тэгэхээр чи Каркаров намайг алах гэж байгаа гэж бодож байгаа юм уу? Яагаад?

Сириус яльгүй саатлаа.

- Надад түгшүүртэй цуу яриа сонсогдлоо. Сүүлчийн үед Үхэл залгигчид их идэвхжиж байгаа. Үүнийг Дэлхийн цомын тэмцээн дээр болсон явдал баталж байна. Хэн нэгэн тэнгэрт Хар тамга илгээсэн... Бас чи яамны нэг мэргэжилтэн алга болсныг сонсоо биз дээ?

- Берта Жоркинс уу?

- Тиймээ. Тэр Албани руу явсныхаа дараа алга болсон байна. Цуу яриагаар бол Волан-де-Морт тэнд сүүлчийн удаа үзэгдсэн шүү дээ. Харин тэр Гурван шидтэний тэмцээний бэлтгэлийн тухай мэдэж байсан.

- Тэр гэнэтхэн Волан-де-Морттой тааралдсан гэж үү?

- Би Бертаг сайн мэднэ. Бид Хогвартсад цуг сурч байсан юм. Берта надаас хэдэн насаар эгч. Тэр бол тэнэг амьтан. Сониучын дээр өөрийн ухаангүй. Муугүй хослол байгаа биз? Би түүний хялбархан занганд орох амьтан гэдгийг хэлэх байна.

- Тэгэхээр... Волан-де-Морт тэмцээний тухай мэдэж байсан байхнээ? Каркаров түүний тушаалыг биелүүлж байгаа гэж бодож байна уу?

- Мэдэхгүй... Мэдэх юм алга... Каркаров Волан-де-Мортыг хүчээ авах юм бол эргэж очихоос буцахгүй хүн. Тэр Волан-де-Морт түүнийг хамгаалж чадах хүчирхэг гэдгийг мэдэж байгаа. Хэн ч чиний нэрийг цомд хийсэн байлаа гэсэн түүнд шалтгаан байсан байна. Тэмцээн бол чамайг золгүй тохиолдлоор устгах хамгийн тохиромжтой арга юм.

- Сайхан л төлөвлөгөө байна. Луунууд өөрийн ажлаа хийх юм чинь алуурчин оролцох хэрэг алга гэж Харри итгэлгүйхэн хэллээ.

- Лууны эсрэг тэмцэх зэвсэг бий шүү, Харри. Дөжрөөх шившлэгийг битгий хэрэглээрэй. Луунууд их хүчтэй болохоор шидэт хүч нь ч агуу байдаг. Үүнийг хийхэд хэд хэдэн шидтэн зэрэг шивших шаардлагатай...

- Мэднэ. Би түүнийг өөрийн нүдээр харсан.

- Гэхдээ чи луутай ганцаараа тэмцэнэ. Нэг энгийн шившлэг бий. Зөвхөн...

Гэхдээ Харри гараа даллан түүнийг зогсоолоо. Зүрх нь үсрэн гарах шахам цохилоно. Эргүүлгэн шатаар хөлийн чимээ сонсогдов.

- Яв! Одоохон яв! Хэн нэгэн ирж байна! гэж тэр Сириуст шивнэлээ.

Харри хөл дээрээ үсрэн бослоо. Хэнд ч Сириусын толгойг харах боломж өгч болохгүй. Түүнийг одоо харах юм бол бөөн шуугиан болж ид шидийн яамнаас Харрид асуулт тавих болно.

Ард нь аяархан тасхийгээд Сириус алга болов. Харри шат руу харлаа. Хэн шөнийн цагаар зугаалж байдаг билээ? Энэ тэнэг л Сириуст лууны хажуугаар өнгөрөхийг хэлэх боломж өгсөнгүй.

Роны унтлагын цамц харагдсанаа өөрөө гарч ирэв. Амралтын өрөөнд зогсож байгаа Харриг хараад зогсон ийш тийшээ харав.

- Чи хэнтэй яриад байсан бэ?

- Харин чи юу хийж байгаа юм? Шөнийн цагаар тэнээд л!

- Би зүгээр л чамайг хаана байгаа бол гэж бодсон юм... Юу ч биш дээ. За явж унтлаа.

- Чи намайг тагнаж байгаа юм уу! гэж Харри орилов. Тэр юу ч мэдээгүй болохыг нь ойлгож байсан ч өмнөө шаргал үстэй нүцгэн хөлтэй унтлагын өмдтэй зогсож байгаа Роныг үзэн ядлаа..

- Уучлаарай. Чиний санааг зовоож болохгүй гэж бодсонгүй! Саад болохоо больё! Дараагийн ярилцлагандаа бэлд! гээд Роны царай уурласандаа улайлаа.

Харри ширээн дээрээс ах дүү Кривигийн тэмдгийг аваад Рон руу чулуудлаа. Тэмдэг духыг нь цохиод шалан дээр унав.

- Үүнийг чамд! Мягмар гаригт зүүгээрэй. Аз болвол духан дээр чинь сорви гарч ирэх байх. Чи үүнийг л мөрөөддөг биз дээ!

Харри амралтын өрөөний шат руу явлаа. Тэр түүнийг найз нь зогсоохыг хүлээсэн ч найдлага нь бөхөв. Рон чимээгүй зогссоор үлдэв. Харри түүний дэргэдүүр өнгөрч унтлагын өрөөндөө ороод удтал уурсав.

Тэгээд Рон хэзээ эргэж ирснийг сонссонгүй.

БҮЛЭГ 20: АНХНЫ ДААЛГАВАР

Ням гаригийн өглөө тэр хувцаслахдаа сэтгэл үймэрсэндээ болоод оймсоо өмсөхийн оронд малгай руугаа хөлөө хийчихлээ. Эцэст нь хувцаслаад яаран гарч Гермионаг хайлаа. Тэрбээр Жиннигийн хамт Их танхимд өглөөний ундаа ууж байв. Хоолны үнэрт Харрийн дотор муухайрав. Тэр Гермионаг сүүлчийн халбага будаагаа идэхийг хүлээгээд нуурын эргээр зугаалъя гэж дуудав. Явах замдаа лууны тухай болон Сириус юу хэлсэн тухай ярилаа. Ингээд яриагаа хоёр дахь удаагаа тойрохдоо төгсгөв.

Түүнийг Сириусын Каркаровоос болгоомжил гэсэн анхааруулга түгшээж байв. Гэхдээ Гермионагийн бодлоор луунууд илүү аюултай байлаа.

- Эхлээд чамайг мягмар гаригийн үдэш амьд үлдээх талаар бодож үзье. Дараа нь Каркаровын тухай ярилцъя.

Тэднийг гурав дахь тойргоо хийж байх үед ямар нэгэн энгийн шившлэг лууг ялахад туслана гэснийг санав. Толгойд юу ч ороогүй болохоор номын сан руу явцгаалаа. Харри лууны тухай тэвэр дүүрэн ном аваад андууд тохиромжтой шившлэг эрж эхэллээ.

- Хумсыг нь тайрах шившлэг... Хайрсыг хэрхэн арьс болгон хувиргах вэ... Үгүй ээ, энэ Хагридад таалагдахгүй. Түүнд луунаас үнэтэй зүйл байхгүй. <<Луунуудыг ялах маш хэцүү. Тэдний зузаан арьс эртний шившлэгээс хамгаалдаг болохоор зөвхөн хүчирхэг шид л нэвтэлж чадна.>> Гэхдээ Седрикийн үгээр бол лууны эсрэг ердийн шидийн тусламжтай тэмцэж болно гэсэн.

- Алив жирийн шившлэгийн ном үзэцгээе гээд Харри <<Луунд дуртай хүмүүс>> гэсэн номыг дөхүүлэв.

Тэр ном овоолсон ширээний ард суугаад эргүүлж эхлэхэд Гермиона тасралтгүй тохойгоор нудран шивнэж байлаа.

- Таслах шившлэг... Яагаад лууг таслах хэрэгтэй юм бол? Чи түүний соёог чихэртэй саваа болгон хувиргахыг хүсэхгүй биз дээ? Номонд тэдний арьс нэвтэршгүй гэж бичсэн нь гай болж байна. Хувиргалын шившлэг хэрэглэх үү? Тийм аварга биетэд бүтэхгүй л байх. Профессор МакГонагалл ч тэмцэж чадахгүй дээ. Илүү хүчтэй шившлэг хэрэгтэй. Гэхдээ энэ шившлэг их хэцүү болохоор бид түүнийг чадахгүй. Би түүнийг С.И.Ш.-д бэлтгэж байхдаа уншсан юм...

- Гермиона гуйя чимээгүй. Би төвлөрөх хэрэгтэй байна гэж Харри гуйлаа.

Гермиона чимээгүй болсон ч амар болсонгүй. Толгойд нь янз бүрийн бодол эргэлдэн дүнгэнэж байлаа. Тэрбээр <<Хараалын эсрэг шившлэг>>, <<Агшин зуур хуйхыг нь хуйлах>>, гэхдээ луунд үс байхгүй л дээ... <<Чинжүүгээр амьсгалах>> хэрвээ лууны дөл хүчтэй бол... <<Эврийг нь яаж ам руу нь эргүүлэх вэ>> зэвсэггүй болгох гэсэн гарчгуудыг найдлагагүй харлаа.

Номын санд Виктор Крам орж ирэв. Тэрбээр Харри, Гермиона хоёр руу баргар царайлан хараад дэргэдүүр нь өнгөрч овоолсон номтой алсын булан руу очлоо.

- Ахиад л тэр байна! Яагаад тэнэг хөлөг онгоцон дээрээ уншиж болдоггүй юм бол? Эндээс явъя, Харри. Амралтын өрөөнд хайсан нь дээр юм шиг байна. Одоохон шүтэн бишрэгчид нь цуглаж эхлэнэ гэж Гермiona уурсан хэлэв.

Тэгтэл ч үнэхээр хэсэг охид өлмий дээрээ гэтэн номын сан руу ороход нэг нь Болгарын далбаа бүсэлхийндээ уясан байлаа.

Харри шөнө бараг унтсангүй. Тэр даваа гаригийн өглөө сэрэхдээ энэ бүх хугацаанд анх удаа Хогвартсаас зугтдаг юм уу гэж бодлоо. Их танхимд ороод ийш тийшээ харав... Шилтгээнээс явах гэж үү? Хаашаа ч явахгүй гэдгээ ойлгож байна л даа. Тэр өөр хаана ч жаргалтай байхгүй. Зөвхөн эцэг эхтэйгээ төрсөн гэртээ л байсан байж болох юм... Гэхдээ тийм үеийг Харри санасангүй.

Луутай нүүр тулгарснаас Улаан модон гудамж руу Дадли руу очсон нь дээр гэж үү. Харри яльгүй тайвширлаа. Гахайн утсан мах арайхийн дуусгаад (хоолой хүндхэн давжээ) босохдоо Пуффендуйн ширээнээс босож байгаа Седрик Диггориог харлаа.

Седрик лууны тухай мэдэхгүй. Тэр ганцаархнаа тэмцэлд бэлэн биш байгаа. Хатагтай Масим, Каркаров хоёр аваргуудаа эхний тэмцээнд бэлдэж байдаг.

- Гермiona хүлэмж рүү явж бай. Би чамайг гүйцнэ гэж Харри Седрикийн араас дагуулан харж хэллээ.

- Чи хоцроно шүү дээ. Одоохон хонх дуугарна.

- Би чамайг гүйцнэ ээ!

Харри гантиг шат руу очиход Седрик зургадугаар дамжааныханаар хүрээлүүлэн өгсөж байв. Тэдний хажууд Седриктэй ярилцах гэж үү? Үгүй дээ! Гэтэл Диггори шившлэгийн хичээл рүү яарч байдаг. Тэгтэл нэг санаа төрлөө! Тэр саваагаа өргөөд,

- Диффиндо! гэв.

Седрикийн цүнх задрав. Түүнээс өд, сурах бичиг, цаас, бэхийн хоёр сав унан хагарлаа. Найзууд нь туслахаар яарав.

- Санаа зовох хэрэггүй, хичээлдээ явцгаа. Флитвикт намайг жаахан хоцорно гэж хэлээрэй гэж Седрик хэлэв.

Харри үүнийг л хүлээж байв. Тэр саваагаа жанчиндаа нуугаад Седрикийн хүрээлэгчдийг ангидаа орохыг хүлээж байгаад түүн рүү очлоо.

- Сайн уу. Миний цүнх урагдчихлаа гээд Седрик шалан дээрээс бэхэнд будагдсан <<Хувиргалын хичээлийн хурдавчилсан авлага>> авлаа.

- Седрик эхний тэмцээн лууны тухай байх болно гэж Харри түргэн хэлэв.

- Юу гэнээ? гээд Седрик дээшээ харав.

- Луунууд. Тэд дөрөв байна лээ. Хүн бүрд нэг. Бид тэдний дэргэдүүр өнгөрөх ёстой гэж Харри хэлэхдээ Флитвик Седрикт юу тохиолдсоныг мэдэхээр гараад ирэх вий гэж айлаа.

Седрик түүн рүү харав. Саарал нүдэнд нь Харрийн бямба гаригийн шөнө харж байсан байсан үл итгэсэн байдал хуржээ.

- Чи итгэлтэй байна уу? гэж Седрик шивнэлээ.

- Бүрэн. Өөрөө харсан юм чинь.

- Чи яаж мэдсэн юм бэ? Энэ чинь боломжгүй.

- Энэ чухал биш. Зөвхөн би ч биш Флер, Крам хоёр мэдэж байгаа гэж Харри хэлэхдээ үнэнийг хэлж Хагридад таагүй явдал үүсгэхийг хүссэнгүй.

Седрик гартаа бэхийн сав, өд, ном барьсаар босч ирээд уранхай цүнхээ мөрөндөө өлгөлөө. Тэр гайхан сэжиглэсэн янзтай Харри руу харлаа.

- Чи яагаад надад хэлж байгаа юм бэ?

Харри түүн рүү гайхан харлаа. Хэрвээ Седрик өөрийн нүдээр луунуудыг харсан бол ийм асуулт толгойд нь орж ирэхгүй байсан даа. Гийм мангастай гэнэтхэн тулгараасай гэж дайсандаа ч хүсэх юм биш. Мэдээж Малфой, Снегг хоёр биш л дээ...

- Энэ чинь шударга шүү дээ. Бид одоо бүгд мэдэх боллоо.

Седрик түүн рүү үл итгэсэн янзтай харсан хэвээр. Нурууны ард нь танил модон хөлийн чимээ сонсогдов. Хажуугийн ангиас Хурц нүдэт гарч ирлээ.

- Надтай яв, Поттер. Харин Диггори, хичээлдээ ор гэж тэр сөөнгөтөв.

Харри Грюм рүү болгоомжлон харав. Тэр үнэхээр бүгдийг сонсчихсон гэж үү?

- Уучлаарай, профессор, би... э-ээ... ургамал судлалын хичээл рүү явж байна.

- Айх хэрэггүй, Поттер. Миний араас...

Харри түүнийг дагахдаа эргэлзлээ. Одоо юу болох бол! Гэнэтхэн Грюм түүнийг лууны тухай хаанаас мэдсэн талаар асуувал яана! Дамблдорд Хагридын тухай хэлэх болов уу? Эсвэл түүнийг шууд өмхий хүрэн болгон хувиргах болов уу? Тэгвэл лууны хажуугаар өнгөрөхөд амар. Тэр жижигхэн юм чинь гучин метрийн өндрөөс харагдахгүй гэсэн утгагүй бодол төрөв.

Ангид орцгоолоо. Грюм хаалга хаагаад түүн рүү шидэт болон ердийн нүдээрээ ширтэн хараад,

- Талархмаар алхам байлаа, Поттер гэж тайван хэлэв.

Харри юу хэлэхээ мэдсэнгүй учир дараагийн үгийг нь хүлээв.

- Суу гэж Грюм хэллээ.

Харри суугаад ийш тийшээ харав. Тэр энд өмнө нь хоёр багшийн үед ирж байсан билээ. Профессор Туг үсийн үед ханан дээр түүний хөргүүд инээмсэглэн нүд ирмэж байдаг сан. Люпины үед ямар нэгэн шинэ хичээлд бэлтгэж байгаа гайхалтай амьтад байдаг байсан. Харин одоо өрөөнд ер бусын хачирхалтай зүйлүүд дүүрэн байлаа. Бүгд мракоборцын холбогдолтой зүйл бололтой.

Ширээн дээр орой дээрээ эргэлддэг том шилэн бөмбөлөг байв. Вредноскоп гэж Харри шууд танилаа. Түүнд тийм зүйл байгаа ч арай жижиг билээ. Буланд байгаа жижигхэн ширээн дээр зурагтын антеннтай адилхан долгионтой зүйл байна. Ханан дахь толинд өрөөн дэх зүйл тусахгүй агаад дотор нь бүүдгэр дүрсүүд хөдлөнө.

- Миний хар шид илрүүлэгч зүйлүүд таалагдаж байна уу? гэж Грюм асуув.

- Энэ одоо юу вэ? гээд Харри долгионтой алтан антенныг заалаа.

- Худал хэлэхийг илрүүлэгч. Бодлоо нууж худал хэлвэл чичирч эхэлдэг юм. Энд ажиллахгүй байгаа. Хэтэрхий олон саадтай. Сурагчид яагаад гэрийн даалгавар хийгээгүй талаараа үргэлж худал ярьдаг юм. Вредноскоп исгэрээд л байна, исгэрээд л байна. Түүний исгэрэхийг зогсоохгүй бол эргэн тойрон бээрийн зайд аюул отож байгаа юм шиг мэдрэмж төрнө. Мэдээж зөвхөн хүүхдийн дүрсгүйтэл биш л дээ.

- Толин дотор юу байгаа юм бэ?

- Энэ бол дайсан илрүүлэгч. Эргэн тойронд байгаа дайсныг хардаг юм. Харин аюул тулгарвал би авдраа онгойлгоно.

Тэр сөөнгөтөн хөхрөөд цонхны дор байгаа авдрыг заалаа. Түүн дээр долоон цоожны нүх байв. Авдарт юу байгаа юм бол...

- Тэгэхээр чи лууны тухай мэддэг болсон юм биз дээ? гээд профессор Харриг газар дээр эргэж авчирлаа.

Харри үүнээс л айж байсан юм. Тэр Седрикт юу ч хэлээгүй байсан бол гэхдээ тэр Грюмд Хагридын дүрэм зөрчсөнийг хэлэхгүй.

- Санаа зовох хэрэггүй, Харри. Хууран мэхлэх явдал Гурван шидтэний тэмцээний нэг хэсэг байсаар ирсэн зүйл гээд Грюм суугаад модон хөлөө ёолон татлаа.

- Би хэнийг ч хуураагүй. Зүгээр л... санамсаргүй...

Грюм инээмсэглэв.

- Би чамайг буруутгаагүй байна, хүү минь. Хатагтай Максим, Каркаров хоёр аваргадаа мэдэж байгаа бүхнээ ярьсан. Тэд ялж Дамблдорд үзүүлээд өгөхийг хүсч байгаа.

Грюм ахиад л сөөнгөтөн хөхрөхөд шидэт нүд нь түргэн эргэлдсэн учир Харрийн толгой эргэлээ.

- Тэгэхээр... чи лууны дэргэдүүр яаж өнгөрөхөө мэдэж байгаа хэрэг үү?

- Үгүй.

- Би чамд туслахгүй. Надад тал тохой татдаг зан байхгүй. Зүгээр л хэдэн ашигтай зөвөлгөө өгье. Нэгдүгээрт өөрийн хүчтэй талаа ашигла.

- Надад ямар ч хүчтэй тал байхгүй гэж Харри хэллээ.

- Уучлаарай. Тэд чамд байгаа. Бодоод үздээ! Чи юуг бүхнээс илүү хийдэг вэ?

Харри төвлөрөхийг оролдов. Бүхнээс илүү гэнэ ээ? Мэдээж энэ амархан шүү дээ...

- Квиддич.

- Сайн байна. Би чамайг гайхамшигтай нисдэг гэж сонссон гээд Грюмын шидэт нүд цоо ширтэв.

- Гэхдээ... Шүүр хэрэглэж болохгүй. Зөвхөн шидэт саваа... гээд Харри Грюмын нүд рүү харав.

- Хоёр дахь зөвөлгөө бол. Чухал шаардлагатай энгийн шившлэгийг ашигла.

Харри түүн рүү гайхширан харлаа. Чухал гэнээ?

- Хүү минь бод... Хоёр зөвөлгөөг хамтад нь. Энэ тийм ч хэцүү биш гэж тэр шивнэлээ.

Тэгтэл нэг бодол орж ирэв. Тэр сайн нисдэг ч үүнд шүүр шаардагдана. Шүүрийг авчрахын тулд...

Арван хормын дараа Харри гуравдугаар хүлэмж рүү гүйж очоод профессор Стеблээс яаран уучлалт хүсэн Гермiona руу очлоо.

- Гермiona, надад чиний тусламж хэрэгтэй байна.

- Яасан, Харри? гэж тэр шивнээд бутан дээгүүр Харри руу түгшин харлаа.

- Гермiona надад маргааш үдээс хойшоос өмнө Татдаг шидийг сурах хэрэг байна.

Ингээд тэд бэлтгэлдээ орлоо. Үдийн хоолонд явсангүй. Хоосон анги олоод Харри бүх хүчээ гарган өрөөнд байгаа янз бүрийн зүйлсийг нисгэж ирүүлэхийг хичээв. Ном, өд замын хагастаа чулуун шалан дээр унаж байлаа...

- Төвлөр, Харри төвлөр...

- Чинийхээр бол би юу хийж байна гэж! хэмээн Харри уурсаад,

- Гэхдээ яагаад ч юм миний толгойноос аварга том луу салж өгөхгүй байна. Алив, ахиад нэг оролдож үзье гэв.

Тэр мэргэ төлгийн хичээлийг алгасахыг хүссэн ч Гермiona шидэт тооны ухаанаа таслахыг зөвшөөрөөгүй болохоор бэлтгэл болсонгүй. Харри бүтэн цагийн турш профессор Трелонигийн Ангараг, Санчир гаригийн хооронд долоон сард төрсөн хүмүүст үхлийн аюул заналхийлж байгаа тухай хичээлийг тэвчиж өнгөрүүлэв.

- Үхэл гэнээ, тэгвэл сайн биз. Зөвхөн түргэлээсэй! Зовохыг хүсэхгүй байна! гэж Харри тэссэнгүй хэлэв.

Рон инээд алдах шахлаа. Сүүлийн үед тэр анх удаагаа Харригийн нүд рүү харсан ч уурласандаа хариу харсангүй. Үлдсэн хичээлийн туршид Харри саваагаараа ширээн доор байгаа зүйлсийг хөдөлгөхийг оролдов. Ахиад л болсонгүй.

Хоолны дараа Харри Гермionaгийн хамтаар хоосон ангидаа эргэж очихдоо багш нартай тааралдахгүйн тулд үл үзэгдэх цуваа өмслөө. Бэлтгэл шөнө дунд хүртэл үргэлжлэв. Цаашаа хичээллэх байсан ч Пивз орж ирээд Харрид юм хум шидэх нь таалагдсан гэж бодсон бололтой сандал чулуудаж эхлэв. Тэд Филчийг чимээ шуугиан сонсохоос өмнө ангийг яаран орхиж Гриффиндорын амралтын өрөө рүү явлаа. Тэнд хэн ч байсангүй.

Шөнө хоёр цаг болтол Харри эргэн тойрондоо байгаа янз бүрийн зүйл болох ном, өд, сандал, чулууны цуглуулга, Невиллийн бах Треворыг хөдөлгөхийг оролдов. Сүүлчийн цаг дээр л жинхэнээсээ Татдаг шидийг сурлаа.

- Болж байна шүү, Харри. Сайн байна гэж Гермiona сэтгэл хангалуун магтав.

- Одоо л юу хийх ёстойг ойлголоо. Намайг луу айлгаад байж гээд Харри Гермiona руу талхидлагын толь бичигийг өшиглөлөө.

Тэр саваагаа аваад ахин,

- Акцио толь бичиг! гэв.

Хүнд ном Гермionaгийн гараас мултарч өрөөн дундуур нисэхэд Харри барьж авлаа.

- Харри чи үнэхээр сурчихаж! гээд Гермiona хөөрлөө.

- Маргааш ажиллаж үзээсэй билээ. Шид хэрэглэхэд багагүй зайтай шүү дээ. <<Аянга>> шилтгээнд байхад би харин гадаа байна.

- Тэр чухал биш. Зөвхөн сайн төвлөрөх хэрэгтэй. Энэ л чухал шүү. Бид унтсан нь дээр байх. Маргааш өглөө эрт босно.

Харри Татдаг шидийг хийж сураад айдас нь жаахан намдлаа. Гэхдээ өглөө эргээд л бүрэн айдаст автав. Сургуулийн уур амьсгал догдолсон баяр хөөрөөр дүүрлээ. Хичээл үд дунд дуусахад сурагчид хашаа руу явсан ч тэнд хоосон байсан болохоор юу болохыг мэдсэнгүй.

Харри эргэн тойрноосоо хачирхалтай салан тусгаарлагдахыг мэдрэв. Таагүй үг, доогтой инээдний (Поттер хайрцаг амны алчуур авч яв!) алинд нь ч анхаарал хандуулсангүй. Сэтгэл зовнил хүчтэй байсан болохоор лууны урд гараад бүгдийн нүдэн дээр саваагаа даллаж чадах уу гэж хүртэл боджээ.

Цаг галзуурсан юм шиг түргэн өнгөрч байлаа. Дөнгөж эхний хичээл болох ид шидийн түүхэнд суутал үдийн хоол руу явах болжээ (Өглөө юу хийлээ дээ? Луутай уулзахад ердөө цагийн хугацаа үлджээ) Профессор МакГонагалл түүн рүү хурдан алхаагаар хүрч ирэв. Их танхимд байсан бүх хүн түүн рүү харлаа.

- Поттер аваргууд явчихсан. Чи эхний тэмцээнд бэлтгэх хэрэгтэй байна.

- Очлоо гээд Харри босохдоо сэрээгээ тавган дээр чимээтэй унагачихлаа.

- Амжилт хүсье, Харри! Чи сайн байх болно! гэж Гермiona шивнэлээ.

- Тиймээ гэж тэр өөрийн биш хоолойгоор бувтнажээ.

Харри Профессор МакГонагаллын хамтаар танхим дундуур явлаа. Тэр. Гермionaгийн адил түгшсэн байв. Чулуун шатаар уруудан арван нэгэн сарын хүйтэн агаарт гарлаа. МакГонагалл гараа мөрөн дээр нь тавив.

- Сандрах хэрэггүй. Үйл явдлыг хянахын тулд шидтэнгүүд жижүүрлэж байгаа... Гол нь чадах бүх зүйлээ хийгээрэй... муу зүйл бодож болохгүй. Чи зүгээр биз дээ?

- Тиймээ, зүгээр.

Луутай ойн цоорхойд очлоо. Модны хажуудах хашааны дэргэд майхан босгож мангасуудыг халхалжээ.

- Бусад руугаа ор. Өөрийн ээлжээ хүлээгээрэй. Тэнд ноён Бэгмен байгаа. Тэр чамд юу хийхийг чинь тайлбарлаж өгнө... Амжилт хүсье гэж профессор МакГонагалл чичирсэн хоолойгоор хэлэв.

- Баярлалаа гэж Харри хэлэв. Профессорыг явмагц Харри дотогш орлоо.

Буланд намхан модон ширээний ард Флер Делакур сууж байлаа. Тэр цонхийн цайсан ч ердийнхөөрөө өөртөө итгэлтэй байв! Виктор Крам улам барайснаас үзэхэд бухимдаж байгаа бололтой. Седрик нааш цааш холхино. Тэрбээр Харриг хараад инээмсэглэхэд хөшсөн булчингаа арайхийн хөдөлгөн хариу инээмсэглэлээ.

- Сайн уу, Харри! Ор, ор! Гэртээ байгаа юм шиг байгаарай! гэж Бэгмен баяртайгаар дуу алдав.

Бэгмен хар шаргал зөгий шиг судалтай хуучин жанчаа өмсчээ. Махлаг хөгжилтэй тэрбээр цонхийж түгшсэн аваргууд руу харав.

- Ингээд бүгд цуглалаа. Би юу хийхийг чинь хэлье! Үзэгчид цугларах үед би энэ хүүдийг онгойлгох болно гээд улаан өнгийн торгон хүүдий сэгсчиж үзүүлэв.

- Тэндээс та нар жижигхэн загвар сонгон авч хэнтэй тэмцэхээ мэдэх юм. Бүгд янз янзын байгаа. Ээлж дараалан гараа шургуулаад хэнд юу оногдохыг мэдээрэй. Та нарын даалгавар бол алтан өндөгийг авах явдал!

Харри эргэн тойрноо харлаа. Седрик ойлгосон янтай толгой дохиод ахиад л майхан дотуур холхиж эхлэв. Флер, Крам хоёр хөдөлсөнгүй. Магадгүй ухаан алдаж унахаас айсан юм болов уу? Харри үүнд ойрхон байлаа. Гэхдээ ялгаатай нь гэвэл тэд энд сайн дураараа байгаа...

Төдөлгүй хүний олон хөлийн чимээ майхны хажуугаар өнгөрөх нь сонсогдов. Үзэгчид инээлдэн, тоглож сэтгэл хөөрөн ярилцана... Харри өөр гариг дээр байгаа аятай тусгаарлагдсанаа мэдрэв. Тэр агшинд Бэгмен ягаан торгон хүүдийг онгойлгов.

- Хатагтай таныг гуйя гээд хүүдийг Флер руу сунгав.

Тэр гараа дотогш шургуулан хоёр дугаартай Уэльсийн жижигхэн ногоон луу хүзүүнээс барин гаргаж ирлээ. Флер өчүүхэн төдий ч гайхсангүй. Тиймээ, Харригийн зөв байж. Хатагтай Максим түүнд лууны тухай бүгдийг хэлжээ.

Хоёрдугаарт Крам сонголоо. Түүнд гурав дугаартай Хятадын галт бөмбөлөг оногдов. Крам түүнийг хөлдөө тавиад нүд цавчилгүй ширтэв.

Седрик Шведийн нэг дугаартай богино хоншоортыг гаргалаа. Тэгэхэд л Харри түүнийг юу хүлээж байгааг ойлгожээ. Тэр гараа уутанд шургуулан Унгарын дөрөв дугаартай эвэр сүүлтийг гаргаж ирлээ. Харри бяцхан лууг авахад далавчаа дэвэн соёогоо яралзуулав.

- Ингээд боллоо! Эдгээр луунуудтай та нар учрах болно. Лууны хүзүүн дээр дарааллын дугаар байгаа. Бүгд ойлгомжтой юу? Би тайлбарлагч хийх болохоор та

нарыг орхих хэрэгтэй болох нь. Ноён Диггори шүгэл дуугарахаар хашаа руу түрүүлж гараарай, ойлгов уу? Харри чамд хэлэх хоёр үг байна.

- Э-э... за гээд Харри майхнаас Бэгменийг даган гарлаа.

Тэрбээр мод руу очоод эргэж харан эцэг ёсны халамжит хоолойгоор,

- Ямаршуу байна даа, Харри? Би чамд ямар нэгэн юмаар туслах уу? гэв.

- Юу? гээд Харри ойлгосонгүй хэлснээ,

- Үгүй дээ. Хэрэггүй гэв.

- Чамд үйл явдлын төлөвлөгөө байгаа юм уу? Би чамд хэдэн зөвөлгөө өгөх гэсэн юм. Чи бусдаас жижигхэн болохоор би чамд тусалж болох юм... гэж Бэгмен хуйвалдагчын нам дуугаар хэллээ.

- Үгүй гэж Харри хэлээд,

- Баярлалаа, би юу хийх ёстойгоо мэдэж байгаа гэлээ.

- Хэн ч мэдэхгүй, Харри гээд Бэгмен нүдээ ирмэв.

- Үгүй дээ. Би маш сайн байна. Надад төлөвлөгөө байгаа гээд Харри дотроо <<Хэзээ ч ийм муу байсангүй>> гэж бодлоо.

Шүгэл дуугарлаа.

- Бурхан минь! Би явах хэрэгтэй! гээд Бэгмен яаран алга болов.

Харри майхандаа эргэж ирэхэд цонхийн цайсан Седрик угтав. Харри дэргэдүүр нь өнгөрөхдөө амжилт хүсэх гэсэн ч сөөнгөтөн ойлгомжгүй юм бувтнажээ.

Харри, Флер, Крам гурав гадаа үзэгчид орилон шуугилдахыг сонслоо. Тэгэхээр Седрик хашаанд гарч лууныхаа амьд хувилбартай нүүр тулгарсан хэрэг байх нь.

Суугаад сонсож байхаас дор зүйл гэж байсангүй. Седрик Шведийн богино хоншоортын дэргэдүүр өнгөрөх гэсэн оролдлого болгонд үзэгчид шуугин хашгиралдаж байлаа. Крам өмнөхийн адил суугаад шал руу харна. Флер Седрик шиг холхиж эхлэв. Харин тайлбарлагч Бэгмен,

- Ахиад жаахан... дэргэдүүр нь! Тэр эрсдэлд орж байна! Алив! Ээ! Ухаантай оролдлого байсан ч ажилласангүй! гэлээ.

Арван таван хормын дараа чих дөжрөм хашгиралт дунд Седрик лууг залилан алтан өндөгийг авлаа.

- Гайхалтай! Үнэхээр сайн байна! Харин одоо шүүгчдийн үнэлгээ! гэж Бэгмен хашгирав.

Гэхдээ үр дүнг хэлсэнгүй. Харри шүүгчид үнэлгээг үзэгчдэд харуулсан байх гэж бодлоо.

Ахиад шүгэл дуугарав.

- Гурав үлдлээ! Хатагтай Делакур гарч ирнэ үү! гэж Бэгмен зарлав.

Флер хөлөөсөө толгой хүртлээ чичирэхэд Харрийн дотор хүйт оргив. Тэр майхнаас гарахдаа толгойгоо өндөрт өргөж гартаа саваагаа барилаа. Харри, Крам хоёр үлдээд хоёр талын буланд суун бие бие рүүгээ харав.

Бүгд эхэллээ.

- Энэ ухаалаг арга гэдэгт итгэлгүй байна! Ойрхон байна! Хэтэрхий ойрхон! Ингэж болно гэж үү! Анхааралтай бай! Чөтгөр гэж! Одоохон авчих нь гэж бодлоо! гэх хөгжилтэй тайлбарлагч Бэгмений дуу гарав.

Арван хормын дараа алга ташилт нүргэлэв. Тэгэхээр Флер бас чадсан байх нь. Үзэгчид үнэлгээ хүлээн чимээгүй болов... дараагийн... гурав дахь шүгэл.

- Ноён Крам, таны ээлж! гэж Бэгмен мэдэгдэв.

Крам суудлаасаа босч гарахад Харри ганцаар үлдэв.

Тэр хэзээ ч ингэж сэтгэл түгшиж байсангүй. Зүрх нь чанга булгилж хурууны үзүүр нь чичирэн майханд биш үзэгчдийн урд луутай байгаа юм шиг санагдав.

- Маш зоригтой! Сайн байна! гэж Бэгмен хашгирлаа. Түүнийг дууг даран хятадын галт бөмбөлөг орилохд үзэгчид амьсгаа даран хүлээв.

- Хүн биш машин л гэсэн үг! Тиймээ! Тэр өндгийг авчихлаа!

Алга ташилт хүйтэн агаарт аварга том толь хагалсан аятай нүргэлэв. Крам үеэ давсан болохоор Харрийн ээлж иржээ.

Харри хөшсөн хөл дээрээ босоод юу болохыг хүлээв. Шүгэл дуугарав. Харри майхнаас гарахад айдас нь оргилдоо хүрлээ. Тэр мододын хажуугаар өнгөрч эцэст нь хашаанд орлоо.

Түүний эргэн тойрны бүх зүйл өнгөт зүүд адил санагдана. Олон зуун царай түүний зогссон газар руу ширтэв. Хашааны төгсгөлд эвэр сүүлт аварга том өндгөн дээрээ хэвтжээ. Далавчаа хагас хумиж ууртай шар нүд нь цоо ширтэнэ. Хайрстай гүрвэлийнх шиг аварга том сүүлээрээ газар цохилон гүнзгий мөр үлдээж байлаа. Үзэгчид орилон шуугилдав. Тэд түүнийг дэмжиж байгаа юм болов уу? Эсвэл үгүй юм болов уу? Ямар ялгаа байна! Ажилдаа орох цаг болж... Төвлөрөх... Энэ бол цорын ганц аврал...

Тэр саваагаа өргөөд,

- Ацио <<Аянга!>> гэж хашгирлаа.

Тэгээд мөргөн гуйж хүлээлээ... гэнэтхэн шид ажиллахгүй бол... гэнэт шүүр ирэхгүй бол... Харрид эргэн тойрны бүх зүйл нэвт гэрэлтэх шиг болж хашааны цаана байгаа хүмүүсийн нүүр хачирхалтай балархайтав...

Ажиллаа! Түүн рүү <<Аянга>> агаар зүсэн шуугин ирэх нь сонсогдов. Шүүр ойн цоорхой дундуур хашаа руу нисэн ирээд түүний суухыг хүлээн агаарт хөвөв. Үзэгчид улам хүчтэй хашгиралдав... Бэгмен ямар нэг зүйл хашгирсан ч Харри сонссонгүй... яах гэж!

Хөлөө шүүрэн дээгүүр давуулаад дээшээ хөөрөв. Тэгтэл хормын дараа гайхамшигтай явдал боллоо.

Харри улам өндөрт хөөрөв. Үс нь салхинд хийсэж үзэгчдийн царай ягааран, эвэр сүүлт нохойноос томгүй харагдана. Тэгэхэд Харри дор зөвхөн газар ч биш айдас үлдсэнийг ойлгов... Тэр ахиад өөрийгөө эзэмджээ.

Энэ бол бас л нэг квиддичийн тэмцээн гэсэн үг... Бас л нэг ээлжит тэмцээн гэхдээ өрсөлдөгч нь луу.

Харри доошоо харахад алтан өндөг саарал дэвсгэр дээр гялалзаж байлаа. Лууны сарвуун дор аюулгүй хэвтэж байгаадаа баярласан мэт.

- Сайн байна. Арга барилаа өөрчлөө... Урагшаа! гэж Харри өөртөө тушаалаа.

Тэр шунгалаа. Лууны толгой түүн рүү эргэв. Тэр цагаа олон хажуу тийшээ зайлсхийхэд нэг хувийн өмнө түүний байсан газар галын дөл оргилов... гэхдээ Харри үүнд анхаарал хандуулсангүй... энэ бол бас л нэг блажераас бултах гэсэн үг.

Үзэгчид орилолдов.

- Үгүй ер! Жинхэнэ нислэг байна даа! Ноён Крам үүнийг харав уу? гэж Бэгмен хашгирсан ч Харри түүнийг сонссонгүй.

Харри дээшээ нисээд тойрог эргэлдэхэд луу түүнийг дагуулан харж урт хүзүүгээ эргүүлэв. Одоо толгой нь эргэж байгаа болохоор галаар тургисан ч онохгүй байх...

Харри огцом доош нисэхэд эвэр сүүлт амаа ангайлаа. Гэхдээ түүнд аз бага таарчээ. Галнаас зугтсан ч луу сүүлээ сарвалаа. Харри зүүн тийш бултахыг оролдоход урт сүүл мөрийг нь шүргэн өнгөрч жанчыг нь урлаа...

Мөр нь хорсон өвдөхөд үзэгчид чимээгүй орилдов. Зүгээр дээ, шарх гүн биш... Харри дээшээ хөөрөөд лууны ар луу эргэлдэв. Ингэх ёстой юм шиг санагджээ.

Луу ниссэнгүй өндөгөө хамгаалсаар байв. Байж ядан далавчаа хумьж тэнийлгэн шар нүдээрээ Харриг ширтэнэ. Өндөгөө орхихоос айж байна. Харрид энэ л хэрэгтэй байлаа. Өндгөө мартаж... Тэр болгоомжтойгоор алгуур хуурлаа.

Тэр лууны галанд оногдохгүйн тулд зүг бүр тийшээ нислээ. Луу толгойгоо хөдөлгөн түүнийг босоо хүүхэн хараагаар ширтэж соёогоо ярзайлгав.

Тэр дээшээ хөөрлөө. Лууны хүзүү дээшээ сунан шившлэг хийлгэсэн могой адил болов.

Харри дээгүүр нь хоёр метрийн зайд нисэхэд луу уурласандаа цөхрөн орилов. Тэр дээгүүр нь эргэлдэж байгаа ялааг онохоор сүүлээ савлаа. Гэхдээ тэр түүний хүрэхээргүй өндөрт байлаа. Гал тургихад бултлаа.. лууны ам том нээгдэв...

- Алив, алив. Би энд байна. Намайг барь. Ингээд... гэж Харри дээгүүр нь өдөн нисэв.

Луу тэссэнгүй багахан онгоц шиг хар жигүүрээ дэлгэв. Харри агшин зуур шумбалаа. Лууг дайсан нь хаашаа алга болсныг ойлгож амжихаас урьтан хумстай сарвуугаар хамгаалагдаагүй өндөг рүү ухасхийв. Гараа <<Аянга>>-аас салгаад алтан өндөгийг авч галзуурсан хурдаар дээшээ хөөрлөө.

Тэр үзэгчдийн дээгүүр эрүүл гартаа хүнд өндөг тэврэн нислээ. Хэн нэгэн чимээ чангалах шиг санагдав. Харри анх удаа үзэгчдийн хашгирч орилолдон алга ташихыг сонслоо. Түүнд Дэлхийн цомын тэмцээн дээр Ирландын хөгжөөн дэмжигчтэй байгаа юм шиг санагджээ.

- Үгүй, та нар хараад үз л дээ! Хамгийн залуу аварга бүгдээс түргэн өндгийг авлаа! Түүнд ялах боломж байна! гэж Бэгмен хашгирав.

Харри луу сургагчид эвэр сүүлтийг номхруулахаар ухасхийхыг харав. Профессор МакГонагалл, профессор Грюм болон Хагрид нар яаран гүйлдэж гар даллан дуудахад инээмсэглэсэн царай нь харагдав. Тэрбээр чих дөжрөм чимээ шуугианд газардав. Сүүлчийн долоо хоногт анх удаагаа зүрх нь амарчээ. Тэр эхний тэмцээнийг тэсч гарлаа амьд үлдлээ...

Харри <<Аянга>>-аасаа буув.

- Маш сайн байна, Поттер! Шүүгчдийг зөвлөлдөх зуур хатагтай Помфри руу оч... Тэр хэдийн Диггорид тусалж байгаа гэж профессор хэлээд чичирсэн гараа шархадсан мөрөнд хүргэв.

- Чи дийллээ, Харри! Хэнийг гээч! Чи эвэр сүүлтийн талаарх Чарлигийн үгийг сонссон биз дээ, тэр хамгийн...

- Баярлалаа, Хагрид! гэж Харри чанга хашгирав. Ойн сахиулд түүнд луу үзүүлсэн гэж хэлэх боломж өгч болохгүй.

Профессор Грюм их сэтгэл хангалуун байсан бөгөөд шидэт нүд нь сормуусан дороо эрчигнүүр адил эргэлдэж байлаа.

- Маш сайхан хуурлаа, Поттер гэж тэр сөөнгөтөв.

- Поттер майханд орж анхны тусламж ав гэж профессор МакГонагалл давтав.

Тэгээд Харри хашаанаас гарлаа. Хоёр дахь майханд хатагтай Помфри сэтгэл зовсон байртай зогсож байв.

- Луунууд! гэж тэр Харриг оронгуут уурсан дуу алдав.

Майханг хоёр тасалгаа болгон хуваажээ. Хөшигний цаана Седрикийн сүүдэр харагдана. Тэр сууж байв. Бурханы авралаар шарх нь тийм ч аюултай биш байлаа. Хатагтай Помфри Харрийн мөрийг хараад,

- Өнгөрсөн жил Дементорууд, энэ жил луунууд! Ирэх жил хэнийг авчрах бол? Чиний аз болоход шарх чинь гүн биш байна. Би одоохон цэвэрлээдэхье гэж үглэв.

Тэр шархыг цэвэрлэж зөөлөн арчаад ягаан өнгийн шингэн түрхэхэд уугин хорслоо. Хагагтай Помфри саваагаа мөр лүү нь чиглүүлэхэд өвдөлт алга болов.

- Ингээд хормын турш тайван суугаад үнэлгээгээ мэдэхээр явж болно.

Тэрбээр майхны хоёр дахь тасалгаа руу ороод,

- Диггори чи зүгээр үү? гэх нь сонсогдов.

Харри сууж байв. Бүх цус нь адреналинаар дүүрчээ. Гадаа юу болж байгааг харахыг хүссэн ч амжсангүй. Майханд Гермiona орж ирэхэд араас нь Рон дагалджээ.

- Харри, чи агуу! Гайхамшигтай, Харри! Үнэн шүү! гэх түүний дуу хадав. Тэр их айсан бололтой хацар дээр нь хумсны мөр үлджээ.

Гэвч Харри Рон руу харж байлаа. Тэр цонхийн цайсан бөгөөд Харриг хий үзэгдэл аятай нүд бүлтийн харна.

- Харри хэн ч чиний нэрийг цомд хийсэн бай тэр чамайг алахыг хүссэн гэдгийг би ойлголоо гэж тэр чухал өнгөөр хэлэв.

Энэ бол сүүлийн хэдэн долоо хоногт тохиолдоогүй явдал боллоо. Яг л Харри Ронтой аварга болохын өмнө уулзаж байгаа юм шиг.

- Бодож олов уу? Удлаа шүү гэж тэр хүйтнээр хэлэв.

Гермиона тэдэн рүү бухимдсан байртай харав. Рон ам нээсэн ч үг хэлсэнгүй. Харри түүний уучлал гуйхад бэлэн байгааг мэдэж байсан ч сонсохыг хүссэнгүй.

- Зүгээр дээ, Рон. Бүгдийг март гэж найздаа хэллээ.

- Үгүй ээ, би яаж...

- Март! гэж Харри давтлаа.

Рон зовнингуй инээмсэглэхэд Харри хариу инээмсэглэв.

Гермиона уйллаа.

- Чи яагаад уйлж байгаа юм? гэж Харри гайхлаа.

- Та хоёр ямар тэнэг юм бэ! гээд тэр хашгираад хөлөө дэвслэхэд нүднээс нь нулимс урсаж байлаа. Тэрбээр хоёуланг нь тэврээд цурхиран уйлав.

- Явъя, Харри. Одоо шүүгчдийн дүн гарна гээд Рон толгойгоо сэгсэрлээ.

Ийм аз жаргалыг Харри цагийн өмнө мөрөөдөж зүрхлэхгүй байлаа. Тэр алтан өндөг, <<Аянга>>-аа авч майхнаас гарав. Дэргэд нь Рон явах зуураа,

- Чи тэмцээнд хамгийн шилдэг нь байсан! Седрик хувиргалын шившлэг хэрэглэж чулууг нохой болгон хувиргасан. Түүгээр лууны анхаарлыг татах гэж л дээ. Сайн бодол бараг л бүтсэн дээ. Түүнийг өндөг авмагц луу сүүлчийн агшинд нохойг орхиод түүн рүү галаар тургисан. Аз болоход Диггори бултаж амжсан. Флер нэг шид хэрэглэн лууг ховсдлын байдалд оруулсан. Тэр хөшсөнөө гэнэтхэн дөлөөр тургихад Флерийн юбка шатсан ч шидэт саваанаасаа ус гарган унтраасан. Крамын толгойд нисэх тухай ороогүй гэвэл чи үнэмших үү! Тэр хоёрдугаарт орох байх. Тэр нэг шившлэгээр лууны урдаас ширтэхэд өвдсөндөө зайлсхийсэн. Бүх зүйл сайн болсон доо. Крамд үүнийх нь төлөө өндөр оноо өгөх байх гэлээ.

Тэд хашааны гадаа ирэхэд Рон амьсгаа дарав. Эвэр сүүлтийг холдуулахад Харри таван шүүгчийг харлаа. Тэд алсын буланд алтан бүтээлэгтэй ширээний суугаад зөвлөлдөж байв.

- Шүүгчид аваргад арав хүртэл оноо өгнө гэж Рон тайлбарлав.

Харри анхны шүүгч хатагтай Максим саваагаа өргөхийг хальт харлаа. Түүнээс том наймын тоо бичсэн урт мөнгөн тууз хөврөн гарлаа. Үзэгчид алга ташив.

- Муугүй шүү! Чи маажуулсныхаа төлөө хоёр оноо алдлаа гэж Рон хэлэв.

Дараагийнх нь ноён Крауч байв. Тэр Харрид есөн оноо өгөв.

- Сайн байна! гэж Рон дуу алдаад Харрийн нуруун дээр алгадав.

Дамблдор мөн агаарт есийн тоо гаргав. Үзэгчид хөөрөн шуугилдав.

Людо Бэгмен арван оноо өглөө.

- Арав гэнээ? Би гэмтсэн шүү дээ... Тэр тоглосон байлгүй? гэж Харри гайхлаа.

- Гомдоллох хэрэггүй дээ, Харри гэж Рон хөөрөн хашгирав.

Каркаров хамгийн сүүлчийнх нь байлаа. Тэр саваагаа даллахад мөнгөлөг туузан дээр дөрвийн тоо гарав.

- Дөрөв гэнээ? Новшийн өөдгүй шүүгч! Крамд арвыг өгсөн биз дээ! гэж Рон орилов.

Гэхдээ Харри тоосонгүй. Каркаров түүнд тэг оноо тавиагүй нь их юм. Рон өмнөөс нь зуу дахин уурсан байлаа. Тэр түүнд хэлээгүй ч гэсэн хашааг сэтгэл дүүрэн орхиж явлаа. Зөвхөн Рон ч биш Гриффиндорынхон түүнд баяр хүргэж байлаа. Бараг бүх сургуулиараа Седрикээс дутуугүй түүний талд байв... Харин Слизеринийхэн түүнийг тэсч чадна гэж бодоогүй бололтой.

Сургууль хүрэх замын хагаст тэднийг Чарли Уизли гүйцэв.

- Крам та хоёр нэгдүгээр байрын хуваан эзэлсэн, Харри! Би ээждээ ууль илгээх гээд гүйж байна. Энд болсон бүх зүйлийг бичнэ гэдгээ тангарагласан юм. Энэ чинь гайхамшигтай хэрэг шүү дээ! Өө тийм л дээ, надаас чамайг хэдэн хором хүлээлгэхийг гуйсан. Бэгмен майханд аваргуудтай ярилцахыг хүсч байгаа юм байх.

Рон хүлээхийг амлахад Харри майхандаа эргэн ирлээ. Одоо түүний эргэн тойрон өөрчлөгдөн нөхөрсөг болжээ. Тэр удаан хугацааны шаналалаа эвэр сүүлттэй тэмцсэнтэй харьцуулав. Сүүлчийнх нь харьцуулахын аргагүй мянга дахин муу байлаа.

Флер, Седрик, Крам нар хамтдаа ирцгээв.

Седрикийн нүүрний түлэгдсэн талд шаргал тос түрхсэн харагдана.

- Сайн байна, Харри гээд тэр инээмсэглэв.

- Чи ч гэсэн сайн байлаа гэж Харри инээмсэглэлээ.

- Та нар бүгд сайн байлаа! гээд майхнаас Людо Бэгмен өөрөө лууны өндөг авсан аятай тэнгэрт хөөрөх нь холгүй гарч ирлээ.

- Надад цаашдын явцын талаар түргэн хэлэх үг байна. Хоёр дахь тэмцээн гурван сарын дараа буюу хоёр сарын хорин дөрөвний өглөөний есөн цаг гучин минутад болно. Энэ хүртэл та нарт бодох хугацаа олгоё. Гартаа байгаа алтан өгдөгийг харж нээгээд... юу байгааг нь үзээрэй. Өндөгний дотор хоёр дахь даалгаварын түлхүүр

байгаа. Тэр та нарт бэлтгэхэд туслах юм. Бүгд ойлгомжтой юу? Итгэлтэй байна уу? Тэгвэл амарцгаа!

Харри майхнаас гарахад Рон хүлээж байлаа. Найзууд хөөрөлдсөөр шилтгээн рүү буцав. Харри бусад аваргууд лууг яаж залилсныг тодорхой мэдэхийг хүсч байв. Тэгтэл хэсэг модны араас ногоон жанчтай эмэгтэй гарч ирлээ.

Энэ бол Рита Скитер байв. Тэрбээр найзууд руу Түргэн бичигч үзэгтэйгээ чиглэв.

- Баяр хүргэе, Харри! Ердөө ганц үг! Чи луутай нүүр тулгарах үедээ юу мэдэрсэн бэ? Шүүгчдийн үнэлгээг шударга гэж бодож байна уу?

- Ганц л үгээр хариулъя. Баяртай гэж Харри хатуу хэлэв.

Ингээд Роны хамтаар шилтгээн рүү явлаа.

БҮЛЭГ 21: БООЛЫН ХӨДӨЛМӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ФРОНТ

Орой нь андууд уулийн байшин руу очиж Гахайг авлаа. Харри Сириуст лууны дэргэдүүр эсэн мэнд өнгөрсөн тухайгаа мэдэгдэх хэрэгтэй байлаа. Замдаа Ронд загалмайлсан эцгийнхээ Каркаровын тухай хэлсэн үгийг хүүрнэжээ. Рон сонссон даруйдаа цочролд оров. Дурмстрангын захирал Үхэл залгигч байсан гэнээ! Үүнээс өөр юу хүлээнэ гэж.

- Бид яагаад үүнийг шууд сэжиглээгүй юм бол? Бүгд ойлгомжтой байж! Малфой галт тэргэнд эцэг нь Каркаровтой найзалж байсан гэсэн биз дээ? Одоо тэд хаана танилцсан нь ойлгомжтой. Тэд л Дэлхийн цом дээр багтай байсан таарна... Тэр л чиний нэрийг цомд хийсэн байх. Түүнд одоо тэнэг санагдаж байгаа байх даа? Төлөвлөгөө биелсэнгүй чи ердөө шалбархайтай л үлдлээ! Нааш ир, Гахай чамаар хийлгэх зүйл байна.

Гахай шуудан хүргэх хүндэтгэл оногдсонд баясан хөөрөв. Тэр баяртай гуугчин Харриг тойрон эргэлдлээ. Рон түүнийг барьж авахад Харри захиаг сарвуунд нь уялаа.

- Хамгийн аюултай тэмцээн ард үлдлээ бусад нь гайгүй хөнгөн байх. Юу гэдгийг нь мэдэх үү? Харри, би чамайг тэмцээнд ялах байх гэж бодож байна. Үнэн шүү гэж Рон Гахайг илгээхдээ хэллээ.

Рон үүнийг сүүлийн хэдэн долоо хоногт гаргасан араншингаа цайруулахын тулд хэлж байгаа нь Харрид ойлгомжтой байлаа. Гермiona хана налан зогсоод гараа зөрүүлэн Рон руу баргар харна.

- Харригийн урд хоёр тэмцээн байна. Хэрвээ эхнийх нь луу байсан бол цаашдаа юу байгааг төсөөлж байна уу?

- Чинийхээр бол ямар ч найдлагагүй юм биз дээ? Чи заримдаа профессор Трелонигоос ялгарах юмгүй болох юм. Зөвхөн гай зовлон гэж Рон уурслаа.

Тэр Гахайг цонхоор гаргав. Тэр огцом доош унаснаа дөрвөн метрийн өндрөөс нисч одлоо. Харри урт захиа бичээгүй болохоор ачаа нь хөнгөхөн байлаа. Тэр яаж луутай тэмцсэн, шүүрээ авсан, галаас нь бултсан, даажигнаж өндөгийг авсан тухай бичжээ.

Гахайг харанхуйд уусан алга болсон хойно Рон,

- Явчихлаа доошоо бууцгаая. Харри чиний хүндэтгэлд зориулан үдэшлэг зохиож байгаа. Фред, Жорж хоёр гал зуухнаас зөндөө идэх юм авчирсан гэлээ.

Тэднийг амралтын өрөөнд ороход дэлбэрэх шахам баяр хөөр нүргэлэв. Ширээ, зуухны тавиур ер нь тавьж болох бүх юм дээр морин шилтэй хулууны шүүс, цөцгийн шар айраг, бялуу болон амттан овоолжээ. Ли Жордан доктор Фойерверкусын чийглэг цаасан буу буудуулахад агаарт олон өнгийн оч үсрэв. Сайн зурдаг Дин Томас Харри лууг тойрон <<Аянга>>-аар нисч байгаа хэд хэдэн зурагт хуудас зуржээ. Бас Седрик толгойгоо дөлд хуйхлуулж байгаа хоёр зураг байлаа. Урьдын адил бүгд хамтдаа сууцгаав.

Харри тавган дээр хоол овоолж авлаа. Тэр сүүлийн үед хоолойгоороо бараг юм давуулаагүй болохоор их өлсөж байв. Ийм их аз жаргалтай байгаадаа итгэж ч чадсангүй. Рон дэргэд нь сууж, анхны тэмцээн ард нь хоцорч, дараагийнхийг нь хүртэл бүтэн гурван сар байна!

- Чөтгөр гэж, хүнд байна шүү! хэмээн Ли Жордан Харрийн урд байсан өндгийг алган дээрээ тавингаа,

- Харри онгойлгоорой! Дотор нь юу байгааг харцгаая! гэв.

- Харри алтан өндөгний даалгавараа өөрөө таах ёстой. Тэмцээний дүрэмд тэгж заасан байгаа... гэж Гермиона оролцов.

- Би лууны дэргэдүүр яаж өнгөрөх тухай юу ч мэдээгүй гэж Харри түүнд шивнэлээ. Гермиона гэмшингүй инээмсэглэв.

- Онгойлго, Харри! гэж хэдэн хүн Лиг дэмжлээ.

Жордан өндгийг Харрид өгөхөд хумсаараа ховилыг нь даран нээлээ.

Өндөг хов хоосон байлаа. Тэр агшинд өрөөнд аймшигтай чахарсан чимээ сонсогдов. Харри ийм хөгжим бараг толгойгүй Никийн үхлийн ой дээр тоглож байсныг саналаа.

- Хаагаарай! гээд Фред чихээ даран орилов.

Харри хаалаа.

- Энэ чинь одоо юу вэ? Эмгэн шулмын чарлаантай төстэй юм байна. Чи тэдний хажуугаар өнгөрөх юм биш биз? гээд Симус Финниган өндөг рүү харлаа.

- Хэн нэгэн тарчилж байх шиг байна! Магадгүй чамд Круциатусын эсрэг тэмцэх хэрэг гарах байх! гэж цонхийн цайсан Невилл хэлээд зайдсаа шалан дээр унагав.

- Тэнэг юм, Невилл. Энэ чинь хууль бус шүү дээ. Тэд Круциатусыг аваргуудад хэрэглэж зүрхлэхгүй! Энэ чимээ Персигийн дуулахтай адилхан юм! Харри чи түүнтэй тэмцэх юм биш биз дээ! Юу болохыг төсөөлж байна! Перси дуулж Харри хөгжмийг нь тэвчээд л! гэж Жорж хэллээ.

- Гермиона чанамалтай боов авахгүй юм уу? гээд Фред таваг сунгав.

Гермиона Фред руу сэжигтэй ширтэв.

- Айх хэрэггүй. Би юу ч илбэдээгүй. Зөвхөн цөцгийтэй жигнэмэгийг илбэдсэн гэж Фред инээмсэглэв.

Невилл хэдийн цөцгийтэй жигнэмэг амандаа хийжээ. Фредийн үгийг сонсонгуутаа тэр нулиман гаргалаа.

- Тоглосон шүү дээ, Невилл! гэж Фред инээд алдав.

Гермиона чанамалтай боов аваад,

- Фред чи эд нарыг гал тогооноос авчирсан уу? гэж асуув.

- Тэгсэн. <<Ноёнтоон! Бидэнд таньд хэрэгтэй бүх юм байна! Бүгд шүү!>> гэж Фред гэрийн үйлчлэгчийн хоолойг дуурайн баясан хэлээд,

- Би тэдэнд өлсөж үхэх гэж байгаа хэмээн хэлсэн болохоор шарсан галууны мах өгсөн юм гэв.

- Чи тийшээ яаж орсон юм бэ? гэж Гермиона жирийн өнгөөр гэмгүйхэн сонирхов.

- Маш амархан. Сагстай жимсний хөрөгний ард хаалга нь нууцлагдсан байдаг юм. Лийрийг гижигдмэгц инээгээд... Харин чи яагаад энэ тухай сонирхоод байгаа юм бэ? гээд Фред Гермиона руу асуунгуй харлаа.

- Юу ч биш гэж Гермиона түргэн хэлэв.

- Тэднийг хаалгаар гаргах нь уу? Ухуулах хуудас тарааж бослого зохион байгуулах нь уу? гэж Жорж хэлэв.

Хэдэн хүмүүс инээлээ. Гермиона юу ч хэлсэнгүй.

- Гуйя үйлчлэгчийн хувцас цалин хөлсний тухай санаа зовохоо больж үз! гэж Фред түүнд хэлэв.

Тэгтэл Невил ганхсанаа том канар бялзуухай болон хувирлаа.

- Өө, намайг уучлаарай, Невилл! Бид үнэхээр илбэдсэн! гэж Фред хөхрөн хэлэв.

Шид хормын дараа алга болов. Невиллийн өд зумран унаснаа хэвийн байдалдаа орж хормын дараа бүгдтэй инээлдэн суу байлаа.

- Цөцгийтэй жигнэмэг! Жорж бид хоёрын бүтээл! Нэг орц нь долоон сикль! гэж Жорж баясгалантай мэдэгдэв.

Үүр цайх дөхөхөд Харри, Рон, Невилл, Симус болон Дин нар унтлагын өрөөндөө орлоо. Харри хөшгөө татахын өмнөхөн Унгарын эвэр сүүлтийн жижигхэн дүрсийг шүүгээн дээрээ тавилаа. Луу эвшээгээд цагариглан нүдээ анив.

Хагридын лууны тухайд хэлдэг үнэн байж хэмээн Харри бодоод адар ширтэв. Үнэхээр эелдэг амьтан, маш их шүү...

Арван хоёр сард болоход Хогвартст цасан шуурга тавьж нойтон цас хаялав. Өвөл шилтгээнд айлчилсан ч сургуульд ханан зуух байгаа болохоор зузаан хана хүйтнээс хамгаалж байлаа. Харин Дурмстрангын зочдын хувьд ямар байгаа бол? Тэдний хөлөг онгоц долгион дээр хүчтэй салхинд ганхан хар далбаа нь тэнгэр рүү дэрвэж байв. Шармбатоны сүйх тэргэнд ч гэсэн хүйтэн байгаа байх даа. Хагрид хатагтай Максимын морьдод арвайн шарз өгч байгааг Харри ажиглажээ. Шидэт амьтны хичээл хамгийн хүнд үедээ хүрлээ. Тэд аймшигт соплохвостууд дээр ажилласан хэвээр бөгөөд жинхэнэ толгой нь маш их хэрэгтэй байв.

Саяхны хичээл дээр Хагрид тэднийг хулууны талбай руу дагуулан аваачив. Хүйтэн салхитай байсан болохоор бүгд дагжин чичрэв.

- Тэдний ичдэг эсэхийг нь сайн мэдэхгүй юм. Эдгээр хайрцгуудыг хучиж өвөл унтуулах гэж оролдоод үзэх хэрэгтэй.

Соплохвостууд ердөө арав үлдсэн бөгөөд бие биеэ алсан нь ойлгомжтой байлаа. Биеийн урт нь гурван метр хүрчээ. Зузаан саарал хуяг, хүчирхэг хайрстай хөл, галаар дэлбэрдэг сүүл, хатгуур болон соруул хослуулсан тийм амьтныг Харри хэзээ ч харж

байсангүй. Хагрид тэднийг дэр болон хөнжлөөр хучсан хайрцагнууд руу аваачихад хүүхдүүд сэтгэлээр үхлээ.

- Бид тэднийг хайрцагт оруулахад болох юм. Дараа нь хайрцагны тагыг сөхөж юу болохыг харах болно.

Гэхдээ соплохвостууд ичих бодолгүй нь илхэн байлаа. Тэд дулаахан тухтай хайрцагнуудын хадаасыг нь сугартал хүчтэй мөргөх аж. Тэгээд халамжыг үнэлэлгүй хайрцгаа зад татан гарлаа.

- Сандрах хэрэггүй! Сандрах хэрэггүй! гэж ойн сахиул хашгирав.

Малфой, Гойл, Крэбб тэргүүтэй хэдэн сурагчид Хагридын овоохойны ар луу гүйн орж хаалгыг нь урдаа барив. Харри, Рон, Гермiona гурав хоёр хүний хамтаар Хагридад туслахаар яарав. Тэд есөн соплохвостыг хүлж номхотгов. Эцэст нь нэг л үлдэв. Тэр толгой дээгүүрээ сүүлээ өргөн сүрдүүлэн довтлоход Харри, Рон хоёр шидэт саваагаа чиглүүлэв.

- Түүнийг битгий айлга! Битгий айлга! Зөвхөн бусдыг нь гэмтээхгүйн тулд сүүлийг нь хүлчих! гэж Хагрид гуйв.

Гэхдээ Рон, Харри хоёр галаар буудах соплохвостын дайралтаас зугтан овоохойны хана наллаа.

- Түүнийг айлгасан гэнээ! гэж Рон хашгирав.

- Үгүй ерөө... Ийм үйл явдлыг инээдтэй гэж нэрлэж болохгүй юм гэх дуу гарав.

Ногооны талбайд болсон үхлийн үзүүлбэрийг Рита Скитер ширтэж байлаа. Өнөөдөр Рита нил ягаан өнгийн үслэг захтай дээл өмсөж матрын арьсан цүнхээ мөрөн дээгүүрээ тохжээ.

Хагрид урагшаа харайн соплохвостын дайралтыг биеэрээ хаалаа. Амьтны сүүлээс дэлбэрэлт үүсч хулууны гандсан талбай дээгүүр оч цацрав.

- Та хэн бэ? гэж Хагрид асуугаад соплохвостын сүүлийг олсоор баглав.

- Рита Скитер. Зөнч сонины сурвалжлагч гээд тэр инээмсэглэхэд алтан шүд нь гялалзав.

- Дамблдор таныг энд байлгах хориотой гэсэн хэмээн Хагрид хөмсөг зангидан уяагаа чангалав.

Рита сонсоогүй дүр эсгээд,

- Энэ гайхамшигтай амьтныг чинь юу гэдэг юм бэ? гэж инээмсэглэн хэллээ.

- Галт соплохвост гэж Хагрид хариулав.

- Үнэхээр тийм гэж үү? Хэзээ ч тэдний тухай сонсож байсангүй. Тэд хаанаас ирсэн юм бэ? гэж Рита сонирхон асуулаа.

Харри ойн сахиулыг улайхыг хараад зүрх нь ёгхийв. Нээрэн Хагрид тэднийг хаанаас авчирсан юм бол? Гермiona бас тэгж бодсон бололтой түргэхэн,

- Тиймээ тэд их сонирхолтой биз дээ, Харри? гэв.

- Юу гэнээ? Өө, тийм л дээ. Их сонирхолтой гэж Харри Гермиона хөлийг нь гишгэхэд зөвшөөрлөө.

- Өө, Харри! Чи энд байгаа юм уу! Чамд шидэт амьтны хичээл таалагддаг уу? Энэ чиний дуртай хичээл үү? гээд Рита түүн рүү эргэв.

- Тиймээ гэж Харри итгэлтэй хэлэв. Хагрид түүнийг талархсан харцаар харлаа.

- Сайхан хэрэг. Удаан багшилж байна уу? гээд тэр Хагрид руу эргэлээ.

Рита Дины маажуулсан хацар, Лавандагын урагдсан жанч, Симусын түлэгдсэн хурууг гүйлгэн харав. Хүүхдүүд овоохойн цонхоор цухуйн хамраа нааж тулаан юу болж дуусахыг хүлээнэ.

- Хоёр дахь жилдээ гэж Хагрид хэлэв.

- Таныг ярилцлага өгөхөөс татгалзахгүй байх гэж бодож байна? Шидэт амьтдын туршлагынхаа тухай? Та <<Зөнч>> сонинд лхагва гариг бүр амьтны тухай мэдээлэл гардагыг мэдсэн байх. Би соплохвостуудын тухай бичих бодолтой байна.

- Солплохвостууд гэнээ! Тиймээ... яагаад үгүй гэж Хагрид тэсч ядан хэлэв.

Харрийн зүрх хүндээр цохилгов. Хагридыг яаж Рита Сиктерд харагдалгүйгээр анхааруулах вэ? Тэгээд тэднийг яаралгүйхэн дараагийн долоо хоногт Гурван шүүрт ярилцлага өгөх тухай хэлэлцэхийг сонслоо. Шилтгээнд хичээл дууссаны тэмдэг болох хонх дуугарав.

- Баяртай, Харри! Хагрид баасан гаригийн үдэш уулзая! гэж Рита Скитер хөгжүүн хашгирав.

- Тэр түүнийг бүх үгийг хувиргана даа гэж Харри санаа алдав.

- Хэрвээ тэр соплохвост хууль бусаар авчираагүй бол гэж Гермиона цөхрөнгүй хэлэхэд бүгд бие бие рүүгээ харлаа.

- Хагрид өмнө зөндөө асуудалд орж байсан ч Дамблдор хэзээ ч халаагүй. Хамгийн муу нь гэвэл Хагрид соплохвостоос ангижрах байх даа. Уучлаарай... би сая муу гэж хэлсэн үү? Хамгийн дээр гэх гэсэн юм!

Харри, Гермиона хоёр инээлдээд хоолонд орохоор явлаа.

Мэргэ төлгийн хичээл дээр Харри бүхнээс илүү хөгжилтэй байлаа. Тэд ододын зураг судалж түүгээр зөгнөн хэлсэн хэвээр бөгөөд одоо найз нь дэргэд нь байгаа болохоор ахиад л зугаатай болов. Тэдний яаж үхэх тухай аймшигт маргааныг сонсоод профессор Трелони их сэтгэл хангалуун байлаа. Харин тэд дэлхийн ван хүмүүсийн өдөр тутмын амьдралд яаж нөлөөлдөгийг сонсоод инээд алдахад профессор Трелони уурлаж эхэллээ.

- Би өнгөрсөн шөнө энд хатгамал хийгээд сууж байтал бөмбөлөг намайг гэнэт эзэмдсэн юм. Би болор бөмбөлөгний гүн рүү хартал хэн намайг харж байсан гэж бодож байна? хэмээн Трелони уурссанаа нуухын тулд нууцлаг хоолойгоор шивнэн хэлээд Харриг учиртай харлаа.

- Ердийн хэмжээнээс том хөгшин сарьсан багваахай байсан юм болов уу? гэж Рон нүдээ анин шивнэлээ.

Харри бүх хүчээ гарган инээхгүй байхыг хичээв.

- Үхэл, хүүхдүүд минь, үхэл...

Парвати, Лаванда хоёр айдаст автан алгаараа амаа дарав.

- Тиймээ. Тэр шилтгээнийг тойрон эргэлдэж бүгдэд улам ойртож байна... Яг л махчин шувуу шиг гэж профессор Трелони орилоод Харриг харахад томоор эвшээхгүй байж чадсангүй.

Хичээл дуусахад Харри, Рон хоёр алтан олсон шатаар бууж цэвэр агаарт гаран баярлав.

- Зуу дахь удаагаа миний үхлийг хэлж байна! Хэрвээ би зөгнөн хэлсэн болгонд нь үхсэн бол хэдийн анагаах ухааны гайхамшиг болох байлаа гэж Харри хэлэв.

- Хэт баяжуулсан хий үзэгдэл гэж Рон инээн хэлтэл тэдний дэргэдүүр цуст барон бүлтгэр нүдээ ууртай гялалзуулан өнгөрлөө.

- Бурханы авралаар өнөөдөр гэрийн даалгавар байхгүй. Гермionado профессор Вектор гэрийн даалгавар өгсөн нь сайн хэрэг. Түүний хийх ажилгүй байх нь надад таалагдаггүй юм....

Гэхдээ Гермionado оройн хоолонд ирсэнгүй, номын санд ч мөн адил үзэгдсэнгүй. Тэнд зөвхөн Виктор Крам байлаа. Рон номын тавиуруудын хоорондуур шагайнгаа Крамыг хараад түүнээс гарын үсэг авах эсэх тухай Харритай шивнэн зөвлөлдөв. Хажуугийнх нь номын тавиурын дэргэд зургаа долоон охин нуудаж байв. Тэгтэл Роны сонирхол шууд буурлаа. Тэд цамхаг руугаа буцацгаав.

- Тэр хаачсан юм бол? гэж Рон гайхширав.

- Мэдэхгүй. <<Дэмий яриа!>> гээд Харри мөрөө хавчив.

Тарган хатагтай онгойтол ард нь гүйх хөлийн чимээ гарав.

- Харри! гээд Гермionado гулган зогсоход тарган хатагтай хөмсгөө өргөлөө.

- Харри надтай яв! Түргэл, чи тийшээ заавал очих ёстой! Итгэмээргүй юм болсон шүү! Явцгаая.

Гермionado гараас нь зуурч хонгил руу чирэв.

- Юу болсон бэ? гэж Харри асуулаа.

- Явъя би чамд нэг юм үзүүлъя! Түргэл!

Харри Рон руу харахад тэр сонирхсон янзтай байлаа.

- Явцгаая гээд Харри хонгилоор Гермionadoгийн араас дагалаа. Рон яаран араас нь дагалдав.

- Та нар намайг мартчихлаа! Тух алдуулсандаа ч уучлал гуйсангүй шүү! Би эргэж иртэл чинь нээлттэй зогсох болж байна уу? гэж тарган хатагтай уурсав.

- Баярлалаа! гэж Рон мөрөн дээгүүрээ хэллээ.

- Гермиона бид хаашаа явж байгаа юм бэ? гэж Харри гантиг шатаар уруудахдаа асуулаа.

- Удахуй өөрөө харна! гэж хариулав.

Сүүлчийн гишгүүрийг уруудаад тэр Седрик Диггорийн тэр үдэш алга болсон хаалга руу эргэв. Харри урьд нь хэзээ ч энд ирж байсангүй. Тэд чулуун шатаар уруудан хонгилд орж ирлээ. Гэхдээ Снеггийнх шиг баргар биш уужим бөгөөд бамбарын хурц гэрэлтэй ажээ. Ханыг янз бүрийн хоолны хөгжилтэй зургуудаар чимэглэжээ.

- Хүлээгээрэй гэж хэлээд Харри хонгилын голд зогсов.

- Яасан? гээд тэр түүн рүү харлаа.

- Би бүгдийг ойлгочихлоо.

Тэр Роныг нудраад Гермионагийн цаана байгаа зураг руу заав. Энэ бол том тавагтай мөнгөн жимсний зураг байлаа.

- Гермиона! Чи ахиад л биднийг Г.Ү.Х.Н-д хутгахыг хүсээ юу! гээд Рон гараа савчив.

- Үгүй, үгүй! Юу гэж дээ! Энэ ямар ч Г.Ү.Х.Н биш... гэж Гермиона яаран эсэргүүцэв.

- Нэрээ сольчихоо юу? Бид одоо боолын хөдөлмөрөөс чөлөөлөх фронт гэж дуудах уу? Миний хувьд хангалттай! Би үүнд оролцохгүй... гээд Рон хөмсгөө зангидав.

- Би чамаас юу ч хийхийг гуйгаагүй байна! Би тийшээ зөвхөн тэдэнтэй ярилцахын тулд орсон юм. Тэгээд уулзсан... Харри, түргэлээрэй! Чи одоо өөрөө харна аа! гэж Гермиона тэвчээргүйхэн хэлэв.

Тэр ахиад л Харригийн гараас шүүрч аваад тавган дээрх жимсний ногоон лийрийг гижигдэв. Тэгтэл инээх чимээ сонсогдож том ногоон хаалга болон хувирлаа. Гермиона хаалгыг онгойлгон Харриг араас нь хүчтэй түлхэв.

Харри дотогш ороод ийш тийшээ харлаа. Гал зуух их их өндөр адартай агаад Их танхим шиг том ажээ. Чулуун ханын дагуу гялалзсан сав суулга хайруулын тавгууд өлгөж алсын буланд том тоосгон ханан зуух байлаа. Тэгтэл өрөөний голд жижигхэн амьтад цуглан,

- Ноён Харри Поттер! Ноён Харри Поттер! гэж часхийн дуугарав.

Дараагийн агшинд үйлчлэгч нар түүнийг чанга тэврэхдээ хавиргыг нь хугачих шахлаа.

- Добби? гэж Харри дуу алдав.

- Тиймээ, Добби, ноёнтоон! Добби ноён Харри Поттерыг харна гэж найдаж байсан юм. Ноён Харри Поттер түүн дээр зочилж ирлээ!

Добби түүнийг ухран оруулав. Үйлчлэгчийн одон бөмбөг шиг бүлтгэр ногоон нүдэнд нь баярын нулимс мэлтгэнэжээ. Тэр бараг өөрчлөгдсөнгүй. Харандаа шиг шовх хамар, сарьсан багваахай шиг дэлдэн чихтэй, урт хуруу тавхайтай байлаа. Зөвхөн хувцас нь өөрчлөгджээ.

Малфойнд амьдарч байхдаа Добби хуучин дэрний уут өмсдөг байсан юм. Одоо гэрийн үйлчлэгч олон янзын хачирхалтай хувцас өмсчээ. Тэр нь Дэлхийн цом дээр байсан шидтэнгүүдээс ч дор байлаа. Толгойдоо данхны зурагтай малгай өмсөж, түүн дээрээ хурц өнгөтэй тэмдэг хатган, нүцгэн цээжиндээ зангиа зүүн, хүүхдийн хөл бөмбөгийн богино өмд, хоёр янзын оймс өмсчээ. Тэдний нэг нь Харрийн хөлөөсөө тайлж Малфойг хууран үйлчлэгчийг чөлөөлсөн хар оймс байлаа. Нөгөөдөх нь шаргал өнгийн судалтай ягаан оймс байлаа.

- Добби чи энд юу хийж байгаа юм бэ? гэж Харри гайхлаа.

- Добби Хогвартст ажиллахаар ирсэн, ноёнтоон! Профессор Дамблдор Добби, Винки хоёрыг ажилд авсан, ноёнтон минь!

- Винки гэнээ? Тэр бас энд байгаа юм уу? гэж Харри асуулаа.

- Тиймээ-тийм, ноёнтоон! гээд Добби Харрийн гараас хөтлөн гал зуухны урт модон ширээнүүдийн дундуур дагуулж явлаа. Ширээ дөрөв байсан бөгөөд Их танхимынхтай адил ажээ. Одоо оройн хоол дууссан болохоор хоосон байлаа. Магадгүй цагийн өмнө сав суулгаар дүүрэн байсан биз.

Зуугаад жижигхэн үйлчлэгч нар гал зуухны ханын дагуу зогсоод Добби тэдний урдуур Харриг дагуулан өнгөрөхийг харна. Бүгд Хогвартсын сүлд тэмдэг бүхий нүүр гарын алчуураар хийсэн ижилхэн хувцастай байлаа.

- Винки, ноёнтоон! гээд Добби тоосгон ханан зуухны өмнө зогсов.

Винки зуухны урдах сандал дээр сууж байв. Доббиг бодвол жирийн хувцастай байлаа. Богинохон юбка, цамц, чихээ цухуйлгах нүхтэй цэнхэр малгай өмсчээ. Хэдийгээр Доббийн хачин цуглуулга цэвэрхэн байсан бол Винки хувцсандаа санаа тавьдаггүй нь илт. Цамц нь шөлний толботой бөгөөд юбка нь түлэгдэн нүх гарчээ.

- Сайн уу, Винки! гэж Харри мэндлэв.

Винкигийн уруул чичирхэд том хүрэн нүдэнд нь нулимс дүүрч цамц руу нь урсав. Яг л Дэлхийн цомын тэмцээн дээр харсны адил байлаа.

Гермиона, Роны хамтаар гал зууханд орж ирлээ.

- Өө, Винки хонгор минь уйлах хэрэггүй дээ гэж Гермиона хэлэв.

Тэгтэл бүр хүчтэй енгэнэлээ. Добби Харриг баясан гийж харна.

- Харри Поттер аяга цай уухгүйсэн болов уу? гэж тэр Винкигийн уйлах чимээг даван часхийн дуугарав.

- Ээ... за гэж Харри хэллээ.

Агшин зуур Харрид зургаан гэрийн үйлчлэгч данх, гурван аяга, сүүний сав, амтат жигнэмэг, бялуу бүхий том мөнгөн тавиур авчирав.

- Сайхан үйлчилгээ! гэж Рон бахдан дуу алдав. Гермиона түүн рүү ууртайгаар хяламхийсэн ч үйлчлэгч нар жаргалтай байлаа. Тэд гүнзгий бөхийн ёслоод ухрахад Добби зочдод цай аягалав.

- Добби чи энд удаж байна уу? гэж Харри цай авах зуураа асуув.

- Ердөө долоо хонож байна, ноён Харри Поттер! Добби профессор Дамблдор луу очсон, ноёнтоон. Та гэрийн үйлчлэгчид шинэ газар олоход ямар хэцүү болохыг төсөөлөхгүй дээ! Маш хүнд шүү, ноёнтоон! Үнэхээр хүнд! гэж үйлчлэгч инээмсэглэн хэлэв.

Энэ үгийн дараа Винки бүр чанга уйлахад нулимс нь улаан лоольтой адил хамрыг нь даган урсаж цамцыг нь нэвт норголоо.

- Добби ажил хайж хоёр жилийн турш тэнүүчиллээ! Тэгээд ямар ч ажил олсонгүй. Учир нь Добби цалин авахыг хүсч байсан юм! гэж тэр хэлэв.

Үйлчлэгч нар ихэд сониучирхан сонссоноо Добби ямар нэгэн ичмээр бүдүүлэг үг хэлсэн аятай цаашаа эргэлээ.

Гермиона үйлчлэгчийг урамшуулав.

- Сайн байна, Добби! Хэн ч цалин хөлсгүй ажиллах ёсгүй!

- Баярлалаа, хатагтай! Гэхдээ шидтэнгүүдэд цалин хөлс шаарддаг үйлчлэгч хэрэггүй, хатагтай. Тэд сайн үйлчлэгч ингэдэггүй юм гэж хэлээд Доббийн өмнө хаалга хааж байлаа! Добби ажиллах дуртай ч хувцас өмсөж цалин авахыг хүсч байсан ноён Харри Поттер... Добби бол чөлөөтэй үйлчлэгч гээд Добби инээмсэглэв.

Хогвартсын үйлчлэгч нар Добби руу халдварт өвчинтэй аятай эргэж харцгаав. Зөвхөн Винки л байрандаа үлдээд улам чанга цурхирлаа.

- Нэг удаа Добби Винкитэй тааралдаад тэр ч бас чөлөөтэй болсныг харсан! гэж Добби баяртай хэлэв.

Тэгтэл Винки сандал дээрээс унаад жижигхэн нударгаараа шал нүдэв. Гермиона түүнийг босгож тайвшируулахаар яаран ухасхийсэн ч ямар ч амжилт олсонгүй.

Винкигийн орилоон дундуур Добби түүхээ үргэлжлүүлэв.

- Тэгээд Доббид нэг санаа орж ирсэн, ноён Харри Поттер! Яагаад Добби, Винки хоёр хамтдаа ажил хайж болохгүй гэж? Харин Винки <<Хаа нэгтээ хоёр үйлчлэгчийг зэрэг авах ажил байгаа гэж үү?>> хэмээн асуусан. Тэгээд Добби бодтол Хогвартс санаанд нь орж ирлээ! Ингээд Добби Винкигийн хамтаар профессор Дамблдор дээр очиход тэр биднийг ажилд авсан юм!

Добби хөөрсөндөө нүдэнд нь аз жаргалын нулимс мэлтэрлээ.

- Профессор Дамблдор хэрвээ Добби цалин хөлс хүсч байвал тэр төлөх болно гэсэн, ноёнтоон! Добби чөлөөтэй үйлчлэгч шүү дээ. Добби долоо хоногт нэг удаа галлеон авч, сард нэг удаа амрах юм!

- Гэхдээ энэ чинь бага байна шүү дээ! гэж нударгаараа шал балбан орилох Винкигийн чимээн дундуур Гермиона уурсан хашгирлаа.

- Профессор Дамблдор Доббид долоо хоногт арван галлеон төлж хоёр амралтын өдөртэй болгоё гэсэн! гээд үйлчлэгчийн бие тийм их чөлөөт цаг болон баян болохоос айх мэт чичирлээ.

- Гэхдээ Добби татгалзсан, хатагтай. Добби чөлөөтэй үйлчлэгч болохоор мөнгө түүнд хэрэггүй, хатагтай. Добби зүгээр л ажиллах дуртай юм!

- Винки чамд профессор Дамблдор хэдийг төлж байна? гэж Гермиона эелдэгээр сониучирхав.

Тэр энэ асуулт Винкиг сэргээнэ гэж ташаа боджээ. Винки уйлахаа болиод өндийн сууж Гермиона руу муухай харахад царайд нь уур хилэн тодров.

- Тиймээ, Винки бол шившигтэй үйлчлэгч! Тэгэхээр Винкид цалин хэрэггүй! Винки үүнийг хүсэхгүй байна! Винки чөлөөтэй байгаадаа маш их ичиж байна!

- Ичих гэнээ? Винки чи яаж байна! Ноён Крауч л ичих ёстойгоос биш чи биш! Чи ямар ч муу зүйл хийгээгүй! Тэр чамтай аймшигтай харьцсан биз дээ гэж Гермиона гайхширан хэлэв.

Гэтэл энэ үгийг сонсод Винки чихээ даран орилов.

- Та миний эзнийг доромжиллоо, хатагтай! Ноён Краучыг доромжилж болохгүй! Ноён Крауч сайн шидтэн, хатагтай! Ноён Крауч үзэшгүй муухай Винкигийн хувьд зөв алхам хийсэн!

- Винки эрх чөлөөндөө дасахгүй байгаа юм, ноён Харри Поттер. Винки ноён Краучын харьяанд байхгүй больж юу хүссэнээ хэлж болохоо мартчихсан. Харин тэр шилтгээнд амаа хамхисан дээр дээ гэж Добби шивнэлээ.

- Гэрийн үйлчлэгч нар эзнийхээ талаар бодлоо хэлж болохгүй юм уу? гэж Харри асуув.

- Үгүй дээ, ноён Харри Поттер. Энэ бол гэрийн үйлчлэгчийн үүргийн нэг хэсэг. Бид гэр бүлийнхээ алдар гавьяаг өргөхийн тулд эздийнхээ нууцыг хадгалж тэдний тухай муу үг хэлж болохгүй. Харин профессор Дамблдор хэлэхдээ үүнийг шаардахгүй гэсэн... гэж Добби чухалчлан хэлэв.

Добби гэнэтхэн догдолсноо Харри ойртлоо.

- Тэр Доббид хэлэхдээ ухаан муутай хөгшин зөнөг гэж нэрлэж болно гэсэн! хэмээн айсан янзтай шивнээд инээд алдав.

- Гэхдээ Добби хүсэхгүй байна, Харри Поттер. Добби профессор Дамблдор маш их хайртай болохоор түүний нууцыг хадгалахдаа бахархах болно гээд чихээ далбагнуулан толгойгоо сэгсэрлээ.

- Харин Малфойгийнхийг одоо хэлж болох юм уу? гээд Харри инээмсэглэв.

Доббийн том нүдэнд айдас хурав.

- Добби... Добби болно. Добби Харри Поттерт хэлнэ. Түүний хуучин эзэн... муу... хар шидтэн байсан! гэж итгэлгүйхэн мөрөө цэхлэн хэлэв.

Хормын зуур Добби хийсэн зүйлдээ айх мэт дагжин чичирлээ. Дараа нь ширээ толгойгоороо хүчтэй мөргөж,

- Добби муу! Добби муу! гэлээ.

Харри үйлчлэгчийн зангианаас чирэн ширээнээс холдуулав.

- Баярлалаа ноён Харри Поттер гэж Добби толгойгоо илэн хэлэв.
 - Чи чөлөөлөгдөхийн тулд жаахан дадлага хийх хэрэгтэй юм байна гэж Харри хэлэв.
 - Дадлага гэнээ, Добби! Чи яаж эздийнхээ тухай тэгж ярьж зүрхэлж байна! гэж Винки ууртай часхийв.
 - Тэд миний эзэн биш, Винки! Добби тэдний юу хэлэхээс санаа зовохгүй байна!
 - Чи муу үйлчлэгч, Добби! гэж Винки дуу алдахад ахиад л нүдэнд нь нулимс дүүрэв.
 - Хөөрхий ноён Крауч! Тэр Винкигүй хэр байгаа бол? Түүнд миний тусламжгүй амьдрах их хэцүү байгаа даа! Би амьдралынхаа туршид Краучид үйлчилж байна. Миний ээж, эмээ өмнө нь түүнд үйлчилж байсан... Тэд чөлөөтэй Винкигийн тухай мэдэх юм бол юу хэлэх бол? Шившиг ямар шившиг вэ! гээд тэр нүүрээ юбкандаа наан цурхирлаа.
 - Винки надад итгэ, ноён Крауч чамайг байхгүйд маш сайн байгаа. Би түүнийг саяхан харсан... гэж Гермиона хатуу хэлэв.
 - Та нар миний эзнийг харсан гэнээ? Энд Хогвартст уу? гэж тэр дуу алдаад юбкараа нойтон нүүрээ арчиж Гермиона руу бүлтийн харав.
 - Тиймээ. Тэр ноён Бэгмений хамтаар Гурван шидтэний тэмцээнд шүүгч хийж байгаа юм гэж Гермиона толгой дохив.
 - Ноён Бэгмен бас ирсэн хэрэг үү? Ноён Бэгмен муу шидтэн! Маш муу шидтэн! Миний эзэн түүнд дургүй! Маш дургүй шүү! гэж Винки тэдний гайхлыг төрүүлэн уурсав.
 - Бэгмен муу гэнээ? хэмээн Харри гайхлаа.
 - Тиймээ гэж Винки толгойгоо ууртай сэгсчин батлаад,
 - Миний эзэн Винкид тэгж хэлсэн юм. Гэхдээ Винки түүнийг хэлэхгүй! Винки нууцыг хадгалж чаддаг! Хөөрхий эзэн минь, хөөрхий эзэн минь! Винки түүнд юугаар ч тусалж чадахгүй гээд ахиад л цурхирч эхлэв.
- Тэдэнд Винкид хэлэх нэг ч ухаалаг үг олдсонгүй. Андууд Винкиг орхин цай уух зуур Добби чөлөөтэй үйлчлэгчийн амьдралын талаар болон юу худалдаж авахаар төлөвлөж байгаа тухайгаа ярилаа.
- Добби цамцны тухай мөрөөддөг, Харри Поттер! гэж тэр баяртай хэлээд нүцгэн цээжээ заав.
 - Сонсооч, Добби надад чамд өгөх цамц байна. Ээж түүнийг зул сарын баяраар нэхсэн юм. Тэр надад үргэлж бэлэглэдэг юм. Чамд хүрэн өнгө таалагддаг уу? гэж Ронд үйлчлэгч их таалагдсан бололтой хэлэв.
- Добби баясан гийлээ.
- Бид чамд зориулан жаахан багасгаж болно. Чамд зохино доо гэж Рон үргэлжлүүлэв.

Андууд гарахаар босоход үйлчлэгч нар янз бүрийн хоол барин тойрон хүрээлж зууш идэхийг санал болгов. Мэхийн ёслох үйлчлэгч нарыг хараад Гермiona зовж шаналсан янзтай татгалзсан бол Харри, Рон хоёр халаасаа амтат боов, бялуугаар дүүргэж авлаа.

- Их баярлалаа! Баяртай, Добби! гэж Харри тэдний дундуур явахдаа хэлэв.

- Харри Поттер... Добби тань дээр очиж болох уу? гэж чөлөөтэй үйлчлэгч хулчгардуухан асуув.

- Бололгүй яахав, ирээрэй гэж Харри хэлэхэд Добби баясан гийлээ.

- Мэдэж байна уу? Би үргэлж Фред, Жорж хоёрыг гал зуухнаас ийм их хоол яаж хулгайлдаг юм бол гэж бодож байсан юм? Гэтэл ердөө амархан хэрэг байж. Үйлчлэгч нар чамайг амттанаар дарах гээд хүлээж байхад! гэж Рон шатан дээр гарсан хойноо хэлэв.

- Үйлчлэгч нарын аз болохд тэдэнд Добби байна. Тэд чөлөөтэй үйлчлэгч хэр сайн амьдарч байгааг нүдээр харлаа шүү дээ. Тэд ч бас тэгэхийг хүсч болох юм! гэж Гермiona гантиг шатаар өгсөхдөө хэллээ.

- Тэд Винкигийн жишээг дагалдахгүй гэж найдна хэмээн Харри хэлэв.

- Тэр удахгүй уйлахаа больчихно. Цочирдол нь арилахаар Винки Хогвартет дасаж болно. Ноён Краучгүй түүнд хамаагүй дээр байх болно гэж Гермiona ямар ч эргэлзээгүй дуугарав.

- Гэхдээ тэр түүнд хайртай шүү дээ гэж Рон хэлээд цөцгийтэй бялуу идлээ.

- Түүнд яагаад Бэгмен таалагддаггүй юм бол? Ноён Крауч түүнд юу гэж хэлсэн юм бол? гэж Харри асуулаа.

- Магадгүй хэлтэс муу толгойлдогт нь дургүй байдгаа хэлсэн болж таарлаа. Гэхдээ Бэгменд хошин шогийн мэдрэмж бий шүү гэж Рон дуугарав.

- Энэ тухай Персид битгий хэлээрэй хэмээн Гермiona инээмсэглэв.

- Юу гэж дээ хэлэхгүй. Перси ажилладаг хүнээ хошин шогийн мэдрэмжтэй гэдгийг тэвчихгүй. Түүнд Доббийн малгайг өмсгөсөн ч инээхээргүй хүн гэж Рон хэлээд шоколадтай боов идэж эхэллээ.

БҮЛЭГ 22: ГЭНЭТИЙН ДААЛГАВАР

- Поттер! Уизли! Анхаарлаа хандуулцгаана уу!

Профессор МакГонагаллын уурсан хоолой агаарыг ташуур адил ороолгоход хувиргалын хичээлийн төгсгөлд юм оролдон сууж байсан Харри, Рон хоёр давхийн цочлоо. Андууд хэдийн Гвинейн шувууг усан гахай болгон хувиргах даалгавараа дуусгаад эргээд анхны төрхөнд оруулсан нь одоо том торон дотор багшийн ширээн дээр хэвтэж байв (Невилл дүүрэн өд болжээ). Тэд самбар дээр байсан гэрийн даалгавараа бичээд авчихсан байлаа.

Хонх дуугарах дөхсөн болохоор Харри, Рон хоёр ертөнц дээрх бүх зүйлийг мартаад Фред, Жорж хоёрын хуурамч шидэт савааг илд болгон хувиргахыг оролдоход Ронх төмөр тоть, Харрийнх хаймран загас болжээ.

- Поттер, Уизли та хоёр биеэ насанд хүрсэн хүн шиг авч яв. Зарлал бүгдэд хамаатай гэж профессор МакГонагалл уурсан хэлэхэд Харри загасаа чимээгүйхэн шалан дээр унагачихлаа.

- Гурван шидтэний тэмцээний уламжлалт бүжигт үдэшлэг ойртож байна. Бид бүжиг дээр гадаадын зочидтойгоо ойртон нөхөрлөх хэрэгтэй. Бүжигт үдэшлэг зөвхөн дөрөвдүгээр дамжаанаас дээшхи ахлах ангийн сурагчид оролцох юм. Мэдээж та нар үдэшлэгт оролцох хамтрагчаа доод дамжааныхнаас сонгож болно...

Лаванда Браун сонссон даруй чанга инээлээ. Парвати Патил түүнийг нудраад хоёулаа инээдээ барьж ядан Харри руу харцгаалаа. Профессор МакГонагалл хөмсгөө ч хөдөлгөсөнгүй. Илэрхий шударга бус байдал Харригийн уурыг хүргэв. Рон тэр хоёр тэдэн шиг зүйл хийгээгүй билээ.

- Ёслолын хувцас өмсөөрэй. Бүжигт үдэшлэг зул сарын баярын өдөр Их танхимд оройн найман цагаас эхлээд шөнө дунд өндөрлөнө. Бас нэг...

Профессор МакГонагалл ангийг хянамгай харцаар ажиглаад,

- Бүжигт үдэшлэг дээр үс зүсээ янзлаарай гэж таагүйхэн хэлэв.

Лаванда амаа даран бүр чанга инээлээ. Энэ удаад юу түүнийг инээлгэснийг Харри ойлгож байв. Хувиргалын багш үсээ үргэлж нэг хэвийн дагзан дээрээ овоолон зангиддаг байсан юм.

- Зөвхөн энэ ч биш бид баяр дээр Хогвартсын сурагчдад тавьдаг шаардлагаа сулруулахгүй. Хэрвээ та нарын хэн нэгэн түүнийг зөрчвөл би их сэтгэл хангалуун бус байх болно гэж тэр ширүүн хэллээ.

Хонх дуугарлаа. Анги шуугиж сурах бичгээ цүнхлээд мөрөндөө өлгөн гарцгаав.

- Поттер чамд хэлэх үг байна гэж профессор МакГонагалл чимээ шуугиан дундуур хашгирав.

Толгойгүй хаймран загасны тухай байх гэж Харри баргар бодоод багшийн ширээ рүү очлоо. Хүүхдүүдийг гарахыг хүрээж байгаад Профессор МакГонагалл,

- Поттер, аваргууд болон тэдний хосууд... гэв.

- Ямар хос? гэж Харри асуулаа.

Профессор түүнийг тоглоом хийж байна гэж бодсон аятай сэжигтэй хараад,

- Бүжигт үдэшлэгийн хос. Өөрөөр хэлбэл бүжгийн хамтрагч гэж хүйтнээр хэллээ.

Харрийн зүрх ёгхийв.

- Бүжгийн хамтрагч гэнээ? Би бүжиглэдэггүй гэж тэр улайн хэлэв.

- Сурах хэрэгтэй! Хогвартст болох бүжгийг уламжлал ёсоор аваргууд сонгосон хостойгоо нээх юм гэж профессор уурсангүй хэллээ.

Харри гэнэтхэн өөрийгөө бүрх малгай, урт хормой бүхий ёслолын хувцас өмсөөд гоёмсог дашинзтай охинтой явж байна төсөөлөв. Петунья эгч Вернон ах хоёр тэгж хувцасладаг байсан юм.

- Би бүжиглэдэггүй гэж тэр давтлаа.

- Гэхдээ тийм уламжлалтай юм. Чи Хогвартсын аварга болохоор бичигдсэнийг хийх л болно. Хамтрагчаараа хэнийг сонгохоо бодож үзээрэй, Поттер гэж профессор МакГонагалл хатуу хэлэв.

- Гэхдээ би...

- Чи миний юу хэлснийг сонссон! гэж тэр эсэргүүцэхийн аргагүй өнгөөр хэллээ.

Долоо хоногийн өмнө Харрид бүжгийн хамтрагч ол гэж хэлсэн бол луутай харьцуулахад юу ч биш гэж хэлэх байв. Харин одоо бол арав дахин луутай тулалдсан нь дээр байлаа. Охиныг бүжигт урина гэнээ! Үүнээс аймшигтайг бодох ч юм биш.

Энэ жил олонхи сурагчид гэр лүүгээ зул сарын баярын амралтаар явсангүй. Харри үргэлж Улаан модон гудамж руу явалгүй үлддэг байлаа. Гэхдээ өмнөх жилүүдийн хувьд хуруу дарж тоолом цөөн хүн үлддэг байсан юм. Энэ удаад ахлах дамжааныхны хэн нь ч явсангүй. Бүгд бүжигт үдэшлэгт охинтой явах тухайд санааширч байв. Тэд Хогвартст хэр их байдаг билээ! Тэр одоо л үүнийг анзаарлаа. Охидууд шилтгээний өнцөг булан бүрд шивнэлдэн хөхрөлдөж хажуугаар нь хөвгүүн өнгөрвөл чанга инээлдэнгээ баярын шөнө юу өмсөх тухай ярилцаж байв.

- Тэд нар дандаа хамтдаа явж байх юм даа? Яаж нэгийг нь урих вэ? гэж Харри Ронд хэлээд түүн рүү харан инээлдэх охид руу харлаа.

- Магадгүй бугуйлдаж болно биз? Чи хэнийг урихаа сонгочихсон уу?

Харри хариулсангүй. Сонгоод л байдаг сонгоод л байдаг харин хэнийг урихаа мэдсэнгүй. Чжоу түүний дээд дамжааных бөгөөд маш хөөрхөн! Бас квиддич тоглодог. Рон Харрийн юу бодож байгааг мэдсэн бололтой,

- Сонсооч, чамд ямар ч санаа зовох зүйл байхгүй. Чи чинь аварга шүү дээ. Саяхан Унгарын эвэр сүүлтийг ялсан. Чамд ямар ч охин татгалзахгүй гэхэд мөрийцөхөд ч бэлэн байна! гэв.

Саяхны маргаанаа санаад Рон бүх хүчээ гарган хоолойны таагүй өнгөө хэвийн болгохыг хичээв. Гэхдээ хамгийн сонирхолтой нь Роны зөв байлаа.

Маргааш өдөр нь түүнийг Пуффендуйн гуравдугаар дамжааны нэг ч үг сольж байгаагүй буржгар охин урьжээ. Тэр түүнийг үгүй гэж хэлэхээс өмнөхөн хариугаа хүлээн зогссор байсан юм. Охин ихэд гомдон уруулаа жимийгээд явахад Рон, Симус, Дин гурав ид шидийн түүхийн хичээлийн турш түүгээр даажигнажээ. Тэр өдөр Харри ахин хоёр урилга авлаа. Хоёр дугаар дамжааны болон харахад аймаар хүчирхэг төрхтэй хэрвээ татгалзах юм бол нам цохихоос ч буцахгүй тийм тавдугаар дамжааны охиноос.

- Дажгүй л юм байна гэж Рон инээхээ болиод хэлэв.

- Надаас хамаагүй өндөр юм байна шүү дээ. Би түүнтэй бүжиглэхийг оролдвол ямар харагдахыг төсөөлөөд үз! гэж Харри түгшин хэллээ.

Тэр Гермионагийн Крамын тухайд хэлсэн <<Тэр зөвхөн алдартай болохоороо таалагдаж байгаа юм>> гэснийг саналаа. Ингээд Харри хэрвээ аварга биш байсан бол эдгээр охид урих байсан эсэхийг бодлогоширч байв. Тэгээд гэнэтхэн өөрөөсөө хэрвээ түүнийг Чжоу урьсан бол энэ үгийг санах байсан эсэхээ асуулаа.

Бүжигт үдэшлэг түүний амьдралыг сайн тал руу нь өөрчилжээ. Үүний шалтгаан нь алтан өндөг болон луу байлаа. Тэр хонгилд нөхөрсөг бус харилцаатай бараг тааралдахаа больсон бөгөөд үүнд Седрик холбоотой гэж бодож байв. Тэр л Пуффендуйнханы тархинд талархал төрүүлэх авралын үг хэлснээс зайлахгүй. <<Седрикийг дэмжиж байна>> гэсэн гомдмоор тэмдгүүд цөөрчээ. Зөвхөн Драко Малфой түүнийг Рита Скитер сурвалжлагаар даажигнах бөгөөд инээсэн хэвээр байлаа. Ахин нэг баяртай үйл явдал бол Хагридын яриа <<Зөнч>> сонинд гарсангүй.

- Тэр шидэт амьтны талаар бага сонирхож байсан гэж Хагрид найзуудад улирлын сүүлчийн хичээл дээр хэлэхэд тэдний санаа амарчээ.

Тэднийг баярлуулан Хагрид соплохвостуудтай шууд харьцах явдлыг зогсоожээ. Тэд одоо гурван хөлтэй ширээний ард суугаад овоохойны гадаа байгаа соплохвостуудын шинэхэн хоолыг бэлдэж байлаа.

- Тэр зөвхөн Харригийн тухай асуусан. Би түүнд чамайг Дурслийнхаас авсан цагаас хойш найзууд болсон гэсэн. <<Та үүнд харамсаж байгаагүй юу?>> гэж тэр асуусан шүү. <<Бас нэг ч удаа хичээл дээр чинь доромжилж байгаагүй юу?>> гэж. Намайг үгүй гэж хэлэхэд царай ярвайж харагдсан. Харри хичээлийг тэвчиж чаддаггүй тухай үг сонсохыг хүссэн нь гарцаагүй.

- Мэдээж хүссэн. Тэр намайг эмгэнэлтэй жижигхэн баатар болгож бичихийг хүсч байгаа юм! Би үүнд нь бүр залхчихсан гэж Харри хэлээд том түмпэнгээс лууны элэг авч хутгаар хэрчлээ.

- Шинэ сахиулсан тэнгэр олвол таарна. Тэр Харриг насанд хүрээгүй гэмт хэрэгтэн гэж сонсохыг хүссэн байх гэж Рон хэлээд саламандрын өндөгний хальсыг хуулав.

- Гэхдээ энэ тийм биш шүү дээ! гэж Хагрид цочирдсон байртай хэлэв.

- Тэр Снеггээс ярилцлага авах хэрэгтэй байсан юм. Өөр хэн түүнд хүссэн мэдээлэл өгч чадах билээ. <<Поттер анхны өдөр сургуульд ирсэн цагаасаа л дүрэм зөрчсөн...>> гээд л.

- Тэр тэгж хэлсэн гэж үү? Мэдээж чи дүрэм зөрчсөн л дөө. Гэхдээ их сайн байсан шүү дээ гэж Хагрид гайхахад тэр гурав тэсэлгүй инээлдэв.

- Сайн байлгүй яахав. Гомдох хэрэггүй! гээд Харри инээмсэглэв.

- Чи зул сарын бүжигт үдэшлэгт орох уу? гэж Хагридаас Рон асуулаа.

- Бодож л байна. Тийм зүйлийг харах хэрэгтэй. Харри бүжгийг нээнэ биз дээ. Тэнд бүх аваргууд байна... Ингэхэд чи хэнийг урих гэж байна?

- Хэнийг ч биш гээд Харри улайлаа. Хагрид асуухаа болихоор шийдэв бололтой.

Хичээлийн сүүлчийн өдрүүд хөгжөөн шуугиан ихтэй байлаа. Шилтгээнд бүжигт үдэшлэгийн тухай цуу яриа дэгдэж байв. Харри заримд нь итгэсэнгүй. Жишээлбэл, Дамблдор хатагтай Розмертагаас найман зуун торх балын дарс худалдаж авсан, <<Эмгэн шуламс>> гэдэг хамтлаг урьсан зэрэг. <<Эмгэн шуламс>> гэдэг тийм хамтлаг байдгийг Харри мэдэхгүй байлаа. Дурслийнханд шидэт радио байхгүй юм чинь. Гэхдээ шидэт радио сонсож өссөн хүмүүсээс үзэхэд алдартай хамтлаг бололтой.

Хэд хэдэн багш нар түүний дотор жижигхэн Флитвик ахлах дамжааныханд гар даллаж бүжгийн өмнөх зөвөлгөө өгнө. Лхагва гаригт Флитвикийн хичээл дээр бүгд юу хүссэнээ хийж байсан бөгөөд харин тэр өөрөө Харритай татдаг шидийг лууны тэмцээн дээр яаж ашигласан тухай яриа өрнүүлэв. Өөр багш нар үүнд анхаарал хандуулсангүй. Ид шидийн түүхийн багш профессор Бинс аль эрт үхсэн болохоор бүжигт үдэшлэг огт хамаагүй байлаа. Түүний албинуудын цуст бослогын тухай яриа Персигийн тогооны зузааны тухай илтгэлтэй адилхан уйтгартай сонсогдох аж. Профессор МакГонагалл, Грюм хоёр сурагчдыг хичээл дээр сүүлчийн мөч хүртэл ажиллуулах бөгөөд мэдээж Снегг юуны түрүүнд Харриг уусмалын хичээл дээр хийх ажилгүй байхаас санаа тавьжээ. Тэр хичээлийн сүүлчийн хорны эсрэг уусмалыг туршиж үзнэ гэж мэдэгдсэн байна.

- Жинхэнэ ёрын амьтан байна даа! Биднийг сүүлчийн өдөр шалгах юм гэнэ! Хичнээн ихийг цээжлэх болж байна! Зул сарын баярын өмнөх сүүлчийн өдрийг гутаах нь байна! гэж Рон уурслаа.

- М-м... чи бүх хүчээ дайчлахгүй байх шиг санагдаж байна хэмээн Гермiona овоолоостой номны дээгүүр шилтгээний шидэт газрын зураг дээр жижигхэн дэлбэрдэг байшин суурилуулж байгаа Роныг харж хэллээ.

- Гэхдээ энэ чинь зул сар шүү дээ, Гермiona гэж Харри хэлээд арав дахь удаагаа <<Педдлийн их буунуудын нислэг>> номоо уншлаа.

Гермiona түүнийг таагүй харцаар ажиглав.

- Харин би чамайг хорны эсрэг ерөндөг туршуулахыг хүсээгүй бол өөр илүү чухал ажил хийх хэрэгтэй гэж бодож байна.

- Жишээлбэл ямар? гэж Харри асуугаад Педдлийн багийн Жоуи Женкинс блажерыг эсрэг багийнхаа ангууч руу илгээхийг ажиглав.

- Өндөгний нууц!

- Тайвшир даа, Гермiona. Надад хоёр сарын хорин дөрвөн хүртэл хугацаа хангалттай байна.

Эхний тэмцээний дараа Харри алтан өндөгөө чемодандаа хийгээд нэг ч өнгийж харсангүй. Урд нь хоёр хагас сар байхад алтан хальсан дор байгаа чарлаан юу болохыг мэдэж амжих л байлгүй.

- Тааврыг тайлахад хоёр сар хангалтгүй ч юм билүү. Чи хоёр дахь тэмцээн дээр тэнэг харагдахыг хүсээгүй л юм бол тааврыг таах ёстой.

- Гермiona, түүнийг тайван орхи. Түүнд багахан амралт хэрэгтэй гэж Рон хэлээд сүүлчийн хоёр зургийг тавьтал шатаж хөмсөг нь хуйхлагдчихлаа.

- Ёслолын хувцсан дээр сайхан харагдах байх даа, Рон гэж ширээнд ирж суусан ихрүүд даажигнан хэлэв.

- Рон чиний Гахайг авч болох уу? гэж Жорж асуулаа.

- Үгүй дээ, тэр сүүлчийн захианаасаа ирээгүй байгаа. Та нар түүгээр яах гэж байгаа юм?

- Жорж түүнийг бүжигт урих гэж байгаа гэж Фред даажигнан хэлэв.

- Чиний тэнэг толгойгоор л захиа илгээх хэрэгтэй Жорж хэллээ.

- Та хоёр хэнд бичих гэж байгаа юм? хэмээн Рон сонирхлоо.

- Хамраа дүрэх хэрэггүй дээ, Рон. Чамайг бас шатаачихна шүү гэж Фред саваагаараа заналхийлэн сүрдүүлэнгээ,

- Та хоёр бүжгийн хамтрагчаа олсон уу? гэв.

- Үгүй.

- Яарах хэрэгтэй. Бүх хөөрхөнүүд нь дуусчихад та хоёрт юу ч үлдэхгүй гэж Фред хэллээ.

- Чи хэнтэй явах гэж байгаа юм? хэмээн Рон асуулаа.

- Анжелинатай гэж Фред огтхон ч ичсэн янзгүй хэлэв.

- Юу гэнээ? Түүнийг хэдийн урьчихаа юу? гэж Рон гайхлаа.

- Сайхан асуулт байна! гээд Фред толгойгоо эргүүлээд амралтын өрөөгөөр нэг,

- Анжелина гэж хашгирлаа.

Анжелина зуухны өмнө Алиса Спиннеттэй ярилцан зогсож байв.

- Яасан? гээд тэр Фред рүү харав.

- Надтай хамт бүжигт явах уу?

Анжелина түүнийг шинжсэн байртай харангаа,

- Явна гэж инээмсэглэн хэлээд эргэж яриандаа орлоо.
- Харж байна уу гэж Фред хэлээд эвшээн босч Жоржод,
- Явж сургуулийн уулийг авъя гэв.

Ихрүүд явчихлаа. Рон хөмсгөө тэмтрэхээ болиод хөөрхийлөлтэй уугиж байгаа зурган дээгүүр Харри руу харав.

- Түүний зөв, Харри. Ямар нэг юм хийх хэрэгтэй... тэгэхгүй бол зөвхөн савдаг үлдэх нь байна.
- Савдаг гэнээ... уучлаарай хэн гэж? хэмээн Гермiona эгдүүцсэн байртай асуулаа.
- Чи мэдэж байгаа биз дээ. Би Элоизой Мижентэй явж байснаас ганцаараа явсан нь дээр.
- Түүний батга саяхан арилсан. Дажгүй охин шүү дээ!
- Түүний хамар нүүрнийхээ дунд биш!
- Ойлгомжтой. Чамд ямар таалагддагыг ойлголоо. Чи хамгийн хөөрхөн охиныг урих гэж байгаа юм байна? Мэдээж ямар нь чамтай явах билээ дүүрчихсэн тэнэг л биш бол?
- Наадах чинь харин үнэн сонсогдож байна...
- За, би явж унтлаа гэж Гермiona янзгүй дуугараад унтлагын өрөө лүүгээ явлаа.

Сургуулийн захиргаанаас Шармбатон, Дурмстрангын зочдод урьд хожид байгаагүй зул сарын баяр тэмдэглэн сэтгэгдэл төрүүлэхийг хүсч байгаа нь ойлгомжтой байлаа. Шилтгээн хэзээ ч ийм гоёмсог байсангүй. Гантиг шатны бариулыг хайлдаггүй мөсөн угалз хээгээр гоёж уламжлал ёсоор Их танхимд арван хоёр ширхэг гацуурыг гялалзсан жимс, гуугладаг алтан ууль болон өөр бусад шидэт тоглоомуудаар чимэглэжээ. Рыцарын хуяг дуулгууд дэргэдүүр нь өнгөрөх болгонд зул сарын сүлд дууг дуулж байв. Хоосон дуулга баяртайгаар хангинуулах хэдий ч харамсалтай нь дууныхаа зөвхөн хагас үгийг нь мэддэг аж. Сургуулийн харуул Филч арван удаа дуулганд нуугдан өөрийн зохиосон бүдүүлэг дуугаа дуулах Пивзийг хөөж гаргалаа.

Харри Чжоуг бүжигт уриагүй л байв. Тэр Роны хамтаар ихэд сэтгэл хөдөлсөн ч найзыгаа бүжигт хамтрагчгүй явах тэнэг хүн биш гэж итгэж байв. Харри бусад аваргын хамтаар бүжгийг эхлүүлэх болсондоо түгшиж байлаа.

- Хамгийн муу төгсгөл гэвэл уйланхай Миртл байна гэж тэр баргар царайлан хошигножээ. (Уйланхай Миртл бол гуравдугаарт давхарт байдаг охидын жорлонгын хий үзэгдэл юм).
- Харри бид үүнийг шүд зуун хийх ёстой. Өнөө орой л энэ бүхэнд цэг тавья гэж Рон баасан гаригийн өглөө шийдэмгий мэдэгдэв.
- Ээ... тэгье гэж Харри толгой дохилоо.

Гэхдээ тэр өдөр Харри Чжоутай ганцаар байхад нь тааралдсангүй. Түүнтэй ид шидийн түүхийн хичээл хүрэх замдаа тааралдсан ч ахиад л найз охидуудаараа

хүрээлүүлэн явж байв. Тэр хаашаа ч ганцаар явдаггүй юм байх даа? Магадгүй түүнтэй охидын жорлонгын үүдэн дээр уулзаж болох юм болов уу? Хэрвээ ойрын үед түүнийг урихгүй бол өөр хүн урьчих болов уу?

Харри Снеггийн хяналтын ажил дээр төвлөрч чадаагүй учир жоронд орох орцыг мартжээ. Гэхдээ одоо түүнд бүгд хамаагүй байв. Чжоуг урихын тулд зоригтой байх хэрэгтэй. Хонх дуугарав уу үгүй юу тэр цүнхээ авч газар дорх хонгилоос гүйн гарав.

- Оройн хоолон дээр уулзая гэж тэр Рон, Гермiona хоёрт хашгираад хоёр гишгүүр алгасан харайж дээшээ өгслөө.

Тэр түүнтэй ердөө хэдэн үг солих болно. Тэгээд л болно... Хэдэн хонгилоор явж өнгөрөхөд дүүрэн хүнтэй байлаа. Эцэст нь түүнийг хар урлагаас хамгаалах хичээлээс гарч явахыг нь харлаа.

- Чжоу! Чамтай хоёр үг сольж болох уу?

Чжоугийн найз охид хөхөрч эхлэв. Тэнэг охидын инээхийг хуулиар хориглох юмсан гэж Харри уурсан бодлоо! Чжоу ганцаараа инээсэнгүй.

- Тэгэлгүй яахав гэж хэлээд найзуудаасаа салан түүн рүү хүрч ирэв.

Харри түүн рүү харахад сэтгэл санаа нь дээд зэргээр хөвчирчээ.

- М-м гэж тэр хэллээ. Үгүй ээ, тэр түүнийг урьж болохгүй. Болохгүй, тэгээд л болоо! Үгүй ээ, ёстой! Харригийн амнаас үг гарсангүй. Чжоу гайхан түүнийг харна.

- Надтайбүжгэндявахыгхүсчбайнауу?

- Уучлаарай юу гэнээ?

- Надтай бүжигт явахыг хүсч байна уу? (Тэр яагаад улайчихав аа!)

- Бүжигт гэнээ?

- Бүжигт!

- Өө, Харри, надад үнэхээр харамсалтай байна. Би өөр хүнтэй явна гээд амлачихсан хэмээн Чжоу мөн адил улайн хэллээ.

- Аан гэж Харри хэлэв.

Тэгтэл мөчийн төдийд дотроос нь хилэнц урж байгаа юм шиг хачирхалтай мэдрэмж төрөн сэтгэл санаа нь хоосрох шиг болов.

- Өө, тийм. Зүгээр дээ..

- Надад их харамсалтай байна, үнэн шүү гэж Чжоу аяархан хэлэв.

- Ойлгож байна...

Тэд зогсоод бие биеэ харлаа.

- Би тэгэхэд...

- Тиймээ гэж Харри хэллээ.

- За, баяртай! гээд Чжоу улайсан хэвээр явлаа.

- Чи хэнтэй явах гэж байгаа юм? хэмээн Харри түүний араас асуув.

- Седриктэй. Седрик Диггори.

Доторхи бүх зүйл нь байрандаа оров. Зөвхөн цээжинд нь тугалга цутгасан мэт хүнд оргино. Хоолны тухай мартаад Харри цамхагтаа эргэн ирлээ. Алхам бүрд нь Чжоугийн хэлсэн <<Седриктэй. Седрик Диггори>> гэсэн үг чихэнд нь хангинах аж. Урьд нь Седрик тэдний багийг хожсон ч гэлээ түүнд таалагддаг байсан юм. Седрик царайлаг залуу болохоор бүгд түүнийг хүндэтгэдэг. Гэхдээ одоо Харри Седрик зөвхөн царайлагаас цаашгүй бөгөөд бусдаас дээрдэх юу ч үгүй тийм ч ухаантай биш гэдгийг ойлгов.

- <<Шидэт дагина>> гэж тэр шинэ нууц үгээ бувтналаа.

- Тиймээ зөв гээд тарган хатагтай нугасан дээрээ эргэн үүд онгойв.

Амралтын өрөөнд ороод Харри гайхал төрүүлэм үзэгдэл харав. Рон алсын буланд үнсэн саарал царайтай сууж байлаа. Дэргэд нь Жинни суугаад аяархан хоолойгоор тайвшируулахыг хичээнэ.

- Юу болсон бэ, Рон? гээд Харри түүн рүү хүрч очлоо.

Рон толгойгоо өргөхөд нүүрэнд нь айдас дүүрэн байв.

- Би яах гэж үүнийг хийв ээ? Юу намайг хатгав? гэж тасалдсан хоолойгоор дуугарав.

- Чи юуны тухай яриад байна? гэж Харри асуулаа.

- Тэр... тэр Флерийг бүжигт явах уу гэж урьсан юм гэж өмнөөс нь Жинни хариулаад инээмсэглэхгүйг хичээн гарыг нь өрөвдөнгүй иллээ.

- Юу гэнээ?

- Би яагаад хийснээ мэдэхгүй байна! Би юунд найдсан юм бол? Эргэн тойронд дүүрэн хүн байсан. Би лав галзуурсан байх. Бүгд намайг харсан! Би танхим дундуур түүний хажуугаар явахад Диггоритой ярилцаад зогсож байсан юм. Гэнэт намайг юу хатгасныг бүү мэд. Би түүнийг урьчихсан!

Рон дуу алдан ёолоод нүүрээ алгаараа дарснаа,

- Харин тэр намайг яг тэнгисийн нялцгай биет шиг харсан шүү. Хариу ч хэлээгүй. Харин би... би... мэдэхгүй... ухаан ороод зугтчихсан гэлээ.

- Түүнд вейлагийн цус байгаа. Чиний зөв байсан. Түүний эмээ нь вейла байсан юм билээ. Үүнд чиний буруу байхгүй. Энэ юу болохыг ойлгож байна уу? Чи түүний дэргэдүүр өнгөрөхөд тэр чамд эртний шившлэг илгээсэн байна. Тэр Диггори руу чиглүүлсэн хэдий ч чи түүнд нь өртжээ. Харин Диггорид юу ч тохиолдоогүй байна. Тэр бүжигт Чжоуг урьсан.

Рон Харриг нүдээ гялалзуулан ширтэв.

- Би сая түүнийг урилаа. Тэр надад тэгж хэлсэн юм хэмээн Харри хэлэв. Жинни үүнийг сонсоод нүүрэн дээрх инээмсэглэл нь алга болов.

- Энэ чинь сайн хэрэг шүү дээ! Зөвхөн биднээс гадна Невиллд хос алга. Тэр хэнийг урьсаныг мэдэх үү? Гермионаг!

- Байж боломгүй юм... хэмээн Харри сонссон зүйлдээ гайхширлаа.

- Тиймээ би ч гэсэн мэдэж байна гээд Роны хацарны өнгө сэргэн инээд алдаад,

- Невилл надад өөрөө уусмалын хичээлийн дараа хэлсэн. Гермиона түүнд сайн хандан хичээл хийхэд нь тусалж уусмалыг нь бэлтгэж өгдөг юм байна л даа... Харин тэр түүнд өөр хүнд зөвшөөрсөн гэж хэлсэн гэнэ. Ха-ха! Хэрвээ! Тэр зүгээр л бүжигт Невиллтэй явахыг хүсээгүй байх... Тийм дээ хэн ч хүсэхгүй юм чинь!

- Инээх явдалгүй! гэж Жинни уурслаа.

Хөргөн гарцаар Гермиона орж ирэв.

- Яагаад хэн ч оройн хоолон дээр байсангүй вэ? гээд найзууд руугаа ойртов.

- Яагаад гэвэл... Алив та нар инээхээ болиоч дээ! Яагаад гэвэл энэ хоёр дөнгөж сая бүжигт явах охиноо урихад татгалзсан байна! гэж Жинни тайлбарлав.

Харри, Рон хоёр инээхээ болив.

- Баярлалаа, Жинни... гэж Рон гашуунаар хэлэв.

- Бүх хөөрхөнүүд нь хэдийн сонгогдсон байгаа биз, Рон? хэмээн Гермиона толгойгоо бардам хаялаад,

- Одоо Элоиза Мижен сайхан санагдахаар байгаа биз? Гэхдээ би чамайг хаа нэгтээгээс хэн нэгнийг олно гэдэгт итгэлтэй байна гэв.

Рон гэнэтхэн түүн рүү өөр харцаар харав.

- Гермиона! Невиллийн зөв чи бол охин шүү дээ!

- Муугүй ажиглалт байна гэж Гермиона егөөдөнгүй хэлэв.

- Чи Харри бид хоёрын нэгтэй бүжигт явахгүй юм уу?

- Үгүй дээ, чадахгүй! гэж Гермиона тасхийлээ.

- Алив л дээ, бидэнд хос хэрэгтэй байна. Бүгдэд хос байхад бидэнд байхгүй болохоор тэнэг харагдах байх...

- Би та нартай явахгүй. Би өөр хүнтэй явна гээд хэлчихсэн хэмээн Гермиона гэнэтхэн улайлаа.

- Чи хэнтэй явах юм бэ. Невиллээс ангижирсан гээ биз дээ!

- Ангижирсан гэнээ? Чи тэгж бодож байна уу? гээд Гермиоангийн нүдэнд аюултай оч дүрсхийлээ.

- Рон чи гурван жилийн турш миний охин гэдгийг ажиглаагүй хэрэг үү. Тэгээд хүмүүсийг олсон хойно ажигладаг!

Рон түүн рүү нүдээ бүлтийлгэн харав.

- За яахав. Бид үүнийг мэднэ. Тэгээд? Бидэнтэй явах уу? гэж тэр инээмсэглэв.

- Би хэдийн хэлсэн биз дээ. Өөр хүнтэй явна гэж хэмээн Гермiona жинхэнээсээ уурсаад амралтын өрөөнөөс нисэн гарлаа.
 - Тэр худал хэлж байгаа юм! гэж Рон араас нь харан хэлэв.
 - Худал хэлээгүй гэж Жинни аяархан хэлэв.
 - Тэр хэнтэй явах гэж байгаа юм бол?
 - Хэлж чадахгүй нь энэ бол түүний нууц.
 - За яахав. Энэ чинь инээдтэй байна! Жинни чи Харритай яв, харин би зүгээр л...
 - Чадахгүй нь гээд Жинни мөн адил улайлаа.
 - Би Невиллтэй явна. Гермiona түүнд татгалзсаны дараа тэр намайг урьсан юм. Харин би бүжигт оролцох өөр боломж олдохгүй байх гэж бодоод... Би чинь дөнгөж гуравдугаар дамжаа шүү дээ гэж Жинни золгүй царайлан хэлээд,
 - За би хоолонд явлаа гээд босч өрөөнөөс гарлаа.
 - Тэд яагаа вэ? гээд Рон Харри руу бүлтийн харав.
- Харри энэ агшинд Парвати, Лаванда хоёр амралтын өрөөнд орж ирэхийг ажиглав. Шийдвэртэй алхам хийх хэрэгтэй байлаа.
- Энд хүлээж байгаарай гээд тэр үсрэн босоод Парвати руу очин юу ч бодолгүй,
 - Надтай бүжигт явах уу? гэв.
- Парвати хөхөрлөө. Харри инээж дуусахыг нь тэвчээртэй хүлээсний эцэст хуруугаараа жанчныхаа товчыг оролдон байж,
- Тиймээ явъя гэж хэлээд улайлаа.
 - Баярлалаа гэж Харри гүнээ сэтгэл амран хэлээд,
 - Лаванда, чи Ронтой явахгүй биз? гэв.
 - Тэр Симустэй хамт явна гэж Парвати найзынхаа өмнөөс хариулаад хоёулаа хөхрөлдөв.
- Харри санаа алдлаа.
- Чамд Ронтой явах хүн байхгүй биз? гэж Харри дуугаа намсган аяархан асуулаа.
 - Гермiona Грэйнджер яасан юм? гэж Парвати асуув.
 - Түүнийг урьчихсан.
- Парвати гайхсандаа хөмсгөө өргөв.
- Тийм үү? Хэн? гэж итгэлгүйхэн хэллээ.
 - Мэдэх юм алга. Роны хувьд яах болж байна? гэж Харри мөрөө хавчин дуугарав.
 - Миний эгч болох байх.. Чи түүнийг мэднэ дээ... Когтевранд сурдаг юм. Хэрвээ хүсч байвал би түүнд хэлье гэж Парвати удаанаар хэлэв.
 - Сайхан санаа байна! Түүнтэй ярилцаад хэлээрэй.

Ингээд Харри Рон руу эргэн ирлээ. Тиймээ энэ бүжигт үдэшлэгт баатрын амжилт шаардагдлаа. Одоо зөвхөн Падма Патилын хамар нүүрнийхээ голд байна гэж найдах л үлдлээ.

БҮЛЭГ 23: БҮЖИГТ ҮДЭШЛЭГ

Зул сарын баярын амралтаар дөрөвдүгээр дамжааныханд маш их даалгавар өгчээ. Гэхдээ Харри номны ард суухыг яарсангүй. Амралтын өмнөх долоо хоногийн турш хөгжилджээ. Олонхи нь гэртээ хариагүй болохоор Гриффиндорын амралтын өрөө хичээлийн үе шиг хүнтэй байлаа. Зочны өрөө чимээ шуугианд бүр багассан юм шиг санагдана.

Фред, Жорж хоёрын цөцгийтэй жигнэмэг том амжилт олж амралтын анхны өдөр хүмүүс хаа сайгүй шаргал өд унагаж байв. Гэхдээ Гриффиндорынхон төдхөн ов мэхэнд дасаад ямар нэг юм идэхийн өмнө дотор нь цөцгийтэй жигнэмэг нуучихсан юм биш биз гэж гэнэтхэн болгоомжилдог болжээ. Жорж, Фред хоёр ахин өөр зүйл бэлтгэж байгаа гэж нууцаа хэлсэн болохоор Харри ихрүүдийн гараас юу ч авахаа больжээ. Тэр Дадлигийн хүнд хэлэн чихрийн түүхийг мартаж амжаагүй байлаа.

Цас будран орж шилтгээн битүү цасанд хучигдлаа. Шармбатоны цэнхэр сүйх тэрэг том цагаан хулуу шиг болж, Хагридын байшин амтат боов шиг үзэгдэн, Дурмстрангын хөлөг онгоцны цонх мөсөөр хучигджээ. Үйлчлэгч нар гал зуухандаа гар хумхилгүй хөдөлмөрлөсөөр хоолны ширээнд шарсан мах, янз бүрийн амттан тавигдаж байлаа. Бүгд баярлаж байсан ч зөвхөн Флер Делакур цаг үргэлж ямар нэг юманд харамсана.

- Танай хоол хэтэрхий хүнд юм. Миний сайхан жанч надад багтахаа больсон! гэж тэр Их танхимд сэтгэл хангалуун бус дуу алдлаа. Харри, Рон, Гермiona гурав түүгээр өнгөрөхөд Рон Харригийн нурууны ард нуугдав.

- Хөөрхий амьтан! Яамар эмгэнэлтэй юм бэ! гэж Гермiona даажигнан хэлэв. Гэхдээ Флер танхимаас гарч ясан болохоор түүнийг үгийг сонссонгүй.

- Гермiona чи бүжигт хэнтэй явах гэж байгаа юм бэ? гэж Рон асуулаа.

- Хэлэхгүй. Яагаад гэвэл чи шоолно.

- Тоглож байна уу, Уизли! Чи хэн нэгэн энэ морины шүдтэй эрлийзийг урина гэж бодож байна уу? гэх Малфойн хоолой ард сонсогдов.

Харри, Рон хоёр нударга зангидахад Гермiona Малфойн мөрөн дээгүүр харан гар даллаад,

- Профессор Грюм, өглөөний мэнд! гэж хашгирав.

Малфой цонхийн цайж эргэж хараад нүдээрээ хайлаа. Грюм үргэлж түүний хүсээгүй үед гарч ирдэг болохоор одоо багш нарын ширээнд сууж байв.

- Яасан татганадаг өмхий хүрэн болохоос айгаа юу? гэж Гермiona дооглонгуй хэлээд найзуудтайгаа инээлдэн шатаар өгслөө.

- Гермiona чиний шүд... гэж Рон гэнэтхэн түүн рүү харж хэлэв.

- Миний шүд яасан гэж?

- Тэд өөр болчихож. Би сая л харлаа...

- Тиймээ өөр болсон. Чи намайг Малфойн бэлэглэсэн соёотой явна гэж бодоогүй биз дээ?

- Үгүй дээ, тэд шал өөр болчихож. Урьд нь ийм байгаагүй шүү дээ. Бүгд жигдхэн болчихож...

Гермиона зальжин инээмсэглэхэд Харри ч гэсэн түүний инээмсэглэл өөр болсныг харлаа.

- Намайг хатагтай Помфри руу гүйж очсоныг санаж байна уу? Тэр надад толь өгөөд шүдээ урьдын хэвэндээ орохоор даллаарай гэсэн юм. Харин би... шууд даллаагүй болохоор тэр багассан.

- Ээж аав хоёрд таалагдахгүй байх даа. Би тэднээс хичнээн удаа шүдийг минь багасгаж өгөхийг гуйсан ч байгаагаараа дээр гэсэн юм. Эцэг эх минь шүдний эмч болохоор шүдийг шидээр... Хараач! Гахай эргээд ирж!

Роны жижигхэн ууль мөсөн хашлагатай шатны орой дээр суугаад суугаад чанга жиргэн сарвуундаа цаасны өөдөс зуусан харагдана. Түүний хажуугаар өнгөрсөн хүмүүс жижигхэн уулийг заан инээлдэж гуравдугаар дамжааны хэдэн охид зогслоо.

- Хараач, ямар жижигхэн юм бэ! Хөөрхөн байгаа биз!

- Тэнэг жижигхэн өдөн бөмбөг! гээд Рон гүйн Гахайг авлаа.

- Захиагаа шууд хаягийн дагуу хүргэж бай. Бүгдийн нүдэн дээр анхаарал татах хэрэггүй.

Гахай Роны гараас цухуйгаад аз жаргалтай гууглав. Гуравдугаар дамжааны охид түүнийг гайхан харцгаана.

- Юугаа харсан юм! Эндээс явцгаа! гэж Рон зандраад гараа даллахад Гахай улам чанга гуугчив.

- Харри үүнийг барьж байгаач гэж Рон аяархан хэлэхэд гомдсон гуравдугаар дамжааныхан явцгаалаа.

Тэр захиаг авч Харрид өгөхөд халаасандаа сайтар нуугаад цамхаг руугаа яарцгаав.

Амралтын өрөөнд бүгд хөгжилдөн тэдэнд хэн ч анхаарал хандуулсангүй. Харри, Рон, Гермиона гурав цас хаялж байгаа харанхуй цонхны дэргэд суугаад Харри захиаг чанга уншив.

Сайн уу, Харри.

Чамд лууг дийлсэн явдалд баяр хүргэе. Цомд нэрийг чинь хийсэн хүн сэтгэлээр унасан байх даа. Би Конъюнктивитус шившлэгийн тухай хэлэх гэсэн юм. Лууны хамгийн эмзэг газар бол нүд...

- Тийм учраас л үүнийг Крам ашигласан байх нь! гэж Гермиона шивнэлээ.

...чи сайн боджээ. Сайн байна!

Гэхдээ тайвширах болоогүй. Зөвхөн нэгдүгээр сорилт л ард үлдлээ. Тэмцээн бол хэн нэгэн чамд цохилт өгөх туйлын боломжтой газар юм. Нүдээ нээлттэй байлгаж эргэн

тойрондоо төвлөрөн асуудалд орохгүй байхыг хичээгээрэй. Болгоомжтой бай. Урьдын адил ер бусын зүйл болвол надад бичээрэй.

Сириус.

- Яг л Грюм шиг гэж Харри аяархан хэлээд захиаг дотуур халаасандаа шургуулав.
- Нүдээ нээлттэй байлга! Би нүдээ аниад хана мөргөх гээд байгаа юм байх даа...
- Түүний зөв, Харри. Чиний урд хоёр сорилт байна. Өндөгний тааврыг таах хэрэгтэй гэж Гермiona хэлэв.
- Түүнд цаг бий шүү дээ! Алив, Харри шатар тоглоцгооё гэж Рон хэллээ.
- Тоглоё гэж Харри зөвшөөрөөд Гермiona руу харан,
- Боль доо, Гермiona. Ийм чимээ шуугиантай байхад төвлөрч чадна гэж үү? Тэр ч байтугай өндгөн доторх орилоон сонсогдохгүй гэлээ.
- Чиний зөв байх гэж Гермiona санаа алдан хэлээд араас нь дагав.

Зул сарын өглөө Харри яг л хэн нэгэн сэрээсэн аятай сэржээ. Тэр нүдээ нээтэл харанхуйд дугуй том ногоон нүд хамар тулах шахам ширтэж байлаа.

- Добби! Ахиж битгий ингээрэй! гэж Харри дуу алдав.
- Доббиг өршөөгөөрэй, ноёнтоон гэж үйлчлэгч буруутай дуугараад хойшоо огло үсрэн уруулаа нарийхан хуруугаараа амаа дарлаа.
- Добби ердөө Харри Поттерт зул сарын мэнд хүргэж бэлэг өгөхөөр ирсэн юм, ноёнтоон! Добби Харри Поттерийг айлгахыг хүсээгүй. Харри Поттер, Доббиг ирж болно гэсэн шүү дээ ноёнтоон.
- Болно, Добби. Дараагийн удаа намайг сэрээхдээ ширтэх биш зүгээр л түлхээрэй. Бас ийм ойрхон хамраа шүргэх шахам битгий бөхийгөөрэй гээд хүндээр амьсгаадах нь хэвээр байсан ч зүрхний нь цохилт нь намдлаа.

Харри хөшгөө түлхэн босож суугаад ширээн дээрээс нүдний шилээ авч зүүлээ. Түүний дуу Рон, Симус, Дин, Невилл нарыг сэрээжээ. Тэд хөнжлөө яран сэгсгэр үстэй толгойгоо цухуйлгав.

- Хэн нэгэн чам руу дайраа юу? гэж Симус нойрмог бувтнав.
- Зүгээр дээ, Добби л байна. Унт гэж Харри хэлэв.
- Бэлэг авчраа юу гээд Симус орны хөлд овоолоостой байгаа хайрцагыг харлаа.

Рон, Дин, Невилл нар хэдийн сэрээд бэлгээ задлахаар яарав. Харри Добби руу эргэж харлаа. Тэр орны дэргэд нь зогсоод айлгасан явдалдаа гэмшингүй толгойгоо унжуулж байв. Үйлчлэгчийн толгойд байгаа данхны зурагтай малгай гацуурын мөчирт өлгөсөн тоглоом шиг санагдана.

- Добби, Харри Поттерт бэлэг өгч болох уу? гэж тэр хулчгардуухан асуув.
- Тэгэлгүй яахав. Надад ч гэсэн чамд өгөх юм бий.

Харри худал хэлжээ. Тэр Доббид юу ч аваагүй байсан ч чемоданаа онгойлгон Вернон ахын бөөрөнхийлсөн хуучин шар оймсыг гаргаж ирлээ. Харри түүн дотор вредноскопоо хийсэн билээ. Тэр вредноскопоо авч оймсоо Доббид өгөөд,

- Зул сарын мэнд, Добби. Уучлаарай, би баглахаа мартчихаж гэв.

Добби баясан гийв.

- Оймс бол Доббийн дуртай хувцас, ноёнтоон! гээд хоёр янзын оймстой хөлөө өргөн харуулав.

- Доббид долоон ширхэг оймс байгаа, ноёнтоон... Гэхдээ ноёнтоон, дэлгүүрийн худалдагч андуурсан байх тэр Харри Поттерт адил өнгийн оймс өгсөн! гээд тэр том нүдээрээ шортоо хүртэл татсан оймсоо харлаа.

- Юу гэж дээ, Харри үүнийг тооно гэж үү? хэмээн Рон нүдээ ирмэв. Тэр орон дээрээ янз бүрийн цаастай бэлэгнүүд тавьжээ.

- Нааш ир, Добби үүнийг чамд. Хоёр ширхэг оймс байгаа холиод өмсөнө биз. Бас энэ шинэ цамц.

Тэрбээр Доббид нил ягаан хос оймс, хатагтай Уизлийн нэхсэн цамц сунгалаа.

Добби өгөөмөр занд гайхан бахаджээ.

- Та ямар сайхан сэтгэлтэй юм бэ, ноёнтоон. Добби ноёнтоныг гайхамшигтай шидтэн гэж мэдлээ. Та Харри Поттерын сайн найз болохоор өгөөмөр уужим сэтгэлтэй юм... гэж хэлээд газар шүргэх шахам Ронд мэхийн ёслол.

- Яалаа гэж дээ, Добби энэ чинь ердөө оймс шүү дээ гээд Роны чих улайлаа. Гэсэн ч тэр сэтгэл хангалуун байв.

- Хөөх, Харри! гээд тэр Харригийн өгсөн <<Пушкийн Педдл>> багийн малгайг аваад,

- Янзтай! хэмээн толгойдоо өмслөө.

Харин тэр үед Добби Харрид жижигхэн бэлэг өгөв. Харри түүнийг задалтал бас оймс байлаа.

- Добби түүнийг өөрөө нэхсэн юм, ноёнтоон. Добби ажилласан мөнгөөрөө утас худалдаж авсан юм гэж аз жаргалдаа автсан үйлчлэгч баяртайгаар мэдэгдэв.

Зүүн талын оймсон дээр хурц улаан өнгөтэй шүүр байхад, баруун талынх дээр нь ногоон өнгийн алтан снитч байлаа.

- Ямар гоё юм бэ! Их баярлалаа, Добби гээд Харри оймсыг өмсөхөд үйлчлэгчийн нүдэнд нулимс мэлтрэв.

- Добби явах боллоо, ноёнтоон. Бид зул сарын зоог бэлтгэж байгаа юм гээд үйлчлэгч бүгдтэй салах ёс гүйцэтгэн гар даллаад гал зуух руу яарлаа.

Харри үлдсэн бэлгээ харав. Тэнд Доббийн өөрийн гараар хийсэн бэлэгний хажууд даруухан харагдах ердийн цаасан хайрцагтай амны цаас байлаа. Дурслийн бэлэг байж таарна. Тэд ах дүү Уизлийн чихрийн тухай мартаагүй байгаа нь илт. Гермiona

Харрид <<Британи болон Ирландын квиддичийн багуудын тухай>> гэдэг ном бэлэглэсэн бол Рон том хайрцагтай шивхэн бөмбөг бэлэглэжээ. Сириус агшин зуур бүх цоож онгойлгодог тонгорог бэлэглэж, Хагрид том хайрцагтай Харрийн дуртай амттан болох янз бүрийн амттай Берти боттс үрэл, шоколадан мэлхий, Друблсийн хамгийн сайн тэсэрдэг бохь зэргийг явуулжээ. Хатагтай Уизли ээлжит цамц болон (Цээжин дээрээ ногоон луутай. Чарли л түүнд лууны тухай хэлсэн байж таарна) том хайрцагтай гэрийн амттан явуулсан байлаа.

Рон, Харри хоёр бэлгээ далд хийгээд Гермionatoй цайндаа орохоор явлаа.

Эргэж ирээд амралтын өрөөнд үд хүртэл бэлгээ сонирхоцгоож Их танхимд болсон сүр жавхлантай үдийн хоолонд орцгоолоо. Ширээ шарсан цацагт хяруул, бялуу болон том цаасан бугаар дүүрчээ.

Тэднийг үдээс хойш гадаа гарахад өтгөн хунгарласан цасан дундуур Дурмстрангын хөлөг онгоц болон Шармбатоны сүйх тэрэг рүү очих зам үүссэн харагдана. Харри болон ах дүү Уизли нар цасаар байлдахад Гермiona тэмцлийг гаднаас нь харахыг илүүд үзэж таван цагийн алдад бүжигт үдэшлэгт бэлтгэхээр шилтгээн рүү буцав.

- Чамд бэлтгэхэд гурван цаг хэрэгтэй юм уу? гэж Рон үл итгэсэн байртай хэлтэл шанд нь Жорж шилэн хүзүү рүү нь том цасаар онов.

- Чи хэнтэй явах гэж байгаа юм бэ? гэж Рон Гермionaгийн араас орилсон ч тэр гар зөвхөн даллаад чулуун шатаар гүйн шилтгээний хаалгаар орлоо.

Бүжигт үдэшлэгт цайллага багтсан болохоор өнөөдөр зул сарын зоог болсонгүй. Долоон цагт харанхуй болоход бүгд нүд гялбам цасан дээгүүр шилтгээн рүү гүйцгээв. Тарган хатагтай Виолетатай хөжгилтэй ярилцах агаад хөлдөө ликёр дарсны хоосон шил тавьсан харагдана.

- Шидэт дагина гэж хөвгүүд нууц үгээ хэлэв.

- Тиймээ үнэн гэж тарган хатагтай хөхрөөд тэднийг дотогш оруулав.

Харри, Рон Симус, Невилл нар унтлагын өрөөндөө ёслолын хувцасаа сольж өмсөхдөө бүгд зовонгуйрсан харагдана. Ялангуяа Рон толины урд хиртхийсэн байдалтай эргэлдэж байв. Жанч биш охидын даашинз гэсэн үг! Рон шийдвэр гарган эрчүүдийнх шиг харагдуулахын тулд таслах шидээр том зах ханцуйвч хоёроо авч хаялаа. Бараг юу ч болоогүй гэж хэлж болохгүй ч зах ханцуйных нь нэхсэн тор алга болж оронд нь унтлагын өрөөнд зодоон болсон аятай хөвөрсөн утас үлджээ.

- Та нар хамгийн сайхан охид гэдгийг ойлгох юм алга! гэж Дин дуу алдаад мөрөө хавчлаа.

- Амьтны соронзон гэж Рон бувтнаад захнаасаа цухуйсан утсыг татлаа.

Гриффиндорын зочны өрөө янз бүрийн өнгийн хувцастай үдэшлэгийн оролцогчдоор дүүрчээ. Ихэнхи нь ердийн хар жанчтай байлаа. Парвати шатан дээр Харриг хүлээж зогсов. Парвати их хөөрхөн харагдаж байсан бөгөөд ягаан өнгийн даашинз өмсөж, урт хар үсээ сүлжээд алтан туузаар зангидаж, гялалзсан алтан бугуйвч зүүжээ. Харри

түүний жанчыг хараад Парвати инээгээгүйд санаа амарчээ. Тэрбээр ямар нэг юм хэлэхийг оролдоод эв хавгүйхэн,

- Чи... э-э... сайхан харагдаж байна гэлээ.
- Баярлалаа гэж Парвати талархаад Ронд хандан,
- Падма чамайг үүдний танхимд хүлээж байгаа гэлээ.
- За гэж Рон толгой дохиод ийш тийшээ харан,
- Гермiona хаа байна? гэлээ.

Парвати мөрөө хавчлаа.

- За явцгаах уу, Харри?
- Явъя гэж Харри хэлээд хаашаа ч явахыг хүсэхгүй байсандаа санаа алджээ. Амралтын өрөөнд Фред орж ирээд хөгжилтэй нүд ирмэв.

Үүдний танхимд сурагчид цуглан найман цагаас Их танхимын хаалга нээгдэхийг хүлээнэ. Олонхи хүмүүс хосоо өөр тэнхимээс сонгосон бөгөөд цугласан хүмүүс дундаас бие биеэ хайх аж. Парвати эгч Падмагаа олоод Рон, Харри хоёртой танилцуулав.

- Сайн уу гээд Падма толгой дохив. Тэр Парватигийн адил хөөрхөн бөгөөд оюу өнгөтэй жанч өмсчээ. Падма Роны жанчны сэмэрсэн зах, ханцуйг гүйлгэн харав.
- Сайн уу гэж Рон баргар царайлан хэлээд Падма руу харалгүй цугласан хүмүүс рүү харснаа,
- Өө үгүй ээ... гэлээ.

Дэргэдүүр нь Флер Делакур өнгөрөхийг ажиглангуутаа Рон Харригийн нурууны ард нуугдлаа. Флер Когтевраны багийн ахлагч Рожер Девисийн зүг чиглэв. Тэр мөнгөлөг саарал атлаасан даашинз өмссөн нь маш сайхан харагдаж байлаа. Тэднийг хажуугаар өнгөрөхийг хүлээж байгаад Рон найзынхаа нурууны ардаас толгойгоо өндийлгөв.

- Гермiona хаа байна? гэж тэр ахиад л асуув.

Газар дорхи амралтын өрөөнөөс Слизеринийхэн гарч ирэв. Урд нь өндөр захтай хар хилэн жанч өмссөн Малфой алхана. <<Амбан сайдтай адилхан болж>> гэж Харри бодлоо. Малфой хуниасаар чимэглэсэн цайвар ягаан өнгийн даашинзтай Пэнси Паркинсинтой сугадсан байлаа. Крэбб, Гойл хоёр ногоон хувцас өмссөн нь хөвдтэй үхэр чулууг санагдуулах агаад хамтрагчаа хайцгаав.

Хүнд царсан үүд чахран нээгдэхэд түүгээр профессор Каркаров тэргүүтэй Дурмстрангын зочид орж ирэв. Түүний ард Крам үл таних цэнхэр даашинзтай үзэсгэлэнтэй охинтой явж байлаа. Хаалга хаагдахаас урд Харри шилтгээний урд талын нуга дээр сарнайн бут голдоо өвлийн өвгөний буга бүхий хөшөөтэй агуй бий болсныг ажиглав. Сарнайн бут хөшөөн дээгүүр янз бүрийн өнгийн бяцхан амьд дагинас нисэлдэнэ.

- Тэмцээний оролцогчид наашаа гэх профессор МакГонагаллын дуу гарав.

Парвати баясан гийж туузаа засав. <<Удахгүй уулзъя>> гээд тэр найзууддаа даллаад хуваагдсан олны дундуур МакГонагаллын заасан зүг руу очлоо. Профессор дөрвөлжин хээтэй улаан шотланд жанч өмсөж цэцгээр хөвөөлсөн бүрх малгай тавьжээ. Тэр аваргуудад энд хүлээж байгаад танхим руу хосоороо ёслолын байдалтай гараад бусад нь хүлээж байгаа ширээний ард суух ёстой гэдгийг тайлбарлав.

Флер Делакур Рожер Дэвисийн хамтаар хамгийн түрүүнд зогсов. Дэвис түүний хос болсон зол завшаандаа итгэхгүй байгаа мэт Флерийн гоо сайхнаас нүд салгахгүй байлаа. Седрик, Чжоу хоёр ойртон ирэхэд Харри буруу харжээ. Тэр тэдэнтэй ярихыг хүссэнгүй. Тэгтэл Крамын хамт зогсож байгаа охин дээр нүд тусахад гайхсандаа амаа ангайлаа.

Энэ бол Гермиона байв!

Зөвхөн шал өөр болжээ. Өтгөн үс нь гялалзах агаад толгой дээрээ дэгжин овоолжээ. Тэр тэнгэрийн цэнхэр өнгөтэй даашинз өмсөж мөрөө цэхлэн зогсоно. Тэр догдолсон байртай инээмсэглэхэд үүдэн шүд нь үнэхээр багассан байлаа. Тэр яагаад үүнийг шууд ажиглаагүй юм бол?

- Сайн уу, Харри! Сайн уу, Парвати! гэж Гермиона даллав.

Парвати Гермиона руу нүдэндээ итгэхгүй шахам ширтээд таагүйхэн уруулаа жимийв. Зөвхөн тэр тийм байсангүй. Их танхимын үүд нээгдэхэд цугласан олон орцгоов. Крамын номын санд дагадаг шүтэн бишрэгчид нь Гермионаг алахад бэлэн байх шиг санагдана. Пэнси Паркинсон нүдээ бүлтийлгэн, Малфой гайхсандаа чимээгүйхэн хараалаа. Зөвхөн Рон л Гермионаг харалгүй өнгөрөв.

Эцэст нь бүгд байрандаа суухад МакГонагалл аваргууд хосоороо эгнээ болж түүнийг дагалдахыг зааварлав. Тэднийг ороход Их танхим даяар алга ташиж профессор МакГонагалл шүүгчдийн сууж байгаа том дугуй ширээ рүү хүргэж ирэв.

Танхимын хана мөнгөн хяруугаар очтон гялалзаж зуугаад цагаан боронзон цэцгийн хэлхээг одод түгсэн адраас өлгөжээ. Хоолны урт ширээнүүд алга болж оронд нь тус бүрд нь арван хүн суух зуугаад ширээ бий болжээ. Ширээ болгон дээр дэнлүү асч байлаа.

Харри явахдаа бүгдийн нүдэн дээр бүдэрчихгүйг хичээв. Харин бүгдийн анхаарлыг татаж байгаадаа аз жаргалдаа автсан Парвати Харриг урагшаа хүчтэй чирэхэд түүнд эзэндээ хөтлөгдсөн нохой аятай сэтгэгдэл төржээ. Харри шүүгчдийн ширээнээс холгүйхэн Падма, Рон хоёрыг харлаа. Падма дүнсгэр царайлан суух агаад, Рон Гермиона руу нүд салгалгүй ширтэж харагдана.

Дамблдор тэргүүтэй шүүгчийн ширээнийхэн хосуудыг гэрэлтсэн инээмсэглэлээр хүлээж авав. Каркаров Крамыг Гермионатай байхыг хараад Роны адил таагүйхэн харлаа. Шаргал ододоор чимэглэсэн улаан жанчтай Людо Бэгмен сурагчдын хамт чанга урам зоригтой алга ташлаа. Ердийн хар атлаасан даашинзаа цайвар ягаан өнгийн торгон даашинзаар сольсон хатагтай Максим эелдэгээр алга ташив. Зөвхөн ноён Крауч л байсангүй. Түүний оронд шүүгчийн ширээнд хар хөх өнгийн жанч

өмссөн Перси албархуу сууж байлаа. Үлдсэн суудал тэмцээний оролцогч болон хатагтай нарт нь оногджээ.

Аваргуудыг ширээнд ойртон очиход Перси Харри руу учиртай хараад хажуугийн сандал руу үл мэдэгхэн дохив. Харри дохиог ойлгоод дэргэд нь суулаа. Түүнийг ам нээж амжаагүй байтал Перси баяртайгаар шинэ мэдээ дуулгав.

- Намайг тушаал дэвшүүлсэн. Би ноён Краучын ойрын туслах болохоор түүнийг үдэшлэг дээр төлөөлж байгаа юм.

- Тэр яагаад өөрөө ирээгүй юм бол? гэж үдшийн турш тогооны ёроолын тухай ээлжит лекцээ сонсохыг хүсээгүй Харри асуулаа.

- Ноён Краучыг хүнд өвдсөн гэж айж байна. Түүний эрүүл мэнд Дэлхийн цомын тэмцээнээс хойш муу байгаа юм. Хэт их ажилласан болохоор гайхах зүйлгүй дээ. Жил ч болоогүй байхад сэргээд ирнэ. Агуу хүн шүү! Гэхдээ яамныхан Дэлхийн цомын тэмцээн дээр бүтэлгүйтсэн явдал болон гэрийн үйлчлэгч Винки нь түүнийг сэтгэлээр их унагасан даа. Ноён Крауч түүнийг хөөгөөд туслагчгүй үлдсэн... түүний насан дээр ямар хэцүү байгааг ойлгож байгаа биз дээ. Тэгтэл Дэлхийн цомын дараа энэ тэмцээнийг зохион байгуулах гээд бас энэ Скитер Түргэн бичигч үзэгтэйгээ... Тэр хөөрхий амьтан зул сараар гэртээ чимээгүй байгаа байх даа. Би түүний оронд тавих боломжтой хүн болсондоо баяртай байна.

Харри ноён Крауч яагаад түүнийг Уизерби гэж нэрлэдгийг асуух гэснээ болилоо.

Гялалзсан алтан тавагны хажууд жижиг цэс тавиастай байх бөгөөд хоосон байлаа. Харри шийдэмгий бус эргэн тойрноо харлаа. Үйлчлэгч байсангүй. Дамблдор цэсийг анхааралтай судалж байснаа таваг руугаа харан <<Гахайн котлет>> гэв!

Тавган дээр даруй шарсан гахайн мах бий боллоо. Тэгтэл бүгд юу хийхээ ухаарч цэсээ авахад алтан таваг хоолоор дүүрэв. Харри Гермiona руу сонирхон харлаа. Түүний үйлчлэгчийн нэмэлт хөдөлмөр зовоох болов уу? Гэхдээ Гермiona үйлчлэгчийн тухай мартсан байв. Тэр Виктор Крамтай хөөрөх зуур юу идэж байгаагаа анзаарсангүй.

Харри урьд нь Крамын ярьж байхыг сонсож байсангүй. Тэр үргэлж чимээгүй байдаг атал харин одоо урам зоригтойгоор ярих аж.

- Бидэнд бас шилтгээн байгаа ч ийм том биш ердөө дөрвөн давхар. Гэхдээ их тухтай бөгөөд шидэт гал асаж байдаг юм. Манай газар нутаг эндэхээс том илүү үзэсгэлэнтэй ч өвлийн өдөр богинохон шөнө урт. Бид зун нуур болон уулан дээгүүр нисдэг юм...

- Хөөе, Виктор цааш нь яриад хэрэггүй чиний дур булаам найз чинь биднийг олоод ирж магадгүй гэж Каркаров инээн хэлсэн ч нүд нь хүйтэн байлаа.

Дамблдор инээхэд нүд нь гялалзлаа.

- Игорь чиний хувьд бүгд нууц байх юм даа. Чамайг зочдод дуртай биш гэж бодоход хүрч байна шүү.

- Бид бүгд Дамблдор эзэмшлээ хамгаалдаггүй гэж үү? Бүгд сургуулийн нууцаа мэддэгээрээ болон түүнийг хамгаалдагаараа бахархдаггүй гэж үү? хэмээн Каркаров шар шүдээ ярзайлган хэлэв.

- Харин миний хувьд Игорь, Хогвартсын бүх нууцыг мэддэг гэж батлахгүй. Би өнөө өглөө угаалгын өрөө орохоор явах замдаа шатны хажууд гайхамшигтай үл таних өрөө нээгдсэнийг харлаа. Намайг сайн харахын зуургүй өрөө алга болчихсон. Би мэдээж түүнийг олж чадна л даа. Магадгүй тэр зөвхөн өглөөний тав хагаст юмуу сарын арван таванд нээгддэг байж болох юм .

Харри тавагтай гуляш руугаа тургичихлаа. Перси хөмсөг зангидаж Дамблдор түүн рүү нүд ирмэв.

Тэр үед Флер Делакур өөрийн хосдоо Хогвартсын гоёл чимэглэлийг шүүжлэн ярих аж.

- Энэ юу ч биш! гээд тэр Их танхимын гялалзсан ханыг үл тоомсорлон харлаа.

- Бидэнд мөсөн барималтай ордон бий. Тэд хайлдаггүй бөгөөд очир алмааз адил гялтагнаж байдаг юм. Харин манай хоол ямар тансаг гээч! Биднийг идэхэд тэд дуулдаг юм! Танхимд ямар ч аймшигтай толгойгүй рыцарь байхгүй. Шармбатоны хий үзэгдэл яг ингэж тасхийгээд! гээд Флер алгаа хүчтэй ташив.

Рожер Дэвис Флерийн гоо үзэсгэлэнг алмайран ширтэнэ. Түүний бишрэлт хүчтэй байсан болохоор сонсох зуураа амнаасаа сэрээгээ авсангүй.

- Яг зөв! Тиймээ! Ингээд л гээд тэр Флерийн адил алгаа ташив.

Харри танхим руу харав. Хагрид багш нарын ширээнд суугаад тэдний зүг харна. Тэр аймшигтай үслэг хүрэн костюм өмсчээ. Тэр хатагтай Максим үл мэдэг даллахад тэрбээр хариу даллан лааны гэрэлд опал гялсхийв.

Гермиона Крамыг нэрийг нь зөв хэлэхэд сургаж байв. Тэр түүнийг <<Геримона>> гэж байв.

- Герм-ми-о-на гэж гэж тэр удаанаар хэлэв.

- Герм-ивонна гэж Крам давтлаа.

- Арай дээрдэж байна гэж Гермиона магтаад Харриг харж инээмсэглэв.

Хоолны дараа Дамблдор босож бүгдийг түүний жишээг дагалдахыг урив. Тэр шидэт саваагаа даллахад ширээнүүд хана руу шахагдан хоосон зай үүслээ. Ахин нэг даллахад баруун талын хананд тайз үүсэж бөмбөр, гитар, пийпаа, цуур зэрэг хөгжмийн зэмсэг бий болов.

Эмгэн шулам хамтлагийг хүмүүс хөөрөн алга ташиж угтав. Тэд урт үстэй хар жанч өмссөн аж. Харри тэднийг тоглохыг хүлээж байгаад үүний дараа юу болсныг мартсан байлаа. Гэнэтхэн ширээн дээрх дэнлүү бөхөж аваргууд хосынхоо хамт байрнаасаа бослоо.

- Явцгаая! Одоо бид бүжиглэнэ! гэж Парвати шивнэлээ.

Харри жанчиндаа бүдчин босож зогсов. Эмгэн шуламнууд гунигтай удаан аялгуу тоглолоо. Тэр танхимын гол дахь хурц гэрэлтэй бүжгийн талбай руу алхан гарахдаа хүмүүсийн харцнаас зугтахыг хичээв (тэр нүднийхээ булангаар Симус, Дин хоёр түүн рүү инээдээ барьж ядан даллахыг харжээ). Парвати түүнийг хоёр гарыг шийдэмгий авч нэгийг нь бүсэлхийн дээрээ тавин нөгөөдхийг чанга атгав.

<<Тийм ч муу биш юм>> гэж Харри яаралгүйхэн эргэлдэхдээ бодов (Парвати удирдаж байв). Харри эргэн тойрноо дахин харахад үзэгчид хос болон хуваагдаж бүжиглэж байсан болохоор олон арван харц мэдэрсэнгүй. Түүний хажууд Невилл Жинни хоёр бүжиглэж байв. Невилл хөлөн дээр нь гишгэхэд Жинни ярвайлаа. Дамблдор хатагтай Максимтай вальс эргэлдэнэ. Тэр түүнээс яльгүй өндөр агаад эрүү нь малгайны оройтой нь дүйцэж байсан ч хатагтай Максим эвлэгхэнээр бүжиглэж байв. Хурц нүдэт Грюм эв хавгүйхэн профессор Синистратай эргэлдэх аж.

- Дажгүй оймс байна, Поттер гэж Грюм сөөнгөтөхөд шидэт нүд нь Харригийн жанчыг өрөмдөн харав.

- Добби үйлчлэгч надад зориулан нэхсэн юм гэж Харри инээмсэглэн хэллээ.

- Тэр ямар аймшигтай юм бэ! Минийхээр бол шидэт нүдийг нь хориглох хэрэгтэй гэж Парвати Харрийн чихэнд шивнэлээ. Грюмын модон хөл алсалж холдсон болохоор түүний үгийг сонссонгүй.

Харри цуур чичирхийлэн төгсгөлийн ая тоглохыг сонсоод санаа амарлаа. Бүгд алга ташихад Харри агшин зуур Парватигийн тэврэлтээс мултрав.

- Явж суух уу? гэж тэр асуулаа.

Эмгэн шулам хөгжилтэй түргэн ая тоглож эхлэв.

- Үгүй ээ, алив бүжиглэе л дээ. Надад энэ ая таалагдаж байна! гэж Парвати эсэргүүцэв.

- Харин надад үгүй гэж Харри худал хэлээд Парватиг хөтлөн бүжгийн талбайгаас гарч Фред, Анжелина хоёрын дэргэдүүр өнгөрөөд Рон, Падма хоёрын ширээнд суулаа.

- Үдэшлэг ямаршуу байна даа? гээд Харри асуугаад цөцгийтэй шар айрагны бөглөө онгойлгов.

Рон хариулсангүй. Тэр холгүйхэн бүжиглэж байгаа Рон, Крам хоёр руу муухай харна. Падма гараа зөрүүлэн суугаад ачсан хөлөө хөгжмийн аяар хөдөлгөх зуур түүний байгааг мартсан Рон руу зэвүүцэн харна. Парвати Харрийн хажууд эгчийнхээ адил суутал Шармбатоны сурагч ирж бүжигт урив.

- Харри, чи татгалзахгүй биз дээ? гэж Парвати асуув.

- Юу? гэж Чжоу Седрик хоёрыг ширтэж байсан Харри асуулаа.

- Юу ч биш гээд Парвати бүжиглэхээр бослоо. Ая төгссөн ч тэр эргэж ирсэнгүй.

Бүжгэндээ халууцаж улайсан Гермiona Парватигийн сандалд ирж суув.

- Сайн уу гэж Харри хэлэв. Рон юу ч хэлсэнгүй.

- Ямар халуун юм бэ. Виктор уух юманд явсан гэж Гермiona гараараа сэвэнгээ хэлэв.

Рон түүн рүү хяламхийн харав.

- Хэдийн Виктор болчихсон уу? Харин тэр Вики хэмээн дууд гэж гуйхгүй байна уу?

- Чи яагаа вэ? гээд Гермина гайхан хөмсгөө өргөв.

- Ойлгохгүй байна уу? гэж Рон зэвүүцэнгүй хэлэв.

Гермiona Харри руу харахад мөрөө хавчлаа.

- Рон, юу...?

- Тэр Дурмстрангых! Тэр Харригийн өрсөлдөгч! Бас манай сургуулийн! Харин чи... чи... дайсантайгаа нөхөрлөсөн... ийм л байна гэж Рон хэлэв.

Гермiona гайхсандаа амаа ангайжээ.

- Ямар тэнэг юм бэ! гэж тэр эцэст нь хэлээд,

- Дайсан гэнээ! Харин хэн Викторыг ирэхэд баярлан дэвхцээд байлаа? Хэн түүний гарын үсгийг авахыг хүсээд байлаа? Хэн түүнийг унтлагын өрөөндөө унтуулах гээд байлаа? гэлээ.

Рон энэ бүх зэмлэлийг чихнийхээ хажуугаар өнгөрүүлэв.

- Тэр чамайг номын санд урьсан уу?

- Тиймээ. Тэгээд юу гэж? гээд Герминагийн хацар бас улайлаа.

- Чи түүнийг хараад бөөлжис цутгадаг чинь яасан?

- Үгүй шүү. Би тэгээгүй! Хэрвээ мэдэхийг хүсч байвал тэр өдөр болгон надтай ярихын тулд номын санд орохыг хүсдэг байсан гэсэн. Тэгээд зүрхэлж чадаагүй байна. Тэр надад өөрөө үүнийг хэлсэн юм гэж Гермина нэг амьсгаагаар хэлээд Парватигийн дашинз шиг улаан болов.

- Наадах чинь л байгаа юм гэж гэж Рон егөөдөнгүй хэлэв.

- Энэ чинь юу гэсэн үг юм?

- Ойлгомжтой. Тэр Каркаровын сургуульд сурдаг биз дээ? Чи хэнтэй найзалж байгаагаа мэдэж байна уу... Түүнд зөвхөн Харригийн тухай мэдээлэл өгөх хүн хэрэгтэй...

Гермiona Рон түүнийг алгадсан аятай хараад,

- Тэр надаас Харрийн тухай хэзээ ч асууж байгаагүй гэж чичирсэн хоолойгоор хэлэв.

Тэгтэл Роны дайралт өөр зүг рүү шилжлээ.

- Тэгвэл түүнд өндөгний нууцыг тайлахад чиний тусламж хэрэгтэй болсон байна. Та нар хамтдаа хэрхэн номын санд сууж байгааг төсөөлж байна...

- Би хэзээ ч түүнд өндөгний нууцыг тайлахад туслахгүй! Сонсов уу? Хэзээ ч! Чи яаж ингэж ярьж зүрхэлж байна! Би Харриг ялаасай гэж хүсч байна. Тэр үүнийг мэдэж байгаа тийм биз дээ, Харри? гэж Гермиона хилэгнэлээ.

- Үүнийгээ маш хөгжилтэйгээр үзүүлж байна гээд Рон инээд алдав.

- Энэ тэмцээн ямар зорилготой юм бэ? Янз бүрийн орны шидтэнгүүдийг нөхөрлүүлэхийн тулд биз дээ! хэмээн Гермиона дүрсхийв.

- Тийм биш! Тэмцээний гол зорилго бол ялах явдал!

Рон, Гермиона хоёр чанга хашгиралдсан болохоор эргэн тойрны хүмүүс тэдэн рүү харав.

- Сонсооч, Рон. Гермиона бүжигт Крамтай явж байгаа нь намайг ерөөсөө түгшээхгүй байна гэж Харри тайтгаруулах санаатай хэлэв.

Гэсэн ч Рон зогссонгүй.

- Чи яагаад явж Викигээ хайхгүй байгаа юм бэ. Тэр чамайг хаана байгааг гайхаж байгаа даа.

- Түүнийг битгий Вики гэж дууд! гээд Гермиона үсрэн босож бүжиглэж буй хүмүүсийн дундуур гүйн одлоо.

Рон түүний араас дагуулан харахад царайд нь уур хилэнээс гадна сэтгэл ханамж тодров.

- Чи намайг бүжигт урихгүй юм уу? гэж Падма асуулаа.

- Үгүй гэж Рон хэлээд Гермионагийн араас харав.

- За яахав, сайн байна гээд Падма босож дүү рүүгээ очоод мөн адил францын хамтрагч олов. Харрид түүний хамтрагч Татдаг шившлэгээр дуудчихсан аятай түргэн бий болсон санагджээ.

- Герм-ивонна хаа байна? гэх дуу сонсогдов.

Крам тэдний ширээний хажууд хоёр аяга цөцгийтэй шар айраг бариад зогсож байв.

- Мэдэхийг ч хүсэхгүй байна. Гермивонагаа алдчихаа юу? гэж Рон муухай харан хэлэв.

Крамын царай барайлаа.

- Түүнийг харах юм бол би түүнд уух юм авсан гээрэй гээд тэр явчихлаа.

Тэгтэл цацагт хяруул шиг албархуу Перси ирээд,

- Ямар сайхан юм бэ! Рон чи Виктор Крамтай найз юм уу? Энэ чинь л олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтсийн зорилго шүү дээ гэж гараа үрчин хэлэв.

Харриг гомдоон Перси дэргэдэх сул сандал дээр нь суулаа. Шүүгчдийн ширээ хоосорчээ. Дамблдор ургамал судлалын багш хатагтай Стебльтэй бүжиглэн, Людо Бэгмен МакГонагаллыг урьж, хатагтай Максим Хагридтай ойртохын аргагүй

галзуурсан хурднаар вальс эргэлдэж байлаа. Зөвхөн Каркаров л бүжиглэсэнгүй хаа нэг тийшээ алга болжээ. Ээлжит бүжиг дуусахад бүгд ахин алга ташив. Людо Бэгмен профессор МагГонагаллын гарыг үнсэж ширээ рүү очиход тэнд түүнийг Фред, Жорж хоёр хүлээж байв.

- Тэд яаж байна? Яаж яамны ахмад ажилтанд хандаж зүрхэлж байна! Ямар ч хүндэтгэл байхгүй! гэж Перси хөмсөг зангидан дүү нар луугаа сэжигтэй харж хэлэв.

Бэгмен ихрүүдээс түргэн салж Харри руу гар даллаад ойртов.

- Миний дүү нар таньд саад болоогүй гэж найдаж болох уу, ноён Бэгмен? гэж Перси даруйхан асуулаа.

- Юу гэнээ? Үгүй дээ, үгүй? Тэд надад хуурамч савааны тухай ярьж зах зээлд хэрхэн нийлүүлэх тухай зөвөлгөө авсан юм. Би тэдэнд Зонкогийн дэлгүүртэй холбоо тогтооход нь тусална гэж амалсан.

Перси сэтгэлээр ихэд унав бололтой. Гэртээ хариад шууд ээждээ гомдоллох байх даа гэж Харри бодов. Фред, Жорж хоёрын гайхамшигтай сайхан төлөвлөгөө бол дэлгүүрт өөрсдийн хийсэн бүтээлээ зарах билээ.

Бэгмен Харри руу харан ам нээтэл Перси түүнийг зогсоон,

- Таныхаар бол тэмцээн ямар болох бол ноён Бэгмен? Манай хэлтэс Галт цомд болсон үл ялиг саадыг эс тооцвол сэтгэл хангалуун байгаа. Жаахан азгүй явдал болсон ч дараа нь бүгд хэвийн болсон доо гээд Харри руу харлаа.

- Тэгэлгүй яахав. Бүгд сэтгэл хангалуун байнаа. Хөгшин Барти ирээгүй нь харамсалтай байна. Тэр хэр байна даа? гэж Бэгмен гэрэлтэн асуув.

- Ноён Краучын бие ойрын хугацаанд засрана гэдэгт би итгэлгүй байна. Түүний үүргийг хүлээн авсандаа би хичнээн их баяртай байна гээч. Зөвхөн үдэшлэгт оролцох төдий ч биш... Түүнийг байхгүйд хичнээн их ажил ундарсан гээч. Та сонссон л байлгүй Али Башир хууль бусаар нисдэг хивс оруулж байгаад баригдсан. Одоо бид Трансильвануудтай олон улсын хориг тавих тухай хэлэлцэж байна. Би жилийн эхэнд тэдний олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн даргатай нь уулзах юм... гэж Перси чухалчлан хэлэв.

- Явж зугаалъя. Персигээс холдоё гэж Рон Харрид шивнэлээ.

Тэд юм уухыг хүссэн дүр үзүүлэн босоод бүжиглэж байгаа хүмүүсийн дундуур явж танхимаас гарлаа. Үүдний хаалга нээгдэхэд сарнайн бутан дээгүүр дагниас нисэлдэнэ. Хөвгүүд шатаар буугаад агуйд ороход бутан дундуур тахиралдсан зам одож том чулуун хөшөөнүүд үзэгдэв. Хаа нэгтээ ус цалгилах чимээ сонсогдох нь усан оргилуур байгааг бололтой. Эндхийн сийлбэртэй сандал дээр сурагчид бүжгийн дараа суугаад амарч байв. Харри, Рон хоёр сарнайн бутан дундуур тохойрсон замаар цэцэрлэгийн гүн рүү ортол удалгүй танил таагүй хоолой сонслоо.

- ...ямар ч түгших шалтгаан олж харахгүй байна, Игорьь.

- Чи яаж юу ч болоогүй юм шиг дүр үзүүлж чадаж байна, Северус. Сүүлийн хэдэн сар болсон үйл явдал намайг түгшээж байгааг нуухгүй гэж Каркаров сэтгэл зовсон байртай дуугаа намсган хэлэв.

- Тэгвэл зугт. Зугт... би чиний зугтсаныг тайлбарлачихна. Миний хувьд бол Хогвартсад үлдэх болно гэж Снегг зөвлөв.

Снегг Кракаров хоёр булан тойрон ирлээ. Снегг сарнайн бут руу шидэт саваагаараа зангатал тэндээс айсан хоолой сонсогдож хар дүрс гарч ирэв.

- Пуффендуйгаас арван оноо хаслаа, Фоссетт. Когтевранаас арван оноо хаслаа, Стебинс гэж охины араас үсрэн гарсан хүүг зандарснаа,

- Харин та нар юу хийж байгаа юм? гэж урдаа байгаа Харри, Рон хоёрыг ажиглаад хэлэв.

Каркаров тэднийг хараад тэвдсэн байртай ямаан сахлынхаа үзүүрийг хуруугаараа имэрч байлаа.

- Зүгээр л зугаалж байна. Хориглоогүй биз дээ гэж Рон хэлэв.

- Тэгвэл үргэлжлүүлэн зугаал! гээд Снегг дэргэдүүр нь урт хар жанчаа намируулан өнгөрөв. Каркаров түүнээс хоцорсонгүй. Рон, Харри хоёр цааш явлаа.

- Юу Каркаровыг түгшихэд хүргэсэн юм бол? гэж Рон аяархан асуулаа.

- Тэр яагаад Снеггийг төрсөн нэрээр нь дуудаж байгаа юм бол? гэж Харри удаанаар хэлэв.

Найзууд том чулуун дээр байрлуулсан цаа буганд хүрэхэд усан оргилын ус өндөрт оргилж байв. Усны хажуугийн чулуун сандал дээр хоёр том дүрс сууж байгаа нь сарны гэрэлд харагдав. Тэгтэл,

- Би таныг хараад бүгдийг шууд ойлгосон гэх Хагридын дуу гарлаа..

Харри, Рон хоёр хөшлөө. Ийм үед хүмүүст саад болоод хэрэггүй билээ... Харри бутны ард хагас халхлагдан сууж байгаа Флер Делакур, Рожер Дэвис хоёрыг харав. Тэр Роны мөрөн дээр алгадаад тэдний зүг дохиж эндээс ажиглагдахгүй ухрахыг завдав. Гэвч Флерийг хараад Роны нүд айдаст автан томоор нээгдэж галзуурсан юм шиг толгойгоо сэгсчихэд нь Харри түлхэн цаа буганы арын сүүдэрт аваачлаа.

- Та юу ойлгосон гэж “Агрид? хэмээн хатагтай Максимын дуу гарав.

Харри үнэхээр үүнийг сонсохыг хүссэнгүй. Тэр Хагридын яриа сэм чагнахыг үзэн ялдагыг мэддэг байлаа (ийм явдал тохиолдож байсан юм). Уянгын халилыг сонсохгүй тулд чихээ чанга дарах хэрэгтэй. Гэхдээ энэ боломжгүй. Чулуун цаа бугын нуруун дээр цох явж байлаа. Харри түүн рүү сонирхон харахыг оролдсон ч найзынхаа нууц яриаг сонсохгүй байж чадсангүй.

- Биднийг адилхан... гэдгийг ойлгосон. Таны эцэг эх чинь хэн бэ?

- Би таны юу яриад байгааг ойлгохгүй байна ‘Агрид...

- Миний ээж. Английн хамгийн сүүлчийнх нь байх. Би түүнийг санадаггүй юм... Тэр биднийг орхисон. Би гурав ч хүрээгүй байсан. Ямар ээж тэгэх билээ! Энэ бол тэдний хувьд ердийн л дээ. Түүнд юу тохиолдсон бол... мэдэхгүй юм... магадгүй үхсэн байх...

Хатагтай Максим чимээгүй блов. Харри цаа бугын эвэр дээр явж байгаа цохноос харц салгалгүй сонслоо. Тэр Хагрид хэзээ ч хүүхэд насныхаа тухай ярьж байгааг сонсож байгаагүй билээ.

- Түүнийг явсаны дараа эцгийн минь зүрх шархалсан. Товчхондоо ийм. Би түүнд их хайртай байсан... гээд Хагрид дуугүй болов. Хатагтай Максим хөдлөхгүй суугаад мөнгөлөг дэнлүүг ширтэнгээ сонсож байв.

- Эцэг маань намайг өсгөсөн... дараа нь намайг сургуульд ороход үхсэн. Дамблдор надад тусалсан. Үргэлж эелдэг...

Хагрид халааснаасаа том нусны алчуур гаргаад чанга нусаа нийв.

- Надад таны тухай сонирхолтой байна. Эцэг эх чинь ямар гаралтай вэ?

Хатагтай Максим гэнэт босч,

- Энд хүйтэн байна. Шилтгээн рүү явцгаая гэж хүйтнээр хэлэв.

- Аан? Шилтгээн рүү гэнээ? Жаахан сууцгаая л даа? Би хэзээ ч өөр шигээ хүмүүстэй тааралдаж байсангүй.

- Ямар гэж? хэмээн хатагтай Максим хүйтнээр асуув.

<<Хагрид чимээгүй, битгий хариул>> гэж Харри бурхнаас гуйлаа. Тэр сүүдэрт зогсоод шүд зуун Хагридыг хариулахгүй байх гэж хүлээтэл...

- Хагас аварга биет өөр хэн гэж?

- Та яаж зүрхэлж байна, 'Агрид? гэж хатагтай Максим хашгичив. Түүний хоолой шөнийн нам гүм агаарыг эвдэхэд Флер, Рожер хоёр нуугдсан газраасаа лонхны бөглөө шиг үсрэн гарав.

- Ямар их доромжлол вэ! Хагас аварга биет гэнээ?! Би... би зөвхөн бие томтой!

Тэр босож өнгө өнгийн гэрэлтэй бутны хажуугаар уурсан шүргэж өнгөрлөө. Хагрид сандал дээр суун үлдээд араас нь дагуулан харахад царайны өнгө нь ялгагдсангүй. Дараа нь хормын дараа босож шилтгээн рүү биш овоохой руугаа явлаа.

- Явцгаая гэж Харри хэлэв.

Рон байрнаасаа хөдөлсөнгүй.

- Чи яагаа вэ? гээд Харри Рон руу харав.

Рон Харри руу маш ноцтой харлаа.

- Чи Хагридыг хагас аварга биет гэж мэдэж байсан уу?

- Үгүй. Тэгээд юу гэж? хэмээн Харри мөрөө хавчив.

Ингээд Роны харцаас ахиад шидтэний ертөнцийн үл мэдэгдэх явдал болохыг ойлгожээ. Тэрбээр хүүхэд насаа маглуудын дунд өнгөрүүлсэн болохоор шидтэнүүдийн хувьд чухал байдаг зүйл түүнд хамаагүй юм. Гэхдээ энэ нь жил илрэх бүр улам бүр багасаж байв. Ихэнхи шидтэнүүд найзынх нь ээж аварга биет гэхэд <<Тэгээд юу гэж?>> хэмээн хариулахгүй л байх.

- Шилтгээн рүү явцгаая. Тэнд тайлбарлая гэж Рон хэлэв.

Флер, Рожер хоёр явжээ. Харри, Рон хоёр Их танхим руу ярав. Падма, Парвати хоёр алсын буланд Шармбатоны хөвгүүдээр хүрээлүүлэн суух агаад Гермiona Крамтай бүжиглэж байв. Рон, Харри хоёр бүжгийн талбайгаас холхон суулаа.

- Аварга биет гэдэг чинь юу гэж байгаа юм бэ? гэж Харри сануулав.

- Тэд... тэд... юу гэж хэлэх юм дээ.. Тийм ч сайн биш гэж Рон үгээ олохыг хичээн хэлэв.

- Тэгээд юу гэж? Хагрид сайн шүү дээ.

- Тиймээ мэдэж байна. Чөтгөр ав гэж тэр энэ тухай дуугүй байсанд гайхах юм алга. Би түүнийг хүүхэд насандаа санамсаргүй өсдөг шившлэгт өртсөн байх гэж бодлоо. Хэнд энэ тухай ярихад таатай байх билээ гээд Рон толгойгоо сэгсрэв.

- Гэхдээ ээж нь аварга биет гэхэд ямар учир байгаа гэж?

- Хагрид энэ тухай мэдэж байна. Тэд түүний аюулгүй биш гэдгийг мэднэ. Ойлго, Харри тэд их харгис. Тэд савдагтай адилхан... зөвхөн алах дуртай. Бүгд энэ тухай мэднэ. Англи даяар аварга биетнүүд эртнээс алга болсон.

- Тэдэнд юу тохилдсон юм бол?

- Үхсэн олонхыг нь мракобрецууд алсан. Хилийн цаана аварга биетүүд ууланд нуугдаж байгаа гэж ярьцгаадаг...

- Би хатагтай Максимыг тоглож байна гэснийг ойлгохгүй байна? Хагрид бол хагас аварга биет гэдэг нь тодорхой шүү дээ. Том яс! Эдгээр том амьтад динозаврын хэмжээтэй байдаг юм гэхэд Харри хатагтай Максимиин дүнсийн сууж байгаа шүүгчдийн ширээ рүү харлаа.

Бүжгийн төгсгөл хүртэл Харри, Рон хоёр буланд суугаад аварга биетүүдийн талаар ярилцлаа. Тэд бүжиглэхийг хүссэнгүй. Харри Чжоу болон Седрик руу харахгүй байхыг хичээж байв. Түүн рүү харах тоолонд ямар нэг юм өшиглөмөөр санагдах аж.

Шөнө дунд Эмгэн шулам сүүлчийн бүжгээ тоглож дуусахад удтал чанга алга ташаад бүгд үүд танхим руу явцгаав. Олон хүмүүс бүжиг удаан үргэлжлээгүйд сэтгэл хангалуун бус байсан ч Харри дулаахан тухтай орондоо орох болсондоо баяртай байв. Бүжиг түүнд их уйтгартай санагджээ.

Тэд үүдний танхимд гараад Гермiona Крамыг хөлөг онгоц руугаа явахад нь сайхан нойрсохыг ерөөхийг харлаа. Тэрбээр Рон руу хүйтнээр хараад дэргэдүүр нь чимээгүй өнгөрч гантиг шатаар өгсөв. Харри, Рон хоёр араас нь өгстөл Седрик Диггори замын дунд зогсоов.

- Харри хүлээгээч!

Чжоу доор Седрикийг хүлээж байв.

- Яасан? гэж Харри Седрикийг шатаар өгсөн ирэхэд нь хүйтнээр хэлэв.

Седрик Роны дэргэд ярихыг хүссэнгүйг ойлгоод тэр баргар царайлан дээш өгслөө.

- Сонсооч Харри, би чамд лууны төлөө өртэй. Чи алтан өндөгийг нээсэн үү? Тэр орилж байна уу? гэж Седрик нам дуугаар хэлэв.

- Орилж байсан.

- Тэгвэл... усан санд ор ойлгомжтой юу?

- Юу гэнээ?

- Усан санд хий... зөвхөн өндөгөө өөртэйгээ авч яваарай. Халуун усанд ороод олон талаас нь бод. Энэ чамд тусална, надад итгэ.

Харри түүн рүү харлаа.

- Бас нэг хэлэх үг байна. Зөвхөн ахлагч нарын угаалгын өрөөнд ороорой. Дөрвөн давхарт Борис Бестолковогын зүүн талаасаа тав дах хаалга. Нууц үг нь “шинэхэн нарс”. За би явах боллоо...

Седрик ахин инээмсэглээд Чжоу руу уруудлаа.

Харри ганцаараа цамхаг руугаа явав. Ямар хачирхалтай зөвөлгөө вэ. Усан санд өндөгний орилооныг сонсох нь нууцыг тайлахад яаж туслах юм бол? Седрик тоглосон юм байх даа? Түүнийг Седриктэй харьцуулахад тэнэг амьтан гэж Чжоугийн нүдэнд харуулахыг хүссэн юм байх даа?

Тарган хатагтай болон түүний найз Ви зүүрмэглэж байв. Харри тэдэнд удтал нууц үг хашгирч байж сэрээхэд ихэд уурсан нээгдэв. Зочны өрөөнд түүнийг гэнэтийн үйл явдал хүлээж байлаа. Рон, Гермiona хоёр улаан нүүртэй бие биенээсээ метрийн зайд зогсоод орилж байх нь тэр.

- Чамд энэ таалагдахгүй байна уу? Гэхдээ чи юу хийх ёстойгоо мэдэж байсан биз дээ? гэж Гермiona хашгирав. Түүний дэгжин үс сэгсийсэн агаад уурсах нь улам нэмэгдэв.

- Би юу хийх ёстой байсан гэж? гэж Рон хариу орилов.

- Намайг сүүлчийн минутад биш хэнийг ч сонгоогүй байхад урих хэрэгтэй байсан юм!

Рон ямар нэг юм хэлэхийг хүсэн уснаас гарсан загас шиг ангалзав. Гермiona өсгий дээрээ эргээд шатаар унтлагын өрөө лүүгээ нисэв. Рон Харри руу эргэж харлаа.

- Харав уу? Юу ч ойлгоогүй байна! гэж тэр мэгдсэн хоолойгоор хэлэв.

Харри чимээгүй болов. Тэр Ронтой найрамдсан явдалдаа баярлаж байсан ч Гермionaг хэнээс ч илүү сайн ойлгож байв.

БҮЛЭГ 24: РИТА СКИТЕРИЙН ШУУГИАН

Зул сарын хоёр дахь өдөр бүгд удтал унтав. Амралтын өрөө хүнтэй байсан ч чимээгүй байв. Дургүйхэн ярьж үргэлж эвшээцгээх аж. Гермiona Живоглотыг өвдгөн дээрээ тавиад чихийг нь маажихад тааламжтай хүржигнэлээ. Түүний өтгөн үс ахин сэгсийсэн бөгөөд бүжгийн өмнө Үс гялалзуулдаг ханд хэрэглэсэн гэж Харрид хэлжээ.

Рон, Гермiona хоёр бие биендээ нөхөрсөг хандаж өчигдөрийн маргаанаа сөхсөнгүй. Өглөө нь тэр хоёр Гермionaд Хагрид болон хатагтай Максимын зугаалгын тухай ярьж өглөө. Хагридыг хагас аврага биет гэж мэдэнгүүтээ Гермiona зөвхөн мөрөө хавчих төдийгөөр Роны адил нөлөөлсөнгүй.

- Тэгээд юу гэж? Би тэгж бодсон юмаа. Тэр жинхэнэ аврага биет биш гэдэг нь илт шүү дээ. Учир нь тэд долоон метрийн өндөртэй байдаг юм. Гэхдээ үнэнийг хэлэхэд энэ бүх аварга хүний тухай сандрал юунд хэрэгтэй юм бэ. Тэднээс яагаад айх ёстой гэж? Тэд бүгдээрээ ууртай алуурчин биш. Бид бүх хүн чоноос айдаггүй биз дээ. Зүгээр л мухар сүсэг!

Рон эсэргүүцэх санаатай амаа нээсэн ч маргаан дэгдэхээс айн хэлсэнгүй. Гэхдээ Гермionaг цааш харахад нь итгэлгүйхэн толгой сэгсэрчээ.

Амралтын эхний долоо хоногт юу ч хийгээгүй болохоор гэрийн даалгавар хийх цаг болжээ. Бүгд сурах бичиг, цаас, үзгээ дургүйхэн авчирч гашуунаар ажилдаа орлоо. Харри үргэлж хуналы руу харж байв.

Хоёр сарын хорин дөрвөн ойлтсон ч тэр алтан өндөгний дотор юу байгааг таагаагүй л байв. Тэрбээр хэдэн удаа унтлагын өрөөндөө өндөгөө чөмоданаас авч нээгээд анхааралтай сонссон ч юуны тэмдэг болохыг нь мэдсэнгүй. Энэхүү гурвалсан хөрөөний хөгжим санагдуулсан дуутай адилхан чимээг амьдралдаа хэзээ ч сонсож байгаагүй аж. Тэр өндөгийг хаагаад хүчтэй сэгсчиж үзсэн ч чарлаан өөрчлөгдсөнгүй. Тэр ч байтугай түүнийг хана руу өшиглөсөн ч амжилт олсонгүй.

Мэдээж Харри Седрикийн хэлсэн үгийг санаж байсан ч түүний тусламжгүй хийхээр шийджээ. Седрик үнэнээсээ туслахыг хүссэн бол шууд хэлэх байсан даа. Харри түүнд лууны тухай хэлсэн шүү дээ. Харин Седрик угаалгын өрөөнд орохыг зөвлөж байна. Сайхан зөвөлгөө байна даа! Гэхдээ түүнд шилтгээнд Чжоутай зугаалж байгаа хүний тусламж хэрэггүй.

Ийм бодлогоширол амралтын төгсгөл хүртэл үргэлжиллээ. Харри цүнхэндээ сурах бичиг, цаас, үзгээ хийлээ. Алтан өндөгний тухай асуудал хүзүүнээс нь тээрмийн чулуу зүүсэн аятай зовоох аж.

Гадаа цас хунгарлаж профессор Стеблийн хүлэмжийн цонхонд мөсөн хээ угалз тогтон цонхоор юу ч харах боломжгүй болжээ. Тийм хүйтэнд хэн ч шидэт амьтны хичээл рүү явахыг хүсэхгүй байлаа.

Шөнө цас даржээ. Тэднийг овоохойны хаалган дээр нь хижээл насны богинохон үс, урт эрүүтэй шидтэн хүлээж байлаа.

- Түргэл хонх таван минутын өмнө дуугарсан! гэж тэр холоос сэтгэл хангалуун бус хашгирав.

- Та хэн бэ? Хагрид хаана байна? гэж Рон асуулаа.

- Намайг Граббли-Дерг гэдэг. Би та нарт түр хугацаагаар шидэт амьтны хичээл заах болно гэж шидтэн тайлбарлав.

- Хагрид хаана байна? гэж Харри чанга асуулаа.

- Өвдсөн.

Харригийн ард хэн нэгэн зэвүүнээр инээд алдав. Тэр эргэж харвал овоохой руу Драко Малфой тэргүүтэй Слизеринийхэн ойртож явлаа. Тэд их баяртай байсан бөгөөд профессор Граббли-Дергийг хараад өчүүхэн төдий ч гайхсангүй.

- Миний араас яваарай гээд багш эмэгтэй Шармбатоны алтан морьд чичрэн зогсох хашааг даган явлаа.

Харри, Рон, Гермиона гурав араас нь дагахдаа Хагридын овоохой руу харвал хөшиг нь хаалттай байв. Магадгүй тэнд Хагрид ганцаархнаа өвдөөд хэвтэж байгаа байх.

- Тэр яагаа вэ? гэж Харри багшаас асуулаа.

- Та нарын хэрэг биш гэж Граббли-Дерг татгалзав.

- Би тэгж бодохгүй байна. Хагрид яагаа вэ?

Гэхдээ профессор дүлий юм шиг байв. Хашааг тойроод цаашаа ой руу явлаа. Ойн цоорхойд модноос гайхамшигтай сайхан том ганц эвэрт уяатай байв.

Охид дуу алдав.

- Ямар үзэсгэлэнтэй юм бэ! Түүнийг хаанаас авчирсан юм бол? Барихад хэцүү байх даа! гэж Лаванда Браун шивнэлээ.

Ганц эвэртийн цэвэрхэн цагаан биений хажууд цас хүртэл саарал харагдаж байлаа. Тэр алтан туурайгаараа цас малтан сум шиг эвэртэй толгойгоо хаялав.

Харри урагш тэмүүлсэн ч профессор Граббли-Дерг түүний цээж рүү өвдтөл түлхэн зогсоов.

- Хөвгүүд үлд! Ганц эвэрт эмэгтэй хүний гарыг эрхэмлэдэг юм. Охид урагшаа болгоомжтой. Алгуурхан яаралгүй яваарай...

Профессор охидыг дагуулсаар ганц эвэртэд болгоомжтой ойртоход хөвгүүд хашааны ард үлдлээ.

- Тэр яасан юм бол? Соплохвостоос болсон юм болов уу...? гэж Харри Роноос ууртай багш явсан хойно асуув.

- Чиний Хагрид бүрэн бүтэн байгаа. Зүгээр л хүмүүст үзэгдэхээс ичээд байгаа юм гэж Малфой аяархан хэлэв.

- Ичих гэнээ? Яагаад? гэж Харри Малфой руу огцом эргэлээ.

Тэрбээр халааснаасаа хуйлаастай сонин гаргав.

- Сонирх л доо. Чамайг гомдоохыг хүсэхгүй байна гэж тэр мушийн инээмсэглэв.

Харри сонинг аваад дэлгэн уншив. Рон, Симус, Дин, Невилл нар мөрөн дээгүүр нь өнгийн харцгаалаа. Сонины мэдээллийн тэргүүнд Хагридын жинхэнэ дээрэмчин шиг зураг байлаа.

ДАМБЛДОРЫН АСАР ТОМ АЛДАА

Ид шидтэний Хогвартс сургуулийн захирал Альбус Дамблдор бүгдэд хачин жигтэй явдлаараа алдартай билээ. Тэр багш нараа сонгохдоо тээнэгэлзэж байгаагүй. Өнгөрсөн есөн сард тэр ид шидийн яамныхныг гайхуулан тэтгэвэртээ гарсан экс мракобрец болох муу нэрээрээ алдартай Аластор “Хурц нүдэт” Грюмыг хар урлагаас хамгаалах хичээлийн багшаар урьсан юм. Грюм дэргэд нь огцом хөдөлгөөн хийсэн хэнийг ч довтлоход бэлэн байдаг хүн. Гэхдээ Хурц нүдэт Грюм шидэт амьтны хичээлийн багш хагас аварга биетийг бодоход найдлага төрүүлэм эелдэг хүн юм.

Түүнийг Рубеус Хагрид гэдэг. Тэр урьд нь Хогвартсад сурч байхдаа гурав дугаар дамжаандаа хөөгдсөн бөгөөд Дамблдор түүнийг ойн сахиулаар үлдэх боломж олгожээ. Өнгөрсөн жил Хагрид захирлын нууцлаг ивээлээр шидэт амьтны хичээлийн багш болсон байна.

Айдас хүрэм том биетэй догшин төрхтэй Хагрид шинэ эрх мэдлийнхээ хүрээнд сурагчдад мангас гэж болох амьтдыг ээлж дараалан авчирдаг байна. Түүнд хэдийн хохирогч бий болжээ. Дамблдор энэ бүхнийг нүдээ анин өнгөрүүлж байхад сурагчид түүний хичээлд явах осолтой гэж үзэж байна.

<<Намайг гиппогриф шархдуулж, миний анд Винсент Крэббийг флоббер-өт хазсан. Бид бүгд энэ Хагридыг үзэн яддаг ч айсандаа чимээгүй байдаг>> гэж бидэнд дөрөвдүгээр дамжааны сурагч Драко Малфой мэдэгдсэн юм.

Хагрид айлган сүрдүүлэх ажлаа болих огт бодолгүй байна. Тэр өнгөрсөн сард <<Зөнч>> сонины сурвалжлагчид шинэ төрлийн мангас болох галт наймаалжны төрхтэй амьтнаа соплохвост гэж нэрлэдэг тухайгаа ярьжээ. Эдгээр соплохвостууд их аюултай амьтад юм. Шидэт амьтны угсаа төрөл тэжээх нь зөвхөн шидэт амьтдыг хянан зохицуулах хэлтсийн зөвшөөрөлтэй явагддаг. Гэхдээ Хагрид үүнийг үл ялих зүйл гэж бодсон бололтой.

<<Би эдгээр хөгжилтэй амьтадтай ажиллаж байгаадаа баяртай байна>> гэж Хагрид ярилцлага өгөхдөө дурьджээ. <<Зөнч>> сонины олсон баримтан дээр үндэслэн Хагрид бол цэвэр цусны шидтэн биш бөгөөд зөвхөн дүр үзүүлэгч болохыг тогтоожээ. Тэр бол хүн ч биш. Түүний ээжийг аварга биет Фридвильфа гэж нэрлэдэг байсны дээр үеийн нутгийн оршин суугчид мэднэ.

Аварга биетүүд хэрцгий цусанд дуртай бөгөөд өнгөрсөн зуунд өөр хоорондоо дайтаж устан үгүй болсон юм. Үлдсэн хэсэг нь Хэцүү нэртийн талд нэгджээ. Тэд л маглуудыг бөөнөөр нь алсан хэрэгт буруутгагдаж байна.

Ихэнхи аварга биетүүд Хэцүү нэртийн талд байсан болохоор ид шидийн яамнаас маркоборецуудыг устгах ажилд томилсон бөгөөд үүнээс Фридвильф ямар нэгэн аргаар бултан зугтжээ. Магадгүй хилийн чанад руу зугтан ууланд аварга биетүүдтэй

нуугдаж байж болзошгүй. Шидэт амьтныг хичээлийг харгис хэрцгий занг нь өвлөн авсан Фридвильфын хүү зааж байна.

Хачирхалтай тохиолдлоор Хагрид Хэцүү нэртийг доройтуулсан хүүтэй найзалжээ. Тэр үед Хагридын ээж нь Хэцүү нэртийн туслагчдын адил нуугдсан. Харри Поттер том биет найзынхаа талаарх гашуун үнэнийг мэдээгүй байж болох юм. Гэвч Альбус Дамблдор Харри Поттер болон бусад сурагчид хагас аварга биетийн аюул занал дор байгаа нь тодорхой.

Тусгай сурвалжлагч

<<Өдөрт тутмын Зөнч>> Рита Скитер

Харри сонинг уншиж дуусаад амаа ангайсан Рон руу харав.

- Тэр яаж энэ бүхнийг мэдсэн юм бол?

Харри Малфой руу эргэлээ.

- Чи бүгд Хагридыг үзэн яддаг гэж юу яриад байгаа юм? Крэббийн тухай юун хөгийн юм биччихээ вэ! Түүнийг өт хазсан гэнэ үү? Өтөнд шүд байхгүй шү дээ!

Крэбб сэтгэл хангалуун хөхрөв.

- Одоо энэ болхи амьтныг хөөнө гэж найдаж байна. Хагас аварга биет шүү! Харин би түүнийг хүүхэд байхдаа лонх <<Яс ургуулагч>> санамсаргүй уучихсан юм байх гэж бодлоо... Одоо ээж аавууд айна даа. Энэ мангас тэдний хүүхдийг иднэ... ха-ха-ха... гэж Малфой нүдээ гялалзуулан баясан хэллээ.

- Чи... чи...

- Та нар хичээл рүүгээ анхаарал хандуулж байна уу? гэж профессор Граббли-Дерг хашгирав.

Охидууд ганц эвэртийг тойрон хүзүү болон ташааг нь энхрийлэн иллээ. Харри толгойных нь эвэр рүү харав. Тэр уурласандаа чичирч байсан болохоор сонин гараас нь унав. Профессор ганц эвэртийн тухай хөвгүүдэд сонсогдохоор чанга ярилаа.

- Түүнийг бидэнтэй үлдэнэ гэж найдаж байна! Одоо л би шидэт амьтны хичээл гэж юу болохыг ойлгож байна. Бидэнд ганц эвэрт шиг амьтад л таарахаас биш янз бүрийн мангас биш... гэж Парвати Патил хичээлийн төгсгөлд шилтгээн рүү явах замдаа хэлэв.

- Хагрид яах болж байна? гээд Харри чулуун шатаар өгсөхдөө Парвати руу ууртай харав.

- Тэр яана гэж? Ойн сахиулаараа үлдэнэ биз гэж Парвати хатуу хэлэв.

Бүжигт үдэшлэгийн дараа Парвати Харритай хүйтэн харьцах болжээ. Түүнд илүү их анхаарал хандуулах ёстой байсан гэж бодож байгаа бололтой. Бүгд түүний дараагийн удаагийн Хогсмид явалтаар Шармбатоны хөвгүүдтэй уулзахаар төлөвлөж байгаа талаар ярилцаж байв.

- Маш сайхан хичээл боллоо. Граббли-Дерг хичнээн их зүйл ярьсан гээч! Би ганц эвэртийн тухай бараг мэддэггүй юм байна... гэж Гермiona Их танхимд ороод хэлэв.

- Унш! гээд Харри сонинг хамар дор нь сунгалаа.

Гермиона сонинг амаа ангайн уншаад Роны адил асуулт тавив.

- Скитер энэ бүхнийг хаанаас мэдсэн юм бол? Хагрид өөрөө хэлсэн юм болов уу?

- Үгүй дээ! Тэр бидэнд энэ тухайгаа яриагүй. Түүнийг Хагридад миний тухай хүссэн зүйлийг нь яриагүйд уурласан гэж бодож байна. Түүнийг өмхий хүрэн шиг тойрч гүйгээд үүнийг шиншилж олоо биз гэж Харри Гриффиндорын ширээнд суухдаа хэллээ.

- Магадгүй тэр бүжгэн дээр болсон Хагрид, хатагтай Максим хоёрын яриаг сонссон юм болов уу? гэж Гермiona асуулаа.

- Цэцэрлэгт хүрээлэнд тэр байгаагүй. Түүнийг сургуулийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй байгаа. Хагрид Дамблдор түүнийг хориглосон гэж хэлсэн хэмээн Рон хэлэв.

- Эсвэл түүнд үл үзэгдэх цув байдаг юм болов уу? Бутан дунд нуугдаад сонссон байж болох шүү дээ гэж Харри хэлээд тахианы шөл хутган тавгандаа хийхдээ цалгиулав.

- Рон та хоёр шиг үү? гэж Гермiona хэлэв.

- Чинийхээр бид түүнийг чагнах гэж оролдсон байх нь уу? Бидэнд ямар ч сонголт байгаагүй! Хагридын эх аварга биет байсан тухай яриаг усан тэнэг хүн л сонсох байх даа! гэж Рон эгдүүцлээ.

- Бид түүн дээр очих хэрэгтэй. Өнөө орой мэргэ төлгийн хичээлийн дараа. Түүнээс ахиад хичээлээ заахыг гуйя. Чи түүнийг эргэж ирэхийг хүсэж байгаа биз дээ? гээд Харри Гермiona руу харлаа.

- Би... надад профессор Граббли-Дергийн хичээл таалагдаж байгаа л даа... Гэхдээ би Хагридыг эргэж ирээсэй гэж хүсэлгүй яахав хэмээн Гермiona Харригийн ууртай харцыг ажиглаад яаран нэмэрлэв.

Тэд оройн хоолны дараа шилтгээнээс гарч цасан дээр гүнзгий мөр үлдээн Хагридын овоохой руу явлаа. Хаалга цохиход дотор Соёот хуцав.

- Хагрид бид байна. Онгойлгооч гэж Харри хашгираад хаалга нүдлээ.

Хагрид чимээгүй байв. Соёот улин маажсан ч хаалга онгойсонгүй. Тэд хаалгыг арван хором хиртэй нүдэж, Рон цонхыг нь жингэнүүлэн цохьсон ч Хагрид гарч ирсэнгүй. Андууд эцэст нь шилтгээн рүүгээ явлаа.

- Тэр яагаад биднээс зугтаж байгаа юм бол? Бидэнд түүний хүн эсвэл хагас аварга биет эсэх нь хамаагүй шүү дээ! гэж Гермiona бодлогоширов.

Харин Хагрид тэгж бодоогүй бололтой. Тэр долоо хоногийн турш хоолны цагаар багш нарын ширээнд үзэгдсэнгүй суудал нь хоосон байсан бөгөөд шилтгээний эргэн

тойронд ч харагдсангүй. Харин шидэт амьтны хичээл дээр өмнөхийн адил профессор Граббл-Дерг заасаар байлаа. Малфой боломжыг алдалгүй тавласан хэвээр.

- Поттер яасан хагас аварга биет найзаа санаад байна уу? Заан шиг хүнээ алдчихсан уу? гэж багшийн хажууд Харригийн чихэнд шивнэлээ.

Нэг сарын дундуур хүүхдүүд Хогсмид явцгаалаа. Гермиона Харриг бас явна гэхэд ихэд гайхжээ.

- Би чамайг үлдэнэ байх гэж бодсон юм. Амралтын өрөө нам гүм байгаа бодохоор өндөгний тухай таавраа бодоход амар шүү дээ.

- Өө, тийм л дээ би бараг таачихсан. Муугүй санаа орж ирээд гэж Харри худал хэлэв.

- Үнэн үү? Сайн байна! гэж Гермиона сэтгэгдэл төрсөн байртай хэлэв.

Харри зөвөлгөөг сонсоод гэм буруугаа мэдэрсэн ч үл тоомсорлов. Өндөгний түлхүүрийг тайлахад таван долоо хоногийн хугацаа үлдээд байна... Гэхдээ энэ чинь бараг зуун жил шүү дээ... Хогсмид... Тэнд Хагрид байгаад эргэж ирэхийг нь гуйж болох ч юм билүү.

Хагс сайн өдөр бүгд хамтдаа шилтгээнээс гарч хаалга руу явлаа. Хүйтэн ясанд хүртэл жиндэж байв. Дурмастрангын хөлөг онгоц эргийн хажууд зогссон хэвээр. Тавцан дээр нь Виктор Крам зөвхөн богино өмдтэй зогсож байлаа. Туранхай хэдий ч эрүүл чийрэг тэрбээр тавцангаас үсрэн нуур луу шумбалаа.

- Тэр галзуурсан байхаа! Нэг сарын хүйтэнд шүү! гэж Харри Крамын толгой нуурын дунд үзэгдэхэд дуу алдав.

- Түүний ирсэн газар бүр хүйтэн шүү дээ. Манай ус дулаахан санагдаж байгаа байх гэж Гермиона хэлэв.

- Нууранд аварга том наймаалж байдаг биз дээ! гэж Рон түгшлээ.

- Тэгээд юу гэж? Тэр Дурмастрангынх биз дээ? Тэр их сайн. Тэр надад энд байх нь илүү таалагдаж байгаа гэж хэлсэн.

Рон чимээгүй боллоо. Бүжигт үдэслэгийн дараа тэр нэг ч удаа Виктор Крамтай яриагүй бөгөөд амралтын хоёр дахь өдөр Харри түүний орон доороос Болгарын баригчийн жижиг дүрсийг олжээ.

Хогсмидод жавартай хүйтэн байлаа. Харри Хагридыг хайн харсан ч гудамж дэлгүүрийн алинд ч байсангүйд Гурван шүүр рүү орохыг санал болгов.

Бааранд ердийнх шигээ их хүнтэй байлаа. Харри ширээнүүдийг гүйлгэн харахад Хагрид байсангүй. Тэр сэтгэлээр унан Рон, Гермиона хоёрыг дагалдан цөцгийний шар айраг авлаа. Шилтгээнд үлдэж өндөгний орилохыг сонсохыг сонссон нь дээр байсан бололтой.

- Тийшээ хараач. Тэр яагаад хэзээ ч ажил дээрээ байдаггүй юм бол? гэж Гермиона шивнээд лангуун дээр байгаа толь руу заав.

Түүнд харанхуй буланд суугаад албингуудтай ямар нэг юмны талаар түргэн ярьж байгаа Людо Бэгмений дүрс харагдав. Албингууд сүрдүүлсэн янзтай гараа цээжиндээ зөрүүлэн түүнийг харж байлаа.

<<Бэгмен энд амралтын өдөр юу хийж байгаа юм бол?>> гэж Харри бодлоо. Хоёр дахь тэмцээн хол байсан болохоор шүүгчийн шаардлагагүй байлаа. Харри ахиад толин дахь Бэгмен рүү харав. Ид шидийн яамны спорт тоглоомын хэлтсийн дарга Хар тамга тэнгэр үзэгдэхийн өмнө ойд харагдсан шигээ сэтгэл түгшсэн байлаа. Бэгмен бааран дотор хүмүүсийг тойруулан харснаа Харриг ажиглав.

- Одоохон ирнэ гэж тэр албингуудад хэлээд хүүхдийнх шиг царайдаа инээмсэглэл тодруулан Харри руу ярав.

- Юу байна даа, Харри? Чамайг энд харна гэж бодсонгүй шүү! Бүх зүйл хэвийн биз дээ?

- Тиймээ, баярлалаа гэж Харри хэлэв.

- Чамтай хэдэн үг сольж болох уу? Та нар эсэргүүцэхгүй биз дээ? гэж Бэгмен Рон, Гермиона хоёроос асуулаа.

- Үгүй... гээд Рон Гермиона руу харав.

Бэгмен Харригийн гараас хөтөлж лангууны төгсгөл рүү хатагтай Розмертагаас холхон аваачив.

- Чамайг эвэр сүүлтийг гайхамшигтай ялсанд чинь баяр хүргэе. Сайн байна!

- Баярлалаа гэж Харри талархав.

Бэгмен ямар нэг юм хэлэхийг хүссэнээ толин дахь албингууд руу харж Харри руу ширтлээ.

- Жинхэнэ хар дарсан зүүд гэж тэр Харригийн албингуудыг ширтэхийг хараад хэллээ.

- Тэд англи хэл мэддэггүй юм... яг л Дэлхийн цомын тэмцээн дээр байсан Болгарчууд шиг... гэхдээ дохиж зангахыг бол ойлгоно. Харин эд нарын албаны дуржигнасан хэлнээс би зөвхөн <<бладвак>>, <<кирка>> гэсэн хоёр үгийг л мэдэж байна. Надад энэ үг ойлгогдохгүй байгаа ч тэднийг айлгахыг хүсэхгүй байна хэмээн Бэгмен яриагаа инээдээр төгсгөв.

- Тэдэнд таниас юу хэрэгтэй юм? гэж Харри асуулаа. Албингууд суугаад Бэгмений хөдөлгөөн бүрийг дагуулан харж байлаа.

- Чамд яаж тайлбарладаг юм билээ... Тэд Барти Краучыг эрж байгаа юм гээд Бэгмен гэнэтхэн зовнисон янзтай болов.

- Тэгвэл энд хайх ямар хэрэгтэй гэж? Тэр энд биш Лондонд яаманд байгаа биз дээ.

- Ер нь бол би түүний хаана байгааг мэдэхгүй байна. Тэр ажилдаа явахгүй байгаа. Хоёр долоо хоног болж байна. Түүний туслах Перси Уизли өвдсөн байх гэж хэлсэн. Тушаалаа уулиар илгээж байгаа. Зөвхөн цуу яриа төдий болохоор хэнд ч хэлж болохгүй шүү? Учир нь энэ сурвалжлагч Рита Скитер түүнийг тойрон шиншилж

байна. Бартигийн өвдсөнийг мэдэх юм бол нүд цавчиж амжаагүй байхад шинэ шуугиан болгоно. Магадгүй Берта Жоркинсийн адил алга болсон гэж хэлж мэдэх хүн.

- Берта Жоркинс олдоогүй байгаа юм уу?

- Үгүй дээ. Би хүн илгээсэн (Аль хэдийн тэгэх ёстой байсан юм гэж Харри бодлоо). Бүх зүйл их хачирхалтай байна. Албани руу явсныг нь би сайн мэдэж байна. Тэр тэнд үеэл ахтайгаа уулзсан байсан. Дараа нь өмнө зүг рүү нагац эгч рүүгээ яваад усанд шумбасан юм шиг ор сураггүй алга болсон... Түүнд юу ч тохиолдсон бол гэж ухаан ч хүрэхгүй юм. Зугтсан юм болов уу? Үгүй л баймаар юм. Хэн түүнийг мэдэх билээ? Бид чинь одоо юу яриад байна аа? Гол яриандаа орсон нь дээр байх гэж Бэгмен түшсэн байртай хэлээд,

- Өндөгний тухай таавар юу болж байна даа? гэлээ.

- Бараг таасан гэж Харри ахин худал хэлэв.

Гэхдээ Бэгмен Харриг худал хэлснийг тааварласан бололтой.

- Сонсооч Харри шуудхан хэлэхэд энд шударга бус юм болж байна... Чамайг сайн дураараа хүсээгүй байхад тэмцээнд оролцуулсан. Бас... гээд Харри руу бөхийн бараг сонсогдохгүй шахам хоолойгоор,

- Хэрвээ би чамд би тусалвал... Чи ойлгож байгаа биз дээ... Чи надад анхнаасаа л таалагдсан. Лууны хувьд их ухаалаг байсан. Ердөө тусламж гуйхад болно... гэж шивнэлээ.

Харри Бэгмений цэнхэр нүдтэй хүүхдийн дугуй ягаан царай руу ширтлээ.

- Би өөрөө энэ тааврыг таах болно гэж Харри болгоомжтой хэлэв. Ид шидийн спорт тоглоомын хэлтсийн дарга Харриг мэхэлж байгаа гэж бодоогүй байлгүй.

- Тэгэлгүй яахав. Бид зүгээр л Хогвартсын сурагч ялаасай гэж хүссэн юм.

- Та Седрикт тусалж болно шүү дээ?

Бэгмен хөмсөг зангидлаа.

- Үгүй дээ, тэгэхгүй. Чамд яаж тайлбарладаг юм билээ... Чи надад таалагдаж байна гэж хэлсэн. Иймээс л би чамд туслахыг хүсч байгаа юм...

- Их баярлалаа. Би тааврыг бараг таасан ахиад хэд хоногийн дараа бүх юм тодорхой болно.

Харри яагаад татгалзсанаа өөрөө ч мэдсэнгүй. Бэгмен түүнд харь санагдсан болохоор түүнээс тусламж авах гэдэг луйвар шиг санагджээ. Рон, Гермiona хоёрын нөхөрсөг зөвөлгөө юм уу Сириусынх бол өөр хэрэг шүү дээ.

Бэгмен ихэд доромжлогдсон байдалтай харагдсан ч юу ч хэлсэнгүй тэр үед Фред, Жорж хоёр хүрч очлоо.

- Сайн уу, ноён Бэгмен өнөөдөр таньтай энд уулзана гэж бодсонгүй шүү! Таныг зочлохыг зөвшөөрнө үү! гэж Фред дуу алдав.

- Үгүй дээ... Үгүй хүүхдүүдээ, их баярлалаа гээд Бэгмен урам хугарсан байртай Харри руу харав.

Ихрүүд ч мөн адил урам хугарсан янзтай Бэгмен рүү харж байлаа.

- За би явах хэрэгтэй боллоо. Та нартай уулзсандаа баяртай байна. Амжилт хүсье, Харри.

Ингэж хэлээд тэрбээр үүд рүү явлаа. Албингууд суудлаасаа босон дагалдав. Харри Рон, Гермиона хоёр руу хүрч очлоо.

- Тэр юу хүсээ вэ? гэж Рон асуув.

- Өндөгний тааварт туслахыг хүсч байна.

- Байж боломгүй юм! Тэр шүүч шүү дээ. Тэгээд ч чамд тусламж хэрэггүй биз дээ? гэж Гермиона цочирдон хэлэв.

- Ер нь бол, тийм...

- Дамблдор Бэгмен мэхлэхийг оролдож байгааг мэдэх юм бол юу хэлэх байсан бол? Харин тэр Седрикт туслах болов уу? гээд Гермиона толгойгоо сэгсэрлээ.

- Үгүй дээ, би асуусан.

- Диггорид хэн туслах билээ гэж Рон унтууцахад Харри зөвшөөрлөө.

- Энд албингууд юу хийж байгаа юм бол? Тэд их эелдэг бус царайтай харагдаж байсан шүү гээд Гермиона аягатайгаасаа балгав.

- Бэгмен тэд Краучыг хайж байгаа гэсэн. Тэр өвдөөд ажилдаа очоогүй удаж байгаа юм байх.

- Магадгүй Перси түүнийг хордуулсан байх. Краучыг үхэхээр өөрөө олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга болох гэж байгаа юм хэмээн Рон хэлэв.

Гермиона Рон руу тийм зүйлээр тоглодоггүй юм гэж хэлэхийг хүссэн мэт зэмлэнгүй харав.

- Албингуудад ноён Крауч ямар хэрэгтэй юм бол? Тэд ер нь бол шидэт амьтдыг хянах хэлтэстэй л холбоотой байдаг...

- Эсвэл тэдэнд орчуулагч хэрэг болсон юм болов уу? Крауч зуугаад хэл мэддэг биз дээ гээд Харри мөрөө хавчив.

- Хөөрхий албингуудын төлөө санаа зовж байна уу? Ү.А.Х.Н байгуулахыг хүсч бана уу? Үзэшгүй муухай албингуудыг хамгаалах нийгэмлэг? гэж Рон хэллээ.

- Их инээдтэй байна! гэж Гермиона егөөдөнгүй хэлээд,

- Албингууд өөрсдийгөө аваад явж чадна. Чи профессор Бинсийг муу сонссон юмаа даа? Албингуудын бослогын талаар юу ярьсаныг мартчихсан уу? гэв.

- Сонсоо ч үгүй гэж Рон хариулав.

- Хэн түүнийг сонсох юм! гэж Харри андыгаа дэмжлээ.

- Тэгвэл би та нарт хэлье. Албингууд шидтэнтэй эн тэнцүү харьцдаг. Тэд их ухаантай. Тэд бол аймхай гэрийн үйлчлэгч нар биш гээд Гермона балгав.

Рон үүдний хаалгаар орж ирсэн Рита Скитерийг хараад,

- Зөвхөн тэр л дутаж гэнэ дээ! гээд ярвайв.

Сурвалжлагч өнөөдөр шаргал өнгийн жанч өмсөж, урт хумсаа ягаан өнгөөр буджээ. Түүнийг гүзээтэй зурагчин нь дагалдаж явлаа. Скитер хоёр аяга уух юм аваад гурван найзуудаас холгүйхэн суув. Тэрбээр ямар нэг юмны тухай түргэн хөгжилтэйгээр ярилаа.

- Тэр өнөөдөр тийм ч яриа биш байгаа биз, Бозо? Чи яагаад гэж бодож бана? Түүнд яагаад албингууд шаардагдсан юм бол? Маш анхаарал татмаар байгаа биз... Надад ч гэсэн тэгж бодогдсон! Тэр хэзээ ч худал хэлж чаддаггүй юм. Үүнийг жаахан ухаад үзвэл яаж байна? Сурвалжлагаа <<Ид шидийн яамны спорт тоглоомын хэлтсийн дарга Людо Бэгмений шившиг>> гэж нэрлэвэл ямар вэ...

- Ахиад л хэн нэгний амьдралыг сүйрүүлэх гэж байна уу? гэж Харри чанга хэлэв.

Эргэн тойрны хүмүүс эргэж харцгаав. Рита Скитер Харриг олж хараад нүдээ том болгов.

- Харри! Ямар гэнэтийн бэлэг вэ? Бидэнтэй суугаач... гэж баяртайгаар уулга алдлаа.

- Би таньд алхам ч ойртохгүй! Та яаж Хагридын тухай тийм жигшүүртэй юм бичиж зүрхлэв?

Скитер зурагтай хөмсгөө хөдөлгөв.

- Уншигчид үнэнийг мэдэх ёстой, Харри. Би ердөө л өөрийн ажлаа хийсэн юм...

- Тэр хагас аварга биетэн тэгээд юу гэж? Түүнд ямар ч муу зүйл юу ч байхгүй! гэж Харри дүрсхийлээ.

Бааранд чимээгүй болов. Хатагтай Розмерта лангууныхаа ард ангайн зогсоод гартаа барьсан морин шилтэй дарс нь асгарч байлаа.

Скитерийн уруул дээрх инээмсэглэл үл мэдэгхэн чичирснээ ахин томоор инээмсэглэв. Тэрбээр яаран матрын арьсан цүнхээ нээж хуудас цаас, Түргэн бичигч үзгээ гаргаж ирлээ.

- Ярилцлагаа эхлэх үү, Харри? Хагридын тухай яриач. Чи түүний тухай сайн мэддэг юм байна. Том биений цаана юу нуугдаж байна? Бас та нарын тайлбарлаж боломгүй нөхөрлөл? Энэ юу гэсэн үг вэ? Тэр чиний эцгийг орлодог уу?

Гермиона шилэн аягаа гар бөмбөг аятай барин үсрэн бослоо.

- Та бол жигшүүртэй эмэгтэй! Таны шившигтэй сурвалжлагыг уншсан хэн ч хэлнэ. Тэр ч байтугай Людо Бэгмен...

- Суу тэнэг охин минь мэдэхгүй зүйлийнхээ талаар хэзээ ч битгий ярьж бай гэж Скитер Гермионаг сэжигтэйгээр харж хүйтнээр хэлээд,

- Би Людо Бэгмений тухай чиний толгойны үс ургахаас өмнөхөн мэднэ гээд Гермionaгийн өтгөн үс рүү харлаа

- Харри, Рон эндээс явцгаая гэж Гермiona хэллээ.

Гурвуулаа хүмүүсийн хараан дор үүд рүү явцгаалаа. Босгон дээр Харри эргэж харав. Скитерийн Түргэн бичигч үзэг цаасан дээр сараачиж байлаа. Андууд гудамжинд гаран шилтгээн рүү яарлаа.

- Тэр одоо чиний тухай бичиж байна гэж Рон болгоомжлон хэлэв.

- Оролдоод үзэг л дээ! Би түүнд тэнэг охин гэдгээ үзүүлээд өгнө! Өшөөгөө авах л болно доо. Эхлээд Харри дараа нь Хагридын гэж Гермiona уурссандаа чичрэн хэллээ.

- Рита Скитерийг уурлуулах хэрэггүй байсан юм. Тэр үүний төлөө чамайг уучлахгүй гэж Рон сэтгэл зовсон байртай хэлэв.

- Би түүнээс айхгүй байна. Миний эцэг эх шидтэн биш болохоор <<Зөнч>> сонин уншдаггүй. Тийм учраас би нуугдахгүй гээд Гермiona хурдаа нэмэхэд Харри, Рон хоёр арай ядан гүйцлээ.

Тэгтэл Харрид түүний Малфойг алгадахдаа тэгж их уурласан байдал санаанд оров.

- Хагрид түүнээс айх хэрэггүй. Өөр юу олно гэж. Алив та хоёр хөдөлж болохгүй байна уу? Түргэн явцгаая!

Гермiona шилтгээний далавчтай гахай бүхий хаалгаар гүйн ороод Хагридын овоохой руу чиглэв. Харри, Рон хоёр араас нь дагалаа.

Цонхны хөшиг хаалттай хэвээр бөгөөд Соёотын хуцах чимээ сонсогдоно.

- Хагрид! Хагрид онгойлго! Чамайг гэртээ байгааг чинь бид мэдэж байна! Чиний ээж аварга биет байсан эсэх нь ямар ялгаа байна. Новшийн Скитерийг нулимж орхи. Хагрид онгойлгоорой чи... гэж Гермiona үүд балбан хашгирав.

Хаалга нээгдлээ.

- Аль эрт л ингэх байсан... гээд Гермiona чимээгүй боллоо. Босгон дээр Хагридын оронд Альбус Дамблдор зогсож байв.

- Өдрийн мэнд гэж тэр эелдэгээр инээмсэглэв.

- Бид Хагрид дээр ирсэн юм гэж Гермiona дуугарлаа.

- Би тэгж бодсон юмаа. Орох уу? гэж Дамблдор хэлэхэд нүд нь хөгжилтэй гялалзав.

- Өө... тэгэлгүй яахав гэж Гермiona зөвшөөрлөө.

Тэд овоохой руу орцгоов. Соёт галзуурсан юм шиг Харри руу чихээ маажуулахаар ухасхийв. Харри нохойг холдуулаад эргэн тойрноо харав.

Хагрид ширээний ард суугаад хоёр том сэнжтэй аягатай цай тавьжээ. Түүний байдал аймшигтай байлаа. Нүд нь хавдаж царай нь улаан толботой үсний тухайд нь хэлэх ч юм биш. Самнаагүй болохоор овоолсон бухал гэсэн үг.

- Сайн уу, Хагрид гэж Харри хэлэв.

Хагрид толгойгоо өргөөд,

- Сайн уу гэж сөөнгөтөв.

- Ахиад цай хэрэгтэй байх гэж Дамблдор хэлээд шидэт саваагаа агаарт эргэлдүүлэх агшинд ширээн дээр тавиуртай цай, бялуу бий болов. Тэрбээр тавиурыг хоослон бялууг ширээн дээр тавихад бүгд чимээгүйхэн сууцгаав.

- Хагрид чи хатагтай Грэйнджерийн хаалганы ард юу хашгирахыг сонссон биз дээ? гээд Дамблдор инээмсэглэв.

Гермиона улайсан ч Дамблдор инээмсэглэн яриагаа үргэлжлүүлэв.

- Гермионагийн адилаар Харри, Рон хоёр ч гэсэн урьдын нөхөрлөлөө эвдэхгүйн тулд хаалга эвдэхэд бэлэн байна.

- Тэгэлгүй яхав, Хагрид! Чи бидний сайн найз шүү дээ! Энэ муу новшийн Скитер... уучлаарай захирал аа гэж тэр хэлээд Дамблдор руу гэмшингүй харав.

- Би чиний юу хэлснийг сонссонгүй, Харри. Дүлий гээд л бодчих гэж Дамблдор хэлээд хуруугаа оролдон адар руу ширтэв.

- Аан тийм л дээ гээд Харри мэгдэн толгой дохисноо,

- Би зөвхөн... Хагрид чи энэ сурвалжлагчаас болоод биднийг найзлахаа больсон гэж бодоогүй биз дээ? гэв.

Хагридын нүднээс аварга том хоёр нулимс бөмбөрч өтгөн сахал руу нь орлоо.

- Би чамд хэлсэн биз дээ, Хагрид. Би эцэг эхчүүдээс олон захиа авсан. Би чамд тэднийг үзүүлсэн. Тэд өөрсдөө Хогвартет суралцаж байсан болохоор ойлгож байгаа. Чи уншсан. Хэрвээ би одоо чамайг халвал тэд үүнийг... гэж Дамблдор адар ширтсэн хэвээр хэлэв.

- Бүгд биш. Бүгд намайг үлдэхийг хүсэхгүй байгаа.

- Чамайг бүгд хайрлахыг хүлээвэл удаан хугацаанд овоохойдоо хаалттай сууж байх болох нь гэж айж байна. Намайг сургуулийн захирал байх хугацаанд миний ажилд таагүй байгаа тухай захиа ирээгүй нэг ч долоо хоног байгаагүй. Тэгээд би өрөөндөө хэнд ч үзэгдэхгүй нуугдаад суух байсан болж байна уу? гээд Дамблдор хөмсгөө зангидан Хагридыг шилэн дээгүүрээ харлаа.

- Гэхдээ та хагас аварга биетэн биш шүү дээ гэж Хагрид сөөнгөтөв.

- Болно, Хагрид! Харин миний төрөл төрөгсөд хэн билээ? Дурслийн гэр бүл! гэж Харри тэссэнгүй.

- Харж байна уу, Хагрид чамд сайн жишээ боллоо гэж Дамблдор дэмжээд,

- Миний ахыг юу гэх гэж байна? Аберфортыг ямаанд зохимжгүй шившлэг хийсэн гэж буруутгаж байсан юм шүү. Бүх сонинд энэ тухай бичсэн. Тэгээд Аберфортыг бүгдээс нуугдсан гэж бодож байна уу? Ерөөсөө тийм юм болоогүй! Юу ч болоогүй

юм шиг үргэлжлүүлэн ажилласан. Үнэнийг хэлэхэд түүний уншсан эсэхийг мэдэхгүй юм. Энэ... гэв.

- Хагрид сургуульдаа эргэж ирээч. Бид чамайг санаж байна гэж Гермiona хэлэв.

Хагрид шүлсээ залгихад хацрыг нь даган нулимс урслаа. Дамблдор ширээнээс босов.

- Хагрид би чиний гарах тухай өргөдөлд гарын үсэг зурахгүй. Даваа гаригт ажилдаа эргэж ороорой. Найм хагаст чамайг Их танхимд өглөөний цайн дээр хүлээж байя. Ингээд ямар ч татгалзал байхгүй. Баяртай.

Дамблдор салах ёс гүйцэтгээд Соёотын чихийг маажин гарч явлаа. Хагрид палбигар том гараараа нүүрээ хаан енгэнүүлэв. Гермiona түүний мөрийг иллээ. Хагрид гараа нүүрнээсээ холдуулж нулимстай улайсан нүдээр найзуудаа харав.

- Дамблдор... аугаа хүн шүү...

- Энэ ч тодорхой. Би бялуу авч болох уу, Хагрид? гэж Рон хэлэв.

- Тэгэлгүй яахав. Сургуулийн захирлын хэлсэн зөв... Би гэж тэнэг амьтан... Хөгшин эцэг минь миний авирлахыг харсан бол ичих байсан байх даа... Би та нарт эцгийнхээ зургийг үзүүлэх үү? Хүлээж байгаарай гээд Хагрид нулимсаа арчлаа.

Тэр босож хувцасны шүүгээнээс хайрцаг гарган хуучны гандсан гэрэл зураг гаргаж ирэв. Хагридын мөрөн дээр түүнтэй адил нүдтэй жижигхэн шидтэн сууж байлаа. Зураг дээр Хагрид хоёр метр хагас байсан ч сахалгүй цэвэрхэн байгаагаас үзэхэд арван нэгэн наснаас хэтрээгүй бололтой.

- Хогвартет орсныхоо дараа авхуулсан юм. Аав их баярласан даа! Намайг шидтэн хэдий ч авахгүй гэж бодсон юм... ээжээс болоод... Үнэнийг хэлэхэд би шидтэний ухаанд авъяастай байгаагүй... Намайг хөөгдсөний дараа... үхсэнд баярлаж байна... би тэр үед гуравдугаар дамжаанд байсан юм... Дамблдор надад шууд тусалсан. Ойн сахиулаар авсан. Хамгийн гол нь тэр хүмүүст итгэдэг юм. Өөр захирлууд шиг биш. Хүнийхээ хувьд гайхамшигтай авъяастай. Өөрөө ч зохимжгүй гэр бүлээс гаралтай... Гэхдээ одоо энэ хэнд хамаатай юм бэ? Гүжирдсэнд нь баярлаж байна... Тэгэхэд бусад хүмүүс яс томтой гэж ярьж байна. Би ямар байсан түүгээрээ л байх болно. Аав хэлэхдээ хэзээ ч өөрөөсөө битгий ич. Харин үүнийг зөвшөөрөхгүй байгаа хүмүүсийг нулимж орхи гэдэг байсан. Түүний зөв байж. Би бол тэнэг амьтан. Харин тэр яаж байна. Би зөвхөн том ястай гэнээ. Түүний ясыг!

Харри, Рон, Гермiona гурав бие биенээ ичингүйрэн харлаа. Хагридын хатагтай Максимтай ярьсан яриаг сонссоноос хагас зуун соплохвостыг салхилуулсан нь дээр биз. Хагрид мэдээж юу ч ажиглаагүй бололтой.

- Харри би чамайг анх хараад бид адилхан гэж мэдсэн гээд нүдээ гялалзуулан гэрэл зургийг далд хийж,

- Эцэг эх чамд байхгүй. Сургуульд явахаас айж байсан. Харин тэгэхэд одоо өөрийгөө хар л даа! Сургуулийн аврага гээд хэсэг дуугүй болсноо,

- Намайг юу хүсч байгааг мэдэх үү? Тэдэнд үзүүлээд өг. Хож. Чамд цэвэр цус байгаа эсэх нь чухал биш. Төрөл төрөгсдөөсөө хэзээ ч ичих хэрэггүй. Дамблдорын зөв

сургуульд хэн шидтэн авьяастай нь сурах ёсгүй. Ингэхэд чиний лууны өндөг юу болж байна?

- Гайхамшигтай!

Хагридын царайд инээмсэглэл тодорлоо.

- Ухаантай байна! Бүгдэд үзүүлээд өг, Харри! Тэднийг ял.

Хагридад худал хэлэх бусдад худал хэлэхээс ондоо байлаа. Тэр үдэш Харригийн нүдэнд Хагридын аз жаргалтайгаар түүнийг ялна гэж итгэж байсан царай тасралтгүй харагдаж байлаа. Өндөгний тайлагдаагүй таавар зүрхэн дээр нь хүндхэн дарахад маргааш Седрикийн зөвөлгөөг оролдоод үзэхээр шийдэв.

БҮЛЭГ 25: АЛТАН ӨНДӨГ БА ШИДЭТ НҮД

Алтан өндөгний нууцыг тайлахын тулд угаалгын өрөөнд хэр удах нь тодорхойгүй байсан тул Харри хэнд ч харагдахгүйгээр шөнө очихоор шийджээ. Тэр Седрикийн үгийг даган ахлагч нарын угаалгын өрөө рүү явах дургүй байлаа. Тэнд орохыг хэдхэн хүнд л зөвшөөрдөг шүү дээ.

Харри төлөвлөгөөгөө нямбайлан бэлдлээ. Сургуулийн харуулч Филч түүнийг өмнө шөнө барьж байсан удаатай болохоор ийм явдал ахин давтагдахыг хүссэнгүй. Хамгийн гол нь үл үзэгдэх цув болон Тонуулчны газрын зураг байгаа болохоор дүрэм зөрчихөд тийм ч аюултай биш байв. Газрын зураг дээр сургуулийн бүх нууц гарц хонгилд харагддаг бөгөөд шилтгээн дотуур явж байгаа хүмүүсийг төлөөлсөн цэгэн дээр нэр нь гардаг юм. Цэг угаалгын өрүү рүү ойртож Харрид угаалгын өрөө рүү хэн нэгэн ойртон ирж байгааг сануулах болно.

Пүрэв гаригийн орой Харри унтлагын өрөөнөөсөө үл үзэгдэх цуваа өмсөн яаран гараад лууны тэмцээнд орж байсан үеийнх шигээ амралтын өрөөнд орж хүлээв. Энэ удаад гаднаас амралтын өрөө рүү Рон нууц үг (гадилын бялуу) хэлэн орж ирлээ.

- Амжилт хүсье гэж тэр шивнээд амралтын өрөөнд ороход Харри үзэгдэлгүй дэргэдүүр нь өнгөрөн ахлагч нарын угаалгын өрөө лүү явлаа.

Гартаа хүнд өндөг бариад шидэт газрын зураг ширтэн дээгүүрээ нөмрөгтэй явах хэцүү байлаа. Аз болоход сарны гэрэлтэй хонгил хүнгүй хоосон байсан бөгөөд ямар ч аюул тохиолдсонгүй. Харри Борис Бестолковогийн гартаа бээлийтэй гайхширан зогсож байгаа хөшөө рүү дөхөж очоод хэрэгтэй хаалгаа тоолон Седрикийн зөвлөсөн “шинэхэн нарс” гэдэг нууц үгийг хэллээ.

Хаалга чахран онгойлоо. Харри угаалгын өрөө лүү ороод хаалгаа хааж үл үзэгдэх цуваа тайлан ийш тийшээ харлаа.

Ахлагч нарын угаалгын өрөө цагаан гантигаар хийсэн сүр жавхлантай уужим өрөө байлаа. Адраас сайхан лааны суурь бүхий гэрлийн бүрхүүл унжина. Өрөөний голд тэгш өнцөгт хэлбэртэй гантиг усан сан байх бөгөөд хөвөөгөөр нь ойролцоогоор зуугаад ширхэг янз бүрийн өнгийн бариултай алтан цорго байлаа. Хажууд нь үсэрдэг тавцан харагдана. Цонхонд шал хүртэл унжсан урт цагаан ёрог даавуун хөшиг байх бөгөөд буланд нүүр гарын алчуур хураалттай байв. Хананд лусын дагина хадан дээр унтаж байгааг дүрсэлсэн алтан жаазтай зураг байх агаад цайвар үс нь амьсгалах тоолонд намирна.

Харри усан сан руу очин ийш тийшээ явж үзэв. Сүр жавхлантай угаалгын өрөөнд цорго онгойлгож болох ч Седрик түүгээр тоглож гэж Харри бодов. Угаалгын өрөөнд алтан өндөгний нууцыг яаж тайлах юм бэ? Гэхдээ нэгэнт ирсэн болохоор унтууцан нүүр гарын алчуур авч жанч, газрын зураг, өндгөө усан сангийн ирмэг дээр тавиад өвдөглөн хэдэн гоожуур нээлээ.

Гоожуураас янз бүрийн хөөстэй ус гоожив. Тийм хөөснүүдийг Харри амьдралдаа харж байсангүй. Нэг цоргоноос хөл бөмбөгийн хэмжээтэй ягаан, цэнхэр хөөс гарч байхад өөр нэгээс цас шиг зузаан дээр нь хэвтэж болохоор хөөс гарч байлаа. Гурав

дахь цоргоноос ангилам үнэртэй ягаан үүл шиг хөөс гарч алгуур усан дээгүүр хөвөв. Харри гоожуурыг хаагаад янз бүрийн өнгөтэй хөөсийг харж сонирхлоо. Ялангуяа усны гадаргуу дээр байгаа том нуман хэлбэртэй хөөс түүнд таалагдав. Уужим усан санд бүлээн ус түргэн дүүрэхэд хөөснүүд хэлбэр хэмжээгээ өөрчлөв. Харри цоргонуудыг хаагаад хүрэм, шаахайгаа тайлж усанд болгоомжтой оров.

Усан сан хангалттай гүнзгий байлаа. Тэр усан дотуур хэдэн удаа хөвөөд өндөг рүү эргэж ирэн бодлогоширов. Янз бүрийн өнгийн хөөстэй дулаахан усан дотор зогсоод таавар таах таатай байсан ч ямар нэгэн санаа орж ирсэнгүй.

Харри хөөсөн дээгүүр гараа сунгаж өндөгийг аваад нээлээ. Танил чарлаан угаалгын өрөөнд дүүрч гантиг хананд цуурайтан учрыг нь олохын аргагүй юм боллоо! Харри өндөгийг түргэхэн хаагаад Филч сонсчихоогүй байгаа даа гэж түгшлээ. Үнэхээр Седрик даажигнасан байвал яана гэж почирдон бодтол өндөг гараас нь мултарч шалан дээр унаад хана цохилоо.

- Би чиний оронд байсан бол өндгөө усанд хийх байсан даа гэх хэн нэгний хоолой сонсогдов.

Харри огт санаандгүй байсандаа хөөс залгичихлаа. Босоод хартал дүнсгэр хий үзэгдэл охин хөлөө ачаад цоргон дээр сууж байв. Энэ бол уйланхай Миртл байв. Тэр гурван давхарын жорлонд амьдардаг бөгөөд үргэлж уйлж байдаг ч гэнэтхэн ахлагч нарын угаалгын өрөөнд ороод иржээ.

- Миртл чи юу? Би бараг нүцгэн байна шүү дээ! гэж Харри уурслаа.

Өтгөн хөөсөн дотор юу ч харах боломжгүй байсан ч Харри яагаад ч юм Миртл түүнийг гоожуур дээр суугаад харж байсан гэж боджээ.

- Би чамайг усан сан руу ормогц нүдээ аньсан. Чи бараг зуун жил над дээр ирсэнгүй гэж Миртл хэлээд зузаан шилнийхээ цаана нүдээ анивчив.

- Гэхдээ би чиний жорлон руу орж болохгүй. Тэр чинь охидынх шүү дээ гээд Харри яльгүй доошлон толгойгоо цухуйлгав.

- Чи өмнө нь тоодоггүй л байсан биз дээ. Үргэлж ирдэг байсан! гэж Миртл золгүй хэлэв.

Миртл үнэн хэлжээ. Харри, Рон, Гермiona гурав урьд нь нууцаар хориотой Хувиргагч уусмал чанаж байхдаа үргэлж Миртлийн жорлонд очдог байсан юм. Түнийг уугаад Харри, Рон хоёр цагийн хугацаатай Крэбб, Гойл хоёрын дүрд хувиран Слизериний амралтын өрөөнд орсон билээ.

- Намайг үүний төлөө зэмлэсэн. Тэгээд л би тийшээ буцаж очихгүй байх нь дээр гэж бодлоо хэмээн Харри хэлэв.

- Өө, тэгвэл ч яахав. Харин өндгөө усанд хийх хэрэгтэй. Седрик Диггори тэгж хийсэн гэж уйланхай Миртл эрүүн дээрх батгаа шахангаа дүнсгэр хэлэв.

- Чи түүнийг тагнаа юу? Энд орой болгон байж ахлагч нарын шумбахыг хардаг юм биш биз дээ? гээд Харри үрчийлээ.

- Заримдаа. Гэхдээ би нэг ч удаа гоожуур дээр сууж хэнтэй ч ярьж байгаагүй гэж Миртл зальжин хэлэв.

- Хүндэтгэсэн явдалд баярлалаа. Нүдээ аниад хэлэх хүртэл битгий нээгээрэй.

Миртл нүдний шилээ алгаараа дарахад Харри усан сангаас гарч алчуур бүсэлхийгээрээ уяад алтан өндгөө авлаа. Ингээд ахиад л усан санд оров.

- Одоо наадхаа усан дор онгойлго гэж Миртл Харриг хурууны завсраараа харж зөвлөв.

Харри өндгөө усанд хийж онгойлголоо. Өндөг орилсонгүй түүнээс Харрийн учрыг нь олохооргүй дуу сонсогдов.

- Чи өөрөө усан дороо ор гэж Миртл тушаав.

Харри гүнзгий амьсгалаад гантиг шалан дээр сууж өндгийг нээн найрал дууг сонсоход нуруу нь ирвэгнэлээ.

Бидний хоолой хаана сонсогдохыг олоорой

Тэнд зөвхөн биднээс гадна загас л бий

Бидний юу авсныг хайж олоорой

Бид чиний хамгийн үнэтэй зүйлийг авсан

Түргэн хай чамд цагийн хугацаа байгаа

Тэгээд бидний хулгайлсан зүйл рүү буцаж ир

Энэ замыг эрслэн сонгосон бол

Цагаас хэтэрвэл ирэхгүй гэдгийг санаарай

Харри усан дороос хөөс яран гараад үсээ сэгсэрлээ.

- За яасан сонсов уу? гэж Миртл сониучирхав.

Тиймээ. <<Бидний хоолой хаана сонсогдохыг олоорой. Тэнд зөвхөн биднээс гадна загас л бий...>> Ахиад нэг сонсох хэрэгтэй байна гээд Харри ахиад гүнзгий амьсгал аван усан дор умбалаа.

Тэр ахиад гурван удаа сонсож алтан өндөг доторх дууны үгийг тогтоолоо. Усан дороос толгойгоо цухуйлгав. Миртл гоожуур дээр суугаад түүнийг чимээгүй харна.

- Хм... газар дээр хоолойг нь сонсох боломжгүй хүмүүсийг хайх юм болов уу? Энэ хэн байж болох вэ? гэж Харри асуув.

- Удаан бодлоо шүү гэж Миртл баясав.

Тэгэхэд Харри уйланхай Миртлийг зөвхөн Гермiona Хувиргагч уусмал уугаад сүүлтэй болж нүүрэнд нь муурны үс ургахад баясан хөөрч байсныг санав. Харри угаалгын өрөөг харлаа. Усан дор сонссон хоолой хаа нэгтээ амьдардаг усны амьтдын тухай хэлсэн байх. Харри таавраа Миртлд хэлэв.

- Диггори таасан. Хэвтээд бодоод л байсан, бодоод л байсан. Бараг зуун жил усны бүх хөөс алга болтол бодсон.

- Усан дор... усан дор... Миртл чи нууранд аварга том наймаалжаас өөр хэн амьдардагыг мэдэх үү?

- Бүх төрлийн амьтад. Би заримдаа нууранд сэлдэг юм. Хэн нэгэн миний жорлонгын усыг татчихвал сонголтгүй сэлэх хэрэгтэй болдог.

Харри уйланхай Миртлийг усны хоолойгоор жорлон руу яаж нисэж орж байсныг төсөөлөөд,

- Тэнд хүний хэлээр ярьдаг хэн нэгэн амьдардаг юм уу? Хүлээгээрэй, хүлээгээрэй...

Харрийн харц угаалгын өрөөний цорын ганц зураг дээр тусав.

- Лусын дагина нууранд байдаг юм уу?

- Өө, маш сайн байна! Диггоригоос түргэн бодож оллоо. Харин тэр унталгүй хөхрөөд л сүүлээ даллаж байдаг юм гээд Миртл дургүйхэн лусын дагина руу толгой дохив.

- Аан! Тэгэхээр хоёр дахь тэмцээн нууран дотор усны хүмүүсийн дэргэд юм байх байхнээ... гэж Харри баяртайяа дуу алдав.

Харри гэнэтхэн юу хэлснээ ойлготол баяр хөөр нь бөхөв. Тэр бараг сэлж чадахгүй. Дадли чаддаг ч харин тэр чадахгүй. Петунья эгч, Вернон ах хоёр түүнийг ганц өдрийн дотор живнэ гэж бодсон байх. Усан сангийн хана бол нэг хэрэг ч, гүнзгий том нуур бол өөр хэрэг! Бас усан дор өөр амьтад амьдардаг...

- Тэнд яаж амьсгалах вэ? гэж Харри сэтгэлээр унан асуулаа.

Миртлийн нүдэнд гэнэтхэн нулимс мэлтрэв.

- Ямар бүдүүлэг юм бэ! гээд тэр халааснаасаа нусны алчуур гаргаж ирэв.

- Бүдүүлэг гэнээ? гээд Харри ойлгосонгүй.

- Мэдээж шүү дээ! Яаж амьсгалах гэнэ үү? Надад хэлж байгаа юм уу? гэж Миртл угаалгын өрөөгөөр нэг орилоод,

- Би... амьсгалаагүй... бараг зуун жил... гээд нүүрээ алчуураар даран чанга нусаа нийлээ.

Харри Миртл үхсэн тухайгаа яриа гарахад маш их гомддогийг санах. Өөр хий үзэгдэл бол тэгж их гомдохгүй дээ.

- Уучлаарай, би хүсээгүй... Би мартчихаж...

- Өө, тийм л дээ Миртлийн үхсэнийг маш амархан мартаж юм. Намайг амьд байхад бүгд мартдаг байсан. Үхээд цаг болоход миний биеийг хэн ч эрээгүй. Би тэнд суугаад хүлээж байсан болохоор мэднэ. Оливия Хорнби жорлонд орж ирээд <<Ахиад л чи энд байна уу, дүнсгэр Миртл? Профессор Диппет чамайг надаас асуусан...>> гэж хашгираад гэнэтхэн миний биеийг харсан... өө, тэр үүнийг удтал мартаж чадаагүй байх гэдэгт би итгэлтэй байна. Заримдаа би түүнд өөрийгөө

сануулахын тулд дагадаг байлаа. Би түүний ахын хуриман дээр байснаа санаж байна...

Харри Миртлийн үгийг сонсолгүй лусын дагины дууны тухай бодож байлаа. Тэд <<бид чиний хамгийн үнэтэй зүйлийг авсан>> гэж дуулсан. Тэгэхээр тэд ямар нэгэн зүйл хулгайлж түүнийг эргүүлж авчирах хэрэгтэй байх нь. Тэд юу авсан юм бол?

- ...тэр ид шидийн яаманд намайг дагахыг болиулахын тулд очсон. Би түүнээс хойш жорлонд амьдрах болсон юм даа.

- За. Надад ойлгомжтой боллоо. Нүдээ ань даа би гарлаа гэж Харри хэлэв.

Тэр усан сангийн ёроолоос өндгөө аваад алчуураар сайтар арчин хүрмээ өмсөж үл үзэгдэх цуваа авлаа.

- Чи миний жорлонд ирж байх уу? гэж Миртл гунигтай асуув.

- Тэгж байгаад очно... Баяртай, Миртл. Тусалсанд баярлалаа гэж Харри хэлээд Миртлийн жорлонд зочлохоос өмнө шилтгээний жорлонгууд хаагдах байх гэж бодлоо. Ингээд үл үзэгдэх цуваа нөмөрлөө.

- Баяртай гээд Миртл гоожуур руу буцаж оров.

Харри харанхуй хонгилд гараад газрын зургаа харан хэн нэгэн ойртож байгаа эсэхийг шалгав. Филч болон, хатагтай Норрисийн нэр өрөөндөө байв. Шагналын танхимд байгаа хий үзэгдэл Пивзээс бусад нь унтаж байлаа. Харри цамхаг руугаа явах замдаа гэнэтхэн газрын зураг дээр ямар нэг хөдөлгөөн орохыг харлаа.

Северус Снеггийн өрөөний зүүн талд Бартемиус Крауч гэсэн нэр бүхий цэг гарав. Харри газрын зургийг ойртуулан харлаа. Ноён Крауч өвдсөн бөгөөд ажилдаа ч явахгүй, бүжигт үдэшлэгт ч ирээгүй билээ. Тэр шөнийн цагаар Хогвартст юу хийж байгаа юм бол? Цэг өрөөн дотор холхин нэг булангаас нөгөөд зогсож байлаа.

Харри шийдвэргүйхэн удааширч сониучирхан харав. Тэр ойролцоох шат руу очоод уруудав. Ноён Краучын ухаанд юу орсон юм бол?

Харри чимээгүйхэн шатаар буухад хүрэмнийх нь шаржигнах болон гишгүүр хяхтнах дуунаар зарим хөргүүд сэрж ууртайгаар харж байлаа. Замын хагаст Харри хөрөг түлхэн онгойлгоод нарийхан шатаар хоёр давхар руу буулаа. Ахиад л газрын зураг руу хараад гайхлаа. Ноён Крауч шөнийн цагаар бусдын өрөөнд юу хийж байгаа юм бол?

Харри доошоо уруудахдаа нэг хөлөө нүхэнд хийчихлээ. Түүнийг ноён Краучын хачирхалтай гарч ирэлт эзэмдсэн байсан болохоор урд нь Невиллийн бүдэрч байсан хуурамч гишгүүрийг мартсан байв. Харри хөлөө авахыг эв дүйгүйхэн оролдтол алтан өндөг нь чийгтэй байсан болохоор хазайгаад яах ийхийн зуургүй гишгүүр даган хэн нэгэн том бөмбөр нүдэж байгаа аятай өнхөрлөө. Үл үзэгдэх цув мөрнөөс нь гулгахад Харри амжин барьж авах гэтэл Тонуулчны газрын зураг гараас нь мултраад доошоо өнхрөн зургаан гишгүүрийн дор тогтов. Харрийн өвдөг нүхэнд орсон болохоор газрын зурагт хүрсэнгүй.

Алтан өндөг гишгүүр даган хүчтэй өнхөрч хөрөг түлхэн онгойлгоод хонгилоор нэг чарлав. Харри шидэт саваагаа аван газрын зурганд хүрэх гэсэн ч хэтэрхий хол болохоор хүрч чадсангүй.

Нөмрөгөө дээгүүрээ нөмөрч юу болохыг хүлээн айсандаа хөшлөө.

- ПИВЗ!!! гэх хоолой сонсогдов.

Сургуулийн харуул Филч андаа гарчээ. Тэр хол байсан ч Харри түргэн гүйж ирэх хөлийн чимээ болон сөөнгө ууртай хоолойг нь сонсож байв.

- Энэ юун чимээ шуугиан бэ? Бүх шилтгээнийг сэрээх гээ юу! Би чамайг гүйцнээ, Пивз! Өө, гүйцнэ! Энэ одоо юу вэ?

Хөлийн чимээ нам гүм болж метал жингэнэхэд өндөгний орилоон зогсов. Филч өндөгийг авч ойртуулан харлаа. Харри хөдөлгөөнгүй зогсоод сонсож байлаа. Филч нууц хаалгаар гарч ирээд Пивзийг хайх болно... Пивз тэнд байхгүй... Тэр шатаар өгсөхөд Тонуулчны газрын зураг байх болно... Тэгвэл үл үзэгдэх цув ч аврахгүй. Филч газрын зургийг хараад Харри Поттер нэртэй цэг хаана зогсож байгааг харах болно.

- Муурхан минь, алтан өндгийг хардаа (хатагтай Норрис дэргэд нь байлаа). Энэ чинь хоёр дахь тэмцээний даалгавар байна! Нэг аваргынх нь өндөг байна!

Харрийн зүрхний цохилт түргэхэд нүд нь харанхуйлав.

- ПИВЗ! Хулгайч минь гараад ир! гэж Филч баясан орилов.

Тэр хөргөөр шурган гарч ирэхэд Харри түүний бүлтгэр нүдийг харлаа. Филч дээшээ харсан ч хэнийг ч харсангүй.

- Нуугдчихсан уу? Зүгээр дээ би чамайг гүйцнэ, Пивз. Тэмцээний аваргын өндөгийг хулгайлна гэнээ. Одоо л Дамблдорoor чамайг хөөлгөх болно! Гараад ир өөдгүй хулгайч хий үзэгдэл минь!

Филч шатаар өгсөхөд түүний тосон саарал зүстэй туранхай саарал муур дэргэд нь явж байлаа. Хатагтай Норрисийн гэрэлтсэн хоёр нүд Харри руу харав. Түүний толгойд ахиад л муур үл үзэгдэх цувьг нэвт харчих болов уу гэсэн бодол төрөв. Хуучин халат өмссөн Филч улам ойртсоор байлаа. Харри хөлөө нүхнээс авах цөхөрсөн оролдлого хийсэн ч улам гүнд шигтгэлээ. Филч газрын зургийг олох юм бол муу юм болно.

- Филч? Юу болоод байна?

Ойртон ирэх хөлийн чимээг сонсоод Харри, Филч хоёр эргэж харав. Шатны доод талд Харрийн Филчээс ч илүү айдаг Северус Снегг зогсож байв. Тэр саяхан орноосоо боссон бололтой унтлагын урт цамцтай уурссан нохой шиг зогсож байлаа.

- Пивз энэ өндөгийг доош нь өнхөрүүлсэн юм, профессор гэж Филч хорлонтой шивнэлээ.

Снегг шатаар Филч рүү гүйв. Харрийн зүрх галзуурсан мэт цохилоход шүдээ зуулаа.

- Пивз гэнээ? Гэхдээ Пивз миний өрөөнөөс авч чадахгүй гээд Снегг Филчийн гарт байгаа өндөг рүү харав.

- Өндөг таны өрөөнд байсан юм уу, профессор?

- Мэдээж үгүй! Би шатаар юм өнхрөх болон орилох чимээ сонсоод... гэж Снегг зандарлаа.

- Тиймээ, профессор энэ өндөг өнхөрсөн юм...

- Явж шалгах хэрэгтэй...

- Түүнийг Пивз унагасан...

- Би замдаа миний өрөөнд бамбар асаж шүүгээний үүд дутуу онгойсон байхыг харлаа. Хэн нэгэн тэнд юм эрж байж!

- Гэхдээ Пивз чадахгүй...

- Мэдээж чадахгүй! Би өрөөгөө шившлэгээр лацадсан болохоор зөвхөн шидтэн л орж чадна! Филч явж урилгагүй зочныг эрж олцгооё гээд Снегг дээшээ Харриг нэвт харлаа.

- Профессор би хүсэхдээ...

Филч Пивзийг буланд шахах сайхан боломжыг алдаж байгаадаа харамсангуй байртай Харрийг нэвт харлаа. <<Яв. Снеггтэй яв! Гуйя>> гэж Харри бодлоо. Хатагтай Норрис эзнийхээ хөлд байв. Түүнийг бараг үнэрлэсэн байх даа... Тэр яах гэж усан санд анхилам үнэртэй хөөс хэрэглэсэн юм бол?

- Профессор Пивз сурагчын юмыг хулгайлсан. Одоо л захирал намайг сонсож үзэшгүй муухай хий үзэгдлийг шилтгээнээс хөөх болно... гэж Филч гонгинов.

- Таны үл бүтэх хий үзэгдэлээс чинь илүү миний өрөөнд хулгай орчихоод байна...

Доор модон хөлийн чимээ сонсогдов.

Снегг яриагаа огцом зогсоолоо. Тэд хоёулаа доошоо харав. Тэдний толгой дээгүүр Харри хазгар Грюмыг харлаа. Хурц нүдэт хөргийн цаанаас гарч ирэхдээ унтлагын цамцан дээгүүрээ аяны жанчаа углаж таягаа тулсан байлаа.

- Унтлагын хувцастай цугларалт уу? гэж Грюм инээвхийлэв.

- Профессор Снегг бид хоёр чимээ сонслоо. Хий үзэгдэл Пивз ямагт танхайрч байдаг юм. Харин профессор Снеггийн өрөөнөөс хэн нэгэн хүн юм хулгайлсан...

- Амаа хамхи! гэж Снегг шивнэлээ.

Грюм шат руу гарч ирээд шидэт нүдээрээ Снеггийг дараа нь Харрийг харлаа.

Харрийн зүрх аймшигтай цохилгов. Грюм үл үзэгдэх цувьг нэвт хардаг! Ер бусын хачирхалтай дүр зураг төсөөлөгдөв. Снегг унтлагын цамцтайгаа, Филч гартаа алтан өндөгтэй, харин Харри хөлөө нүхэнд шургуулчихаад зогсож байдаг. Грюмын амнаас гайхсан авиа гарлаа. Хэдэн секундэд турш Харри тэр бие бие рүүгээ ширтэв. Дараа нь Грюмын шидэт нүд Снегг рүү харлаа.

- Би зөв сонсов уу? Хэн нэгэн таны өрөөнд байсан хэрэг үү, Снегг?

- Энэ чухал биш гэж Снегг хүйтнээр хэлэв.

- Эсрэгээрээ маш чухал. Хэн таны өрөөг ухахыг хүсдэг билээ?

- Ямар нэгэн сурагч л байх. Энэ анхны удаагаа тохиолдож байгаа юм биш. Миний уусмалын хувийн нөөцнөөс авсан байсан. Хууль бус уусмал чанах гэж байгаа биз хэмээн Снегг нүдээ гялалзуулан хэлэв.

- Уусмалын нөөц гэнээ? Магадгүй та өрөөндөө өөр юм нууж байсан юм биш биз?

Снеггийн царайны өнгө хатуурч чамархайны судас нь гүрэлзээд,

- Грюм та намайг юу ч нуугаагүй гэдгийг сайн мэдэж байгаа. Та миний өрөөг нэгжиж болно гэж заналхийлсэн өнгөөр хэлэв.

Грюм гашуунаар инээмсэглэв.

- Мракоборец л тийм эрхтэй байдаг юм, Снегг. Дамблдор надад тушаахдаа...

- Дамблдор надад итгэдэг. Би тэр таньд үүнийг тушаасан гэдгийг итгэхгүй байна гэж Снегг шүд зуун хэлэв.

- Мэдээж Дамблдор итгэдэг. Тэр ер нь хүмүүст итгэдэг. Тэдэнд шинэ амьдрал эхлэх боломж олгодог. Харин би толбо байгааг ажиглахгүй өнгөрч чадахгүй нь. Намайг юуны тухай ярьж байгааг ойлгож байна уу?

Снегг гэнэтхэн маш хачирхалтай үйлдэл хийлээ. Тэр зүүн бугуйгаа хүчтэй өвдсөн аятай баруун гараараа шүүрч авав.

- Явж унт, Снегг гээд Грюм инээмсэглэв.

- Хэн ч таньд надад тушаах эрх өгөөгүй! Би зөв гэж үзэж байгаа бол шөнөжингөө сургууль дотуур явах болно гэж Снегг өөртөө уурсан байртай гараа буулгаад хэлэв.

- Тэгвэл яв даа Грюм заналхийлэл дүүрэн хоолойгоор хэлээд,

- Харанхуй хонгилд ахиад тулгарах байлгүй... Ингэхэд тэнд юу байна вэ?

Грюм Тонуулчны газрын зураг руу заахад Харри айдаст автлаа. Снегг, Филч хоёр зэрэг эргэж харахад Харри цөхөрсөн алхам хийж нөмрөгөө сөхөн Грюм рүү даллан өөрийгөө заагаад,

- Энэ минийх! Минийх! гэж дохив.

Снеггийн царай өөрчлөгдөн ойлгосон шинж тодров.

- Акцио цаас!

Газрын зураг Снеггийн хуруунаас мулт үсэрч Грюмын гарт орлоо.

- Уучлаарай, алдаа болжээ. Энэ минийх. Санамсаргүй гээсэн юм...

Снеггийн хар нүд Грюмын гарт байгаа газрын зураг руу нэг харснаа, Филчийн гарт байгаа өндөг рүү харж гэнэт...

- Поттер гэж шүдний завсраар сийгүүлэв.

- Юу гэнээ? гээд Грюм газрын зургийг халаасандаа хийлээ.

- Поттер! Энэ өндөг бол Поттерынх. Би түүний цаасыг мэднэ. Тэр бас Поттерт байсан. Тэр хаа нэгтээ энд байгаа! Үл үзэгдэх цувтай! гээд Снегг Харрийн байгаа газар луу түүнийг харж байгаа аятай ширтлээ.

Снегг сохор хүн шиг гараа сунган дээшээ алгуур өгсөхдөө Харрийг үнэрлэх гэж байгаа аятай хамраараа шиншлээ. Снеггийн хурууны үзүүр хүрэх шахахад Харри хойшоо болов...

- Тэнд хэн ч байхгүй, Снегг! Гэхдээ би захиралд баяртайгаар таны ухаанд шууд Харри Поттерын нэр орж ирсэн гэдгийг мэдэгдэнэ гэж Грюм хашгирав.

- Тэгээд юу гэж? гээд Снегг эргэж харахад гар нь Харригийн цээжнээс хэдхэн инчийн зайд хөшсөн ч буулгасангүй.

- Дамблдор хэн Поттерт шүдээ зуудагийг мэдэж аваг. Бас надад сонирхолтой байна л даа гээд Грюм шатаар хазганан өгсөхөд бамбарын бүдэг гэрэл зэрэмдэг царай дээр нь тусаж хамар нь бүр аймшигтай харагдав.

Хормын турш бүгд дуугүй боллоо. Снегг удаанаар гараа буулгав. Харри түүний царайг харсангүй.

- Би зүгээр л тэгж бодсон юм. Поттерыг ахиад шөнийн цагаар тэнэж байна гэж... Тийм явдал түүний хувьд дасал болсон зүйл... Түүнийгээ зогсоох ёстой... өөрийнхөө аюулгүй байдлын тулд гэж Снегг хүчээр тайван хэлэв.

- Поттерт түгшсэн гэнээ! Тийм байж...

Ахиад хормын турш Снегг, Грюм хоёр бие биенээ чимээгүй ширтэв. Хатагтай Норис усан сангийн анхилам үнэрийг аваад толгойгоо эргүүлэн чанга дуугарав.

- Би явж унтлаа гэж Снегг гашуунаар хэлэв.

- Энэ шөнө төрсөн хамгийн сайхан санаа байна. Филч, одоо надад өндгөө өгдөө гэж Грюм хэллээ.

- Өгөхгүй! Энэ бол Пивзийн тэрслүү явдлын нотолгоо, профессор Грюм гээд Филч өндөгийг хайртай хүү шигээ тэвэрлээ.

- Энэ бол тэмцээний оролцогчын өндөг. Надад түүнийг өг. Одоохон!

Снегг нэг ч үг хэлэлгүй шатаар уруудаад Грюмын дэргэдүүр өнгөрөв. Филч хатагтай Норрисыг дуудахад Харри руу харж байсан муур эзэн рүүгээ гүйв. Харри хүндээр амьсгаадан Снегг явахыг сонслоо. Филч Грюмд өндгөө өгөөд муурынхаа араас явлаа.

- Зүгээр дээ, муурхан минь өглөө хоёулаа Дамблдор дээр орж Пивзийн тухай бүхнийг хэлэх болно...

Хаалга хаагдав. Харри таягаа чанга атган хүндхэн мацах Грюм руу харлаа.

- Поттер арай гэж мултрав уу?

- Тиймээ... таньд баярлалаа гэж Харри тамирдан хэлэв.

- Энэ юу вэ? гээд Грюм халааснаасаа Тонуулчны газрын зургийг гаргаж ирэв.

- Шилтгээний газрын зураг гээд Харри Грюм түүнийг шатны нүхнээс гаргах байх гэж найдав. Хөл нь хүчтэй өвдөж байлаа.

- Мерлины сахлаар андгайлъя. Үгүй ээ, Поттер энэ бол шилтгээний ердийн зураг биш гэж Грюм шивнээд зураг руу харахад шидэт нүд нь шугам дээр тусав.

- Ер нь бол ашигтай эд. Профессор Грюм та намайг гарахад туслахгүй юу? гээд Харри өвдсөндөө нүдэнд нь нулимс цийлэгнэлээ.

- Юу? Аан, тийм л дээ...

Грюм Харрийн гараас татаад хөлийг нь нүхнээс сугалахад Харри дээшээ өгсөн зогслоо.

Грюм газрын зургаас нүд салгасангүй.

- Сонсооч, Поттер чи хэн нэгэн Снеггийн өрөө рүү орохыг харсан юм биш биз? Газрын зураг дээр юм харагдсан уу?

- Харсан. Ноён Крауч гэж Харри үнэнээ хэлэв.

Шидэт нүд газрын зургийг нэгжлээ. Грюм үнэхээр түгшив бололтой.

- Крауч гэнээ? Чи алдаагүй биз дээ?

- Үгүй.

- Шилтгээнд тэр байхгүй байна. Хм... Крауч гэнээ... маш сонирхолтой юм...

Ахин нэг хормын турш Грюм газрын зургийг чимээгүйхэн ширтлээ. Энэ мэдээ түүнд нэг санаа төрүүлэх шиг болсонд Харри юу болохыг мэдэхийг хүслээ. Асууж болох болов уу үгүй болов уу? Харри Грюм түүнд айдас төрүүлж байгаа ч... томхон таагүй явдлаас гарахад тусласан болохыг мэдэж байв...

- Профессор Грюм, яагаад ноён Крауч профессор Снеггийн өрөөнд орохыг хүссэн юм бол?

Грюмын шидэт нүд газрын зурагнаас салж Харри руу харлаа. Грюм түүнийг нэвт харангаа хэлэх эсэхээ шийдэж ядах шиг санагдав.

- Би ингэж хариулмаар байна, Поттер. Хөгшин Хурц нүдэттэй харьцуулахад зөвхөн Барти Крауч л зөвхөн хар шидтэнийг барих талаар л боддог юм.

Тэр ахин газрын зураг руу харав. Гэхдээ Харри үүнд тайвширсангүй.

- Профессор Грюм, энэ ноён Крауч ямар нэг юм сэжиглэсэн байж болох уу...

- Тэр юу сэжиглэсэн гэж?

Хэлэх үү! Грюмд Харри шилтгээний нууцыг хэлэн мэдээллийг гадагш гарахыг хүссэнгүй. Магадгүй Сириусын тухай ярих хэрэг гарна...

- Мэдэхгүй. Сүүлийн үед олон ойлгомжгүй явдал болоод байна. <<Зөнч>> сонинд энэ тухай бичсэн. Хар тамга Дэлхийн цомын тэмцээн дээр илгээсэн, Үхэл залгигчид гээд л...

Грюмын хоёр нүд том нээгдэв.

- Чи ухаалаг хүү байна, Поттер гээд түүний шидэт нүд газрын зураг руу шилжив.

- Крауч магадгүй ингэж бодсон байж мэднэ. Туйлын магадгүй юм. Сүүлийн үеийн зарим нэг Скитерийн тусламжтай цуу яриагаар бол... Олон хүмүүс айж байгаа гээд тэр инээвхийлэв.

- Хэрвээ би ямар нэгэн юм үзэн ядах ёстой бол Үхэл залгигчдийн эрх чөлөөтэй явж байгааг л үзэн ядах байна гэж тэр бувтнаад зурагны зүүн дээд булан руу харав.

Харри Грюм рүү гайхширан харав. Тэр үнэхээр Харрийн бодож байгаа зүйлийг бодлоо гэж үү?

- Харин одоо Поттер чамаас асуух зүйл байна гэж Грюм ажил хэрэгч өнгөөр хэлэв.

Харри сэтгэлээр уналаа. Одоо Грюм түүнээс энэ газрын зургийг хаанаас авсныг асуух байх даа. Үүнийг гарт нь орсон тухай ярьвал бүхэл бүтэн түүх болно. Түүнд өөрийнх нь эцэг нь, Фред Жорж хоёр, хар урлагаас хамгаалах хичээлийн сүүлийн багш профессор Люпин нар оролцсон. Харри асуултаас зайлсхийхийн тулд анхаарлаа төвлөрүүлэв. Грюм зургийг өмнүүр нь даллаад,

- Би үүнийг түр ашиглаж болох уу? гэв.

- Тэгэлгүй яахав! гэж Харри баярлав. Түүнийг хаанаас авсныг асуугаагүйд санаа амарсан ч Грюм түүнд тусалсан болохоор өртэй үлдлээ.

- Баярлалаа, Харри. Тэр надад их хэрэг болно. Би түүгээр... Харин одоо, Поттер орлуугаа гэж Грюм сөөнгөтөв.

Тэд хамтдаа шатаар өгсөв. Грюм дэлхий дээр газрын зурагнаас өөр юу ч байхгүй мэт харц салгасангүй. Чимээгүйхэн яваад өрөөнийхөө үүдэнд хүрсний дараа Грюм зогсоод Харри руу харав.

- Поттер чиний толгойд мракоборец болох бодол орж байв уу?

- Үгүй гээд Харри гайхан түүн рүү харав.

- Энэ тухай бодоод үзээрэй. Сайн бодоорой... Ингэхэд чи өндөг аваад шилтгээн дотуур зүгээр нэг зугаалж байсан хэрэг биш биз дээ?

- Аан биш дээ. Би өндөгний тааврыг таах гэж байсан юм гээд Харри инээмсэглэв.

Грюм түүн рүү ирмэхэд шидэт нүд нь ахин зураг дээр тусав.

- Шөнийн зугаалгаас өөр юу ч санаа өгөхгүй. Тийм биз дээ, Поттер? Өглөө уулзая гээд Харрид алтан өндөгийг өгөөд газрын зургийг харсаар өрөөндөө орж хаалга хаав.

Харри удаанаар Гриффиндорын цамхаг руу явахдаа Снегг, Крауч болон болсон бүх үйл явдлын тухай бодлоо. Яагаад Крауч өвдсөн хэр нь Хогвартст шөнө явж байдаг хэрэг вэ? Снегг өрөөндөө юу нууж байсан юм бол? Крауч тэнд юу эрсэн юм бол? Бас Грюм Харриг мракоборец болно гэж бодож байна. Үгүй ерөө! Харри унтлагын өрөөндөө ороод үл үзэгдэх цуваа тайлж алтан өндөгнийхөө хамтаар чемодандаа хийлээ. Мракоборец болоход муугүй ч бүх маркоберцууд зэрэмдэг байдаг хэрэг үү. Тэгвэл ч бодох л хэрэгтэй болох нь.

БҮЛЭГ 26: ХОЁР ДАХЬ ДААЛГАВАР

- Өндөгний тааврыг аль хэдийн таачихсан гэсэн яасан! гэж Гермiona уурсав.

- Чимээгүй! Шалгах хэрэгтэй байсан юм ойлгов уу? гэж Харри уурслаа.

Андууд шившлэгийн хичээлийн сүүлчийн цаг дээр сууж байв. Татдаг шидийн эсрэг Түлхдэг шид орж байлаа. Шидийн тусламжтай анги дотуур янз бүрийн хэмжээтэй эд зүйлсийг нисгэж байв. Профессор Флитвик санамсаргүй хэн нэгнийг гэмтээхгүйн тулд хүн болонд давхарласан дэр өглөө. Онолоор бол сайхан ч амьдрал дээр тийм ч сайн болсонгүй.

Невилл дэрнээс гадна нисгэж болох бүх зүйлсийг түлхэн тэр ч байтугай профессор Флитвик хүртэл оногдлоо.

- Өндөгний тухай түр мартаж үз! Снегг, Грюм хоёрын тухай сонссон нь дээр байх гэж Харри профессор Флитвик хажуугаар нь нисээд шүүгээний орой дээр газардахад хэлэв.

Хичээл дээр шуугиантай хөгжилтэй байсан болохоор Харри гадны чихнээс айлгүй Рон, Гермiona хоёрт өнгөрсөн шөнийн адал явдлынхаа тухай ярилаа.

- Тэгэхээр Снегг Грюм түүнийг өрөөг нэгжиж болно гэж хэлсэн юм уу? Грюм Снеггийг Каркаровын адил мөрдөж байгаа юм болов уу? гэж Рон шивнэн асуугаад саваагаа даллалал дэр нь нисээд Парватигийн малгайг оночихов.

- Хэрвээ Дамблдор түүнийг гуйгаагүй бол яах вэ? Грюм Дамблдорыг Снеггэд буруугаа гэмших боломж өгсөн гэсэн хэмээн Харри хэлээд хайхрамжгүй саваагаа даллалал ширээн дээр байсан дэр тонгорцоглоод шал руу уначихлаа.

- Юу гэнээ? Магадгүй Грюм Снегг чиний нэрийг Галт цомд хийсэн гэж бодсон юм болов уу? хэмээн Рон нүдээ том болготол түүний дэр агаарт хөөрөн эргэлдэж лааны суурийг цохиод Флитивикийн ширээн дээр уналаа.

- Рон минь дээ, бид Снегг Харриг алахыг хүсэж байгаа гэж бодож байтал аврахыг хүсч байсныг санаж байна уу? гэж Гермiona эргэлзэнгүй хэлээд толгой сэгсрэв.

Тэр шившлэгээр дэрийг түлхэхэд анги дотуур нисэн буух ёстой хайрцган дээр газардав. Харри Гермionaг хөмсөг зангидан харлаа. Снегг үнэхээр нэг удаа түүнийг аварсан... Гэхдээ хачирхалтай юм байна даа. Тэр эцгийг нь үзэн яддаг байсныхаа адил Харриг үзэн яддаг. Тэд хамт сурдаг байсан билээ. Снегг түүнийг гэмгүй байхад шийтгэн Гриффиндороос оноо хасах боломжыг алддаггүй. Тэр ч байтугай Харриг сургуулиас хөөлгөхийг санал болгож байсан.

- Би Грюмын хэлсэн үгэнд санаа зовохгүй байна. Дамблдор их ухаантай. Хагрид, Люпин хоёрт хэн ч ажил өгөхгүй байхад тэр итгэн ажил өгсөн. Тэд ч түүний итгэлийг алдаагүй. Түүний Снеггийн хувьд ч зөв тэр ердөө л жаахан...

- Хорон гэж үү? Алив л дээ, Гермiona тэгвэл хар шидтэн баригч түүний өрөөнд юу хийж байсан болж байна? гэж Рон хэлэв.

- Ноён Крауч яагаад өвдсөн дүр үзүүлсэн юм бол? Бүжигт үдэшлэг дээр ч ирээгүй хаа нэг тийшээ алга болсон. Гэнэтхэн шөнө шилтгээнд гараад ирдэг гэж Гермiona Роныг үл тоомсорлон хэллээ.

- Чи Винкигээс болж ноён Краучид дургүй байгаа юм гэж Рон хэлээд дэрийг цонх руу чиглүүлэв.

- Харин чи Снеггэд шударга бус хандаж байна гэж Гермiona хэлээд дараагийн дэрийг хайрцган дээр буулгалаа.

- Снеггэд хоёр дахь боломж олгохоос өмнө юу хийж байсныг мэдэх юмсан гэж Харри хэлээд дэрээ Гермionaгийнх дээр буулгасан явдалдаа өөрөө ч гайхлаа.

Сириус Харригаас Хогвартст болсон бүх ер бусын зүйлийг бичихийг гуйсан билээ. Тэр үдэш Харри түүнд Снеггийн өрөөнд болсон явдал болон Грюмын сүрдүүлсэн ярианы тухай бичлээ. Захиагаа уулиар илгээгээд хамгийн гол нь яаж бүтэн цаг усан дор амьсгалахгүй байх талаар бодлоо.

Харри усанд шумбадаг хэрэгслийн тухай тайлбарлахад Рон түүнийг Татдаг шидийн тусламжтай маглын ойролцоох хотоос авахыг санал болгов. Гэхдээ Гермiona хэрвээ Харри хоёр сарын хорин дөрвөнд усанд шумбагчийн хэрэгслийг маглуудын нүдэн дээр тэнгэрт нисгэх юм бол олон улсын шидтэний хуулийг задруулах тул тэмцээнээс хөөгдөх болно гэж няцаажээ.

- Ямар нэг юм хувиргавал дээр байх. Жишээлбэл шумбагч онгоц ч юм уу. Бид хүнийг хувиргаж болохгүй нь харамсалтай. Зөвхөн зургадугаар дамжаанд л заадаг юм. Харин одоо бол хийхгүй байсан дээр. Энэ нь муугаар дуусаж болох юм...

- Миний толгойд яндан дуран ургаасай гэж хүсэхгүй байна. Грюмын дэргэд би хэн нэгэн рүү дайрч болох юм. Харин тэр намайг хувиргах...

- Түүнийг чамайг хүссэн зүйлд хувиргана гэж бодохгүй байна! Энэ талаар сайтар бодох хэрэгтэй гэж Гермiona эсэргүүцэв.

Ингээд Харри ахин тоостой номнуудын дунд суулаа. Андууд завсарлагааны ихэнхи хугацааг номын санд өнгөрүүлж үдэш болон амралтын өдрүүдэд усан дор бүтэн цаг тэсч болох шившлэг хайж байлаа. Хэдийгээр Харри номын сангийн хориотой хэсэгт ажиллах зөвшөөрөл профессор МакГонагаллаас авч тастай адилхан номын санч хатагтай Пинсэд өгсөн ч гэлээ тэндээс усан дор нэг цаг амьсгалахгүй байх юу ч олсонгүй.

Танил айдас Харриг эзэмдэхэд хичээлдээ төвлөрч чадахаа болив. Урьд нь нууранд шилтгээн юмуу Хориотой ойн адил анхаарал хандуулдаггүй байсан. Одоо цонхны хажууд суугаад саарал ус руу харахад харанхуй хүйтэн гүнд нь сарны гэрэл ч тусч хүрэхээргүй мэт санагдана.

Эхний тэмцээний өдөр хүртэл хэн нэг нь цагийг хоёр дахин хурдлуулсан юм шиг явж байсан. Одоо хоёр сарын хорин дөрвөн хүрэхэд долоо хоног (бас ч гэж цаг байна)... таван өдөр (ямар нэг юм олдох байлгүй дээ)... гурав (ямар нэг юм олдооч гуйж байна).... үлджээ.

Хоёр хоногийн дараа хоёр дахь тэмцээн эхлэх гэж байхад Харри ахиад хоолноос гарав. Даваа гаригийн өглөөний цайны үеэр Сириусаас захиа ирэхэд түүнд найдлага төржээ. Харри хуйлаастай цаасыг дэлгээд богинохон захиаг уншив.

Дараагийн удаа Хогсмид явах өдрөө даруйхан мэдэгд.

Тийм товчхон захиа Сириус бичиж байсангүй. Харри хуудсыг эргүүлж харсан ч хоосон байлаа.

- Хоёр долоо хоногийн дараа шүү дээ. Май энэ үзэг. Одоохон энэ уулиараа хариу явуулчих гэж Гермiona Харригийн мөрөн дээгүүр зурвасыг уншаад шивнэлээ.

Харри сар өдрийг тавиад зурвасыг буцаан уулийн саварт уяж нисгээд араас нь гунигтай дагуулан харав. Тэр юу хүлээсэн юм бол? Усан дор бүтэн цаг байх зөвөлгөө юу? Сүүлчийн захиандаа Грюм, Снегг хоёрын тухай бичээд хамгийн гол зүйлээ асуухаа мартчихаж.

- Түүнд Хогсмид явах өдрийг мэдэх ямар хэрэг байгаа юм бол? гэж Рон гайхав.

- Мэдэхгүй. Түргэн явцгаая. Шидэт амьтны хичээлээс хоцрох нь гэж Харри ууль харагдахаа болиход сүүлчийн найдлага нь бөхөн хэлэв.

Хичээлийг ахин Хагрид заалаа. Тэр соплохвостуудад урам хугарсандаа (ердөө хоёр үлджээ) профессор Граббли-Дергээс дутуугүй гэдгээ нотлох гэж ганц эвэртээс ч татгалзсангүй. Тэр мангас шиг амьтанд дуртай болохоор ганц эвэртэд хортой соёо байсан бол хөөрөн ярих байлаа.

Хагрид хичээлд зориулан ганц эвэртийн хоёр жижигхэн унага барьж авжээ. Нас бие гүйцсэн ганц эвэртээс ялгаатай нь унаганууд алтлаг өнгөтэй байлаа. Парвати, Лаванда хоёр бахадсан харцаа салгасангүй бөгөөд тэр ч байтугай Пэнси Паркинсонд таалагдсан ч үүнийгээ нууж байлаа.

- Унага түргэн өсдөг юм. Хоёр жилийн дараа хэдийн мөнгөлөг болчихно. Дөрвөн настайд нь эвэр ургана. Долоон жилийн дараа цасан цагаан өнгөтэй болно. Унага гарын аяар болохоор хөвгүүд айх хэрэггүй. Хэн хүссэн нь илж болно. Тэдэнд чихэр өгөөрэй...

- Чи зүгээр үү, Харри? гэж Хагрид унагыг тойрон шавсан хүүхдүүдээс холдоод хэлэв.

- Тиймээ хэмээн Харри толгой дохив.

- Догдолж байна уу?

- Тиймээ... жаахан л.

- Би чиний анхны тэмцээний өмнө хичнээн их санаа зовсон гээч. Чи тэгэхэд эвэр сүүлтийг дийлсэн. Харин одоо би зовохгүй байна. Чи чадна. Өндөгний таавраа таачихсан уу? гээд Хагрид мөрөн дээр нь том гараараа алгадахад Харрийн өндөг нахисхийив.

Харри түүнээс усан дор яаж цаг амьсгалахгүй байхыг асуух гэснээ больж толгой дохьжээ. Тэр Хагрид руу харлаа. Түүнд нууранд шумбасан тохиолдол гарч байсан

болов уу? Тэнд олон амьтан байдаг шүү дээ. Эсвэл зөвхөн шилтгээний нутаг дэвсгэрийн амьтдыг харах үүрэгтэй юм болов уу.

- Чи ялна. Би үүнийг мэдэрч байна. Нэгт орох болно гэж Хагрид сөөнгөтөөд ахин Харрийн мөрөн дээр алгадахад газар хэдэн инчийн гүнд шигдэх шиг санагджээ.

Хагрид Харрийг сэтгэл өндөр харав. Харри инээмсэглэн жижигхэн ганц эвэртийг илэхээр явлаа.

Хоёр дахь тэмцээний өмнөх үдэш жинхэнэ хар дарсан зүүд шиг байлаа. Хэрвээ тэр ямар нэг гайхамшигаар тохиромжтой шившлэгийг олоод шөнийн дотор сурахгүй бол болохгүй байдаг. Тэр яагаад өндөгний тааврыг тийм орой таасан юм бол? Яагаад даруйхан ажиллаж эхэлсэнгүй вэ? Хичээл дээр хэн нэг багшаас усан дор яаж цаг амьсгалахгүй байхыг асууж болох байсан шүү дээ.

Үдэш харанхуй болов. Харри, Рон, Гермиона гурав номын санд орж зузаан ботиуд овоолж аваад шившлэг эрж эхлэв. Хуудсан дээр ус гэсэн үг дайралдах болгонд Харрийн зүрх хүчтэй цохилох хэдий ч ердөө л уусмалын жорын хэсэг байх аж <<Тогоонд хоёр пинт ус хийж мандрогорын навч, шанаган хорхой...>>. Харрийн гар сулрав.

- Ямар ч тохиромжтой шившлэг алга. Ер нь юу ч алга. Хатаах шившлэг л дөхөж байна гэхдээ нуурыг хатаая гэвэл хүчтэй шивлэг хэрэгтэй гэж Рон хэллээ.

- Юу ч байхгүй байх боломжгүй юм! Тэмцээний даалгавар биелэгдэшгүй байх боломжгүй дээ гээд Гермиона лаагаа зузаан <<Мартагдсан эртний шившлэгүүд>> гэсэн боть руу ойртуулан жижигхэн үсгийг нь харав.

- Энэ чинь биелэгдэшгүй юм байна. Харри маргааш нууранд толгойгоо хийгээд лусын дагинууд руу хашгир. Ямар нэг санаа өгөх ч юм билүү. Минийхээр бол өөр юу ч бодож олж чадахгүй юм байна.

- Тийм байх боломжгүй. Бид муу эрж байна! гэж Гермиона ууртай бувтналаа.

Гермиона номын санд тохиромжтой шившлэг байхгүй гэдэгтэй эвлэрч чадахгүй байлаа. Ийм зүйл түүнд хэзээ ч тохиолдож байгаагүй юм.

- Юу хийх ёстойг мэдэж байна. Амьтан болж хувирах ёстой байх. Сириус шиг анимаг гэж Харри хэлээд <<Хөгжилтэй заль мэхүүд болон түүний төрлүүд>> гэсэн ном руу толгойгоо бөхийлгөв.

- Яг зөв. Нэг удаа ч гэсэн алтан загас болж хувирах юмсан гэж Рон дэмжив.

- Эсвэл мэлхий юмуу гээд Харри ядарсандаа эвшээлээ.

- Үүнд чинь жил хэрэгтэй. Дараа нь яамны анимагт бүртгүүлнэ гээд Гермиона <<Хүнд шидэт даалгаварууд болон тэдний шийдвэрүүд>> гэсэн номыг гүйлгэн харснаа,

- Профессор МакГонагаллын хэлснийг санаж байна уу... яамны хууль бус шидийн хэлтэст ямар амьтан болж хувирах болон онцгой шинж тэмдэгээ бүртгүүлэх ёстой. Үүнгүй бол болохгүй...

- Би тоглосон шүү дээ, Гермиона. Өглөө гэхэд мэлхий болон хувирч сурахгүй гэдгээ мэдэж байна гэж Харри хэлэв.

- Юу гээчийн дэмий зүйл вэ! Арай боломжтой юм ярьж болохгүй байна уу? гэж Гермиона дуу алдаад номоо хаалаа.

- Би тэгж бодохгүй байна! Сайхан маргааны сэдэв байна гэх Фред Уизлийн хоолой сонсогдов.

Харри, Рон, Гермиона гурав зэрэг дээшээ харлаа. Номын тавиурын цаанаас Фред, Жорж хоёр гарч ирэв.

- Та хоёр энд юу хийж байгаа юм бэ? гэж Рон ах нараасаа асуулаа.

- Чамайг хайж байна. МакГонагалл явуулсан юм. Чамайг бас Гермионаг.

- Яах гэж? хэмээн Гермиона гайхлаа.

- Мэдэхгүй гэхдээ тэр их баргар царайтай байсан гээд Фред мөрөө хавчив.

- Биднийг та хоёрыг өрөөндөө авчир гэсэн хэмээн Жорж хэлэв.

Рон, Гермиона хоёр Харри руу харахад түүний дотор хүйт оргив. Одоо тэдэнд МакГонагалл юу гэж хэлэх бол? Магадгүй түүнд тусалж байгааг мэдсэн байх. Харин тэр ганцаараа хийх ёстой шүү дээ.

- Амралтын өрөөнд уулзая. Аль болох олон ном аваад аваад ирээрэй гэж Гермиона хэлээд сандлаасаа босов.

- За гээд Харри толгой дохив.

Гермиона, Рон хоёр түгшин гарч одов. Найман цагт хатагтай Пинс номын сангийн бүх лааг унтраахад Харри явлаа. Хүнд номнуудтай амралтын өрөөндөө эргэж ирээд өрөөний буланд суун ахиад л шившлэг хайж эхлэв. <<Дундад зууны үеийн шидтэний гарын авлага>>, <<Арван наймдугаар үеийн зууны шүлгэн шившлэг>>, <<Тэнгисийн гүн дэх аймшигтай амьтад>>, <<Дотор чинь унтаж байгаа хүч чамайг аугаа болгоно>> зэрэг номд юу ч байсангүй.

Өвдөг дээр нь Живоглот харайн гарч ирээд цагариглан нойрмог хүржигнэв. Амралтын өрөө алгуурхан хоосорлоо. Нэг ангийнхан нь Хагридын адил маргаашийн өдөрт баяртайгаар Харрид амжилт хүсэв. Хэнд ч Харри хоёрдугаар даалгаварт амжилттай оролцоно гэдэгт эргэлзээ байсангүй. Бүх сайн сайхан хүссэн үгийг Харри толгойгоо чимээгүйхэн дохин сонсоход хоолойдоо гольфын бөмбөг залгичихсан юм шиг мэдрэмж төржээ. Шөнө дундын үед амралтын өрөөнд зөвхөн Живоглот тэр хоёр үлдэв. Бүх номоо үзэж дуусгасан ч Рон, Гермиона хоёр ирсэнгүй.

Боллоо. Юу ч олсонгүй. Өглөө нуур луу очоод шүүгч нарт хэлэхээс...

Харри өөрийгөө шүүгчдийн ширээ рүү очоод энэ сорилтыг давах хүч байхгүй гэдгээ хэлж байна гэж төсөөлөв. Бэгмен дугуй нүдээ гайхан нүдээ бүлтийлгэж, Каркаров баяртайгаар шар шүдээ ярзайлгаж, Флер Делакур <<Би мэдэж байсан юм... Тэр чинь жаахан хүүхэд шүү дээ>> гэж хэлэх байх даа. Харин Малфой энгэртээ <<Поттер

өмхий>> тэмдгээ зүүн урагш гарч ирнэ. Хагрид чихэндээ итгэлгүй гомдлын нулимс унагана...

Муурын тухай мартаад Харри хөл дээрээ үсрэн бослоо. Живоглот шалан дээр үсрэн буугаад тургилан Харри руу ууртай хараад сүүлээ хөдөлгөв. Харри эргүүлгэн шатаар унтлагын өрөө лүүгээ гүйлээ. Одоохон үл үзэгдэх цуваа аваад номын сан явах хэрэгтэй тэнд шөнөжингөө сууж...

Арван таван хормын дараа Харри номын санд чимээгүй явж очоод,

- Люмос гэж шивнэлээ.

Савааны үзүүрээс нь хүйтэн дөл асахад Харри тавиур даган явж лусын дагина ба хаан, усны мангас, алдартай шидтэнгүүд болон тэдний бүтээлүүд гээд товчхондоо усан дор ганц цаг амьсгалахгүй байхыг хэлж болох бүх номыг цуглуулав. Харри ширээний ард суугаад том зузаан боть аван шидэт савааны гэрлээ тусган үзлээ...

Нэг цаг... хоёр цаг... Ном болгоны дараа цөхрөхгүйн тулд Харри өөртөө <<Дараагийнхт нь л байгаа>> гэж хэлж байлаа.

Ахлагч нарын угаалгын өрөөний лусын дагина толгой дээрээ түүнийг <<Аянга>>-ыг өргөн хөхөрнө. Харин Харри хөөстэй усан дунд зогсоод түүний хад руу дэвхэрч байлаа.

- Хүрээд ав л даа! Алив үсэр! гэж лусын дагина шоолов.

- Чадахгүй. Надад өгөөч гэж Харри шүүрээ авахыг хичээн орилов.

Лусын дагина түүний хавирга руу шүүрний модоор өвдтөл нудраад хөхрөв.

- Өвдөж байна! Боль л доо! Ёо...

- Харри Поттер сэрэх ёстой, ноёнтоон!

- Хатгахаа болиоч.

- Добби Харри Поттерыг хатгах ёстой, ноёнтоон. Харри Поттер сэрэх ёстой.

Харри нүдээ нээлээ. Тэр номын санд <<Шидэт саваа хамгийн сайн туслах>> гэдэг номын хуудас дэрлээд хэвтэж байв. Үл үзэгдэх цувны юүдэнгээс толгой нь цухуйжээ. Харри өндийн босож нарны хурц гэрэлд анивчин шилээ засав.

- Харри Поттер яарах хэрэгтэй! Хоёр дахь тэмцээн арван хормын дараа болох гэж байна! Харри Поттер... гэж Добби часхийн дуугарав.

- Арван хором гэнээ? Арав... Юу?

Тэр цагаа харав. Доббигийн зөв байлаа. Есөн цаг хорин минут болж байв! Харрийн зүрх палхийв.

- Харри Поттер яарах хэрэгтэй! Харри Поттер нууран дээр бусадтайгаа хамт байх ёстой, ноёнтоон гээд Добби гараас нь зулгаав.

- Үгүй ээ, Добби хэтэрхий оройтсон. Би явахгүй... даалгаварыг яаж биелүүлэхийг мэдэхгүй гээд Харри найдлагагүй гараа савчив.

- Харри Поттер ахиад л ялна. Добби Харри Поттер шившлэгийг олоогүй гэдгийг мэднэ. Добби олсон.

- Чи юу? Олсон гэнээ? Гэхдээ чи хоёр дахь даалгавар юу болохыг...

- Добби мэднэ, ноёнтоон! Харри Поттер нуураас Уизиг олох хэрэгтэй...

- Юу олно гэнэ ээ?

- Таны Уизи, ноёнтоон Уизи. Тэр Доббид цамц өгсөн гээд тэр богинохон шортон дээрээ өмссөн хүрэн цамцаа татлаа.

- Тэд... тэд Роныг хулгайлсан юм уу? гэж Харри чихэндээ итгэлгүй асуулаа.

- Тэд хулгайлсан. Харри Поттергүй бол их муу зүйл болно. Цагийн дараа...

<<Зөвхөн цаг тэгээд дараа нь эргэж ирэхгүй>>. Харри айдаст автан үйлчлэгч руу нүд бүлтийлгэн харлаа.

- Би юу хийх ёстой вэ, Добби?

- Харри Поттер үүнийг идэх ёстой. Энэ бол жабросли, ноёнтоон. Идээд нууранд тайван шумбаж болно гээд үйлчлэгч богино өмднийхөө халааснаас саарал ногоондуу өнгөтэй хархын сүүл шиг зүйл гаргаж ирлээ.

- Үүгээр яадаг юм? гээд Харри итгэлгүйхэн жабросли руу харлаа.

- Усан дор амьсгалахад туслана, ноёнтоон.

- Добби, чи яг итгэлтэй байна уу? гээд Харрийн цөхрөл туйлдаа хүрчээ.

Добби нэг удаа түүнд туслахыг хүссэн нь гарных нь ясыг алга болгоход хүргэсэн билээ.

- Добби яг мэдэж байна, ноёнтоон. Добби олон удаа сонсож байсан, ноёнтоон. Добби бамбарын гэрэлд шал угааж байсан юм. Добби профессор МакГонагалл, профессор Грюм хоёрыг багш нарын дараагийн тэмцээний тухай хөөрөлдөж байхыг сонссон... Добби Харри Поттер Уизигаа алдахыг хүсэхгүй байна!

Тэгэхээр Рон хулгайлагдсан байх нь. Харри үсрэн босоод үл үзэгдэх цуваа цүнхэндээ хийж Доббийн жаброслиг халааслаад номын сангаас үсрэн гарахад үйлчлэгч араас нь дагалдав.

- Добби гал зууханд очих ёстой, ноёнтоон. Доббиг хайж байгаа. Таньд амжилт хүсье, ноёнтоон гээд Добби хонгилоор гүйн одлоо.

Харри хонгилоос гарч шат руу гурван гишгүүр алгасан үсрээд,

- Баярлалаа, Добби! Баяртай! гэж хашгирав.

Танхимд сурагчид түлхэлцэн нуурын дэргэдэх хоёр дахь тэмцээн руу яарч байлаа. Харри дэргэдүүр нь шурдхийн өнгөрч царсан хаалгаар үсрэн гарахдаа ах дүү Кривиг хийстэл мөргөчихлөө.

Хоёр сарын илчгүй нар гийж байсан ч зэврүүн байх аж. Нуурын нөгөө эрэг дээр лууны тэмцээний үеийнх шиг үзэгчдэд зориулан хашаа дугуйруулан татжээ. Үзэгчид

цугларан дүүрч инээлдэн шуугина. Зүүн талын эрэг дээр алтан бүтээлэгтэй шүүгчдийн ширээ байсан бөгөөд Харри тийшээ шууд очлоо.

Седрик, Флер, Крам нар шүүгчдийн ширээний өмнө зогсож байв.

- Би энд байна гэж Харри амьсгаадан хэлээд ширээний өмнө ширүүхэн зогсохдоо Флерийн жанч руу шавар үсэргэчихлээ.

- Чи хаана байсан бэ? Тэмцээн одоохон эхлэх гэж байна гэх хэн нэгний албархуу дуу гарав.

Ноён Краучын оронд шүүгчдийн ширээнд Перси Уизли сууж байсан бөгөөд тэр ирээгүй л байв.

- Боль доо, Перси. Харрид амьсгаагаа дарах боломж өг хэмээн Людо Бэгмен санаа амран хэлэв.

Дамблдор нөхөрсөг инээмсэглэхэд, Каркаров хатагтай Максим хоёр түүний ирсэнд урам хугарсан янзтай харагдана. Тэр харваас түүнийг хүлээгээгүй байлаа.

Харри хүндээр амьсгаадан өвдгөө тулав. Хавирга руу нь хутгаар хатгуулж байгаа юм шиг өвдөлт хэдэн хормын дараа зүгээр болов. Людо Бэгмен оролцогчдыг эрэг дагуу арван футын зайтай зогсоов. Харри хамгийн захад богино өмдтэй саваагаа бэлхэн барьсан Крамын дэргэд зогслоо.

- Бүх зүйл хэвийн үү, Харри? Юу хийхээ мэдэж байгаа биз? гэж Бэгмен Харриг Крамаас жаахан холдуулаад хэллээ.

- Тиймээ гээд Харри хавиргаа үрэв.

Бэгмен сэтгэлээр унасан янзтай мөрөө унжуулан шүүгчдийн ширээ рүү очоод шидэт саваагаа Дэлхийн цомын тэмцээнийх шиг хоолойдоо хүргэж <<Сонорус!>> гэлээ.

- Хоёрдугаар тэмцээний оролцогчид бэлэн боллоо. Тэдэнд хулгайлагдсан зүйлийг олоход цагийн хугацаа байгаа. Шүгэл дуугарахад эхлээрэй. Нэг... хоёр... гурав!

Хүйтэн агаарт үзэгчдийн орилох, шүгэлдэх, алга таших чимээ хадав. Харри өрсөлдөгчдөө юу хийхийг харалгүй гутал, оймсоо тайлж халааснаасаа жабросли гарган аваад амандаа хийн нуур луу орлоо.

Хүйтэн ус хөлийг нь халуу шатаав. Усанд өвдгөө хүртэл ороход хөл нь мэдээ алдаж гөлгөр чулуун дээр халтиран норж хүндэрсэн жанч нь доош татлаа. Харри яаран наймаалжны тэмтрүүл шиг гулгамтгай жаброслиг зажлав. Тэгээд бүсэлхийгээ хүртэл усанд дунд зогсоод залгин юу болохыг хүлээв.

Үзэгчид инээлдэв. Тэр үнэхээр тэнэг харагдаж байгаа байх даа. Тэмцээнд ямар ч шид бэлтгээгүй байдаг. Харри даарч бүх биеийн арьс нь арзайгаад чичирч эхэллээ. Слизеринийхэн шүгэлдэж инээлдэхэд тэдний зүг харахгүй байхыг хичээв.

Харрид гэнэтхэн нүүрийг нь үл үзэгдэх дэрээр арчих шиг санагджээ. Тэр шүлсээ залгихыг оролдсон ч уушгинд нь агаар дутаж толгой нь эргэн чихнийх нь доогуур сахлын хутгаар зүсэж байгаа юм шиг...

Харри хүзүүгээ барихад усан дор амьсгалах загалмайтай болжээ. Жабросли! Удаан бодолгүй ус руу шумбалаа.

Хүйтэн ус залгихад амьсгалж байгаатай аятай мэдрэмж төрөв. Хоёр дахь удаагаа ус залгихад толгой нь эргэхээ больж загалмайгаа мэдрэн хүчилтөрөгч тархинд нь очлоо. Харри нуурын хий үзэгдэл адил ногоон усан дотор гараа сунган харахад сарвуундаа сарьстай болсон байлаа. Хөлөө эргэж харахад урт нарийхан болж мушгиран мөн сарьс бүхий сэлүүртэй болсон байв.

Хүйтэн ус сэрүүхэн тэр ч байтугай таатай юм шиг санагдана. Харри ахин нэг удаа гараа даллаад хөлөө онгоцны сэнс шиг ажиллуулан түргэн хөвлөө. Нүд нь цавчилгүй сайн харж байв. Тэрбээр доош тонгорцоглоод усны гүн рүү түргэн хөвлөө.

Тэр ямар нэгэн хачирхалтай харанхуй манантай газар хөвөн очлоо. Нам гүмд чихний хэнгэрэгт нь даралт үзүүлнэ. Харанхуйд аюул занал отоож байх шиг санагдах аж. Эргэн тойрны зүйлс шинэ өнгөөр өөрчлөгдөн өтгөн лаг шиг ургасан усны хар замаг чулуун дээгүүр гялтагнан үзэгдэв. Харри улам гүн рүү доошлон нуурын голд хүрээд нүдээ том нээн харахад айдас хүрэм саарал ус тодорхойгүй сүүдэртэнэ.

Мөнгөлөг сумтай адилхан загас дэргэдүүр нь цайвалзан өнгөрөв. Хэдэн удаа урд нь ямар нэгэн юм хөдөлж байхыг харсан ч том замаг байлаа. Аз болоход ямар ч аварга том наймаалж болон усны амьтан тааралдсангүй.

Хагас метрийн зайд өндөр ургасан цайвар ногоон өнгийн зүлэг шиг замаг бүхий нуга өнгөрөв. Харри цавчилгүй урагш ширтэн харанхуйгаас ямар нэгэн аюул заналхийлж байгаа эсэхийг харлаа. Гэнэт хэн нэгэн шагайнаас нь чанга зууран авав.

Харри эргээд доошоо харвал гриндилоу байв. Жижигхэн эвэртэй усны чөтгөр замагнаас гарч ирээд Харригаас урт нарийхан хуруугаараа зууран сахлын хутга шиг хурц шүдээ ярзайлгав. Харри халааснаасаа шидэт саваагаа автал ургамлын цаанаас ахин хоёр чөтгөр гарч ирээд жанчнаас зууран доош чирлээ.

- Релашо! гэж Харри чимээгүй хашгирахад амнаас нь том ногоон хөөс гарч саваанаас гэрэл гялсхийн ус бургилав. Ногоон чөтгөрүүд уурласандаа улайхад Харри хөлөө ясархаг сарвуунаас салган аваад түргэн цааш хөвлөө. Нэг гриндилоу хөлнөөс нь ахин зуурч авахад өшиглөөд хартал түүний хамтрагчид сүрдүүлэн нударга зангидаад замагт нуугдав.

Харри удаашран хөвөх зуураа саваагаа далд хийгээд чимээ анирдав. Нам гүм улам аниргүй болов. Харри усан дотор эргэлдэн бүтэн тойрог хийхэд нам гүм чихний хэнгэрэгэнд нь хүчтэй даралт учруулж байв. Тэр бүр гүнд ороход эргэн тойронд замаг байтугай юу ч байсангүй.

- Чи ямархуу байна даа? гэх хэн нэгний хоолой сонсогдлоо.

Харри цочирдон түргэн эргэн харахад дэргэд нь уйланхай Миртл хөвж зузаан шилнийхээ цаанаас харж байв.

- Миртл үү! гэж Харри хашгирахад амнаас нь дуу гарахын оронд том хөөс гарав. Уйланхай Миртл инээлээ.

- Тийшээ сэл. Би чамтай явахгүй. Тэд намайг хөөгөөд байдаг болохоор би дургүй байдаг юм... гэж тэр хэлэв.

Харри талархсаны тэмдэг болгон эрхий хуруугаа гозойлгоод гриндилоу нуугдсан байж болох замаг дээгүүр болгоомжтой хөвлөө.

Бараг хориод хором хөвөх шиг санагджээ. Маш уудам газар дээгүүр хөвөхөд ногоон замаг хар лаг шиг нүүгэлтэн хөдөлгөөнийг нь даган хуйларч байлаа. Эцэст нь түүнд танил лусын дагины дуу сонсогдов.

Харри түргэн сэлээд бүүдгэр усан дотор том чулуу байхыг харлаа. Чулуун дээр хэдэн усны хүн суугаад гартаа аварга том наймаалж хөөдөг бололтой жад барьжээ. Харри лусын дагина дууг даган чулууны дэргэдүүр өнгөрлөө.

Цаана нь бүдүүлэг хийцтэй замганд хучигдсан чулуун байшин байв. Харанхуй цонхонд царай цухуйхыг харсан ч ахлагч нарын угаалгын өрөөний лусны дагины зурагтай адилгүй байлаа.

Усны оршин суугчид саарал арьстай, сэгсгэр ногоон үстэй, жигд бус шар шүдтэй, хүзүүндээ хайргаар хийсэн хүнд зүүлт зүүсэн байлаа. Тэд Харри руу ууртай харцгаана. Хоёр нь овоохойноос жад барин хөвж гарч ирээд ойртон ирж байгаа зочноо харж хүчирхэг мөнгөлөг сүүлээрээ ус цохив.

Харри усны хүмүүсийг хараад хурдаа хасав. Чулуун овоохойнуудын эргэн тойронд цэцэрлэг шиг өтгөн замаг ургаж нэгнийх нь гаднах шонгоос гриндилоу уяжээ. Эргэн тойрноос усны хүмүүс гарч ирээд түүний сарьсан сарвуу сэлүүрийг сониучирхан харж гараараа заан ярилцаж байлаа. Харри булан тойроод маш хачирхалтай үзэгдэл харав.

Байшингийн өмнөх талбайг хөвөөлөн бүлэг усны хүмүүс цугларчээ. Талбайн голд бүдүүлэг хийцтэй лусын хааны хөшөө байлаа. Хөшөөний өмнө хэсэг лусны дагина тэмцээний оролцогчдод зориулсан найрал дуу дуулах аж. Хөшөөнөөс зузаан олсоор дөрвөн хүн уяатай байлаа.

Рон Гермиона, Чжоу Чанг хоёрын дунд уяатай байсан бөгөөд арав орчим настай Флер Делакурын адил мөнгөлөг үстэй охин байлаа. Түүний дүү байх гэж Харри бодов. Тэд бие биенийхээ мөрийг дэрлээд бөх унтахад амнаас нь нарийхан хөөс бургилна.

Харри хөшөө рүү хөвж очоод жадаар зэвсэглэсэн хүмүүс түүн рүү дайрах байх гэж бодсон ч дайрсангүй. Замгаар хучигдсан олс их хатуу харагдав. Харри Сириусын зул сарын баяраар бэлэглэсэн хутгыг санасан ч чемодандаа байгааг саналаа.

Харри ийш тийшээ харав. Түүнийг тойрон хүрээлсэн олонхи хүмүүс гартаа жад барьжээ. Харри урт ногоон сахал, аварга биетэй, махчин загасны шүдтэй усны хүн руу очоод жадыг нь гуйлаа. Усны хүн инээгээд татгалзсаны тэмдэг болгон толгой сэгсрэв.

- Бид туслахгүй гэж тэр сөөнгөтөн хэлэв.

- Жадаа өгөөч! гэж Харри уурсаад (амнаас нь хөөс гарлаа) гараас нь жадыг нь авахаар оролдсон ч тэр угз татан аваад инээмсэглэсэн хэвээр толгойгоо сэгсэрлээ.

Харри талбайн эргэн тойронд ямар нэгэн хурц юм байна уу гэж хайлаа!

Нуурын ёроол нилэнхийдээ чулуугаас тогтжээ. Харри хурц үзүүртэй чулуу аваад хөшөө руу буцан Роны олсыг огтолж эхлэв. Таван хормын дараа чөлөөтэй болсон ч Рон унтсан хэвээр чимээгүй хөвнө.

Харри ахиад л ийш тийшээ харав. Седрик, Флер, Крам нар харагдсангүй. Тэд хаана байгаа юм бол? Яагаад яарахгүй байгаа юм бол? Харри Гермиона руу хөвж очоод олсыг нь огтлохыг завдав.

Түүнийг хэд хэдэн хүчирхэг гар барин зогсоов. Тав зургаан лусын хүмүүс түүнийг Гермионагаас холдуулаад инээлдэн ногоон үстэй толгойгоо сэгсэрлээ.

- Өөрийнхөө олзлогдогчыг аваад дээшээ хөв. Бусдыг нь орхи гэж тэдний нэг хэллээ.

- Бодох ч юм биш! гэж Харри уурсан хэлэхэд хоёр том хөөс гарав.

- Чиний даалгавар бол найзыгаа гаргах... Бусад нь энд үлдэнэ...

- Энэ ч гэсэн миний найз! Би тэднийг үх гээд орхиж чадахгүй! хэмээн Харри Гермионагийн зүг заан хашгирахад том мөнгөлөг хөөс үүсэв.

Чжоугийн толгой Гермионагийн мөрөн дээр тавиаастай байх агаад Флертэй төстэй охин ногоорон зэвхийрчээ. Харри тэдний гараас сугарахыг оролдоод улам бүр инээлгэлээ. Тэр ахиад л цөхрөн нүдээрээ бусад оролцогчдыг хайлаа. Тэд хаачаа вэ? Дээшээ Роныг гаргаад бусад руу нь эргэж ирдэг юм билүү? Тэднийг ахиж олох болов уу? Харри цагаа харсан ч ажиллахаа больсон байв.

Усны хүмүүс дээшээ харан хуруугаараа заалаа.

Харри толгойгоо өргөлөө. Седрик тэдний зүг ирж байлаа.

Түүний толгой нь том хөөсөн дунд байсан бөгөөд царай нь шилний цаана байгаа мэт хачирхалтай балархайтан үзэгдэнэ.

- Би төөрөөд! Флер, Крам хоёр удахгүй энд ирнэ гэж Седрик уруулаа чичигнүүлэн хэлэв.

Харри гүнзгий санаа амарлаа. Седрик халааснаасаа тонгорог гарган олсыг огтолж Чжоуг аваад дээшээ хөвлөө.

Тэр үлдээд хүлээв. Флер, Крам хоёр хаана байна? Удахгүй цаг дуусах гэж байдаг хэрвээ дууны үгэнд итгэх аваас олзлогдогчид хэзээ ч иргэж ирэхгүй...

Лусын дагинууд орилолдов. Тэд Харриг тавиад эргэж харлаа. Түүн лүү аймшигтай мангас ирж байлаа. Их бие нь хүнийх атал толгой нь махчин загасных ажээ. Энэ бол Крам байв. Тэр өөрийгөө махчин загас болгон хувиргасан ч тааруухан болсон бололтой.

Аварга загас Гермиона руу ирээд олсыг хазан сэгсчив. Крам далайн гахайныхаас томгүй шүдээрээ эв дүйгүйхэн олсны талыг хазлаа. Харри түүнд туслахаар яаран

очоод мөрөн дээр нь алгалан хурц үзүүртэй чулуугаа үзүүлэв. Крам хормын дотор уяаг таслан Гермionaгийн бүсэлхийнээс зуугаад эргэж ч харалгүй дээшээ хөвлөө.

Юу хийх ёстой вэ? гэж Харри цөхрөн бодлоо. Хэрвээ түүний мэдэж байгаагаар бол Флер ирэх ёстой... Гэхдээ үзэгдсэнгүй... Юу хийх вэ...

Тэр Крамын хаясан чулууг шүүрэн автал усны хүмүүс ойртон ирж ахин толгойгоо сэгсэрцгээв.

Харри шидэт саваагаа гаргалаа.

- Замаас зайл!

Амнаас нь хөөс гарсан ч усны хүмүүс ойлгон инээлдэхээ больж шар нүдэнд нь савааг хараад айдас тодров. Хэдийгээр тэд олуулаа байгаа ч ид шидийг аварга том наймаалжаас илүү мэддэг бололтой.

- Би гурав хүртэл тоолно! Нэг... хоёр гээд Харри гурван хуруугаа гозойлгон зангахад амнаас нь хөөс гарлаа.

Лусын хаад салхинд хөөгдсөн мэт алга болов. Харри чулуунаас хүлээтэй охиныг суллав. Нэг гараараа түүнийг тэвэрч нөгөө гараараа Роны шилэн хүзүүнээс зуураад дээшээ хөвлөө.

Хөвөхөд амаргүй байлаа. Тэр сарьстай гараа ашиглаж чадахаа больсон болохоор зөвхөн сэлүүр нь ажиллах аж. Харри сэлүүрээ уурсан хөдөлгөсөн ч Рон болон Флерийн дүү хоёр доошоо шуудайтай төмс шиг чангааж байв... Харри дээшээ харлаа. Дээр нь харанхуй усанд нарны нэг ч цацраг тусахгүй аж.

Лусын хүмүүс болон дагина түүнийг хүрээлэн харахад бүх хүчээ гарган аль болох дээшээ хөвөхийг хичээв. Цаашдаа юу болох бол? Тэд түүнийг барьж доош нь живүүлэх болов уу? Магадгүй хүн иддэг юм болов уу?

Харри хөлөөрөө тэмцэн зүтгэсээр байсан ч мөр нь аймшигтай янгинан өвдлөө.

Амьсгалахад хүнд болов. Чихнийх нь дор өвдөж ахиад л эргэн тойрон хүйтэн нойтон болов... Толгой дээгүүр нь гэрэл татав.

Харри хөлөө сүүлчийн хүчээ гарган тийрэхэд сэлүүр биш хөл болсон байв. Агаар дутагдан толгой нь эргэлээ... дээшээгээ... ахиад жаахан л...

Ахиад хөлөөрөө тийрэхэд булчин нь эсэргүүцэн чинэрэн өвдөв. Уураг тархи нь агаараар дутагдан амьсгалж чадахаа больсон ч тэр явах ёстой зогсож болохгүй...

Тэгтэл нуурын гадаргуу дээр гараад ирлээ! Гайхамшигтай цэвэр хүйтэн салхи нойтон нүүрийг нь илбэв. Харри амьдралдаа анх удаагаа агаар амьсгалж байгаадаа баярлаж цээж дүрэн амьсгалав.

Рон, охин хоёрыг дэргэдээ барин хөвлөө. Ногоон үстэй лусын хаад болон дагина гарч ирээд баяртай инээмсэглэв.

Үзэгчид орилон шүгэлдэж хөл дээрээ дэвхцэв. Харри Рон охин хоёрыг үхсэн байх гэж айлаа. Гэхдээ үгүй дээ тэд сэргж нүдээ нээлээ. Охин айж сандарсан бол, Рон хурц гэрэлд анивчин Харри руу эргэж хараад,

- Түй, ямар нойтон юм бэ! Чи хэнийг авчраа вэ? гээд Флерийн дүү рүү харлаа.
- Флер түүний араас ирээгүй. Юу хийх ёстой байсан гэж? Тэнд үлдээх байсан хэрэг үү? гэж Харри амьсгаадан тайлбарлав.
- Харри, чи ямар тэнэг юм бэ! Чи үнэнээсээ биднийг үхнэ гэж бодоо юу? Дамблдор хэзээ ч үүнийг зөвшөөрөхгүй!
- Гэхдээ дуу...
- Зөвхөн та нар усны дор цагаас илүү тэсэж чадахгүй. Чамайг баатарын ёсоор байсныг ойлгож байна.
- Харрид ичгүүртэй байв. Рон унтаад нуурын ёроолд ямар аймшигтай жад бүхий алуурчин шиг усны хүмүүс хүрээлж хараагүй болохоор ярихад амар байлаа.
- Алив л дээ. Надад түүнийг гаргахад туслаач. Тэр сайн сэлж чаддаггүй бололтой.
- Тэд Флерийн дүүг хоёр талаас нь дэмжин шүүгчид зогсож байгаа эрэг рүү сэллээ. Хориод усны хүн гарч ирээд хүндэт харуул аятай хяхарсан дуугаар сүлд дууллаа дуулж байв.
- Хатагтай Помфри эрэг дээгүүр сандчин гүйж Гермiona, Крам, Седрик, Чжоу нарт ноосон хөнжил өглөө. Дамблдор, Людо Бэгмен хоёр Харри, Рон хоёрыг хараад баяртай инээмсэглэв. Цонхийн цайсан Перси тэдэнд туслахаар ус туучин ирэв. Хатагтай Максим ус руу орохоор тэмцэн зүтгэлэх Флерийг тогтоон барих аж.
- Габриэль! Габриэль! Тэр амьд уу? Гэмтээгүй биз дээ?
- Тэр сайн гэж Харри хашгирахыг хичээсэн ч амжилт олсонгүй.
- Перси Роныг гарахад туслаад ноосон хөнжил нөмрүүлэв (Чи холд, Перси! Би өөрөө гарчихна) Дамблдор, Бэгмен хоёр Харриг эрэг дээр гарахад туслав. Флер эцэст нь хатагтай Максимын гарнаас мултарч дүүгээ цээжиндээ тэврэв.
- Тэнд гриндилоу байсан... тэд намайг дайрсан... миний дүү... би бодохдоо...
- Нааш ир! гэж хатагтай Помфри тушаагаад Харриг Гермionaд түшүүлэн очиход ноосон хөнжлөөр номхотгодог цамц өмсгөсөн аятай чанга ороогоод ам руу нь халуун шингэн цутгалаа.
- Харрийн чихнээс уур суунаглав.
- Сайн байна, Харри! Сайн байна! Өөрөө бүхнийг таалаа гэж Гермiona баяртай дуу алдав.
- Гэхдээ... гээд Харри түүнд Доббийн тухай ярих гэснээ Каркаровын ууртай харцыг ажиглалаа. Бүх шүүгчдээс зөвхөн тэр л Харри Рон болон Флерийн жижигхэн дүүтэй аюулгүй буцаж ирсэнд баярласангүй.
- Тиймээ өөрөө гэж Каркаровд сонсогдохын тулд чанга хэллээ.
- Герм-ивонна чиний толгой дээр усны цох явж байна гэж Крам хэлэв.
- Крам түүнийг аварсан гэдгээ сануулахын тулд анхаарлыг нь татахыг оролдсон ч Гермiona тоолгүй цохоо унагаад Харрид хандан,

- Чи цагтаа амжаагүй нь харамсалтай... Биднийг удаан хайсан уу? гэв.

- Үгүй дээ... Би түргэн олсон.

Харри ямар тэнэг болохоо мэдэрлээ. Энд хуурай газар дээр байхад Дамблдор олзлогдогчидод үхэх боломж өгөхгүй нь тодоос тод байв. Роныг аваад явах хэрэгтэй байж ямар тэнэг юм бэ! Хамгийн түрүүнд ирэх байжээ... Седри, Крам хоёр бусдад санаа зовж цаг үрээгүй болохоор усны хүмүүсийн дууг ноцтойгоор хүлээн аваагүй бололтой...

Дамблдор эрэг рүү бөхийн удирдагч нь бололтой хамгийн хэрцгий төрхтэй усны хүнтэй ярилцаж байлаа. Дамблдор огцом исгэрсэн чимээ гарган тэдний хэлээр ярилаа. Эцэст нь тэр цэхлэн босоод шүүгчдэд,

- Оноо өгөхийн өмнө зөвлөлдөх хэрэгтэй боллоо гэв.

Шүүгчид түүн рүү очив. Хатагтай Помфри Роныг Персигийн тэврэлтэнд өгөөд чинжүүт уусмалаа барин Флер болон түүний дүү рүү очлоо. Флерийн царай болон гар нь маш олон зүсүүлсэн хэр нь хатагтай Помфрид эмчилэх боломж олгосонгүй.

- Габриэлийг хараач гэж тэр хатагтай Помфригаас гуйгаад Харри руу эргэн,

- Чи миний дүүг аварсан. Тэр чиний олзлогдогч биш байсан ч гэлээ хэмээн хөөрөн хэлэв.

- Аварсан гэж Харри хэлэхдээ бүх гурван охиныг тэнд нь уяатай орхисон болоосой гэж чин сэтгэлээсээ хүслээ.

Флер бөхийн Харрийн хацар дээр үнсээд (тэр улайгаад ахиад л чихнээс нь утаа гараагүй байгаа даа гэж боджээ) Рон руу эргэлээ.

- Харин чи түүнд тусалсан гэж тэр хэлэв.

- Тиймээ. Жаахан л гэж Рон найдангүй хэлэв.

Флер түүнийг үнслээ. Гермiona уурссан янзтай харагдав.

Тэдний ард Людо Бэгмений шидэт дуу гарахад үзэгчид чимээгүй болов.

- Ноёд хатагтай нараа бид шийдвэр гаргалаа. Усны хүмүүс бидэнд нуурын ёроолд юу болсныг хэлсний дагуу аваргуудыг тавь хүртэлх оноогоор дүгнэх болно.

- Хатагтай Флер толгойгоо хөөс болгох маш сайн шившлэг хийсэн ч түүнийг гриндилоу дайрсны улмаас гол зорилго болох өөрийн олзлогдогчоо аварч чадаагүй байна. Бид түүнд хорин таван оноо өгч байна.

Үзэгчид алга ташив.

- Би тэг авсан ч болно гээд Флер толгойгоо сэгсрэв.

- Ноён Седрик Диггори мөн адил шившлэг хэрэглэн толгойгоо хөөс болгож олзлогдогчоо аван хамгийн түрүүнд ирсэн ч нэг минут хожигдсон. Ноён Диггорт дөчин долоон оноо өгч байна. Пуффендуйн үзэгчид орилон алга ташихад Чжоу түүн рүү аз жаргалтай нүдээр харав.

Харрийн зүрх шимширлээ. Хэрвээ Седрик цагтаа амжаагүй бол тэр ч гэсэн хожигдсон байх нь.

- Ноён Виктор Крам бүрэн бус хувирсан явдал нь даалгавар биелүүлэхэд саад болсонгүй. Тэр олзлогдогчтойгоо хоёрт ирсэн. Түүний үнэлгээ дөчин оноо.

Каркаров бардмаар бүгдээс чанга алга ташив.

- Ноён Харри Поттер жабросли хэрэглэн маш сайн үр дүн үзүүллээ. Тэр хамгийн сүүлд эргэж ирсэн. Гэсэн хэдий ч усны оршин суугчид ноён Харри Поттер хамгийн түрүүнд олзлогдогчоо олсон ч зөвхөн өөрийнхийгөө ч бус бусдыг аврахыг хүссэн учир саатсан гэж мэдэгдлээ.

Рон, Гермиона хоёр Харри руу гашуудалтай харлаа.

- Бараг бүх шүүгчид гээд Бэгмен Каркаров руу хяламхийснээ,

- Энэхүү гавъяаг нь үнэлэн хамгийн өндөр оноо өглөө. Ингээд бүгд... ноён Поттерын оноо дөчин тав боллоо гэв.

Харрийн зүрх аз жаргалтайгаар цохилон. Тэр Седриктэй нэгдүгээр байрыг хуваан эзэлжээ. Рон, Гермиона хоёр гэнэтийн явдалд гайхан Харри руу амаа ангайн хараад инээлдэн чанга алга ташлаа.

- Чи тэднийг хожсон, Харри! Ёс суртахуунтай байсныхаа төлөө гэж Рон хашгирав.

Флер ч гэсэн бүх хүчээ гаргах алга ташихад, Крам Гермионатай ахин ярихыг хичээсэн ч цаадах нь Харрид баяр хүргээд анзаарсангүй.

- Гурав дахь буюу хамгийн сүүлчийн тэмцээн зургаан сарын хорин дөрөвний үдэш болно. Аваргуудад сарын өмнө юу хүлээж байгааг хэлэх болно. Та бүхэнд оролцогчдыг халуун дотноор дэмжсэнд талархлаа.

Болчихлоо гэж Харри гайхширан бодоод хатагтай Помфри аваргууд болон олзлогдогч нарт нь хуурай хувцас өгөхөөр гүйн одохыг харлаа... Бүгд ард хоцорлоо... Одоо зургаан сарын хорин дөрвөн хүртэл юунд ч санаа зоволгүй тайван амьдарч болох нь байна...

Шилтгээний чулуун шатаар өгсөхдөө Харри ойрын үед Хогсмид явж Доббид дараа жил хүртэл өдөр болгон өмсч болох оймс авч өгөхөөр шийдлээ.

БҮЛЭГ 27: ТЭНҮҮЛЧ БУЦАЖ ИРСЭН НЬ

Хоёр дахь тэмцээний дараа сургууль даяараа нууранд аваргуудад тохиолдсоныг сонирхсон бөгөөд мэдээж Рон анхаарлын төвд байж Харригийн гавьяанаас хуваалцлаа. Тэр өдөрт арван удаа өөрийн адал явдлын тухай ярьж, ярих болгондоо нарийн ширийн явдлыг нь өөрчилж байлаа. Эхний удаад нь Рон, Гермiona хоёрыг МакГонагалл дуудаж тэнд Дамблдор тэднийг олзлогдогчид болсон бөгөөд Нойрсуулах шидийн тусламжтай унтуулан зөвхөн уснаас гарахдаа сэрэх юм гэж батлан хэлсэн тухай үнэнийг өгүүлж байв. Долоо хоногийн дараа түүний хулгайлагдсан аймшигт түүх ганц биеийн тоон дээр хувирч хадан дээр хүлэх гэсэн тавин ширхэг хуягласан усны хүний эсрэг тэмцэл болж хувирав.

Рон алдартай болсон болохоор Падма Патил түүнд таатай хандаж хонгилд тааралдахдаа үйл явдлын талаар асуух боломжыг алдахгүй байлаа.

- Би шидэт саваагаа ханцуйндаа нуусан болохоор энэхүү усны тэнэгүүдийг арчиж хаяхад юу ч садаа болоогүй гэж Рон итгүүлэв.

- Хурхиралтын тусламжтай юу? гэж Гермiona хорон үгээр идлээ. Хүмүүс түүнийг Виктор Крамын сэтгэл зүрхний хатагтай гэж шоолж байсан болохоор ааш муутай байлаа.

Рон чихээ хүртэл улайгаад тэмцлийн тухай өөр юм ярьсангүй.

Гурван сард хуурай байсан хэдий нүүр, гар хүйтэн салхинд бээрч байлаа. Хүчтэй салхины улмаас шуудан хоцорч байв. Бор ууль Сириусын захиаг баасан гаригийн өглөөний цайны үеэр авчирахдаа өд сөд нь сэгсийж боссон байв. Харри түүний сарвуунаас зурвасыг авахад ахин өөр хаа нэг тийшээ илгээхээс айсан мэт нисэж одов.

Сириус өнгөрсөн удаагийнх шиг товчхон захиа бичжээ.

Бямба гаригийн хоёр цагаас Хогсмид тосгоны захад (Дэрвиш Бэнгсийг өнгөрөөд) хүрээд ир. Хоол авчраарай.

- Тэр Хогсмидэд ирэх гэж байгаа юм уу? гэж Рон гайхлаа.

- Тэгэх гэж байгаа бололтой гэж Гермiona хэлэв.

- Түүний барьчихвал яана гэж Харри айлаа.

- Боль доо! Одоо хүртэл бариагүй л байгаа биз дээ. Тэгээд ч Хогсмидэд демонторууд байхаа больсон гэж Рон хэллээ.

Харри зурвасыг хуйлаад халаасандаа хийлээ. Тэр үнэнийг хэлэхэд Сириустай уулзахыг маш их хүсч байв. Баасан гаригийн сүүлчийн хоёр цаг уусмалын хичээл байсан ч газар дорхи хонгил руу халаасандаа зурвастай хөгжилтэй орлоо.

Ангийн гадаа Малфой, Крэбб, Гойл, Пэнси Паркинсон тэргүүтэй Слизеринийхэн зогсоод ямар нэг юм харан чанга инээлдэж байв. Гойлын тарган мөрөн дээгүүр Пэнси цухуйж тэдний ойртон ирэхийг дооглонгүй харлаа.

- Тэд хүрээд ирлээ! гэж тэр хөхрөхөд Слизеринийхэн хойшоо боллоо. Пэнсигийн гарт эмэгтэйчүүдийн <<Шидтэн>> гэдэг сэтгүүл байв. Хавтсан дээр нь буржгар үстэй шидтэн том бялуу руу саваа чиглүүлэн инээмсэглэж харагдана.

- Унш, Грэйнджер. Чамд таалагдана гэж Пэнси хашгираад сэтгүүлээ Гермиона руу шидэв. Тэр цочсон ч сэтгүүлийг барьж авлаа. Энэ агшинд Снегт хаалга нээж сурагчдыг хичээлдээ орохыг дохив.

Гермиона, Харри, Рон гурав ердийнхөөрөө хамгийн ард талын ширээнд суулаа. Снегт самбар луу эргээд шохойгоор шинэ уусмалын жор бичив. Гермиан сэмхэн сэтгүүлээ шагайв. Тэр сэтгүүлийн мэдээллийн гол дүр болжээ. Харри, Рон хоёр ойртон бөхийв. Дээд талын хуудсан дээр Харригийн өнгөтэй гэрэл зураг байх агаад түүний доор Рита Скитерийн ээлжит нийтлэл байлаа.

ХАРРИ ПОТТЕРЫН ШАРХАЛСАН ЗҮРХ

Харри Поттер ер бусын хүү хэдий ч өсвөр насны хүүхдийн сэтгэлээр унах явдал тойрч гарсангүй. Бага насандаа эцэг эхийнхээ эмгэнэлт үхлийн улмаас хайр эдлээгүй түүнийгээ сургуулийн найз Гермиона Грэйнджерээр тайтгаруулна гэж бодсон байх. Гэхдээ түүнд маш түргэн шинэ цохилт иржээ.

Хатагтай Грэйнджер маглуудын гэр бүлд төржээ. Энэхүү огтхон ч гайхамшигтай биш охин нэр алдарт дуртай бөгөөд их зантай юм. Алдартай болоход түүнд ганц Харри Поттер багадсан байна.

Гурван шидтэний тэмцээнд оролцохоор Хогвартст Дэлхийн цомын тэмцээний баатар Болгарын баригч Виктор Крам иржээ. Хатагтай Грэйнджер түүнийг урхиндаа оруулж хоёр алдартай хүний сэтгэл зүрхээр тоглосон байна. Крам тэр ч байтугай түүнийг зуны амралтаараа Болгард ирэхийг урьжээ. <<Би хэзээ ч үүнтэй төстэй охинтой тааралдаж байсангүй>> гэж Виктор Крам хэлсэн байна.

Хатагтай Грэйнджер золгүй хөвгүүдийн сэтгэл зүрхийг татах төрөлхийн увдистай гэдэг нь тодорхой.

Тэр бол зүгээр л аймшиг. Түүнд тархи бий болохоор Хайрын уусмал чанаж чадна. Минийхээр бол ингэсэн байж таарна гэж дөрөвдүгээр дамжааны охин Пэнси Паркинсон хэлжээ.

Хогвартст Хайрын уусмал хориотой болохоор Альбус Дамблдор эргэлзээгүй сурагчынхаа амжилтыг сонирхох хэрэгтэй. Харин Харри Поттерийн хувьд дараагийн удаа сэтгэл зүрхээ илүү найрсаг охинд өгнө гэж найдах л үлдлээ.

- За тэр би хэлсэн биз дээ? Би Рита Скитерийг уурлуулах хэрэггүй гэж анхааруулсан! Тэр чамайг сэтгэл зүрхийг зальхайгаар уруу татагч болгож байна. Өөрөөр хэлбэл ертөнцийн гамшиг! гэж Рон Гермионад шивнэлээ.

- Юу гэнээ? хэмээн Гермиона инээдээ барьж ядан Рон руу харлаа.

- Миний ээж тэгж хэлдэг юм гэж Рон ичингүйрэн хэлээд чихээ хүртэл улайлаа.

- Тэр энэ удаад оносон юм алга. Зүгээр л зохиогоод биччихэж. Шал дэмий юм! гэж Гермиона инээсэн хэвээр хэлээд сэтгүүлийг сандал дээр тавилаа.

Гермиона түүнийг ширтэн ичингүйрэх юмуу сэтгэлээр унахыг нь хүлээж байгаа Слизеринийхний зүг харлаа. Тэрбээр тэдэнд даажигнан инээмсэглэж гар даллаад Харри, Рон хоёртой хамтдаа Ой ухаан хурцалдаг уусмал бэлдлээ.

- Нэг л хачирхалтай юм. Рита Скитер энэ бүхнийг яаж мэдсэн юм бол? гэж тэр арван хормын дараа нэг гартаа нүдүүр, нөгөө гартаа хатсан цохтой уур барьж бодлогоширон хэллээ.

- Юу мэдсэн гэж? Чи үнэхээр Хайрын уусмал чанаж чаддаг юм уу? гээд Рон гайхан түүн рүү харлаа.

- Битгий тэнэг юм яриад бай! Мэдээж үгүй. Тэр Виктор Крам намайг зуны амралтаар урьсныг мэдсэн яаж юм бол? гээд Гермиона цохоо нүдэнгээ улайгаад цаашаа харлаа.

- Юу гэнээ? гээд Рон нүдээрээ унагахад түсхийх чимээ гарав.

- Нуураас гаргаад хэвийн толгойтой болсон хойноо шууд урьсан. Хатагтай Помфри бидэнд хөнжил өгөхөд тэр намайг шүүгчдэд сонсогдохгүйгээр холдуулан хэрвээ надад зун ямар нэгэн төлөвлөгөө байхгүй бол...

- Чи түүнд юу гэж хэлсэн? гээд Рон нүдүүрээ авч Гермиона руу харлаа.

- Тэр өмнө хэзээ ч надтай адил охинтой тааралдаж байгаагүй гэж хэлсэн хэмээн Гермиона улайн хэллээ. Харрид хүртэл түүнээс халуу дүүгэх нь мэдэгдлээ.

- Гэхдээ Рита Скитер яаж сонссон юм бол? Тэнд байгаагүй шүү дээ. Эсвэл байсан юм болов уу? Магадгүй үл үзэгдэх цувтай Хогвартсын хоёр дахь тэмцээн дээр ирсэн юм болов уу?

- Чи түүнд юу гэж хэлсэн? гэж Рон асуултаа давтаад нүдүүрээ ширээ цөмөртөл буулгав.

- Би та хоёрыг хүлээгээд түүнтэй манатай байсан...

- Хатагтай Грэйнджер таны хувийн амьдрал онц сонирхолтой гэдэг нь эргэлзээгүй ч хичээл дээр ярих хэрэггүй. Гриффиндороос арван оноо хаслаа гэх хүйтэн хоолой сонсогдоход гурвуул цочлоо.

Снегг чимээгүйхэн дэргэд нь хүрч ирээд яриаг нь сонссон байлаа. Ангиараа тэдэн рүү харахад Малфой энгэр дээрх <<ПОТТЕР ӨМХИЙ>> гэсэн тэмдгээ гялалзуулав.

- Бас хичээл дээр сэтгүүл уншиж байгаа хэрэг үү! гээд тэр <<Шидтэн>> сэтгүүлийг авлаа.

- Ахиад арван оноо хаслаа! Тэгэлгүй яахав. Поттер сонины өгүүлэлд гарахгүйгээр амьдарч чадахгүй юмаа гэж Снегг хэлээд хар нүд нь гялсхийв.

Слизеринийхэн хөхрөлдөхөд Снеггийн уруул дээр ёжтой инээмсэглэл тодорч сэтгүүлийг аваад Харригийн уурыг хүргэн чанга уншлаа.

- <<Харри Поттерын шархалсан зүрх>>... Поттер таны зүрхэнд энэ удаад юу тохиолдоо вэ? <<Харри Поттер ер бусын хүү...>>

Харрийн царай улайлаа. Снегг мөр болгонд зогсон Слизеринийхнийг инээлдэх боломж олгож байв. Түүний уншиж байгаа нийтлэл арав дахин муухай сонсогдох аж. Гермиона хүртэл улайжээ.

- <<...Харин Харри Поттерийн хувьд дараагийн удаа сэтгэл зүрхээ илүү найрсаг охинд өгнө гэж найдах л үлдлээ.>>. Ямар уярмаар юм бэ! гээд Снегг дуусгаад сэтгүүлийг Слизеринийхний хөхрөлдөөн дунд хуйлав.

- Та гурвын хайрын холбоог эвдэхийн тулд салгах хэрэгтэй болох нь. Уизли эндээ үлд. Хатагтай Грэйнджер хатагтай Паркинсоны хажууд суу. Харин Поттер миний урд талын ширээнд суу. Хөдөлцгөө! Цаг яваад байна шүү!

Харри уурсан цүнх болон уусмалын орц, тогоогоо аваад багшийн урд талын хоосон ширээн дээр суулаа. Снегг байрандаа суугаад түүнийг хэрхэн тогоогоо тавихыг харна. Харри Снегг рүү харахгүйг хичээн ахин цохыг нүдүүрээрээ нухав.

- Поттер таны тухай хэтэрхий их бичиж байна. Алдар нэрд толгой чинь эргэж гүйцжээ гэж Снегг аяархан хэлэв.

Харри чимээгүй байлаа. Снегг түүнийг уурлуулахыг оролдож байна. Түүнд зөвхөн шалтаг өгөх л юм бол Гриффиндорос тавин оноо хасах байлаа. Хичнээн удаа тэгж байлаа!

- Та шидтэнийг ертөнцийг төөрөгдүүлж чадна гэж боддог уу? гэж Снегг аяархан хэнд ч сонсогдохооргүй хэллээ. (Харри цохоо үргэлжлүүлэн нухахад тэд хэдийн нунтаг болон хувирчээ).

- Гэвч надад таны зураг хэдэн удаа сонин дээр гарах чинь хамаагүй. Миний хувьд Поттер та бол ердөө сургуулийн дүрэм журмыг бичигдээгүй гэж үздэг олиггүй нэг хүү.

Харри бэлтгэсэн нунтагаа тогоондоо хийгээд цагаан гааны үндэс хэрчиж эхлэв. Түүний гар үл ялиг чичирэхэд Снеггийн яриаг сонсоогүй дүр эсгэв.

- Би жинхэнээсээ анхааруулж байна шүү, Поттер. Та алдартай эсэх чинь огтхон ч хамаагүй ахиж нэг л удаа миний өрөөнд орохыг оролдох юм бол... гэж Снегг заналхийлсэн хоолойгоор хэлэв.

- Би таны өрөөний хажуугаар ч өнгөрөөгүй! гэж Харри сонсоогүй дүр эсгэж байснаа маргаад хэллээ.

- Бүү худал хэл! Бумслангын арьс, жабросли миний хувийн нөөцөнд байдаг. Би хэн тэднийг миний нөөцөөс хулгайлсныг мэдэж байна гэж Снегг зандраад Харриг хар нүдээрээ өрөмдөн харлаа.

Харри нүд цавчилгүй Снеггийн нүд рүү зоригтой ширтэв. Тэр үнэхээр түүний өрөөнөөс юу ч хулгайлаагүй юм. Бумслангын арьсыг хоёрдугаар дамжаанд Гермиона Хувиргагч уусмал бэлтгэхийн тулд авсан билээ. Снегг Харриг хичнээн сэжиглэсэн ч тэр үед юу ч баталж чадаагүй. Харин жаброслигийн хувьд бол Добби л хулгайлсан байж таарлаа.

- Би таны юу яриад байгааг ойлгохгүй байна гэж Харри хүйтнээр хэлэв.

- Миний өрөөнд хулгай орсон шөнө унтлагын өрөөндөө байгаагүйг чинь би сайн мэдэж байна! Хурц нүдэт Грюм таны шүтэн бишрэгчдийн фэн клубт нэгдэж орсон ч гэлээ би чиний зан авирыг тэвчиж чадахгүй шүү. Ахиад нэг л удаа миний өрөөнд орох юм бол. Поттер, чи үүнийгээ хатуу төлнө шүү!

- За яахав. Хэлснээр чинь хийе гэж Харри хүйтнээр хэлээд цагаан гааны үндэс рүүгээ эргэв.

Снеггийн нүд гялалзан жанч руугаа гар сунгалаа. Харри агшин зуур түүн рүү шившлэг илгээх нь гэж айсан ч гартаа тунгалаг шингэнтэй жижигхэн шилэн сав гаргаж ирэв.

- Энэ юу болохыг мэдэх үү, Поттер? гэж тэр асуугаад ахиад л нүдээ ууртайгаар гялалзуулав.

- Үгүй гээд Харри шил рүү нүд салгалгүй ширтлээ.

- Энэ бол Үнэн илрүүлэгч уусмал жинхэнэ үнэнийг хэлүүлдэг юм. Энэ их хүчтэй болохоор бүх нууцаа хэлэхэд гуравхан дусал хангалттай. Энэ уусмал ид шидийн яамны хүчтэй хяналтан дор байдаг юм. Гэхдээ би санамсаргүй хоолон дээр чинь хулууны шүүсэнд чинь хольж чадна. Тэр үед Поттер бид миний өрөөнд байсан эсэхийг чинь мэдэх болно гэж шилэн савыг сэгсчин заналхийлэн хэлэв.

Харри юу ч хэлэлгүй ахиад л цагаан гааны үндэс рүүгээ эргэн хутга авч хэрчиж эхлэв. Мэдээж Снеггэд шалтгаан өгөх л юм бол сүрдүүлгээ хэрэгжүүлэх болно. Тэр энэ уусмалын үйлчлэл дор юу хэлэхийг бодохоос ч аймшигтай байлаа. Найзуудаа барьж өгч Гермiona, Добби хоёрын тухай хэлэн Сириусын нууц захианы тухай... бас Чжоугийн тухай гэж бодтол Харрийн зүрх булгилав. Тогоондоо хийх зуураа Харри Грюмын зөвхөн өөрийн савнаасаа хэрэглэдэг жишээг дагадаг ч юмуу гэж бодлоо.

Ангийн хаалга тогшив.

- Ороорой гэж Снегг ердийн хоолойгоор хэллээ.

Хаалга нээгдэн Каркаров орж ирээд сурагчдын гайхсан харцны өмнө ширээн дундуур явлаа. Тэр их түгшсэн байртай ямаан сахлынхаа үзүүрийг хуруугаараа имэрч байв.

- Бид ярилцах хэрэгтэй байна гэж тэр хэлээд Снеггэд дөхөж очив. Каркаров Снеггээс ондоо хэнд ч сонсогдохыг хүсээгүй бололтой бараг уруулаа хөдөлгөхгүй шахам хэлэв. Харри үндсээ бэлдэх зуураа чих тавилаа.

- Хичээлийн дараа ярилцъя гэж Снегг гэнэтийн зочин түүнийг сатааруулсан явдалд аяархан хэлэв.

- Хором байхад л болно. Чи хаашаа ч зайлахгүй, Северус. Чи яагаад надаас зугтаад байгаа юм бэ?

- Хичээлийн дараа! гэж Снегг шивнэлээ.

Харри шилэн аяга руу авах гэж байгаа дүр үзүүлэн профессор Снегг болон зочин руу нь харлаа. Каркаровын сэтгэл хүчтэй донсолж, харин Снегг уурласан байлаа.

Каркаров Снеггийг энэ удаад зугтахаас сэргийлсэн мэт хичээлийн туршид ард нь зогслоо. Харрид Каркаров яагаад хүрч ирсэн нь сонирхолтой байв. Сурагчид юм хумаа хураагаад ангиас гарахад Харри тогоогоо угаах гэж буй дүр үзүүлэн үлдээд чих тавилаа.

- Юу болсон бэ? гэж Снегг шивнэлээ.

- Энэ гэж Каркаров хэлэв.

Харри тогооныхоо араас харлаа. Каркаров зүүн гарынхаа ханцуйг сөхөн бугуйн дээрээ байгаа нэг юмыг үзүүлж байв.

- Харав уу? Хэзээ ч ийм тод байгаагүй юм шүү гэж Каркаров бараг уруулаа хөдөлгөхгүй шахам хэлэв.

- Одоохон гараа буулга гэж Снегг тушаагаад ангийг гүйлгэн харав.

- Чи үнэхээр юу ч ажигласангүй гэж үү? гэж Каркаров бухимдлаа.

- Дараа ярилцъя, Каркаров гэж Снегг түүний яриаг таслаад,

- Поттер та энд юугаа мартаа вэ? гэлээ.

- Тогоогоо цэвэрлэж байна, профессор гэж Харри гэмгүй царайлан хэлээд нойтон алчуураа үзүүлэв.

Каркаровын царайнд уурссан өнгө тодорч өсгий дээрээ эргэн ангиас гарч одов. Харри уусмалын профессортой ганцаар үлдээд яаран сурах бичиг болон уусмалын орцоо цүнхэлж Каркаровын араас гарлаа. Хаалганы ард түүнийг Рон, Гермiona хоёр хүлээж байв. Тэр тэдэнд сонссон зүйлээ ярилаа.

Маргааш нь үд дунд Харри, Рон, Гермiona гурав Хогсмид явлаа. Тэнгэр цэлмэж нар ээнэ. Найзууд мөрөн дээрээ жанчаа тохоод, Харри цүнх дүүрэн арваад тахианы гуя, бүтэн талх, хулууны шилтэй шүүс зэрэг Сириусэд өгөх зүйл авч явлаа.

Замдаа <<Үл үзэгдэх малгай>> гэдэг дэлгүүрт орж Доббид алт мөнгөн гялалзсан од бүхий оймс өөр нэг хосын хамт сонгон авахдаа хөгжилдлөө. Нэг хагаст дэлгүүрээс гарч тосгоны хамгийн захын мухлаг болох <<Дэрвис Бэнгс>> руу явлаа.

Харри Хогсмидэд ийм алс явж байсангүй. Тахиралдсан зөрөг зам үргэлжлэх тусам байшингууд цөөрөн цэцэрлэг улам өтгөн болж байв. Уул руу өгсөхийн өмнө зам сүүлчийн удаа хашаан дундуур гарлаа. Тэнд тэднийг шүдэндээ сонин зуусан танил сэгсгэр хар нохой хүлээж байв.

- Сайн уу, Сириус гэж Харри хэлэв.

Хар нохой тахианы аятайхан үнэр ханхалж байгаа Харрийн цүнхийг үнэрлэв. Тэр сүүлээ хөдөлгөн хашаан дээгүүр харайгаад уул руу өгсөн гүйлээ. Андууд хашааг даваад араас нь яарлаа.

Сириус тэднийг битүү үхэр чулуутай газар хөтөлж ирэв. Тэрбээр дөрвөн хөл дээрээ хөнгөхөн гүйх агаад Харри, Рон, Гермiona гурав амьсгаадан хөл нь цуцаж эхлэв. Хүнд цүнх нь Харрийн мөр лүү чангаана. Хагас цаг мацсаны эцэст Сириус нарийхан ангал руу ороод гэнэтхэн алга болоход найзууд араас нь сэрүүхэн харанхуй агуй

орлоо. Агуйн буланд том чулуунаас Клювокрылыг уяжээ. Хагас морь, хагас бүргэд гиппогриф тэднийг шаргал нүдээрээ ууртай ажиглав.

Андууд түүнд бөхийн ёслоход хагас минутын дараа хүлээн авч хайрслал өвдөг дээрээ эелдэгээр бөхийн ёслол. Гермiona түүн рүү гүйн очиж хүзүүг нь илэв. Харри загалмайлсан эцэг нь болж хувирч байгаа хар нохойг нүд салгалгүй ширтлээ.

Сириус Азкабанаас зугтахдаа өмсөж байсан саарал жанчаа өмсчээ. Харритай амралтын өрөөнд ярьсан үеэс хойш хар үс нь урт ургаж удтал угааж самнаагүйн улмаас сэгсийжээ. Тэр бүр турж яс арьс болжээ.

- Тахиа! гэж Сириус сөөнгөтөн хэлээд амандаа зуусан <<Зөнч>> сонины дугаарыг шалан дээр унагалаа.

Харри мөрнөөсөө үүргэвчээ авч боодолтой тахианы гуя болон талх гаргаж хутганы хамтаар Сириуст өглөө.

- Баярлалаа! гэж тэр хэлээд хоолыг авч чулуун шалан дээр суугаад шүдээрээ зулгаангаа,

- Энд зөвхөн харх л байх юм. Хогсмидоос их хоол хулгайлж болохгүй байдаг. Сэжиг төрүүлэхгүйн тулд эелдэг байсан нь дээр шүү дээ хэмээн инээмсэглэхэд Харри ч бас инээмсэглэлээ.

- Чи энд юу хийж байгаа юм бэ, Сириус?

- Загалмайлсан эцгийн үүргээ биелүүлэх гэж явна гээд тахианы ясыг нохой шиг мэрэх зуураа,

- Чи түгших хэрэггүй дээ. Би үргэлж жирийн тэнэмэл нохойны дүр үзүүлдэг. Ойрхон байхыг хүссэн юм. Чи сүүлчийн захиандаа... Ер нь бол үүл бүрхээд байна. Би хүмүүсийн хуучин сонинг хулгайлж мэдээлэл авч байгаа болохоор үүнийг мэдрээд байна гэж Харрийн түгшсэн харцыг ажиглаад нэмэрлэв..

Тэр шалан дээр хэвтэж байгаа <<Зөнч>> сонины шар хуудас руу дохиход Рон тэднийг цуглуулав.

- Чамайг барьчихвал яана? Гэнэт мэдчихвэл яана? гэж Харри тайвширсангүй.

- Дамблдор та гурваас өөр хэн ч намайг анимаг гэж мэдэхгүй гэж Сириус мөрөө хавчаад тахианы ясыг үргэлжлүүлэн мэрэв.

Рон Харриг тохойгоороо түлхээд <<Зөнч>> сонины хоёр дугаар сунгалаа. Эхний сонины тэргүүн нүүрэн дээр <<Барти Краучын нууцлаг өвдөл>> гэж байсан бол, нөгөөдөх дээр нь <<Ид шидийн яамны ажилчин алдагдлаа. Сайд хувийн хяналтаа чангатгах хэрэгтэй болжээ>> гэжээ.

Харри Каручын тухай нийтлэлийг гүйлгэн харав. Мөр болгоноос <<... хэн ч түүнийг арван нэгэн сараас хойш хараагүй байна... гэрт нь хэн ч байгаагүй... Гэгээн Мунгогийн шидэт өвчин эмгэгийн эмнэлэг тайлбар өгөхөөс татгалзлаа... Ид шидийн яам хүнд өвчний тухай цуу яриаг батлаагүй байна...>> гэж хашгирч байлаа.

- Ноён Краучыг үхсэн гэж бодоход хүрэх нь байна. Гэхдээ тэр хүнд өвдсөн бол Хогвартст ирэхгүй шүү дээ гэж Харри удаанаар хэлэв.

- Миний ах Краучын ойрын туслах. Тэр Краучыг өвдсөн гэж хэлсэн юм хэмээн Сириуст Рон мэдэгдэв.

- Миний нэр цомоос үсрэн гарсан тэр үдэш ноён Крауч үнэхээр өвдсөн харагдаж байсан. Түүнээс хойш би түүнийг харсангүй гэж Харри хэлээд сонинг үргэлжлүүлэн уншив.

- Гайхах зүйлгүй Винкиг хөөсний шанд бие нь муудаа биз. Түүнийг байгаа байхгүйн ялгааг одоо л мэдэрсэн байх даа хэмээн Гермiona Ключокрылыг илсэн хэвээр хэлэв.

- Гермiona зөвхөн гэрийн үйлчлэгчид санаа зовдог гэж Рон бувтнаад баргар царайлан харлаа.

Сириус сонирхсон байртай харагдав.

- Крауч гэрийн үйлчлэгчээ хөөсөн гэж хэлсэн үү?

- Тиймээ, Дэлхийн цомын тэмцээн дээр гэж Харри хэлээд Хар тамга илгээгдсэн газраас Винки гэмт хэрэг үйлдэгдсэн Харрийн саваатай баригдахад ноён Крауч хэр уурласан тухай тайлбарлав.

Харригийн яриаг сонсох зуураа Сириус босоод холхиж эхлэв.

- Алив үйл явдлын зураглалыг босгох гэж оролдъё. Чи эхлээд үйлчлэгчийг үзэгчдийн суудал дээр ялангуяа онцгой албаны суудал дээр харсан байна. Тэр Краучид байр хадгалж байжээ. Тийм үү? гэж хормын дараа хэлээд дараагийн тахианы гуяа авлаа.

- Тийм гэж Харри, Рон, Гермiona гурав батлав.

- Гэхдээ Крауч тэмцээн дээр ирээгүй. Тийм үү?

- Тийм. Тэр их завгүй байсан гэж хэлсэн санагдаж байна гэж Харри хэлэв.

Хэсэг хугацааны турш Сириус чимээгүйхэн холхиж байснаа,

- Харри чамайг дээд талын суудалд байх үед шидэт саваа халаасанд чинь байсан уу? гэв.

- М-м. Үгүй ээ, санахгүй байна. Надад хэрэг болоогүй болохоор анзаарсангүй. Би халаасандаа гараа ойд орсон хойноо хийхэд зөвхөн омниокль байсан юм. Чи хэн нэгэн миний савааг дээд талын суудал дээр байхад хулгайлсан гэж бодож байна уу? Харин дараа нь түүгээр тэнгэрт Хар тамга илгээсэн байж болох уу?

- Бүрэн боломжтой гэж Сириус толгой дохив.

- Гэхдээ Винки энд ямар ч хамаагүй! гэж Гермiona хашгирав.

- Үйлчлэгч ганцаараа тавцан дээр байгаагүй. Ингэхэд ард чинь хэн сууж байсан бэ? гэж Сириус хөмсгөө зангидлаа.

- Олон хүн байсан. Болгарын яамны сайд... Корнелиус Фаж... Малфой...

- Яг тийм Малфойнхон! Тэд л байж таарна! гэж Рон дуу алдав. Түүний дуу агуйд цуурайтахад Клювокрыл гайхан толгойгоо өргөлөө.
 - Өөр хэн тэнд сууж байсан? гэж Сириус асуув.
 - Өөр хэн ч байгаагүй гэж Харри хариуллаа.
 - Яагаад хэн ч байхгүй гэж? Людо Бэгмен байсан биз дээ? гэж Гермиона сануулав.
 - Аан, тийм л дээ...
 - Бэгменийг би мэдэхгүй. Түүнийг зөвхөн <<Уимбурийн хэдгэнүүд>> багт тоглодог байсныг мэднэ. Та нар түүний талаар юу мэдэх вэ?
 - Бараг юу ч... Намайг Гурван шидтэний тэмцээнд ялуулахын тулд туслах гэж байсан.
 - Туслахыг оролдсон гэнээ? Яах гэж? хэмээн Сириус хөмсгөө улам зангидлаа.
 - Намайг таалагддаг гэж хэлсэн.
 - Хм... гэж Сириус бодлогоширов.
 - Тэр Хар тамга тэнгэрт үзэгдэхээс өмнө ойд байсан. Санаж байна уу? гэж Гермиона хэлэв.
 - Тиймээ, гэхдээ ойд үлдээгүй биз дээ? Бид түүнд буудалд үймээн дэгдсэн гэж хэлсэн болохоор тийшээ шилжсэн байх гэж Рон хэллээ.
 - Чи хаашаа шилсэнийг нь яаж мэдэж байгаа юм бэ? гэж Гермиона эсэргүүцэв.
 - Больж үз! Чи Людо Бэгмен тэнгэрт Хар тамга илгээсэн гэж хэлэх гээд байгаа юм уу? гэж Рон итгэлгүйхэн асуув.
 - Энэ чинь Винкитэй адилхан л байгаа биз дээ гэж Гермиона зөрүүдлэв.
 - Би Гермиона зөвхөн гэрийн үйлчлэгчид санаа зовж байгаа гэж хэлсэн биз дээ хэмээн Рон Сириус руу учиртай харав.
- Сириус гараа өргөн тэднийг чимээгүй болголоо.
- Тэгэхээр Хар тамга илгээгдсэн газраас Харрийн савааг гартаа барьсан үйлчлэгч олдсон... Тэгээд Крауч яасан бэ?
 - Бут руу ухасхийсэн. Тэнд хэн ч байгаагүй л дээ гэж Харри хэллээ.
 - Ойлгомжтой. Тэр үйлчлэгчээ сэжиглүүлэхгүйн тулд буруугаа хэн нэгэнд тохохыг хүсчээ. Харин дараа нь түүнийг хөөсөн гэл үү?
 - Тиймээ, хөөсөн! Түүнийг зөвхөн майханд гишгүүлэхгүйн тулд зугтсаны төлөө шүү дээ гэж Гермиона хатуу хэлэв.
 - Гермиона, чи хэзээ үйлчлэгчид санаа зовохоо болих юм бэ? гэж Рон тэссэнгүй.
 - Гермиона Крауч хэн болохыг чамаас илүү ойлгож байна, Рон. Хүнийг сайн танихын тулд өөртэйгээ чацуу болон доод тушаалын хүнтэй яаж хандаж байгаагаар нь мэдэж болно гээд Сириус толгой сэгсэрлээ.

Тэрбээр үс сахалд баригдсан нүүрээ гараараа илээд гүнзгий бодлогоширов.

- Энэ бүхний дараа Барти Крауч алга болсон... Үйлчлэгчдээ суудал хадгалахыг тушаагаад харин өөрөө нэг тийш алга болсон. Гурван шидтэний тэмцээний зохион байгуулагч хэрнээ тэмцээний үеэр үзэгдээгүй. Энэ Краучтай төсгүй л байна даа. Хэрвээ Крауч өвчнөөс болж ажилдаа ирээгүй удаа бий гэвэл Ключокрылыг идсэн ч бэлэн байна.

- Чи Краучыг мэддэг юм уу? гэж Харри асуулаа.

Сириусын царай барайж Харри анх удаагаа уулзахдаа түүнийг алуурчин гэж бодсон үеийнх шиг болов.

- Өө, би маш сайн мэднэ. Тэр л намайг Азкабан руу шүүх хуралгүй илгээсэн юм даа гэж аяархан хэллээ.

- Юу гэнээ? гэж Рон, Гермиона хоёр нэгэн зэрэг уулга алдав.

- Байж боломгүй юм! гэж Харри хэллээ.

- Үгүй ээ, байж болно! Крауч урьд нь ид шидийн хуулийн албадан мөрдүүлэх хэлтсийг толгойлж байсан юм. Та нар үүнийг мэдэхгүй юу? гээд Сириус толгой сэгсрэнгээ тахианы махнаас том хазлаа.

Харри, Рон, Гермиона гурав толгойгоо сэгсрэв.

- Түүнд яамны сайдын суудал ойрхон байсан юм. Барти Крауч түүнтэй хэн ч зэрэгцэхээргүй маш хүчирхэг шидтэн байлаа. Гэхдээ тэр эрх мэдэлд дуртай. Үгүй дээ, Волан-де-Мортыг хэзээ ч дэмжихээргүй хүн гэж Сириус Харрийн царайны хувирлыг харж яаран хэлээд,

- Барти Крауч үргэлж хар хүчний эсрэг байсан. Тэгэхэд олон хүн хар хүчний талд байсан ч гэсэн... үгүй дээ, та нар үүнийг ойлгохгүй... хэтэрхий залуу байна... гэв.

- Миний аав Дэлхийн цомын тэмцээн дээр бас ингэж хэлж байсан. Бидэнд ойлгуулахыг оролдоод үзэж болохгүй юу? хэмээн Рон хөмсөг зангидан хэлэв.

- За яахав, тэгвэл сонсоцгоо гээд Сириус инээмсэглэн агуйн гүн рүү очоод эргэж ирэнгээ,

- Волан-де-Мортыг маш хүчтэй байсан гэж төсөөлөөд үз. Хэн түүний талд ажиллаж хэн түүний эсрэг байгааг хэн ч мэдэхгүй. Зөвхөн тэр хүмүүсийг удирдаж хэзээ ч хийж чадахааргүй хамгийн аймшигтай зүйл хийлгэдэг гэдэг нь илэрхий байсан юм. Бид гэр бүл, найз нөхдийнхөө хамт айдас хүйдэс дор амьдарч байлаа. Долоо хоног болгон шинэ аллага, алга бололт, эрүүдэн тамлалтын тухай мэдээлж байв... Ид шидийн яамнаас юу хийхээ мэдэхээ больсон. Тэд үүнийгээ маглуудаас нуухыг оролдж байсан ч тэд ч бас хохирогч болж байсан юм. Эргэн тойрон айдас... сандрал... үймээн самуун. Тийм л байсан юм гэлээ.

- Тэр үед зарим хүмүүс бусдаасаа илүү хамгийн муу болж байлаа. Зарчмын хувьд Краучын эхлэл сайн байсан. Тэр түргэн дэвшиж Волан-де-Мортын талыг дэмжигчдийг гөрөөлж эхэлсэн. Маракоберецуудад байран дээр нь алах зэрэг онцгой

эрх олгож байлаа. Зөвхөн намайг ч биш өөр бусдыг мөрдлөгөггүй Дементорууд руу илгээж байсан юм. Хүчний эсрэг хүчтэй тэмцсэн. Крауч ганцаараа Уучлашгүй шидийг сэжигтэний эсрэг хэрэглэх шийдвэр олгосон. Яг л Волан-де-Морт шиг. Үүнийгээ дэмжих хүмүүс олсон. Тэд их олуулаа байсан болохоор түүнийг яамны сайдад нэр дэвшүүлсэн юм. Гэнэтхэн Волан-де-Морт хүчээ алдсан. Бүгд Крауч удахгүй яамны сайд болно гэж бодож байлаа. Тэгтэл бүх юм нурах нь тэр гээд Сириус инээмсэглэснээ хөмсөг зангидаад,

- Түүний өөрийнх нь хүү Үхэл залгигч нарын дунд баригдан Азкабан руу илгээгдсэн юм. Тэднийг Хар лордыг эрж олон хүчээ олоход нь туслах гэж байсан гэж буруутгасан гэв.

- Краучын хүүг барьсан гэнээ? хэмээн Гермiona сонссон зүйлдээ итгэлгүй асуулаа.

- Тиймээ. Энэ хөгшин Бартид цохилт болсон доо. Ажлын төлөө өөрийн гэр бүлээ золиослосон хэрэг. Өдөр шөнөгүй ажил дээрээ байж байлаа. Өөрийнхөө хүүг ч гэж мэдээгүй гээд Сириус гиппогрифт тахианы яс хаяж өгөөд газар суун талх авч хэдэн хэсэг болгон хуваалаа.

- Тэгэхээр түүний хүү Үхэл залгигч байсан хэрэг үү? гэж Харри асуугаад түүнийг амандаа хэрхэн талх чихэхийг харав.

- Хэн түүнийг мэдэх билээ? Түүнийг баригдах үед би Азкабанд байсан юм. Энэ бүхнийг би зугтсаныхаа дараа мэдсэн. Түүнийг Үхэл залгигчдын хамтаар барьсан юм билээ. Тэр буруу газраа хэрэггүй үед байсныхаа зовлонг үүрсэн. Яг л нөгөө үйлчлэгч шиг гэж Сириус зажлангаа хэлэв.

- Крауч хүүгээ эрүүдсэн хэрэг үү? гэж Гермiona шивнэлээ.

Сириус нохой хуцахтай төстэй инээлээ.

- Хүүгээ эрүүдсэн гэж үү? Гермiona би чамайг энэ хүн хэн болохыг ойлгосон гэж бодсон юмсан. Түүний нэр хүндэд заналхийлсан бол юу ч хийхэд бэлэн. Тэр бүх амьдралынхаа туршид сайдын суудал руу тэмүүлсэн юм. Чи түүний үйлчлэгч нь зөвхөн нэрийг нь хар хүчтэй холбоотой болгосны төлөө хөөгдсөнийг хараа биз дээ. Энэ чинь л Крауч байгаа юм. Хүүгээ шүүх эцгийн хайр түүнд хангалттай байсан. Шүүх дээр хүүгээ хичнээн үзэн ядаж уучлахгүй байгаагаа харуулсан даа... Үүний дараа залуу хүү шууд Азкабан руу явсан юм.

- Өөрийнхөө хүүг Дементорт өгсөн гэнээ? хэмээн Харри айдаст автлаа.

- Өгсөн. Би түүнийг Дементорууд хэрхэн өрөөний хажуугаар авч явахыг харсан. Тэгэхэд хориос хэтрээгүй байсан юм. Зэргэлдээх өрөөнд оруулсан. Тэр шөнөжингөө ээжийгээ дуудаж уйлсан. Дараа нь тайвширсан. Хэдэн өдрийн дараа бүр тайвширсан... Зүүдэндээ л зөвхөн хашгирдаг байлаа...

Хормын төдийд Сириус үхлийн харцаар гөлөрлөө.

- Тэр одоо Азкабанд байгаа юу? гэж Харри асуулаа.

- Үгүй. Тэнд байхгүй. Жилийн өмнө үхсэн гээд Сириус хүндээр санаа алдав.

- Үхсэн гэнээ?

- Тэнд олон хүн үхсэн. Ухаан солиороод хоол идэхээ болино. Амьдрах хүсэлгүй болдог юм. Би үргэлж үхэл ойрхон байгааг мэддэг байсан. Дементорууд үхлийг мэдрэхээр тайван бус болдог юм. Харин Краучын хүү анхны өдрөөсөө л өвдсөн харагдаж байсан. Крауч шиг яамны чухал албан тушаалтын хувьд түүнийг үхэл рүү нь эхнэрийнхээ хамт илгээсэн юм даа. Би тэгэхэд Краучыг сүүлчийн удаа өрөөний дэргэдүүр хөл дээрээ арай ядан тогтож яваа эхнэрээ авч явахыг харсан. Ээж нь уй гашуундаа төдөлгүй үхсэн. Яг л хүү шигээ. Крауч тэгэхэд хүүгийнхээ биеийг авахаар ирээгүй. Би Дементорууд түүнийг зөөж байхыг харсан.

Сириус талх зажлах зуураа лонхтой хулууны шүүсийг ганц балгалтаар хоослов.

- Ингэж л хөгшин Крауч бүх юмаа алдсан юм. Итгэж явсан бүхнээ эрх мэдлийн оргилд хүрэхээс өмнө алдсан. Ганцхан хормын дараа сайд болох гэж байхад... хүү нь үхэж, эхнэр нь үхэж гэр бүлийн нэр нь шившиг болсон. Би чөлөөтэй байх үедээ түүний огцом уналтыг сонссон. Ганц хүүгээ үхсэний дараа сэтгэл шимширч сайн гэр бүлээс гаралтай хүү нь яагаад тийм заваан юманд орооцолдсоныг өөрөөсөө асуусан биз. Хариулт нь энгийн байсан даа. Эцэг нь түүний амьд байгааг мартсан байсан. Ингээд өндөр суудал Корнелиус Фажад ногдож, Крауч ердөө л олон улсын шидтэнгүүдийн хамтын ажиллагааны хэлтэсийг толгойлох болсон юм.

Удтал нам гүм болов. Харри Дэлхийн цомын тэмцээн дээр Крауч модны цаанаас олдсон дуулгаваргүй гэрийн үйлчлэгчээ хараад уурандаа нүд нь бүлтрэх шахсаныг санах. Энэ нь Крауч яагаад үйлчлэгчээ Хар тамга илгээгдсэн газраас олохдоо дэлбэрэх шахсаны тайлбар байх нь. Ой ухаанд нь хүүгийнх тухай шуугиан болон найдлага нь бөхсөн тухай дүрсхийсэн биз.

- Грюм хар шидтэнтэй хийх тэмцэл Краучын толгойны өвчин болсон гэж хэлсэн хэмээн Харри хэлэв.

- Би ч гэсэн түүнийг жинхэнэ донтсон гэж сонссон. Гэхдээ минийхээр бол тэр ахиад нэг л Үхэл залгигчыг барих юм бол алдагдсан эрх мэдэл нь эргэж олдоно гэж боддог юм шиг байгаа юм гээд Сириус толгой дохив.

- Ийм учраас л тэр Снеггийн өрөөг ухсан байх нь! гэж Рон дуу алдаад Гермiona руу баяртайгаар харав.

- Тиймээ, зөвхөн үүнийг л ойлгохгүй байна гэж Сириус хэллээ.

- Байгаа! гэж Рон эсэргүүцлээ.

Сириус толгойгоо сэгсрэв.

- Үгүй дээ. Хэрвээ Крауч Снеггийг сэжиглэж байсан бол яагаад тэмцээнийг шүүхээр ирээгүй юм бэ? Хогвартст жирийн байдалтай ирээд мөшгөсөн нь дээр юм биш үү. Энд нь ямар нэгэн өөр юм байна.

- Снегг үнэхээр ямар нэгэн таагүй юм нуусан юм биш биз? гэж Харри асуулаа.

- Таатай ч байсан таагүй ч байсан Дамблдор Снеггэд итгэдэг гэж Гермiona эхлэв.

- Тайвшир, Гермiona. Дамблдор мэдээж ухаалаг л даа. Гэхдээ энэ чинь маш ухаантай хар шидтэн түүнийг мунхруулж чадахгүй гэсэн үг биш шүү дээ гэж Рон хэлэв.
- Тэгвэл Снегг яагаад Харриг нэгдүгээр дамжаанд сурч байхад аварсан юм бэ? Түүнийг үхэг гээд орхиж болох байсан шүү дээ!
- Би хаанаас мэдэх юм! Магадгүй Дамблдор түүнийг сургуулиас хөөхөөс айсан биз.
- Харин чи энэ талаар юу гэж бодож байна, Сириус? гэж Харри чанга асуухад тэр хоёр чимээгүй боллоо.
- Тэд хоёулаа зөв алхам хийсэн. Би эртнээс Дамблдор яагаад түүнийг сургуульд авсан учрыг гайхдаг байлаа. Снегг сурагч байх үеэсээ л хар шидийг сонирхож үүгээрээ сургуульдаа алдартай байлаа. Тэгэхэд туранхай, бохир, урт тослог үстэй явдаг байсан юм гээд Сириус Рон, Харри хоёр руу инээмсэглэн харав.
- Нэгдүгээр дамжаандаа долдугаар дамжааны сурагчдын хагасаас илүү шившлэг мэддэг байсан. Дараа нь Слизеринийхэн бараг бүгд Үхэл залгигчид болсон гээд тэр хуруу даран тоолов.
- Розье, Уилкис хоёрыг Волан-де-Мортын уналтын дараа мракоборецууд алсан. Эхнэр нөхөр хоёр Лестрейнж Азкабанд байгаа. Эйвериг би Хар Лордод Имперуус шившлэгийн нөлөөн дор үйлчилж байсан гэж сонссон. Тэр одоо чөлөөтэй байгаа. Харин Снеггийн хувьд хэзээ ч Үхэл идэгчээр буруутгагдаж байгаагүй. Зөвхөн энэ л байгаа юм. Тэдний олонхийг барьж авч чадаагүй. Снегг их ухаантай зальтай шидтэн болохоор уснаас хуурай гарсан юм.
- Снегг Каркаровыг маш сайн таньдаг ч үүнийгээ нууж байсан гэж Рон хэлэв.
- Тийм шүү, өчигдөр Каркаров уусмалын хичээл дээр орж ирэхэд Снеггийн царай ямар болсныг харсан уу! Снегг түүнээс бултаад байсан болохоор Каркаров түүнтэй ярихыг хүсчээ. Каркаров их сэтгэл түгшсэн янзтай байсан. Гаран дээрээ Снеггэд ямар нэг юм үзүүлээд байсан ч харамсалтай нь би харж чадаагүй л дээ гэж Харри нэмэрлэв.
- Снеггэд гаран дээрээ юм үзүүлсэн гэнээ? гэж Сириус гайхан асуугаад бохир үсээ маажин мөрөө хавчлаа.
- Юу болохыг нь ойлгох юм алга... Гэхдээ Каркаровын сэтгэл түшин Снеггээс юм асуухаар ирнэ гэдэг чинь... гээд гонсойсон шинжтэй агуйн хана руу харснаа,
- За яахав. Баримт баримтаараа үлдэг. Дамблдор Снеггэд итгэдэг. Тиймээ тэр хэн ч итгэхээргүй хүмүүст итгэдэг юм. Тэр Хогвартст Снеггийг аваагүй байсан бол Волан-де-Мортын талд байх байсан гэв.
- Тэгвэл Грюм, Крауч хоёр яагаад түүний өрөөг сонирхож байсан юм бол? гэж Рон тэсэлгүй дуугарав.
- Грюм Хогвартст мэдээж ганц багшийн өрөөний төлөө ирээгүй. Тэр хар урлагаас хамгаалахад дэндүү ноцтой ханддаг юм. Грюм ер нь бол хэнд ч итгэдэггүй болохоор гайхах юм алга. Тэр хэзээ ч хүмүүсийг ялангуяа чухал хүмүүсийг алж байгаагүй.

Үргэлж дайснуудаа амьдаар нь барьж авдаг байсан. Тиймээ тэр хэрцгий өрсөлдөгч хэдий ч хэзээ ч үзэн ядалтаас мултарч байгаагүй. Краучын хувьд бол өөр хэрэг. Хэрвээ үнэхээр өвдсөн юм бол? Юугаа Снеггийн өрөөнд эрсэн хэрэг вэ? Эсвэл эрүүл бол... үүнийг юу гэж ойлгох вэ? Ямар чухал ажлын улмаас Дэлхийн цомын тэмцээний тавцан дээр үзэгдсэнгүй гэж? Гурван шидтэний тэмцээн дээр ирэхээргүй тийм завгүй байна гэж үү?

Сириус чимээгүй болоод ахин агуйн хана руу ширтлээ. Клювкрыл хошуугаараа шал тэмтчин яс хайлаа.

- Танай ах чинь Краучын ойрын туслах гэсэн үү? Чи түүнийг хэзээ хамгийн сүүлд даргаа харсныг асууж чадах уу? гээд Сириус Рон руу харав.

- Оролдоод үзье... Гэхдээ Перси намайг Краучыг сэжиглэж байгааг мэдэх ёсгүй. Ах даргаа ухаангүй хүндэтгэдэг юм гэж Рон итгэлгүйхэн хэлэв.

- Берта Жоркинсийн тухай бичсэн хоёр дахь сонинг хардаа гэж Сириус хэлэв.

- Бэгмен түүнийг олоогүй байгаа гэсэн хэмээн Харри дуугарав.

- Тиймээ нийтлэлд үүнийг дурьдсан байсан. Тэр Бертаг ой тогтоолт нь шүүрэн шанага гэж тодорхойлсон байсан. Берта мэдээж бидний сүүлд уулзсанаас хойш өөрчлөгдсөн байх. Гэхдээ урьд нь мартамхай биш байсныг би мэдэж байна. Ой ухаан сайтай хэдий ч хов живэнд дуртай амаа хамхиж мэддэггүй байсан юм. Энэ л түүнд янз бүрийн таагүй явдал авчирдаг байсан даа. Яаманд хариуцлагатай ажил эрхэлж байхдаа дарамтанд байсан. Магадгүй ийм учраас л Бэгмен түүнийг ийм удаан хугацаанд хайгаагүй биз... гэж Сириус гүнзгий бодлогоширон хэлснээ,

- Цаг хэд болж байна? гэлээ.

Харри цагаа харахдаа явахаа больсон гэдгийг нь саналаа.

- Гурав хагас гэж Гермiona хэлэв.

- Та нар сургууль руугаа буцсан чинь дээр байх. Ийшээ ирэхийг хориглож байна, ойлгомжтой юу? Ямар нэг юм тохиолдвол ууль илгээгээрэй. Хэрвээ гэнэтийн ер бусын зүйл болвол даруйхан мэдэгд. Бас сургуулиас зөвшөөрөлгүй алхам ч холдож болохгүй! Магадгүй хэн нэг нь чамд халдах төлөвлөгөө зохиож байж мэднэ гэж Харри руу харан хэллээ.

- Гэхдээ луун дээр ч гриндилоу дээр ч хэн ч халдаагүй шүү дээ гэж Харри хэлэхэд Сириус унтууцан харлаа.

- Битгий тэнэг юм ярь. Би энэ тэмцээн дууссан үед л тайван амьсгаа авч болох нь байна. Тэгтэл зөвхөн зургаан сард дуусах байдаг. Бас нэг юм байна. Миний жинхэнэ нэрийг бүү дууд. Ньюх гэж нэрлээрэй.

Сириус Харрид хоосон лонх, амны алчуурыг нь өгөхөд Клювкрылтэй салах ёс гүйцэтгэв.

- Та нарыг тосгоны зах хүртэл гаргаж өгье. Магадгүй ахиад нэг сонин олдож магадгүй...

Тэрбээр ахиад л том хар нохой болон хувирлаа. Агуйгаас ээлжлэн гараад үхэр чулуун дундуур доош уруудацгаав. Сириус бүгдэд өөрийгөө илэх боломж өгөөд тосгоныг тойрон гүйлээ.

Харри, Рон, Гермиона гурав Хогсмид дундуур шилтгээн рүүгээ зүглэв.

- Перси Краучын тухай Сириус юу хэлснийг мэдвэл яах бол? Гэхдээ түүнд хамаагүй байх л даа... Эсвэл бүр илүү бахдах юм болов уу... Перси хууль дүрэмд дуртай болохоор Крауч хууль зөрчилгүй төрсөн хүүгээсээ татгалзсан нь сайн байна гэж хэлэх байсан байх хэмээн Рон ахлах зуураа гэнэтхэн хэлэв.

- Гэхдээ Перси гэр бүлийнхээ хэнийг ч Дементорт өгөхгүй биз дээ гэж Гермиона эгдүүцлээ.

- Мэдэхгүй. Магадгүй хэн нэгэн түүний дэвших замд саад болвол... Түүний хичнээн их зүйлд санаархдагыг мэднэ биз дээ гэж Рон хэлэв.

Гурван найз чулуун шатаар өгсөж үүдний танхимд оров. Их Танхимаас оройн хоолны сайхан үнэр ханхална.

- Хөөрхий Ньюх. Зөвхөн хархаар хооллож байсан гээд бодоод үздээ! Харри тэр чамд үнэхээр хайртай юм байна гэж Рон хэллээ.

БҮЛЭГ 28: НОЁН КРАУЧ УХААН СОЛИОРСОН НЬ

Ням гаригт өглөөний цайны дараа Харри, Рон, Гермиона гурав даргынх нь тухай захиа Персид илгээв. Захианд Рон Сириусын гуйсан ёсоор ахаасаа хэзээ сүүлчийн удаа ноён Краучыг харсныг асуужээ. Үүнийгээ хийх ажилгүй уйдаж байсан Хэдвагээр явууллаа. Ууль цонхоор нисэж одоход андууд дагуулан хараад гал зуух руу очиж бэлгээ Доббид өглөө.

Тэднийг ирсэн явдалд гэрийн үйлчлэгч нар хөөрөн бужигнан гүйлдэж цайгаар дайлангаа алхам бүрдээ эелдэгээр мэхийн ёсолж байлаа. Добби бэлгээ хараад хөөрөн баярлажээ.

- Харри Поттер, Доббид хэтэрхий сайн байна! гэж тэр том нүдэндээ нулимс гялалзуулан хэлэв.

- Юу гэж дээ, Добби! Чиний жабросли миний амийг аварсан шүү дээ гэж Харри хэлэв.

- Шоколадтай боов санамсаргүй үлдээгүй биз? гэж Рон асуугаад баясан гийсэн үйлчлэгч нарыг харав.

- Чи саяхан өглөөний ундаа уусан биз дээ! гэж Гермиона хөмсөг зангидсан хэлсэн ч дөрвөн үйлчлэгч дүүрэн бялуутай том мөнгөн тавиур дамжлан авчрав.

- Ньюхэд жаахан хоол авах хэрэгтэй байна гэж Харри хэлэв.

- Яг үнэн! Гахайг явуулчихъя. Та нар бидэнд жаахан нэмэлт хоол өгөхгүй биз? гэж Рон баяртайгаар бөхөлзөн хоол барьсан тойрон хүрээлсэн үйлчлэгч нарт хэллээ.

- Добби ингэхэд Винки хаана байна? гэж Гермиона асуугаад гал зуухыг тойруулан харав.

- Тэнд зуухны урд байгаа, хатагтай гэж Добби чихээ доош буулган дуугарлаа.

- Өө, хонгор минь дээ гээд Гермиона үйлчлэгчийг харлаа.

Харри ч мөн адил зуухны зүг харав. Винки өнгөрсөн удаагийнх шиг сандал дээр суусан хэвээр бөгөөд утаанд харласан ханан зуухнаас ялгагдах үгүйтэй харагдана. Түүний хувцас бохирдож хуучирчээ. Сандал дээр ганхан суугаад лонх цөцгийний шар айраг барьж зуух руу ширтэж байв. Тэднийг харах үеэр том зогсиулав.

- Винки, зургаа дахь лонх шар айргаа ууж байгаа юм гэж Добби Харрид шивнэн мэдэгдэв.

- Зүгээр дээ, цөцгийний шар айраг тийм ч хатуу биш гээд Харри гараа савлаа.

- Гэрийн үйлчлэгчийн хувьд маш хатуу, ноёнтоон гээд Добби толгойгоо сэгсрэв.

Винки ахиад зогсиулахад бялуу авчирсан үйлчлэгч нар зэмлэнгүй харснаа ахин ажилдаа орлоо.

- Винки гэрээ санаад байгаа юм, ноёнтоон. Винки ноён Краучыг түүний эзэн гэж бодсоор байгаа юм. Добби одоо түүний эзэн профессор Дамблдор болсон гэж хэлсэн ч сонсохгүй байгаа юм гэж Добби гунигтай шивнэлээ.

Харрид гэнэтхэн нэг санаа төрж зуух руу очоод үйлчлэгч руу бөхийн,

- Сонсооч, Винки чи ноён Крауч яасныг мэдэх юм биш биз? Тэр яагаад Гурван шидтэний тэмцээнд ирэхээ больсон юм бол? гэв.

- Эзэн... тэмцээнд ирээгүй гэнээ? хэмээн Винки сүүмийсэн нүдээр Харри руу хараад найгалаа.

- Тиймээ. Бид түүнийг эхний тэмцээнээс хойш харсангүй. <<Зөнч>> сонинд түүнийг өвдсөн гэж бичсэн байсан.

Үйлчлэгч ахиж ганхаад бүүдгэр нүдээр Харри руу харлаа.

- Эзэн... өвдсөн... гэнээ?

Түүний доод уруул чичрэв.

- Өвдсөн байж магадгүй ч бид мэдэхгүй байна гэж Гермиона хурдхан нэмэрлэв.

- Эзэнд түүний Винки хэрэгтэй байгаа! Эзэнд ганцаар байхад их хэцүү байгаа... гэж үйлчлэгч орь дуу тавив.

- Винки өөр хүмүүс гэртээ гадны тусламжгүй болоод л байдаг шүү дээ гэж Гермиона шаргуу хэлэв.

- Винки түүний зөвхөн зарц ч биш! гэж тэр эгдүүцэн часхийгээд улам хүчтэй ганхахдаа шар айрагаа бохир цамц руугаа асгачихлаа.

- Эзэн Винкид итгэн хамгийн чухал нууцаа хэлсэн.

- Ямар? гэж Харри асуулаа.

Винки толгойгоо хүчтэй сэгсрэхдээ үлдсэн шар айрагаа арай асгачихсангүй.

- Винки үүнийг яагаад ч хэлэхгүй. Винки эзнийхээ нууцыг хадгалдаг. Та бусдын хэрэгт хамраа дүрж байна гэж үйлчлэгч найган хэлээд Харри руу сөлөр харлаа.

- Винки чи Харри Поттертэй яаж ингэж ярьж зүрхэлж байна! Харри Поттер зоригтой өгөөмөр сэтгэлтэй. Харри Поттер хэзээ ч бусдын хэрэгт оролцдоггүй! гэж Добби уурсав.

- Оролцож байна! Миний эзний хэрэгт оролцож байна. Винки шударга үйлчлэгч. Винки шилтгээнд амаа хамхиж байгаа. Харин хэн нэг нь түүнийг мэдэхээр шиншилж байна... гээд түүний нүд гэнэт анилдан хивсэн дээр унаад хурхирч эхлэв. Шар айрагны хоосон шил чулуун шалан дээгүүр өнхөрлөө.

Арваад үйлчлэгч түүн рүү ухасхийн зэвүүцсэн янзтай ажиглав. Тэдний нэг лонхыг авч бусад нь Винкиг том ширээний бүтээлэгээр хучлаа.

- Бидэнд их ичгүүртэй байна! Согтуу шүү! Гуйя бүх үйлчлэгчийг тийм гэж битгий бодоорой хэмээн ичиж улайсан нэг үйлчлэгч хэлэв.

- Тэр их гунигтай байгаа! Та нар түүнийг жаахан тайвшируулж болохгүй юу? гэж Гермиона унтууцав.

- Уучлаарай хатагтай гэрийн үйлчлэгч ажил дээрээ гунигтай байх ёсгүй. Тэр эзэндээ зүтгэх ёстой гэж мөнөөх үйлчлэгч гүнзгий бөхийн ёсолж хэлэв.

- Ай, бурхан минь! Та нар үүнийг зөвшөөрч байгаагаараа ч эзнээсээ дээрдэх юм алга! Та нарт цалин хөлс, амралт, сайн хувцас хэрэгтэй. Тушаал биелүүлэхээ больж юу таалагдсанаа хийцгээ! Жишээ нь энэ Доббиг харцгаа гэж Гермина хилэгнэлээ.

- Добби энд хамаагүй, хатагтай гэж Добби хулчийлаа.

Үйлчлэгч нарын нүүрэн дэх инээмсэглэл алга боллоо. Тэд гэнэтхэн Гермионаг аюултай галзуу амьтан аятай ширтэв.

- Энэ та нарын нэмэлт хоол! гэж нэг үйлчлэгч часхийн дуугараад Харрийн гар дээр гахайн утсан гуя, арваад бялуу жимсний хамтаар тавингаа,

- Баяртай гэв.

Үйлчлэгч нар зочиддоо зам тавьж өгөөд жижигхэн гараараа түлхэн гаргав.

- Оймс өгсөнд баярлалаа, Харри Поттер! гэж алчуур нөмрөн унтаж байсан Винкигийн хажууд зогсож байсан Добби гэмшингүй хашгирав.

- Амаа хамхиж болсонгүй юу? Тэд бидэнд хэзээ ч ахиж юм өгөхгүй. Бид одоо ноён Краучын талаар Винкигээс яаж асуух юм? хэмээн Рон Гермиона руу давшлав.

- Өө, чамайг ийм л юм зовооно доо! Чи зөвхөн хоолны тухай бодож байх юм! гэж Гермиона тохуурхав.

Гал зууханд болон үйлчлэгч нарын яриа бүхий л өдрийг гутаалаа

Үдэш амралтын өрөөнд даалгавараа хийхээр сууцгаахад Харри Рон, Гермиона хоёрын маргааныг тэсэхээ болиод Сириусын хоолыг авч уулийн байшин руу явлаа.

Гахай бүхэл бүтэн гуя аваад уул даван нисэж чадахгүй болохоор Харри түүнд туслуулахаар сургуулийн чанга дуутай хоёр ууль авлаа. Тэгээд тэдний дүрсийн араас удтал харж зогслоо. Хоёр томь уул сарвуундаа хайрцаг дамжилж дэргэд нь Роны жижигхэн ууль бялуутай ниснэ.

Харри цонхны тавцан дээрээс бөхийгөөд орчин тойрноо харав. Бүрэнхий болжээ. Хориотой ойн мододын орой шаагиж, Дурмстрангын хөлөг онгоцны далбаа салхинд дэрвэнэ. Хэдэн ууль Хагридын зуухны яндангын утааны цаагуур далд оров. Харри доошоо харлаа. Хагрид овоохойны өмнө газар ухаж байв. Тэр тэнд юу хийж байгаа юм бол? Шинэ ногоо тарьж байгаа юм болов уу. Шармбатоны сүйх тэрэгнээс хатагтай Максим гарч ирээд Хагрид руу очлоо. Тэр түүнтэй яриа өрнүүлэхийг оролдов бололтой. Гэхдээ Хагрид хүрз рүүгээ эргэн тонгойсноос үзэхэд яриа хөөрөө бүтсэнгүй. Хатагтай Максим төдөлгүй сүйх тэрэг рүүгээ явлаа.

Харри Гриффиндорын амралтын өрөө рүү очиж Рон, Гермиона хоёрын толхилцохыг сонсохыг хүссэнгүй. Тэр цонхон дээр зогсоод Хагридыг харанхуйд үзэгдэхээ больтол хэрхэн газар малтахыг нь харав. Өөр нэг ууль шөнийн ангаас нисэн ирээд дэргэд нь газардахад Харри унтахаар явла.

Маргааш өглөө нь Рон, Гермиона хоёрын таагүй уур амьсгал эелдэг тал руугаа өөрчлөгджээ. Роны муу зөгнөл ёсоор үйлчлэгч нар тааруухан хоол бэлтгэсэнгүй Гриффиндорын ширээнд утсан мах, өндөг, шарсан загас ердийнхөөрөө амттай байлаа.

Уулийн шуудан ирэхэд Гермиона тэсч ядсан байртай ирсэн шувуу бүрийг харж байв.

- Перси хариу илгээж амжаагүй байх. Бид өчигдөр л Хэдвигийг явуулсан биз дээ гэж Рон хэлэв.

- Тийм бишээ. Би <<Зөнч>> сонин захиалсан юм. Бүх шинэ мэдээг Слизеринийхнээс түрүүнд мэдэж байхын тулд гэж Гермиона хэлэв.

- Сайн байна! Хараач тэр чамд ирж байх шиг байна гэж Харри уулийг харж хэллээ.

Гермиона дээр саарал ууль ирэв.

- Энэ сонин биш байна. Энэ... гэж Гермиона урам хугаран хэллээ.

Саарал ууль ширээн дээр газардахад араас нь дөрвөн ууль ирлээ.

- Чи хичнээн сонин захиалаа вэ? гэж Харри асуугаад Гермионагийн цом захиа авчирсан уулиудийн түлхэлцээнд унахад барьж авлаа.

- Энэ хаанаас... гээд Гермиона эхний захиаг уншсанаа,

- Өө, үгүй байлгүй дээ! гэж шивнээд улаан болов.

- Юу бичсэн байна? хэмээн Рон дуугарлаа.

- Ямар тэнэг юм бэ... гээд Гермиона Харрид захиаг сунгалаа. Түүн дээр <<Зөнч>> сониноос л хайчилж авсан бололтой үсгээр наан бичсэн үг байв.

ЧИ БОЛ ЖИГШҮҮРТЭЙ ОХИН. ХАРРИ ПОТТЕР ЧАМААС ИЛҮҮГ ХҮРТЭХ ГАВЪЯАТАЙ. ӨӨРИЙНХӨӨ МАГЛУУД РУУГАА ЗАЙЛ.

- Бүгд адилхан байна! гэж Гермиона мэгдсэн байртай шивнээд бусад захиаг уншлаа. <<Харри Поттер чамаас илүү дээр нэгнийг олох л болно...>>, <<Өөртөө мэлхийний түрс чана...>>

Гермиона сүүлчийн захиаг нээтэл түүнээс шар ногоон өнгийн шингэн асгарч шатахуун шиг үнэртэхэд шаргал өнгө хүрсэн арьс түлэгдсэн юм шиг цэврүүтэй болов.

- Бубонтюберийн идээ байна! гэж Рон болгоомжтойгоор дугтуйг авч үнэрлээд хэлэв.

- Ёо! гээд Гермиона хортой шингэнийг амны цаасаар арчихыг хичээсэн ч арьс нь зузаан бээлий өмссөн аятай хавдахад өвдсөндөө уйллаа.

- Одоохон эмнэлэг рүү гүй. Бид хатагтай Стебльд хэлчихье гэж Харри дараагийн ууль захиа авчрахыг хараад яаран хэлэв.

Гермиона гараа цээжиндээ тэвэрч Их танхимаас гүйн гарлаа.

- Би түүнийг Рита Скитерийг уурлуулах хэрэггүй гэж хэлсэн биз дээ! гээд Рон нэг захиаг авч,

- Юу бичсэнийг сонсооч... <<Би “Шидтэн” сэтгүүлээс чи Харри Поттерийн сэтгэлээр яаж тоглосныг уншлаа. Тэр үүнтэй үүнгүй зовж байгаа. Томоохон дугтуй олоод дараагийн захиагаар хараал илгээнэ дээ>>. Чөтгөр гэж! Гермиона ч болгоомжтой байхгүй бол горьгүй юм байна даа! гэв.

Ургамал судлалын хичээл дээр Гермиона ирсэнгүй. Харри, Рон хоёр хүлэмжээс гараад шидэт амьтны хичээлд орохоор Хагридын овоохой руу явлаа. Шилтгээнээс Малфой, Крэбб, Гойл тэргүүтэй хүмүүс гарч ирээд чулуун шатаар буулаа. Пэнсик Паркинсон тэдний араас Слизериний охидтой шивнэлдэн хөхрөлдөж гарч ирээд Харриг харан,

- Поттер, яасан хайртдаа хаягдчихсан уу? Тэр өглөөний цайн дээр их сэтгэлээр унасан байсан даа! гэж хашгирав.

Харри түүнийг үл тоомсорлон <<Шидтэн>> сэтгүүлийн нийтлэлд баясах боломж өгсөнгүй.

Өнгөрсөн хичээл дээр Хагридын ярьсан зүйлийн дагуу ганц эвэртийг үзэж дууссан байв. Харин одоо овоохойны өмнө шинэхэн модон хайрцагнууд нээлттэй байв. Харрийн зүрх түгшлээ. Ахиад шинэ соплохвостууд авчирсан юм биш биз дээ. Тэр хайрцаг руу болгоомжлон дөхөж очоод сэтгэл амарлаа. Түүн дотор үслэг урт хошуутай хар амьтан байв. Тэдний урд сарвуу хүрз шиг хавтгай агаад жижигхэн нүдээ анивчин ягаад тийм их анхаарал татсанаа гайхах мэт.

- Энэ бол нюхлерууд. Арал дээр амьдардаг юм. Янз бүрийн гялалзсан юманд дуртай... гэж Хагрид хүүхдүүдийг цугларахад хэллээ.

Амьтдын нэг Пэнси Паркинсоны бугуй дээр суун цагийг нь шүдээрээ чангаахад чарлан холдов.

- Жижигхэн эрдэнэс илрүүлэгчээр ашиглаж ч болно. Өнөөдөр бидэнд хөгжилтэй хичээл орж байна. Харж байна уу? гээд Хагрид Харрийн уулийн байшингийн цонхоор харах үед ухаж байсан шороог заангаа нүүр дүүр инээмсэглэн хэлэв.

- Би хэсэг алтан зоос булсан байгаа. Хэний нюхлер их зоос олох юм бол шагнах болно. Үнэтэй зүйлээ нуугаад хайлгаад үз дээ.

Харри цагаа тайлаад халаасандаа нуулаа. Амьтныг гартаа авахад шууд урт хамраа Харрийн чих рүү сунган сонирхон үнэрлэв. Тэр үслэг зөөлөн илээд баймаар ажээ.

- Эндээс нюхлеруудээ авч болно. Ингэхэд хэн байхгүй байна вэ? Гермиона хаа байна? гэж Хагрид дуу алдаад нэг хайрцаг руу харав.

- Эмнэлэг рүү явсан гэж Рон хэлэв.

- Дараа хэлье гэж Харри Пэнси Паркинсон чих тавихыг хараад шивнэлээ.

Ийм амархан бөгөөд хөгжилтэй шидэт амьтдын хичээл урьд нь орж байсангүй. Нюхлерууд усанд шумбаж байгаа юм шиг газар малтан эзэндээ яаран алтан зоос олж өгч байлаа. Роны амьтан бусдыгаа бодвол илүү их алтан зоос овоолов.

- Хагрид чамаас энэ амьтныг худалдан авч болох уу? гэж Рон нюхлер шороо цацлан ухаж ахин нэг зоос гаргаж өгөхөд бахдан хэллээ.

- Ээж чинь баярлахгүй л байх. Тэд байшинг сүйтгэдэг юм. Тэд миний нуусан мөнгийг бүгдийг нь олчихсон юм шиг байна. Өө, Гермiona ирж байна.

Гермиона нуга дээгүүр овоохой руу ирж байлаа. Гар нь том боолттой байсан бөгөөд дүнсгэр царайтай байлаа. Пэнси Паркинсон түүнийг нүдээ онийлгон харав.

- Одоо хэд олсныг нь шалгаарай! Зоосоо тоолцгоо! Хулгайлаад хэрэггүй, Гойл. Лепрекониин алт байгаа юм. Хэдэн цагийн дараа алга болно гэж Хагрид нүдээ нарийсган хэлэв.

Гойл гашуунаар халаасаа сэгсэрлээ. Роны нюхлер бүгдээс илүү зоос олсон болохоор Хагрид түүнд <<Амтат ван >>-гийн том хавтгай шоколад бэлэг болгон өгөв. Үдийн хоолонд орохыг уриалсан хонх дуугарав. Бүгд шилтгээн рүү яарахад андууд Хагридтай үлдээд амьтдыг хайрцагт хийхэд туслав. Шармбатыны цонхоор хатагтай Максим харж байлаа.

- Гермiona чиний гар яагаа вэ? гэж Хагрид сэтгэл зовон асуулаа.

Гермиона түүнд өглөөний захианууд болон сүүлчийн захианд бубонтюберийн идээ байсан тухай ярилаа.

- Санаа зовох хэрэггүй дээ. Рита Скитер миний ээжийн тухай бичих үед би ч бас тийм захианууд авсан. <<Та бол мангас сургуулийн талбайгаас хөөх хэрэгтэй>>, <<Таны ээж гэм буруугүй хүмүүсийг алж байсан болохоор нуур луу үсэрсэн чинь дээр>>

- Үгүй байлгүй дээ! гэж Гермiona цочирдон хэлэв.

- Тиймээ, авсан. Энэ тэнэгүүдэд битгий анхаарлаа хандуул. Захиаг үзсэний ч хэрэггүй гал руу хийчих тэгээд л болоо гэж Хагрид хэлээд нюхлертай харцагнуудыг овоохойны хана руу шахаж тавилаа.

- Хичээл дээр байгаагүй чинь харамсалтай байна. Нюхлерууд их хөгжилтэй байсан, тийм үү Рон? гэж Харри шилтгээн рүү буцах замдаа хэлэв.

Рон Хагридын бэлэглэсэн шоколад руу хөмсөг зангидан харна.

- Чи яагаа вэ? Ийм шоколаданд дургүй юм уу? гэж Харри асуулаа.

- Үгүй л дээ. Ингэхэд чи яагаад надад алтны тухай хэлээгүй юм бэ?

- Ямар алт? гээд Харри ойлгосонгүй.

- Дэлхийн цомын тэмцээн дээр би чамд өгсөн алт. Лепрекончуудын алтыг би чамд омниноклийн төлөө өгсөн биз дээ. Харин чи надад алга болсон гэж хэлээгүй.

Харри хормын турш бодлогошироод алт ясныг саналаа.

- Аан, тэр алт уу... Мэдэхгүй... Би алга болсныг нь ч мэдсэнгүй. Би тэр үед зөвхөн шидэт савааныхаа тухай бодож байсан.

Тэд чулуун шатаар өгсөн үүдний танхимд ороод Их танхим руу үдийн хоол идэхээр явлаа.

Андууд хоолны ширээнд суугаад шарсан мах, йоркширийн чунз хийж авлаа.

- Сайхан хэрэг байна даа! Чи бүтэн халаас дүүрэн алтан зоос алга болж байхад ажиглаагүй байдаг хэмээн Рон ахин алтны тухай ярилаа.

- Сонсооч, миний толгой тэр үед өөр юмаар дүүрэн байсан. Бид бүгд тийм байсан биз дээ? гээд Харрийн тэсвэр алдагдав.

- Би лепреккончуудын алт алга болдог гэж мэдээгүй. Чамд эргүүлээд өглөө гэж бодсон. Гэтэл чи надад зул сараар <<Педдлийн их буунууд>>-ын малгай бэлэглэсэн байдаг.

- Энэ тухай мартаж үз!

Рон сэрээгээрээ төмс хатгаад дээш өргөн ширтээд,

- Ядуу байхыг үзэн ядаж байна! гэлээ.

Рон, Гермиона хоёр бие бие рүүгээ харсан ч юу гэж хариулахаа мэдсэнгүй.

- Ихрүүдийн баяжихыг мөрөөддөг нь зөв. Үүнд ямар ч тэнэг юм байхгүй. Ай даа, надад нюхлер байсан бол! гэж Рон төмс рүү ширтсэн хэвээр хэлэв.

- Сайн байна! Одоо дараагийн зул сараар чамд өгөх талаар бодох хэрэггүй болоо гэж Гермона инээмсэглэсэн ч Рон баргар царайлан төмсийг ширтсэн хэвээр байлаа.

- Больж үз дээ, Рон! Амьдралд үүнээс ч муу юм байдаг юм. Чи гараа бубонтюберийн идээнд түлээгүй биз дээ гээд Гермиона хутга сэрээгээ хавдсан хуруугаараа арай ядан барингаа,

- Энэ Скитерийг үзэн ядаж байна! Гэхдээ бид хэн нь хэн бэ гэдгээ үзэх л болно доо! гэв.

Долоо хоногийн турш Гермиона <<Шидтэн>> сэтгүүлийн ууртай уншигчдын захиаг үргэлжлүүлэн авсаар байлаа. Тэр Хагридын зөвөлгөөг даган захиаг нээлгүй шатааж байв. Гэхдээ зарим таагүй уншигчид Аяндын мэдээ илгээсэн нь Гриффиндорын ширээн дээр шууд дэлбэрч Их танхим даяар доромжлон хашгачиж байлаа.

Тэр ч байтугай <<Шидтэн>> сэтгүүл уншдаггүй хүн бүр Гермиона, Харри, Виктор Крам гурвын <<хайрын гурвалжины>> тухай мэддэг болсон байв. Харри бүгдэд Гермиона тэр хоёр жирийн нөхөрсөг харилцаатай гэж тайлбарлаж байлаа.

- Хэрвээ бид үүнийг тоохгүй байвал энэ шуугиан удахгүй намдана. Тэр миний тухай сүүлд бичсэн ч хүмүүс түргэн мартаа биз дээ гэж Харри Гермионаг ятгалаа.

- Би түүнийг яаж сургуулийн нутаг дэвсгэрт нэвтэрч бусдын яриа хөөрөөг чагнаж чадсаныг мэдэхээс нааш тайвширахгүй гэж Гермиона зөрүүдлэн хэлэв.

Хар урлагаас хамгаалах хичээлийн дараа Гермиона профессор Грюмаас юм асуухаар саатав. Бусад нь ангиас гүйн гарцгаалаа. Грюм тэднээс хэцүү шалгалт авсан бөгөөд Харри муу сонсож байсан болохоор чихээ гараараа барьсаар ангиас гарч явлаа.

Таван хормын дараа Гермiona амьсгаадсаар найзуудыгаа үүдний танхимд гүйцэн ирээд,

- Скиттерд үл үзэгдэх цув байхгүй гэнээ! Грюм түүнийг шүүгчдийн ширээний дэргэд ч нуурын дэргэд ч хараагүй гэж байна. Ер нь бол хаа ч хараагүй гэнэ хэмээн Харрийн чихэнд алгаа ойртуулан хэлэв.

- Гермiona чамайг энэ тэнэгийг март гэж хичнээн удаа хэлэх юм бэ гэж Рон хэлэв.

- Яагаад ч үгүй! Би түүнийг яаж Виктор бид хоёрын яриаг сонссоныг мэдмээр байна. Бас тэр яаж Хагридын эхийн тухай мэдсэн юм бол!

- Сонголын төхөөрөмжтэй юм болов уу гэж Харри хэлэв.

- Юун төхөөрөмж? гээд Рон ойлгосонгүй.

Харри түүнд бусдын яриаг нууцаар бичиж авдаг жижигхэн микрофонтой зүйлийн талаар тайлбарлав. Маглуудын техникийн гайхамшиг Роныг алмайрахад хүргэсэн ч Гермiona түүний яриаг таслаад,

- Та нар Хогвартсын түүхийг уншсан уу? гэв.

- Яах гэж? Чи түүнийг цээжилчихсэн юм чинь чамаас асуухад болно биз дээ хэмээн Рон мөрөө хавчлаа.

- Маглуудын зохион бүтээсэн цахилгаан, компьютер, радио долгион болон бусад зүйлс Хогвартст ажиллахгүй. Энд маш хүчтэй шидийн талбай байгаа. Тэгэхээр Рита Скитер шидийн тусламжтай сонссон байх нь. Ямар гэдгийг нь мэдэх юмсан. Эсвэл тэр хууль бусаар...

- Чамд санаа зовох өөр юм байдаггүй юмуу? Ахиад л Рита Скитерээс өшөө авалтаа эхлэх нь үү? гэж Рон зэмлэнгүй дуугарав.

- Би чамаас туслахыг гуйгаагүй. Өөрөө түүнийг барьчихна.

Тэр өсгий дээрээ эргээд гантиг шатаар дээшээ гүйн одлоо. Харри түүнийг номын сан руу явсан гэдэгт итгэлтэй байв.

- Түүнийг <<Рита Скитерийг үзэн ядаж байна>> гэсэн тэмдэгтэй ирнэ гэж мөрийцөх үү? гэж Рон наргиан болгов.

Гэхдээ Гермiona энэ яриагаа ахиж сөхсөнгүйд Харри, Рон хоёр ихэд талархжээ. Улаан өндөгний баярын амралтын өмнөхөн гэрийн даалгавар ихтэй байв. Харри Гермiona яаж бүгдийг амжуулдагыг гайхаж байлаа. Бүх хичээлээ хийсэн, шидээр сэм сонсох аргуудыг судалсан, номнууд уншсан байх аж. Тэр гэрийн даалгавараа арай ядан амжин хийхийн зэрэгцээ өдөр болгон Сириуст маргалгүй хоол илгээж байв. Өнгөрсөн зун ганц бялуутай сууж байсан болохоор өлсөх гэдэг ямар байдгийг сайн санаж байлаа. Хайрцагтай хоолонд зурвас хавчуулж Хогвартст ямар ч сонин зүйл болоогүй бөгөөд Персигээс хариу ирээгүй байна гэж мэдэгдэнэ..

Хэдвиг улаан өндөгний баярын амралтын төгсгөлд ирлээ. Хатагтай Уизлигаас улаан өндөгний баярын өндөгтэй гэрийн амттан авчирчээ. Илгээмжинд Персигийн захиа байлаа. Харри, Рон хоёрын өндөг лууны өндөг хэмжээтэй бөгөөд чихрээр дүүрэн

байхад, Гермонагийнх тахианы өндөг шиг жижигхэн байлаа. Гермiona түүнийг хараад сэтгэлээр уналаа.

- Рон ээж чинь тохиолдлоор <<Шидтэн>> сэтгүүл уншдаггүй биз?

- Уншдаг. Жорыг нь хэрэглэх дуртай гэж Рон хариулаад чихэр амандаа чихэв.

Гермиона жижигхэн өндгөө гунигтай харлаа.

- Перси юу бичсэнийг уншицгаая гэж Харри яаран хэллээ.

Захиа товч бөгөөд яльгүй ууртай аястай аж.

Би урьд нь олон удаа <<Зөнч>> сонины сурвалжлагчид ноён Крауч зүй ёсны амрах эрхтэй гэж хэлсэн. Тэр надад ердийнхөөрөө уулиар заавраа ирүүлж байгаа. Би өөрөө түүнийг хараагүй удаж байгаа ч бичгийн хэвийг нь таних болохоор надад итгэж болно. Би ажил ихтэй байгаа болохоор ахиж тэнэг цуу яриаг няцаах тэнхэл алга.

Хэрвээ та нарт онцгой шалтаг байхгүй аваас намайг түгшээх хэрэггүй гэж гуйж байна. Улаан өндөгний баярын мэнд хүргэе.

Перси

Ердийнхөөрөө улаан өндөгний баярын амралтаар улирлын сүүлчийн тэмцээний өмнөх бэлтгэл эхэлдэг байлаа. Энэ жил Гурван шидтэний тэмцээний эцсийн тэмцээнд бэлтгэх хэрэгтэй болжээ. Гэхдээ энэ тэмцээн дээр юу байхыг Харри мэдээгүй л байв. Таван сарын сүүлчийн долоо хоногт профессор МакГонагалл түүнийг хичээлийн дараа саатуулав.

- Поттер, өнөө орой есөн цагаас квиддичийн талбай рүү очоорой. Тэнд ноён Бэгмен тэмцээний аваргуудад гурав дахь сорилт юу болохыг тайлбарлах болно.

Найм хагаст Харри цэнгэлдэх хүрээлэн рүү явахад Рон, Гермiona хоёр цамхагтаа үлдэв. Үүдний танхимд түүнийг амралтын өрөөнөөсөө гарч ирсэн Седрик Диггори гүйцэв.

- Гурав дахь сорилт ямар гэж бодож байна даа? Флер ямар нэгэн газар дорхи хонгилд эрдэнэс хайх юм юм яриад байсан гэж Седрик чулуун шатаар буухдаа хэлэв.

- Энэ чинь муугүй л юм байна шүү гэж Харри хэлээд Хагридын нюхлерийг гуйдаг юм билүү гэж бодлоо.

Харанхуй зүлгэн дээгүүр явсаар үзэгчдийн суудлыг өнгөрөн тоглолтын талбайд ирлээ.

- Тэд талбайг яачихаа вэ? гэж Седрик хэлээд хөшсөн юм шиг зогслоо.

Талбай үргэлж жигдхэн өвстэй байдаг хэдий ч одоо зүг бүртээ урт хана орооцолдон мушгирчээ.

- Энэ чинь таримал бургас байна гэж Харри бөхийн хараад хэлэв.

- Хөөе, наашаа ирцгээ! гэж Бэгмен хөгжилтэйгээр тэднийг дуудав.

Тэр талбайн голд Виктор Крам, Флер Делакур хоёртой зогсож байлаа. Харри, Седрик хоёр өтгөн бутыг даван тэдэн рүү яаран очлоо. Флер Харри руу эелдэгээр

инээмсэглэв. Сүүлчийн тэмцээнд дүүг нь нууранд аварсанаас хойш түүний хандлага өөрчлөгдсөн билээ.

- За ямар байна даа? Түргэн ургаж байгаа биз? Сарын дараа гэхэд Хагрид эднийг таван метр өндөр ургуулчихна. Санаа зовох хэрэггүй дээ гэж Бэгмен Харри, Седрик хоёрын янзгүй царайг харж хэлээд,

- Тэмцээн дуусчихаар талбай эргээд өөрийн хэвэндээ орно. Харин энэ юу болохыг тааварлаж байна уу? гэлээ.

Хормын турш бүгд чимээгүй байцгаав.

- Төөрдөг байшин гэж Крам тааварлав.

- Тиймээ, төөрдөг байшин! Гурав дахь тэмцээн бол их энгийн. Ямар ч заль байхгүй. Талбайн голд Гурван шидтэний тэмцээний цом байх бөгөөд хэн түрүүлж хүрсэн хүн хамгийн өндөр оноо авна.

- Зүгээр л дундуур нь зугаалах юм уу? гэж Флер гайхлаа.

- Мэдээж саад бэрхшээл туулна. Хагрид янз бүрийн газар шидэт амьтад байрлуулах болно. Янз бүрийн шившлэгээр тэднийг номхотгох хэрэгтэй. Түрүүлж хамгийн их оноотой аваргууд орох юм гэж Бэгмен баяртайгаар хэлээд Харри, Седрик хоёр луу харан инээмсэглэв.

- Дараа нь ноён Крам. Хамгийн сүүлд хатагтай Делакур. Саад бэрхшээлийг хэрхэн туулснаас хамаарах болохоор ялах боломж бүгдэд нээлттэй. Хөгжилтэй байгаа биз!

Харри Хагридаас ямар аймшигтай зүйл хүлээж болохыг мэдэж байсан учир хөгжилтэй болно гэж бодсонгүй. Гэсэн ч бусдынхаа адил эелдэгээр толгой дохьжээ.

- Хэрвээ өөр асуулт байхгүй бол шилтгээн рүү явцгаая. Энд хүйтэн байна.

Шилтгээн рүүгээ буцахад Бэгмен Харрийн хажууд ирлээ. Одоо л туслахыг санал болгох байх гэж Харри бодтол гэнэт мөрөн дээрээс нь Виктор Крам атган авлаа.

- Хэдэн үг сольж болох уу?

- Аан... за гээд Харри гайхлаа.

- Тэгвэл жаахан явж байгаад ярилцъя.

- Тэгье.

- Харри чамайг хүлээж байх уу? гэж Бэгмен түгшлээ.

- Үгүй дээ, ноён Бэгмен баярлалаа. Би шилтгээн рүү буцах замаа мэднэ гэж хэлэхдээ Харри арай ядан инээдээ барилаа.

Харри, Крам хоёр цэнгэлдэх хүрээлэнгийн хажууд үлдэхэд Крам Хориотой ойн зүг явлаа.

- Бид тийшээ явж яах юм? гэж Харри Хагридын овоохой болон Шармбатоны хурц гэрэлтэй сүйх ард үлдэхэд хэлэв.

- Хэн нэгэн сонсоосой гэж хүсэхгүй байна.

Крам алтан морьдтой хашаанаас хоёр алхамын зайтай модны дор зогсонгоо Харри руу эргэн хараад,

- Герм-ивонна та хоёрын дунд юу болоод байгаа юм гэж хөмсөг зангидан асуулаа.

Харри түүний нууцлаг байдлаас маш чухал зүйл сонсохыг хүлээж байснаа гайхан Крам руу харав.

- Юу ч биш гэж хэлэхэд Крам сүрдүүлсэн янзтай харсан тул тэр агшинд түүний хичнээн өндөр хүчтэй болохыг мэдэв. Тайлбарласан нь дээр бололтой.

- Бид зүгээр л найзууд. Тэр хэзээ ч миний найз охин байгаагүй. Энэ бүхэн ердөө л Рита Скитерийн бодож олсон зүйл.

- Герм-ивонна цаг үргэлж чиний тухай ярьдаг гээд Крам итгэлгүйхэн Харри руу харав.

- Бид чинь найзууд шүү дээ.

Харри Болгарын алдарт баригч Виктор Крамтай ийм энгийнээр ярьж байгаадаа өөртөө ч итгэсэнгүй. Крам арван наймтай байтлаа Харрийг... эн тэнцүү өрсөлдөгч шигээ үзэж байна.

- Та нарын дунд хэзээ ч ямар нэг зүйл байгаагүй юу...

- Үгүй гэж Харри хатуу хэлэв.

Крамын царайд гэгээ татав. Тэр ахин хормын турш Харри руу харснаа,

- Чи маш сайн нисдэг юм байна лээ. Би чамайг эхний тэмцээн дээр харсан гэв.

- Баярлалаа гэж Харри баярлан инээмсэглэхдээ шууд өөрийнхөө өсөн томрохыг мэдэрчээ,

- Харин би чамайг Дэлхийн цомын тэмцээн дээр тоглож байхыг харсан. Финт Ворнски чиний хажууд...

Крамын ардах модны тэнд ямар нэгэн юм хөдлөв. Харри Хориотой ойд юу отож байдгийг туршлагаасаа мэдэх тул зөнгөөрөө Крамын гараас шүүрч аваад холдуулав.

- Яасан бэ?

Харри толгойгоо сэгсэрснээ харанхуй руу сайтар хартал модны тэнд нэг юм хөдлөв. Тэр халааснаасаа шидэт саваагаа яаран гаргалаа.

Бүдүүн царсны цаанаас найгасан хүн гарч ирэв. Эхний хоромд Харри түүнийг таньсангүй. Гэхдээ энэ чинь... Ноён Крауч байна шүү дээ.

Ноён Крауч хэдэн өдрийн турш явган алхсан юм шиг хачирхалтай харагдаж байв. Өмднийх нь өвдөг зулгарч цус гаран, царай нь урагдаж, үс сахалдаа баригдан эцэж ядарсан байв. Гэхдээ түүний гарч ирсэн явдал илүү хачирхалтай байлаа. Крауч зөвхөн өөрөө харж байгаа хэн нэгэнтэй ярьж байгаа юм шиг гараа даллан бувтналаа. Тэр Харрид гудамжны тэнэмэл хүнийг гүнзгий санагдуулав. Харри тийм хүнийг нэг удаа Дурслийнхантай дэлгүүр явахдаа харсан юм байна. Тэр хөгшин бас өөртэйгээ ярьж байсан бөгөөд Петунья эгч Дадлигийн гараас шүүрч аваад гудамжны нөгөө тал

руу гүйн гарахад Вернон ах тэнэмэл гуйлгачин хүмүүсийн талаар зэвүүцсэн урт яриа дэлгэсэн юм.

- Энэ шүүгч үү? Танай ид шидийн яаманд ажилладаг биз дээ? гэж Крам бас Краучыг таниад хэлэв.

Харри толгой дохиод ноён Крауч руу тээнэгэлзэн алгуурхан дөхлөө. Крауч түүнд огтхон ч анхаарал хандуулалгүй модтой үргэлжлүүлэн ярих аж.

- ...үүнийхээ дараа, Уизерби Дамблдор Дурмстрангын тэмцээнд оролцох сурагчдын тооны талаар захиа явуул. Каркаров тэдний тоог арван хоёр гэж мэдэгдсэн...

- Ноён Крауч? гэж Харри болгоомжтой дуудав.

- ... бас хатагтай Максимд ууль явуул. Тэр илүү олныг авчирахыг хүсч байгаа ч Каркаров шиг арван хоёрыг авчрах ёстой... Үүнийг гүйцэтгээрэй, Уизерби. Гүйцэтгэ! Гүйцэтгэ!... гээд ноён Крауч нүдээ бүлтийлгэн мод руу харж уруулаа чимээгүй хөдөлгөснөө найган өвдөг дээрээ унав.

- Ноён Крауч! Та зүгээр үү? гэж Харри дуу алдав.

Краучын нүд эргэлдэв. Харри Крам руу эргэн харав. Тэр хэдэн алхамын ард зогсоод Крауч руу сэтгэл түгшин харж байв.

- Тэр яасан юм бол? гэж Крам асуулаа.

- Мэдэхгүй. Хэн нэгнийг дуудсан нь дээр бололтой...

- Дамблдор! Би... Дамблдортой... уулзах... хэрэгтэй... байна... гэж Крауч дуу алдаад Харрийн жанчнаас зуурч өөр лүүгээ татан дээшээ харлаа.

- Ойлголоо, ноён Крауч. Босоорой хамтдаа явцгаая.

- Би... тэнэг... зүйл... хийсэн. Дамблдор... хэлэх... хэрэгтэй гэж ноён Крауч шивнэлээ. Түүний байдлаас үзэхэд үнэхээр галзуурсан бололтой. Нүд нь аяганаасаа бүлтийж завьжыг нь даган шүлс урсана. Үг болгоноо хүчлэн хэлэх аж.

- Ноён Крауч босоорой. Босоорой, би таныг Дамблдор хүргэж өгье гэж Харри чанга хэлэв.

Ноён Крауч гэнэтхэн Харри руу хараад,

- Чи... хэн... бэ? гэж шивнэлээ.

- Би эндхийн сургуульд сурдаг гэж Харри хэлээд Крам руу тусламж эрэн харсан ч цаадах нь айсан шинжтэй холдон зогслоо.

- Чи... түүнийх биш биз? гэж Крауч уруулаа нээлгүй шахам хэлэв.

- Бишээ гэж Харри юу ярьсныг нь ойлгоогүй хэдий ч хэллээ.

- Чи... Дамблдорынх уу?

- Тийм.

Крауч түүний өөр лүүгээ татахад Харри жанчны үзүүрээ угз татан авахыг хичээсэн ч хэтэрхий чанга зуурсан байлаа.

- Дамблдор... анхааруул.
- Би түүнийг авчирна. Зөвхөн намайг тавьчих, ноён Крауч. Би одоо түүн рүү яваад ирье гэж Харри гуйлаа.
- Баярлалаа, Уизерби. Энэ бүхэн дуусахаар надад аяга цай аваад ирээрэй. Одоохон эхнэр маань хүүгийн хамт ирнэ. Орой ноён ба хатагтай Фажын хамтаар тоглолт үзэх юм хэмээн Крауч ахиад л модтой ярихад Харри түүний жанчыг тавьсныг шууд ажиглаагүйгээ гайхжээ.
- Баярлалаа чамд, миний хүү арван хоёр С.И.Ш авсан. Тиймээ, маш өндөр оноо би их баяртай байгаа. Одоо надад яамны сайд Андоррын зурвасыг авчраад өгнө үү би одоо хариу бичээдэхье...
- Чи түүнтэй энд үлд! Би Дамблдорыг аваад ирье. Түүний өрөө хаана байдгийг мэдэх болохоор түргэн олно.
- Тэр галзуу юм байна гэж Крам тээнэгэлзэн хэлээд Перси гэж бодоод модтой ярилцаж байсан Крауч руу айдаст автан харлаа.
- Зүгээр л дэргэд нь зогсож байхад болно! гээд Харри гүйх гэсэн ч Крауч түүний өвдгийг тэвэрч авсан болохоор газар уналаа.
- Намайг... ганцааранг... минь... битгий... үлдээ. Би... анхааруулахын... тулд... зугтсан юм... Би... Дамблдортой... уулзаж... хэлэх... ёстой... Энэ бол... миний буруу... бүгд... миний буруу... Берта... үхсэн... миний буруу... миний хүү... би буруутай... Дамблдор хэл... Харри Поттер... Хар Лорд... хүчтэй... Харри Поттер...
- Намайг тавиач дээ ноён Крауч. Би Дамблдорыг аваад ирье гэж Харри гуйгаад Крам руу уурсан харж,
- Надад туслаач дээ! гэлээ
- Крам болгоомжлон дөхөөд дэргэд нь суув.
- Түүнийг хааш нь ч явуулалгүй харж байгаарай. Би одоохон Дамблдорыг аваад ирье гэж Харри хэлээд Краучын гарнаас жанчаа угз татан авлаа.
- Түргэлж үзээрэй гэж Крам араас нь хашгирав.
- Ойн цоорхойд гараад Харри харанхуй нуга дээгүүр шилтгээн рүүү гүйлээ. Эргэн тойронд хоосон байх агаад Бэгмен, Флер, Седрик нар хэдийн явцгаажээ. Харри шатаар нисэн гараад царсан үүдийг онгойлгон гантиг шатаар гүйн өгсөж хоёр давхарт гарлаа.
- Таван хормын дараа Харри харанхуй хонгил дундуур гүйж чулуун луу руу очлоо.
- Ним... Нимбэгний ундаа! гэж Харри амьсгаадав.
- Энэ нууц үгээр нууц шатыг Дамблдорын хоёр жилийн өмнө онгойлгож орсон билээ. Нууц үг солигдсон нь илэрхий болохоор чулуун луу амилж хажуу тийш болсонгүй хөшсөн хэвээр Харри руу чулуун нүдээрээ ууртай ширтсээр байлаа.
- Хөдлөөч дээ! Алив л дээ гэж Харри орилов.

Гэхдээ Хогвартст орилж хашгираад хөдөлдөг зүйл байхгүй болохыг Харри сайн мэдэж байв. Ийш тийшээ харлаа. Дамблдор багш нарын өрөөнд байгаа юм болов уу? Харри шат руу ухасхийгэл гэнэтхэн....

- ПОТТЕР! гэх хоолой сонсогдов.

Харри шалан дээр гулган зогсоод эргэж харав!

Чулуун лууны цаадах шатнаас Снегг гарч ирээд Харриг занган дуудахад луу эргэлдэн байрандаа орлоо.

- Чи энд юу хийж байгаа юм бэ, Поттер?

Харри бүх хүчээрээ эргэж гүйгээд Снеггийн өмнө зогслоо.

- Надад профессор Дамблдор хэрэгтэй байна! Тэнд... ойд ноён Крауч гарч ирээд. Тэр гуйсан юм...

- Юун дэмий зүйл вэ? Юугаа яриад байгаа юм? хэмээн Снеггийн нүд ууртай гялалзав.

- Ноён Крауч! Ид шидийн яамны ажилтан! Тэр өвдсөн байх эсвэл... Ой дотор Дамблдортой ярихыг хүсч байна! Нууц үг хэлээч! гэж Харри хашгирлаа.

- Захирал завгүй байна, Поттер гэж Снегг хэлээд тавлангуй инээмсэглэв.

- Надад Дамблдор хэрэгтэй байна! гэж Харри орилов.

- Чи миний юу хэлэхийг сонссонгүй юу. Поттер?

Снегг Харриг үгүйсгэж байгаадаа цэнгэн амьдралынх нь хамгийн чухал агшин аятай зогслоо.

- Сонсооч! Крауч ухаангүй байна... ямар нэг юмны тухай ярьж анхааруулахыг хүсч байна гэж Харри уурлалаа.

Снеггийн ард дахь чулуун луу нээгдэн урт ногоон жанчтай Дамблдор гарч ирэв.

- Энд юу болоод байна? гээд Харри, Снегг хоёрыг сонирхсон байртай ээлжлэн харлаа.

- Профессор! Ноён Крауч... Хориотой ойд байна. Тэр таньтай уулзахыг хүсч байна гэж Харри алхам урагшлаад хэллээ.

Харри Дамблдор асуулт тавина гэж айсан ч аз болоход тийм явдал болсонгүй.

- Явцгаая гэж түргэн хэлээд яаран Харриг дагалдав. Харин Снегг чулуун луунаас хоёр дахин аймшигтай царай гарган үлдэв.

- Ноён Крауч юу гэж хэлсэн бэ? хэмээн Дамблдор гантиг шат уруудахдаа асуулаа.

- Таньд ямар нэгэн аймшигтай зүйл анхааруулахыг хүссэн. Хүүгийнхээ тухай болон Берта Жоркинсийн тухай ярьсан бас Волан-де-Мортын тухай... Волан-де-Морт илүү хүчтэй болж байна гэж хэлсэн санагдаж байна...

- Тийм гэж үү!

Тэд шилтгээнээс харанхуйд гарахад Дамблдор түргэн алхав.

- Тэр ухаан солиорсон юм шиг байсан. Минийхээр бол хаана байгаагаа ойлгохгүй байсан. Перси Уизлитэй ярьж байгаа юм бас таныг дуудсан. Би түүнийг Виктор Крамтай орхичихсон гэж Харри захирлыг арай ядан гүйцээд хэллээ.

- Крамтай үлдсэн гэнээ? Өөр хэн Краучыг харсан бэ? гээд Дамблдор хурдаа нэмэхэд Харри харайх шахам гүйлээ.

- Хэн ч биш. Крам бид хоёр ярьж байсан юм. Ноён Бэгмен бидэнд гурав дахь тэмцээний тухай хэлээд дараа нь бүгд явцгаахад Крам намайг ойд дуудсан. Тэгтэл модны араас Крауч гарч ирээд гэж Харри тайлбарлав.

- Тэд хаа байна? гэж Дамблдор асуугаад харанхуйд байгаа Шармбатоны сүйх рүү харлаа.

- Тэнд гээд Харри Дамблдорыг гүйцэж ой руу оруулав. Краучын хоолой сонсогдохгүй байсан ч холгүйхэн Шармбатоны сүйх тэрэг байгаа болохоор хаашаа явах ёстойгоо сайн санаж байлаа... Энүүхэнд хаа нэгтээ байх ёстой доо...

- Виктор! гэж Харри хашгирав.

Хэн ч хариулсангүй.

- Тэд энд байсан. Би энд байсныг нь маш сайн санаж байна...

- Люмос гээд Дамблдор шидэт саваагаа дээшээ өргөлөө.

Бүдэгхэн гэрэл мододын завсрыг гийгүүлж газар тусав. Тэгтэл харанхуйд хэн нэгний хөл харагдав.

Харри, Дамблдор хоёр яаран очтол модны дор Виктор Крам ухаангүй тэрийгээд хэвтэж байлаа. Крауч ул мөргүй алга болжээ. Дамблдор Крамын дэргэд өвдөглөн суугаад болгоомжтойгоор зовхийг нь нээж үзэв.

- Хөшөөчихөж гэж тэр аяархан хэлээд савааны гэрлээр мододыг харахад бараан шилэн дээр нь сулхан оч гялсхийв.

- Хэн нэгнийг авчирах уу? Хатагтай Помфриг ч юм уу? гэж Харри асуув.

- Үгүй. Хаашаа ч битгий яв гэж Дамблдор түргэн хэлэв.

Тэр шидэт саваагаа толгой дээрээ өргөөд Хагридын овоохойны зүг чиглүүлэв. Тэгтэл савааны үзүүрээс мөнгөлөг зүйл гарч мододын дундуур шөнийн шувууны хий үзэгдэл аятай дүрсхийн нислээ. Дамблдор үүнийхээ дараа Виктор Крам руу бөхийгөөд саваагаа түүн рүү чиглүүлж,

- Сэргэ! гэв.

Крам нүдээ нээлээ. Тэр Дамблдорыг хараад босох гэхэд мөрөн дээр нь даран буцааж суулгав.

- Галзуу хөгшин над руу дайрсан! Би Поттерын гүйсэн зүг рүү харж байтал тэр араас цохисон гэж Крам сулхан холойгоор хэлээд духаа дарлаа.

- Тайван хэвт гэж Дамблдор хэлэв.

Овоохойны зүгээс хүнд алхаа сонсогдов. Хагрид гартаа нум барин Соёотыг дагуулан гүйн гарч ирлээ.

- Профессор Дамблдор! Харри! Энд юу болоод... гэж тэр нүдээ томруулан хэлэв.
- Хагрид түргэхэн профессор Каркаровыг аваад ир. Түүний сурагч дайралтанд өртсөн гэж хэлээрэй. Дараа нь профессор Грюмыг...
- Хэрэггүй дээ, Дамблдор. Би энд байна гэж Грюм сөөнгөтөн хэлээд хазганан дөхөж ирэхэд гартаа барьсан савааны гэрэл нь бутан дээр тусаж үзүүр нь чичигнэлээ.
- Хараал идсэн хөл гэж тэр уурсан хэлээд,
- Аль хэдийн ирчих байсан юм... Юу болоо вэ? Снег Краучын тухай ямар нэг юм хэлсэн... гэв.
- Крауч гэнээ? хэмээн Хагрид гайхан дуу алдав.
- Гуйя, Хагрид түргэн Кракаровыг аваад ир гэж Дамблдор сануулав.
- Аан, тийм л дээ профессор гэж Хагрид бувтнаад харанхуй модны цаагуур алга болоход Соёт араас нь дагалдав.
- Барти Крауч хаачсаныг мэдэхгүй байна. Гэхдээ түүнийг аль болох түргэн олох хэрэгтэй гэж Дамблдор Грюмд хэлэв.
- Ойлгомжтой гээд Грюм саваагаа өргөн ой дундуур явлаа.

Харри, Дамблдор хоёр Каркаровыг чимээгүйхэн хүлээв. Төдхөн Хагридын алхаа, Соёотын аахилах дуу сонсогдсов. Каркаров араас нь явж байлаа. Тэр сэтгэл зовж цонхийсон бөгөөд мөнгөн дээлээ өмсчээ.

- Энд юу болоод байна? Юу болоо вэ? гэж тэр газар хэвтэх Крамыг хараад Дамблдор хашгирлаа.
- Намайг дайрсан. Ноён Крауч юмуу өөр нэгэн хүн гэж Крам өндийн суугаад шилэн хүзүүгээ барин хэлэв.
- Чамайг Крауч дайрсан юм уу? Крауч уу? Гурван шидтэний тэмцээний шүүгч үү?
- Игорь.. гэж Дамблдор хэлсэн ч Каркаров цээжээ гүдийлгэж дээлээ яраад нүдэнд нь аянга цахилав.
- Урвалт! гэж тэр Дамблдор руу хуруугаараа чичин хашгираад
- Тохиролцсон байна! Танай ид шидийн яамныхан хуурамч амлалтаар намайг ийш нь хуурч авчирсан, Дамблдор. Ямар гээчийн шударга тэмцээн бэ! Эхнийх нь Харри Поттер насанд хүрээгүй байж тэмцээнд оролцсон байдаг! Харин одоо чиний яамны найз чинь миний цорын ганц аваргыг зайлуулахыг оролдож байна. Би энд нэг л зальхай явдал байна гэж мэдээд байсан юмаа, Дамблдор. Ийм байж бас олон улсын шидтэнгүүдийн харилцааг ойртуулах талаар ярьж зүрхлээд байгаа юм шүү! Та бол хоёр нүүртэн!

Каркаров газар палхийн суухдаа Дамблдорын гутлаас барьж авах шахлаа. Хагрид удаан бодолгүй түүний дээлнээс бариад газраас өргөн мод руу шахав.

- Алив, уучлалт гуй! гэж тэр архираад аварга том гараараа хоолойг нь шахахад хөл нь агаарт санжигнав.

- Хагрид, боль! гэж Дамблдор хашгирлаа.

Хагрид гэмшингүй Каркаровыг тавихад модны үндсэн дээр палхийтэл унаж мөчир чичрэн толгой дээр нь хатсан навч уналаа.

- Хагрид минь, эелдэг байж Харриг шилтгээн рүү аваачиж үз гэж Дамблдор тушаалаа.

Хагрид баавгай шиг амьсгаадан Каркаров руу муухай харж байлаа.

- Би үлдсэн нь дээр биш үү ноён захирал аа?

- Харриг сургууль руу аваач. Шууд цамхагт нь оруулж өгөөрэй. Харин Харри тэндээс гарч болохгүй. Ямар нэгэн юм хийхээр ч юмуу... уулийн байшинд очихоор бол өглөө болтол хүлээгээрэй. Чи намайг ойлгов уу?

- Аан за гээд Харри захирлын нүд рүү харлаа.

Дамблдор энэ тухай яаж мэддэг байна? Харри дөнгөж сая Сируст Гахайгаар илгээсэн захианы тухай бодож байсан шүү дээ.

- Таньтай Соёт үлдэх болно, ноён захирал аа гэж Хагрид хэлээд модны үндсэн суусан хэвээр байгаа Каркаровыг заналхийлэн харж,

- Суу, Соёт. Явъя, Харри гэв.

Хоёулаа ой дундуур явж Шармбатоны сүйх тэргийг өнгөрөөд шилтгээн рүү явлаа.

- Тэр яаж зүрхэлж байна! гэж Хагрид нуурын эргээр явахдаа уурсав.

- Тэр яаж Дамблдорыг доромжилж зүрхлэв! Дамблдор хэзээ ч тийм зүйл хийхгүй. Тэр чамайг тэмцээнд оролцуулахыг хүсээгүй. Тэр чамайг нүдний цөцгий шигээ хайрладаг! Харин чи! гэхэд нь Харри гайхан харлаа.

- Чи энэ Крамтай ойд юугаа хийж байсан юм! Түүнийг Дурмстрангынх гэдгийг мартаа юу? Тэр чамайг агшин зуур хараал илгээж чадна! Чамайг Грюм юунд сургадаг байна! Чамайг занганд оруулах гэж байна гэж төсөөлөөд үз дээ!

- Крам зүгээр дээ гэж Харри танхим руу орохдоо хэлээд,

- Тэр надад хараал илгээх тухай бодоогүй! Тэр надтай Гермionaгийн тухай ярилцахыг хүссэн юм гэв.

- Гермionатай би өөрөө ярих болно. Энэ гадаадынхныг орхиж үз. Ямар ч тохиолдолд түүнд итгэж болохгүй гэж Хагрид шатаар өгсөхдөө хэлэв.

- Харин чи өөрөө хатагтай Максимтэй болдог юм биз дээ! гэж Харри эгдүүцлээ.

- Надад түүний тухай битгий хэл! гээд Хагрид үнэхээр аймшигтай сүрдүүлсэн төрхтэй боллоо.

- Би түүнийг шууд няцаасан. Надад сайн хүн болж гурав дахь тэмцээнд юу болохыг мэдэхийг хүссэн юм. Ха! Түүнд энэ бүхний дараа итгэнэ гэж үү!

Хагрид үнэхээр уурсан байсан болохоор Харри тарган хатагтайн хөргийн өмнө салахдаа баяртай байлаа. Тэр хөргөн гарцаар амралтын өрөөндөө шурган ороод Рон, Гермиона хоёрын сууж байгаа булан руу ойд болсон явдлыг хэлэхээр яарав.

БҮЛЭГ 29: ЗӨНТЭЙ ЗҮҮД

- Ингэсэн хэрэг үү. Викторьг ноён Крауч юмуу өөр хэн нэгэн дайрсан байна. Харин Виктор дайрсан хүнийг хараагүй байдаг гээд Гермона духаа үрлээ.

- Крауч л дайрсан байж таарна! Дайраад шилжсэн! Харриг Дамблдортой эргэж ирэхэд ул мөргүй алга болсон гэж Рон хэлэв.

- Үгүй дээ. Тэр хөл дээрээ арай ядан зогсож байсан юм чинь хаашаа шилжих билээ гээд Харри толгой сэгсэрлээ.

- Хогвартсын нутаг дэвсгэрт шилжиж болохгүй гэж та хоёр хичнээн удаа хэлэх юм бэ?

- Хэрвээ ингэсэн бол яахав. Крам Краучыг дайраад... алив миний хэлэхийг сонсоцгоо л доо... Өөртөө дөжрөөх шившлэг илгээжээ! гэж Рон бардмаар таавар дэвшүүлэв.

- Крауч алга болсны дараа юу? гэж Гермона хүйтнээр хэлэв.

- Аан тийм л дээ.

Дорно зүгт үүр хаяарчээ. Харри, Рон, Гермона гурав өглөө эрт босож уулийн байшин руу очоод Сириуст том захиа бичлээ. Тэгээд цонхон дээр зогсон манан бүрхсэн газар руу ширтлээ. Ноён Краучын тухай маргалдсаар орой унтсан болохоор гурвуулангийнх нь нүд хавдаж царай нь цонхийжээ.

- Ахиад хэл дээ, Харри. Ноён Крауч юу гэж хэлсэн гэнээ? хэмээн Гермона гуйлаа.

- Тэр өөрийн ухаангүй байсан гэж би хэлсэн биз дээ. Дамблдор ямар нэг юм анхааруулахыг хүсээд байсан. Бас Берта Жоркинсийн тухай ярьсан. Минийхээр бол түүнийг амьд гэж бодохгүй байх шиг санагдсан. Бас цаг үргэлж миний буруу гэж давтаад байсан. Тэгээд бас хүүгийнхээ тухай...

- Үүнд тэр өөрөө л буруутай юм чинь гэж Гермона тургилав.

- Тэр өөрийн ухаангүй байсан. Заримдаа эхнэр, хүү хоёрыгоо амьд юм шиг яриад, заримдаа Персиг дэргэд нь байгаа юм шиг заавар өгч байсан.

- Тэр Хэцүү нэртийн тухай юу хэлснийг сана даа? гэж Рон айсан янзтай хэлэв.

- Би хэлсэн биз дээ. Тэр хүчирхэгжиж байгаа гэж хэмээн Харри дургүйхэн хэллээ.

Андууд чимээгүй болцгоов.

- Чи түүнийг галзуурсан гэж бодож байна уу? Ярьсан зүйлийнх нь хагас нь дэмийрэл байсан байна гэж Рон хуурамчаар хөгжилтэй хэллээ.

- Волан-де-Мортын тухай яг эрүүл хүн шиг ярьж байсан гэж Харри хэлэхдээ Роны давхийхийг ажиглав. Түүний найз хэзээ ч Хар лордыг нэрээр нь дууддаггүй юм.

- Тэр арайхийн ярьж байсан ч юу хийж байгаага болон хүсч байгаага мэдэж байсан. Цаг үргэлж түүнд Дамблдор хэрэгтэй гээд байсан.

Харри адар руу харлаа. Олон хонуур хоосон байсан ч цонхоор шөнийн ангаасаа хулгана зуусан уулинууд нисэн орж ирэв.

- Хэрвээ Снегг байгаагүй бол бид амжих л байсан. <<Захирал завгүй, Поттер. Юун дэмий зүйл вэ?>> гэж тэр түүнийг дуурайн даажигнаж хэлээд,
- Тэр яагаад намайг Дамблдор руу оруулахгүй байсан юм бол? гэв.
- Чамайг саатуулахыг хүсээ биз? Магадгүй... хүлээгээрэй... тэр хэр хурдан ойгоос зугтаж амжих байсан бол? Дамблдор та хоёроос зугтаж чадахаар?
- Магадгүй сарьсан багваахай болж хувирсан байх.
- Профессор Грюм руу очиж ноён Краучын тухай асууя гэж Гермиона санал болгов.
- Түүнд миний газрын зураг байгаа юм чинь олсон байх гэж Харри хэлэв.
- Хэрвээ Крауч сургуулийн хилээс гараагүй бол. Зөвхөн шилтгээний нутаг дэвсгэрийг үзүүлдэг биз дээ гэж Рон хэллээ.
- Чшш! гээд Гермиона хуруугаараа уруулаа дарлаа.

Шатан дээр хөлийн чимээ сонсогдов. Хоолойноос үзэхэд хоёр хүн маргалдаж байгаа бололтой.

- ...энэ чинь айлган сүрдүүлэг шүү дээ! Бидэнд асуудал үүсэж магадгүй....
- Бид шударга тоглохыг оролдсон биз дээ. Бохир тоглож болохгүй гэж үү? Яг л түүн шиг. Бодоод үз дээ хэрвээ ид шидийн яамнаас түүний хийсэн зүйлийн тухай мэдэх юм бол... Харваас тэр үүнийг хүсээд байгаа бололтой.
- Би чамд хэлсэн шүү, захиа бол сүрдүүлэг!
- Хэрвээ бид хожих юм бол тэр үед юу хэлэхийг чинь сонсоё.

Хаалга нээгдэн Фред, Жорж хоёр орж ирэв. Гурван найзуудыг хараад ихрүүд босгон дээр хөшлөө.

- Та нар юу хийж байгаа юм? гэж Рон, Фред хоёр зэрэг хашгирав.
- Захиа илгээсэн юм гэж Харри, Жорж хоёр нэгэн дуугаар хэллээ.
- Ийм эрт үү? гэж Гермиона, Фред хоёр хэмсгөө өргөв.

Фред инээмсэглэлээ.

- За яахав. Бид та нарын юу хийж байсныг сонирхохгүй болохоор та нар юу ч битгий асуугаарай.

Тэр гартаа лацтай дугтуй барьжээ. Харри хяламхийн харсан ч Фред санаандгүй юмуу зориудаар хаягийг нь хааж барилаа.

- Та нарыг саатуулахыг зүрхлэхгүй байна хэмээн Фред тоглоом хийн бөхийгөөд үүд рүү заав.

Рон байрнаасаа хөдөлсөнгүй.

- Та нарыг хэнийг сүрдүүлэх гэж байгаа юм бэ?

Фредийн уруулнаас инээмсэглэл алга болж Рон руу хяламхийн харав.

- Чи юу гэж бодоо вэ! Энэ чинь тоглоом байсан юм! гэж дэмий зүйл байсан аятай хэллээ.

- Тэгж сонсогдохгүй л байсан даа.

Фред, Жорж хоёр бие бие рүүгээ харлаа.

- Би чамайг хамраа хэрэггүй зүйлд битгий дүрж бай гэж урьд нь анхааруулсан шүү, Рон. Чинийхээр бол.. гэж Фред занган хэлэв.

- Өөр юу гэж. Сүрдүүлэг бол тоглоом биш. Жоржын зөв та нарт ноцтой асуудал учирч болзошгүй.

- Би чамд тоглосон гэж хэлээд байна шүү дээ. Рон чи яг Перси шиг юм. Энэ байдлаараа үргэлжилвэл ахлагч болох байх гэж Жорж хэлээд Фредийн гараас захиаг авч ойролцоох уулийн сарвуунд уяв.

- Хэзээ ч тэгэхгүй! гэж Рон дүрсхийлээ.

Жорж цонх руу очоод уулийг гарган тавиад Рон руу эргэв.

- Тэгвэл бүгдийг сургахаа больж үз. Дараа уулзацгаая.

Ихрүүд явцгаахад Харри, Рон, Гермiona гурав бие бие рүүгээ ширтлээ.

- Хэрвээ тэд бүгдийг мэдэж байвал? Крауч болон бусдын тухай? гэж Гермiona шивнэлээ.

- Үгүй дээ. Тэд өөр хэн нэгний тухай маш чухал юм ярьж байсан. Дамблдорын тухай байх гэж Харри эсэргүүцэв.

Гэхдээ Роныг энэ үг тайвшируулсангүй.

- Рон чи яагаа вэ? гэж Гермiona асуулаа.

- Би хэлсэн зүйлд нь итгэхгүй байна. Тэдний бүх бодолд мөнгө байдаг. Би тэдэнтэй их хугацаа өнгөрүүлсэн болохоор...

- Хэрэлдэж болохгүй гэж Харри өгүүлбэрийг нь дуусгаад,

- Гэхдээ мөнгийг сүрдүүлж... гэв.

- Тэд шидэт тоглоомын мухлаг нээхийг хүсдэг юм. Би урьд нь тэднийг ээжийг уурлуулахын тулд тэгдэг юм байх гэж бодсон. Харин үгүй бололтой. Тэдэнд ердөө нэг жил сурах үлдсэн. Тэд цаашдаа юу хийхээ бодох хэрэгтэй байдаг. Аав мухлаг нээхэд хэрэгтэй мөнгөөр туслахгүй.

- Гэхдээ тэд хууль зөрчих тухай яриагүй байлгүй гээд Гермона түгшсэн янзтай болов.

- Яриагүй гэнээ? Их эргэлзэж байна. Тэд зөвхөн хууль зөрчих үйлдэл хийдэг. Хэзээ ч жирийн хөвгүүд байгаагүй гээд Рон мөрөө хавчлаа.

- Гэхдээ хууль гэдэг чинь сургуулийн тэнэг дүрэм журам биш. Сүрдүүлэг бол өөр зүйл. Минийхээр бол үүнийг Персид хэлэх хэрэгтэй байх гэж Гермiona тоглоомгүй айсан янзтай хэллээ.

- Чи галзуурав уу? Персид хэлэх гэнээ? Тэр эелдэгээр Крауч хүүгээ өгсний адил шүүхийн гарт өгөх болно. Явж цайндаа орцгооё гэж Рон Фред, Жорж хоёрын ууль ниссэн зүг рүү харж хэллээ.

- Грюм рүү явахад эрт байна уу? хэмээн Гермиона эргүүлгэн шатаар буухдаа асуув.

- Эрт байна. Тэр биднийг унтаж байхад нь дуусгахаар очиж байна гэж бодож магад. Хичээл орохыг хүлээсэн нь дээр байх гэж Харри хэллээ.

Ид шидийн түүх удтал үргэлжлэв. Харри Роны цагийг харахад маш удаан өнгөрч магадгүй зогссон юм шиг мэт ажээ. Гурвуулаа ангид золтой л унтсангүй. Гермиона хүртэл үзгээ тавьж толгойгоо гараар тулаад сүүмгэр нүдээр профессор Бинсийг харна.

Эцэст нь хонх дуугарахад андууд хар урлагаас хамгаалах хичээлийн анги руу яарлаа. Профессор Грюм хичээл орсны дараа байдаг шигээ их ядарсан байлаа. Ердийн нүдний зовхи нь унжиж сорвитой царайг нь улам тодруулна.

- Профессор Грюм гэж Харри сурагчдын дээгүүр хашгирав.

- Сайн уу, Поттер гэж Грюм сөөнгөтсөн хоолойгоор хариулав. Шидэт нүд нь аяган дотроо эргэлдэн булан тойрохоор яарч байгааа нэгдүгээр дамжааныхан руу тусав.

- Орцгоо гэж Грюм тэднийг уриад ангид орж хаалга хаалаа.

- Та нар ноён Краучыг олсон уу? гэж Харри асуулаа.

- Үгүй гэж Грюм хариулаад багшийн ширээ рүү доголлон явж суугаад модон хөлөө дуу алдан тэнийлгэж дашмагаа авлаа.

- Газрын зураг ашигласан уу? гэж Харри хэлэв.

- Өөр яана гэж? Түүнийг өрөөнөөсөө ой дотор хайна гэдэг чинь чиний тэмцээн дээр шүүр дууддагтай адилгүй. Гэхдээ Крауч газрын зурган дээр гарч ирээгүй.

- Тэр шилжсэн юм болов уу? гэж Рон хэллээ.

- Шилтгээний газар нутагт шилжиж болохгүй гэж хичнээн удаа хэлэх юм бэ, Рон! гэж Гермиона уурсан хэлээд,

- Ноён Грюм шилжихээс өөр аргаар эндээс алга болж болох уу? гэв.

Грюмын шидэт нүд удааширч Гермионаг ширтлээ.

- Зав чөлөөгөөрөө мракоборец болох тухай бодоод үзээрэй, Грэйнджер. Чиний тархи сайн ажилладаг юм байна.

Гермиона сэтгэл хангалуун улайлаа.

- Үл үзэгдэх цув түүнд байгаагүй. Гэхдээ газрын зураг дээр түүнийг зааж байсан. Тэр шилтгээний нутаг дэвсгэрээс гарсан байх гэж Харри хэллээ.

- Асуудал түүнийг өөрөө эндээс алга болов уу эсвэл хэн нэгэн түүнд тусалсан уу гэдэгт байна гэж Гермиона хэлэв.

- Магадгүй хэн нэгэн тусалсан байх. Шүүрэндээ сундлаад хамт ниссэн байх гээд Рон Грюм түүнийг мракоберц болох нь гэж хэлэх нь үү гэсэн байртай харав.

- Зальдсан байж магадгүй юм гэж Грюм зөвшөөрөв.

- Эсвэл Хогсмидэд нуугдсан ч юм уу? гэж Рон асуулаа.

- Хэн түүнийг мэдэх билээ? Гэхдээ Хогвартст лав байгаагүй гэж Грюм толгой сэгсэрлээ.

Профессор том эвшээхэд сорви нь чангарч хэдэн шүд унасан харагдав.

- Дамблдор хэлэхдээ та нарыг судалгаа хийх дуртай гэсэн. Гэхдээ Миний зөвөлгөө бол орхи. Краучид туслах боломжгүй болсон. Дамблдор ид шидийн яаманд мэдэгдэж түүнийг хайх болно. Харин Поттер чи гурав дахь тэмцээнд бэлдэж байна уу?

- Юу гэнээ? Аан, тийм л дээ...

Харри өнгөрсөн шөнө болсон адал явдлаас бодоод төөрдөг байшингийн тухай мартжээ.

- Энэ чинь л чиний бодох ёстой зүйл шүү дээ. Дамблдор хэлэхдээ чамд үүнтэй адилхан зүйл анхны удаагаа тохиолдож байгаа биш гэсэн. Нэгдүгээр дамжаандаа чи гүн ухааны чулуунд хүрэхийн тулд саадтай тулгарч байсан байхаа хэмээн Грюм сорвитой эрүүгээ илээд хэлэв.

- Гермiona бид хоёр түүнд тусалсан юм гэж Рон түргэхэн хэллээ.

Грюм инээмсэглэв.

- Тэгвэл энэ удаад ч гэсэн бэлтгэхэд нь тусал. Хэрвээ тэр ялахгүй бол би их гайхах байна. Харин Поттер сэрэмжтэй байж илүү сэрэмжтэй бай! Хоёр нүдээ нээ! гээд шидэт нүд нь Дурмстрангын хөлөг онгоцны далбаа дэрвэж буй зүг руу харлаа.

- Харин та хоёр Поттероос холдож болохгүй. Ойлгов уу? Би нүдээрээ харж хүрэх зүйлийг л хардаг юм... гээд жирийн нүдээрээ Рон, Гермiona хоёр луу харлаа.

Маргааш өглөө нь Сириусээс захиа ирэв. Тэр Харригийн дэргэд буух мөчид Гермionaгийн урд <<Өдөр тутмын зөнч>> сонин зуусан ууль газардлаа. Гермiona сонинг аваад эхний хуудсыг гүйлгэн уншиж инээмсэглээд,

- Краучын түүх гарсангүй гэлээ.

Тэр сонингоо тавиад найзуудтайгаа нэгдэн хамтдаа Сириусын захиаг уншлаа.

Харри чи Крамтай ой руу явахдаа юугаа бодож байсан юм бэ? Хариу захиандаа шөнийн цагаар хэнтэй ч хаашаа ч явахгүй гэж андгайлаарай. Хогвартсад одоо маш аюултай хэн нэгэн байна. Би тэр хүн л Краучыг Дамблдортой уулзахаас өмнө саад хийж чамаас хоёр алхамын ард нуугдаж байсан гэдэгт итгэлтэй байна. Чи үхэхэд ойрхон байлаа шүү дээ.

Чиний нэр тохиолдлоор Галт цомд орчихоогүй. Хэрвээ хэн нэгэн чамайг алахаар бодсон бол сүүлчийн боломж үлдлээ. Рон, Гермiona хоёртой хамт байж шөнийн цагаар Гриффиндорын цамхагаас бүү гар. Тэгээд гурав дахь тэмцээнд хүч гарган

бэлтгэх хэрэгтэй. Хөшөөх болон зэвсэггүй болох шившлэгээр сургуулилт хий. Алдаа гаргахгүйн тулд аль болох их шившлэг сураарай. Краучид чи юугаар ч тусалж чадахгүй. Биеэ болоомжтой авч яв. Дараагийн захиандаа ахиж тийм ухаангүй үйлдэл хийхгүй гэж ам өг.

Сириус

- Биеэ сургууль дотор ухаангүй авч явж болохгүй гэнэ! Надад сургамж унших нь дутаад байна гэж дээ! хэмээн Харри дуу алдаад захиаг халаасандаа хийлээ.

- Тэр чамд санаа зовж байна. Яг л Грюм, Хагрид нарын адилаар! Чи тэднийг сонсох ёстой гэж Гермiona хэлэв.

- Гэхдээ энэ жил над руу хэн ч дайраагүй. Хэн ч юу ч хийгээгүй.

- Хэрвээ чиний нэрийг цомд хийснийг эс тооцвол. Энэ бүхнийг маш ухаантай хийж. Ньюхын зөв. Тэд цагаа хүлээж байгаа байх. Магадгүй гурав дахь тэмцээнд чам руу дайрч мэднэ.

- Ньюхын зөв байгаад хэн нэгэн Крамыг хөшөөн Краучыг хулгайлсан юм байж. Тэгэхээр бидний ойролцоох модны ард нуугдаж байсан байх нь. Намайг явахыг хүлээж байсан гэж үү? Үнэхээр надад халдах гэж байсан бол нэг л биш байна даа.

- Тэд чамайг золгүй явдлаар цааш харуулахыг хүсч байж мэднэ. Ойд болсон аллагыг золгүй тохиолдол гэж нэрлэж болохгүй. Тэмцээнд үхэх бол өөр хэрэг шүү дээ... гэж Гермiona эсэргүүцэв.

- Тэгвэл яагаад Крамыг дайрахаас айсангүй вэ? Яагаад намайг болохгүй гэж? Бидний хооронд халз тулаан болсон байж болно шүү дээ.

- Би ч гэсэн юу ч ойлгохгүй байна, Харри. Зөвхөн хачирхалтай явдал болоод байна гэдгийг мэдэх байна. Тэгээд ч энэ надад таалагдахгүй байна. Грюм, Ньюх хоёрын зөв. Даруйхан гурав дахь тэмцээнд бэлтгэж эхлэх хэрэгтэй. Тэгээд Ньюхэд Гриффиндорын цамхагаас гарахгүй гэж ам өг хэмээн Гермiona цөхрөн хэллээ.

Хогвартсын газар нутаг хэзээ ч Харриг ингэтлээ гадаа гарахыг урьж байсангүй. Бүх чөлөөт цагаа тэр номын санд өнгөрүүлж байв. Номын дундаас чухал шившлэг хайж найзуудтайгаа хоосон ангид сургуулилна. Ялангуяа түүний хувьд шинэ шившлэг болох Хөшөөх шившлэгийг сурахад төвлөрч байлаа. Гэхдээ Рон, Гермiona хоёртой бэлтгэл хийхэд хүрэлцэхгүй байв.

- Хатагтай Норрисыг хулгайлж болохгүй юмуу? гэж Рон даваа гаригийн өглөөний цайны дараа санал болгов. Андууд шившлэгийн хичээлийн ангид орж түгжжээ. Харри тавь дах удаагаа Хөшөөх шившлэгийг хэрэглэн золгүй Роныг шалан дээр хэвтэж байхад нь сэргээлээ.

- Түүгээр жаахан сургуулилсан нь дээр байх. Эсвэл Доббигоор ч юмуу тэр чиний төлөө бүгдийг хийхэд бэлэн байдаг шүү дээ. Намайг гомдоллож байна гэж бүү бодоорой. Зүгээр л хамаг бие янгинаад байна гэж Рон хөл дээрээ босон хажуу талаа үрээд хэлэв.

- Чи үргэлж дэргэдүүр нь унаад байсан юм чинь. Зөвхөн гэдрэгээ уна! гэж Гермиона зэмлээд дэрнүүдийг засаж тавилаа. Энэ удаа тэд Түлхэх шид хэрэглэж байсан үеийн дэрнүүдийг Флитвикийн шүүгээнээс авчээ.

- Чамд хэлэхэд амархан л даа! Өөрөө хөшсөн ухаантай зогсоод үз гэж Рон уурсан үглэв.

- Хоолны дараа өөр шившлэгээр хичээллэж үзье. Бид зэвсэггүй болох шидийн тухайд санаа зовохгүй байж болно, Харри түүнийг сайн эзэмшсэн. Эхлээд эдгээр шившлэгээр хичээллэх хэрэгтэй гээд Гермиона жагсаалтыг нүд гүйлгэн харлаа.

- Удаашруулах хийх шившлэг. Ямар ч халдлагыг удаашруулах юм байна. Энэ үдшээс эхлэе.

Хонх дуугарлаа. Найзууд яаран дэрээ цуглуулж Флитвикийн шүүгээнд хийгээд ангиас гарлаа.

- Орой хоолон дээр уулзацгаая гэж Гермиона хэлээд шидэт тооны ухааны хичээл рүү гүйн одов. Харин Харри, Роны хамт хойд цамхаг руу буцаж мэргэ төлгийн хичээл рүү явлаа. Хонгилын цонхноос хана шалан дээр нарны гэрэл тусан нүд гялбуулна.

- Өнөөдөр Трелонигийн өрөөнд бид чанагдах байхаа. Тэр үргэлж гал түлж байдаг юм чинь гэж Рон хэллээ

Шатны талбай дээр гаран мөнгөлөг олсон шатаар өгсөөд хатагтай Трелонигийн өрөөнд орлоо.

Роны зөв баж. Бүүдгэр гэрэлтэй өрөөнд бүгчим халуун агаад шарах шүүгээнд орсон юм шиг санагдана. Дотор мансуурам үнэр ердийнхөөс илүү байлаа. Харри хөшгөөр битүү хаасан цонхтой ширээнд очиж суухад толгой нь хэдийн анхилам үнэрээр дүүрчээ. Трелони алчуурынхаа зангилааг гаргах зуур Харри цонх руу ухасхийж жаахан онгойлгоод эрүүгээ сандлын түшлэг дээр тавин сэвшээ салхинд нүүрээ үлээлгэв. Энэ нь маш аятайхан байлаа.

- Хүүхдүүд минь бид од гаригсаар зөгнөн хэлэх хичээлийг бараг үзэж дуусаж байна. Өнөөдөр Ангараг гариг бусад гаригуудтай сонирхолтой холбоо тогтоосон болохоор хүмүүсийн хувь заяаг судлахад маш тохиромжтой байна. Намайг гэрлээ унтраах үе та нар ийшээ хараарай гэж Трелони өндөр түшлэгтэй сандал дээр суугаад том нүдээрээ ангийг тойруулан харж хэллээ.

Профессор шидэт саваагаа даллахад чийдэнгүүд унтарч өрөөнд зөвхөн ханан зуухны гэрэл үлдэв. Трелони доошоо бөхийн сандал дороос нарны системийн шилэн бөмбөгөр оройтой жижигхэн загвар авлаа. Загварын голд гал улаан нар гийж эргэн тойрон есөн гариг болон дагуулууд нь хөдөлсөн гайхамшигтай сайхан завар байлаа. Харри профессорыг Ангараг гариг Далай ванд буландан ойртоход юу болдогыг тайлбарлахыг залхуутайгаар ширтэж байлаа. Түүний ойролцоох анхилам үнэрийг сэвшээ сэвшээ салхи хөөн сарниулна. Цонхны гадаа ямар нэгэн шавьж хөдлөв. Харрийн зовхи анилдлаа...

Тэр цэнхэр тэнгэрт эвэрт ууль унан хөөрөөд толгод дээр байгаа хуучин байшин руу нисэж байлаа. Ууль доошилж улам ойртон нисэхэд сэвшээ салхи Харрийн нүүрийг

илбэнэ. Тэд байшингийн хагарсан цонхоор орлоо. Цаашаагаа баргар хонгилоор нисэж төгсгөлийн өрөөнд хүрээд... цонхыг нь хадаж битүүлсэн харанхуй өрөөнд оров.

Харри уулийн нуруун дээрээс үсрэн буугаад... өмнөө сандал байхыг харав. Дэргэдэх шалан дээр бараан дүрс хөдлөхөд аварга том могой ханан зуухны хивсэн дээр атиралдан... халзан толгойтой шовх хамар усан нүдтэй жижигхэн хүн сөхрөн суугаад цурхиран уйлж байв.

- Сүүлтээ чамд аз таарчээ. Үнэхээрийн азтай хэрэг шүү. Чиний бүдүүлэг алдаа бүгдийг сүйтгэх шахсан ч тэр үхсэн гэх дотор зарсхийм хүйтэн хоолой сандлын гүнээс гарлаа.

- Эзэнтээн!... Эзэнтээн би их баяртай байна... уучлаарай гэж шалан дээр байсан хүн амьсгаадан хэлэв.

- Нагайна чамд аз таарсангүй. Би Сүүлтийг чамд идэхээр өгөхгүй. Гэхдээ зүгээр дээ оронд нь Харри Поттерыг өгөх болно.

Могой нарийхан хэлээ цухуйлган исгэрлээ.

- Харин одоо, Сүүлтээ би нэг ч алдаа гаргахыг тэвчихгүйг мэдэж ав.

- Өршөөгөөрэй, эзэнтээн... эзэнтэн минь би гуйж байна...

Сандал дээрээс шидэт савааны үзүүр цухуйн Сүүлт рүү чиглээд,

- Круцио! гэж хүйтэн хоолой хэлэв.

Сүүлт улайсгасан төмрөөр хайруулж байгаа юм шиг муухай хашгирав. Хашгиралт Харриг дөжрүүлэв. Энэ хашгиралтын дараа тэр юу ч сонсож чадахааргүй болж духан дээрх сорви нь хүчтэй өвдлөө. Харри ч бас хашгирав. Волан-де-Морт сонсоод... Харриг энд байгааг мэдсэн байлгүй дээ.

- Харри, Харри!

Харри нүдээ нээлээ. Тэр шалан дээр хэвтээд профессор Трелони алгаараа нүүрийг нь илж байв. Сорви нь халуу шатан өвдөж байсан тул арай л уйлсангүй. Тэр бол зүүд биш бодит явдалд байлаа. Эргэн тойрон нэг ангийхан нь цугларчээ. Рон дэргэд нь өвдөглөн суугаад айдас дүүрэн нүдээр харж байлаа.

- Чи ямаршуу байна даа? Зүгээр үү?

- Үгүй бололтой. Чи яагаа вэ, Поттер? Ямар нэгэн зүйл хараа юу? Хий үзэгдэл үү? Зөгнөл үү? гэж профессор Трелони сэтгэл хөдөлсөн янзтай хэлээд том нүдээрээ Харриг харлаа.

- Юу ч хараагүй гэж Харри худал хэлэв. Тэр шалан дээр суугаад чичирсэн хэвээр харанхуй булан руу харлаа. Волан-де-Мортын хоолой их ойрхон сонсогдсон доо...

- Чи шалан дээр духан дээрх сорвио даран унаад өнхөрч байсан! Би энэ юуны тэмдэг болохыг мэднэ, Поттер. Энэ чамд хэдийн нэг санаа төрүүлсэн байх ёстой.

Харри түүн рүү харав.

- Би хатагтай Помфри руу явсан нь дээр байх. Толгой тэсвэрлэхийн аргагүй өвдөж байна.

- Хүү минь чи миний өрөөнд эргэлзээгүй ер бусын зөгнөлийн чичиргээг мэдэрсэн. Хэрвээ та одоохон явах юм бол харах ховор боломжоо адах болно....

- Толгой өвдөхийг болиулахаас өөр юу ч харахыг хүсэхгүй байна.

Харри хөл дээрээ босохд айсан сурагчид зам тавив.

- Дараа уулзацгаая гэж Харри Ронд шивнээд цүнхээ авч тагтай үүд рүү явлаа. Префссор Трелони түүний амьдралд ховорхон тохиолдох боломжыг алдсан мэт урам хугарсан төрхтэй харагдав.

Харри олсон шатаар доошоо буугаад эмнэлэг рүү явсангүй бөгөөд ер тийшээ явах тухай бодоогүй болно. Хэрвээ сорви нь ахин өвдөх юм бол даруй Дамблдор мэдэгд гэсэн Сириусын зөвлөгөөг дагахаар шийдлээ. Харри хонгилоор явахдаа зүүдэндээ юу харснаа бодлоо. Бүгд тод хурц болсон доо. Тэр Улаан модон гудамжинд байхдаа тийм зүүд зүүдэлсэн юм. Харри ямар нэгэн зүйл мартаггүйн тулд нарийвчлан бодлоо. Волан-де-Морт Сүүлтийг алдаа гаргасан гэж буруушааж байтал... уулийн шуудангаар захиа ирж хэн нэгэн үхэн алдаа засагдсан гэсэн. Тэгэхээр Сүүлт могойн хоол болсонгүй. Түүний оронд Харриг болгохоор амласан...

Харри Дамблдорын өрөө рүү орох гарц болох чулуун лууны зүг очоод гэнэт нууц үг мэдэхгүй гэдгээ саналаа.

- Нимбэгний ундаа?

Луу хөдөлсөнгүй.

- Лийртэй мөсөн чихэр, Чихэртэй саваа. Друблсийн тэсэрдэг бох, Берти Боттсын үрэл... өө, үгүй ээ тэр тэдэнд дургүй. Зүгээр л нээгдчихэж болохгүй юу? Би түүнтэй уулзах яаралтай хэрэгтэй байна! гэж Харри уурслаа.

Чулуун луу хөдөлсөнгүй.

Түүнийг хөдөлгөх ямар ч зүйл байхгүй болсон болохоор зүрх нь палхийв.

- Шоколадан мэлхий! Чихэртэй үзэг! Жоомны сахал!

Чулуун луу амилж үсрэн холдлоо. Харри хөшөөд нүдээ анивчлаа.

- Тэгэхээр жоомны сахал байсан байх нь уу? Би зүгээр л тоглосон шүү дээ.

Харри гарц руу яаран ороод эргүүлгэн шатны эхний гишгүүр дээр хөл тавихад үүд хаагдан дээшээ хөдлөв. Шат түүнийг алгуурхан дээш авчирч хүрэл цохиуртай царсан үүдний өмнө зогслоо.

Хаалганы цаана хоолой гарах нь сонсогдов. Тэр хөдлөлгүй зогссон хэвээр чагналаа.

- Дамблдор би ямар ч холбоо олж харсангүй айж байна. Зүгээр л юу ч хараагүй тэгээд болоо. Людогийн үгээр бол Берта төөрсөн гэсэн. Бид түүнийг хэтэрхий удаан хугацаанд хайгаагүй гэдгийг зөвшөөрч байна. Гэхдээ түүнд ямар нэг юм үнэхээр

тохиолдсон гэх баталгаа байхгүй шүү дээ. Тэгээд ч Бартигийн алга болсонтой ямар ч хамаагүй гэх ид шидийн яамны сайд Корнелиус Фажын дуу гарав.

- Харин та сайдаа Барти Краучид юу тохиолдсон гэж бодож байгаа хэрэг вэ? гэж Грюм сөөнгөтөн хэллээ.

- Надад хоёр хувилбар байна, Аластор. Крауч ухаан солироод хаа нэг тийшээ явсан тэгээд л болно.

- Тийм хурдан явсан гэж үү, Корнелий гэж Дамблдор тайван хэлэв.

- Өө эсвэл... гэж Фаж ичингүйрэн дуугараад,

- Би болсон явдлыг өөрийн нүдээр харах хэрэгтэй байна. Та бүхэн Шармбатоны сүйх тэрэгний ойролцоо болсон гээ биз дээ? Дамблдор та энэ эмэгтэйд хамаатай гэж бодохгүй байна уу? гэв.

- Маш сайн захирал сайхан ч бүжиглэдэг юм.

- Болно Дамблдор, ажил хэрэгтээ орьё. Та түүнтэй харилцахдаа Хагридад жишээ үзүүлж болохсон. Ингэхэд таны Хагрид ч гэсэн мангасын хэнээтэй аюултай амьтан гэж Фаж уурсан хэлэв.

- Би хатагтай Максимаас илүү Хагридыг сэжиглэхгүй байна, Корнелий. Энэ бол таны л бодол гэж Дамблдор өмнөхийн адил тайван хэллээ.

- Зөвөлгөөнөө дуусгаж болохгүй юу? гэж Грюм дуугарав.

- Тиймээ тийм газар дээр нь очиж үзье гэж Фаж дэмжив.

- Үгүй ээ, би энэ тухай хэлээгүй. Хаалганы цаана Харри Поттер зогсоод таньтай ярихыг хүсэж байна, Дамблдор.

БҮЛЭГ 30: ОЮУН УХААНЫ ЦҮНХЭЭЛ

Өрөөний үүд нээгдэв.

- Сайн уу, Харри Поттер. Орооч гэж Грюм хэлэв.

Харри орлоо. Тэр урьд нь нэг удаа Дамблдорын өрөөнд ирж байсан юм. Сайхан дугуй өрөөний хананд өмнөх захирлуудын үүрэглэж байгаа зургууд өлгөөтэй байдаг. Тэдний цээж намуухан хурхиралтандаа хөдлөх ажээ.

Судалтай жанч өмсөж ногоон бүрх гартаа барьсан Корнелиус Фаж Дамблдорын ширээний дэргэд зогсож байв.

- Харри! Ажил ямар байна даа? гэж Фаж баяртай дуу алдаад түүн рүү алхав.

- Сайн гэж Харри худал хэлэв.

- Бид ноён Краучыг шилтгээний хажуугаас алга болсон шөнийн тухай ярилцаж байлаа. Чи түүнийг олсон гэлүү?

- Тийм гээд Харри толгой дохисноо тэдний яриаг санаад,

- Гэхдээ хатагтай Максимыг би тэнд хараагүй. Тэр нуугдахад тийм ч амархан хүн биш шүү дээ гэж хэлэв.

Дамблдор нүдээ гялалзуулан Фажын нурууны цаанаас инээмсэглэв.

- Ер нь бол тийм л дээ. Бид одоо шилтгээний эргэн тойронд явж үзэх гэж байна, Харри... чи ангидаа буцсан чинь дээр байх... гэж Фаж үл мэдэг ичингүйрэн хэлэв.

- Би таньтай ярилцахыг хүсэж байна, профессор гэж Харри түргэн хэлээд Дамблдор руу харав.

Захирал түүнийг шинжсэн харцаар ажиглав.

- Намайг энд хүлээж бай, Харри. Шилтгээний гадуур явж үзэхэд тийм ч их цаг орохгүй.

Тэд өрөөнөөс чимээгүйхэн гарч хаалга хаалаа. Хэдэн хором өнгөрөв. Грюмын модон хөлийн чимээ хонгилд сонсогдохоо болив. Бүх юм нам гүм болоход Харри ийш тийшээ хараад,

- Сайн уу, Фоукс гэж хэллээ.

Хун шиг сүр жавхлантай галт шувуу Фоукс хаалганы дэргэдэх алтан хөндлөвч дээр суугаад алтлаг сүүлээ дэрэн дээр тавьжээ. Тэр урт сүүлээ хөдөлгөнгөө Харри руу харав.

Харри Дамблдорын ширээний урд талын сандал дээр суугаад Хогвартсын өмнөх захирлуудын хөргүүдийг харлаа. Тэр жаазандаа тайван зүүрмэглэж байв. Харри сонссон зүйлийнхээ талаар бодтол өөрийн эрхгүй сорвио илэв. Сорви ахиж өвдсөнгүй.

Хачирхалтай нь Дамблдорын өрөөнд тэр илүү итгэлтэй тайван болж хагас цагийн дараа захирлыг эргэн ирэхэд зүүднийхээ талаар ярих болно. Харри ханын тавиур руу

хараад хуучин үнгэгдсэн шидэт бүрхийг олж харлаа. Түүний дэргэд ишинд нь том бадмаараг шигтгэж чимэглэсэн мөнгөн илд байв. Харри түүнийг шууд Гриффиндор тэнхимийг үндэслэгч Годрик Гриффиндорын илд болохыг тавилаа. Тэр түүнийг газар дорхи хонгилд шидэт бүрхээс гаргаж байсан билээ. Илд түүнд цагтаа тусламж болон ирсэн юм. Энэ ч эртний хоёрдугаар дамжаанд нь болсон хэрэг л дээ. Харин энэ хачирхалтай саванд гялалзаж байгаа зүйл юу юм бол? Харри эргэж харахад хар шүүгээ ялимгүй онгойлттой агаад мөнгөлөг цагаан судалтай гэгээ татаж байв. Харри Фоукс руу эргэлзэн харснаа босож шүүгээ рүү очиж хаалгыг нь нээв.

Дотор нь ирмэг хөвөөндөө янз бүрийн бичиг дүрс бүхий гүехэн чулуун суулга байлаа. Түүн дотроос хурц мөнгөлөг гэгээ татах аж. Харри ийм зүйлийг урьд нь хэзээ ч харж байгаагүй болохоор шингэн бодис эсвэл хийн алин болохыг мэдсэнгүй. Бодис цайвар мөнгөлөг агаад салхинд мяралзах ус мэт тасралтгүй хуйлран эргэлдэнэ. Энэ гэрэлтэй шингэн эсвэл сурагчаас хурааж авсан хий юм болов уу?

Түүнд гараа хүргэн хуруугаараа мэдрэх маш их хүсэл төрсөн ч бараг дөрвөн жилийг ид шидтэн илбэчингүүдийн сургуульд өнгөрүүлсэн туршлага нь гараа үл мэдэгдэх бодистой зүйлд хүргэх нь тэнэг зүйл гэдгийг хэлээд байлаа. Харри шидэт саваагаа халааснаасаа гарган аваад түгшин ийш тийшээ харснаа хөнгөн түлхэж үзэв.

Суулган доторх мөнгөлөг зүйлийн гадаргуу түргэн эргэлдлээ. Сүүн цагаан бодис шил шиг тунгалаг болов. Харри толгойгоо шүүгээ рүү шургуулаад суулга руу харав. Түүнд ёроол байсангүй агаад хаа нэгтээх том өрөөний адар дээрх дугуй цонхоор харж байгаа юм шиг сэтгэгдэл төрөв. Харри хамраа шилэнд бараг тулгах шахам бөхийлөө.

Газар дорхи танхим бүдэг гэрэлтэй цонхгүй бөгөөд Хогвартсын адил бамбарын гэрэл гийгүүлнэ. Ханын дагуу шалнаас адар хүртэл эгнэсэн сандал дээр дүүрэн шидтэнгүүд суугаад голд нь гинжтэй хоосон сандал байлаа. Харрийн зүрх ёгхийлээ. Гав байгаагаас үзэхэд сууж байгаа хүнийг гинжилдэг байх нь.

Хаана байдаг газар юм бол? Шилтгээнд биш гэдэг нь тодорхой. Тэр үүнтэй адилхан газрыг харж байгаагүй юм. Түүнээс гадна суулганы ёроол дахь нууцлаг өрөөнд цугласан хүмүүс насанд хүрсэн агаад Хогвартсын багш нараас арав дахин их байлаа. Эдгээр хүмүүс чимээгүйхэн суугаад нэг зүгт төвлөрөн ямар нэг зүйл хүлээж байлаа.

Сав дугуй танхим дөрвөлжин болохоор буланд юу байгаа нь харагдсангүй. Жаахан бөхийгөөд толгойгоо эргүүлвэл...

Хамрын үзүүр тунгалаг шингэний дээд талд хүрлээ.

Дамблдорын өрөө гэнэтхэн ганхаж Харри толгойгоороо суулга руу харанхуй хүйтэн усны эргүүлгэнд автсан мэт нисэн орлоо.

Тэр гэнэтхэн танхимыг бүхэлд нь харж болохоор хамгийн өндөр сандалд сууж байв. Харри дугуй цонхоор харж байсан адар өөд харахад харанхуй биш цул чулуу байлаа.

Харри хүндээр амьсгаадан ийш тийшээ харлаа. Өрөөнд байгаа шидтэнгүүдийн хэн ч (энд хоёр зуугаад шидтэнгүүд цугларчээ) дээр сууж байгаа арван дөрвөн настай

сурагчыг ажиглахгүй байх шиг санагдана. Харри дэргэдээ суугаа шидтэн рүү эргэтэл цээжний гүнээс гайхсан дуу алдлаа.

Түүний дэргэд Альбус Дамблдор сууж байв.

- Профессор! Уучлаарай... Би хүсээгүй... Би зүгээр л таны өрөөнд байсан суулга руу шагайсан юм... Би... Ингэхэд бид хаана байна? гэж Харри шивнэлээ.

Гэвч Дамблдор хөдөлсөнгүй. Тэр түүнийг огт ажиглахгүй байлаа. Урьдын адил суугаад булангын хаалга руу нүд салгахгүй ширтэнэ. Харри захирал руу мэгдэн хараад дараа нь алгуур түүний харж байгаа зүг рүү харлаа. Тэгтэл нэг зүйл санаанд орлоо...

Тэр хэдийн үүнтэй адил зүйлтэй учирч байсан юм. Өдрийн тэмдэглэлийн хуудсыг нэвтлэн шидтэний ой дурсамжинд орсон бөгөөд хэн ч түүнийг харж сонсохгүй байсан. Одоо магадгүй адилхан зүйл болоод байгаа юм болов уу...

Харри тээнэгэлзсэнээ Дамблдорын урдуур гараа даллав. Тэр хөмсгөө ч хөдөлгөсөнгүй. Харри хэн нэгний ой дурсамжинд байгаа нь тодорхой болов. Түүний дэргэд арай залуу Дамблдор сууж байлаа. Их адилхан ч буурал сахал үстэй байхыг бодоход саяхны хэрэг бололтой. Гэхдээ энэ ямар газар юм бол? Энд байгаа шидтэнгүүд хэнийг хүлээж байгаа юм бол?

Харри эргэн тойрноо анхааралтай ажиглав. Танхим эргэлзээгүй газар дор байлаа. Хананд нэг ч зураг чимэглэл байсангүй бөгөөд гав гинжтэй суудлыг тойрон дээшээ эгнэн өгссөн сандалууд байлаа.

Түүний хаана ирснээ бодож амжаагүй байтал алсын буланд хөлийн чимээ сонсогдон хаалга нээгдэж гурван хүн орж ирлээ. Үнэндээ бол нэг хүн хоёр Дементор орж ирлээ.

Харрийн дотор хүйт даав. Өндөр нүүрээ юүдэнгээр халхалсан Дементорууд өрөөний голын сандал руу удаанаар гулган хөвж дундаа яваа хүнийг ялзарч муудсан гараараа хөтөлж байв. Тэр хүн одоохон ухаан алдаж унах гэж байгаа мэт санагдахад Харри айдаст автлаа... Одоо хэн нэгний ой ухаанд Дементорууд түүнд хүрэхгүй хэдий ч дурсамж хэтэрхий тод ажээ. Үзэгчид хирдхийсэн байдалтай Дементорууд золгүй хүнийг сандал дээр дөнгөлөн хаалга хаан гартал хүлээлээ.

Хоригдол дагжин чичирч байв. Харри түүн рүү хараад Каркаров байхыг гайхан танилаа. Дамблдороос ялгаатай нь гэвэл Каркаров илүү залуу харагдаж сахал үсэнд нь буурал суугаагүй байв. Торгон дээлийнхээ оронд өрөвдөлтэй ноорсон жанч нөмөрчээ. Хоригдолыг сандал дээр хадсан гинж алтлаг өнгөөр гялалзана.

- Игорь Каракаров гэх хоолой Харрийн зүүн талд гарлаа (Тэр эргээд нөгөө талд нь ноён Крауч сууж байхыг харжээ. Хар үстэй духан дээрх үрчлээ нь цөөхөн бөгөөд түгшсэн янзтай харагдана). Таныг Азкабанд аваачихын өмнө ид шидийн яаманд гэрчийн мэдүүлэг өгүүлэхээр дуудлаа. Та бидэнд чухал мэдээлэл өгнө гэж амалсан билээ.

Каркаров гинжтэй хэвээр босон зогслоо.

- Тиймээ, ноёнтоон. Би яаманд ашигтай мэдээлэл өгөхийг хүсч байна. Туслах гэсэн юм. Надад яамныхан Хар лордын дэмжигчдийг барих гэж байгаа нь тодорхой байна л даа. Би ямар нэг зүйлээр туслахыг хүссэн юм... гэж тэр үхтлээ айсан хоолойгоор хэлэхэд Харри танил нялуун өнгийг ялган сонслоо.

Сандлууд дээр шивнэлт сонсогдов. Зарим нь Каркаровыг сонирхсон янзтай харж байхад, зарим нь үл итгэсэн байртай харж үзэгдэнэ. Тэгтэл баруун талд нь танил хоолой,

- Бузар гэж сөөнгөтлөө.

Харри урагш бөхийгөөд Дамблдорын цаана Хурц нүдэт Грюм сууж байхыг харлаа. Тэр одоогийнхтойгоо огт адилгүй байв! Шидэт нүд байхгүй хоёр нүд нь бүтэн бөгөөд Кракаров руу унтууцсан янзтай ширтэнэ.

- Крауч түүнийг суллах болно. Тэд тохиролцсон юм. Би түүнийг хагас жил мөшгөж байж барьсан. Харин Крауч түүнийг хэдэн нэр хэлсний төлөө суллахыг хүсч байдаг. Би түүний мэдээлэлийг сонсоод Дементорууд руу буцаасан нь дээр гэж бодож байна хэмээн Дамблдорт аяархан шивнэлээ.

Дамблдор таагүйхэн урт хамраа махиралдуулав.

- Аан тийм л дээ, мартчихаж... Альбус чи Дементоруудад дургүй билүү гэж Грюм ёжтой инээмсэглэв.

- Үгүй ээ. Би эртээс яамныхан эдгээр амьтадтай буруу хэлхээ холбоо тогтоосон гэж бодож ирсэн хэмээн Дамблдор тайван хэлэв.

- Тийм ч өөдгүй... гэж Грюм аяархан хэллээ.

- Та бидэнд хэлж чадах бүх нэрээ хэлж болно, Каркаров. Бид таныг сонсож байна гэж Крауч үргэлжлүүлэв.

- Та ойлгох ёстой... Хэцүү нэрт үргэлж үргэлж дээд зэргийн нууц түвшинд ажилладаг байсан... тэр биднийг... би түүний талынхан гэж хэлэхийг хүссэн юм л даа... би тэдний тоонд багтаж байсандаа маш их харамсаж байна хэмээн Каркаров хэллээ.

- Нуух хэрэггүй гэж Грюм басамжлан хэлэв.

- Бид хэзээ ч нэг нэгнийхээ нэрийг мэдэж байгаагүй. Биднийг бүгдийг нь тэр зөвхөн ганцаараа мэддэг байсан...

- Өөрөөсөө зайлуулан бусад руу түлхэх ухаалаг арга байна гэж Дамблдорын хөрш бувтналаа.

- Та бидэнд хэдэн нэр мэдэгдэнэ гэсэн? хэмээн ноён Крауч хэллээ.

- Би... тиймээ чадна. Бүгд Хар лордын ойрын туслахууд. Тэд миний нүдэн дээр түүний тушаалыг биелүүлж байсан. Би мэдээлэл өгч байгаагийн учир нь түүнээс бүрэн татгалзаж гэмшсэний баталгаа юм.

- Нэр! гэж ноён Крауч огцом шаардлаа.

Каркаров чимээтэй амьсгалав.

- Эхнийх нь Антонин Долохов. Би... би өөрөө түүнийг гэм зэмгүй маглуудыг эрүүдэж байхыг харсан. Хэн... Хар Лордын эсрэг байсан хүнийг... Бас...

- Бас өөрөө түүнд тусалсан гэж Грюм яриаг төгсгөлөө.

- Долохов баригдсан. Шууд таны дараа гэж Крауч хэлэв.

- Баригдсан гэнээ? Сонсоход их таатай байна! гээд Каркаровын нүд бүлтийлээ.

Гэхдээ түүний царай өөр зүйлийг гэрчилж байлаа. Мэдээ түүнд цохилт болжээ. Нэг нэр үнэ цэнгүй боллоо!

- Өөр хэн? гэж Крауч хүйтнээр хэлэв.

- Хэн гэнээ? Розье. Ивэн Розье гэж Каркаров яаран хэлэв.

- Розье үхсэн. Бас таныг баривчилсаны дараа. Баривчлагдах үедээ эсэргүүцсэн болохоор алагдсан.

- Тэгэхдээ миний хамрын хэсгийг авч явсан гэж Грюм шивнэлээ.

Харри ахин урагш бөхийгөөд Дамблдорын хөрш хэрхэн гэмтсэн хамраа заахыг харлаа.

- Тэр... тэр үүнээс өөр юу ч хүртэх гавъяагүй хэмээн Каркаровын хоолой цөхөрсөн шинжтэй дуулдав.

Түүний нэрсүүд яаманд ямар ч үнэ хүрсэнгүй. Каркаров түүнийг Дементор хүлээж байгаа хаалга руу харлаа.

- Өөр хэн? гэж Крауч асуулаа.

- Трэверс... тэр МакКинноновыг алахад тусалсан. Мальсибер... Имперуус шидийг ашиглаж... олон хүмүүсийг аймшигтай болгон хувиргасан... Өөр бас Руквуд тагнуул Хэцүү нэртийн яаман дахь мэдээлэгч.

Энэ удаа байгаа онолоо. Үзэгчид хоорондоо шивнэлдэв.

- Руквуд гэнээ? Нууцын хэлтсийн Августус Руквуд уу? гэж Крауч асуугаад өмнөө сууж байгаа шидтэн рүү дохилоо. Тэрбээр ямар нэгэн юм хурдан бичиж авав.

- Тиймээ, тэр. Ид шидийн яамны ханан дотор юу болж байгааг мэдээлдэг байсан...

- Трэверс, Мальсибер хоёрыг бид хэдийн саатуулсан. Руквудын хувьд... Сайн байна, Каркаров хэрвээ ингээд болсон бол таныг Азкабан руу буцаан аваачиж бид энд шийдвэрээ гаргах болно...

- Бүгд биш! Би өөр илүү зүйл мэднэ! гэж Каркаров цөхрөн хашгирав.

Бамбарын гэрэлд Харри түүний хөлс урсахыг харлаа. Үхлийн цонхигор царай хар үс сахалтай нь эрс тэс ялгарна.

- Снегг! Северус Снегг! гэж тэр хашгирав.

- Снегг Их зөвлөлөөр цагаатгагдсан. Түүнийг Альбус Дамблдор батлан дааж байгаа гэж Крауч зэвүүцэнгүй хэлэв.

- Цагаатгагдсан гэнээ! Би баталж байна! Северус Снегг бол Үхэл залгигч! гэж Каркаров хашгираад гинжтэй гэдгээ умартан үсрэн бослоо.

Дамблдор сандлаасаа өндийв.

- Би энэ хэргийг хэдийн гэрчилсэн. Северус Снегг нэгэн цагт Үхэл залгигч байсан. Гэхдээ Волан-де-Мортын унахын өмнөхөн томоохон эрсдэл гарган байж манай мэдээлэгч болсон. Одоо түүний Үхэл залгигч гэдэг бол би л гэсэн үг.

Харри Грюм руу эргэн харлаа. Түүний царай үл итгэсэн янзтай байв.

- Сайн байна, Каркаров. Та бидэнд их тусаллаа. Би таны хэргийг шалгаж үзэх болно. Харин одоо түр зуур Азкабан руугаа буц... гэж Крауч хүйтнээр хэлэв.

Краучын хоолой аяархан болсоор бүр чимээгүй болов. Харри ийш тийшээ харлаа. Газар доорхи хонгил утаа шиг сарнин зөвхөн түүний бие үлдээд бусад бүх зүйл харанхуй эргүүлэгт оров.

Гэнэтхэн газар дорхи танхим ахин бий болов. Харри ноён Краучын зүүн талд өөр газар сууж байв. Танхимын уур амьсгал ч гэсэн ондоо агаад тайван хөгжилтэй байлаа. Шидтэнгүүд хоорондоо квиддичийн тэмцээний тухай хөөрөлдөнө. Харрийн анхаарлыг хоёр эгнээний урд сууж байгаа богинохон цайвар үс, тод ягаан өнгийн жанчтай, амандаа ногоон үзэг зүүсэн хүн татав. Рита Скитер дүрээрээ байсан ч зөвхөн залуу байв. Харри ийш тийшээ харлаа. Дамблдор ахин дэргэд нь суугаад өөр жанч өмсчээ. Ноён Крауч турж эцсэн баргар царайтай байлаа... Харри өөр ахин дурсамжийн... өдөр... өөр шүүх хуралд байгаагаа ойлгов.

Булангийн хаалга нээгдэж танхимд Людо Бэгмен орж ирлээ.

Людо Бэгмен квиддичийн тоглогчын хувцастай байсан бөгөөд өндөр булчинлаг биетэй хамар нь ч гэсэн бүтэн байлаа. Тэр сэтгэлээр унасан янзтай сандал дээр суухад Каркаровын адил гавласангүй. Бэгмен үзэгчдийг тойруулан хараад сэргэж хэн нэгэнд гар даллан инээмсэглэв.

- Людо Бэгмен таныг Шидтэний хуулийн зөвлөлөөс Үхэл залгигчидтай ажил хэргийн холбоотой байсан гэж буруутгаж байна. Бид гэрчийн мэдүүлэгийг чинь сонсож ялын тогтоол гаргах болно. Шийдвэр гарахаас өмнө мэдүүлэх зүйл байна уу?

Харри чихэндээ итгэсэнгүй. Людо Бэгмен үхэл залгигч байсан хэрэг үү?

- Зөвхөн нэг байна. Би... хичнээн тэнэг байснаа ойлгож байна гэж Бэгмен ичингүйрэн инээмсэглэн хэлэв.

Нэг хоёрдугаар эгнээнд ойрхон сууж байсан шидтэнгүүдийн царайд инээмсэглэл тодров. Ноён Крауч тэдний мэдрэмжийг хуваалцсангүй. Тэр Людо Бэгмен руу дургүйцсэн байртай ширүүн харлаа.

- Юу гэвэл энэ үнэн гэж хэн нэгэн Харрийн нурууны ард бувтнав. (Тэр эргэж хараад ахин Грюмыг олж харав). Хэрвээ блажер түүний тархинд нөлөөлчихөөгүй бол үргэлж тэнэг байсан эсэхийг нь мэдэхгүй юм.

- Людовик Бэгмен та Лорд Волан-де-Мортын талынханд мэдээлэл дамжуулсан гэж буруутгагдаж байна. Би үүнд Азкабаны шоронд удаан хугацаагаар хоригдох шийтгэлийг санал болгож байна.

Сандал дээрээс уурссан хашгиралт сонсогдов. Хэд хэдэн шидтэнгүүд суудлаасаа үсрэн босоод ууртайгаар нударга зангидан ноён Краучын зүг хашгирав.

- Гэхдээ би таньд юу болсныг ойлгоогүй гэдгээ хэлэх ёстой! Юу ч ойлгоогүй! Хөгшин Руквуд миний эцгийн найз байсан... Би түүнийг Хэцүү нэртэй холбоотой байсан гэдгийг мэдээгүй! Би ид шидийн яаманд мэдээлэл цуглуулж өгч байна гэж бодсон! Руквуд намайг тэнд ажилд оруулахаар амласан юм... квиддич тоглохоо болихоор... Бүх амьдралдаа толгойгоо блажерын дор тавьмааргүй байна! гэж Бэгмен танхимын чимээ шуугианыг давахыг хичээн орилоход дугуй цэнхэр нүдэнд нь айдас хуржээ.

Танхимд цуглагсад инээлдлээ.

- Шийдвэрийг санал хураалтаар дүгнэнэ. Ноёд шүүгчдээ Азкабан руу явуулах нь гараа өргө гэж ноён Каруч хүйтнээр хэлээд танхимын баруун зүг рүү эргэн харлаа.

Харри ч гэсэн тэр зүг рүү харав. Хэн ч тийм гэж гараа өргөсөнгүй. Олонхи хүмүүс алга ташиж эхлэв. Шүүгчдийн нэг босоож зогслоо.

- За? гэж Крауч сөөнгөтөв.

- Бид ноён Бэгменд Английн шигшээ Туркийн эсрэг тоглосон Бямба гаригийн тоглолтон дээр гайхамшигтай сайхан тоглосонд баяр хүргэхийг хүсч байна.

Ноён Крауч унтууцсан янзтай харагдав. Газар дорхи танхимд алга ташилт нижигнэв. Бэгмен босоод нүүр дүүрэн инээмсэглэн бөхөлзөв.

- Жигшмээр юм! Руквуд түүнийг ажилд авахаар амалсан байдаг! Людо Бэгмен ид шидийн яаманд хар өдрүүдэд бидэнтэй ажилд орох гэж байсан байна... хэмээн Крауч Дамблдор руу эргэж хараад хэлэв.

Ингээд газар дорхи танхим ахин бүдгэрэн уусав. Түүнийг ахин тод төрхөө олох үед Харри ийш тийшээ харлаа. Тэр Дамблдор, Краучын хамт өмнөх суудалдаа суусан хэвээр бөгөөд танхимын уур амьсгал өөрчлөгджээ. Нам гүмийг ноён Краучын нөгөө талд сууж байсан туранхай жижигхэн шидтэн мэгших чимээ эвдэнэ. Тэр чичирсэн гараараа алчуур гарган амаа дарлаа. Харри Краучыг харахад өмнөхөөсөө турж эцэн бууралтжээ. Царай нь ногоорч чамархайны судас нь гүрэлзэнэ.

- Тэднийг оруул гэж тэр танхимын нам гүмийг эвдэн хэллээ.

Булангын хаалга ахин онгойв. Энэ удаад танхимд зургаан Дементор хэдэн хүнийг оруулж ирэв. Олонхи хүмүүс ноён Крауч руу эргэж харан шивнэлдэв.

Дементорууд тэднийг сандал дээр суулгаж гинжлэв. Тэд дөрвүүлээ байлаа. Ноён Крауч руу мэгдсэн янзтай ширтэх тагдгар биетэй эрэгтэй, туранхай цонхигор эрэгтэй, гинжтэй сандлын голд яг хаан шиг сууж байгаа гялалзсан хар үстэй хүнд зовхитой эмэгтэй, цайвар үс сэвхтэй царайтай хориос хэтрээгүй залуу хүү байлаа.

Түүний бүх бие чичирч үс нь сэгсийжээ. Краучын дэргэд сууж байсан туранхай жижигхэн эмэгтэй уйлж алчуур руугаа тонгойв.

Крауч босоод урд нь байгаа дөрвөн хүн рүү харахад нүүрэнд хүчтэй үзэн ядалт илрэв.

- Та нарыг Ид шидийн хуулийн зөвлөлөөс шийтгэх тогтоол гаргахаар авчираад байна. Та нарыг жигшүүрт гэмт хэрэг хийсэн гэж буруутгаж байна...

- Ааваа.... ааваа.. гуйя гэж залуу хүү хашгирав.

- ...энэ шүүхийн танхим ахиж сонсохгүй. Бид гэрчүүдийн үгийг сонссон. Та дөрвийг мракоборец Фрэнк Долгопупсыг Круциатус шид хэрэглэн тамласан гэж буруутгаж байна. Та нар түүнийг алга болсон эзнээ хаана байгаа болохыг мэдэж байсан итгэж байсан... гэж Крауч хүүгийнхээ дууг даран чанга дуугарлаа.

- Ааваа би оролцоогүй! Тангараглая! Намайг ахиад Дементорт битгий өгөөч... гэж залуу хүү хашгирав.

- Бас Фрэнк Долгопупс болон түүний эхнэрийг мэдээлэл өгөөгүйн төлөө Круциатус шид хэрэглэсэн гэж буруутгаж байна. Та нар Хэцүү нэртийг эргэж ирэн хүчээ авна гэж эргэлзээгүй тул. Иймээс би шүүгчдийн бүрэлдэхүүнээс...

- Ээжээ! Ээжээ! Түүнийг зогсоогооч! Ээжээ, би биш гэж тангараглаж байна! хэмээн залуу хүү хашгирахад ноён Краучын дэргэд сууж байсан эмэгтэй цурхиран уйллаа.

- Би шүүгчдээс асууж байна. Эдгээр гэмт хэрэгтнүүдийг бүх насаар нь Азкабанд хорих саналтай нь гараа өргө гэж Крауч бүх хүчээрээ хашгирлаа.

Шүүгчид нэгэн зэрэг гараа өргөв. Үзэгчид Бэгмений адил алга ташсан ч хэрцгий ялгуусан төрхтэй байлаа.

- Ээжээ, үгүй! Би үүнийг хийгээгүй, хийгээгүй! Би юу ч мэдээгүй! Намайг битгий тийш нь явуулаач! гэж залуу хүү хашгирав.

Дементорууд танхимд эргэн орж ирлээ. Гурван насанд хүрсэн хэрэгтэн чимээгүйхэн суудлаасаа бослоо. Хүнд зовхитой эмэгтэй Крауч руу харснаа,

- Хар Лорд эргэж ирнэ, Крауч! Биднийг Азкабанд хорьж болно! Бид түүнийг тэнд хүлээнэ! Түүнийг хүчээ авч бидэн дээр ирээд шагнах болно! Бид түүнд үнэнч хэвээр үлдэнэ! Бид түүнийг хайх болно! гэж хашгирлаа.

Цайвар үстэй хүү Дементоруудын гараас мултрахыг хичээсэн ч тэдний нөлөөлөл дор хүч нь барагдав. Эмэгтэйн тангарагын дараа үзэгчид дооглон инээж олонхи нь хөл дээрээ үсрэн босцгоов. Хар үстэй эмэгтэй түргэн алхан гарахад хүү үргэлжлүүлэн тэмцээр байлаа.

- Би чиний хүү! Би чиний хүү дээ! гэж тэр Крауч руу гуйн хашгирав.

- Надад хүү байхгүй! Надад хүү байхгүй! гэж Крауч нүдээ бүлтийлгэн бүх хүчээрээ хашгирлаа.

Туранхай шидтэн цурхиран уйлж ухаан алдлаа. Крауч үүнийг ажигласангүй.

- Тэднийг гарга! Одоохон гарга! гэж Дементорууд руу шүлсээ үсчүүлэн хашгирав.

- Ааваа! Ааваа! Би буруугүй! Үгүй! ! Ааваа, гуйя!

- Харри өрөөндөө буцах цаг болж гэж намуухан хоолой Харрийн чихэнд хэлэв.

Харри цочин дуу гарсан зүг рүү эргэн харлаа. Дараа нь баруун тийш эргэн харав. Түүний баруун талд Альбус Дамблдор суугаад Дементорууд хэрхэн Краучын хүүг танхимаас гаргахыг харж байв.

- Явцгаая гэж зүүн талд сууж байсан Дамблдор хэлээд Харрийн тохойноос барилаа. Харри дээшээ хөөрөхөө мэдэрчээ. Газар дорхи хонгил гэнэтхэн алга болов. Агшин зуур харанхуйд Харри удаанаар тонгорцоглон эргэлдэж хөл дээрээ газардахдаа нарны гэрэл туссан Хогвартсын захирлын өрөөнд байгаагаа мэдэв. Түүний өмнөх шүүгээний чулуун суулганаас мөнгөлөг гэрэл гялбалзан дэргэд нь Альбус Дамблдор зогсож байлаа.

- Профессор, би болохгүй гэж мэдээгүй... би хүсээгүй... шүүгээний хаалга нээлттэй байсан гэж Харри хэлэв.

- Чамайг ойлгож байна гэж Дамблдор хэлэв. Тэр суулгыг өргөн гялалзтал зүлгэсэн ширээн дээрээ тавиад суудалдаа сууж Харриг эсрэг талдаа суухыг урив.

Харри чулуун суулгаас нүд салгалгүй ширтлээ. Түүний дээр ахин мөнгөлөг цагаан гэрэл гарч хуйлран эргэлдэж эхлэв.

- Энэ юу вэ? гэж Харри чичрэн асуулаа.

- Энэ үү? Энэ бол оюун ухааны цүнхээл. Би заримдаа миний толгой бодол дурсамжаар дүүрснийг мэдэрдэг юм. Чамд ч гэсэн тийм мэдрэмж төрдөг биз дээ?

- М-м... гэж Харри итгэлгүйхэн бувтнав. Үнэнийг хэлэхэд түүнд хэзээ ч ийм мэдрэмж төрж байсангүй.

- Тийм үед би оюун ухааны цүнхээлийг хэрэглэдэг юм. Тийшээ хувийн бодлоо хийгээд харин дараа нь чөлөөтэй үедээ бодно. Дурсамж материалаг болохор үйл явдлын дүр зургийг эргүүлэн ирэхэд амархан болохыг харж байна уу.

- Та үүнийг... таны бодол гэж хэлэх гээ юу? гээд Харри суулганд хуйларсан мөнгөлөг шингэнийг харлаа.

- Тэгэлгүй яахав. Үүнийг хар л даа.

Дамблдор жанчнаасаа саваагаа гарган ирээд мөнгөлөг үстэй шанаандаа хүргэн гялалзсан нарийхан зүйлийг алгуур татлаа. Харрид энэ бол үс биш бөгөөд сүүн цагаан өнгөтэй чулуун суулганд байсантай адил зүйл болохыг ойлгов. Дамблдор үүнийгээ суулга руу нэмэхэд Харрийн гайхсан царай шингэний гадарга дээр гарч ирэв.

Дамблдор урт хуруугаараа суулгын ирмэгээс барин алтны хайгуулчин үйрмэг угааж байгаа аятай эргүүлэв. Харрийн нүүр өөрчлөгдөн Снегтийн царай тодорч ам нь нээгдэн сулхан хоолойгоор ярилаа.

- Тэр буцаж ирсэн... Каркаровынх ч гэсэн... Урьдынхаас илүү тод хүчтэй байна...

- Би энэ бүхэнтэй холбогдож чадна. За болно гэж Дамблдор санаа алдлаа.

Тэр бараан шилнийхээ цаанаас цүнхээлд байсан Снеггийн царайг нүд салгалгүй харж байсан Харри руу харлаа.

- Би ой ухааны дурсамж дээрээ ажиллаж байтал гэнэтхэн ноён Фаж ирээд суулгаа хураасан юм. Би хэтэрхий яарсандаа шүүгээгээ хаахаа мартчихаж. Тэр л чиний сонирхолыг татсан гэдэг нь тодорхой.

- Намайг уучлаарай гэж Харри хэлэв.

- Сониучирхал бол гэм буруу биш. Гэхдээ түүнийг тогтоож барьж байх хэрэгтэй гээд Дамблдор толгойгоо сэгсрэв.

Тэрбээр үл ялиг хөмсөг зангидаад суулга руу шидэт саваагаа хүргэлээ. Тэндээс дүрс үүсэж махлаг биетэй гомдож хөмсөг зангидсан арван зургаан настай охин удаанаар гарч ирлээ. Тэр Дамблдор, Харри хоёрт ямар ч анхаарал хандуулсангүй. Түүнийг ярьж эхлэхэд Снеггийн адил хоолой нь суулганы гүнээс сонсогдов.

- Тэр надад шившлэг илгээсэн, профессор Дамблдор. Харин би зөвхөн түүнийг пүрэв гаригт хүлэмжинд Флоренсийг үнсэхийг харсан гэж шоолсон юм.

- Яах гэж, Берта. Чи яах гэж түүний араас дагасан юм? гэж Дамблдор гунигтай асуугаад дүрс рүү харав.

- Берта гэнээ? Энэ... Энэ Берта Жоркинс гэж үү? хэмээн Харри охин руу харан шивнэлээ.

- Тийм. Би түүнийг сургуульд байгаагаар нь санадаг юм гэж Дамблдор толгой дохиод саваагаараа хатгахад Берта алга болж ахин мөнгөлөг шингэн болов.

Оюун ухааны цүнхээлийн мөнгөлөг гэрэл Дамблдорын нүүрэнд тусахад Харри захирлын хичнээн хөгшин болсныг гайхав. Тэр үргэлж өөр юманд сатаараад хэзээ ч түүний хөгшин болсон тухай бодож байсангүй.

- Тэгэхээр Харри, чи миний ой ухаанд нэвтрэхийн өмнө юм хэлэхийг хүссэн байхаа гэж Дамблдор аядуухан хэлэв.

- Тиймээ, профессор... Би мэргэ төлгийн хичээл дээр... унтчихсан юм.

Тэр чимээгүй болж хариу хүлээхэд Дамблдор зөвхөн,

- Ойлгож байна. Үргэлжлүүл гэлээ.

- Би зүүд зүүдэлсэн. Лорд Волан-де-Мортын тухай. Тэр Сүүлтийг шийтгэж байсан. Та Сүүлт гэж хэн болохыг мэднэ биз дээ...

- Мэднэ үргэлжлүүл гэж Дамблдор яаран хэлэв.

- Волан-де-Морт уулийн шуудангаар захидал авсан. Тэгээд Сүүлтийн алдаа засагдсан гэж хэлсэн. Хэн нэгэн үхсэн гэсэн. Тэгээд Сүүлтийг могойд өгөөгүй. Түүний сандлын дэргэд том могой байсан. Бас өөр... түүний оронд надаар могой гэжээнэ гэж хэлсэн. Дараа нь Сүүлтийг Круциатус шившлэгээр зовооход миний сорви өвдсөн. Маш хүчтэй өвдсөн болохоор би шууд сэрчихсэн.

Дамблдор түүнийг чимээгүй харна.

- Э-э... ингээд л болоо.

- Ойлгомжтой. Одоо өнгөрсөн зунаас хойш чиний сорви өвдсөн удаа байгаа эсэхийг хэлдээ?

- Үгүй... Та зун миний сорви өвдсөнийг яаж мэдээ вэ? гэж Харри тэсэлгүй асуулаа.

- Чи зөвхөн Сириуст бичсэн хэрэг биш. Би ч гэсэн түүнийг Хогвартсаас зугтсаны дараа холбоотой байсан. Би түүнийг уулын агуйд нуугдахыг санал болгосон юм. Хамгийн аюулгүй газар! гэж Дамблдор хэлэв.

Тэрбээр ширээндээ очиж суулаа. Хэдэн удаа чамархайдаа саваагаа хүргэн гялалзсан мөнгөлөг утас гаргаж оюун ухааны цүнхээлд хийв. Бодлууд дотор түргэн эргэлдсэнээ юу ч болоогүй юм шиг толийлоо.

- Профессор гэж Харри эцэст нь өөрийгөө сануулав.

Дамблдор зогсоод түүн рүү харав.

- Өршөөнө үү гэж тэр хэлээд ахин ширээндээ суулаа.

- Та... та яагаад миний сорви өвдсөнийг мэдэхгүй биз?

Тэрбээр Харри руу маш анхааралтай харлаа.

- Надад нэг онол байна. Чиний сорви Волан-де-Морт хэтэрхий ойртох юмуу ялангуяа хүчтэй үзэн ядах үед өвддөг гэж бодож байна.

- Гэхдээ... яагаад?

- Яагаад гэвэл та хоёр шившлэгээр холбоотой болсон. Чиний сорви бол ер бусын сорви.

- Та тэгэхээр... энэ зүүд биш... Болсон явдал гэж бодож байна уу?

- Боломжтой. Маш болзошгүй гэж хэлэх байна. Харри, чи Волан-де-Мортыг харсан уу?

- Үгүй. Зөвхөн сандлых нь араас харсан. Гэхдээ... сандал дээр бараг юу ч байгаагүй. Түүнд бие байгаагүй. Харин тэр яаж саваагаа барьж байсан юм бол? гэж Харри удаанаар хэлэв.

- Үнэндээ яаж юм болоо? гэж Дамблдор бувтналаа.

Хэдэн хормын турш хоёул чимээгүй болов. Дамблдор хоосон зай руу хараад саваагаа өргөн ахин нэг гялалзсан мөнгөн утас суулга руу хийлээ.

- Профессор та түүнийг хүчтэй болж байна гэж бодож байна уу? гэж Харри нам гүмийг эвдэн хэлэв.

- Волан-де-Морт уу? Харри би чамд зөвхөн сэжиглэлээ хэлж чадах байна гэж Дамблдор хэлээд түүнийг цүнхээл дээгүүр сайн танил харцаар харахад Харрид Грюмын шидэт нүд нэвт харж байгаа юм шиг мэдрэмж төржээ.

Дамблдор ахин санаа алдахад Харрид ердийнхөөсөө илүү их ядарч хөгширсөн юм шиг санагдлаа.

- Өнгөрсөн жил Волан-де-Мортын хүчээ авч байгаагийн тэмдэг болох хэдэн хүн алга болсон. Берта Жоркинс Волан-де-Мортын сүүлчийн удаа үзэгдсэн газар алга болсон. Үүний адилаар ноён Крауч... сургуулийн талбайгаас алга болсон. Бас нэг магл. Энэ баримт яамны анхаарлыг татахгүй байгаа нь харамсалтай. Түүнийг Фрэнк Брайс гэдэг байсан бөгөөд Волан-де-Мортын эцгийн тосгонд амьдардаг байсан юм. Түүнийг өнгөрсөн найман сараас хойш хэн ч хараагүй байна. Би яамны олон найзуудаасаа ялгаатай нь маглуудын сонин уншдаг юм даа.

Дамблдор Харриг түгшсэн харцаар ажиглав.

- Надад энэ алга бололтууд холбоотой юм шиг санагдаж байна. Харин яамныхан тэгж бодохгүй байгаа юм... Чи мэдээж энэ тухай хаалганы ард зогсож байхдаа сонссон байлгүй дээ.

Харри толгой дохив. Өрөөнд ахин нам гүм боллоо. Дамблдор бодлоо гаргаж аваад суулганд нэмэв. Харри явах болсныг ойлгосон ч сониучирхал түүнийг сандалд хаджээ.

- Профессор гэж тэр ахин Дамблдорт хандлаа.

- За, Харри гэж захирал хэлэв.

- Э-э... асууж болох уу... миний оюун ухааны цүнхээлд харсан шүүх хурлын тухай?

- Болно. Би олон удаа тэнд байсан ч зарим шүүх хурал бусдаас илүү тод байдаг юм... Ялангуяа одоо... гэж Дамблдор хэлэв.

- Шүүх дээр та намайг олсон шүү дээ? Краучын хүүгийн хурал дээр... Тэд Невиллийн эцэг эхийн тухай ярьсан уу?

Дамблдор Харри руу цоо ширтлээ.

- Невилл чамд яагаад эмээтэйгээ амьдардаг тухайгаа хэзээ ч ярьж байгаагүй юу?

Харри толгойгоо сэгсэрлээ. Тэр дөрвөн жилийн хугацаанд Невиллтэй хамт байхдаа энэ тухай огт асууж байсангүй.

- Тиймээ, тэд Невиллийн эцэг эхийн тухай ярьсан юм. Түүний эцэг Фрэнк профессор Грюмын адил мракоборец байсан юм. Түүнийг эхнэртэй нь Волан-де-Мортын байгаа газрыг хэлүүлэх гэж тамалсан. Чи өөрөө сонссон биз дээ.

- Тэд үхсэн үү? гэж Харри аяархан асуулаа.

- Үгүй. Тэд ухаангүй болсон. Тэд одоо хоёулаа гэгээн Мунгогийн шидэт өвчин эмгэгийн эмнэлэгт байгаа. Невилл эмээтэйгээ амралтаар тэднийг эргэдэг юм. Гэхдээ тэд түүнийг мэдэхгүй л дээ... гэж Дамблдор Харрийн хэзээ ч сонсож байгаагүй гашуудалтай өнгөөр хэлэв.

Харри айдаст автлаа. Тэр яаж дөрвөн жилийн турш үүнийг огт асуухгүй байж чадав аа...

- Нийтгэч эелдэг хүмүүс байсан юм. Волан-де-мортын уналтын дараа бүгд дайралт зогсож аюулгүй боллоо гэж бодоцгоосон. Дайралт уур хилэнгийн давалгааг үүсгэсэн юм. Ид шидийн яамыг даруйхан гэмт хэрэгтнүүдийг барьж авахыг шаардсан. Харамсалтай нь тэд ямар ч найдлагагүй сэтгэцийн гүн өөрчлөлтөнд орсон байсан даа.

- Ноён Краучын хүү буруугүй байж болох уу? гэж Харри удаанаар хэлэв.

- Би энэ тухай юу ч мэдэхгүй гээд Дамблдор толгой сэгсэрлээ.

Ахиад л чимээгүй болоход Харри оюун ухааны цүнхээлд дурсамжууд эргэлдэхийг харлаа. Түүнийг дотроос нь хоёр асуулт зовоож байв... Тэд бол амьд хүмүүст хамаатай юм.

- Э-э.. харин ноён Бэгмен...

- ...Тэр үеэс хойш хар хүчний төлөө ажилласан гэж хэзээ ч буруутгагдаж байгаагүй гэж Дамблдор тайван хэлэв.

- Аан гэж Харри яаран хэлээд бодол хийхээ зогссон болохоор удаанаар эргэлдэж буй оюун ухааны цүнхээл рүү нүд салгалгүй ширтлээ.

- Аан... ээ...

Түүнд нэрийг нь хэлэхэд амаргүй байсан ч оюун ухааны цүнхээл тусаллаа. Түүн дээр ахин Снеггийн дүрс гарч ирэв. Дамблдор түүнийг хараад Харри руу харцаа өргөлөө.

- Профессор Снеггийг буруутгах ямар ч шалтгаан байхгүй.

Харри Дамблдорын гүн цэнхэр нүд рүү харан эртнээс зовоож байсан асуултаа тавилаа.

- Харин та яагаад түүнийг жинхэнээсээ Волан-де-мортын талыг дэмжихээ больсон гэж боддог юм бэ?

Дамблдор хормын турш Харрийн нүд рүү ширтсэнээ дараа нь тайвнаар,

- Энэ бол Харри зөвхөн профессор Снегг бид хоёрт хамаатай асуудал гэв.

Харри яриа дууссаныг ойлголоо. Дамблдор уурлаагүй ч түүний хоолой явах цаг болсон гэдгийг нь хэлж байлаа. Тэр босоход Дамблдор ч гэсэн босов.

- Харри Невиллийн эцэг эхийн тухай хэнд ч битгий хэлээрэй. Тэр бэлэн болох үедээ өөрөө үүнийгээ ярих болно гэж түүнийг хаалганд хүрэхэд хэлэв.

- Ойлголоо, профессор гэж Харри хэлээд бариулаас татав.

- Бас нэг юм, Харри...

Харри эргэж харлаа.

Дамблдор гүн ухааны цүнхээлийн дэргэд зогсож байв. Мөнгөлөг гэрэлд урьдынхаасаа хөгширсөн мэт харагдана. Тэр Харри руу хормын турш чимээгүйхэн харлаа.

- Гурав дахь тэмцээнд чинь амжилт хүсье.

БҮЛЭГ 31: ГУРАВ ДАХЬ ДААЛГАВАР

- Дамблдор бас Хэцүү нэртийг хүчээ авч байгаа гэж бодсон хэрэг үү? хэмээн Рон шивнэлээ.

Харри Рон, Гермиона хоёрт оюун ухааны цүнхээлд юу харсан тухайгаа болон Дамблдороос сонссон зүйлээ ярилаа. Мөн мэдээж Дамблдорын өрөөнөөс гарсан даруй Сириуст ууль илгээжээ. Тэр үдэш найзууд ахиад л амралтын өрөөнд сууцгаав. Яриад л байдаг яриад л байдаг толгой ажилладаггүй. Харри профессор Дамблдор яагаад заримдаа тархи бодлоор дүүрч тэднийг хаа нэг тийш холдуулах хэрэгтэй болдог гэж хэлснийг ойлголоо.

Рон чимээгүйхэн ханан зуухны гал руу ширтэнэ. Өрөөнд дулаахан байсан ч тэр үл мэдэг чичирч байв.

- Тэгэхээр тэр Снеггэд итгэдэг хэрэг үү? Үхэл залгигч байсан гэдгийг нь мэдэж байгаа хэр нь итгэдэг гэж үү?

- Тиймээ гэж Харри толгой дохилоо.

Гермиона арваад хором хиртэй чимээгүй байв. Тэр толгойгоо барин суугаад өвдөг рүүгээ харна. Түүнд ч гэсэн оюун ухааны цүнхээл хэрэг болсон бололтой.

- Рита Скитер гэж тэр эцэст нь хэлэв.

- Чи яаж одоо түүнд санаа зовж чадаж байна? гэж Рон дуу алдлаа.

- Би түүнд санаа зовоогүй. Харин түүний үгийн тухай бодсон юм... Тэр надад <<Гурван шүүр>>-т юу хэлснийг санаж байна уу? <<Би Людо Бэгменийг чиний толгойны үс ургахаас өмнө мэднэ>> гэсэн шүү дээ. Тэр шүүх дээр харсан зүйлээ хэлсэн байх. Тэр танхимд байсан болохоор Үхэл залгигчид мэдээлэл дамжуулсан гэдгийг нь мэддэг байх нь. Бас Винки <<Ноён Бэгмен муу шидтэн>> гэж хэлсэн биз дээ. Ноён Крауч Бэгменийг уснаас хуурай гарсанд уурлаад энэ тухай үйлчлэгчдээ ярьсан байж таарлаа.

- Гэхдээ Бэгмен үүнд санаатайгаар оролцоогүй гэсэн биз дээ?

Гермиона мөрөө хавчлаа.

- Харин Фаж Краучыг хатагтай Максим дайрсан гэж бодож байгаа юм уу? хэмээн Рон Харри руу эргэлээ.

- Тиймээ. Гэхдээ зөвхөн Крауч Шармбатоны сүйх тэргийн ойролцоо алга болсон учир тэгж бодож байгаа юм.

- Бид энэ тухай бодож үзээгүй юм байна шүү. Түүнд аварга биетийн цус байгаа атал үүнийгээ нууж... гэж Рон удаанаар хэлэв.

- Зүйтэй хийж гэж Гермиона огцом таслаад толгойгоо өргөв.

- Хагридын эхийн нууцыг Рита мэдээд юу болсоныг сана. Фажыг сана. Тэр хатагтай Маскисыг зөвхөн хагас аварга биет учраас буруутгаж байна. Энэ мухар сүжиг хэнд

хэрэгтэй юм бэ? Хэрвээ надад том яс байсан бол аюултай үнэнийг нууна гэж хэлэх байна! гээд Гермина цагаа харснаа дуу алдаж,

- Бид нар өнөөдөр ямар ч бэлтгэл хийсэнгүй! Саад арилгагч шидээр сургуулилахаар төлөвлөсөн шүү дээ! Маргаашнаас шууд эхлээ! Явъя, Харри чи унтаж амрах хэрэгтэй гэв.

Харри, Рон хоёр унтлагын өрөө лүүгээ алгуур өгсөв. Харри хүрмээ тайлаад Невиллийн ор луу харлаа. Тэр найзууддаа Невиллийн эцэг эхийн нь тухай юу ч хэлээгүй юм. Шилээ тайлан орондоо орж хэвтээд эцэг эх нь амьд байгаа ч хүүгээ танихгүй байх ямар болохыг төсөөлөв. Харри үргэлж үл таних хүмүүс түүний өнчин гэдгийг мэдэхээр өрөвдөгийг мэдэх болохоор харанхуйд аяархан хурхирч байгаа Невиллийг ч гэсэн өрөвдөх сэтгэл хүлээж байлаа. Харри гэнэтхэн ноён ба хатагтай Долгопупсыг тамласан хүмүүсийг хүчтэй үзэн ядахаа мэдэрлээ... Дементорууд Краучын хүү болон бусад хэрэгтнүүдийг чирэн гаргахад танхимд дэмжсэн хашгиралт сонсогдсон шүү дээ... Тэр одоо л тэдний юу мэдэрснийг ойлгож байв... Гэнэтхэн түүнд залуу хүүгийн үхлийн цонхигор царай харагдахад жилийн өмнө үхсэн гэдгийг санаад давхийлээ

<<Энэ бүхэн Волан-де-Мортоос болсон. Бүгд түүнээс болсон. Тэр гэр бүлүүдийг салгаж амьдралыг нь сүйрүүлсэн...>> гэж Харри адар руу ширтэх зуураа бодлоо.

Рон, Гермиона хоёр гурав дахь тэмцээний өдөр дуусах шалгалтандаа бэлтгэх ёстой байсан ч тэдний бодлоор илүү чухал ажил болох Харритай бүх цагаа өнгөрүүлж байв.

- Бидэнд санаа зовох хэрэггүй. Ямар ч л гэсэн хар урлагаас хамгаалах хичээл дээр хамгийн өндөр оноо авах байх. Бид хамтдаа янз бүрийн шившлэг сурлаа шүү дээ! гэж Гермиона Харри шалгалтын тухай сануулан ганцаар бэлтгэл хийхийг санал болгоход хэлэв.

- Тэгээд ч энэ бэлтгэл ирээдүйн мракоборец болоход маш сайн бэлтгэл болно! Бүгдээрээ болно гэж найдаж байна шүү хэмээн Рон урам зоригтой хэлээд Саад болох шившлэгийг сөрөн зогсохоор оролдов.

Зургаан сар гарахад шилтгээн даяар ахиад л сүүлчийн тэмцээний өмнө сэтгэлийн хөөрөл эхлэв. Шалгалт дуусахаас долоо хоногийн өмнө хүн бүр гурав дахь тэмцээний тухай бодож байлаа. Харри чөлөөтэй хором бүрдээ янз бүрийн шившлэгээр сургуулилж байв. Тэр гурав дахь тэмцээний өмнө өөртөө илүү их итгэлтэй болжээ. Хэцүү хүнд аюултай гэж Грюмын хэлсэн маргаангүй зөв. Тэр замдаа мангас шиг амьтад болон илбэдсэн саадуудыг давах болно. Харин энэ удаад гурав дахь сорилтонд юу бэлтгэж болохыг мэдэж байгаа билээ.

Профессор МакГонагалл Харри, Гермиона, Рон гуравтай шилтгээний янз бүрийн буланд тааралдаад үдийн хоолны дараа хувиргалын ангийг ашиглах зөвшөөрөл олгов. Харри Саад арилгах шидийг түргэн эзэмшиж дайснаа удаашруулан тэр ч байтугай түр зуур зогсоож чаддаг болжээ. Дэлбэрэх шившлэгийн хувьд муугүй болов. Тэр замдаа тааралдсан хатуу биетүүдийг дэлбэлэн хөнгөхөн холдуулж байлаа. Гермиона номын сангаас ахиад Дөрвөн зовхис гэдэг ашигтай шившлэг эрж олжээ.

Шидэт саваа үргэлж хойд зүг рүү заах учир тийм саваатай байхад төөрдөг байшинд төөрөх явдал гарахгүй юм. Харин Бамбай шидийг ашиглахад асуудал тулгарлаа. Энэ нь эргэн тойронд үл үзэгдэх хана бий болгож ирсэн шившлэгийг хугалдаг ажээ. Гермiona Харригийн бамбайг нэвтэлж Хөл хөшөөх шид илгээсэн болохоор арван хормын турш зузаан ботиос эсрэг шившлэгийг нь эрэхэд хүргэлээ.

- Чиний хувьд бүх юм болж байна гэж тэр сурах ёстой шившлэгүүдийн жагсаалтыг харангаа урамшуулан хэлэв.

- Наашаа ирцгээ дээ! Тэнд Малфой юу хийж байгаа юм бол? гэж цонхоор харж байсан Рон хэлэв.

Харри, Гермiona хоёр очив. Малфой модны хажууд үнэнч найзууд болох Крэбб, Гойл хоёртой инээмсэглэн зогсож байв. Тэрбээр зангидсан гараа амандаа ярьж байгаа юм шиг ойртуулав.

- Гар утас ашиглаж байгаатай төстэй байна шүү гэж Харри сонирхон хэлэв.

- Боломжгүй шүү дээ. Би та нарт Хогвартс тийм зүйлүүд ажиллахгүй гэж хэлээ биз дээ гэж Гермiona хэлээд өрөөний голд буцаж очин,

- Нааш ир Харри. Ахиад нэг удаа Бамбай шидийг давтаж үзье гэлээ.

Одоо Сириус өдөр болгон ууль илгээж байлаа. Тэр Гермionaгийн адил сүүлчийн тэмцээнд санаа зовж байв. Тэр захиа болгондоо юу ч болсон Хогвартсын хананаас гарч болохгүй гэдгийг сануулна.

Хэрвээ Волан-де-Морт үнэхээр хүчээ авсан бол миний гол ажил чиний аюулгүй байдал болоод байна. Гэхдээ чи Дамблдорын хамгаалалтан дор байгаа болохоор ямар нэг аюул учрахгүй ч хэдий ч эрсдэлээс холхон бай. Зөвхөн төөрдөг байшингаас аюулгүй гарахад төвлөр.

Зургаан сарын хорин дөрвөн ойртоход Харри нэг болон хоёрдугаар тэмцээний адил тийм хүчтэй сэтгэл түгшсэнгүй. Нэгдүгээрт энэ удаад тэр сайн бэлтгэсэн гэдэгт эргэлзэх явдалгүй байлаа. Хоёрдугаарт гэвэл саад тотгорын эцэст хожих эсвэл хожигдох эсэх нь тодрох юм. Тэмцээн дуусах болохоор бүх санаа зовнил ард хоцрох болно.

Тэмцээний өглөө Гриффиндорын ширээнд онцгой шуугиантай байлаа. Уулийн шуудан Харрид Сириусын амжилт хүссэн ил захидал авчирч өгчээ. Энэ нь ердөө нохойны шавартай сарвууны дардас бүхий хуудас цаас байсан ч Харрийн зүрх булгилав. Ердийнхөөрөө ууль нисэн ирж Гермionaд <<Өдөр тутмын Зөнч>> сонинь шинэхэн дугаар авчирч өглөө. Тэр сонинг эргүүлээд эхний нүүрийг нь харснаа амандаа балгасан хулууны шүүсээ талаар нэг тургичихлаа.

- Юу болсон бэ? гэж Харри, Рон хоёр зэрэг асуулаа.

- Юу ч биш гэж Гермiona яаран хэлээд сонинг нуухыг хичээсэн ч Рон амжин суга татан авлаа.

Тэр эхний нүүрэн дээр гарсан гарчгийг нь харснаа,

- Хөгшин үнээ! Яг өнөөдөр шүү! гэж дуу алдав.
- Яасан? Ахиад л Рита Скитер үү? гэж Харри асуулаа.
- Үгүй гэж Рон хэлээд Гермionaгийн адил сонинг холдуулахыг завдав.
- Ахиад л миний тухай юу? гэж Харри асуулаа.
- Үгүй гэж Рон үнэмшилгүй хоолойгоор дуугарлаа.

Гэхдээ Харри түүний гараас сонин авахаас урьтаж Драко Малфой Слизериний ширээнээс хашгирлаа.

- Хөөе, Поттер! Поттер! Толгой чинь ямар байна даа? Зүгээр үү! Биднийг хазахгүй гэдэгт чинь найдаж болох уу?

Малфойн гарт бас <<Өдөр тутмын зөнч>> сонин байлаа. Слизеринийхэн инээлдэн Харрийн зүг нэгэн зэрэг эргэн харцгаав.

- Алив үзье гэж Харри Ронд хэллээ.

Рон дурамжхан сонингоо өгөв. Харри сонинг дэлгээд өөрийн зургийн дор томоор бичсэн үгийг олж харлаа.

ХАРРИ ПОТТЕР ЭРҮҮЛ БУС АЮУЛТАЙ БАЙНА

Хэцүү нэртийг ялсан хүү одоо тогтворгүй бөгөөд аюултай ч байж болох юм гэж манай тусгай сурвалжлагч Рита Скитер мэдэгдлээ. Саяхны сэтгэл түгшээсэн баримтууд Харри Поттерын хачирхалтай үйлдэлд хамаатай юм. Эдгээр баримтууд нь түүнийг цаашид Гурван шидтэний хүнд тэмцээнд өрсөлдөх эсэх эсвэл бүр Хогвартс сургуульд суралцах эсэхийг шийдэх хүртэл ноцтой аюул дагуулж байна.

<<Өдөр тутмын Зөнч>> сонинд ирсэн мэдээллийн дагуу Поттер мэргэ төлгийн хичээл дээр сорви нь өвдөн ухаан алдан унажээ (Хэцүү нэрт түүний алахыг оролдсох үед духан дээр нь үлдсэн хараалын тэмдэг). Даваа гаригт манай сурвалжлагч Поттер хэрхэн мэргэ төлгийн хичээлээс хашгиран гарч гүйхийн гэрч болсон юм. Түүний сорви хүчтэй өвдсөн болохоор хичээл дээр суух боломжгүй болжээ.

Гэгээн Мунгогийн ид шидийн өвчин эмгэгийн эмнэлэгийн мэргэжилтэнгүүд Хэцүү нэртийн дайралт Поттерын тархинд ул мөрөө үлдээн сэтгэцэд нь нөлөөлсөн байж магадгүй гэж үзэж байна.

- Эсвэл тэр дүр үзүүлж байж ч болох юм. Энэ бол бусдын анхаарлыг өөртөө татах олон аргуудын нэг шүү дээ гэж нэг мэргэжилтэн мэдэгдсэн байна.

<<Өдөр тутмын Зөнч>> сонинд Хогвартсын захирал Альбус Дамблдорын шидтэнгүүдээс болгоомжтойгоор нууцалж байсан Харри Поттерийн тухай сэтгэл түгшээм баримт илт болов.

<<Поттер бол могойн хэлтэй шидтэн юм. Хоёр жилийн өмнө шилтгээнд удаа дараалсан халдлага гарсан. Олон хүн үүнд Поттерийг сэжиглэж байсан бөгөөд тэр халз тулааны клуб дээр ухаанаа алдтал уурлаж бүгдийн нүдэн дээр могой удирдаж нэг хүүхэд рүү дайруулсан. Энэ тухай даран өнгөрүүлсэн. Бас Поттерын найзууд нь хүн чоно болон аварга биет. Үүнийг эрх мэдэлд хүрэх гэсэн оролдлогын эхлэл гэж

бодож байна>> хэмээн Хогвартсын дөрөвдүгээр дамжааны Драко Малфой мэдэгдсэн байна.

Могойн хэлтэй шидтэн могойтой ярьж чаддаг бөгөөд эртнээс хар урлагт тооцогдсоор ирсэн юм. Хамгийн алдартай могойн хэлтэй шидтэн бол Хэцүү нэрт байсан билээ. Хар урлагаас хамгаалах холбооны гишүүн нэрээ хэлэхийг хүсээгүй нэг шидтэн хэлэхдээ <<Бүх могойн хэлтэй шидтэнийг мөрдөн шалгах хэрэгтэй. Би хувьдаа могойн хэлээр ярьж чаддаг ямар ч хүнийг маш их сэжиглэж байна. Могой үргэлж хар урлагийн бэлэг тэмдэг байсаар ирсэн бөгөөд түүхэнд учруулсан хор хохиролын хэмжээ ч багагүй юм. Мэдээж ямар хүн аварга биет, хүн чоно мэтийн хэрцгий амьтадтай найзлахыг хүсэх билээ дээ>>.

Альбус Дамблдор ийм сурагчыг Гурван шидтэний тэмцээнд оролцуулахыг зөвшөөрсөн талаараа анхааралтай бодож үзэх хэрэгтэй болох нь. Түүнчлэн энэ үдшийн тэмцээнд Поттер хар шидийн тусламжтай ялах болов уу гэсэн айдас ч бас байгаа юм.

- Бас л нэг тэнэг зүйл гэж Харри хэлээд сонинг хайхрамжгүй хуйллаа

Слизериний ширээн дээрээс Малфой, Крэбб, Гойл нар түүн рүү хөгжилтэй инээлдэн хуруугаараа шанаагаа өрөмдөж могой дуурайн хэлээ голзолзуулж харагдана.

- Тэр яаж мэргэ төлгийн хичээл дээр чиний сорви өвдсөнийг мэдсэн юм бол? Шилтгээнд байгаагүй биз дээ. Бас тэр юу ч сонсож чадахгүй байсан... гэж Рон гайхав.

- Цонх нээлттэй байсан. Би агаар амьсгалах гэж нээсэн юм гэж Харри хэллээ.

- Гэхдээ чи хамгийн өндөр цамхагт байсан шүү дээ! Газар дээрээс юу ч сонсогдохгүй! гэж Гермiona дуу алдав.

- Чи л ид шидийн нууцаар сонсох аргын тухай судалж байгаа биз дээ! Яаж сонссоныг нь тайлбарлаж өгнө дөө! гэж Харри сануулав.

- Тиймээ судалсан. Гэхдээ би... надад.

Түүний царай гэнэт хачирхалтай мөрөөдөнгүй өнгөтэй боллоо. Тэр гараа алгуур өргөөд үсээ барьж үзэв.

- Чи яагаа вэ? гэж Рон түгшлээ.

- Яагаа ч үгүй.

Тэр ахиад л хуруугаа үсэн дээгүүрээ гүйлгээд үл үзэгдэх гар утсаар ярьж байгаа аятай амандаа барилаа. Харри, Рон хоёр юу ч ойлголгүй бие биеэ харлаа.

- Надад нэг санаа төрлөө. Би мэдэх юм шиг байна... яагаад нэг ч хүн хараагүй болохыг... Грюм хүртэл... тэр цонхны тавцан дээр гарч чадна... түүнд зөвшөөрөл байхгүй юм чинь... мэдээж зөвшөөрөл байхгүй... Тэр миний гарт байх шиг байна! Одоохон номны сан руу гүйж шалгаадахъя! гээд цүнхээ аван Их танхимаас гүйн гарлаа.

- Хөөе! Бид арван хормын дараа ид шидийн түүхийн хичээлийн шалгалттай шүү дээ! гэж Рон орилоод Харри руу эргэж харлаа.

- Тэр Скитерийг үзэн ядсандаа болоод шалгалтаа хүртэл мартаж байна. Чи Бинсийн шалгалтан дээр хуулж болно гэж бодож байна уу?

Харри тэмцээнд оролцсон аваргуудын адил шалгалтнаас чөлөөлөгдсөн билээ. Зүгээр л шалгалтан дээр арын ширээнд суугаад номноос түүнд тус болох шинэ шившлэг эрж байлаа.

- Магадгүй л юм гэж Харри хэлэв. Энэ агшинд профессор МакГонагалл түүн рүү хүрч ирэв.

- Поттер, тэмцээний бүх аваргууд өглөөний цайны дараа хажуугийн танхимд цугларч байгаа шүү.

- Гэхдээ тэмцээн орой эхлэнэ биз дээ! гэж Харри дуу алдаад цагаа эндүүрсэн байх вий гэж айсандаа жанч руугаа өндөг унагачихлаа.

- Мэдээж тэгнэ, Поттер. Танхимд оролцогчдын гэр бүл цуглараад хүлээж байгаа. Тэд сүүлчийн тэмцээнийг үзэхээр уригдан ирсэн юм. Өнөөдөр чи тэдэнтэй өдрийг өнгөрүүлэх боломжтой гээд тэр явчихлаа.

Харри түүнийг алмайран харсаар үлдэв.

- Тэр үнэхээр Дурслийнхан ийшээ ирнэ гэж бодсон юм байх даа? гэж Роноос асуув.

- Мэдэхгүй. Би явахгүй бол Бинсээс хоцрох нь байна. Удахгүй уулзая!

Танхим түргэн хоосров. Харри Флер Деклакур Когтевраны ширээнээс босоод Седрикийг гүйцэхийг харлаа. Түүний араас Крам алгуур хөдлөв. Харри өглөөний цайгаа дуусгахыг яарсангүй. Тийшээ явах хүсэл ер нь байсангүй. Түүнд гэр бүл байхгүй болохоор хүнд үед дэмжихээр ирэхгүй. Хамгийн дээр нь гэвэл номын санд орж шившлэг эрэх явдал байв. Танхимын хажуугийн өрөөний хаалга нээгдэж Седрикийн толгой цухуйв.

- Харри, түргэлээрэй! Чамайг хүлээгээд байна! гэж тэр хашгирлаа.

Харри үхтлээ гайхан бослоо. Дурслийнхан үнэхээр ийшээ ирлээ гэж үү? Тэр Их танхимаас гараад хажуугийн өрөөнд орлоо.

Седрик эцэг эхийнхээ хамтаар хаалганы дэргэд зогсож байв. Крам өрөөний буланд Болгарын эцэг эхтэйгээ ярилцана. Хоёулаа хар үстэй агаад бүргэд хамрыг Крам эцгээсээ өвлөн авсан бололтой. Нөгөө нэг буланд Флер францаар эхтэйгээ ярина. Түүний жижигхэн дүү Габриэль дэргэд нь зогсоод ээжийнхээ гараас барьж байлаа. Тэр Харриг хараад гар даллахад хариу даллав. Тэгтэл ханан зуухны урд хатагтай Уизли, Билл хоёрыг зогсож байхыг харлаа. Баярласан Харри гүйх шахам хүрэв.

- Гэнэтийн бэлэг! Бид чамайг дэмжихээр ирсэн, Харри! гэж хатагтай Уизли сэтгэл хөдлөн дуу алдаад бөхийн үнсэв.

- Чи бэлэн үү? Чарли ч гэсэн ирэхийг хүссэн ч ажлаасаа холдож чадаагүй. Тэр бидэнд чиний эвэр сүүлтийг хэрхэн гайхамшигтай сайхан ялсан тухай ярьсан! гэж Билл хэлээд инээмсэглэн гарыг нь сэгсэрлээ.

Флер Делакур ээжийнхээ мөрний цаанаас Биллийг сонирхон ажиглав. Түүний урт үс, соёотой ээмэг анхаарлыг нь татсан бололтой.

- Та нар ирсэн чинь ямар сайн хэрэг вэ! Би бодохдоо... үнэхээр Дурслийнхан ирээгүй байгаа даа гэж хэмээн Харри талархаад хатагтай Уизли руу харлаа.

- Хм-м гээд хатагтай Уизли уруулаа жимийв. Тэр Дурслийнхнийг хэзээ ч түүний дэргэд шүүмжилж байгаагүй ч тэдний нэрийг дурьдах болгонд нүдэнд нь таагүй гал дүрсхийдэг юм.

- Сургуульдаа эргэж ирэх гайхамшигтай байна шүү! Би энд бүтэн таван жил байсангүй. Нөгөө галзуу хөлөг баатар байсаар байгаа юу? Ноён Кэдоган? гээд Билл эргэн тойрноо харахад тарган хатагтайн найз Виолетта түүн рүү нүд ирмэв.

- Өө, байлгүй яахав.

Харри түүнтэй өнгөрсөн жил танилцсан билээ.

- Харин тарган хатагтай?

- Би ч гэсэн санаж байна. Нэг удаа намайг зэмлэсэн шүү! Би унтлагын өрөөндөө шөнийн дөрвөн цагаас эргэж ирсэн юм...

- Та шөнөжин хаана байгаа вэ? гээд Билл гайхан эх рүүгээ харлаа.

Хатагтай Уизли инээмсэглэв.

- Эцэгтэй чинь зугаалсан юм. Харин түүнийг сургуулийн харуул Апполиона Принг барьчихсан... эцэг чинь мөр үлдээсэн болохоор...

- Биднийг шилтгээр аялуулж болох уу, Харри? гэж Билл асуулаа.

- Дуртайяа гэж Харри хэллээ.

Гурвуулаа Их танхимын хаалга руу хөдлөв. Диггорын гэр бүлийнхэний хажуугаар өнгөрөхдөө Харри Седрикийн эцгийн таагүй харцыг ажиглалаа.

- Аан чи юу! Чамайг өөртөө итгэлтэй байгаа биш гэж айж байна! Седрик чамайг оноогоороо гүйцсэн! гэж Харриг хөлөөс толгой хүртэл хараад хэллээ.

- Юу? гэж Харри гайхан асуулаа.

- Түүнд анхаарал хандуулах хэрэггүй. Тэр Рита Скитерийн гурван шидтэний тэмцээний тухай сурвалжлагыг уншаад тэгж байгаа юм... Тэнд чамайг Хогвартсын цорын ганц аварга гэж бичсэнийг санаж байна уу... гэж Седрик хөмсөг зангидан шивнэлээ.

- Тэр түүнийг дурьдаа ч үгүй байсан! Гэхдээ чи түүнд үзүүлээд өг, Сед. Чи урьд нь нэг удаа ялж байсан биз дээ гэж Амос Диггори хатагтай Уизли, Билл хоёрт сонсогдохоор дуу алдлаа.

- Рита Скитер явсан газар бүртээ шуугиан дэгдээж байх юм. Амос чи ид шидийн яаманд ажилладаг юм чинь мэднэ биз дээ! гэж хатагтай Уизли уурсав.

Ноён Диггори уурласан хэдий ч эхнэр нь гараас нь татахад мөрөө хавчаад эргэж харлаа.

Харри өглөөг Билл, хатагтай Уизли хоёртай тааламжтай өнгөрүүлэв. Тэд сургуулийн бүх нутаг дэвсгэрээр явж Харри Шармбатоны сүйх тэрэг, Дурмстрангын хөлөг онгоцыг үзүүлэв. Хатагтай Уизли түүнийг төгссөний дараа суулгасан шажигнуур удыг ихэд сонирхож байлаа. Дараа нь Хагридын урд байсан ойн сахиул Оггагын тухай удтал дурсацгаав.

- Перси ямаршуу байна даа? гэж Харри хүлэмжний хажуугаар өнгөрөхөд асуулаа.

- Тийм ч сайн биш гэж Билл хэлэв.

- Тэр маш их сэтгэлээр унасан. Ид шидийн яамнаас ноён Краучын алга болсон тухай чимээгүй өнгөрүүлэхийг хүсч байгаа ч Персигээс ноён Краучын илгээсэн заавар хаана авч байсныг асуусан. Бүгд эдгээр заавруудыг Крауч бичээгүй гэж бодож байгаа юм. Перси их санаа зовсон доо. Түүнд оройны тэмцээн дээр даргыгаа орлох зөвшөөрөл ч өгөөгүй. Түүний оронд Корнелиус Фаж ирсэн.

Үдийн хоолны үеэр шилтгээндээ эргэж ирцгээв.

- Ээж! Билл! Та нар энд юу хийж байгаа юм бэ? гэж Рон тэднийг Гриффиндорын ширээнээс гараад гайхан дуу алдав.

- Сүүлчийн тэмцээнд Харриг дэмжихээр ирээд байна! Би үүнийг хоол хийхгүй байх сайхан боломж гэдгийг хэлэх байна. Ингэхэд чиний сүүлчийн шалгалт чинь юу болсон бэ?

- А-а... Хэвийн! Албингуудын бослогонд оролцсон бүх нэрийг санаж чадаагүй (Хатагтай Уизли агшин зуур ширүүн болов). Бүгд хэвийн дээ. Тэдний нэрс нь Сахалт, Бохир зэрэг хачин нэрүүд байдаг болохоор ямар ч аймаар зүйл байхгүй гэж Рон түүнийг тайвшируулаад тавгандаа хоол хийж авлаа.

Удалгүй тэдэнтэй Фред, Жорж болон Жинни нэгдэхэд Харрид Үүрэнд эргэж очих шиг санагджээ. Тэр тэмцээний тухай мартаад байтал Гермiona хоолны үеэр эргэн ирж өглөөний яриаг сануулав. Ингэхэд тэр Рита Скитерийн нууцыг тайлсан болов уу?

- Алив, яриарай...

Гермиона хатагтай Уизлигийн зүг болгоомжлон харж толгойгоо сэгсрэв.

- Сайн уу, Гермiona гэж хатагтай Уизли хөндий мэндлэв.

- Сайн уу гээд хатагтай Уизлийн ширүүн төрхөнд Гермionaгийн нүүрнээс инээмсэглэл алга боллоо.

Харри өөр тийшээ хараад,

- Хатагтай Уизли та Рита Скитерийн <<Шидтэн>> сэтгүүлд бичсэн дэмий зүйлд итгээгүй биз дээ? Гермionaг миний найз охин гэсэн! гэв.

- А-а! Мэдээж итгээгүй гэж хатагтай Уизли хэлэв.

Ингээд Гермионад илүү элэгсэг хандлаа.

Харри, Билл хатагтай Уизли гурав үдээс хойшийн турш шилтгээний эргэн тойронд зугаалаад Их танхимд цайллаганд оролцохоор эргэж ирэв. Багш нарын ширээнд хэдийн Людо Бэгмен, Корнелиус Фаж нар суужээ. Бэгмен ердийнхөөрөө хөгжилтэй байх агаад хатагтай Максимын дэргэд суусан Фаж эсрэгээрээ баргар царайлан яриа хөөрөөгүй байлаа. Хатагтай Максим таваг руугаа ширтэхэд Харрид түүний нүд улаан болсон юм шиг санагдав. Хагрид түүний зүг харж байлаа.

Харри сэтгэл хөдөлсөндөө болоод баярын зоогноос юу ч идсэнгүй. Шидэт адрын цэнхэр өнгө бүрэнхий болгон алгуур өөрчлөгдөв. Эцэст нь Дамблдор ширээнээсээ босоход бүх танхим чимээгүй болов.

- Ноёд хатагтай нараа та бүхнийг таван хормын дараа Гурван шидтэний сүүлчийн тэмцээн болох газар болох квиддичийн талбайд урьж байна. Харин одоо бүх аваргуудыг ноён Бэгментэй явахыг гуйх байна.

Харри босоход Гриффиндорынхон алга ташлаа. Уизлийнхан болон Гермиона түүнд амжилт хүсэхэд Седрик, Флер, Крам нарын хамтаар Их танхимаас гарлаа.

- Ямаршуу байна даа, Харри? Өөртөө итгэлтэй байна уу? гэж Бэгмен үүдний чулуун шатаар уруудахдаа хэлэв.

- Бүгд хэвийн гэж Харри хариулав. Тэр сэтгэл догдлон бүх шившлэгээ амандаа давтаад өөртөө илүү итгэлтэй боллоо.

Төдхөн цэнгэлдэх хүрээлэн рүү хүрч очлоо. Квиддичийн талбай танигдахын аргагүй болон өөрчлөгджээ. Тэгш өнцөгт талбайн хөвөөгөөр хорин фунтын өндөртэй таримал бургасан хашаа ургасан харагдана. Тэдний өмнө төөрдөг байшин руу ордог гарц байлаа. Дотогш хөтөлсөн хонгил харанхуй агаад дотор зарсхиймээр ажээ.

Таван хормын дараа цэнгэлдэх хүрээлэнд анхны үзэгчид ирж эхлэв. Агаарт сэтгэл хөдөлсөн хоолой олон зуун хөлийн алхааны чимээ гарч үзэгчид суудлаа эзлэхээр яарав. Цэлмэг тэнгэрт анхны одод түглээ. Бэгмен аваргуудыг дагуулан Хагрид болон профессор МакГонагалл, Грюм, Флитвик нар луу очлоо. Тэдний том улаан малгай болон, Хагридын нуруун дээр том одод гялалзана.

- Бид гадаа эргүүл хийнэ. Хэрвээ хэн нэгэн зовлонд учирвал тусламж дуудахын тулд агаарт улаан оч илгээгээрэй бид даруйхан очиж туслах болно. Бүгд ойлгомжтой юу? гэж аваргуудад профессор МакГонагалл мэдэгдлээ.

Аваргууд толгой дохив.

- Тэгвэл урагшаа! гэж Бэгмен жижүүрүүдийг хөгжилтэйгээр удирдав.

- Амжилт хүсье, Харри гэж Хагрид швнээд эргүүлүүд янз бүрийн зүгт тарж төөрдөг байшингийн эргэн тойронд өөрсдийн байраа эзлэв. Бэгмен саваагаа холойдоо хүргээд аяархан,

- Сонорус! гэлээ.

Тэгтэл түүний хүчтэй шидэт хоолой цэнгэлдэх хүрээлэн даяар нүргэлэв.

- Ноёд хатагтай нараа Гурван шидтэний тэмцээний сүүлчийн сорилт эхлэх гэж байна! Тэмцээний оролцогчид онооны дагуу орцгоох юм! Хамгийн түрүүнд ноён Седрик Диггори болон ноён Харри Поттер нар гарна. Хоёулаа Хогвартс сургуулийнх бөгөөд тус бүрдээ наян таван оноотой!

Орилж хашгирах болон алга таших чимээ шуугианд Хориотой ойн шувуу үргэн харанхуй тэнгэрт дэрхийн нисэцгээв.

- Хоёрдугаар байранд Дурмстранг сургуулийн ноён Виктор Крам наян оноотой! Гуравдугаар байранд хатагтай Шармбатоны сургуулийн Флер Делакур! гэхэд алга ташилт нүргэлэв.

Харри үзэгчдийн суудал дээр байгаа хатагтай Уизли, Билл, Рон, Гермiona нарыг харлаа. Тэд Флерт эелдэгээр алга ташив. Тэр тэдэн рүү гар даллахад хариуд нь баяртай даллав.

- Ингээд Харри болон Седрик нар шүглийн дуугаар эхлээрэй! Гурав... хоёр... нэг... гэж Бэгмен.

Тэр шүглээ огцом үлээхэд Харри, Седрик хоёр төөрдөг байшин руу ухасхийн орлоо.

Өндөр таримал бургасан хашаан дундах зам харанхуйд сүүдэртэнэ. Хашаа дэндүү өтгөн бөгөөд илбэдсэн болохоор тэднийг дотогш ормогц цэнгэлдэх хүрээлэнгийн чимээ шуугиан нам гүм болов. Тэр ч байтугай Харрид хэсэг зуур усан дор байгаа мэт санагджээ. Тэр саваагаа аваад <<Люмос!>> гэж хэлэхэд ард нь Седрик бас тэгж хэлэх нь сонсогдлоо.

Хамтдаа хориод метр яваад салаалсан замд хүрэв. Бие бие рүүгээ харлаа.

- Дараа уулзая гээд Харри зүүн тийш эргэлээ.

Седрик баруун зүг рүү эргэв.

Бэгмен ахин шүгэл үлээв. Тэгэхээр төөрдөг байшинд Крам орсон бололтой. Яарах хэрэгтэй. Сонгосон зам нь хэтэрхий хоосон санагдана. Тэр баруун тийш эргээд хурдаа нэмэн саваагаа толгой дээрээ өргөлөө. Замд урьдын адил юу ч тааралдсангүй хэвээр.

Алсад ахин Бэгмений шүглийн дуу сонсогдож бүх аваргууд төөрдөг байшинд орлоо.

Харри ийш тийшээ харав. Түүнийг хэн нэгэн түүнийг мөрдөөд байгаа юм шиг хачин сэтгэгдэл төржээ. Тэнгэр хэсэг зуурын дараа харанхуйлж төөрдөг байшинд харанхуй боллоо.

Зам хоёр тийш салаалав.

- Чиглүүл гэж тэр саваандаа шивнээд алган дээрээ тавилаа.

Саваа нэг эргэлт хийгээд зогсож баруун талд байгаа өтгөн бургас руу заалаа. Тэгэхээр тэнд хойд зүг юм бол баруун хойт зүг төөрдөг байшингийн төв байх нь. Хамгийн дээр нь гэвэл зүүн тийш эргэж баруун тийш явах анхны боломжыг олж авах байлаа.

Зам урьдын адил хоосон хэвээр үргэлжилнэ. Харри баруун тийш эргэхэд хоосон бөгөөд ямар ч саад тоггор байсангүй. Харри яагаад гэдгийг нь мэдэхгүй ч бухимдаж эхлэв. Юу ч байхгүй байх боломжгүй юм! Төөрдөг байшин түүний анхаарлыг сулруулж байгаад занганд оруулах гэж байгаа байх. Ард нь ямар нэг юм шар шурхийв. Харри саваагаа дайралтанд бэлтгэн өргөөд эргэн харлаа. Савааны гэрэлд Седрик баруун талаас гарч ирлээ.

Түүний бие чичирч ханцуйнаас нь утаа уугиж байв.

- Хагридын соплохвост байна! Аварга том! Би арай гэж няцаалаа! гэж тэр шивнэлээ.

Седрик толгой дохиод дараагийн эргэлтэн дээр алга болов. Харри гүхй шахам урагшилаа. Соплохвостоос аль болох холдсон нь дээр шүү дээ! Дараагийн эргэлтэн дээр булан тойроод хартал...

Түүний урд Дементор байв. Гурван метр шахам өндөр нүүр нь юүдэнгээр далдлагдсан бөгөөд ялзарсан гараа урагш сунгажээ. Дементор түүний ирэхийг мэдсэн бололтой шууд ирлээ. Харри түүний сөөнгөтсөн амьсгалыг сонгож хүйтэн хөлс нь дааварласан ч юу хийх ёстойгоо мэдэж байв...

Төөрдөг байшингаас гарч Рон, Гермион хоёртой ялалтаа тэмдэглэж байгаа аз жаргалтай бодолд төвлөрөөд саваагаа өргөн,

- Экспекто патронум! гэж хашгирлаа.

Савааны үзүүрээс мөнгөн буга гарч Дементорыг чиглэхэд алхам ухрахдаа жанчиндаа бүдэрлээ. Харри хэзээ ч Дементор бүдэрч байхыг хараагүй юм байна.

- Хүлээгээрэй! Энэ чинь Боггарт байна! Ридикулус! гэж патронустаа хашгирлаа.

Боггарт чанга тасхийн эргэлдээд дүрсээ өөрчлөн жижигхэн үүл болон хувирав. Мөнгөн буга харамсалтай нь замхран алга болов. Харри түүнийг үлдээгүйд харамслаа. Тийм хамтрагчтай байхаас татгалзахгүйсэн... Харри чимээ анирдан алхах зуураа саваагаа бэлхэн барьж байлаа.

Зүүн... баруун... ахиад зүүн... хоёр ч удаа мухарт туллаа. Ахиад зүг чиг олох шид хэрэглэв. Савааны үзүүр түүний хэтэрхий дорно зүгт явж байгааг заалаа. Буцаж яваад баруун тийш эргэтэл өмнөө хачирхалтай алтлаг манан байхыг харлаа. Харри түүн рүү болгоомжтой дөхөн очиход савааны гэрэл нь гийгүүлэв. Ямар нэгэн шид бололтой. Түүнийг дэлбэлж болох эсэх нь сонирхолтой?

- Редукто! гэж тэр хашгирав.

Шид мананг нэвтлэн ямар ч хөнөөл учруулсангүй. Тэр шидийг хатуу биетэд хэрэглэж болно гэдгийг мартсан байна шүү дээ! Одоо юу хийх вэ? Эсвэл зүгээр нэвтлээд гарах юм болов уу? Тийм эрсдэлд орж болох уу? Эсвэл эргээд гарц руугаа явсан нь дээр юм болов уу?

Түүний эргэлзээг холгүйхэн хашгирах чимээ эвдлээ.

- Флер! гэж Харри хашгирав.

Ахиад л нам гүм болов. Харри ийш тийшээ харлаа. Түүнд юу тохиолдсон юм бол? Дуу нь урд талд нь сонсогдсон доо. Харри гүнзгий амьсгал аваад шидэт манан руу ухасхийв.

Хөл доорх газар нь эргэлдэв. Харри газраас дүүжлэгдэн уруугаа харахад үс нь сэгсийж шил нь гуяан дээрээ дүүжлэгдэн дор нь ёроолгүй тэнгэр байв. Тэр шилээ барьж аваад хамартаа нааж айдас дүүрэн хөшлөө. Хөл нь ногоон адар дээрх өвснөөс цавуудсан мэт санагдана. Доор нь одод түгсэн тэнгэр байлаа. Нэг л алхам хийвэл газраас үүрд салах болно.

<<Бод... бод!>> гэж тэр өөртөө тушаагаад нүүрэнд цус хуралдахыг мэдэрлээ.

Гэхдээ түүнийг эргээд газарт буулгаж болох нэг ч шившлэг мэдэхгүй байв. Алхах ёстой юм болов уу? Тэр судасны цохилт лушгих чимээг сонслоо. Сонголт энгийн байлаа. Урагшаа алхах эсвэл тэнгэр лүү улаан од илгээж тэмцээнээс хасагдахыг хүсэх.

Харри хоосон зай руу харахгүйн тулд нүдээ аниад болгоомжтой баруун хөлөө ногоон адраас холдуулав.

Ертөнц хэвийн байрандаа орлоо. Харри өвдгөө тулаад гайхамшигтай хатуу чийгтэй газар дээр байгаагаа мэдэрлээ. Хэдэн удаа гүнзгий амьсгал аваад тайвширч хөл дээрээ босон яаран алтлаг манангаас гараад эргэж харахад сарны гэрэлд гэм хоргүйхэн туяарч байв.

Харри уулзвар дээр зогсож Флерийн ямар нэг ул мөр байна уу гэж харлаа. Тэр түүний хашгиралтыг сонссон гэдэгтээ итгэлтэй байв. Тэр юутай тулгарсан юм бол? Түүнд юу тохиолдсон юм бол? Энд улаан оч байхгүй ч аюулд учраагүй гэсэн үг биш дээ. Магадгүй тэр саваагаа өргөж амжаагүй юм болов уу? Харри баруун тийш эргээд түгших нь улам нэмэгдлээ. Тэгтэл үүнтэй зэрэгцэн нэг бодол гялсхийв. Нэг аварга алга алга болсон байна...

Флерийн хашгиралтаас үзэхэд тоглоомноос гарсан нь лавтай. Цом хаа нэгтээ дэргэд нь байгаа бараг л хүрээд байна. Тэр үнэхээр ялчих юм биш байгаа даа? Харри агшин зуур өөрийгөө бүх сургуулийнхны өмнө гартаа цомыг барьж нэрийг нь аваргаар зарлахыг сонслоо...

Арван хормын турш юу ч болсонгүй зөвхөн мухар гудамж байв. Хоёр ч удаа нэг газраа ирлээ. Эцэст нь үл таних замаар гүйхэд ханан дээр туссан савааны дөл чичигнэж байв.

Ахин нэг эргэлт хийгээд... соплохвосттой нүүр тулчихлаа.

Соплохвост аварга том биетэй гэсэн Седрикийн зөв байж. Тэр гурван метрийн өндөртэй агаад хилэнцийг санагдуулна. Аварга том хуяган дээр нь Харрийн савааны гэрэл гялсхийв.

- Окаменкей!

Шившлэг зузаан хуяган дээр ойход Харри арай ядан бөхийж амжив. Соплохвост хариуд нь гомдоогч руу галаар бууджээ. Үснээс нь хиншүү үнэртлээ.

- Замри! гэж Харри хашгирав. Гэвч шившлэг хуяган дээр ахин ойлоо.

Харин яаран ухраад тэнцвэрээ алдан уналаа.

- Замри!

Соплохвост түүнээс хэдхэн дюймийн зайд хөшлөө. Шившлэг хуягаар хамгаалагдаагүй зөөлөн хэсэгт тусчээ. Харри хүндээр амьсгаадан хөдөлгөөнгүй амьтныг түлхээд хар хурдаараа зугтлаа. Шившлэг түүний удаан барихгүй болохоор таван хормын дараа соплохвост ахин аюултай болж эхлэх байлаа.

Тэр зүүн тийш эргээд мухарт тулан баруун тийш эргэвэл ахин мухар байлаа. Зүрх нь түг түг цохилоход ахин дөрвөн зовхисын шившлэг хэрэглэн уулзвар луу буцаж баруун хойд зүг рүү явах өөр зам сонголоо.

Харри сонгосон замаараа таван хором хиртэй яаран явтал гэнэт хашааны цаана ямар нэгэн чимээ гарахад хөл нь газраас ургасан аятай зогслоо.

- Чи юу хийж байгаа юм бэ? Ямар чөтгөрөө хийх гэж байна? хэмээн Седрик хашгирав.

Тэгтэл Крамын хоолой гарлаа.

- Круцио!

Тэр агшинд Седрикийн өвдсөндөө орь дуу тавих чимээ сонсогдов. Харри айдаст автан Седрикийг олохын тулд урагшаа гүйлээ. Урд нь ямар ч эргэлт байсангүй. Ганц л зам үлдлээ Дэлбэлэх шившлэг. Энэ тийм ч ашигтай болоогүй ч бургасан хашааг шатааж цоорхой гарав. Харри түүнийг хүчтэй өшиглөн мөчир навчиснуудыг хугалж орж болохоор болгов. Харри нүхээр жанчаа уран гараад баруун тийш харвал газар Седрик хэвтэж Крам хажууд нь зогсож байв.

Шажигнах чимээ сонсоод Крам толгойгоо эргүүлж харснаа зугтлаа. Харри саваагаа араас нь чиглүүлээд,

- Окаменей! гэж хашгирав.

Шившлэг Крамын нуруу руу оноход нүүрээрээ газар шургачин унаад хөдөлгөөнгүй болов. Харри Седрик руу ухасхийв. Тэр татвалзахаа болиод хүндээр амьсгаадан нүүрээ алгаараа дарна.

- Чи зүгээр үү? гээд Харри гараа Седрик руу сунгав.

- Тиймээ. Итгэж ч чадахгүй нь... тэр ард гарч ирэхэд... би чимээ сонсоод эргэж хартал... над руу хэдийн саваагаа чиглүүлж байсан гэж Седрик хэллээ.

Тэр чичирсэн хэвээрээ хөл дээрээ босов.

- Итгэж ч чадахгүй байна... тэр надад дажгүй санагдсан гээд Харри Крам руу харлаа.

- Надад ч гэсэн.

- Чи Флерийн хашгирсаныг сонссон уу?

- Сонссон. Чи Крам түүнийг... гэж Седрик хэлэв.
- Мэдэхгүй гэж Харри удаанаар хэллээ.
- Түүнийг энд орхих уу?
- Үгүй дээ. Улаан оч илгээсэн нь дээр байх. Эргүүлүүд түүнийг олоод гаргаг. Тэгэхгүй бол соплохвост шатааж магад.
- Тэр үүнийг хүртэх гавъяатай гэж Седрик хэлээд саваагаа өргөж тэнгэр лүү улаан оч илгээв. Оч үүл болон хөөрөөд Крамын дээр тогтов.

Хормын турш Харри, Седрик хоёр харанхуйд зогсоод бие бие рүүгээ харлаа.

- За. Цаашаа явах уу.. гэж Седрик хэлэв.
- Юу? Аан тийм л дээ гэж Харри хэллээ.

Хачирхалтай агшин байлаа. Крам тэднийг нийлүүлсэн хэдий ч ахиад л өрсөлдөгчид болцгоов. Хоёул чимээгүй харанхуй зам дээгүүр урагшилаад уулзвар дээр Харри зүүн тийш эргэхэд, Седрик баруун тийш явлаа. Төдхөн Седрикийн хөлийн чимээ нам гүм болов.

Харри цаг үргэлж саваагаараа зүг чиг олсоор явж байлаа. Тэр одоо зөвхөн Седриктэй өрсөлдөж байгаа болохоор гэнэтхэн хэзээ ч байгаагүйгээр ялах хүсэл төрөв. Толгойд нь Крам яагаад Уучлашгүй шившлэгийг хүний эсрэг хэрэглэв гэсэн бодол орж ирэв. Грюм хичээл дээр үүнийг хэрэглэсэн хүн амьдралынхаа эцэс хүртэл Азкабанд хоригддог гэсэн. Крам тийм үнээр цомыг хожихыг хүсэж байна... Харри хурдаа нэмлээ.

Одоо цаг ямагт мухар тааралдаж төөрдөг байшингийн төвд ойртох тусам улам харанхуй болж байлаа. Урд нь ахиад хөдөлгөөн мэдрэгдэхэд савааны гэрлээ тусган харахад <<Мангасуудын тухай аймшигт ном>>-ны зурган дээрээс харж болохоор амьтан байлаа.

Энэ бол сфинкс байв. Арслан шиг том бие эмэгтэй хүний толгой бүхий хүнд хумстай сарвуутай бөгөөд урт шаргал сүүлнийхээ үзүүрт цацагтай ажээ. Харри эмэгтэй-арсланд дөхөн очиход түүн рүү хүчирхэг толгойгоо эргүүлж бүйлсний өнгөт том нүдээрээ ширтлээ. Харри шийдвэргүйхэн саваагаа өргөлөө. Гэвч арслан эмэгтэй үсрэн холдсонгүй зам хаан зогсоод гүн сөөнгө хоолойгоор ярилаа.

- Чи байндаа ойрхон байна. Товч зам энд л байгаа.
- Тэгвэл... та намайг өнгөрүүлэх үү? гэж Харри асуухдаа хариултыг нь бараг таалаа.
- Мэдээж үгүй. Миний оньсогыг таавал гарч болно. Анхны таавраар явах зам нээгдэнэ. Буруу хариулвал дайрна. Юу ч хариулахгүй бол арагшаа ухар.

Харрийн дотор зарсхийв. Гермiona таавар таахдаа сайн болохоос тэр биш. Тэр боломжоо цэгнэж үзэв. Хэрвээ оньсого хүнд бол тэр чимээгүйхэн замаас нь холдож сфинкс түүнд гай учруулалгүй цомд хүрэх өөр зам олох болно.

- За яахав. Таны тааврыг сонсоё.

Сфинкс замын голд суугаад шүлэг хэлэв.

Миний эхний үе нь бүгд зөв

Тэр хурдан гар хөлтэй

Миний хоёрдугаар үе шийдвэр рүү хөтлөнө

Түүний хэмжээ хууль ёсных

Миний гуравдугаар үз эрэгтэй хүний хийсвэр нэр

Өнгөгүй арьс, нэргүй

Тэднийг бүгд нь хамтатгавал чи амьтныг таах болно

Чи ямар амьтныг үнсэхээсээ үхэхийг илүүд үзэх вэ

Харри алмайран хараад,

- Ахиад жаахан удаан хэлж болох уу? гэж эелдэгээр гуйлаа.

Сфинкс нүдээ анивчаад нууцлагаар инээмсэглэн тааврыг давтлаа.

- Тааврын гол нь миний үнсэхийг хүсэхгүй амьтанд байгаа юм биз дээ? гэж Харри асуулаа.

Сфинкс нууцлагаар инээмсэглэв. Харри энэ баталгаатай хариулт гэж бодлоо. Үнсэхийг хүсэхгүй амьтан олон байлаа. Жишээлбэл соплохвост. Гэхдээ сфинкийн таавар өөр ямар нэг зүйлийн тухай байлаа. Эхнээс нь сонсох хэрэгтэй. Эхний мөрөнд нь түргэн гэж байсан. Түргэн, хурдан... За яахав дараа нь энэ тухай бодож болно биз.

- Э-э... дараагийн мөрийг давтаж болох уу?

Тэр давтлаа.

- Надад сүүлчийн мөрийг хэлж өгөөч?

Сфинкс давтлаа.

- Эрэгтэй хүний хийсвэр нэр... эрэгтэй, эрэгтэй... Аан! Тэр энэ байна!

Сфинкс инээмсэглэлээ.

- Тэгэхээр эхний мөр нь хурдан... хурдан... тэр хурдан гэж Харри холхих зуураа давтаад,

- Хил... нц... хил... нц... миний үнсэхийг хүсэхгүй амьтан бол хилэнц!

Сфинкс инээмсэглээд хөл дээрээ босон холдов.

- Баярлалаа! гэж Харри дуу алдаад өөрийгөө гайхан урагш явлаа.

Тэр байндаа ойрхон байна... Саваа нь түүнийг зөв замдаа явж байгааг зааж байлаа. Хэрвээ ямар нэгэн аймшигтай зүйл тааралдахгүй бол хожих болно...

Харри урагшаа гүйлээ. Хоёр тийш салсан уулзвар дээр иржээ

- Чиглүүл гэж тэр шивнээд саваагаа тавихад эргэлдэн баруун тийш заалаа. Харри баруун замаар ороход төдхөн гэрэл гялалзав.

Харри зуун ярдын зайд намхан индэр дээр Гурван шидтэний цом гялалзан байхыг харлаа. Гэнэтхэн хар дүрс түүний өмнөх зам дээгүүр ухасхийв.

Седрик цом руу түрүүлж хүрэх нь байна. Тэр хар хурдаараа цом руу гүйж байлаа. Седрик өндөр түүнээс урт хөлтэй болохоор... Харри түүнийг хэзээ ч гүйцэхгүй нь байна.

Энэ юу вэ? Тэдний гүйхтэй зэрэгцэн ямар нэгэн аварга том бутны цаагуур Седрик рүү түргэн хөдлөв. Седрик зөвхөн цом руу харж байсан болохоор түүнийг харсангүй.

- Седрик! Зүүн талд чинь! гэж Харри орилов.

Седрик эргэж хараад мангасын хамар дороос мөргөлдөхөөс бултсан ч яарсандаа бүдэрч унав. Түүний саваа нь гараас нь мулт үсрэхэд лут том аалз гарч ирээд Седрик рүү дөхөв.

- Окаменей! гэж Харри хашгирав.

Шившлэг аалзны том үслэг биеийг оносон ч зөвхөн чулуугаар цохьсон юм шиг амжилт гаргажээ. Аалз ганхсанаа Седрикийг мартаад Харрийн зүг ухасхийв.

- Окаменей! Замри!

Тус болсонгүй. Аалз хэтэрхий том болохоор шидэт хүч нь их байж шившлэг зөвхөн түүнийг уурлууллаа. Хормын зуур Харри өмнөө зургаан гялалзсан хар нүд, тас нясхийх сахлын хутга шиг хурц эрүү харлаа. Аалз түүнийг урд хөлөөрөө барьж авахыг оролдон дээшээ өргөв. Харри цөхрөн өшиглөхийг оролдсон ч хазуур хөлөнд нь шигдэн орж тэсэхийн аргагүй өвдөв.

- Окаменей! гэж Седрик хашгирсан ч түүний шившлэг хүчгүй байлаа. Аалз ахин хазуураа тас няс хийлгэхэд Харри сүүлчийн хүчээ шавхан саваагаа өргөөд,

- Экспеллиармус! гэж хашгирав.

Ажиллаа. Аалз Харригаас гурван метрийн өндөрт үсэрч дээшээ харан унав. Бодохын завдалгүй арван хормын өмнө соплохвост руу довтолсон шиг аалзны эмзэг газар руу чиглүүлэв.

- Окаменей! гэж хоёр хоолой хашгирав.

Хоёр шившлэг аалзыг хүчтэй цохиход хашаа мөргөн унаад зам дээр хөлөө атиралдуулав.

- Харри! Чи зүгээр үү! Тэр чамайг няц дарчихаагүй биз дээ? гэж Седрик асуув.

- Үгүй гэж Харри хариулаад хүндээр амьсгаадав.

Түүний хөл цус болж жанч нь аалзны хазуурт урагджээ. Харри хөл дээрээ босохыг хүссэн ч чичирсэн хөл нь биеэ даахгүй байлаа. Тэр хашаа тулан бөхийгөөд ийш тийшээ харлаа.

Гурван шидтэний тэмцээний цом Седрикийн нуруунаас хоёр алхамын зайд гялалзана.

- Цомыг ав. Түргэл. Чи дэргэд нь байна гэж Харри амьсгаадан хэллээ.

Гэвч Седрик хөдөлсөнгүй. Тэр зүгээр зогсоод Харри руу харснаа дараа нь эргэж цом руу харав. Харри түүний хэрхэн урагш алхаж тэмцээний гол шагналыг гартаа барихыг хүсч байгааг харлаа. Гэсэн ч Седрик ахин Харри эргэж хараад гүнзгий амьсгал авав.

- Үгүй ээ чи ав. Чи хожсон. Чи өнөөдөр хоёр удаа миний амьдралыг аварлаа.

- Энэ чинь тэмцээнд хамаагүй гэж Харри хэллээ. Түүний уур нь хүрч аалзтай хийсэн тэмцлийн дараа хөл нь янгинан өвдөнө. Эцсийн эцэст бүх чармайлтын дараа Седрик түүнийг ялах нь байна. Седрик Чжоуг бүжигт урьсан шүү дээ.

- Цомд хэн түрүүлж хүрсэн хүн оноо авах болно. Энэ чинийх. Би ийм хөлтэй явж чадахгүй.

Седрик цомоос холдон хэдэн алхам аалз руу урагшлаад зогсож толгойгоо сэгсэрлээ.

- Яагаад ч үгүй!

- Хүнлэг сэтгэлтэй байхаа больж үз. Цаг алдах хэрэггүй цомыг ав. Эндээс гарах хэрэгтэй байна гэж Харри уурсан хэллээ.

Седрик Харриг хашаанаас түшин хөл дээрээ зогсохыг хичээхийг харлаа.

- Чи надад лууны тухай хэлсэн. Хэрвээ чи байгаагүй бол би эхний тэмцээнд унах байсан.

- Надад бас тусалсан юм. Харин чи надад өндөгний тааварт тусалсан. Тэгэхээр бид тэнцүү гээд Харри хөлнийхөө цусыг жанчаар арчихыг хичээлээ.

- Гэхдээ надад өндөгөнд тусалсан юм.

- Тэгээд юу гэж? Бид тэнцүү л юм байна шүү дээ гэж Харри хэлээд өвчтэй хөлөөрөө болгоомжтой гишгэв. Хөл нь чичирлээ. Мэдээж тэр гурван метр хүрэлгүй унана.

- Чи хоёр дахь тэмцээнд их оноо авсан. Чи нуурын ёроолд бүх хүнийг гаргатал үлдсэн. Би бас тэгж хийх байсан гэж Седрик бууж өгсөнгүй.

- Би дуунд чухал хандсан цорын ганц тэнэг! Цомыг ав! гэж Харри гашуунаар хэллээ.

- Үгүй.

Тэр аалзны сарвайсан хөлний дэргэдүүр өнгөрөөд Харрийн дэргэд зогсож түүн рүү цоо ширтлээ. Седрик их чухал төрхтэй байв. Тэр тэнхим нь зуун жилд ч олохгүй алдар гавъяанаас татгалзаж байгаага ойлгож байв.

- Яв гэж Седрик хатуу хэлэв.

Түүний царайнаас харвал шийдвэр гаргахад амаргүй байгаа бололтой хэдий ч эргэлтгүй шийдсэн байв. Тэр чулуун царай гарган гараа энгэртээ зөрүүлэн зогсоод Харриг нүд салгахгүй ширтэнэ.

Харри Седрикээс харц салган цом руу харлаа. Нэг гайхамшигтай мөчийн дараа гартаа цом барьж гарах нь байна. Цомыг толгой дээрэ өргөхөд цугласан хүмүүс хашгиралдан Чжоугын хөөрөн бахадсан царай тодорч байгаа нь маш тод ойрхон харагдав. Дүр зураг бөхөхөд түүний байранд баргар царайтай Седрик зогсож байлаа.

- Хоёулаа явъя гэж Харри хэлэв.

- Юу?

- Хамтдаа авъя. Энэ бол зөвхөн бидний ялалт ч биш. Энэ бол Хогвартсын ялалт. Бид түүнийг хоёулаа хожлоо.

Седрик Харри руу гайхан хараад гараа буулгав.

- Чи... чи итгэлтэй байна уу?

- Тиймээ. Бид үргэлж бие биендээ тусалж байсан. Бас энд хоёулаа зэрэг ирсэн. Тийм болохоор хамтдаа авцгаая.

Хормын турш Седрик чихэндээ итгэхгүй байгаа мэт санагдсан ч түүний царайд аз жаргалтай инээмсэглэл тодров.

- Сайн байна. Явцгаая.

Тэр Харрийн тохойноос дэмнэн шагнал хүлээж байгаа индэр рүү очиход туслав. Хоёулаа гялалзсан цом руу гараа сунгалаа.

- Гурав тоолно шүү, за юу? Нэг.. хоёр... гурав! гэж Харри хэллээ.

Ингээд хамтдаа цомонд хүрлээ.

Тэр агшинд Харрид хүйснээс нь татаж байгаа юм шиг танил мэдрэмж төрөв. Хөл нь газраас хөндийрлөө. Гар нь цомонд салж болохооргүй наалджээ. Цом түүнийг хаа нэгтээ салхинд эргэлдүүлэн Седрикийн хамт нислээ.

БҮЛЭГ 32: ЯС, БИЕ, ЦУС

Харри хүчтэй газардахад гэмтсэн хөл дээрээ найган унав. Цом гараас нь мултарлаа. Харри толгойгоо өргөн харав.

- Бид хаа байна?

Седрик чимээгүйхэн толгой сэгсрэв. Тэр Харрид босоход нь туслаад хоёул ийш тийшээ харав.

Энд Хогвартсыг санагдуулах юу ч байсангүй. Шилтгээнийг тойрон хүрээлсэн уулс байхгүй байгаагаас үзэхэд зуун милийн хол зайд газардсан бололтой. Тэд харанхуй оршуулгын газар зогсоод баруун талд нь том уд модтой жижигхэн сүм байлаа. Зүүн талд толгод дээр хуучин байшин үзэгдэнэ.

Седрик Гурван шидтэний цом руу харлаа.

- Чамд хэн нэгэн үүнийг зөөвөрлөгч гэж хэлсэн үү?

- Үгүй. Энэ даалгаварын хэсэг юм болов уу? гээд Харри сониучирхан ийш тийшээ харлаа. Энд нам гүм бөгөөд аймшигтай ажээ.

- Мэдэхгүй. Саваагаа гаргацгаая гэж Седрик сэтгэл зовсон байртай хэллээ.

Харри зөвшөөрлөө. Тэр Седрик үүнийг санал болгосонд баяртай байв. Хоёул саваагаа гаргалаа. Харри эргэн тойрноо харахад ахиад л хэн нэгэн түүнийг хараад байгаа юм шиг хачирхалтай мэдрэмж төрөв.

- Хараач хэн нэгэн ирж байна гэж Седрик хэлэв.

Харанхуйд ямар нэг юм харахыг цөхрөн оролдоод булшин дундуур хүн ойртохыг хяламхийн харлаа. Тэр намхан биетэй нүүрээ юүдэнгээр далдалсан агаад гартаа хуйлаастай зүйл болгоомжтой авч явлаа. Тэдний хоорондын зай түргэн ойртоход Харри гарт нь хүүхэд байхыг харлаа... эсвэл зүгээр хувцас юм болов уу?

Харри саваагаа буулгаад Седрик рүү харахад асуунгуй байртай эргэж ширтэв. Хоёулаа өндөр гантиг булшны чулууны ёроолд зогссон жижигхэн үл таних хүн рүү харлаа. Хормын турш гурвуулаа бие биенээ ширтэв.

Тэгтэл Харрийн ерөөс хүлээгээгүй зүйл болж сорви нь дэлбэрэх шахам өвдлөө. Саваагаа унагаад нүүрэндээ гараа наан сөхөрлөө. Тэр юу ч харахгүй байсан бөгөөд зөвхөн толгой нь хагарах шахам өвдөнө.

Хаа нэгтээгээс хүйтэн хоолой гарч,

- Түүнийг ал гэлээ.

Исгэрэх чимээ гарч харанхуйд өөр хоолой,

- Авада Кедавра! гэлээ.

Харрийн зовхины өмнүүр ногоон гэрэл гялсхийхэд дэргэд нь хүнд юм унах сонсогдов. Сорви нь тэсвэрлэшгүй өвдөж авч хаявал дээрдэх юм шиг санагдана. Харри айдаст автан нүдээ нээлээ.

Дэргэд нь Седрик хэвтэж байв. Тэр үхсэн байлаа.

Харрид бүтэн зууны турш Седрикийн гайхсан царай, томоор нээгдсэн саарал нүд, хагас нээгдсэн уруул руу харах шиг санагджээ. Үнэн хэрэгтээ агшин зуур л байж юу болсныг мэдэж амжихаас урьтаж түүнийг хөл дээр нь босгов.

Жижигхэн хүн хуйлаастай зүйлээ газар тавиад шидэт саваагаа Харри руу чиглүүлэн гантиг булш руу аваачив. Дараа нь түүнийг чулуунд нуруугаар нь шахав. Харри савааны сулхан гэрэлд булшны чулуун дээр ТОМ РЕДДЛ гэсэн нэр зурсхийхийг харлаа.

Үл таних хүний саваанаас олс гарч Харриг хүзүү болон шагайгаар нь булшны чулуутай хүлэв. Юүдэн дороос түргэн амьсгал сонсогдоно. Харри эсэргүүцэхийг оролдсон ч жижигхэн хүн түүнийг нударгаараа цохиход нэг хуруу нь байхгүй байхыг ажиглалаа. Тэгэхээр түүн рүү хөгшин Сүүлт дайрсан байх нь.

- Чи! гэж Харри дуу алдав.

Сүүлт юу ч хариулсангүй. Тэр олсыг илбэдэж дуусаад чичирсэн гараараа зангилааг шалгав. Харрийн гараа хөдөлгөж чадахгүйг шалгаж үзээд жанчин дотроосоо хар алчуур гаргаж олзлогдогчын аманд чихлээ. Тэгээд нэг ч үг хэлэлгүй араар нь тойрон далд оров. Харри толгойгоо эргүүлж чадахгүй учир юу болсныг харж чадсангүй.

Арван алхамын зайд Седрикийн бие байв. Цаахан талд нь ододын гэрэлд Гурван шидтэний цом гялалзана. Харрийн саваа Седрикийн хөлд байлаа. Харрийн хүүхэд гэж бодсон жанчаар ороосон хуйлаастай зүйл булшны дэргэд байв. Түүн дотор хэн нэгэн байгаа бололтой хөдөллөө. Харри түүн рүү хартал сорви нь ахин халуу шатан өвдлөө... тэр гэнэтхэн жанчин дор байгаа зүйлийг харахыг хүсэхгүй... Сүүлт түүнийг нээхийг хүсэхгүй байгааг ойлгов.

Хөл дор нь чимээ гарлаа. Харри доошоо хартал аврага могой булшыг тойрон гулсаж байв. Ахиад Сүүлтийн түргэн амьсгаадах чимээ сонсогдов. Тэр ямар нэгэн хүнд юм зөөж байгаа бололтой. Тэр ахин гарч ирэхдээ дүүрэн устай чулуун тогоо авч ирэв. Тогоо дотор нь том биетэй эрэгтэй хүн багтчихмаар аварга том байлаа.

Газар хэвтэж байсан хуйлаас улам хүчтэй хөдлөв. Түүн дотор байгаа амьтан гадагш чөлөөлөгдөн гарах гэж байгаа бололтой. Сүүлт шидэт саваагаа тогооны ёроол руу сунгаад гал тас нясхийн асаав. Могой яаран харанхуй руу холдов.

Тогоонд дахь шингэн түргэн халав. Таван хором ч өнгөрөөгүй байтал буцалж дээшээ улаан оч цацалж байлаа. Сүүлт галыг өрдөхөд уур улам өтгөрөв. Хэн нэгэн хуйлааснаас гарахыг тэмцэн зүтгэв. Тэгтэл Харри ахин хүйтэн хоолой сонслоо.

- Түргэл!

Буцалж байгаа шингэний гадаргуу алмаазаар сийлсэн мэт очтон гялалзана.

- Бүгд бэлэн, эзэнтээн.

- Одоо... гэх хүйтэн хоолой сонсогдов.

Сүүлт хуйлаасыг газар дэлгэн дотор нь байсан зүйлийг гаргахад Харрийн цээжнээс гайхсан дуу гарав.

Сүүлт чулуунд бүдчин хуйлаасыг дэлгээд өтнөөс ч мянга дахин дор зэвүүн муухай зүйл гаргаж ирэв. Сүүлтийн оршуулгын газар авчирсан зүйл атийсан жаахан хүүхдийг санагдуулав. Гэхдээ тэр хүний хүүхэдтэй адилгүй байлаа. Үсгүй хайрстай түүхий мах шиг улаан бие, сул дорой нарийхан гар хөл, нүүр нь могойнх шиг агаад гялалзсан улаан нүдтэй ажээ.

Амьтан арчаагүй юм шиг санагдлаа. Тэр гараа сунган Сүүлтийн хүзүүгээр тэвэрлээ. Энэ агшинд юүдэн түүний толгойноос унаж Харри цайвар жигшүүртэй царай олж харав. Сүүлт тогооны ирмэгт ирэх агшинд Харри оргилон буцалж байгаа шингэний гадарга дээр муу ёрын царай тусахыг харлаа. Сүүлт амьтныг тогоонд хийхэд исгэрснээ алга болов. Харри бие хэрхэн чулуун тогооны ёроолд зөөлөн унахыг сонслоо.

Живчихлээ гэж Харрийн толгойд орж ирэв. Сорви нь тэсэхийн аргагүй өвдлөө... Гуйя... живчихсэн.

Тэгтэл Сүүлт ярьж эхлэхэд хоолой нь чичирч байлаа. Тэр саваагаа өргөөд нүдээ анин хүндээр,

- Эцгийн яс хүүг төрүүлнэ!

Харри айдаст автан хөл нь хальтирхад тоос боссон агаарт Сүүлтийн үг намдахыг сонсов. Усны гялалзсан гадаргуу өөрчлөгдөн шингэн хортой цэнхэр болгов.

Тэгтэл Сүүлтийн гонгинох чимээ гарав. Тэр жанчин дороосоо урт нарийхан мөнгөн чичлүүр хутга гаргаж ирээд ахин ярьж эхлэхдээ айсандаа түгдчиж байв.

- Зарцын... бие... сайн дураараа өгч байгаа... эзнээ сэргээнэ!

Тэр хуруугүй мухар баруун гараа сунгаад хутга барьсан гараа дээш өргөлөө.

Харри юу болох гэж байгааг ойлгоод нүдээ анилаа. Гэхдээ чих нь зүрх зүсэм орилохыг сонсохгүй байж чадсангүй. Түүнийг бас хутгаар дүрсэн мэт санагджээ. Ямар нэгэн юм газар уналаа. Сүүлт зовж тарчилсаар шингэн цалгиулан тогоо руу юм хийв.

Харри нүдээ нээж чадаагүй ч.. уусмал час улаан өнгөтэй болохыг зовхио нэвт харлаа.

Сүүлт өвдсөндөө орь дуу тавив. Харри гэнэтхэн нүүрнийхээ урд халуун амьсгал мэдрээд Сүүлт түүн рүү ирснийг ойлгов.

- Дайсны цус... албадан авсан... чиний дайсныг сэргээнэ!

Харри хэтэрхий чанга хүлэгдсэн учир эсэргүүцэж чадсангүй. Нүдээ сөлийлгөн уяа руугаа харж мултрахыг хичээхдээ Сүүлтийн гарт гялалзсан мөнгөн хутга чичрэхийг харлаа. Хурц үзүүр жанчыг нь урж тохойны арьсыг нэвтлэхэд цус урсав. Сүүлт өвдсөндөө гонгиносоор халааснаасаа шилэн сав гаргаж Харрийн шархан дээр барихад түргэн дүүрэв.

Сүүлт тогоо руу эргэн явж цусыг хийлээ. Шингэн агшин зуур нүд гялбам тунгалаг цагаан өнгөтэй болов. Уусмалаа бэлдэж дуусаад Сүүлтийн хүч барагдаж өвдөг дээрээ унаад цус алдаж байгаа гараа барьж цурхиран уйлав.

Тогоо оргилон буцлахад гялтагнасан очис зүг бүр нисэж эргэн тойрноо гийгүүлэв. Юу ч болсонгүй...

Живж үхсэн, алдаа болсон гэж Харри гуйлаа.

Тэгтэл гэнэтхэн цацарч байсан очис унтарлаа. Цагаан уур олгойдон Харриг бүрхэхэд Сүүлт, Седрик нарыг харахаа болив.

<<Уусмал болоогүй... гуйя живсэн... тэр үхсэн>>

Гэвч манан дундуур тогооноос өндөр туранхай араг яс шиг хүн удаанаар цухуйхад Харри үхтэлээ айлаа.

- Намайг хувцасла гэж тэр дотор зарсхийм хүйтэн хоолойгоор хэлэв.

Сүүлт шархтай гараа цээжиндээ тэвэрсээр арайхийн хөл дээрээ босож газар дээрээс юүдэнтэй жанч аваад нэг гараараа эзнийхээ толгой дээгүүр нөмөргөлөө.

Амьд араг яс тогооноос газар буухдаа Харригаас нүд салгасангүй. Харри үхлийн цонхигор царайнаас зугтаж чадсангүй. Гурван жилийн өмнө хар дарсан зүүдэнд нь энхүү цусан улаан нүд, могойны хамар...

Лорд Волан-де-Морт ахин төржээ.

БҮЛЭГ 33: ҮХЭЛ ЗАЛГИГЧИД

Волан-де-Морт цаашаа эргэж хараад өөрийнхөө биеийг шалгалаа. Түүний гар том цагаан аалзыг санагдуулах агаад урт цагаан хуруунуудаараа цээж, гар, нүүрээ энхрийлэн барьж үзэв. Харанхуйд улаан хүүхэн хараа нь муурынх шиг гялалзана. Тэр хуруунуудаа атийлган тоолоход нүүрэнд нь аз жаргалтай өнгө тодров. Тэр газар цус алдан татвалзан хэвтэж байгаа Сүүлтэд огтхон ч анхаарал хандуулсангүй. Аварга могой ахин гулсан ирээд булшыг ороон исгэрлээ. Волан-де-Морт урт хуруугаа халаасныхаа гүн рүү хийн шидэт саваагаа гаргаж ирлээ. Түүнийгээ энхрийлэн илбээд газар уйлагнан хэвтэж байгаа Сүүлт рүү занган уяатай байгаа Харрийн зүг чулуудлаа. Сүүлт атийгаад гонгинов. Волан-де-Морт улаан нүдээ өргөн Харриг хараад дотор арзайм хүйтнээр инээв.

Сүүлт мухар гараа цусанд бядсан жанчаар ороожээ.

- Эзэнтээн... эзэнтээн... та амалсан... та амалсан биз дээ гэж тэр хахаж цацан дуугарлаа.

- Гараа сунга гэж Волан-де-Морт залхуутайгаар хэлэв.

- Эзэнтээн... баярлалаа, эзэнтээн...

Сүүлт цусанд будагдсан гараа сунгалаа.

- Нөгөө гараа Сүүлтээ гээд Волан-де-Морт ахин инээв.

- Эзэнтээн, гуйя... гуйя...

Волан-де-Морт үнэнч зарц луугаа бөхийгөөд зүүн гарыг нь авч огцом хөдөлгөөнөөр ханцуйг нь уран тохойг нь гаргаж ирлээ. Харри арьсан дээр тод улаан шивээс байхыг хараад Дэлхийн цомын тэмцээн дээр тэнгэрт илгээгдсэн амнаасаа могой цухуйлгасан гавал бүхий Хар тамга байхыг танилаа. Волан-де-Морт анхааралтай тэмдэг рүү харахад Сүүлт аяархан цурхирлаа.

- Тэр ахиад энд байна. Тэд түүнийг ажигласан... одоо харцгаа... одоо бүгд мэдэх боллоо гэж тэр аяархан хэлэв.

Тэр урт нарийхан хуруугаараа Сүүлтийн тамган дээр дарлаа.

Харрийн сорви халуу шатан өвдөж Сүүлт чих дөжиртөл орилов. Волан-де-Морт гараа холдуулах үед тамга тас хар өнгөтэй болсон байв. Волан-де-Мортын царайд сэтгэл хангалуун байдал илэрч цэхлэн зогсоод харанхуй оршуулгын газар руу харав.

- Тэд одоохон түүнийг харах болно. Хичнээн зоригтой нь энд ирэх бол? Харин хэдэн тэнэг нь ирэхээс айх бол? гэж шивнээд гялалзсан улаан нүдээрээ ододын зүг харлаа.

Тэр Сүүлтийн өмнө урагш хойш холхин харанхуй оршуулгын газар луу харж байлаа. Хормын дараа ахин Харри руу хараад зогсоход могойтой адил царайнд нь хэрцгий инээмсэглэл тодорлоо.

- Харри Поттер чи миний талийгаач эцгийн чулууны урд зогсож байна. Тэр бол тэнэг магл байсан... яг л чиний үнэт ээж шиг. Гэхдээ тэд хоёулаа авах ёстой зүйлээ

хүртсэн. Чиний ээж чинь хүүгээ хамгаалах гээд үхсэн... харин эцгийнхээ хувьд би өөрөө алсан. Гэхдээ тэр надад үхсэнийхээ дараа ч хэрэг болсон доо...

Волан-де-Морт ахин хөхрөөд оршуулгын газар дундуур холхиход могой чимээгүйхэн гулсаж түүний дэргэд очлоо.

- Толгод дээр байгаа байшинг харж байна уу, Поттер? Тэнд миний эцэг амьдардаг байсан юм. Ээж шидтэн бөгөөд доор тосгонд амьдардаг байлаа. Тэр түүнд хайртай байсан. Тэгээд түүнд шидтэн гэдгээ хэлсэн юм. Аав шидийг тэвчиж чаддаггүй байсан.

- Тэр түүнийг хаяж магл эцэг эх рүүгээ очсон, Поттер. Харин ээж минь намайг өнчин хүүхдийн газар төрүүлээд үхсэн. Би тэнд өсөөд түүнийг хайж олно гэж тангарагласан. Би түүнээс эртний тэнэг нэрийг нь өвлөж авсан... Том Реддл...

Тэр оршуулгын газар луу харан холхисон хэвээр.

- Би гэр бүлийнхээ түүхийг ярьж байна гэж бодоод үз дээ. Би уяхан сэтгэлтэй болж байгаа бололтой... Хар, Харри! Волан-де-Мортын жинхэнэ гэр бүл энд байна. Тэд эргэн ирцгээж байна...

Шөнийн нам гүмийг жанч шар шурхийх чимээ эвдэв. Оршуулгын газрын дундах том уд модны сүүдэрт шилжиж ирсэн шидтэний сүүдэрүүд бий болов. Тэд бүгд багтай бөгөөд толгойдоо юүдэн углажээ. Тэд нүдэндээ итгэхгүй байгаа мэт удаанаар ойртон ирлээ. Волан-де-Морт тэднийг чимээгүйхэн хүлээв. Нэг Үхэл залгигч өвдөг дээрээ сөхрөн Волан-де-Морт руу мөлхөж хар жанчыг нь үнсэв.

- Эзэнтээн... эзэнтээн гэж тэр бувтналаа.

Үхэл залгигчид нэг нэгнийхээ араас өвдөг дээрээ унаж Волан-де-Морт руу мөлхөн жанчыг нь үнсээд чимээгүйхэн холдож байлаа. Том Реддлийн булш, Харри, Волан-де-Морт, газар атиралдан хэвтэх Сүүлт нарыг тойрон багахан цагариг үүсэв. Цагаригт зарим газар хоосон байх нь зарим хүнийг хүлээж байгаа бололтой. Харин Волан-де-Морт үүнээс илүүг хүлээсэнгүй. Тэр багтай царайнуудыг эргэж харахад бүгд давхийлээ.

- Тавтай морилоорой, Үхэл залгигчидаа. Арван гурван жил... бидний сүүлд уузсанаас хойш арван гурван жил өнгөрчээ. Бүгд миний энэ үдшийн дуудлаганд хүрч ирлээ. Тэгэхээр Хар тамга өмнөхийн адил хүчинтэй байна уу? Эсвэл үгүй юм болов уу? гэж тэр аяархан хэлэв.

Волан-де-Морт ахин тэнгэр лүү хараад нүхэн хамраа сарталзуулан амьсгалав.

- Би гэм буруу үнэрлэж байна. Агаарт гэм бурууны өмхий үнэр ханхалж байна гэж тэр гэнэтхэн хэлэв.

Ирэгсэд ахин цочсон ч хэн ч хойш ухарч зүрхэлсэнгүй.

- Би та нарын эрүүл амьд байгааг харж байна. Та нарын хүч чадал алдагдаагүй агшин зуур шилжин хүрч ирлээ! Ингээд би өөрөөсөө яагаад энэ шидтэнгүүд урьд нь үнэнч байхыг андгайлсан эзэндээ туслахаар ирсэнгүй вэ гэсэн асуулт тавихад хүрч байна?

Хэн ч юу ч хэлсэнгүй. Хэрвээ газар мэгшин хэвтэх Сүүлтийг эс тооцвол хэн ч хөдөлсөнгүй.

- Ингээд би өөртөө хариулъя. Бүх юм энгийн та нар намайг үхсэн гэж итгэсэн. Ингээд дайсныхаа талд буцаж орсон. Тэдэнд өөрийгөө гэм буруугүй гэж андгайлж шившлэгийн үйлчлэл дор юу хийж байгаагаа мэдээгүй гэж хэлсэн...

- Ингээд би өөрөөсөө тэд намайг ахин сэргэхгүй гэж яаж итгэсэн юм бол гэж асууж байна. Тэд ямар хүчтэй шидээр үхлээс хамгаалагдсан болохыг минь мэднэ. Өөрсдийнхөө нүдээр миний хүч чадал хязгааргүй бөгөөд дэлхий дээрх хамгийн хүчирхэг шидтэн гэдгийг харсан.

- Хариулт энгийн байна. Магадгүй тэд Лорд Волан-де-Мортыг ч дийлэх хүчирхэг шидтэн байдаг гэж итгэсэн байж болох юм... Магадгүй тэд өөр хүнд үнэнч байна гэж тангарласан байх... бохир цустангууд болон эгэлчүүд, маглуудыг хамгаалагч Альбус Дамблдор? хэмээн Волан-де-Морт исгэрлээ.

Дамблдорын нэрийг сонсоод тойрог хөдөлж толгой сэгсрэн өөр хоорондоо шивнэлдлээ.

Волан-де-Морт тэднийг үл тоомсорлов.

- Би урам хугарч байна... би маш их урам хугарч байна...

Нэг үхэл залгигч гэнэтхэн урагш алхаж хөлөөсөө толгой хүртлээ чичирсээр Волан-де-Морт-ын өмнө сөгдлөө.

- Эзэнтээн! Эзэнтээн, намайг өршөө! Биднийг бүгдийг өршөө!

Волан-де-Морт хөхрөөд саваагаа өргөн,

- Круцио! гэв.

Үхэл залгигч газар тарчлан өнхөрч өвдсөндөө чих дөжрөм хашгирлаа. <<Энэ хашгиралт тосгонд сонсогддоггүй юм байхдаа>> гэж Харри бодлоо. Ямар нэгэн цагдаа ч юмуу... хэн нэгэн... ямар нэгэн...

Волан-де-Морт ахин саваагаа өргөлөө. Үхэл залгигч чимээгүй болж нуруугаараа хэвтэн хүндээр амьсгаадна.

- Бос, Эйвери. Бос. Чи надаас өршөөл гуйна гэнээ? Гэхдээ би өршөөхгүй. Хэнийг ч өршөөхгүй. Би бүгдийг санаж байна... Урт удаан арван гурван жил... Та нар арван гурван жилийг төлсөн үед би өршөөж болох юм... Сүүлт хэдийн өрөө төлсөн тийм биз дээ? гээд газар хэвтэж байгаа Сүүлт рүү харлаа.

- Чи үнэнч шударгаа батлах гэж эргэж ирээгүй. Чи хуучин найзуудаасаа айсан учир эргэж ирсэн. Чи өвдөлтийг хүртэх гавъяатай. Чи миний зөв гэдгийг мэдэж байгаа.

- Тиймээ, эзэнтээн. Гуйя... гэж Сүүлт дуу алдан ёолов.

- Гэхдээ чи намайг ахин биеэ олоход тусалсан. Ямар ч ашиггүй хулчгар амьтан чи надад тусалсан... Лорд Волан-де-Морт үргэлж түүнд тусалсан хүмүүсийг шагнадаг юм гэж тэр хүйтнээр хэлээд цурхиран уйлж байгаа Сүүлтийг харлаа.

Хар лорд саваагаа өргөн даллав. Агаарт хайлмал мөнгөн тууз бий болов. Ахин нэг хормын дараа тэр хүний бугуй болон хувирлаа. Сарны гэрэлд бугуй гялалзсаар доошлон Сүүлтийн цустай бугуйнд залгагдлаа.

Цурхиралт агшин зуур намдав. Сүүлт хүндээр амьсгаадсаар мөнгөн бугуйгаа өргөн гайхан харахад гялалзсан бээлий өмссөн юм шиг санагдана. Тэр мөнгөн хуруугаа тэнийлгэж үзээд чичирсээр газраас жижиг мөчир авч хугалав.

- Миний эзэн... эзэнтээн... тэр сайхан юм байна... баярлалаа... баярлалаа...

Сүүлт өвдөг дээрээ мөлхөн Волан-де-Мортын жанчны хормойг үнслээ.

- Чиний үнэнч байдал хэзээ ч гуйвах ёсгүй, Сүүлтээ гэж Волан-де-Морт шаардангуй хэлэв.

- Тангарлая эзэнтээн... гуйвашгүй эзэнтээн...

Сүүлт босож Үхэл залгигчдын эгнээнд орлоо. Тэр гайхаж бахадсан харцаар хүчирхэг шинэ гараа харахад нүүрэнд нь хатаж амжаагүй нулимс гялтагнана. Волан-де-Морт түүний баруун талд зогсож байгаа Үхэл залгигч руу ойртов.

- Люциус, миний гулгамтай найз минь. Надад чамайг шударга журамтай болсон хэдий ч хуучин замаасаа гараагүй гэж хэлсэн. Чи өмнөхийн адил маглуудын эсрэг багийг толгойлсоор байгаа биз дээ? Гэхдээ чи намайг эрж олохыг хичээгээгүй, Люциус... Чиний Дэлхийн цомын тэмцээн дээр хийсэн үзүүлбэр намайг хөгжөөснийг хэлэх ёстой... Гэхдээ өөрийн эрч хүчээ арай ухаалгаар эзэндээ туслахад зарцуулж болсонгүй юу?

- Эзэнтээн, би үргэлж тэмцэлд бэлхэн байсан. Би таны эргэж ирсний шинж тэмдгийг мэдэнгүүтээ агшин зуур тань дээр эргэн ирлээ гэх Люциус Малфойн дуу юүдэн дороос сонсогдов.

- Гэхдээ чи миний үнэнч зарц Үхэл залгигчын илгээсэн Хар тамгыг хараад өнгөрсөн зун зугтаасан. Надад бүгд ойлгомжтой байна, Люциус... Чи миний урмыг хугаллаа... Ирээдүйд би чамаас илүү үнэнч хүлээж байна гэж Волан-де-Морт залхуутай хэлэхэв.

- Тэгэлгүй яахав, эзэнтээн... Таны энэрэл хязгааргүй билээ, баярлалаа таньд эзэнтээн...

Волан-де-Морт цааш хөдлөөд Малфойн дэргэдэх хоёр хүн зогсож болохоор хоосон газар зогслоо.

- Энд эхнэр, нөхөр Лестрейнж зогсох ёстой байсан. Гэхдээ тэд Азкабанд булшлагдсан. Тэд надад үнэнч байсан. Намайг орхилгүй Азкабан руу явсан. Азкабаны ханыг нураах үед тэднийг зүүдэндээ ч үзээгүй шагнал хүлээж байх болно. Дементорууд бидэнтэй нэгдэнэ... тэд манай холбоотон болно... бас цөлөгдсөн аварга биетүүдийг эргэж дуудна... миний үнэнч зарц нар эргэн ирж бүхэл бүтэн арми айдас төрүүлэх болно...

Тэр ахин тойрон явлаа. Зарим Үхэл залгигчдыг чимээгүй өнгөрч заримынх нь өмнө зогсон ярилцаж байв.

- Макнейр... Сүүлт чамайг ид шидийн яамны аюултай амьтдыг устгах хэлтсийн даалгавар биелүүлж байгаа гэсэн үү? Чамд удахгүй илүү дээр золиос олж өгнө, Макнейр. Лорд Волан-де-Морт үүнд чинь санаа тавих болно...

- Баярлалаа, эзэнтээн... баярлалаа гэж Макнейр буюу тавиналаа.

- Харин Крэбб. Чи энэ удаад сайн ажилласан биз, Крэбб? Бас Гойл? гээд Волан-де-Морт хоёр том юүдэнтэй дүрс рүү дөхөн очлоо.

Хоёулаа эв хавгүйхэн бөхийлөө.

- Тиймээ, эзэнтээн.

- Тэгэлгүй яахав, эзэнтээн...

- Чамд ч гэсэн хамаатай Нотт гээд Волан-де-Морт ноён Гойлын сүүдэрт зогсож байсан хүн рүү хандлаа.

- Эзэнтээн би таньд урьдын адил үнэнч хэвээрээ...

- Хангалттай гэж Волан-де-Морт толгой дохилоо.

Тэр хамгийн том зайд зогсоод хоосон газрыг улаан нүдээрээ хүмүүсээр хүрээлүүлсэн мэт харав.

- Энд зургаан Үхэл идэгч зогсож байх байсан... Гурван зарц минь үхсэн. Нэг нь эргэж ирэхээс хулчийсан... тэр үүндээ харамсах болно. Нэг нь үргэлж намайг алах тухай боддог... Ингээд хамгийн сүүлчийн үнэн зарц минь тэр үргэлж надад үнэнч зүтгэж байсан.

Үхэл залгигчид шивнэлдлээ. Харри тэдний баган дундаасаа бие биесээ ширтэхийг харлаа.

- Үнэнч зарц минь одоо Хогвартет байгаа. Түүнд бидэн рүү залуу найзыг минь илгээсэнд талархах ёстой... Тиймээ гээд Волан-де-Морт уруулгүй ам ёжтой мушийхад олон арван нүд Харри руу харлаа.

- Харри Поттер сонирхолтойгоор бидэнтэй нэгдэж миний эргэн төрснийг тэмдэглэх гэж байна. Түүнийг хүндэт зочин гэж нэрлэж ч болох юм.

Нам гүм болов. Сүүлтийн баруун талд зогсож байсан Үхэл залгигч урагш алхахад баган дороос Люциус Малфойн хоолой гарав.

- Эзэнтээн бидэнд хэлээч... та яаж энэ бүхнийг хийж чадав... ямар гайхамшигаар... яаж бидэндээ эргэн ирэв ээ!

- Өө, Люциус минь. Энэ бол гайхалтай түүх байгаа юм. Түүний төгсгөлийг би залуу найзаараа хийх болно.

Тэр яаралгүйхэн Харри руу ирж дэргэд нь зогслоо. Одоо бүгдийн харц тэр хоёр луу чиглэжээ. Могой цагаригт гулсан хүрч ирлээ.

- Та нар миний уналтын шалтгааныг мэдмээр байна уу? гэж Волан-де-Морт аяархан асуулаа. Түүний улаан нүд Харриг өрөмдөн харахад сорви нь хүчтэй хатгуулан өвдсөн учир арай л хашгирчихсангүй тэслээ.

- Та нар намайг тэр шөнө би түүнийг алахыг оролдоод хүчээ алдсаныг мэднэ. Поттерыг үхсэн эх нь аварсан юм. Тэр үхэхийнхээ өмнө хамгаалалт үлдээснийг би мэдээгүй... Би түүнд хүрч чадахгүй байж.

Волан-де-Морт урт нарийхан хуруугаа сунган Харрийн хацарт хүргэлээ.

- Түүний ээж нь хүүгийнхөө төлөө амиа өгсөн... Энэ бол маш эртний шид хэдий ч би түүнийг санаж байна. Хамгийн тэнэг нь би мартсан байлаа. Гэхдээ энэ чухал биш би одоо түүнд хүрч чадаж байна.

Харри урт нарийхан хүйтэн хуруу хүрэхийг мэдэртэл толгой нь өвдсөндөө арай салаад уначихсангүй. Волан-де-Морт чих рүү нь аяархан инээж хуруугаа аваад яриагаа үргэлжлүүлэв.

- Найзууд минь би тэгэхэд буруу тооцоолсон гэдгээ хүлээж байна. Тэнэг эхээс нь болж хараал буцаж ойн намайг цохьсон. Ө-ө... энэ бол жинхэнэ өвдөлт байсан найзууд минь. Би түүнд бэлэн биш байлаа. Миний бие ухаан санаа орхигдон хий үзэгдэл болсон ч... гэхдээ би амьд хэвээр үлдсэн... Би хэн болсоноо өөрөө ч мэдэхгүй байлаа... Би үхэшгүй мөнхийн болох янз бүрийн арга туршиж үзсэн. Та нар миний үхлийг ялах мөрөөдлийг мэднэ. Миний туршилтуудын аль нэгэн ажилласан бололтой. Яагаад гэвэл эргэж туссан хараал намайг алаагүй. Гэхдээ би хүчгүй сул дорой биет болж өөртөө ч тусалж чадахааргүй болсон... надад бие байхгүй болохоор шидэт саваа ч ашиглаж чадахгүй байлаа...

- Тэр үеийг санаж байна би хормоос хоромд унтах нойргүй аж төрж байлаа... Би ойн гүнд нуугдан хүлээсэн... Би үнэнч найзуудын хэн нэг ирнэ гэдэгт итгэлтэй байсан. Үхэл залгигчид намайг хайж олно гэж бодож байлаа... Тэднийг дуудах шидийг би ашиглаж чадахгүй болсон байсан... Гэвч би үр дүнгүй хүлээсээр...

Үхэл залгигчдын тойрог ахин чичирлээ. Волан-де-Морт чимээгүй болсноо илүү аймшигтайгаар үргэлжлүүлэв.

- Надад зөвхөн нэг арга үлдсэн. Би өөр хэн нэгний биеийг ашиглаж болох байлаа. Гэхдээ би олон хүмүүстэй газар ойртож зүрхлээгүй. Би мракоборецууд намайг хайсаар байгаа гэдгийг мэдэж байсан. Заримдаа би амьтны биеийг ашиглан могой болж байсан ч энэ нь зөвхөн амьтны бие байсан болохоор шидэд муу зохицож байлаа. Би ашиглаад амьдралыг нь дуусгаж байлаа.

- Дөрвөн жилийн дараа миний зовлон төгсгөл болсон. Над руу ойн гүн рүү залуухан тэнэг шидтэн ирсэн. Эцэст нь надад мөрөөдөж байгаагүй аз таарах нь тэр. Тэр Дамблдорын сургуулийн багш байлаа. Түүнийг өөртөө элсүүлэх их амархан байлаа. Тэр намайг буцаан аваачихад би түргэн түүний биеийг эзэмдсэн юм. Түүнд ойрхон байж миний тушаалыг яаж биелүүлэхийг нь хянаж байлаа. Гэвч миний төлөвлөгөө нурсан. Би гүн ухааны чулууг авч чадаагүй. Мөнхийн амьдралтай болж чадаагүй. Би ахиад хожигдсон. Ахиад л Харри Поттерт талархлаа...

Мөчийн төдийд чимээгүй боллоо. Хэн ч хөдөлж навчис хүртэл сэржигнэсэнгүй. Багтай Үхэл залгигчид хөдөлгөөнгүй зогссод Харри болон Волан-де-Морт-ыг нүд салгалгүй харна.

- Би зарцынхаа биеийг алдсан тэр үхсэн. Ингээд би ахиад л хүн биш хий үзэгдэл ч биш болсон. Би нууц газраа эргэн ирээд үнэнийг хэлэхэд хүч чадлаа олж чадна гэдэгтээ эргэлзсэн. Тиймээ, энэ бол хамгийн хүнд үе байлаа. Гэвч би ахин нэг аз ирнэ гэж найдсан. Үхэл залгигчдаас тусламж ирнэ хүлээгээгүй.

Ганц хоёр шидтэн хавчганан хөдлөхөд Волан-де-Морт анхаарал хандуулсангүй.

- Гэнэт жилийн дараа итгэмээргүй явдал болсон. Надад хуучин зарц минь эргэж ирсэн... Сүүлт. Арван гурван жилийн өмнө тэр хуурамчаар үхсэн ч найзууд нь байсан хүмүүс түүнийг устгах вий гэсэндээ эзэндээ эргэж ирэхийг илүүд үзжээ. Тэр намайг байгаа гэж цуу яриа тарсан газраар удаан эрсэн байлаа. Мэдээж түүнд харх болон хувирсан явдал нь тусалсан. Сүүлт хархтай холбоотой байх дуртай. Түүний жижигхэн бохир найз нь Албанийн ойн гүнд жижигхэн амьтан л хүрч чадах газар хайгаад сүүдэртэй тулсан. Сүүлт намайг энэ гэдгийг шууд ойлгосон байна.

- Гэхдээ түүний замд таагүй явдал тохиолджээ. Тэр нэг шөнө өлссөндөө ойн захад дэн буудлын дэргэд ямар нэг хоол хайхаар зогсчээ.... Ингээд ид шидийн яамны Берта Жоркинстэй тааралдсан байна.

- Харин одоо хувьд заяа Волан-де-Мортыг хэрхэн ивээснийг харцгаа. Энэ Сүүлтийн төгсгөл байсан байж болох ч миний сэргэх сүүлчийн найдлага байсан юм. Гэхдээ Сүүлт Берта Жоркинстой ярилцан түүнтэй зугаалъя гэж итгүүлсэн. Тэр түүнийг дийлээд над руу авчирсан юм. Берта Жоркинс надад тэнгэрээс илгээсэн бэлэг байлаа... жаахан ятгахад л... үнэтэй мэдээлэл өгсөн.

- Тэр надад Хогвартсд удахгүй Гурван шидтэний шидтэний тэмцээн болно гэж хэлсэн. Мөн миний үнэнч Үхэл залгигч надад туслахыг хүсэн холбоо тогтоохыг хичээж байгаа талаар мэдэж байсан. Тэр надад олон зүйлийг ярьсан. Би түүний ой ухаан өөрчлөх хүчирхэг шидийг эвдэн урьд нь хэн нэгний өөрчилсөн бүх мэдээллийг гаргаж авсан. Би түүний биеийг ашиглаж чадахгүй болохоор ангижирсан.

Волан-де-Морт аймшигтай инээмсэглэл тодроход улаан нүдэнд нь харуусал өчүүхэн төдий ч байхгүй байв.

- Сүүлтийн биеийг би ашиглаж чадахгүй түүний гарч ирэлт хэтэрхий олон асуудал дагуулах байсан. Гэхдээ тэр надад зарцын хувьд хэрэгтэй байсан ч тааруухан шидтэн байлаа. Сүүлт миний зааврыг даган хагас биеэ олоход туслаагүй бол ахин төрөх боломжгүй байлаа. Миний зохион бүтээсэн хоёр шившлэгт... Нагайна бага зэрэг тус болсон гээд Волан-де-Морт хажуудаа байгаа могой руу харлаа.

- Уусмалд ганц эвэртийн цус, Нагайнагын өгсөн могойн хор... ингээд би бараг хүний хэлбэртэй болж ямар ч аялалыг дааж чадахаар боллоо.

- Гүн ухааны чулууг хулгайлах талаар мартаж хэрэгтэй болсон. Дамблдор түүнийг устгасан гэдгийг би мэдэж байсан. Гэхдээ надад ердийн бие биш үхэшгүй мөнхийн бие хэрэгтэй байлаа... Ингээд би хуучин биендээ ахин хувилж урьдын хүч чадлаа олох зорилго тавьсан.

- Би үүнд яаж хүрэхийг мэдэж байсан. Эртний хар шидийн шившлэг намайг ахин эргүүлэн авчирлаа. Түүнд гурван хүчтэй шидэт орц ордог. Тэдний нэг болох Сүүлтийн гар хэдийн болсон. Зарцын сайн дураараа өгсөн бие...

- Эцгийн ясыг амархан олсон тэр энд оршуулагдсан байсан. Гэхдээ дайсны цус... Сүүлт цусыг намайг үзэн яддаг дурын шидтэнгээс авч болох байсан... Намайг хичнээн олон хүн үзэн яддаг билээ. Гэхдээ би хэний цус намайг хүч чадалтай болгохыг мэдэж байсан. Харри Поттерын цус. Тэр үед л би арван гурван жилийн өмнө алдсан хүч чадалтайгаар ахин төрөх юм. Тэр үед миний судсанд түүний эхийн үлдээсэн хамгаалалт бий болох байлаа.

- Гэхдээ Харри Поттерт яаж хүрэх билээ? Тэр арван гурван жилийн Дамблдор түүнийг ямар хүчирхэг шидээр хамгаалсаныг ч мэдэхгүй биз. Шид Поттерыг хамаатнуудтайгаа амьдарч байхад нь дурын аюулаас хамгаалж байсан. Тэр ч байтугай би түүнд хүрч чадахгүй байлаа. Дэлхийн цомын тэмцээн дээр... Би тэнд Дамблдорын шившлэг суларна гэж бодсон. Гэхдээ Дэлхийн цомын тэмцээн ид шидийн яамны зуугаад шидтэнгүүдийн хамгаалалтан дор явагдсан болохоор би түүнд хүрч чадаагүй. Харин Хогвартст махигар хамартай маглуудад хайртай тэнэг намайг шөнө ч орой ч нэвтрүүлэхгүй. Тэгэхээр би түүнд яаж хүрэх вэ?

- Тэгтэл хувь заяа надад Бертаг илгээлээ Тэр надад Гурван шидтэнгүүдийн тэмцээний тухай мэдээлсэн. Миний үнэнч Үхэл залгигч Хогвартст очиж Поттерын нэрийг Галт цомд хийсэн юм. Ингээд тэр ялагч болсон. Би зарцынхаа тусламжтай Харриг бүх даалгаварыг давахад тусалсан. Гурван шидтэний тэмцээн цомонд түрүүлж хүрэх ёстой байв. Миний үнэнч зарц түүнийг илбэдэж зөөвөрлөгч болгон хувиргасан. Цомд хүрэнгүүт тэр энд Дамблдорын эртний хамгаалалтын шидээс холдож миний гарт орсон. Ингээд тэр энд байна... та нарын намайг ялсан гэж боддог хүү...

Волан-де-Морт урагш алхаад Харри Поттерын луу эргэж харав. Тэр саваагаа өргөлөө.

- Круцио!

Харри тэсвэрлэхийн аргагүй өвдөлтийг мэдэрчээ. Яс нь хайлж байгаа юм шиг санагдан сорви нь халуу шатаж, толгой нь хагарах шахан өвдөж нүд нь галзуурсан юм шиг эргэлдэв. Харри өвдөлтийг болиулах ганц л зүйлийг хүсч байлаа. Үхэл...

Тэгтэл бүх юм дууслаа. Тэр булшны чулууны олсноос хүчгүй өлгөгдөхөд манан дундаас цусан улаан нүд асан гэрэлтэж байв. Харанхуйд Үхэл залгигчидын инээд хадав.

- Түүнийг надаас хүчтэй гэж боддог нь тэнэг хэрэг болохыг харав уу. Би үргэлж энэ гүнзгий төөрөгдслийг дуусгахыг хүсдэг байлаа. Харри Поттер үхлээс азтай тохиолдлоор зугтсан юм. Би та нарт үүнийг батлахын тулд нүдэн дээр чинь алж үзүүлэх болно. Дамблдор түүнд туслахгүй, эх нь ч гэсэн түүний төлөө үхэхгүй. Гэхдээ би ахин нэг өршөөл үзүүлье. Би түүнийг эсрэг тэмцэх боломж олгож байна. Ингэвэл та нарт бидний хэн хүчтэй талаар эргэлзээ үлдэхгүй бизээ. Жаахан хүлээчих, Нагайна гэж тэр исгэрэхэд могой Үхэл залгигчидын зүг мөлхөв.

- Сүүлтээ түүний уяаг тайлаад савааг нь буцаагаад өг.

БҮЛЭГ 34: ЭРТНИЙ ШИВШЛЭГ

Сүүлт Харри руу очоод мөнгөн гараа сунган амнаас нь алчуурыг авч нэг цохилтоор олсыг огтлов.

Хормын нэг хувьд Харрийн толгойд зугтах ухаангүй бодол төрсөн ч шархадсан хөл нь чичирэхэд Үхэл залгигчид эгнээнээ хулгана ч гарахын аргагүй хумин ойргов.

Сүүлт Седрикийн бие рүү очиж шидэт саваатай эргэж ирээд түүнийгээ Харригийн гарт шургуулав. Ингээд тэр эгнээндээ нэгдлээ.

- Чи халз тулалдаж чадах уу, Харри Поттер? гэж Волан-де-Морт улаан нүдээ гялалзуулан аяархан асуулаа.

Харри хоёр жилийн өмнө тэр нэг удаа халз тулааны клубт богино хугацаанд явсан ч зөвхөн зэвсэггүй болгох Экспеллиармус гэдэг шившлэгийг сурсан юм. Түүгээр тэмцэж болох уу? Волан-де-Мортыг зэвсэггүй болгосон ч дэргэд нь Үхэл залгигчид болох арван гурваас доошгүй хүн зогсож байна... Үүнд түүнийг сургаагүй билээ. Түүнд одоо няцаахын аргагүй Авада Кедавра гэдэг шившлэг заналхийлж байна. Грюм тэдэнд хичнээн удаа анхааруулсан билээ. Волан-де-Мортын зөв түүнийг энд юу ч хамаалахгүй... ээж нь ч Дамблдор ч байхгүй...

- Эхлээд бид нэг нэгэндээ бөхийн ёслох хэрэгтэй, Харри. Бөхий. Дүрмийг баримтлах ёстой. Дамблдорт энэ таалагдах болно... Үхэхийн өмнө бөхий, Харри гэж Волан-де-Морт хэлээд үл мэдэгхэн бөхийсөн ч толгойгоо буулгасангүй.

Үхэл залгигчид хөхрөлдөв. Волан-де-Морт уруулгүй аманд ёжтой инээмсэглэл тодров. Харри бөхийсөнгүй. Тэр Волан-де-Мортод муур хулгана болон тоглох боломж өгч болохгүй... Түүнд үхлийн өмнө баясах боломж өгч болохгүй...

- Би бөхий гэж хэлсэн шүү! хэмээн Волан-де-Морт давтаад саваагаа өргөв.

Харрид үл үзэгдэх гар нуруун дээр нь хүчтэй дарж байгаа юм шиг мэдрэмж төржээ. Үхэл залгигчид ахин инээлдэв.

- Маш сайн байна. Харин одоо надад эр хүн шиг бардам зогсоодох. Тэгж эцэг чинь үхсэн юм... гэж Волан-де-Морт аяархан хэлээд саваагаа өргөхөд Харри цэхлэн зогсов.

- Халз тулаан эхэллээ

Волан-де-Морт Харриг хуруугаа хөдөлгөж амжихаас урьтаж саваагаа занган ахиад Круциатус илгээхэд галаар түлж байгаа юм шиг өвдөж хутгаар биеийн хэсэг бүрийг нь сийчин хаях шиг болов. Харри унаад хашгирлаа. Тэр амьдралдаа хэзээ ч тэгж хашгирч байсангүй...

Өвдөлт зогслоо. Харри амьдралд эргэн ирж арайхийн хөл дээрээ өндийв. Түүний бие чичирч Сүүлтийн зүссэн гар захирагдахгүй болжээ. Харри Үхэл залгигчдын хана руу алхам ухарлаа. Тэд инээлдэн түүнийг Волан-де-Мортын зүг түлхэв.

- Багахан амсхийлт. Маш богинохон... Өвдөж байгаа биз, Харри? Чи ахин давтахыг хүсэхгүй л байгаа биз дээ? гэж Волан-де-Морт хэлэв. Түүний хамрын үзүүр хөөрсөндөө сартайжээ.

Харри чимээгүй байлаа. Энэ өршөөл энэрэлгүй улаан нүднээс тэр хувь заяагаа олж харлаа. Тэр одоо Седрик шиг үхэх болно... Юу ч хийгээд нэмэргүй үхнэ... Удаан тоглохгүй... Тэр Волан-де-Мортын үгэнд захирагдахгүй... Үхэхийн өмнө гуйхгүй...

- Би чамас ахин давтаж үзэх эсэхийг чинь асууж байна? Надад хариул! Имперо.

Харри амьдралдаа гурав дахь удаагаа ой ухаан нь хоосрохыг мэдэрлээ... Ямар их баяр хөөр вэ! Өөр юуны ч тухай бодох юм биш... Тэр яг л дулаахан усанд таатай зүүрмэглэж байгаа мэт... Зөвхөн <<үгүй>> гэж хэл... зүгээр л <<үгүй>> гэж хэл...

<<Хэлэхгүй, хэлэхгүй! гэсэн шийдвэртэй хоолой толгойд нь сонсогдлоо>>.

<<Үгүй гэж хэл>>...

<<Яагаад ч үгүй!>>

<<Хэл!>>

- ХЭЛЭХГҮЙ!

Энэ үг түүний цээжний гүнээс гарч оршуулгын газар даяар цуурайтав. Хөнгөхөн хөөрөл гэнэт сарниж ахиад л Криуцатиусын дараа бүх бие нь янгинаан өвдөв. Харри ахиад л хаана байгаа болон түүнийг юу хүлээж байгааг ойлгов...

- Хэлэхгүй юм биз дээ. Үгүй гэж хэлэхгүй юм биз дээ? Би чамайг үхлийн өмнө дуулгавартай байхад сургах болно... Магадгүй ахин нэг удаа жаахан өвдөлт үү? гэх Волан-де-Морт-ын сүрдүүлсэн хоолой сонсогдов.

Тэр саваагаа өргөхөд Харри хэдийн бэлэн байж удаан хугацааны квиддичийн бэлтгэл нь тусаллаа. Тэр агшин зуур гантиг булшны араар ухасхийн ороход шившлэг ард нь чулуу онож бутлах чимээ сонсогдов.

- Бид нуугдаж тоглоохгүй, Харри гэх Волан-де-Мортын хүйтэн хоолой дэргэд нь сонсогдоход Үхэл залгигчид ахин инээлдэв.

- Чи надаас нуугдаж чадахгүй. Магадгүй чи халз тулаан хийхээс ядарсан байх? Магадгүй түүнийг түргэн дуусгахыг хүсч байж мэднэ, Харри. Тэгвэл гараад ир. Бүх зүйл нүд ирмэх зуур болно... Өвдөж ч амжихгүй... Үхсэнээ ч мэдэхгүй...

Харри булшны чулууны ард атийн сууж байхдаа төгсгөл ирснийг ойлгож байлаа. Ямар ч найдлага байхгүй... тусламж ирэхгүй. Волан-де-Мортын алхаа ойртох нь сонсогдлоо. Тэгтэл айдас нь алга болов. Тэр хүүхэд шиг нуугдаж тоглож байгаад үхэхгүй. Волан-де-Морт хөлөнд сөхөрч байгаад үхэхгүй... Тэр толгойгоо бардам өргөөд эцэг шигээ өөрийгөө хамгаалахыг оролдох ч энэ боломжгүй...

Ой ухааны хаа нэгтээ Волан-де-Морт могой шиг царай үзэгдэхэд Харри хөл дээрээ босож шидэт саваагаа чанга бариад түүнийг угтан очлоо.

Тэгтэл түүний хүлээж байсан мөч ирж Харри <<Экспеллиармус>> гэж хашгирахтай зэрэгцэн Волан-де-Морт <<Авада Кедавра>> гэж хашгирлаа.

Волан-де-Мортын саваанаас ногоон оч гарсан бол Харрийн саваанаас улаан оч гарлаа. Оч агаарт мөргөлдөхөд Харри саваа гэнэт цахилгаан цэнэгт холбогдсон мэт чичирлээ. Гар нь саваанаас ургасан аятай болжээ. Хоёр савааны нарийхан цацраг нэгдэн ногоон ч биш улаан ч биш шөнийн харанхуйд хурц алтлаг өнгийн утас болов. Харри гайхширан утсыг дагуулан харлаа. Волан-де-Мортын саваагаа атгасан урт нарийхан хуруунууд чичирч харагдана...

Гэнэт Харрийн хөл хөндийрэхөд савааны гялалзсан алтан утсаар дамжин Волан-де-Мортын хамт агаарт хөөрлөө. Холгүйхэн Томас Реддлийн булш нисэн өнгөрөв. Үхэл залгигчид тэдэн рүү гүйж эзнээсээ юу хийх ёстойг хашгиран асуулаа. Дараа нь тэд ахин тойрон хүрээлж саваагаа өргөхөд могой тэдний хөлд гулсан цагариглав.

Харри Волан-де-Морт хоёрын холбогдсон алтан утаснаас мянга мянган очис нисэн гарч дээгүүр нь нуман хэлбэртэй алтан пөмбөгөр тор үүсгэхэд цөөвөр чоно шиг тойрон хүрээлсэн Үхэл залгигчид хашгиран гараа даллав.

- Юу ч хийх хэрэггүй! гэж Волан-де-Морт дагалдагсаддаа хашгиран тушаахад улаан нүд нь гайхсандаа томорсон байлаа.

Хар Лорд юу болоод байгааг ойлгоогүй ч бүх хүчээ гарган Харритай холбогдсон утсыг алтлаг утсыг эвдэхийг хичээлээ. Харри саваагаа хоёр гараараа барьж байсан учраас утас тасарсангүй.

- Миний тушаалгүй юу ч битгий хий гэж Волан-де-Морт ахин орилов.

Тэгтэл агаарт гайхамшигтай сайхан дуу хадав... Энэ дуу Харри Волан-де-Морт хоёрын холбогдсон утаснаас цацарсан туяанаас ирж байлаа.. Харри галт шувууны дуу болохыг танилаа.

Энэ чимээ шиг найдлага төрүүлсэн сайхан дууг тэр амьдралдаа сонсож байсангүй. Уянгын дуу зөвхөн агаарт ч биш зүрхэнд нь дуулдаж түүнийг Дамблдортой холбоход чихэнд нь үг дуулдав.

<<Утсыг битгий тасал.>>

<<Мэднэ>> гэж Харри хөгжимд хэлэв. Гэвч барихад улам хэцүү болж байв. Түүний саваа хүчтэй чичирэхэд Волан-де-Морт тэр хоёрын цацраг өөрчлөгдөн том гэрэлтэй дуслууд алтан утас дагуу гулсан ирлээ.

Эхний дусал ойртоход саваа нь хүчтэй чичигнэлээ. Дусал ойртох тусам саваа галзуурсан мэт чичирч байв. Ахиад жаахан л удвал тэр саваагаа барьж тэсэхгүй нь шатах юмуу хугарах байх.

Харри хүч гарган дуслыг Хар лордын саваа руу буцаахыг хичээв. Чихэнд нь галт шувууны дуу сонсогдон харц нь дусал дээр ууртайгаар төвлөрч... удаан маш удаанаар ирсэн замаар нь буцаав. Харин одоо Волан-де-Мортын саваа хугарах гэж байгаа мэт чичирлээ. Харри нүдэндээ ч итгэсэнгүй. Волан-де-Морт гайхаж мэгдэн айсан байртай харагдав...

Сүүлчийн дусал чичирсээр түүний саваанаас инчийн зайд зогсоход Харри юу болоод байгааг хэзээ энэ бүхэн дуусахыг ойлгосонгүй... Түүний бүх бодол яаж дуслыг

Волан-де-Морт саваа руу буцаах вэ гэдэг ганц л зүйлд төвлөрчээ. Удаан... маш удаанаар... дуслыг алтан утас дагуу буцаалаа.

Тэгтэл Волан-де-Мортын өвдсөндөө орилох чимээ сонсогдов... Түүний нүд айдаст автан томоор нээгдэхэд савааны үзүүрээс хагас тунгалаг Сүүлтэд өгсөн шиг гар гарч ирснээ алга болов. Ахин өвдсөн хашгиралт... савааны үзүүрээс ямар нэгэн том саарал утаа шиг зүйл гарч ирэв... Энэ бол толгой байв... араас нь цээж Седрик Диггорийн их бие гарч ирлээ.

Харри цочирдсондоо арай л шидэт саваагаа алдчихсангүй зөнгөөрөө чанга атгасан болохоор алтан утас эвдэгдсэнгүй. Эцэст нь Седрик Диггорийн хий үзэгдэл (Үнэхээр хий үзэгдэл гэж үү? Тэр амьд юм шиг байх юм) Волан-де-Мортын саваанаас бүтнээр гарч ирлээ... Хий үзэгдэл алтан утас руу харан цэх зогсоод,

- Чанга бариарай, Харри гэв.

Түүний хоолой алсад байгаа юм шиг сонсогдлоо. Харри Волан-де-Морт руу харлаа... Түүний улаан нүдэнд айдас тодорч үзэгдэнэ. Тэр Харригийн адил юу ч ойлгоогүй бололтой. Харри пөмбөгөр торны гадаа Үхэл залгигчид хашгиралдахыг бүдэгхэн сонслоо.

Ахиад л хашгиралт.. ямар нэг юм саваанаас гарлаа... толгой, гар, их бие... Харрийн зүүдэндээ харж байсан хөгшин хий үзэгдэл саваанаас гарлаа... Седрикийн дэргэд харайн буугаад таягаа тулан Харри болон Волан-де-Мортын саваа холбогдсон алтан тор харлаа...

- Тэгэхээр тэр үнэхээр шидтэн юм биз дээ? Тэр намайг алсан... Түүнд үзүүлээд өг, хүү минь гэж өвгөн Волан-де-Морт руу харан хэллээ.

Саваанаас дараагийн толгой... эмэгтэй хүний... Харригийн гар чичигнэхэд саваагаа барьсан хэвээр үлдлээ. Хагас тунгалаг хий үзэгдэл бусдын адил газардаад халз тулааныг харав. Берта Жоркинс. Тэр Харри руу хараад хашгирлаа.

- Ямар ч тохиолдод саваагаа битгий буулгаарай! Барь! Чанга барьж битгий алдаарай! Түүний хоолой Седрикийн адил алсад байгаа юм шиг сонсогдох ажээ.

Тэр хоёр хий үзэгдлийн хамтаар алтан торны дотор талд зогсоход Үхэл залгигчид гадуур нь гүйлдэв. Волан-де-Мортын үхсэн хохирогчид халз тулааныг хүрээлэн Харрид дэмжсэн үг шивнэж байлаа.

Волан-де-Мортын савааны үзүүрээс ахин нэг толгой цухуйхад Харри шууд хэн гэдгийг нь ойлгов... Тэр түүнийг Седрикийн хий үзэгдлийг харсан цагаасаа хүлээж байсан юм... тэр түүнийг санаж байлаа.

Залуу эмэгтэй хүний утаан сүүдэр газар унаад босч түүн рүү харав... Харригийн гар чичирэхэд эхийнхээ царай луу харлаа.

- Эцэг чинь одоохон ирнэ. Тэр чамайг харахыг хүсч багаа. Бүх юм сайн болно... тэсээрэй гэж аяархан хэлэв.

Ингээд ахиад л... ахиад л толгой дараа нь бие... Удалгүй Харригийн урд түүний адил үстэй Жеймс Поттерын дүрс газардав. Түүний хохирогчид хүрээлэхэд Волан-де-

Мортын царай хувхай цайлаа. Эцэг нь Харригийн дэргэд ирээд алсад байгаа юм шиг хоолойгоор ярилаа.

- Холбоо алга болох үед бид түүнийг нэг минут барина... илүү боломжгүй. Зөөвөрлөгч рүү түрэн очоорой тэр чамайг Хогвартст хүргэх болно... Намайг ойлгов уу, хүү минь?

- Тиймээ гэж Харри дуу алдаад гараас нь алдуурах шахаж байгаа саваагаа чанга барилаа.

- Харри миний биеийг аваад яваарай. Эцэг эхэд минь аваачиж өг... гэж Седрикийн сүүдэр шивнэлээ.

- Тэгнэ ээ гэж Харри хэлэв. Тэр царайгаа хүчлэн саваагаа арай ядан барьж байлаа.

- Боллоо. Зугт гэж эцэг нь шивнэлээ.

- ОДОО! гэж Харри хашгирлаа.

Саваагаа ахин барьж тэсэхгүй болжээ. Тэр саваагаа хүчтэй угз татан авахад алтан утас тасарлаа. Гэрэлт тор алга болж галт шувууны дуу чимээгүй болов. Гэхдээ хий үзэгдлүүд алга болсонгүй Волан-де-Мортыг хана шиг тойрон хүрээлэв.

Харри хар хурдаараа хөшсөн хоёр Үхэл залгигчийн дундуур туулай шиг бүлт үсрэн гарав. Тэр онхол донхол булшин дундуур гүйхэд араас шившлэг илгээгдэн булшны чулуу хагарах чимээ сонсогдлоо. Тэр хөлнийхөө өвдөхийг тоолгүй Седрикийн бие рүү гүйлээ. Түүний бүх л бодол ганц зүйл Седрикийн биеийг авч явах тухай төвлөрчээ.

- Түүнийг хөшөө! гэх Волан-де-Морт орилоон хадав.

Харри Седрикийн биенээс гурван метийн зайд байх гантиг сахиусан тэнгэрийн хөшөөний ард улаан очноос нуугдан үсэрч ороход далавчиг нь шившлэг хэмх цохив. Саваагаа чанга атгаад нуугдсан газраасаа босож <<Импедимента>> гэж араас нь ирж байсан хүмүүс рүү мөрөн дээгүүрээ чиглүүлэн хашгирлаа.

Хашгиралт сонсогдох нь нэгээс багагүй хүн оногдсон бололтой. Зогсоод эргэж харах цаг үлдсэнгүй. Цомын хажууд гүйж очоод газар унахад саваа дэлбэрэх чимээ сонсогдож очис толгой дээгүүр нь нисэв. Тэр гараа сунган Седрикийн мөрнөөс барилаа...

- Бүгд холд! Би түүнийг өөрөө ална! Тэр минийх! гэсэн Волан-де-Морт хашгиралт сонсогдов.

Волан-де-Морт ердөө нэг хөшөөний цаана ирсэн ч Седрикийн бие хүнд болохоор цомонд хүрч чадахааргүй байлаа...

Харанхуйд Волан-де-Мортын улаан нүд гялсхийн үзэгдэхэд уруул нь мушийн гартаа саваагаа барьсан байлаа...

- Акцио! гэж Харри хашгираад цомын зүг даллав.

Цом агшин зуур дэргэд нь үсрэн ирэхэд Харри барьж аваад нислээ...

Волан-де-Морт уурсан дуутай зэрэгцэн хүйснээс нь татах шиг болж. зөөвөрлөгч ажиллан улаан очтой хуй салхинд Седрикийн хамт эргэлдэн нислээ.

БҮЛЭГ 35: ҮНЭНИЙГ ХЭЛҮҮЛЭГЧ

Харри хатуу газар нүүрээрээ шургачин унахад ногооны үнэр ханхлав. Зөөвөрлөгчөөр нисэхэд тэр нүдээ аньжээ. Тэр хөдөлсөнгүй. Уналтын дараа амьсгаадан хөлөг онгоцоны тавцан дээр байгаа юм шиг толгой нь эргэнэ. Харри хоёр гартаа Седрикийн бие болон цомыг чанга зуурчээ. Хэрвээ тэднийг тавих юм бол харанхуйд алдчих гэж байгаа юм шиг санагдаж байлаа. Туйлдаж ядарсандаа газар хэвтээд ногооны үнэр үнэртэн хэн нэгэн ямар нэгэн юм хийх... ямар нэг юм тохиолдохыг хүлээтэл... сорви нь чинэрэн өвдлөө.

Чих дөжрөм чимээ сонсогдов. Эргэн тойронд нь орилох, хашгирах, алга таших чимээ сонсогдож байлаа. Царай нь хар дарсан зүүдэнд байгаа мэт үрчийж хар дарсан зүүд үргэлжилсээр байгаа мэт...

Хэн нэгний гар дээш нь эргүүлэн харуулав.

- Харри! Харри!

Тэр нүдээ нээлээ.

Түүний дээр одот тэнгэр гялалзаж дэргэд нь Альбус Дамблдорын нүүр харагдав. Эргэн тойрон харанхуйд хүмүүс хүрээлэн ойртож байлаа. Газар хөлийн чимээнд доргих нь сонсогдов.

Цом түүнийг төөрдөг байшингийн дэргэд эргэн авчирчээ. Харри үзэгчдийн суудал дээрээс гүйлдэх дүрснүүд болон гялалзах ододыг харлаа.

Тэр цомыг тавиад Седрикийг чанга тэвэрлээ. Түүний гарыг Дамблдор татав. Захирлын нүүр ахиад бүдгэрлээ.

- Тэр эргээд ирсэн. Волан-де-Морт эргээд ирсэн гэж Харри шивнэлээ.

- Юу болсон бэ? Юу болоод байна?

Харрийн дээр айж хирдхийсэн Корнелиус Фажын царай харагдав.

- Бурхан минь! Диггори! Дамблдор... тэр үхсэн байна!

Энэ үгийн дараа аймшигтай мэдээ шөнийн харанхуйд тарлаа.

- Тэр үхсэн гэнээ! Үхсэн! Седрик Диггори үхчихэж!

- Харри түүнийг тавь гэх Фажын хоолой сонсогдов. Хэн нэгэн түүний хурууг салгахыг хичээсэн ч улам хүчтэй зуурлаа.

Түүн рүү Дамблдорын нүүр бүүдгэртэн бөхийв.

- Харри чи түүнд тусалж чадахгүй. Бүх юм дууссан. Түүнийг тавь.

- Тэр өөрийгөө энд авчрахыг хүссэн. Эцэг эхдээ авчрахыг... гэж Харри шивнэлээ.

- Сайн байна, Харри... түүнийг ямар ч гэсэн тавь.

Дамблдор бөхийгөөд хөгшин хүнээс гармааргүй гэнэтийн хүчээр хурууг нь тавиулан түүнийг дээш босгов. Харри ганхлаа. Толгойг нь хүнд алхаар цохьчихсон мэт

манарна. Шархтай хөл нь чичирч биеийн жингээ даахгүй болжээ. Хүмүүс шахцалдан шивнэлдэж харанхуйд улам ойртож байлаа.

- Тэр яагаа вэ? Юу болсон юм бол? Диггори үхсэн юм уу?

- Түүнийг одоохон эмнэлэг рүү аваачих хэрэгтэй! Тэр шархдсан байна, Дамблдор. Диггорийн эцэг эхийг энд дуудах хэрэгтэй... Би Харриг эмнэлэгт аваачиж өгье... гэж Фаж чанга хэлэв.

- Үгүй ээ би зөвшөөрөхгүй...

- Дамблдор одоо Амос Диггори гүйгээд ирнэ... тэр... түүнийг харахаас өмнө мэдэгдсэн дээр байх...

- Харри энд үлдээрэй...

Охид дуу алдан уйлав. Эргэн тойрон Харрийн нүдний өмнө хачирхалтайгаар сүүмэлзлээ.

- Бүх юм сайн болно, хүү минь би чамтай хамт байна... Одоо эмнэлэг рүү явцгаая...

- Дамблдор намайг энд үлд гэсэн хэмээн Харри хэлэв. Сорви нь хүчтэй дэлбэрэх шахам өвдөж байсан болохоор нүдний хараанд бүх зүйл балархайтан үзэгдэж байлаа...

- Чи хэвтэх хэрэгтэй... түргэл...

Хэн нэгэн том хүчтэй хүн Харриг түшиж айсан хүмүүсээс холдуулав. Бүх зүгээс хашгирах уйлах чимээ сонсогдож байлаа. Харриг түшиж байсан эрэгтэй хүн тэдний дэргэдүүр өнгөрөөд шилтгээний зүг чиглэв. Нуга дээгүүр явж нууран дээр байгаа Дурмстрангын хөлөг онгоцыг өнгөрөв. Харри түүнд явахад нь тусалж байгаа хүний амьсгаадах чимээнээс өөр юу ч сонсохгүй байлаа.

- Юу болсон бэ, Харри? гэж тэр асуулаа. Модон хөл чулуун шатан дээр түг хийх чимээ гарав. Энэ бол Хурц нүдэт Грюм байв.

- Цом бол зөөвөрлөгч байсан. Тэр Седрик бид хоёрыг оршуулгын газар аваачсан... Тэнд Волан-де-Морт... Хар лорд байсан гэж Харри хэллээ.

Гантиг шатаар өгсөхөд ахиад л модон хөлийн чимээ дуулдав.

- Хар лорд гэж хэлсэн үү? Цаашаа юу болсон бэ?

- Седрикийг алсан... Тэр Седрикийг алсан...

- Харин дараа нь?

Түгхийх чимээ хонгилоор эргэлээ.

- Тэр уусмал чанаж... өөрийн биетэй болсон...

- Хар лорд биедээ эргэн ирсэн гэнээ? Тэр эргэн ирсэн хэрэг үү?

- Дараа нь Үхэл залгигчид ирсэн... Харин би түүнтэй халз тулаан хийсэн...

- Чи Хар лордтой халз тулаан хийсэн юм уу?

- Зугтаахын тулд... миний саваа... ямар нэг юм болсон... Би ээж аавыгаа харсан... тэд түүний саваанаас гарч ирсэн...

- Ор, Харри... энд суу... Одоо бүх юм хэвийн болно... үүнийг уу...

Харри түлхүүр цоожинд эргэх чимээ сонслоо. Хэн нэгэн түүнд аяга бариулав... Грюм...

- Уучих... тэгвэл дээрдэх болно... Алив Харри надад яриач бүгдийг тодорхой мэдэх хэрэгтэй байна.

Грюм аягыг уруулд нь ойртуулав. Халуун ногоо шиг амттай шингэн хоолойг нь түлэхэд Харри ханиалгав. Грюмын өрөө болон түүний эзэн хурцаар тодорлоо. Грюм Фаж шиг цонхийсон агаад хоёр нүдээрээ цавчилгүй Харрийн нүүр лүү ширтэж байв.

- Волан-де-Морт эргэж ирсэн гэсэн үү, Харри? Чи итгэлтэй байна уу? Энэ бүхэн яаж болсон юм бэ?

- Тэр эцгийнхээ шарилаас, Сүүлтээс, бас надаас юм авсан гэж Харри хэллээ.

Толгой нь цэлмэхэд сорви өвдөхөө намдлаа. Тэр өрөөнд харанхуй байсан ч Грюмын царайг тод харж байлаа. Цэнгэлдэх хүрээлэнгийн талбайд хашгирч орилох чимээ сонсогдоно.

- Хар лорд чамаас юу авсан бэ? гэж Грюм асуулаа.

- Цус гээд Харри гараа үзүүлэв. Жанчны ханцуй дээр Сүүлтийн хутгаар зүссэн газар урагджээ.

Грюм хүндээр амьсгал авснаа аяархан исгэрлээ.

- Харин Үхэл залгигчид? Түүн дээр эргэн ирсэн үү?

- Тиймээ. Олуулаа байсан...

- Тэр тэднийг яаж угтаж авсан бэ? Уучилсан уу? гэж Грюм аяархан асуув.

Тэгтэл Харри гэнэтхэн саналаа. Дамблдорт шууд хэлэх хэрэгтэй байж.

- Хогвартст Үхэл залгигч байгаа! Тэр л миний нэрийг цомд хийж тэмцээний төгсгөл хүртэл хүрэхэд тусалсан...

Харри босохыг оролдсон ч Грюм түүнийг сандал руу буцаан түлхээд,

- Би тэр Үхэл залгигч хэн болохыг мэднэ гэж аяархан хэлэв.

- Каракаров? Тэр хаана байна? Та түүнийг барьсан уу? Хорьсон уу? гэж Харри хашгирав.

- Каркаров гэнээ? хэмээн Грюм хачирхалтай инээн асуугаад,

- Каркаров өнөө шөнө гарт нь Хар тамга амилах үеэр зугтсан. Тэр Хар лордтой уулзахыг хүсэж байсан ч түүнээс урван хэтэрхий олон үнэнч дагалдагчдыг барьж өгсөн... Гэвч түүнийг хол зугтаж чадна гэдэгт эргэлзэж байна. Хар лорд дайснаа цээрлүүлж чадна гэлээ.

- Каркаров зугтсан гэнээ? Тэр биш юм уу? Тэгвэл... хэн миний нэрийг цомд хийсэн юм бэ?

- Үгүй. Тэр биш. Энэ бол би гэж Грюм удаанаар хэлэв.

Харри буруу сонслоо гэж боджээ.

- Үгүй та биш... тийм байх боломжгүй...

- Би байсан гээд түүний шидэт нүд эргэлдэн гадаа хүн байгаа эсэхийг шалган хаалганы зүг харлаа. Тэрбээр саваагаа гаргаад Харри руу тулгав.

- Тэр тэднийг уучилсан юм биз дээ? Чөлөөтэй зугаалж байсан Үхэл залгигчидыг уу? Хэн тэгээд Азкабанаас зугтсан хэрэг болж байна?

- Юу? гээд Харри ойлгосонгүй.

Тэр түүн рүү чиглэсэн савааг харав. Энэ ч таагүй тоглоом байна даа!

- Би ахиад асууя тэдгээр шаарнуудыг уучилсан хэрэг үү? Эдгээр дагалдагчид Азкабанд орохоос айж түүнээс урвасан. Тэр өөдгүй амьтад зориг зүрхтэйгээ харуулах гэж Дэлхийн цомын тэмцээн дээр багтай цугларсан байсан. Тэгэхэд би айлгах гэж тэнгэрт Хар тамга илгээсэн юм.

- Та... Та юу яриад байна аа?

- Би чамд урьд нь хэлж байсан, Харри... Би энэ дэлхий дээр юунаас ч илүү чөлөөтэй үлдсэн Үхэл залгигчдыг үзэн яддаг гэж. Тэд эзэндээ өөрсдөд нь хэрэг болох үед очиж байна. Би тэднийг шийтгэх байх гэж найдаж байлаа. Би тэднийг тамлах болно гэж бодсон. Тэр тэднийг шийтгэсэн үү, Харри? гээд Грюмын царайд гэнэтхэн ухаангүй инээмсэглэл тодорлоо.

- Тэр тэдэнд намайг ганцаараа үнэнч үлдсэн гэдгийг хэлсэн үү... Өөрийн амьдралаараа дэнчин тавин байж түүний юунаас ч хүссэн зүйлийг өгсөн гэдгийг... Чамайг!

- Та гэнээ? Байж боломгүй юм...

- Хэн чиний нэрийг өөр сургуулийн нэртэйгээр цомд хийсэн бэ? Би! Хэн чамайг аюул ослоос хамгаалж ялуулахын тулд бүгдийг хийсэн бэ? Би! Хэн Хагридад чамд луу үзүүлэх санаа төрүүлсэн бэ? Ахиад л би! Хэн чамд лууны эсрэг тэмцэх арга зааж өгсөн бэ? Мэдээж би!

Грюмын шидэт нүд хаалга руу харахаа болиод инээвхийлэв.

- Энэ маш амаргүй байсан, Харри. Нэг ч сэжиглэл авхуулалгүй зальжин зохицуулсан. Чи бүх даалгаварыг шууд хийсэн бол Дамблдор таагүй зүйл үнэрлэх байлаа. Чамайг гурав дахь тэмцээний төөрдөг байшинд орох үед би өрсөлдөгчдийг чинь цомд хүрэх замаас зайлуулсан. Гэхдээ надад чиний мулгуу байдал саад болж байлаа... Хоёр дахь тэмцээнд бүтэлгүйтэхээс... би юунаас ч илүү айж байсан. Би чамайг дагаж байсан, Поттер. Чамайг өндөгний нууцыг тайлаагүй гэдгийг мэдэж ахин нэг зөвлөгөө өгсөн...

- Энэ та биш. Надад Седрик хэлсэн гэж Харри сөөнгө хоолойгоор эсэргүүцэв.
- Харин Седрикт усан дор онгойлгохыг хэн хэлсэн болж байна? Би! Би түүнийг өндөгний тухай чамд хэлнэ гэдэгт итгэлтэй байсан. Сайн хүмүүсийн эвийг хөнгөхөн олж болдог юм, Поттер. Седрик чамайг лууны тухай хэлсний хариуг төлнө гэдэгт би итгэлтэй байсан. Гэхдээ энэ бүхний дараа ч гэсэн чи усан дор яаж амьсгалахаа олоогүй. Би чамайг үргэлж харж байлаа. Хичнээн цаг номын санд суусан ч гэлээ! Харин ном чиний дэргэд унтлагын өрөөнд чинь байсан шүү дээ! Би түүнийг Долгопупсд хичээлийн жилийн эхэнд өгсөнийг санаж байна уу? <<Газар дундын тэнгисийн усны шидэт ургамал>> гэдэг ном. Тэнд жаброслигийн тухай бүх зүйл бичээстэй байсан. Би чамайг бүгдээс тусламж гуйх байх гэж бодсон. Долгопупс мэдээж чамд түүний тухай хэлэх байсан. Гэхдээ чи түүнээс гуйгаагүй... Чиний бардам байдал бүгдийг сүйрүүлсэн.
- Би юу хийх ёстой байсан гэж? Өөр гэмгүй аргаар чамд жаброслигийн тухай мэдэгдэх үлдсэн. Бүжигт үдэшлэг дээр чи надад Добби гэрийн үйлчлэгч зул сарын баяраар оймс бэлэглэсэн гэсэн. Би үйлчлэгчийг багш нарын өрөөнд ирж хувцас цэвэрлэхийг тушаасан. Харин би өөрөө профессор МакГонагаллтай тохиромжтой шившлэгийн туай яриа өрнүүлж олзлогдогчыг аврахдаа Харри Поттер жабросли ашиглахгүй бол харамсана гэдгээ илэрхийлсэн юм. Чиний жижигхэн найз үйлчлэгч чинь Снеггийн өрөөнөөс жабросли хулгайлж дараа нь чамд өгсөн...
- Грюм саваагаа Харрийн зүрхэнд тулгалаа. Грюмын ард өлгөсөн Дайсан илрүүлэгч толь дээр бүүдгэр сүүдрүүд хөдлөв.
- Чамайг нууранд удахад би айсан шүү, Поттер. Живж үхсэн юм болов уу гэж бодсон. Харин аз болоход Дамблдор чиний тэнэг уужим сэтгэлийг үнэлэн хамгийн өндөр оноо өгсөн. Би ахиад л санаа амарсан.
- Төөрдөг байшинд бусдыг бодоход илүү амар байсан. Би өөрөө жижүүрлэж байсан болохоор хана нэвт харж чиний замаас бүх таагүй зүйлийг зайлуулсан. Би л чиний цомд хүрэх замыг цэвэрлэх гэж Флер Делакурыг хөшөөж, Имперуусын тусламжтай Крамыг Диггори руу дайруулсан юм шүү дээ.
- Харри балмагдан Грюм руу харав. Тэр юу болоод байгааг ойлгосонгүй... Дамблдорын найз алдартай маркоборец... тийм олон Үхэл залгигчийг барьсан хүн... Энэ бол ухаангүй... тайлбарлаж боломгүй хэрэг байлаа.
- Дайсан илрүүлэгч дээр тод сүүдэр гарч ирэв. Харри Грюмын мөрөн дээгүүр өрөөнд гурван хүн улам ойртохыг харав. Гэхдээ Грюм тэднийг ажигласангүй Харри руу ширтэж байлаа.
- Хар лорд чамайг алсангүй, Поттер. Харин тэр үүнийг хүсч байсан! Намайг яаж шагнахыг төсөөлөөд үз дээ! Би чамайг түүнд өгч эргэн төрүүлсэн! Харин одоо би чамайг алах болно. Тэр намайг бүх Үхэл залгигчдаас өндөрт тавина. Би хамгийн үнэтэй хамгийн ойрын туслах... хүүгээс нь ч илүү....
- Грюмын жирийн нүд бүлтийхэд шидэт нүд нь Харриг цоо ширтэв. Хаалга цоожтой Харри шидэт саваагаа гаргаж амжихгүй гэдгээ мэдэж байв.

- Хар Лорд бид хоёрт олон адилхан зүйл бий гээд Грюм ухаангүй харцаар Харри руу ширтэн бөхийлөө.

- Бид хоёулаа эцэгтээ гомдсон... Хоёулаа тэдний нэрийг зүүж байгаадаа харамсдаг, Харри. Бас тэр болон би маш баяртайгаар эцгээ алсан... Харин одоо Лар лордод юу ч саад болохгүй!

- Та галзуу юм байна. Та зүгээр л галзуу юм байна! гэж Харри тэссэнгүй хашгирлаа.

- Би галзуурсан гэнээ? гэж Грюм хяналтаа алдсан дуугаар хашгираад,

- Хэн галзуурсныг харцгаая л даа! Хар лордыг эргэн ирэхэд би баруун гар нь байх болно! Тэр эргэж ирнэ! Харри Поттер... Чи түүнийг дийлж чадахгүй. Харин одоо би Харри Поттерыг дийлэх болно! гэв.

Грюм саваагаа өргөн амаа нээхэд Харри амжин саваагаа аваад,

- Окаменей! гэж хашгирлаа.

Нүд гялбам хурц гэрэл гялсхийж аймшигтай тасхийх чимээ гараад өрөөний хаалга үйрдэс болов.

Грюм шалан дээр унав. Харри дайсан илрүүлэгч толь дээр Альбус Дамблдор, Минерва МакГонагалл, профессор Снегг нарын дүрс гарч ирэхийг харлаа. Тэд гурвуулаа үүдэнд ирэхэд Дамблдор түүрүүнд нь явлаа.

Тэр үед л Харри Дамблдор ягаад Волан-де-Мортын айдаг цорын ганц хүн болохыг ойлгожээ. Дамблдор шалан дээр ухаангүй хэвтэж байгаа Грюм болон Харрийн айдас хүрэм төрхийг харлаа. Тэр инээмсэглэсэн ч үгүй нүд нь гялалзсан ч үгүй. Түүний царайд хүчтэй уур хилэн тодроход өрөөний хана одоохон бутрах гэж байгаа мэт санагдав.

Тэр өрөөнд орж ирээд Грюмын ухаангүй биеийг эргүүлэн харуулав. Түүний араас Снегг орж ирээд дайсан илрүүлэгч толинд уурссан царайгаа харлаа.

Профессор МакГонагалл Харрийн хажууд хүрч ирэв.

- Явъя Поттер. Явцгаая. Эмнэлэг рүү... гэж шивнэлээ. Уруул нь чичирч одоохон уйлах гэж байгаа мэт санагдана.

- Үгүй гэж Дамблдор огцом эсэргүүцлээ.

- Дамблдор энэ чухал хэрэгтэй... түүнийг хараач.. тэр өнөөдөр хичнээн ихийг...

- Тэр энд үлдэх болно, Минерва минь. Түүнд ойлгох хэрэгтэй байна. Ойлголт бол дараа нь болсон явдлын эхний алхам юм. Зөвхөн тэр үед өөрийгөө сэргээж чадна. Тэр өнөөдөр юуны учир хүнд сорилт туулснаа мэдэх ёстой гэж Дамблдор түүний үгийг таслан хэлэв.

- Грюм. Тэр яаж чадсан юм бол? гэж Харри гайхсанаа нуухгүй байж чадсангүй.

- Энэ бол Аластор Грюм биш. Чи Аластор Грюмыг мэдэхгүй. Жинхэнэ Грюм хэзээ ч чамд тийм зүйл тохиолдсоны дараа миний хараанаас гаргахгүй. Түүнийг чамтай явмагц би шууд бүхнийг ойлгоод... араас нь ирсэн юм.

Дамблдор Грюмын бие рүү бөхийгөөд түүний халааснаас хэлхээтэй түлхүүр болон дашмаг гаргаж ирлээ. Тэгээд Снегг, МакГонагалл хоёр луу эргэлээ.

- Северус, Үнэнийг хэлүүлэгч хүчтэй уусмалаа аваад дараа нь гал зуухнаас Винки нэртэй үйлчлэгчийг аваад ир. Минерва минь, Хагридын овоохой руу явж хулууны талбайд очвол том хар нохой байгаа. Түүнийг миний өрөө лүү аваачаад ийшээ эргээд ирээрэй гэв.

Хэдийгээр захирлын заавар хачирхалтай байсан ч тэд гайхсанаа нууж байлаа. Хоёул яаран өрөөнөөс гарцгаав. Дамблдор долоон цоожтой авдар луу очоод түлхүүр шургуулан эхний түгжээг онгойлгож тагыг нээв. Дотор нь овоолоостой ном байв. Дамблдор авдрыг хаагаад хоёр дахь түлхүүрээр хоёр дахь түгжээг онгойлгон ахин тагыг нээлээ. Номнууд алга болж түүний оронд эвдэрсэн вредноскопууд, цаас, үзэг болон ямар нэгэн мөнгөлөг юм хэвтэж байсан нь Харрид үл үзэгдэх цувьг санагдуулав. Харри Дамблдорын үйл хөдлөлийг хачирхан харж байлаа. Гурав дахь, дөрөв дэх, тав дахь, зургаа дахь цоожыг нээх бүр авдраас ямар нэгэн өөр юм гарч байлаа. Эцэст нь Дамблдор долоо дахь түгжээг нээн авдрыг онгойлгоход Харри гайхсандаа дуу алдлаа.

Тэр гурван метрийн гүн дэх газар дорхи хонгилыг харав. Түүн дотор жинхэнэ боловч маш туранхай Хурц нүдэт Грюм бөх унтаж байв. Модон хөл нь байхгүй, шидэт нүдний аяга нь хоосон, буурал үс нь жигд бус ийш тийшээ өрвийнө. Харри гайхсан харцаа авдар дотор унтаж байсан Грюмээс өрөөний шалан дээр хэвтэж байгаа Грюм руу шилжүүлэв.

Дамблдор авдар руу болгоомжтой үсрэн бууж унтаж байгаа Грюм руу бөхийв.

- Имперуус шидийн нөлөөн дор хөшөөчихөж... маш их суларч доройтсон байна. Мэдээж түүнд амьдаараа хэрэгтэй байсан. Харри надад хууран мэхлэгчийн жанчыг аваад өгөөч. Аластор хүйтэнд бүр бээрчихэж. Хатагтай Помфри түүнийг харж аюул заналхийлэх юмгүй болгоно.

Харри жанчыг өглөө. Дамблдор Грюмыг хучаад авдраас гарлаа. Тэр ширээн дээр байсан Грюмын дашмагыг авч тагыг нь онгойлгон болгоомжтойгоор тонгойлгов. Шалан дээр өтгөн шингэн асгарлаа.

- Хувиргагч уусмал, Харри. Ямар ухаалаг бодсоныг харж байна уу? Жинхэнэ Грюм үргэлж өөрийнхөө дашмагаас уудаг байсан юм. Тэр үүнийг ашиглажээ. Энэ дашмагт Хувиргагч уусмалаа хийсэн байна. Нэр зээлдэгчид уусмалаа хийхэд нөөц шаардагдаж байсан болохоор жинхэнэ Грюмыг гарын дороо байлгаж байсан байна. Үс нь урт богино янз бүрийг харж байна уу. Хууран мэхлэгч жилийн турш тайрчээ. Гэхдээ өнөө шөнө тэр баярласандаа уусмалаа мартсан гэж бодож байна. Түүнд цаг тутамд хэрэг болж байж.. Харцгаая л даа.

Дамблдор сандал дээр хөдөлгөөнгүй суугаад газар хэвтэж байгаа Грюмыг нүд салгалгүй ажиглана. Харри бас харлаа. Хормууд чимээгүй өнгөрсөөр.

Удалгүй Харрийн нүдэн дээр шалан дээр хэвтэж байгаа хүний царай өөрчлөгдөв. Сорви алга болж, арьс нь толийн, зэрэмдэг хамар нь багасаж ердийн хэвэндээ оров. Урт буурал үс нь богиносож өнгө нь хувирлаа. Модон хөл шалан дээр унаж оронд нь амьд хөл түргэн ургав. Ахин нэг агшины дараа шидэт нүд ойчиж түүний байрыг ердийн нүд эзэллээ. Шидэт нүд газар унаад эргэлдэн ийш тийшээ харахаа больсонгүй.

Харрийн өмнө цонхигор царайтай богинохон цайвар үстэй сэвхтэй эрэгтэй хүн хэвтэж байв. Харри түүнийг танилаа. Түүнийг Дамблдорын оюун ухааны цүнхээлд харсан билээ. Дементорууд түүнийг танхимаас гаргахад ноён Краучид ямар ч буруугүй гэж хашгирч байсан... Гэхдээ түүний нүдэнд үрчлээ тогтож илүү нас ахисан харагдана.

Хонгилд түргэн алхах чимээ сонсогдов. Эхлээд Снегг түүний хажууд Винки араас нь профессор МакГонагалл орж ирлээ.

- Крауч! Барти Крауч! гэж Снегг хаалган дээр зогсоод дуу алдав

- Бурхан минь! гээд профессор МакГонагалл үүдэн дээр хөшиж газар хэвтэж байгаа хүнээс нүд салгасангүй.

Бохир навсгар Винки Снеггийн хөлний цаанаас цухуйж часхийн дуугарлаа.

- Ноён Барти, ноён Барти та энд юу хийж байгаа юм бэ?

- Чи түүнийг алсан! Чи түүнийг алсан! Хүү нь миний эзнийг алсан! гэж тэр Краучын цээж рүү асаж хашгирлаа.

- Тэр хөшчихсөн байна, Винки. Холдож бай. Северус та уусмал авчирсан уу?

Снегг Дамблдор Харрийг сүрдүүлж байсан Үнэнийг хэлүүлэгч уусмал бүхий тунгалаг шингэнтэй хуруу шил гарган өглөө. Дамблдор залуу Крауч руу бөхийн хана түшүүлэн суулгахад Дайсан илрүүлэгч толин дээр Дамблдор, Снегг, МакГонагалл нарын царай тусав. Винки алгаараа нүүрээ даран чичирлээ. Дамблдор Краучын амыг хүчээр онгойлгоод гурван дусал хийв. Дараа нь саваагаар цээж рүү нь хатгаад,

- Сэргэ! гэв.

Краучын хүү нүдээ нээв. Царай нь хоосорч харц нь зүг бүрт үсчинэ. Дамблдор түүнтэй нэг түвшинд өвдөг дээрээ суугаад,

- Чи намайг сонсож байна уу? гэж аяархан асуув.

- Тиймээ гэж тэр маш аяархан хэлэв.

- Чи яаж энд ирснээ бидэнд хэлээч. Чи Азкабанаас яаж зугтсан юм бэ?

Крауч гүнзгий амьсгал аван чичирснээ сэтгэлийн хөдлөлгүй хоолойгоор хөврүүлэв,

- Намайг ээж минь аварсан юм. Тэр үхнэ гэдгээ мэдэж байсан. Тэр эцгээс намайг аврахыг гуйсан. Тэр түүнд юунаас ч илүү хайртай байсан. Тэгээд зөвшөөрсөн. Тэд намайг эргэхээр ирсэн. Эхийн үстэй Хувиргагч уусмал өгсөн. Харин тэр минийхийг уусан. Ингэж бидний гадаад байдал солигдсон.

Винки чичирсэн хэвээр ууртайгаар толгой сэгсэрч,

- Ноён Бартигийн тухай үг бүү хэл. Та эцгээ зовлонд унагаж байна гэв.

Крауч ахин нэг гүнзгий амьсгал аваад цааш үргэлжлүүлэн,

- Дементорууд мэдээгүй. Тэд Азкабанд нэг нь эрүүл нөгөө нь үхэж байгаа хоёр хүн орсныг мэдсэн. Дараа нь нэг эрүүл, нэг үхэж байгаа хүн гарсан. Биднийг торны цаанаас өөр хэрэгтэнүүд ширтэж байсан учир эцэг надад ээжийн дашинзыг өмсүүлэн гаргасан.

- Ээж үүний дараа үхсэн. Тэр Хувиргагч уусмалыг үхэхийнхээ өмнө хэрэглэсэн. Түүнийг миний нэр болон гадаад байдалтайгаар оршуулсан. Бүгд түүнийг намайг гэдэгт итгэлтэй байсан гэв.

Крауч ахин нүдээ анивчив.

- Эцэг чинь чамайг гэртээ авчирсан хойноо яасан бэ? гэж Дамблдор чимээгүйхэн асуув.

- Ээжийн үхлийг хуурамчаар зохион байгуулсан. Чимээгүй гэр бүлийн оршуулга болсон. Түүнийг хоосон оршуулсан. Манай үйлчлэгч намайг асарч байсан. Дараа нь намайг удтал нуусан. Би хүчтэй хяналтан дор байсан. Аав намайг дийлэхийн тулд янз бүрийн шид ашигласан. Миний хүч эргэн ирэхэд би зөвхөн яаж эзнээ олох тухай бодож байлаа... Түүнд ахин зүтгэхийг хүссэн юм.

- Эцэг чинь чамайг яаж хянаж байсан юм бэ?

- Имperiус шившлэг. Би бүрэн дүүрэн түүний хяналтанд байсан. Хүчээр ямагт үл үзэгдэх цув өмсдөг байлаа. Үргэлж гэрийн үйлчлэгчтэйгээ хамт байдаг байсан. Тэр намайг харж санаа тавьдаг байсан. Намайг өрөвдсөн. Эцгээс хааяа намайг зугаацуулж байхыг гуйсан. Намайг биеэ сайн авч явсны төлөө.

- Ноён Барти, ноён Барти түүний тухай бүү ярь бид зовлонд унана гэж Винки нулимс урсган алганы завсраар харж хэллээ.

- Чамайг амьд гэдгийг өөр хэн мэдэж байсан бэ? Чиний эцэг болон гэрийн үйлчлэгчээс чинь өөр хүн мэдэж байсан уу? гэж Дамблдор аяархан асуув.

- Тиймээ. Миний эцгийн хэлтсийн нэг шидтэн мэдэж байсан. Берта Жоркинс. Тэр манай гэрт эцэгт бичиг баримтанд гарын үсэг зуруулахаар ирсэн. Тэр гэртээ байгаагүй. Винки түүнийг эцгийн өрөөнд оруулаад гал зуух руу над дээр эргэж ирсэн. Гэхдээ Берта Винкигийн надтай ярихыг сонсчихсон. Сонсоод хэн үл үзэгдэх цуван дор нуугдаж байгааг тааварласан. Аав гэртээ эргэн ирсэн. Берта түүнийг буруутгасан юм. Тэр хүчирхэг шид болох Ой ухааны шидийг хэрэглэж бүхнийг мартуулсан. Хэтэрхий хүчтэй. Тэр хэлэхдээ түүний ой ухаан үргэлж ийм байна гэсэн.

- Тэр яах гэж миний эзний хэрэгт хошуугаа дүрсэн юм? Тэр яагаад биднийг тайван орхиж болоогүй юм? гэж Винки үргэлжлүүлэн мэгшив.

- Одоо надад Дэлхийн цомын тэмцээний тухай ярь гэж Дамблдор хэллээ.

- Винки эцэгтэй ярьсан юм. Түүнийг хагас жил ятгасан. Би гэрээс удаан хугацаанд гараагүй байсан. Би квиддичид дуртай. Тэр намайг харж байна гэж хэлсэн. Үл үзэгдэх цувтай байлгана гэж. Түүнд цэвэр агаар хэрэгтэй гэсэн. Ээж минь үүнийг хүсч байсан гэж хэлсэн. Ээж минь үхэхийнхээ өмнө надад эрх чөлөө өгөхийг хүсч байсан гэж хэлсэн. Намайг цоожтой суулгахын төлөө авраагүй гэж хэлсэн. Эцэг эцэст нь зөвшөөрсөн.

- Бүгдийг болгоомжтой төлөвлөсөн. Эцэг өглөө намайг Винкигийн хамт дээд талын суудалд аваачсан. Винки миний эцэгт суудал хадгалж байгаа гэж хэлэх ёстой байсан. Харин энэ суудал дээр би үл үзэгдэх цув өмсөөд сууж байсан. Хүмүүс Винкиг ганцаараа сууж байна гэж бодсон юм. Хэн ч мэдээгүй.

- Гэхдээ Винки намайг хүчтэй болсон гэж мэдээгүй. Эцгийн илгээсэн Империусын эсрэг хэдийн тэмцэх чадвартай болоод байсан. Богино хугацааны дараа түүний хяналтнаас мултарч гарах байлаа. Дээд талын суудал дээр би гүн нойронд автсан юм шиг байсан. Би хүмүүсийн дунд суугаад тэмцээн үзэж байлаа. Би гэнэтхэн урдаа суугаа хүүгийн халааснаас шидэт саваа цухуйж байхыг харсан. Шүүхээс надад шидэт саваа хэрэглэхийг зөвшөөрөөгүй. Би түүнийг хулгайлсан. Винки хараагүй. Тэр өндрөөс айдаг юм. Тэр нүүрээ алгаараа дараад сууж байсан.

- Ноён Барти муу хүү! гэж Винки нулимс дуслуулан шивнэлээ.

- Тэгэхээр чи савааг авсан юм байж. Түүгээр юу хийсэн бэ? гэж Дамблдор хэлэв.

- Бид майхан руугаа буцсан. Дараа нь тэднийг сонссон юм. Бид Үхэл залгигчдыг сонссон. Тэд хэзээ ч Азкабанд байгаагүй. Хэн ч эзнийхээ төлөө нэг ч хором зовоогүй. Тэд түүнд эргэж очоогүй. Тэд миний адил бусдын хяналтанд байгаагүй. Эрж олж чадах байсан ч хүсээгүй. Тэд зүгээр л маглуудыг даажигнаж байсан. Тэдний хоолой намайг сэрээсэн миний ухаан бараг цэлмээд байсан. Би уурласан. Надад саваа байсан. Би эзнээсээ урвагчдыг дайрахыг хүссэн. Эцэг майхнаас гараад маглуудад туслахаар яарсан юм. Винки намайг хэрхэн уурлахыг хараад айсан. Тэр өөрийнхөө шидийг ашиглан надтай өөрийгөө холбосон. Тэр намайг майхнаас түлхэн гарч ой дундуур Үхэл залгигчдаас холдсон. Би түүнийг эсэргүүцэхийг хүссэн. Буудал эргэж очихыг хүсэж байлаа. Үхэл залгигчдыг Хар лордоос урвасных нь төлөө шийтгэхийг хүссэн юм. Ингээд би хулгайлсан саваагаараа тэнгэрт Хар тамга илгээсэн.

- Яамны шидтэнгүүд ирсэн. Эргэн тойрон Хөшөөх шившлэг илгээгдсэн. Нэг шившлэг бидний нуугдаж байсан газар болох мод руу ирсэн. Бидний холбоо тайлагдсан. Бид хамтдаа хөшчихсэн.

- Винкиг олох үед эцэг намайг хаа нэгтээ ойрхон байгаа гэдгийг ойлгосон. Тэр намайг бутан дундаас хайгаад олсон. Тэр яамны шидтэнгүүдийг ойгоос явахыг хүлээсэн. Ахин надад Империус хэрэглээд гэртээ аваачсан. Тэр Винкиг хөөсөн. Түүнийг болж би саваатай болсон. Бас арай л зугтаагүй.

Винки цөхрөн уйллаа.

- Бид гэртээ хоёулхнаа үлдсэн. Тэгтэл... тэгтэл... гээд Крачын нүүрэнд ухаангүй инээд тодров.

- Над дээр миний эзэн ирсэн. Тэр бидэн дээр зарц Сүүлтийнхээ гар дээр ирсэн. Эзэн намайг амьд гэдгийг мэдэж байсан. Тэр Берта Жоркинсыг Албанид барьж авсан юм билээ. Тэр түүнд олон зүйлийг хэлсэн байсан. Гурван шидтэний тэмцээний тухай, Хогвартет хөшин мракоборец Грюм багшилах гэж байгаа тухай хэлсэн байсан. Тэр түүнийг тамлахад миний эцгийн илгээсэн Ой ухааны шид эвдэгдсэн байсан. Тэр түүнд намайг Азкабанаас зугтсан гэж хэлсэн. Эцэг намайг эзэндээ зугтах боломж олголгүй цоожтой байлгаж байгаа гэж хэлсэн. Ингэж л эзэн түүний үнэнч зарц магадгүй хамгаас үнэнч зарц нь байгааг мэдсэн юм даа. Энэ бол би. Бертагаас сонссон мэдээний дагуу эзэн төлөвлөгөө зохиосон. Түүнийг биелүүлэхэд би хэрэгтэй байлаа. Тэр бидэн дээр шөнө дунд ирсэн. Эцэг хаалга онгойлгосон.

Крауч амьдралын хамгийн аз жаргалтай өдрөө санаж байна уу гэлтэй нүүр дүүрэн инээмсэглэв. Харин Винки айж хирдхийсэн байдалтай нүдээ бүлтийлгэн хурууны завсраараа харна.

- Бүх зүйл түргэн болсон. Эзэн Имperiуcыг миний эцэгт илгээсэн. Одоо эцэг өөрөө бусдын хяналтанд орсон. Эзэн түүнийг юу ч болоогүй юм шиг хүчээр өдөр тутмын ажлыг нь хийлгэж байсан. Харин би чөлөөтэй болсон. Би сэрсэн. Олон жилийн дараа анх удаа өөрийнхөөрөө байж чадах боллоо.

- Лорд Волан-де-Морт чамд юу тушаасан бэ? гэж Дамблдор асуулаа.

- Надаас түүний төлөө эрсдэлд ороход бэлэн байна уу гэж асуусан. Би бэлэн байсан. Би энэ тухай мөрөөдөөж байсан. Энэ дэлхий дээр юунаас ч илүү үнэнч байдлаа үзүүлэхийг хүссэн. Тэр Хогвартет үнэнч зарц хэрэгтэй байгаа гэж хэлсэн. Зарц ажиглагдахгүйгээр Харри Поттерыг Гурван шидтэний тэмцээнд оруулах ёстой байсан. Зарц Харри Поттерыг харж байх ёстой байлаа. Түүнийг Гурван шидтэний цомд хүргэх ёстой байсан. Цомыг зөөвөрлөгч болгож хувирган түүнд хүрсэн хэнийг ч болов эзэн рүү аваачих ёстой байсан. Гэхдээ эхлээд...

- Та нарт Аластор Грюм хэрэг болсон гэж Дамблдор түүний яриаг таслан дуугарлаа. Түүний хоолой тайван байсан ч цэнхэр нүдэнд нь уур хилэн дүрэлзэнэ.

- Сүүлт бид хоёр хийсэн. Урьдчилж Хувиргагч уусмал бэлдсэн. Түүний гэр лүү очсон. Грюми урдаас эсэргүүцэж бөөн чимээ шуугиан болсон. Бид түүнийг дийлсэн. Хүчээр шидэт авдар луу нь хийсэн. Түүний толгойноос хэдэн үс тасдаж аваад би уусмалд хийсэн юм. Уугаад хоёр дахь Грюм болсон. Түүний хөл болон нүдийг авсан. Тэгээд маглуудыг тайвшируулахаар ирсэн Артур Уизлитай уулзсан. Би хогийн савыг хашаа руу гарган тавьсан. Артур Уизлид хэн нэгэн миний хашаанд нэвтрэх гээд хогийн савыг дэлбэлсэн гэж хэлсэн. Дараа нь би Грюмын хувцасыг баглаад бүх илрүүлэгчийг нь авч авдарт хийн Хогвартет ирсэн. Би түүнийг Имperiуc шившлэгийн тусламжтай амьд байлгаж байсан. Надад түүнээс олон зүйл мэдэх хэрэгтэй байсан. Түүний зан байдлыг суралцахад Дамблдор юу ч ажиглаагүй. Түүний үс цаг үргэлж Хувиргагч уусмалд хэрэг болж байлаа. Бусад орцууд нь

амархан олдсон. Бумслангын арьсыг Снеггээс авсан. Уусмалын профессор намайг өрөөндөө оруулахгүй гэхээр нь нэгжлэг хийхийг тушаасан гэж хэлсэн.

- Сүүлт Грюмыг дайрсныхаа дараа яасан бэ?

- Сүүлт манай гэр лүү очиж эцэгт эзний хамт анхаарал тавьж байх ёстой байсан.

- Гэхдээ эцэг чинь зугтсан гэж Дамблдор хэлэв.

- Тиймээ. Хэсэг хугацааны дараа тэр шидийг миний адил эсэргүүцэж эхэлсэн. Нэг өдөр л тэр юу болоод байгааг ойлгосон. Тэр үед эзэн аюулгүй байдлын тулд эцгийг гэрээс гаргаж болохгүй гэж шийдсэн байлаа. Түүгээр захиа бичүүлж ид шидийн яаманд илгээсэн. Түүнийг өвдсөн гэж бичсэн. Гэхдээ Сүүлтийн үүргээ хайнга биелүүлсэн. Тэр сайн хараагүй. Эцэг зугтсан. Эзэн түүний Хогвартс руу ирж байгааг тааварласан. Эцэг бүгдийн тухай Дамблдорт хэлэхийг хүсэж байсан. Намайг Азкабанаас сулласан тухайгаа хэлэх гэж байсан.

- Эзэн надад эцгийн зугтсан тухай хэлсэн. Ямар ч үнээр хамаагүй түүнийг зогсоохыг тушаасан. Би хүлээгээд харж байсан. Харри Поттероос авсан газрын зургийг ашигласан юм. Зураг байхгүй бол төлөвлөгөө бүтэхгүй байсан.

- Газрын зураг гэнэ ээ? Юун зураг билээ? гэж Дамблдор түргэн асуулаа.

- Хогвартсын газрын зураг. Тэр Поттерт байсан. Поттер түүн дээр намайг харсан юм билээ. Поттер намайг Снеггийн өрөөнөөс Хувиргагч уумалын орц хулгайлж байхад харсан. Тэгээд бид адилхан нэртэй учир миний эцэг байна гэж бодсон. Тэр үед би Поттероос газрын зургийг авсан. Би түүнд аав хар шидтэнгүүдийг үзэн яддаг гэж хэлсэн. Поттер миний эцэг Снеггийн араас явж байгаа гэж итгэсэн.

- Бүтэн долоо хоногийн турш би эцэг Хогвартст ирэхийг хүлээсэн. Нэг орой газрын зураг дээр эцэг гарч ирсэн. Би үл үзэгдэх цув өмсөөд түүнийг угтан явсан. Тэр Хориотой ойн захаар явсан. Дараа нь Поттер, Крам хоёр гарч ирсэн. Би хүлээсэн. Поттерыг дайрч болохгүй байлаа. Тэр миний эзэнд бүтнээрээ хэрэгтэй байсан. Поттер Дамблдорын араас гүйсэн. Би Крамыг хөшөөсөн юм. Тэгээд эцгээ алсан.

- Үгүй э-э-э-э! Ноён Барти, та юу яриад байна? гэж Винки орилов.

- Тэгэхээр чи эцгийгээ алсан юм байж. Түүнийг биеийг яасан бэ? Дамблдор аяархан хоолойгоор асуув.

- Ойд орхисон. Үл үзэгдэх цуваар хучаад тавьсан. Надад газрын зураг байсан. Би Поттер шилтгээн рүү гүйхийг харсан. Тэр Снеггтэй уулзсан. Түүний дараахан Дамблдортой нэгдсэн. Би Поттер хэрхэн шилтгээнээс Дамблдортой цуг гүйж гарахыг харсан юм. Би ойгоос гарч араас нь гүйцсэн. Дамблдорт Снегг намайг хаашаа явахыг хэлсэн гэж хэлсэн.

- Дамблдор надад эцгийгээ хайхыг тушаасан. Би түүний бие рүү эргэж очсон. Дараа нь газрын зураг руу харсан. Бүгд явсан хойно би эцгийн биеийг хувиргасан. Түүнийг яс болгон хувиргасан юм... Үл үзэгдэх цуваа өмсөөд ясыг Хагридын овоохойн өмнөх газар булсан.

Өрөөнд Винкигийн уйлах чимээнээс ондоо дуу гаралгүй нам гүм боллоо.

- Харин өнөө үдэш... гэж Дамблдор дуугарав.

- Би Гурван шидтэний цомыг төөрдөг байшинд аваачиж тавьсан. Тэгээд түүнийг зөөвөрлөгч болгон хувиргасан. Миний эзний төлөвлөгөө биелсэн. Эзэн хүчтэй болоход би ямар ч шидтэний мөрөөдөж зүрхлэхгүй зүйлээр шагнуулах байлаа.

Түүний царайд ахин ухаангүй инээмсэглэл тодроод толгой нь мөрөн дээрээ унжив. Түүний хажуугийн шалан дээр Винки суугаад цурхиран сууж байлаа.

БҮЛЭГ 36: ЗАМ САЛАВ

Дамблдор дээшээ босоод Бартиг Краучыг жигшил дүүрэн харцаар ажиглав. Тэр саваагаа даллан олс гаргаад Бартиг чанга хүлэв.

Тэгээд профессор МакГонагалл руу эргэлээ.

- Минерва минь, Харриг дээш нь аваачих хүртэл түүнийг харж байхгүй юу?
- Тэгэлгүй яхав гэж профессор МакГонагалл хэлэв. Тэр бөөлжис цутгам зүйл харж байгаа аятай саваагаа зэвүүцэнгүй Барти Крауч руу чиглүүлэн барилаа.
- Северус, хатагтай Помфриг ийшээ ирэхийг гуйгаач. Аластор Грюмыг эмнэлэгт хүргэх хэрэгтэй байна. Дараа нь гадагшаа гарч Корнелиус Фажыг ийш нь ирэхийг уриарай. Тэр Краучыг өөрийн биеэр байцаахыг хүсэх байх. Хэрвээ түүнд би шаардагдвал хагас цагийн дараа эмнэлэгт байна гэж хэлээрэй.

Снегг чимээгүйхэн толгой дохиод өрөөнөөс гарав.

- Харри? гэж Дамблдор аяархан хэллээ.

Харри босоод ахин найгалаа. Тэр Барти Краучаас сонссон яриандаа болоод өвчтэй хөлөө мартсан байв. Гэвч одоо өвдөлт ахин ирж чичирч байлаа. Дамблдор гарнаас нь барилаа.

- Эхлээд миний өрөө рүү явцгаая, Харри. Тэнд биднийг Сириус хүлээж байгаа гэж тэр аяархан хэлэв.

Харри толгой дохилоо. Тэр болсон явдалд бүх бие нь цуцан мэдээ алдаж байсан ч гэлээ түүнд хамаагүй байлаа. Тэр цомонд хэрхэн хүрсэн тухай бодохыг хүссэнгүй. Ой ухаанд нь байгаа гэрэл зураг шиг хурц дүр зургуудийг санахыг хүсэхгүй байлаа. Хурц нүдэт Грюм авдрандаа хэвтэж, Сүүлт мухар гартайгаа атиралдан хэвтэж байгаа. Волан-де-морт тогооноос гарч ирч байгаа. Седрикийн хий үзэгдэл түүнээс эцэг эхдээ биеийг нь аваачиж өгөхийг гуйж байгаа.

- Профессор ноён ба хатагтай Диггори хаана байгаа юм бэ?

- Тэд профессор Стебльтэй хамт байгаа. Тэр Седрикийн тэнхимийн эрхлэгч болохоор түүнийг биднээс илүү мэднэ гэж Дамблдор хэлэхэд Краучтай ярьсан ярианы туршид тайван байсан хоолой чичирлээ.

Чулуун луу руу очиход Дамблдор нууц үгийг хэлээд гарц нээгдэж хөдөлдөг эргүүлгэн шатаар өгслөө. Дамблдор царсан хаалгыг түлхэв.

Өрөөний голд Сириус зогсоод царай нь Азкабанаас зугтсан үеийнх шигээ эцэнхий цонхигор харагдана. Тэр Харри руу ухасхийв.

- Харри, чи зүгээр үү? Би ямар нэг юм болно гэж мэдэж байсан юм. Юу болсон бэ?

Тэр чичирсэн гараараа Харриг Дамблдорын ширээний өмнөх сандалд суулгав.

- Юу болсон бэ? гэж тэр шаардангуй давтан асуулаа.

Дамблдор Сириуст Барти Краучаас мэдсэн бүхнийг ярилаа. Харри хагасыг нь сонслоо. Тэр эцэж ядарсандаа бүх бие нь янгинаж сандал дээр сууж байхдаа нойрноос өөр юу ч бодсонгүй.

Толгой дээр нь далавчны зөөлөн дэвэлт сонсогдов. Галт шувуу Фоукс хонуур дээрээсээ Харрийн өвдөг дээр буув.

- Сайн уу, Фоукс гэж Харри шивнээд алтлаг өд сөдийг нь илбэв. Фоукс нүдээ анивчаад ухаалаг нүдээрээ ширтэв. Дулаахан галт шувуу өвдөг дээр нь суух аятайхан байлаа.

Дамблдор чимээгүй болов. Тэр ширээндээ суугаад Харрийн царай луу ширтлээ. Харри түүнээс нүд буруулахыг оролдов. Дамблдор түүнээс асуух болно. Тэгвэл Харри бүгдийг санахад хүрнэ.

- Харри чи төөрдөг байшинд зөөвөрлөгчид хүрсний дараа юу болсныг мэдэх хэрэгтэй байна гэж Дамблдор хэлэв.

- Энэ бүхнийг өглөө болж болохгүй юу, Дамблдор? Тэр унтаж амарсан нь дээр байх гэж Сириус сөөнгөтөн хэлээд гараа Харрийн мөрөн дээр тавилаа.

Харри Сириуст талархсан ч Дамблдор сонсоогүй аятай түүн рүү бөхийлөө. Харри Дамблдорын гүн цэнхэр нүд юу хүсч байгааг арайхийн ойлголоо.

- Харри чамд нойрсуулах шид туслана гэдгийг мэдэж байна. Гэхдээ энэ нь тийм биш. Тэд санаа амралтыг авчирахгүй. Өвдөлт намдсан ч дараагийн удаа тэсэхийн аргагүй болно. Чи өнөөдөр гайхамшигтай зүрх зориг үзүүлсэн болохоор ахин нэг удаа үзүүлэхийг гуйж байна. Юу болсныг яриач.

Феникс аяархан долгиолсон чимээ гаргахад Харри амьдралын шингэнд булхах шиг болж дотор нь халуу оргиж хүч нэмэгдлээ.

Тэр гүнзгий санаа алдаад ярьж эхлэхэд дүр зураг ахин нүдний өмнө эрээлжлэн үзэгдэв. Тэр оргилон буцалж байсан уусмал, Волан-де-Мортын сэргэсэн, хэрхэн Үхэл залгигчид оршуулгын газар ирсэн, Седрикийн бие цомын дэргэд хэвтэж байсан гээд л бүгдийг ярилаа.

Хоёр гурван удаа Сириус юм хэлэхийг хүссэн ч Дамблдор занган болиулав. Харрид зогсолтгүй ярих нь амар байсан болохоор үүнд талархжээ. Ярихад хүнд байсан ч зүрх нь амрахыг мэдэрлээ.

Харри Сүүлт гарыг нь хутгаар зүссэн тухай ярихад Сириус ууртайгаар дуу алдаж, Дамблдор цочтол үсрэн босоод гараа үзүүлэхийг хүсэв.

Харри урагдсан жанчны дорх шархаа үзүүлэв.

- Тэр миний цус түүнд хүч чадал өгнө гэсэн. Миний ээжийн үлдээсэн хамгаалалт түүнийг бас хамгаална гэсэн. Энэ үнэн байсан тэр миний нүүрэнд хүрсэн.

Агшин зуур Харрид Дамблдорын нүдэнд ялалтын оч гялсхийх шиг санагджээ. Гэвч дараагийн агшинд Дамблдор суудал дээрээ буцан суугаад ядарсан хөгшин хэвээр харагдав.

- Тэгэхээр Волан-де-Морт энэ саадыг давсан юм байж. Үргэлжлүүл Харри, үргэлжлүүл.

Харри үргэлжлүүллээ. Волан-де-Морт тогооноосоо хэрхэн гарч ирсэн тухай, Үхэл залгигчидад юу гэж хэлсэн тухай, Сүүлтэд түүнд савааг эргүүлэн өгөхийг тушаасан тухай ярилаа. Түүнчлэн халз тулаан хийхэд шидэт савааны оч нэгдэж алтан утас үүсгэсэн тухай ярьтал хоолойд нь юм тээглэж цааш нь үргэлжлүүлж чадсангүй. Ой ухаанд нь Хар лордын саваанаас гарсан хий үзэгдлүүд орж иржээ. Тэр ахиад л Седрик, үл таних хөгшин, Берта Жоркинс... эцэг... эхээ харлаа.

Харри Сириус нам гүмийг эвдсэн явдалд баяртай байв.

- Саваа нэгдсэн гэнээ? Яагаад? гээд Дамблдор луу харлаа.

Харри Дамблдор руу харлаа. Захирал гүн бодолд автан сууж байв.

- Эртний шившлэг. Тэдний хооронд үл үзэгдэх гүүр боссон байна гэж бараг сонсогдохгүй шахам хэлээд Харри руу харлаа.

- Урвуу үйлчилсэн хэрэг үү? гэж Сириус асуув.

- Тиймээ. Харрийн саваа, Волан-де-Морт-ын саваатай адилхан шидэт шүншлэгтэй. Тус бүрд нь галт шувууны сүүл байгаа. Энэ шувууны гэж Дамблдор хэлээд Харрийн өвдөг дээр сууж байгаа алтлаг шувуу руу харлаа.

- Миний саваанд Фокусын өд байгаа гэнээ? хэмээн Харри гайхлаа.

- Тиймээ. Чамайг ноён Олливандерийн дэлгүүрээс дөрвөн жилийн өмнө худалдан авахад хоёр дахь савааг чи авсан гэж надад мэдэгдсэн юм.

- Энэ шөнө саваанууд уулзжээ... ийм тохиолдолд юу болох вэ? гэж Сириус асуув.

- Тэд нэг нэгнийхээ эсрэг тэмцэж чадахгүй. Хэрвээ эзэд нь тэднийг тэмцэлд хэрэглэвэл маш ховор тохиолдол болно. Нэг нь нөгөөгийнхөө шидийг буцааж урвуулна. Ар араас нь цаашид гэх мэт. Ийм учраас л Седрик түрүүнд нь гарч ирсэн хэрэг гээд Харри руу харахад толгой дохилоо.

- Диггори амилсан гэж үү? хэмээн Сириус огцом асуулаа.

- Үхсэн хүнийг ямар ч шившлэг амилуулж чадахгүй. Саваанаас болсон явдлын хуулбар гарч ирнэ. Энэ удаад түрүүлж Седрикийн хий үзэгдэл гарч иржээ...

- Тэр надтай ярьсан. Седрикийн хий үзэгдэл өөр юу ч байсан... гээд Харри чичирлээ.

- Хий үзэгдэл Седрикийн гадна төрх болон зан аашийг хадгалсан байдаг юм. Дараа нь би Волан-де-Мортын хохирогч болох өөр сүнснүүд гарч ирсэн гэж таамаглаж байна...

- Хөгшин өвгөн. Берта Жоркинс. Бас... гэж Харри арайхийн хэлэв.

- Чиний эцэг эх үү? гэж Дамблдор аяархан асуулаа.

- Тиймээ.

Сириус мөрийг нь өвдтөл базлаа.

- Энэ бол савааны хийсэн сүүлчийн аллага. Хэрвээ холболтыг таслаагүй бол өшөө сүнс илүү олон гарч ирэх байлаа. Их сайн байна, Харри. Харин хий үзэгдлүүд... тэд юу хийсэн бэ?

Харри хий үзэгдлүүд хэрхэн саваанаас гарч ирээд алтан торны дотор зогсоход Волан-де-Морт тэднээс айж байсан. Харин эцэг нь юу хийхийг тайлбарлаж, Седрик сүүлчийн гуйлтаа хэлсэн зэргийг ярилаа.

Тэр үргэлжлүүлж чадсангүй. Сириус мөрийг нь тавилаа. Харри дээшээ харахад алгаараа нүүрээ дараад зогсож байлаа.

Феникс Харрийн өвдөгөөс дэрхийн буугаад сүр жавхлантай толгойгоо шархтай хөлд нь хүргэв. Шархан дээр хэдэн хүнд сувдан нулимс унав. Тэгтэл өвчин гараар арчсан юм шиг алга болов. Шарх алга болж арьс эдгэлээ.

- Ахиад нэг удаа хэлэхэд гэж Дамблдор галт шувууг хонуур дээрээ буцан суухад хэлэв,

- Чи өнөөдөр гайхамшигтай эр зориг гаргажээ, Харри. Үнэнийг хэлэхэд чамаас ийм зүйл хүлээж байсангүй. Чи эр хүний ёсоор Волан-де-Морттой эн тэнцүүхэн тулалдсан байна. Харин одоо чи бидний мэдэх ёстой бүх зүйлийг ярилаа. Баярлалаа. Одоо хатагтай Помфри руу очицгооё. Тэнд хоноорой. Чамд нойрсуулдаг уусмал хэрэгтэй. Сириус чи түүнтэй үлдэхийг хүсч байна уу?

Сириус толгой дохиод том хар нохой болон хувирлаа. Гурвуулаа шат уруудан эмнэлэг рүү яарлаа.

Дамблдор хаалга түлхэн нээв. Хатагтай Помфри Уизлийн гэр бүлийнхэнтэй түгшсэн байртай зогсож байв. Хатагтай Уизли, Билл, Рон, Гермиона нар түүн рүү цоо ширтэн байцаах аж. Харри хаана байна? Түүнд юу тохиолдоо вэ?

Хөлийн чимээ сонсоод бүгд эргэж харцгаав.

- Харри! Өө, Харри минь дээ! гээд түүн рүү хатагтай Уизли ухасхийв.

- Молли гэж Дамблдор хатуу хэлээд дунд нь зогслоо.

- Намайг сонсооч гуйя. Харри өнөөдөр аймшигтай хүнд сорилтыг туулсан. Миний өрөөнд бас болсон явдлын талаар ярьсан. Түүнд нам гүм тайван байх хэрэгтэй байна. Хэрвээ Харри хүсвэл та нар үлдэж болно. Зөвхөн өнөөдөртөө ямар ч асуулт битгий тавиарай гээд Рон, Гермиона, Билл нар луу харлаа.

Хатагтай Уизли толгой дохив. Түүний царай шохой шиг цайрчээ.

Тэрбээр чимээгүй зогсож байсан Рон, Гермиона, Билл нар луу эргэн хараад ууртайгаар,

- Чшш! Түүнд амралт хэрэгтэй байна гэлээ.

- Ноён захиралаа энэ талаар асууж болох уу?... гэж хатагтай Помфри том хар нохой руу харан хэллээ.

- Энэ нохой хэсэг зуур Харрийн дэргэд байх болно. Тэр маш сайн сургагдсан амьтан гэж би чамд хэлэх байна. Харри орондоо ор гэж Дамблдор энгийнээр өгүүлэв.

Дамблдор түүнийг асуултаас зайлсхийлгэсэн явдалд тэр үгээр хэлэхийн аргагүй талархжээ. Түүнд бүхнийг ахин тайлбарлах хүч байсангүй ч найзууд нь дэргэд байсан явдалд санаа амарч байлаа.

- Би Фажтай ярилцаад эргээд ирье. Бас чамайг маргааш энд үлдээсэй гэж хүсч байна хэмээн Дамблдор хэлээд гараад явчихлаа.

Хатагтай Помфри Харриг орон дээр хэвтүүлэв. Өрөөний алсын буланд жинхэнэ Грюм хөдөлгөөнгүй хэвтээд дэргэдэх шүүгээн дээр нь модон хөл, танил шидэт нүд байлаа.

- Тэр хэр байна? гэж Харри асуулаа.

- Сайн байгаа гээд хатагтай Помфри унтлагын хувцас сунгав.

Харри жанчаа тайлж цамцыг өмсөөд оронд орж хэвтэв. Рон, Гермиона, Билл, хатагтай Уизли болон том хар нохой орны дэргэд нь сууцгаалаа. Харрид ахиад гэнэт ямар нэг юм тохиолдох гэж байгаа аятай Рон, Гермиона хоёрын нүдэнд айдас тодрон үзэгдэнэ.

- Би зүгээр дээ. Зүгээр л маш их ядарлаа.

Хатагтай Уизли нүдэндээ нулимс цийлэгнүүлэн хөнжлийг нь заслаа.

Хатагтай Помфри аягатай ханд барьсаар өрөөнд орж ирэв.

- Харри үүнийг бүгдийг нь уугаарай. Зүүдлэхгүй унтана гэж ширүүн хэлэв.

Харри аягатайг аваад хэд балгатал нүд нь шууд анилдав. Эргэн тойрон утаа шиг сарнин эмнэлгийн гэрэл хөшгөн дундаас нөхөрсгөөр анивчин гийж бие нь зөөлөн дулаан гудас дээр хэвтлээ. Тэр уусмалыг дуусгалгүй ядарсандаа унтчихлаа.

Харри нойрмоглоон сэрэхэд дулаахан их аятайхан байлаа. Тэр зүүдэлж байгаа юм шиг санагдан нүдээ нээхийг хүссэнгүй. Өрөө утаа шиг манантсан хэвээр байсан болохоор нэг их удаан унтаж чадаагүй гэсэн үг.

Дэргэд нь шивнэлт сонсогдов.

- Тэд одоохон болихгүй бол түүнийг сэрээх нь байна.

- Тэд яагаад хашгиралдаад байгаа юм бол? Ямар нэг юм болсон юм болов уу?

Харри нүдээ нээлээ. Хэн нэгэн нүдний шилийг нь авсан болохоор хатагтай Уизли, Билл хоёрын дүрс бүүдгэртэн үзэгдэв.

- Энэ Фажын хоолой байна. Харин энэ Минерва МакГонагаллынх байна! Тэд яагаад маргалдсан юм бол? гэж хатагтай Уизли шивнээд сандлаасаа өндийв.

Одоо Харрид ойртон ирэх хоолой сонсогдлоо.

- Минерва минь, харамсалтай байна... гэж Фаж хаалганы дэргэд ирээд чанга хэлэв.

- Түүнийг шилтгээн рүү оруулах хэрэггүй байсан юм! Дамблдор энэ тухай мэдвэл.. гэж МакГонагалл хашгичлаа.

Өрөөний хаалга саван нээгдэв. Билл хөшгийг нээхэд бүгд үүд рүү харахдаа Харри хэрхэн өндийн сууж шилээ зүүснийг харсангүй.

Өрөөнд Фаж алхлан орж ирлээ. Түүний араас МакГонагалл болон Снегг нар дагалджээ.

- Дамблдор хаа байна? гэж Фаж хатагтай Уизлигаас асуув.

- Тэр энд байхгүй! Энэ бол эмнэлгийн өрөө, сайдаа. Гарсан нь дээр байх... хэмээн тэр уурсан хэлэв.

Хаалга ахин нээгдэж энэ удаад Дамблдор орж ирлээ.

- Юу болоо вэ? Та нар яагаад хүмүүсийн амгалан тайвныг алдуулаад байна? Минерва би гайхаж байна... Би таныг Барти Краучыг харж байхыг гуйсан биз дээ... гэж хэлээд профессор МакГонагалл руу ширүүн харлаа.

- Ингэх шаардлагагүй болсон, Дамблдор! Сайд үүнд санаа тавьсан! гэж тэр дуу алдав.

Харри хэзээ ч профессор МакГонагаллыг ингэтлээ их уурсаж нударга зангидан чичирч байхыг харж байсангүй.

- Бид ноён Фажад Үхэл залгигч баригдсан гэж мэдэгдсэн. Тэр хоёр Дементороор хамгаалуулан орохыг шаардсан. Тэдний хамтаар Барти Краучын хүлээтэй хэвтэж байгаа өрөөнд орж ирээд... хэмээн Снегг аяархан хэлэв.

- Би хатуу эсэргүүцсэн, Дамблдор! Би түүнд нэг ч Дементорыг шилтгээний босго даван оруулж болохгүй гэж хэлсэн гэсэн ч... гэж профессор МакГонагалл хэлэв.

- Хүндэт профессор минь! гэж Фаж унтууцан дуугарав.

- Би ид шидийн яамны сайд болохоор аюултай гэмт хэрэгтэнд асуулт тавихын тулд өөрийгөө хамгаалуулах...

МакГонагалл түүнийг яриаг таслаад,

- Дементорууд өрөөнд орж ирээд Крауч руу ухасхийн тэгээд... гэлээ.

Харрийн дотор хүйт даав. Профессор МакГонагалл болсон явдлыг тайлбарлах тохиромжтой үг эрж байсан ч гэлээ Дементор бага Краучын сэтгэл санааг сорсон нь ойлгомжтой байлаа. Үхлийн үнсэлт үхлээс ч илүү аймшигтай буй за.

- Тэгэх л ёстой байсан юм. Түүнийг нэгээс ч илүү аллаганд буруутгаж байгаа гэж Фаж сүржигнэв.

- Гэхдээ тэр мэдүүлэг өгч чадахааргүй боллоо, Корнелиус. Яагаад эдгээр хүмүүсийг алснаа хэлж чадахааргүй боллоо хэмээн Дамблдор сайдыг анх удаа харж байгаа аятай хэллээ.

- Яагаад алсан гэнээ? Энэ ч тодорхой! Тэр ухаан солиорчихсон хэрэг! Минерва, Сириус хоёрын яриагаар бол Хэцүү нэртийн тушаалыг биелүүлж байгаа гэдэгтээ итгэлтэй байсан гэсэн!

- Тэр үнэхээр Волан-де-Мортын тушаалыг биелүүлж байсан шүү дээ, Корнелиус. Эдгээр хүмүүсийн үхэл урьдчилан төлөвлөсөн гэмт хэргийн золиос болсон. Төлөвлөгөө бүтсэн. Волан-де-Морт өөрийн биеэ олсон.

Фаж эрүүндээ боксын цохилт авсан аятай болов. Тэр Дамблдор руу итгэлгүйхэн алмайран харлаа.

- Хэцүү нэрт... эргэн ирсэн гэнээ? Дэмий яриа! Дамблдор энэ чинь инээдтэй байна...

- Минерва, Сириус хоёр таньд хэлсэн зүйлд эргэлзэх хэрэггүй. Бид өөрийн чихээрээ Барти Краучын үгийг сонссон. Үнэнийг хэлүүлэгч уусмалын нөлөөн дор тэр бидэнд Азкабанаас хэрхэн зугтсан тухайгаа болон болон, Волан-де-Морт түүний чөлөөтэй болсныг Берта Жоркинсоос мэдсэн тухай ярьсан. Ингээд тэр Барти Краучын гэрт ирсэн. Бага Краучыг эцгийнх нь хяналтаас сулласан. Харри Поттерыг яаж барих төлөвлөгөө зохиосон. Төлөвлөгөө бүтсэн. Волан-де-Морт эргэн төрсөн.

- Сонсооч, Дамблдор. Та үнэхээр энэ бүхий дэмий юманд итгэж байгаа хэрэг үү? Хэцүү нэрт ахин төрсөн гэнээ? Боль доо... Крауч Хар лордын тушаалыг биелүүлсэн гэдэгтээ итгэж байсан. Гэхдээ галзуу хүний үгэнд итгэж болох уу? гэж Фаж гайхширан хэлээд үл мэдэг инээмсэглэв.

- Харри төөрдөг байшинд Гурван шидтэний цомд хүрэхэд шууд Волан-де-Морт руу аваачсан байна. Харри өөрийн нүдээрээ Лорд Волан-де-Морт эргэн төрөлтийн гэрч болсон. Миний өрөө рүү явцгаая би таньд бүгдийг тайлбарлая.

Харри унтаагүй байхыг хараад Дамблдор толгойгоо сэгсэрч,

- Би таныг өнөөдөр Харригаас юм асуухыг зөвшөөрөхгүй гэж айж байна гэв.

Фаж хүлцэнгүй инээмсэглэсээр байв. Тэр бас Харриг харлаа.

- Та... э-э... энэ хүүгийн ярианд итгэж байгаа юм уу? гэж Дамблдор хэллээ.

Тэр агшинд бүгд чимээгүй болж нам гүмийг зөвхөн Фаж руу хурц соёогоо яралзуулан архирах Сириусын хүрхэрэлт эвдэнэ.

- Мэдээж итгэж байна. Би Краучын мэдүүлэг болон Харригийн Гурван шидтэний цомонд хүрсний дараа юу болсныг сонссон. Бүх түүх адил байгаа бөгөөд эцэстээ Берта Жоркинс яагаад өнгөрсөн зун алга болсон дүр зураг тодорч байна.

Фаж ахиад л Харри руу хачирхалтай инээмсэглэв.

- Та Лорд Волан-де-Мортын эргэж ирсэн гэсэн галзуу солиотой хүний үгэнд болон энэ хүүд... итгэж байгаа хэрэг үү...

Фаж ахиад л Харри руу харахад тэр бүхнийг ойлголоо.

- Та Рита Скитерийн нийтлэлийг уншаа юу, ноён Фаж? гэж аяархан асуулаа.

Рон, Гермиона, хатагтай Уизли, Билл нар түүн рүү эргэн харцгаав. Тэд Харриг унтаагүй гэдгийг мэдсэнгүй.

Фаж үл мэдэгхэн улайсан ч Дамблдор руу зөрүүдлэн ширтэв.

- Тиймээ уншсан! Тэгээд хүүгийн талаар нууцалж байсан шинэ юм мэдсэн шүү. Тэгэхээр Харри могойн хэлтэй шидтэн юм биз дээ? Хэрвээ түүний бүх хачирхалтай мэдэгдэл унадаг өвчнөөс болж...

- Та Харригийн сорви сүүлийн үед үргэлж өвдөж байгаа гэж хэлэх гээ юу? хэмээн Дамблдор хүйтнээр асуулаа.

- Үүнийг түүний толгойны өвчин баталж байгаа юм биш үү? Шөнийн хар дарсан зүүд үү? Эсвэл хий юм харсан хэрэг үү?

- Намайг сонс, Корнелиус гээд Дамблдор түүн рүү алхахад дээр өрөөнд залуу Краучид ихээхэн хүч гарзасан нь харагдав.

- Харри бидэн шиг л эрүүл. Түүний духан дээрх сорви тархинд нь нөлөөлөөгүй. Тиймээ Лорд Волан-де-Морт ойрхон ирэх юм уу аллага хийвэл сорви нь өвддөг юм.

Фаж гэжүүдлэхээ болиод алхам ухарлаа.

- Өршөөгөөрэй, Дамблдор би эртнээс хараалаар үүссэн сорви аюул ослын дохио өгдөг гэж хэзээ ч сонсож байсангүй.

- Гэхдээ би өөрийнхөө нүдээр Волан-де-Морт яаж төрснийг харсан шүү дээ! Би Үхэл залгигчдыг харсан! Тэдний нэрийг нь ч санаж байна! Люциус малфой... гэж Харри хашгираад орноосоо үсрэн босох гэсэн ч хатагтай Уизли буцаан суулгав.

Снегг давхийлээ. Харри түүн рүү харахад Снегг ахин Фаж руу харав.

- Малфой цагаатгагдсан! Өгөөмөр хандив өгдөг маш эртний гэр бүл... гэж сайд доромжлогдсон байртай уулга алдав.

- Макнейр! гэж Харри үргэлжлүүлэв.

- Бас цагаатгагдсан! Одоо ид шидийн яаманд ажиллаж байгаа!

- Эйвери... Нотт... Крэбб... Гойл...

- Чи арван гурван жилийн өмнө Үхэл залгигч байгаад цагаатгагдсан хүмүүсийн нэрийг хэлж байна! Магадгүй тэдний хуучин түүхийн тухай мэдсэн биз! Бурхны авралаар, Дамблдор... Энэ хүү өнгөрсөн хичээлийн жилийн төгсгөлд бас солиотой түүх ярьж байсан. Түүний түүх улам ухаангүй болж байхад та түүнийг үнэмшиж л байдаг. Тэр могойтой ярьж чаддаг! Тэгсэн ч гэсэн Дамблдор та түүнд итгэж байгаа хэрэг үү?

- Та бол тэнэг! Седрик Диггори! Ноён Крауч! Эдгээр хүмүүсийн үхэл таныхаар бол галзуурсан хэрэг болж байна уу! гэж профессор МакГонагалл хаширав.

- Үүнд ямар ч баталгаа байхгүй! Та нар цочирдсондоо арван гурван жилийн турш арайхийн хүрсэн бүхнийг сүйтгэх гэж байна! гэж Фаж уурссандаа хүрэгтэн хашгирав.

Харри чихэндээ итгэсэнгүй. Тэр Фажыг үргэлж зөөлөн сүржиндүү зантай ер нь бол муугүй хүн гэж боддог байлаа. Одоо түүний өмнө тухтай тайван ертөнц нь амгалан тайвнаа алдах гэж байгаад хилэгнэсэн жижигхэн шидтэн зогсож байлаа.

- Волан-де-Морт эргэж ирсэн. Үнэнийг нүдээрээ харж бүх ертөнцөд мэдэгд. Тэгвэл аврагдах боломжтой. Юуны түрүүнд Дементоруудыг Азкабанаас холдуул...

- Дэмий яриа! Дементоруудыг холдуулах гэнээ? Би энэ тухай дуугарвал өрөөнөөсөө өшиглүүлэн хөөгдөх болно! Шидтэнгүүдийн тэн хагас нь зөвхөн үүний төлөө тайван унтдаг! гэж Фаж хашгичив.

- Тэгвэл нөгөө хагас нь Корнелиус тайван унтаж чадахгүй байна. Хар Лордын талынхан Волан-де-Мортын анхны дуудлагаар урвахад бэлэн амьтдаар хамгаалуулаад байна! Тэд танаас урвах болно, Фаж! Волан-де-Морт тэдэнд таны өгч чадахаас их зүйлийг өгнө! Өнөөдөр биш ч маргааш Дементорууд түүний талынхантай нэгдэхэд та үгэндээ оруулж чадахгүй. Түүнийг урьдын хүчээ олсон цагт миний үгийг санаарай!

Фаж ам ангайсан ч үг хэлэх чадалгүй болсон харагдав.

- Хоёрдугаарт гэвэл яаралтай аварга биетүүдэд төлөөлөгч явуул.

- Аварга биетүүдэд төлөөлөгч явуул гэнээ? Цэвэр ухаангүй явдал! гэж Фаж ухаанаа алдтал уурсан хашгирав.

- Тэдэнтэй нөхөрсөг харилцаа тогтооход оройтохгүй. Цаашдаа Волан-де-Морт тэднийг өөрийн талдаа татаж хэний ч өгөөгүй эрх чөлөө өгнө гэж амлах болно.

- Та... та үнэхээр хэлж байна уу? Аварга биетүүдтэй холбоо тогтооно гэнээ! Шидтэнгүүд намайг тасдаж хаяна. Хүмүүс тэднийг үзэн яддаг... Миний албан тушаал төгсгөл болно гээд Фаж толгойгоо сэгсэрснээ Дамблдор руу алхам ойртлоо.

- Та зөвхөн өөрийн албан тушаалдаа сохорч, Корнелиус! гээд Дамблдорын хоолой чангарлаа. Түүний хүч барагдсан ч нүд нь гялалзсан хэвээр байв.

- Та үргэлж цэвэр цусанд хэтэрхий их ач холбогдол өгдөг байсан! Хэнээс төрөх нь чухал биш хэн болох нь чухал! Таны Дементор сая цэвэр цусны шидтэнгийн гэр бүлээс үлдсэн цорын ганц хүнийг устгалаа. Энэ хүн ямар атаархамгүй амьдрал сонгон авсныг хар! Миний үгийг дагахыг зөвлөө. Волан-де-Мортод бидний дөнгөж босгоод байгаа ертөнцийг устгах хоёр дахь боломжыг өгч болохгүй!

- Ухаангүй явдал. Галзуурсан... гэж Фаж шивнэлээ.

Өрөөнд нам гүм болов. Хатагтай Помфри Харрийн орны хөлд амаа даран зогсоно. Хатагтай Уизли урьдын адил мөрийг нь дарсан хэвээр. Билл, Рон, Гермiona нар Фаж руу гайхан ширтжээ.

- Хэрвээ та үнэнийг харахыг хүсэхгүй байгаа бол, Корнелиус өнөөдрөөс эхлээд бидний зам салах нь байна. Хэрэгтэй зүйлээ хийгтүн. Би ч гэсэн өөрийнхөөрөө хийе.

Дамблдорын хоолойд сүрдүүлсэн аяс байхгүй зөвхөн бодлоо гаргаж хэлсэн ч Фаж түүн рүү шидэт саваа чиглүүлсэн аятай хүлээн авчээ.

- Харин одоо намайг сонс, Дамблдор гээд тэр сүрдүүлэн хуруугаа зангаад,

- Би таныг гүнээ хүндэтгэж үргэлж чөлөөтэй хөдлөх боломж олгодог байсан. Би таны зарим шийдвэрийг чинь хүлээн зөвшөөрч чадаагүй ч чимээгүй байсан. Хэн

таньд хүн чоно болон Хагридыг ид шидийн яамны зөвшөөрөлгүй багшлуулахаар зөвшөөрсөн юм бэ. Хэрвээ та миний эсрэг хөдлөхөөр шийдсэн бол... гэв.

- Би зөвхөн Волан-де-Мортгын эсрэг л хөдлөнө. Хэрвээ та түүний эсрэг байгаа бол бид холбоотон болж болох юм, Корнелиус.

Фаж юу хэлэхээ мэдсэнгүй. Хэсэг зуур гартаа малгайгаа эргэлдүүлэн чимээгүй байлаа. Эцэст нь гуйсан хоолойгоор,

- Тэр эргэж ирж чадахгүй, Дамблдор. Ерөөсөө ч боломжгүй... гэв.

Снегг шийдэмгий урагш алхаад зүүн гарын ханцуйгаа сөхөн Фажын хамар луу сунгав. Сайд ухарлаа.

- Энэ. Үүнийг хар. Хар тамга. Өмнө нь хэзээ ч ийм тод байгаагүй юм. Хар өнгөөр шатаж байхыг харж байна уу. Хар лордын Үхэл залгигчид бүрийн гар дээр ийм тэмдэг байдаг. Үүгээр бид биеэ таньж түүнийг дуудахад очдог юм. Нэг хүний гарт байгаа тамганд хүрэх юм бол бүгд агшин зуур шилжин очно. Сүүлчийн жил тамга урьд урьдынхаас илүү тод болж байна. Каркаровт бас бий. Та Каркаров юуны учир өнөөдөр зугтсаныг мэдэж байна уу? Бид хоёулаа Хар тамга төөнөхийг мэдэрсэн. Хоёулаа түүний эргэж ирснийг мэдэж байсан. Каркаров Хар лордын өшөө авахаас айсан юм. Тэр түүнээс урван хэтэрхий олон дэмжигчдийг нь барьж өгсөн. Эзэн түүнийг гараа дэлгээд угтахгүй нь лавтай.

Фаж Снеггээс алхам ухрав. Тэр Снеггийн үгийг сонсоогүй бололтой зэвүүн тэмдэг рүү ширтэж байлаа. Тэгснээ толгой сэгсрээд,

- Би таны тоглоомыг ойлгохгүй байна, Дамблдор. Таны холбоотонгуудаас би олон зүйлийг сонслоо. Юу ч нэмэх хэрэггүй. Маргааш би таньтай холбогдоё. Хогвартсад болсон явдлыг шалгах болно. Харин одоо намайг уучлаарай, яам руу явах хэрэгтэй байна гэв.

Тэр замын хагаст хөшсөнөө эрж хараад Харрийн ор руу дөхөж ирэв.

- Чиний шагнал. Мянган галлеон. Шагнал гардуулах ёслол маргааш болох байсан ч нөхцөл байдал ийм байхад... гэж хөндий хэлээд халаасан дотроосоо том хүүдийтэй алт гарган шүүгээн дээр тавилаа.

Тэр малгайгаа толгой дээрээ тавиад өрөөнөөс шийдэмгий алхан гарч хаалга хаалаа. Фажын алхаа намдмагц Дамблдор Харрийн орны дэргэд зогсож байгаа хүмүүс рүү харав.

- Хийх ажил их байна. Молли минь... би Артур та хоёрт найдаж болох уу?

- Тэгэлгүй яахав хэмээн хатагтай Уизли толгой дохив. Тэр цонхийн цайсан ч дуу нь шийдэмгий байлаа.

- Артур Фажыг мэднэ. Тэр ид шидийн яаманд ажилладагын учир нь маглуудыг ихэд сонирхдогт байгаа юм. Фаж түүнд жинхэнэ шидтэнгүүдээр бахархах хэрэгтэй гэж хэлсэн байсан.

- Түүнд захиа илгээх хэрэгтэй байна. Бүгдтэй даруйхан холбоо тогтоох хэрэгтэй. Хэрвээ ид шидийн яамны албан хаагчид Корнелиусын адил харалган биш бол гэж Дамблдор хэлэв.

- Би эцэг рүүгээ явъя. Одоохон гэж Билл хэллээ.

- Сайн байна. Түүнд болсон бүх явдлыг хэлээрэй. Намайг түүнтэй удахгүй холбогдоно гэж хэл. Болгоомжтой байх хэрэгтэй. Фаж намайг яамны ажил хэрэгт оролцож байна гэж бодох ёсгүй...

- Бүгдийг ойлголоо гэж Билл хэлэв.

Тэр Харрийн мөрөн дээр алгадаад эхийгээ үнсэн жанчаа нөмрөөд өрөөнөөс түргэн алхан гарлаа.

- Минерва, Хагридыг аль болох түргэн миний өрөөнд ирэхийг гуйгаач. Бас хатагтай Максимыг. Хэрвээ тэр ирэхийг зөвшөөрвөл гээд Дамблдор профессор МакГонагаллын зүг эргэн харав.

Профессор МакГонагалл чимээгүйхэн толгой дохиод гарлаа.

- Поппи минь, профессор Грюмын өрөө рүү очиж үзээч. Тэнд Винки үйлчлэгч их уй гашууд автсан байгаа. Түүнийг гал зуух руу явахад нь тусал. Добби тэнд санаа тавих болно гэж Дамблдор хатагтай Помфрид хандан хэлэв.

- Одоохон явлаа гэж хатагтай Помфри хэлээд эмээсэн янзтай мөн гаран явлаа.

Дамблдор Хатагтай Помфрийн ард хаалга хаагдан хөлийн алхаа намдтал чимээгүй болов.

- Харин одоо хоёр хүн бие биенээ таних цаг болжээ. Сириус минь... хүний төрхтэй болж үзээч.

Аварга том хар нохой тэр агшинд хүн болон хувирав.

Хатагтай Уизли уулга алдан орон дээр суув.

- Сириус Блэк!

- Ээжээ чимээгүй! Бүх юм зүгээр! гэж Рон дуу алдав.

Снегг хашгирсангүй ч арагшаа давхийн ухрахад царайд нь жигшин зэвүүцэл тодров.

- Тэр! Тэр энд юу хийж байгаа юм бэ? гэж Снегг түүнээс дутуугүй дургүйцсэн царай руу харж архирлаа.

- Тэр миний зочин. Яг л чиний адил, Северус. Би хоёуланд чинь итгэж байна. Хуучны гомдлоо мартаж нэг нэгэндээ итгэх цаг болсон гэж Дамблдор тэднийг харж хэлэв.

Дамблдор гайхамшигтай гэж Харри бодов. Сириус, Снегг хоёр бие биенээ үзэн ядсан харцаар өрөмдөн ширтлээ.

- Та нар дайсагнасан харьцаагаа гаргахгүй байхад л болно. Гар барьцгаа. Одооноос та нар нэг тал. Бидэнд цаг бага үлдлээ. Хэрвээ бид нэгдэж чадахгүй бол хэзээ ч ялалтанд хүрэхгүй гэх Дамблдорын хоолойд тэвчээр алдсан өнгө сонсогдов.

Сириус, Снегг хоёр бие бие рүүгээ муухай харсаар алгуур ойртож зовлон хүссэн аятай түргэхэн гар барилаа.

- Эхэндээ хангалттай. Одоо хүн бүрд ажил байна. Фажын үйл хөдлөлөөс үзэхэд юу ч өөрчлөгдөхгүй нь бололтой. Сириус даруйхан замдаа гар. Римус Люпин, Арабела Фигг, Наземникус Флетчер болон бүх хуучин найзуудаа анхааруул. Намайг чамтай холбоо тогтоотол Люпиныд нуугдаж бай.

- Гэхдээ... гэж Харри хэллээ.

Тэр Сириусыг үлдэхийг хүсчээ. Зөвхөн уулзаад хоёр тийш салах нь байна шүү дээ.

- Би удахгүй ирнэ, Харри. Амалж байна. Дамблдор туслах ёстойг ойлгож байгаа биз дээ?

- Тиймээ, ойлгож байна.

Сириус түүний гарыг түргэхэн атгаад Дамблдорт толгой дохин ахиад л нохой болон хувирч үүд рүү гүйлээ. Гарахдаа сарвуугаараа хаалганы бариулыг онгойлгов.

- Северус чи намайг юу гуйхыг мэдэж байгаа. Хэрвээ... хэрвээ чи бэлэн бол гэж Дамблдор Снеггт хандан хэлэв.

- Бэлэн гээд Снегг толгой дохилоо.

Тэр цонхийн цайсан агаад хүйтэн нүд нь хачирхалтай гялалзаж байв.

- Тэгвэл амжилт хүсье гэж Дамблдор хэлээд Снегг рүү харлаа. Тэрбээр үг хэлэлгүй гарч хаалга хаав.

Хормын дараа Дамблдор ярьж эхэллээ.

- Би явах хэрэгтэй байна. Седрикийн эцэг эхтэй уулзах хэрэгтэй. Харри нойрсуулагч ханд уусан нь дээр байх. Өглөө уулзацгаая.

Дамблдор явчихлаа. Харри дэрэн дээрээ хэвтэв. Гермiona, Рон, хатагтай Уизли нар түүнийг чимээгүйхэн харцгаана. Удтал хэн ч юу ч ярьсангүй.

- Харри хандаа уугаад амар. Чи сайн унтаж амрах хэрэгтэй. Ямар нэгэн таатай юмны тухай бод... Жишээлбэл шалгалын мөнгөөр юу худалдаж авахаа ч юм уу гэж хатагтай Уизли хэлээд цомтой алтыг түлхэв.

- Надад хэрэггүй. Түүнийг та ав. Би үүнийг хожоогүй. Энэ алт бол Седрикийнх гэж Харри аяархан хэлэв.

Тэр төөрдөг байшингаас гарсан тухай бодохгүйг хичээв. Дотор халуу оргин нулимс цийлэгнэлээ. Хэдэнтээ нүдээ анивчаад адар ширтэв.

- Чи юунд ч буруугүй, Харри гэж хатагтай Уизли шивнэлээ.

- Би түүнд цомыг хамтдаа авахыг санал болгосон юм.

Одоо зөвхөн нүдэнд нь нулимс цийлэгнээд зогсохгүй хоолой нь зангирлаа.

<<Рон цаашаа хар!>> гэж Харри бодолдоо гуйлаа.

Хатагтай Уизли хандыг шүүгээн дээр тавиад Харриг тэвэрлээ. Хэн ч хэзээ ч түүнийг ингэж тэвэрч байсангүй. Зөвхөн ээж нь л тэгсэн байх. Шөнө болсон бүх хүнд зүйл нүдний урдуур жирэлзэв. Эхийнх нь царай, эцгийнх нь хоолой, Седрикийн бие газар хэвтэж байна гээд л. Харри мэгшихгүйн тулд арай л уруулаа хазсангүй.

Чанга алгадах чимээ гаран хэн нэгэн алгаараа юм цохив. Цонхны дэргэд зогсож байсан Гермиона ямар нэгэн юм гартаа барьжээ.

- Уучлаарай гэж тэр шивнэлээ.

- Энэ чиний ханд гээд хатагтай Уизли түргэхэн хэлээд нүдийг нь арчин гарт нь бариулав.

Харри нэг балгалтаар аягыг хоослов. Уусмал агшин зуур үйлчилэхэд даван туулахын аргагүй гүн нойронд автав. Тэр эсэргүүцсэнгүй хүссэн ч үгүй. Толгойгоо дэрэн дээр тавиад ер нь юуны ч тухай бодсонгүй.

БҮЛЭГ 37: ЭХЛЭЛ

Сүүлчийн сар болсон явдлыг хараад Харри тийм ч олон дурсамж үлдсэнгүйг ойлгов. Түүнд санаа зовоох зүйл хэтэрхий их болжээ. Дурсамжууд нэг нь нөгөөгөөсөө хүнд байлаа. Хамгийн хүнд нь гэвэл Диггорийн эцэг эх эмнэлгийн өрөөнд өглөө ирсэн явдал байв.

Тэд түүнийг болсон явдалд буруутгалгүй харин ч эсрэгээрээ Седрикийн биеийг орхисонгүйд талархал илэрхийлэв. Ноён Диггори мэгшин уйлж байсан ч хатагтай Диггорийн нүд уйлж чадахааргүй мэт хуурай байлаа. Харри тэдэнд Седрик хэрхэн үхсэнийг ярьжээ.

- Тэр минь зовоогүй л юм байна. Амос эцсийн эцэст... тэр цомыг хожжээ. Тэр их жаргалтай байсан байх даа гэж хатагтай Диггори хэлэв.

Тэр явахын өмнө Харрид хандан,

- Өөртөө санаа тавь, Харри. Болгоомжтой байгаарай гэж хэллээ.

Харри шүүгээн дээрх алтыг авлаа.

- Үүнийг аваач. Энэ Седрикийнх тэр цомд түрүүлж хүрсэн юм.

Гэвч Хатагтай Диггори цаашаа эргээд,

- Үгүй дээ үгүй хонгор минь.. чи яаж байна... өөртөө үлдээ гэв.

Маргааш өдрийнх нь орой Харри Гриффиндорын цамхагт эргэн очлоо. Гермiona, Рон хоёр түүнд Дамблдор өглөөний цайны үеэр бүх сурагчдыг цуглуулсан тухай ярьжээ. Тэр Харригаас төөрдөг байшинд юу болсон тухай асуухгүй байхыг хүссэн байна. Харри хонгилд хүмүүс түүнээс зайлсхийн араас нь харж шивнэлдэж байхыг ажиглав. Магадгүй Рита Скитерийн сурвалжлагыг уншсан болоод түүнийг аюултай гэж итгэж байгаа биз. Эсвэл Седрикийн үхлийн талаарх өөрсдийн таамгаа гаргасан биз. Харри үүнд санаа зовсонгүй. Тэр Рон, Гермiona хоёртой бүх цагаа өнгөрүүлэн ярилцаж заримдаа найзуудынхаа шатар тоглохыг харан чимээгүй суудаг байлаа. Тэд гурвуулаа Хогвартсын хананы гадаа юу тохиолдсон тухай мэдээ хүлээж байгаагаа хэлүүлэлтгүй ойлгож байлаа. Ирээдүй тайван байна гэж бодоогүй ч одоохондоо бүх зүйл тайван байв. Рон Харрид хатагтай Уизлиг гэр лүүгээ буцахын өмнө Дамблдортой уулзсан тухай хэлжээ.

- Тэр чамайг энэ зун шууд манайд очуулж болох уу гэж асуусан. Харин Дамблдор эхэндээ Дурслийнд байсан нь дээр гэж хэлсэн шүү.

- Яагаад? гэж Харри гайхлаа.

- Ээж хэлэхдээ Дамблдор өөрийн гэсэн шалтгаан байгаа гэсэн. Энэ тухай асууж болох биш гээд Рон мөрөө хавчлаа.

Харри Рон, Гермiona хоёроос гадна зөвхөн Хагридтай ярьж байлаа. Хар урлагаас хамгаалах хичээлийн багш өвдсөн болохоор хоёр хичээл орсонгүй өнгөрөв. Пүрэв гаригт хоолны дараа андууд Хагридын очив. Нарлаг дулаахан өдөр байлаа. Соёт нээлттэй хаалгаар угтан ирж чанга хуцан сүүлээ даллав.

- Тэнд хэн байна? гээд Хагрид хаалгаар гарч ирснээ,

- Харри! гэв.

Тэрбээр Харри руу түргэн очин аварга том гараараа тэвэрч үсийг нь сөргүүлэн илээд,

- Чамайг харахад таатай байна. Гэрт орцгооё гэв.

Модон ширээн дээр хувингийн хэмжээтэй хоёр аяга байлаа.

- Олимпийн аягаар цай уусан юм. Тэр саяхан явсан гэж Хагрид хэлэв.

- Хэн? гэж Рон гайхлаа.

- Хэн гэнээ? Мэдээж хатагтай Максим гэж Хагрид хэлэв.

- Та хоёр эвлэрчихээ юу? гэж Рон асуув.

- Чамайг юуны тухай яриад байгааг ойлгохгүй байна гэж Хагрид зайлсхийн хэлээд шүүгээнээс хэдэн аяга авчирав.

Хагрид цай аягалж жигнэмэг таваглаад сандалд сууж Харри руу цохных шиг хар нүдээрээ ширтлээ.

- Чи зүгээр үү?

- Тиймээ гэж Харри хэлэв.

- Үгүй дээ. Мэдээж үгүй. Гэхдээ бүгд биш гэж Хагрид эсэргүүцэв.

Харри чимээгүй болов.

- Би түүний эргэж ирснийг мэдэж байгаа гэж Хагрид гэнэтхэн хэлэхэд Харри, Рон, Гермиона гурав гайхан түүн рүү харлаа.

- Үргэлж мэддэг байсан юм. Түүний хүлээж байгаа гэдгийг мэддэг байсан... Ахиад амь орно гэж. Ингээд амиллаа. Одоо юу хийх вэ? Тэмцэх болно. Магадгүй түүнийг ахин сүр хүчээ олохоос өмнө зогсоож болох байх. Дамблдор тэгж бодож байгаа юм. Дамблдор агуу хүн шүү. Тэр бидэнтэй байгаа болоод би тайван байгаа юм.

Хагрид найзуудын үл итгэсэн царайг хараад өтгөн хөмсгөө гайхширан өргөлөө.

- Суугаад санаа зовох хэрэггүй. Болох ёстой юм болдогоороо болно. Дамблдор надад чиний юу хийснийг хэлсэн, Харри.

Хагрид цээжээ түхийлгэн Харри руу бардам харав.

- Чи эцэг шигээ алхам хийсэн. Би үүнээс ч илүү магтаж чадахгүй юм байна.

Харри сүүлчийн өдрүүдэд анх удаа инээмсэглэлээ.

- Дамблдор чамайг юу хийхийг гуйсан юм бэ, Хагрид? Тэр шөнө профессор МакГонагалл чамайг хатагтай Максимын хамт дуудсан биз дээ.

- Зун хийх жаахан ажил өгсөн. Гэхдээ энэ бол нууц... Хэнд ч хэлж болохгүй... та нарт хүртэл. Хатагтай Максим бас надтай хамт явна. Би тэгж бодож байгаа юм. Түүнтэй ярилцахаас.

- Энэ Волан-де-Морттой холбоотой юу?

Хагрид нэрийг сонсоод давхийлээ.

- Магадгүй юм. Харин одоо... одоо... Хэн надтай явж сүүлчийн соплохвостыг харахыг хүсч байна? Тоглосон юм... Тоглосон юм! гэж тэдний царайг хараад дуу алдлаа.

Харри хүндхэн зүрхтэйгээр Хогвартсаас явах чемоданаа баглалаа. Тэр үдэлтийн цайллагнаас айж байлаа. Түүнийг тэмцээний ялагчаар зарлах байх. Харри эмнэлгийн өрөөнөөс гараад Их танхимд орохдоо сониучирхсан харцнаас зугтахыг хүсэв.

Өнөөдөр танхимд ердийнхөөрөө ялсан тэнхимын далбаа байсангүй. Багш нарын ширээг хар даавуугаар бүтээсэн харагдана. Харри Седрикийг хүндэтгэсэн тэмдэг болохыг тааварлав.

Багш нарын ширээн дээр жинхэнэ Хурц нүдэт Грюм сууж байлаа. Модон хөл, шидэт нүд нь байрандаа байв. Грюм хэн нэгэн түүнд хандах болгонд почин давхийх аж. Харри үүнийг буруутгасангүй. Хэрвээ чи арваас доошгүй сарын хугацаанд авдартаа суусан бол ингэх нь мэдээж шүү дээ. Багш нарын ширээнд Каркаровын суудал хоосон байв. Тэр одоо хаана байгаа юм бол? Воалан-де-Морт түүнийг барьсан болов уу?

Харин хатагтай Максим байрандаа сууж байлаа. Дэргэд нь Хагрид суух агаад ямар нэг юмны тухай аяархан хөөрөлдөнө. Профессор МакГонагаллын хажууд Северус Снегг сууж байв. Тэдний харц тулгарлаа. Түүний царайны хувирал нь ойлгомжгүй байсан ч үргэлж байдаг шигээ гашуун баргар төрхтэй байв. Снегг нүдээ буруулав. Харри удтал түүнийг харлаа.

Тэр Воалан-де-Мортын эргэн ирдэг шөнө Дамблдорын ямар даалгаварыг биелүүлэх гэж байсан юм бол? Яагаад... яагаад Дамблдор Снегг түүний талд байгаа гэдэгт итгэлтэй байсан юм бол? Тэр оюун ухааны цүнхээлд Снегг бол тагнуул байж үнэн хэрэгтээ Воалан-де-Мортын эсрэг ажиллаж байсан бөгөөд том эрсдэл гаргасан гэж хэлсэн. Тэр үнэхээр ахиад эрсдэлд орохыг зөвшөөрсөн юм болов уу? Магадгүй ахиад Үхэл залгигчидтай холбоотой болсон юм болов уу? Хэзээ ч Дамблдорыг дэмжиж байгаагүй Воалан-де-Мортын цаг нь ирэхийг хүлээж байсан юм болов уу?

Харрийн бодлыг Дамблдор босон таслав. Их танхимд чимээ шуугиан багатай байсан ч нам гүм боллоо.

- Ахин нэг жил төгслөө гэж Дамблдор хүүхдүүдийг тойруулан хараад хэлэв.

Тэр чимээгүй болоод Пуффендуйн ширээ рүү харлаа. Тэд чимээгүйхэн гашуудалтай сууцгаана.

- Би олон зүйлийг өнөө үдэш та бүхэнд хэлэхийг хүсэж байна. Гэхдээ юуны түрүүнд бидний дунд суугаад үдэлтийн найранд оролцох ёстой байсан маш сайн хүнээ алдсан гэдгийг хэлэх ёстой. Хамтдаа босож түүний дурсгалыг хүндэтгэе гээд Дамблдор цомоо өргөн,

- Седрик Диггорийн төлөө гэв.

Сандал хөндлөх чимээ гарч танхим даяараа босоод цомоо өргөн янз бүрийн хоолойгоор <<Седрик Диггорийн төлөө!>> гэв.

Харри Чжоу руу харлаа. Түүний нүүрийг даган нулимс чимээгүйхэн урсана. Бүгд суухад Харри ширээ лүүгээ ширтлээ.

- Седрик Пуффендуй тэнхимийн үлгэр жишээ сайн сурагч байсан. Ажилд хөдөлмөрт дуртай эелдэг үнэнч шударга жинхэнэ нөхөр байлаа. Бид түүнийгээ үхлээр алдсан. Ингээд би та бүхэнд үнэнийг хэлэх нь зүйтэй гэж бодлоо.

Харри толгойгоо өргөн Дамблдор луу харлаа.

- Седрик Диггорийг Лорд Волан-де-Морт алсан.

Танхимд айсан шивнэлт түгэв. Сурагчид Дамблдор руу айдаст автсан итгэлгүйхэн харцаар ширтэцгээлээ. Захирал чимээ шуугиан намдахыг тайвнаар хүлээв.

- Ид шидийн яамнаас намайг та нарт үүнийг мэдэгдэхийг хүсээгүй. Олон эцэг эх айна гэж бодсон байж ч болох ч гол учир нь Волан-де-Мортын эргэж ирсэнд итгэхгүй байгаа бөгөөд та нарыг жаахан хүүхдүүд гэж бодсоор байгаа юм. Гэхдээ би худал хэлснээс үнэнийг хэлсэн дээр гэдэгт итгэлтэй байна. Седркийн үхлийг золгүй явдлаар тайлбарлах нь түүнийг дурсгалыг доромжилсон хэрэг болно.

Зүг бүрээс айж мэгдсэн царайнууд Дамблдорын зүг ширтлээ. Слизериний ширээнд Малфой Крэбб, Гойл хоёрт юм шивнэв. Харрийн уур хилэн дүрэлзэхэд Дамблдор руу эргэн харлаа.

- Ахин нэг хүнийг би хэлэх ёстой. Тэр бас Седрикийн үхэлд холбоотой. Энэ бол Харри Поттер гэж Дамблдор хэлэв.

Танхимд давалгаа үүсч хүмүүсийн толгой Харрийн зүг харснаа ахин захирал руу харлаа.

- Харри Поттерт Лорд Волан-де-Мортоос зугтах боломж гарсан. Тэр өөрийн амьдралаараа дэнчин тавьж байж Седрикийн биеийг Хогвартст авчирсан. Харри Поттер эр зоригтойгоор насанд хүрсэн шидтэний хийх зүйлийг хийсэн. Түүнийг хүндэтгэн цомоо өргөцгөөе.

Дамблдор буурьтайгаар Харри руу эргэж хараад цомоо өргөв. Бүх танхим ахин хөл дээрээ босож олон хүн түүний нэрийг Седрик Диггорийн адил хэллээ. Гэвч хүмүүсийн дунд хоосон зай бас харагдана.

Харри Малфой, Крэбб, Гойл нар болон Слизериний олонхи сурагчид цомоо өргөөгүйг харав. Дамблдор мэдээж юу ч ажигласангүй. Түүнд шидэт нүд байхгүй юм чинь.

Эцэст нь бүгд байрандаа суухад Дамблдор үргэлжлүүлэв.

- Гурван шидтэний тэмцээний гол зорилго нь шидтэнгүүдийг хооронд нь нөхөрлүүлэх явдал билээ. Хар лорд эргэж ирсэн болохоор холбоо урьдынхаас илүү чухал боллоо.

Дамблдор Хагрид, хатагтай Максим болон Шамрбатоны сурагч Флер Делакур руу харснаа Слизериний ширээнд сууж байгаа Виктор Крам руу харлаа. Дамблдор одоохон тэдний талаар таагүй зүйл хэлэх гэж байгаа аятай Крамын нүдэнд айдас тодров.

- Энэ танхимд байгаа зочин бүрийг Хогвартс үргэлж баяртай угтах болно гээд түүний харц Дурмстрангын сурагчид дээр тусав.

- Лорд Волан-де-Морт эргэн ирсэн гэдгийг ахин тэмдэглэж хэлэх байна. Бидний аврагдах зам бол хамтдаа хүчтэй байх явдал юм. Лорд Волан-де-Морттой сөргөлдсөн хүн бүр түүний дайсан болно. Бид түүний эсрэг нөхөрлөл итгэл холбоогоо батжуулан тэмцэх ёстой. Хэл заншилаараа ялгаатай нь хамаагүй бидний зорилго бол зүрх сэтгэлээ нэг нэгэндээ нээх явдал.

- Би үүнд алдсан байгаасай гэж найдаж байгаа ч бидний урд хүнд хэцүү өдрүүд ирээд байна. Энэ танхимд сууж байгаа хүмүүсийн зарим нь Лорд Волан-де-Мортын гарт хэдийн зовсон. Тэдний олонхийн гэр бүлийг сүйрсэн билээ. Харин долоо хоногийн өмнө та нарын нөхөр үхсэн.

- Седрикийг санацгаа. Хэрвээ та нарт шударга замд сонголт хийхэд хүнд байвал хүүд юу тохиолдсоныг санацгаа. Эелдэг зоригтой хүү зөвхөн Лорд Волан-де-Мортын замд санамсаргүй тааралдсанахаа төлөө үрэгдсэн юм. Седрик Диггориг санацгаа!

Харрийн тээш баглаатай дээр нь Хэдвигийн тор байлаа. Тэр, Рон, Гермиона хоёр болон бусад дөрөвдүгээр дамжааныхантай Хогсмидын буудал хүргэх сүйх тэрэг хүлээж байв. Нарлаг дулаахан өдөр байлаа. Харри Улаан модон гудамжинд зуны сэвшээ салхи навчис үлээж цэцгийн мандалд өнгө алаглаж байгаа талаар төсөөлөв. Гэхдээ бодол түүнийг баярлуулсангүй.

- ‘Арри!

Тэр эргэж харлаа. Шилтгээний чулуун шатаар Флер Делакур яаран өгсөж ирэв. Харри онгорхой хаалгаар Хагрид хатагтай Максид аварга том алтан морьдыг хөллөхөд тусалж байхыг харлаа. Шамрбатоны сүйх тэрэг замд гарахад бэлэн болжээ.

- Бид удахгүй уулзана гэдэгт итгэлтэй байна. Танай хэлийг сайн сурахын тулд энд ажил олно гэж найдаж байна хэмээн Флер хэлээд гараа сунгав.

- Энэ чинь маш... сайн байна гэж Рон ээрэн хэлэв. Флер түүн рүү инээмсэглэв. Гермиона хөмсөг зангидлаа.

- Баяртай Харри. Танилцахад их таатай байлаа! гэж Флер салах ёс гүйцэтгээд явлаа.

Харрийн сэтгэл санаа үл ялиг хөгжлөө. Тэр Флер хатагтай Максим руу гүйн одоход өглөөний нарны гэрэлд мөнгөлөг үс нь хэрхэн туяарахыг сонирхон ажиглав.

- Дурмстрангынхан яаж буцах юм бол? Онгоцоо Каркаровгүй жолоодож чадах юм болов уу? гэж Рон хэлэв.

- Каркаров жолооддоггүй. Тэр бүхээгт суугаад харин бид бүх ажлыг хийдэг гэх хэн нэгний баргар хоолой дэргэд нь гарлаа.

Крам Гермионатай салах ёс гүйцэтгэхээр иржээ.

- Чамтай хэдэн үг сольж болох уу? гэж тэр түүнээс асуув.

- Өө... тэгэлгүй яахав гэж Гермиона хэлээд үл мэдэг улайн Крамын хамт явлаа.

- Битгий удаарай! Сүйх тэрэг хормын дараа ирэх гэж байна хэмээн Рон араас чанга хашгирав.

Гэхдээ сүйх тэрэг түүнийг бага зовоосон бололтой. Тэр хүмүүсийн дундуур өлмий дээрээ босож хүзүүгээ сунган Гермиона, Крам хоёр юу хийж байгааг харахыг хичээв. Тэд маш түргэн эргэж ирлээ. Рон Гермионагийн царай луу ширтсэн ч юу ч тааварлахын аргагүй байв.

- Надад Диггори таалагддаг байсан. Тэр үргэлж надтай эелдэг байсан. Үргэлж шүү. Хэдийгээр би Дурмстрангаас Каркаровтой хамт... ирсэн ч гэлээ хэмээн тэр баргар царайлан нэмэв.

- Та нар шинэ захиралтай болсон уу? гэж Харри асуулаа.

Крам мөрөө хавчив. Дараа нь Флерийн адил Харри, Рон хоёртой гар барилаа. Роны царайгаас үзэхэд дотор нь тэмцэл явагдаж байгаа бололтой. Крам хэдийн эргэсэн хойно Рон гэнэтхэн,

- Чиний гарын үсгийг авч болох уу? гэлээ.

Гермиона шилтгээн рүү ирж байгаа сүйх тэрэг рүү харан инээмсэглэв. Крам гайхсан ч сэтгэл хангалуунаар Ронд цаасан дээр гарын үсгээ зурж өглөө.

Энэ зуны өдөр Хогвартс руу буцаж ирсэн есөн сарын бороотой өдрөөс ялгаатай байлаа. Үүлгүй цэлмэг байв. Галт тэрэгний тасгалгаанд Харри, Рон, Гермиона нараас ондоо хэн ч байсангүй. Гахай тасралтгүй гуугачсан тул ахин Роны ёслолын хувцасаар хучигджээ. Хэдвиг толгойгоо жигүүр дороо шургуулаад зүүрмэглэж байв. Харин Живоглот хоосон суудалд том шаргал дэр аятай цагариглана. Галт тэрэг өмнө зүг рүү хөдлөхөд долоо хоногийн турш чимээгүй байсан андууд гэнэтхэн ярилцаж эхэллээ. Дамблдорын үдэлтийн цайллага Харрийн сэтгэлийг онгойлгожээ. Түүнд болсон явдлыг санахад тийм их хэцүү байхаа больсон байна. Тэдний санааг Дамблдор яаж Хар лордыг зогсоох бодол зовоож байлаа. Яриа хөөрөө тэргэнцэртэй хоол ирсний дараа тасалдав.

Гермиона идэх юм худалдаж аваад мөнгөө цүнхэндээ хийж <<Өдөр тутмын зөнч>> сонины сүүлчийн дугаар гаргаж ирлээ. Харри дотор нь юу бичигдсэнийг харахаар сонин руу хартал өнгийлөө. Гермиона түүний түгшсэн байдлыг ажиглаад итгэлтэйгээр,

- Тэнд юу ч байхгүй. Өөрөө хар л даа, үнэхээр юу ч байхгүй. Би өдөр болгон шалгаж байгаа. Зөвхөн Гурван шидтэний тэмцээний сүүлчийн өдөр шагналыг Харри Поттер хожсон гэсэн жижигхэн мэдэгдэл гарсан. Седрикийн тухай дурсаа ч үгүй. Ер нь бол юу ч гараагүй. Минийхээр бол Фаж л ийм боломж өгөөгүй байх.

- Тэр Ритагын амыг хамхиулж чадахгүй. Тэнд ийм үйл явдал болсон байхад гэж Харри эсэргүүцэв.

- Рита гурав дахь тэмцээний тухай нэг ч үг бичиж чадахгүй гэж Гермиона хачирхалтай хүчилсэн хоолойгоор хэлээд,

- Үнэнийг хэлэхэд тэр хэсэг хугацааны турш юу ч бичиж чадахгүй. Хэрвээ би түүний нууцыг тайлаагүй бол хүсэх л байсан байх даа гэлээ.

- Чи юуны тухай яриад байна? гэж Рон асуулаа.

- Би түүний бусдын яриа сонсож хэрхэн байсныг тайлсан. Хориотой аргаар Хогвартсад байсан юм билээ гэж Гермиона нэг амьсгаагаар мэдэгдэв.

Сүүлчийн өдрүүдэд тэр энэ тухайгаа найзууддаа ярихыг хүссэн гэдэгт Харри эргэлзсэнгүй. Гэхдээ тэр аймшигтай гурав дахь тэмцээнээс хойш биеэ барьж байлаа.

- Тэр яаж сонссон юм бол? гэж Харри асуулаа.

- Чи яаж таасан юм бэ? гээд Рон түүн рүү харлаа.

- Ер нь бол энэ санааг Харри надад хэлж өгсөн гэж Гермиона хэлэв.

- Би юу? Хэзээ? гэж Харри гайхлаа.

- Сонсох төхөөрөмжыг санаж байна уу?

- Гэхдээ чи сургуулийн нутаг дэвсгэрт ажиллахгүй гэсэн биз дээ...

Электрон төхөөрөмж ажиллахгүй. Гэхдээ Рита Скитер бүртгэгдээгүй анимаг байсан. Тэр хувирч чадна гэж Гермиона хөөрснөө нуулгүй хэлээд цүнхнээсээ таглаатай шилэн сав гаргаж ирэв.

- ...цох болдог юм!

- Чи тоглож байна уу! Чи чадахгүй... тэр энэ биш... гэж Рон дуу алдав.

- Тэр мөн гээд Гермиона инээмсэглэн бардмаар шилийг сэгсэрлээ.

Дотор нь мөчир навч хоёр байх агаад түүн дээр том хар цох сууж байлаа.

- Хэзээ ч энэ тухай бодож үзэж байсангүй... Чи тоглосон байлгүй дээ.. гэж Рон шивнээд шилэн сав руу харав.

- Үгүй дээ, тоглоогүй. Би түүнийг ээж чинь Харриг тэврэх үед эмнэлгийн цонхны тавцан дээр барьсан юм. Анхааралтай хараад Ритатай маш адилханыг олж харсан. Аймшгийн шил нь хүртэл адилхан.

Харри цох руу харахад Гермионагийн зөв байлаа. Тэр ч гэсэн зарим нэг юм саналаа.

- Хагрид хатагтай Максимтай эхийнхээ тухай ярих үед хөшөөн дээр энэ цох сууж байсныг би сайн санаж байна!

- Мэдээж шүү дээ! гэж Гермиона батлаад,

- Харин Виктор миний үсэн дээрээс цохыг унагах үед бид нуурын эрэг дээр ярилцаж байсан юм. Хэрвээ андуураагүй бол мэргэ төлгийн хичээл дээр чиний сорви өвдөх үед Рита цонхны тавцан дээр сууж байсан. Бүтэн жилийн турш сургууль дотуур дүнгэнэн нисэж хов жив цуглуулж байжээ гэв.

- Харин бид Малфойг модны дор харсныг санаж байна уу... гэж Рон удаанаар хэлэв.

- Тиймээ тэр Ритатай ярилцаж байсан. Тэр түүний алганд байсан. Тэр бас нууцыг нь мэддэг байсан. Ийм учраас л жижигхэн ярилцлагандаа Слизеринийхнийг оруулдаг байж. Тэд түүний хууль зөрчсөнийг тоолгүй Хагрид болон бидний тухай аймшигтай мэдээлэл өгч байж.

Гермиона шилэн савыг Роны гараас аваад ууртайгаар дүнгэнэж байгаа цох руу инээмсэглэн харлаа.

- Би түүнийг Лондонд эргэж очмогц чөлөөлнө гэж амалсан. Шилэн сав тусгай шившлэгтэй болохоор тэр хүн болон хувирч чадахгүй. Би түүнд жилийн турш үзэгнийхээ тухай март гэж хэлнэ. Түүний хүмүүсийн тухай аймшигтайгаар бичдэг зуршлаасаа салж чадах эсэхийг харцгаая.

Гермиона инээмсэглээд цохтой шилэн савыг цүнхэндээ буцааж хийлээ.

Өрөөний хаалга гулган нээгдэв.

- Маш ухаантай байлаа, Грэйнджер гэж Драко Малфой хэлэв.

Крэбб, Гойл хоёр түүний ард зогсож байлаа. Тэд үргэлж байдаг шигээ сэтгэл хангалуун дайсагнасан төрхтэй байв.

- Тэгэхээр гээд Малфой өрөөнд алхан орж ирээд удаанаар тойруулан харахад нүүрэнд нь ёжтой инээмсэглэл тодров.

- Чи хөөрхий сурвалжлагчыг шилэн саванд түгжиж, харин Поттер ахин Дамблдорын дуртай сурагч болсон юм биз дээ. Том амжилт шүү гээд нүүр дүүрэн инээмсэглэв.

Крэбб, Гойл хоёр баясан инээлдлээ.

- Бүхнийг мартахыг хичээж байна уу? Юу ч болоогүй юм шиг харагдахыг хичээж байна уу? гэж Малфой аяархан асуугаад тэр гурав руу харав.

- Эндээс зайл гэж Харри хэллээ.

Сүүлчийн удаа Малфойг харах үед Крэбб, Гойл хоёртой Дамблдорын үдэлтийн үгэн дээр шивнэлдэж байсан. Харрийн чих дүнгэнэж гар нь өөрийн эрхгүй халаас руугаа явав.

- Чи ялагдагчдын талыг сонгосон, Поттер! Би чамд анхааруулсан биз дээ! Бидний Хогвартс явахдаа уулзсан анхны өдөр? Би чамд эдгээр нийгмийн шааруудаас хол яв гэж хэлсэн дээ! гээд тэр Рон, Гермиона хоёрын зүг толгойгоороо сэжлээ.

- Харин одоо хэтэрхий хожимдсон, Поттер! Хар лорд эргэж ирэхэд тэд хамгийн түрүүнд үхэх болно! Бохир цустнууд болон маглуудад хайртай хүмүүс! Хоёр дахь нь байхыг ч үгүйсгэхгүй. Эхнийх нь Диггори...

Гэнэтхэн хэн нэгэн хайрцаг цаасан буу буудуулсан юм шиг дэлбэрэлт үүсэв. Нүд гялбам шившлэгүүд гялсхийж чих дөжрөм дуу гарахад Харри толгойгоо сэгсрээд шал руу харлаа.

Малфой, Крэбб, Гойл нар үүдэн дээр ухаангүй хэвтэж байв. Гурван найз босоод янз бүрийн шившлэг хэрэглэсэн саваагаа гартаа барьжээ. Зөвхөн тэд ч ингэсэнгүй.

- Бид энэ гурвыг мөрдөхөөр шийдсэн юм гэж Фред ажил хэрэгч өнгөөр хэлээд Гойлын хажуугаар орж ирлээ. Түүний гарт саваа байсан бөгөөд араас нь Жорж орж ирлээ.

- Гайхалтай үр дүнтэй байлаа. Хэн Фурункулус шившлэг илгээсэн бэ? гэж Жорж хэлээд Крэбб рүү харав.

- Би гэж Харри хэлэв.

- Харин би Хөл хөшөөх илгээсэн. Эдний царайд жижигхэн тэмтрүүл байгааг харж байна уу. Алив эднийг эндээс гаргая. Өрөөг чимэглэхгүй байна.

Рон, Харри, Жорж гурав Малфой, Гойл, Крэбб нарыг хөлөөрөө түлхэн өнхрүүлж хонгилд гаргалаа. Тэд ухаан ороогүй хэвээр замбараагүй шившлэгт өртсөний улмаас аймшигтай харагдана. Андууд өрөөндөө эргэж ороод хаалгаа хаалаа.

- Хэн нэгэн тоглох уу? гэж Фред асуугаад шидэт хөзөр гаргаж ирэв.

Тэд хэдийн тав дахь удаагаа тоглоод байтал Харри асуулт тавилаа.

- Та нар тэр үед хэнийг сүрдүүлэх гэж байсан юм бэ? гэж Жоржоос асуув.

- Аан. Энэ... гэж Жорж баргар хэлэв.

- Энэ чухал биш болсон. Ямар ч л гэсэн одоо гээд Фред толгой сэгсэрлээ.

- Бид татгалзсан гээд Жорж мөрөө хавчлаа.

Гэхдээ Харри, Рон, Гермiona гурав асуултынхаа хариуг харж байсан болохоор Фред эцэст нь,

- За яахав, хэрвээ та нар үнэхээр мэдэхийг хүсээд байгаа юм бол... Людо Бэгмен байсан юм гэлээ.

- Бэгмен гэнээ? Та нар түүнийг холбоотой... гэж Харри болгоомжлов.

- Үгүй дээ. Тэр зүгээр л ичгүүргүй аашилсан юм гэж Жорж хэлэв.

- Та нар яагаад түүнийг сүрдүүлсэн юм бэ? гэж Рон асуулаа.

Фред тээнэгэлзсэнээ хариулав.

- Дэлхийн цомын тэмцээн дээр бидний мөрийцсөнийг санаж байна уу? Ирланд хожсон ч Крам снитчийг барина гэж.

- Тиймээ гэж Харри, Рон хоёр хэллээ.

- Тэр мөрийгөө бидэнд цэнгэлдэх хүрээлэнгээс цуглуулсан лепрекончуудын алтаар төлсөн юм.

- Юу гэнээ?

- Тэгээд л алт алга болчихсон. Маргааш өглөө нь гэж Фред хэлэв

- Гэхдээ... санаандгүй тэгсэн хэрэг биш биз дээ? гэж Гермiona хэлэв.

Жорж гашуунаар инээмсэглэв.

- Бид ч гэсэн эхэндээ тэгж бодсон. Түүнд учрыг тайлбарлан бичээд эндүүрсэн учир мөнгө буцааж өгнө гэж бодсон. Юу ч бүтээгүй! Тэр зүгээр л хариу өгөөгүй. Бид түүнтэй Хогвартсад зуун удаа ярилцахыг ородсон ч ямар нэгэн аргаар зугтаад байсан.

- Харин дараа нь... Биднийг азаа үзэхэд хэтэрхий залуу байна гэж хэлээд юу ч өгөөгүй гэж Фред хэлэв.

- Бид тэгэхэд мөнгөө эргүүлж авахыг шаардсан юм гэж Жорж нэмэрлэв.

- Тэр юу гэсэн? гэж Гермиона дуу алдав.

- Татгалзсан тэгээд л болоо гэж Фред хариулав.

- Гэхдээ энэ чинь та нарын бүх цуглуулга шүү дээ! гэж Рон дуу алдав.

- Чи хэлэх нь дутаад байж гэнэ дээ! гээд Жорж толгойгоо сэгсэрснээ,

- Эцсийн эцэст бид зарим нэг юмны тухай мэдсэн. Ли Жордоны эцгийг Бэгмен бас тэгсэн байсан. Тэр алибинуудад их өртэй байсан юм билээ. Тэд түүнийг Дэлхийн цомын тэмцээний дараа барьж аваад сүүлчийн канатыг нь хүртэл суутган авсан ч өр нь төлөгдөөгүй. Ингээд л түүнийг Хогвартс хүртэл дагаад ирсэн. Тэр мөрийнд бүх зүйлээ алдсан. Тэр тэдэнд өрөө яаж төлөхөөр шийдсэн гэж бодож байна?

- Яаж? гэж Харри асуулаа.

- Чамайг мөрийнд тависан. Тэмцээнд ялна гэж томоохон бооцоо тавьсан. Алибинуудын эсрэг мөрийцсөн.

- Ийм учраас л тэр үргэлж надад туслахыг хичээгээд байж! гэж Харри дуу алдав.

- Гэхдээ би ямар ч гэсэн хожсон. Тэгэхээр та нарт мөнгийг чинь эргүүлж өгсөн биз дээ!

- Юу ч болоогүй. Алибинууд түүнтэй бохир тоглосон. Түүнд Харри ганцаараа биш Седриктэй ялсан гэж хэлсэн. Харин Бэгмен ганц дээр тавьсан байжээ. Иймээс Бэгмен зугтсан. Гурав дахь тэмцээний дараа алга болчихсон.

Жорж хүндээр санаа алдаад ахин хөзрөө дэлгэлээ.

Үлдсэн аялал таатай болов. Харри Кингс Кросс буудал хаа нэгтээ алга болж аялал зуны турш үргэлжлээсэй гэж хүслээ... Гэвч энэ жил Харри хэрвээ урд таагүй юм заналхийлж байгаа бол цаг алдаж болохгүйг ойлгожээ. Галт тэрэг удаанаар есөн бүхэл дөрөвний гуравдугаар тавцан дээр зогслоо. Сурагчид ердийнхөөрөө хонгилд чихцэлдэн гарцгаалаа. Рон, Гермиона хоёр өрөөнөөс тээшээ гарган газар хэвтэх Малфой, Крэбб, Гойл нарын дэргэдүүр өнгөрлөө.

Харри саатлаа.

- Фред, Жорж... түр хүлээгээрэй.

Ихрүүд эргэж харав. Харри чемоданаа онгойлгон Гурван шидтэний тэмцээнээс хожсон алтаа гаргаж ирлээ.

- Үүнийг ав гээд Жоржын гар луу сунгав.
- Юу? гэж мэл гайхсан Фред дуу алдав.
- Ав. Надад хэрэггүй гэж Харри шаардангуй хэлэв.
- Чи ухаан солиорчихож гээд Жорж цүнхийг түлхлээ.
- Үгүй дээ, тэгээгүй. Аваад өөрсдийн бүтээлдээ хэрэглэ. Энэ бол та нарын тоглоомын дэлгүүр.
- Тэр үнэхээр ухаан солиорчихож гэж Фред айдаст автсан хоолойгоор хэлэв.
- Сонсож бай, хэрвээ та нар мөнгийг авахгүй гэвэл би одоо тэднийг устгалаа. Надад энэ мөнгө хэрэггүй, харахыг ч хүсэхгүй байна. Харин та нарын тоглоом бүгдийг хөгжөөдөг. Би үүнд сэтгэл хангалуун байна. Бидэнд удахгүй энэ нь өмнөхөөсөө илүү хэрэгтэй болно гэж Харри шийдэмгий хэлэв.
- Харри, гэхдээ энд чинь мянгаас доошгүй галлеон байна шүү дээ гэж Жорж мөнгийг цэгнэн шивнэлээ.
- Тиймээ, багагүй. Хичнээн цөцгийтэй жигнэмэг болохыг төсөөлөөд үз дээ гээд Харри инээмсэглэв.

Ихрүүд түүнийг чимээгүйхэн харна.

- Зөвхөн ээждээ мөнгө хаанаас авснаа бүү хэлээрэй. Тэр та нарыг яаманд ажиллахыг хүсдэг болохоор...
- Харри гэж Фред эхэлсэн ч тэр халааснаасаа шидэт саваагаа гаргалаа.
- Сонсоцгоо, тэднийг ав эсвэл би хормын дотор илбэдлээ. Би одоо сайн шившлэгүүд мэддэг болсон. Надад зөвхөн нэг гуйлт байна. Ронд шинэ ёслолын хувцас авч өгөөрэй.

Ингээд ихрүүдийг үг хэлж амжаагүй байхад Харри өрөөнөөс гарч газар тэрийн хэвтэж байгаа Малфой, Крэбб, Гойл нарын дэргэдүүр өнгөрлөө.

Вернон ах түүнийг хаалтын цаана хүлээж байв. Дэргэд нь хатагтай Уизли зогсож байлаа. Тэр Харриг чанга тэврээд чихэнд нь шивнэлээ.

- Дамблдор чамайг бидэн дээр зуны сүүлчээр ирэхийг зөвшөөрнө байх гэж бодож байна. Түүнд бич, Харри.
- Удахгүй уулзая, Харри гээд Рон нуруун дээр нь алгадав.
- Баяртай, Харри! гэж Гермiona хэлээд хэзээ ч хийж байгаагүй зүйл хийж хацар дээр нь үнслээ.
- Харри... баярлалаа гэж Жорж бувтнахад Фред дэргэд нь зогсоод чимээгүйхэн толгой дохиж байлаа.

Харри ихрүүдэд нүд ирмээд Вернон ах руу эргэн явлаа. <<Ахин санаа зовох хэрэггүй>> гэж тэр өөртөө хэлээд нагац ахынхаа машины арын суудалд суулаа.

Хагрид болох ёстой юм болдогоороо л болно... санаа зовох хэрэггүй гэж хэлсэн.

ТӨГСӨВ